



Артур вангийн

өргөөнөө

Марк Твен



Орос хэлнээс орчуулсан Д Алтанхуяг

АРТУР ВАНГИЙН ӨРГӨӨНӨӨ

Эхлээд би өдрийн тэмдэглэл хөтөлдөг байлаа., хожим олон жилийн дараа ном болгочихсон юм. Тэрнээс хойш мөн ч уджээ! гэв Гар бичмэлээ над өгөөд эндээс унш гэж зааж өглөө

- Эндээс эхлээрэй, урьд нь юу болсныг би танд ярьчихсан Тэгээд бүр үүрэглэж эхлэв Намайг үүд үрүү явж байхад тэр хүн амандаа

- Сайхан нойрсоорой, үзэсгэлэнт ноён гуай гэлээ. би зуухных нь дэргэд суугаад эрдэнэсээ үзэж гарлаа Тэмдэглэлийнх нь нэгдүгээр болон ихэнх хэсэг нь улирлын удаанд шарласан илгэн цаасан дээр бичээстэй байв. Би нэг хуудсыг нь нарийвчлан үзвэл палимпсест, мөн байлаа. Түүхчин -янкийн бичсэн эртний гаргац муутай мөрүүдийн доогуур бүр ч гаргац муутай, бүр ч эртний бичгийн ул мөр эртний лам нарын үлгэр туульсын хэсэг бололтой латин үг, өгүүлбэр харагдана Үл таних хүнийхээ зааж өгсөн газрыг хүртэл би хуудас эргүүлэн хараад цааш нь уншлаа Уншсан зүйлээ сийрүүлбэл

АЛГА БОЛСОН НЭГЭН ГАЗАР ОРНЫ ТУХАЙ ТУУЖ

Нэгдүгээр бүлэг

КАМЕЛОТ

- Камелот Камелот Үгүй ер, дуулаагүй нэр юм. . Галзуугийн байшин л байж таарах нь дээ гэж би дотроо бодож байлаа. Бидний орчинд огт эл хуль бөгөөд хүсэл мөрөөдөл мэт амар жимэр, асар сайхан байлаа. Агаар нь цэцэг ногооны анхилам сайхан үнэртэй, шавьж хорхойн дүнгэнэлдэж, жигүүртэн шувуудын жиргэн донгодох л сонсдохоос биш хүн хар, жин хөсөг ер үзэгдэхгүй аж . Бидний явсан зам маань үнэндээ морины туурайн мөр чийрлэж хажуу талаар нь алгын чинээ өргөн дугуйн мөр үзэгдэх нарийхан муруй зөрөг байлаа. Гэв гэнэт алтан шаргал үс нь мөр рүүгээ буусан арваад насны хөөрхөн охин бидэнтэй тааралдав толгой дээрээ гал улаан намуу цэцгэн баглаа тавьжээ . Тэр цэцгийн зохисон гэдэг хараад ханашгүй санагдлаа . Яаралгүй додигор алхах бөгөөд санаа амарлингуй байдал нүүрэнд нь ил байв. замын хань маань тэр охиныг огт анзаарахгүйгээр үл барам олж үзсэн ч үгүй бололтой . Харин тэр охин яав? гэвэл хуяг дуулгатай хүнтэй өдөр болгон тааралдсаар байгаад хайхрахаа больсон бололтой тэрний хачин өмсгөл чимэглэлийг огтхон ч гайхсангүй, тэгээд дэргэдүүр нь үнээ малын хажуугаар л өнгөрч байгаа юм. аятай огт жишимгүй гарлаа харин намайг харчихаад яасан гэж санана! Нэг гараа өргөн мэл гайхан зог тусаж, амаа ангайн, нүдээ бүлтэгнүүлэн жигтэйхэн айж байлаа. Учиргүй их сонирхох айх хоёр зэрэгцжээ . Бид хоёрыг ойн замын муруйг даган далдран далдартал тэр охин намайг гайхан харсан чигээрээ ширтсээр хоцорлоо миний хамт яваа хүнийг хараад гайхахын оронд намайг хараад гайхдаг нь ямар учиртай юм. бол, би бүр бодоод ухааны нь олсонгүй . Яагаад өөрийг гайхахын оронд намайг ийнхүү эвэртэй туулай мэт гайхдаг, билээ. яагаад тийм балчир бага атлаа жоготой гэгч ширтдэг, билээ. бодоод байхад нэг л жигтэй санагдана . Зүүд нойронд болж буй мэт бодогдож байв. хотод ойртох тусам хөл хөдөлгөөн ихэссээр байлаа. Сүрэл дээвэртэй яйжгий овоохой ч тааралдана, тун муу янзалсан тариалангийн талбай, цэцэрлэг ч тааралдана .

Ажлын мал шиг хүмүүс, ширэлдсэн ширүүн үс нь нүүрээ таллан унжралдсан булиа эр ч тааралдана Өвдгөө давсан урт хормойтой, гар хийцийн хувцастай эр, эмс шаахайрхуу нэг муу гутал өмссөн байв. Тэдний дотор төмөр хүзүүвчтэй хүн олон харагдлаа Бяцхан охид, хөвгүүд нь чармай нүцгэн явна гэтэл энүүнд нь гайхдаг амьтан огт алгадагаа харин тэд их, багагүй л намайг нүд унагаах дөхөн ширтэж, миний тухай ярилцан, Тэр гэр лүүгээ хөл мэдэн гүйлдээд намайг харуулах гэж гэрийнхнийгээ дуудаж байлаа. Тэгсэн мөртлөө надтай цуг яваа хүнийг ер гайхахгүй, харин ч түүнд бэмбэгнэн мэхэсхийцгээхэд мань эр ч хариуд нь тоохгүй хээв нэг явах юм. хотын доторхи сүрэл дээвэртэй эмх замбараагүй орших урцан дунд цонхгүй хэд хэдэн том чулуун байшин байх аж Гудамжны оронд муруй сарий, засаж янзлаагүй зам байна. Үй олон нохой, шалдан хүүхдүүд л наранд тоглон хашгиралдана . Энд тэндгүй гахай хог малтах бөгөөд нэг нь хамаг биеэ шавар болгочихсон хотын гол гудамжны дундах том гэгчийн шалбааг дотор тарайн хэвтгээд торойнуудаа хөхүүлж харагдлаа . Гэв гэнэт тэртээ холоос цэргийн хөгжим тасхийн дуулдлаа . Хөгжмийн дуу ойртох тусам чангарах агаад төдхөн хэсэг морин цэрэг гарч ирлээ . Дуулганых нь чимэг сагсалзан, хуяг нь гялалзан, туг хиур нь намирч, сайхан хувцас хүнар морьдынх нь нэмнээ, жадных нь алга гилбэр гял цал оргиод их л сүрлэг харагдана . Яйжгий овоохой, сүүлээ сөхсөн ноход, нүцгэн хүүхэд, бохир гахайн дундуур шавар шавхай туучин сүрлэгээр өнгөрөх морин цэргүүдийн араас бид гэлдэрлээ . Бид шавхайт гудамжаар өгссөөр уулын орой дээр гарахад өөдөөс салхи сэрчигнэж, харагдахаас асар то м шилтгээн нүднээ тусав Эвэр бүрээ татахад шилтгээний зүгээс мөн эвэр бүрээн дуухадаж тийнхүү хэлэлцээр эхлэв . Лууг муухан дууриаж эрээлсэн хээтэй ханын дээгүүр намилзах туг хиурын дор алхлах шовгор дуулга, хуягтай, мөрөн дээрээ цавчуур хөндөлдүүлсэн цэргүүд бидэнд хариу өгч байлаа. Тэгтэл асар том дааман хаалга нээгдэж, өргөдөг гүүр бууж, сүрдмээр сүрлэг бүнхгэрийн доогуур морьт цэргийн дарга гарч ирэв Бид ч дөрвөн зүгээсээ хөх тэнгэр лүү самардах өндөр нам цамхгаар хүрээлсэн чулуун дэвсгэртэй хашаанд орох нь тэр Тал бүрээс бидэнд хүндэтгэлийн баяр хүргэж, морьтон эрс мориноосоо бууж хүн амьтад хөл алдан гүйлдэж хөгжилдөн баясаж, хүүе, хайя хэмээлдэн авай

Хоёрдугаар бүлэг

АРТУР ВАНГИЙН ӨРГӨӨ

Миний бие самбаачлан хажуухан тийш гараад хараажийн эгэл жир байдалтай нэг өвгөний мөр лүү алгадаж чихэнд нь

- Та над тус болж үз Та энэ галзуугийн газар алба хаадаг хүн үү, аль эсхүл төрөл садныхаа аль нэг хүнийг эргэх гэж ирээд байгаа хүн үү? гэхэд сайхь эр над руу тэнэг нүдээ бүлтэгнүүлэн харж

- Сайхан ноёнтон, гэж утга учиргүй юм. эхлэхэд нь миний бие

- за боль доо, та ч бас л эндхийн өвчтөн юм байна., мэдлээ гээд түүнийг орхин над бага сага юм. тайлж өгөх эрүүл саруул ухаантай амьтан байна. уу үгүй юү хэмээн бодсоор ийш тийш хартал үнэхээр нэг хүн байх шиг болохоор дэргэд нь очиж мөн л чихэнд нь

- Ахлах харгалзагчтай нь яасгээд нэг уулзья даа Тун удахгүй гэтэл нөгөөдөх маань

- над бүү саад бол гэв

- Юү гэв ээ, та?

- Энэ үгийг мэддэг бол над бүү саад бол гэж гэлээ. Тэгснээ өөрийгөө туслах тогооч гэж тан илцуу лаад одоо дэмий юм. чалчих завгүй байна. хэмээсэн боловч төдө лгүй дуртай нь аргагүй дэмийрч намайг хаанаас ийм хувцас х у нартай болсныг мэдэх гэж тун их сонирхон байлаа. чингэтэл хуруугаараа нэг тийш зааж тэр л зав ихтэй хүн, танд хамгийн таарах хүн тэгээд ч бас өөрийг чинь цөхрөлтгүй эрж буй хүн гэлээ. Тэр нь час улаан өмдтэй учир салаа үзүүрт лууван мэт харагдах нэг тура . нхай жаал байв. Сүлжмэл цэнхэр торгон дээлтэй юм. Урт шаргал бужгар үстэй толгой дээрээ ягаан өнгийн хээгүй торгон малга йг чих даран тавиад, малгайдаа өд хатгажээ . Нүүр царайг нь ажвал номхон баймаар, алхаж гишгэхий нь ажвал биеэ их тоосон гэмээр, ер нь л хөргий нь жаазанд тахичихмаар хөөрхөн жаал байлаа.!! миний дэргэд инээмсэглэсээр хүрч ирээд жигтэйхэн гайхан шохоорхож буйгаа нууж чадалгүй намайг нүд хэсүүлэн харснаа

- Таныг аваачихаар ирлээ, би бол зарц нарын ахлагч нь байгаа юм. гэхэд би

- чи яаж ахлагч нь байж таарах вэ дээ? гэчихлээ Энэ маань баахан бүдүүлэг үг болсон боловч яах вэ, би инээд алдлаа . Жаал маань ч дагаад инээдэг байгаа, миний хэлсэн үгэнд ердөөч зэвүү нь хүрээгүй юм. шиг байлаа. Надтай хамт яваадаа ман ь эр үг дэлгэж, хөнгөн хөвсөргөн байдалтай инээж хөхрөн, ёстой л хүүхэд шиг загнах тул бид хоёр төдхөн үй зайгүй найз мэт болов. Надаас тун олон юм. асууж шалгаан, миний хувцас х у нарыг сонирхон, элдэв дээдийн юм. асуух боловч хариу үг сонсолгүй саяхан асуусан юмаа мартчихаад дахин дахин асууж баахан чалчина Тэгж л байгаад 53 оны эхээр төрсөн гэдгээ ч чалчих нь тэр би давхийн цочиж зог тусан, дорой муу дуугаар

- чих минь хазгай дуулчив аа даа Саяын хэлдгээ удаахан шиг, үг үгээр нь хэлж үзээч чи хэдэн онд төрсөн гэнэ ээ?

- Таван зуун арван гурван онд,

- Таван зуун арван гурван онд гэнэ ээ? Чамайг харахад хэн ч ийм гэж санахгүй! за жаал минь , аан гэж бай би харь хүн, энд найз нөхөд байхгүй чи л над үнэнч шударга байж үз чи ер нь эрүүл ухаантай хүн үү? гэхэд тэр маань эрүүл ухаантай хүн гэжээ

- Цаадуул чинь бүгд ухаан эрүүл үү? гэхэд бас л эрүүл ухаантай улс гэлээ. Энэ чинь галзуугийн газар биш гэж үү? Галзуу хүн эмнэдэг газар биш гэж үү гэж би асууж байна шүү дээ гэхэд галзуугийн газар бишээ биш гэлээ., нэг л аймшигтай юм. болж дээ Эсхүл би солио тусаа юу би ингэхэд ямар газар ирээд байна., чи үнэн шударгаар хэлж өгөөч Артур вангийн өргөөний хашаанд т үүний хэлсэн үгийн учир утгыг олигтойхон ухаарахын тулд миний бие дув дуугай хэсэг бодсоноо

- Одоо чи хэдэн он гэж бодож байна. гэж асуулаа

- Таван зуун хорин найман оны зургаадугаар сарын арван есөн миний зүрх ёгхийж амандаа

- Найз нөхөдтэйгээ дахин хэзээ ч уулзахгүй болжээ., хэзээ ч үгүй болж Тэд маань мянга гурван зуу гаруй жилийн дараа мэндлэх тавилантай юмсанж хэмээн үглэв . Тэр жаал над үнэн хэлсэн гэдэгт би яагаад ч юм. итгэсэн юм. зүрх сэтгэл минь итгэвч билэг оюун маань итгэж өгсөнгүй миний ухаанд багтахгүй байлаа., арга ч үгүй юм даа Билэг оюунаа яаж аргалахаа би мэдэхгүй байлаа. Бусад хүний гэрч баримт над тус болж чадахгүй янзтай, яагаад

гэвэл миний билэг оюун тэднийг ухаангүй амьтад гээд хэлэх үгийн нь анзаарах ч үгүй гэтэл Ямар нэг зөнгөөр миний тархи толгойд нэг сайн бодол орж ирэв . Зургадугаар зууны эхний хагаст болсон ганц удаагийн нар хиртэлт 528 оны 6 сарын 2 ний их үдээс хойш яг гурван минутад эхэлснийг би мэдэх билээ. 879 онд миний тооцож байснаартэрхүү эсэргэн жил нар бүтэн хиртэхгүй гэж зурхайчид үзэж байсныг ч би бас мэдэж байлаа. Тэгэхлээр ойрын дөчин найман цагийн дотор л миний зүрх энэхүү их шохоорхол түгшүүрт байдлын уршгаар зогсчихгүй бол тэр жаалын хэлсний үнэн худлыг үнэлж магадтай шийдэх бололцоо олдох байлаа. Нэгэнт миний бие Коннектикуг нутгийн хашир хүн учраас тэр тааврынхаа шийдийг зохих цаг мөчий нь болтол хойш тавиад тэр тухай бодохоо ч больж, тухайн агшныг туйлд нь хүртэл ашиглахын үүднээс хамаг анхаарлаа тухайн нөхцөл байдал дээр төвлөрүүлэв Хөзрөө хадгалж бай!» гэсэн ийм нэг сургаалыг миний бие эрхэмлэдэг учраас гарт чинь дадар, боолоос өөр юм. байхгүй ч байлаа. гэхнээ ээлжээ өнгөрөөж л чинь гэж боддог тэгээд би хоёр янзын шийд эдүгээ ямар ч болгугай арван есдүгээр зуун бөгөөд галзуу хүмүүсийн дотор ийнхүү ороод ирсэн юм. бол би эндээс мултрах зайгүй болох нь ээ энэ галзуугийн газрын эзэн нь эс болж гэм би маань би биш болоход хүрнэ хэрэвзээ үнэхээр зургадугаар зуун юм. бол над тэр тусмаа ээлтэй, гурван сарын дараа би энэ улс орны эзэн болчихно, яагаад гэвэл эднүү сээс мянг а гурван зуун жилийн хоёрно төрсөн би чинь вант улсдаа хамгийн их боповсролтой хүн болж таарна шүү дээ би ч нэгэнт шийд гаргавал дор нь нэг тийш болгодог хүн болохоороо нөгөө зарц залуудаа ингэж хэллээ

- чиний нэрийг Кларенс гэж үү, жаал минь чи над жаахан юм. хэлж аль Намайг наашаа хүргэж ирсэн хүнийг хэн гэдэг юм. бэ? чи бидний ноёныг уу? Тэр чинь алдартай баатар эр, ариун үйлт ноён эрхэмсэг Кэй, манай ван эзэнтэй нэг эхийн хөх хөхөж өссөн ах дүү сенешаль байгаа юм.

- уу хай, чи тэрний талаар юу мэддэгээ над ярьж өгөөч Над дэлгэрэнгүй ярьж өглөө . Харин тэрний ярьсан зүйл надтай шууд холбоотой юм. байлаа. Түүний ярьснаар би бол Кэй ноёны олзны хүн, тэгэхлээр тэдний хэн заншлаа дагаж намайг хар гэрт хийж тамлах, нөхөд маань намайг золих төлж аван авгал тэд надад ус, талхнаас өөр юм. өгөхгүй байх юм. гэнэ . Тураад үхчихэлгүй байтал золих ирвэл мултарч болох юм. байх би уг нь золих ирэхээс өмнө турж үхэж тун магадгүй байсан боловч дэмий зовж, чухал цаг алдах хэрэг байхгүй гэж бодлоо зарц жаал цааш нь ярихдаа, их лавиранд үдийн хоол зооглоцгоож дуусаад одоо яриа хөөрөө архи дарс уух цаг дөнгөж эхэлж буй, Кэй ноён таныг дуудах тушаал өгч, Артур ван болон дугуй ширээ тойрон суух түүний цэрэг эрст үзүүлж таныг олзлон авсан гавьяагаа сайрхан ярих ажээ. Ингэхдээ тэр уг явдлыг нэлээд дэгсдүүлэн ярих бололтой . Тэгж ярихад нь засвар оруулж бопохгүй тэгэх гэж оролдвол хүндэлж үзээгүй хэрэг болж, бүр ч осолтой юм. дэгдэж мэднэ . Тэгээд намайг ханатлаа харсны дараа хар гэрт оруулах юм. байж гэвч Кларенс намайг байн байн эргэж очих арга ухаан олохын дээр миний анд нөхдөд хэл хүргэж өгч чадна гэлээ. миний анд нөхдөд хэл хүргэнэ гэсэн шүү түүнд талархлаа илэрхийлэхээс өөр юм. над юу ч үлдээгүй юм. Яг ингэж байтал нэг зарц ирж намайг дуудаж байна. гэлээ. . Кларенс намайг шилтгээнд оруулаад өөрөө намайг хажуудаа аван суув . Жигтэйхэн сонин зугаатай юм. харагдаж байлаа. дотроо бараг хов хоосон гэмээр тэр том лавиранд байгаа юм. хүм нь бие биендээ тун харш харагдана . Тэр өрөөний таазын өндөр гэдэг танагүй, жигтэйхэн өндөр учраас дээрээс унжуулсан туг хиур нь оройн бүрэнхийд ямар өнтөтэй нь ч ялгарахгүй байх юм. Лавирангийн хоёр хажуу хана дагуу чулуун хэрсгээр хашсан хоёр өндөр давцан байх ба нэгэн дээр нь хөгжимчид, нөгөөдээр нь нүд гялбам гоёж гангалсан эмэгтэйчүүд сууна . Шал

нь элэгдэж хуучирсан том томхавтгай чулуун хучлагатай юм. солихоос горьгүй болжээ. . Үнэнийг хэлэхэд гоёл чимэглэл гэх юм. аар маруухан юм. . Хананд нь том том хивс харагдана, тэрнийгээ урлагийн бүтээл гэж тооцдог бололтой Хивснийх нь хээ угалз дайн тулааныг харуулсан байна. Морьды нь эсгэсэн гурилаар хийсэн юм. уу, эсвэл хүүхэд цаас хайчилж хийсэн юм. уу гэмээр, хүнийг дүрслэхдээ хайрслал хуягтай хийжээ . Бас хайрслал хуягийн оронд дугаргий дугаргий нүх гаргасан байна., тэгэхлээр гархин хуягийг зөөлөн боов хагалдаг нэг сэрээгээр нэвт хатгаа юу гэмээр харагдана . Лавирангийн дотор бүхэл бүтэн хүрээ цэрэг буудаллаж ба й маар талын чинээ нэг их том задгай зуух байх юм. . Сийлмэл чулуун багануудаар хүрээлсэн учраас цогчин дуганын хаалгархуу харагдана Лавирангийн хана дагуухуяг дуулгатай баахан цэрэг эрс зогсоно . Тэд гартаа цавчуураас өөр мэс ер бариагүй агаад огт хөдөлгөөнгүй зогсох тул чулуун хөшөө гэж андуурч мэдмээр юм. дээрээсээ дээвэртэй, доороосоо ч луун шалтай зах зээлийн тэр өргөн талбайн тэг дунд Дугариг Ширээ хэмээн нэрлэдэг царс модон ширээ байна. том гэдэг нь яг л цирк ийн тавцан Тал талд нь нүд эрээлжилж өвдмөөр эрээн мяраан хувцастай өдий төдий эрчүүл суужээ толгой дээрээ бүгдээр өдтэй малгай өмссөн байх юм. . Ванд бараалхан хандахдаа л тэд малгай гаа бага зэрэг сөхөсхийж бөхөлзөнө . Ихэнхи нь нанчид зооглоод завгүй . Түүнийгээ туга л майгий нь авсан эвэрт хийж ууцгаах юм. . Зарим нь талх зажлах буюу үхрийн яс мөлжинө . Хүн бүр хоёр хасар нохойтой байдаг бололтой Ноход нь яс горьдон оцойлцох бөгөөд яс хаямагц нэгэн зэрэг ухасхийнэ . Ноход ноцолдоод толгой, их бие, сүүл хонгорцог нь арсалдан арзганалдан холилдсон эх адаггүй юм. болон хуцах улих сүйдтэй чимээ дэгдэхэд хүмүүс арга буюу аливаа яриагаа зогсооно Нохойн ноцолдоо нь аливаа яриа хөөрөөнөөс хавьгүй сонирхолтой байдаг гэх тул тийм юм. бодоход гонсойн гомдох хүн гэж алга Эрчүүд нь хэний ямар нохой дийлэх нь вэ хэмээн мөрийцөн сонирхож босон харайх бөгөөд хатагтай ноёгтой нар болон хөгжимчид нь хэрсэг дээгүүр дамналдан өнгийнө . Тал бүрээс хөөрөл баяслын шуугиан чих дөжрөөнө Тэгж тэгж дийлсэн нохой нь мөн л дийлсэн хагас зуу орчим нохойтойгоо цуг шалан дээр эвтэйхэн сунаж хэвтээд урд хоёр саварт хавчсан ясаа архиран урхиран хэмлэж эхлэхэд ордныхон зугаа цэнгэлээ үргэлжлүүлээ Өрөөс тэр хүмүүсийн яриа хөөрөө, байдал сэлт нь их л догь я мбархуу байх юм. Тэд нохойн ноцолдоон харах зуур ярилцагч хүмүүсийнхээ үгийг найрсаг анхааралтай чагнан суух юм. . Харин тэд хүүхэд шиг гэнэн юм. гээч Улаан цайм худал зална Бас тэгээд өөрсөн шиг нь мөн хэвнэг худал яриад унавал эргэл з эхгүй итгэхийг нь яана Тэд догшин ширүүн, аймшигтай юмны талаар огт өөрөөр төсөөлөх боловч цуст явдал, зовлон тарчиллын талаар үнэнхүү шүлс залгин ярилцах учир би бүр дагжин чичрэхээ ч больчихсон юм. даг Тэр лавиран дотор ганц би олзны хүн байсангүй . Надаас гадна хориод, хорь гаруй ч бол уу даа олзны хүн байсан Тэдний олонхийг нь хамгийн аймшигт хэрцгий аргаар урж тасчин зэмдэглэж сэглэсэн байлаа. Үс гээг, нүүр царай, хувцас хүнар нь хатаж харлаад нэл цус нөж болжээ. Тэд ядрах, өлсөх, цангахын зовлон гарцаагүй амсаж тарчилсан нь илт байв. Хир, цуснаас өршөөл гуйж царайчлах янз олохгүй дээ Тэгээд ч над Эд өөрснөө лав бусдыг ингэж л байсан амьтад байлгүй Одоо ээлжээ ирэхлээр яагаад ч дэмий гэж боддог биз Ингэхлээр, тэдний хүлцэнгүй нь сэтгэц, тэвчээр оюун ухааных нь чадлын ид огт биш, эд агуурс амьтан шиг тэвчээртэй амьтад юм. эд ер нь л цагаан индиачууд юм даа гэсэн бодол өөрийн эрхгүй төрж билээ.

Гуравдугаар бүлэг

ДУГАРИГ ШИРЭЭНИЙ ХҮЛ ЭГ БААТРУУД

Дугариг Ширээний яриа бол үнэндээ нэг л хэвийн байв. Х үлэг баатрууд хэрхэн ямар хүмүүсийг олзолсон, яаж тэдний найз нөхөд, талынхныг алж хядаж, унаа морь, ээр зэвсгийг нь булааж авсан тухайгаа ярилцана . М иний бодсоноор тэд хүнийг алахдаа хариугаа авах, хуучны өсөөр юм. уу гэнэт үүссэн хэрүүл маргаанаас болж алдаг хэрэг биш байлаа. Огт тийм биш, харин танихгүй хүмүүсийг л, ер хэзээ ч хоорондоо танилцаагүй, ямар ч муу юм. хийж яваагүй тийм хүмүүсийг алдаг байна. . Танихгүй хоёр жаал санаандгүй тааралдаад Чамайг даа, турсгы чинь хуулах хүна гэж заналцаад зодолдож байхыг цөөнгүй үзсэн хүүхдүүд л хүүхэд зангаараа тэгдэг юм. биз гэж би боддог байсан юм. гэтэл энэ сахалтай хүүхдүүд нас сүүдрээ ч бодохгүй яг л жаал хүүхэд шиг загнаж түүгээрээ бас бахархдаг байна. гэлээ. ч гэсэн энэ гэнэн төгцгүүдэд сэтгэл татам тал байх юм. Үнэнийг хэлэхэд тийм том хүүхдийн уураг тархи нь даанч шалихгүй жаахан юм. болохоор загасны дэгээнд өгөөш болгоё гэсэн ч хүртэхгүй биз ээ Гэхдээ тиймэрхүү нийгэмд ер нь уураг тархины хэрэг байх үгүй юм. уураг тархи байх юм. бол саад тээр болж, бүгдийг шахан хавчаад, тэр нийгмийг хууль зүйгүй болгож, ер нь түүнийг оршин тогтох боломжгүй болгоно биз Тэр эрс бараг бүгд царайлаг, эрэлхэг харагдах бөгөөд зарим нь даанч сайхан намба, эетэй байдаг болохоор аливаа шүүмжлэгч арга буюу мухардан ноён гэгдэх нэг хүний царай, бас вангийн царай гойд эергүү, ариун тунгалаг харагдана . Харин нуурын Ланселот Ноёны нүсэр том бие, бардангуй намбанд жинхэнэ сүр жавхлан төгс шингэжээ санамсаргүй тохиолдсон нэгэн явдлаас болж Ланселот ноёны зүг хүн бүхний анхаарал нисэв . Ямар нэг хүний, бодвол ёслолын түшмэлийнх л болов. уу дохиогоор зургаа юм.уу, найман олзны хүн урагш түрэн гарч сөхрөн суугаад хатагтай нарын сууж буй зүг гар өргөн вангийн хатны тухай мөргөлийн үг хэлье хэмээн гуйж эхлэв Ганган цэмцгэр тэр эмсийн дунд хамгийн хүндэт суудал эзэлсэн нэг хатагтай соёрхсоны тэмдэг болгож тэргүүнээ гудайсхийн дохилоо . Тэгэхэд нь бүх олзлогдогсдын нэрийн өмнөөс зарлахдаа миний бие өөрийгөө болон өөрийн нөхдөө вангийн хатны бүрэн мэдэлд өгч биднийг өршөөнө үү, бидний төлөө золих нэхнэ үү, аль эсхүл цаазлан хорооно уу өөрөө мэдтүгэй гэж байгаа юм. гээд, шударга тулалдаанд биднийг ялж, бид бүгдийг олзлон авсан, вантай нэг эхийн сүү хөхөж өссөн сенешаль ноён Кэйн зарлигаар хатан танд хандаж байгаа юм шүү гэж нэмж зарлав хүн бүрийн царайд гайхсан шинж илэрлээ . Вангийн хатны царайнаас бахдам сайхан мишээл нь алга боллоо . Ноён Кэйн нэрийг сонсоод л гонсойв бололтой зарц залуу ёжлон инээмсэглэж, миний чихэнд шивнэхдээ

- Ноён Кэй юу , тэгэлгүй яахав! би итгэнэ ээ! Намайг жулдрай жаал охин ч гэнэ үү, далайн харх ч гэнэ үү дуртайгаараа хэл! Ухаанд багташгүй ийм худал юм. олж зохиохын тулд хүн төрөлхтөн дахиад хоёр мянган жил тархиа ширгэтэл бодох хэрэгтэй болно. гэв хүн бүхэн ноён Кэй рүү хараа чиглүүлэн сорин ширтлээ Ноён ч ажралгүй босож нэг гараараа сүрлэг янзтай зангаж гагцхүү зайлшгүй үнэн баримттай чин үнэнийг нэмэр сэмэргүйгээр ширхэгчлэн ярьж өгнө гээд

- Тэгсэн цагт та бүхэн христосын баатар эрсийн дотор урьд хожид зэвсэг барин тулалдаж явагсдын хамгийн хүчирхэг дайчин эр энд буйг болгоож хүндэтгэн шагших болно.! гэв Тэгээд Ланселот ноёныг гараараа заалаа . Энэ нь гойд ухаалаг зүйл болж хүн бүрийн гайхаш булаав Ланселот ноён адал явдал хайн яваад тулалдаанд сэлмээ ганц далайн буулгахдаа долоон үлэмж биетний толгойг тас цавчин олзонд эрсдэн тарчилж байсан нэг зуун дөчин эмийг чөлөөлсөн, бас цааш нь довтлон давшсаар шинэ шинэ адал явдалтай тулгарч, Кэй ноёныг гадаадын есөн баатар эртэй ганцаараа үзэлцэх хүч тэнцвэргүй тулалдаан хийх гэж байхад нь Ланселот ноён ганцаархнаа нөгөөдүүлийг дуудаж есүүлэнг дарсан, маргааш нь Ланселот

ноён харанхуй шөнөөр сэмхэн босож Кэй ноёны хуяг дуулгыг хэдэрч, Кэй ноёны морийг унаад аль холын улс оронд очиж нэг удаагийн тулалдаанд арван зургаан дайчин эрийг дийлж, өөр нэг байлдаанд гучин дөрвийг буулган аваад тэр хоёр тулалдаанд тийнхүү дийлэгдсэн эрсийг Гурван Эрдэнийн дүйцэн өдөр Артур вангийн өргөөнд очиж Вангийн хатан Гиневрийн мэдэлд амь насаа тушааж өөрсдийгөө вантай нэг эхийн сүү хөхөж өссөн Кэй ноёны олзны хүмүүс бөгөөд түүний эрэлхэг баатар гавьяанд автагсад гэж хэлэх ам тангаргий нь авсан, тэднүүсийн зургаа долоо нь энд нэгэнт хүрэлцэн ирээд байгаа, бусад нь аймшигт шархаа эдгэсэн даруй ирэх юм. гэж өгүүллээ . Вангийн хатан түүний үгийг сонсохдоо ялимгүй ичингүйрч царай нь улайсхийн инээдээ барьж ядан, заримдаа Ланселот ноён уруу хулгай нүдээр жоготой харах нь хэрэв А р санзаст ийм харцанд өртвөл амиа бууны суманд удалгүй алдана даа гэх мэт санагдлаа . Х үн бүхэн Ланселот ноёны эр зориг, уу жим сэтгэлийг шагшин магтах бөгөөд ганц хүн яаж тийм хашир догь байлдаанч эрсийг дийлж олзлон авдаг юм. бол хэмээн би гайхаж байлаа. би ингэж бодсоноо Кларенст хэлбэл тэр өд шиг хөнгөмсөг марзан жаал

- Кэй ноён хатуу архинаас бас нэг татаж орхисон бол ялсан хүнийх нь тоо хоёр дахин өсөх байсан гэлээ. Жаалын царайд гүн гүнзгий гунигийн сүүдэр тусагахад түүнийг өрөвдөв . Жаалын харсан зүг ажвал сахал үс нь буурайсан, далбагар хар хувцастай нэг өвгөн ширээний өмнө салгалан зогсож, толгойгоо дааж ядан, гал нь буурсан сүүмгэр нүдээоээ тэнд буй хүмүүсийг хэсүүлэн ширтэж байв. Хэний ч гомдол саналаа хэлж үл чадах шаналт залхаалтаас эмээсэн хүн бүхний нүүр царайд зарц жаалынх шиг зовуурь илрэв Эзэнтэн минь , дахиад л! гэж нөгөө жаал шүүрс алдсанаа д ахиад л өнөөх чинь аяга тагш юм. балгахлаар арчаагүй ухаандаа орж ирдэг улиг болсон үлгэр халаг гэв Хэн гэгч нь юм. г аргууд увидастай, далан худалч Мерлин гэгч а рилж тонилмоор буг чинь , ганцхан ярьдаг юмтай биднийг залхааж гүйцсэн туучий байгаа юм. ороолон чинь салхи шуурга цахилгаан гялбааг захирч тамын чөтгөр шуламсаар зарлагаа хийдэг болохоор нь түүнээс айхгүй хүн гэж байхгүй Тэрнээс биш ярьдаг ганц юм.ы нь сонсох гэж зовохын оронд аль хэдүйн бодий нь хөтөлж орхихгүй юу хийж суух билээ. Өөрөө их даруу хүн болох гэж, өргөмжлөн магтуулахыг боддо г гүй хү н болох гэж з ориуд тэр тэгж гэнэ Энэ ингэж гэнэ гэж ярьдаг юм. Адгийн муу шаар! аянганд ниргүүлж үхмэр! Яриад дуусахчаан болсон цагт нь намайг сэрээгээрэй гээд жаал маань миний мөрийг дэрлэн унтаж буй дүр үзүүлэв . Өвгөнийг эхэлмэгц жаал үнэхээр дугжран эхэллээ Ноход нь ч унтаж эхэллээ , ордныхон, зарц гоцго нар, хүлэг баатрууд бүгд нойрсож эхэллээ . Уйтгартай залхуу хүрэм дуугаар ярьсаар байхад тал талаас хурхирах нэгэн хэмийн чинээ анир гарах нь яг гуулин хөгжмийн дагай бүдүүн ая мэт сонсдоно зарим нь гараа дэрлэн унтсан байна., зарим нь толгой гэдийлгэн амаа ангайн хурхирч байна. . Ялаа батгана дүнгэнэн суугаад идэхэд үргээж байгаа амьтан ч алга Оготно хулгана олон зуун нүхнээс гарч оромжиндоо дураараа тонгочих адил энд тэндгүй гүйлдэв Нэг нь бүр вангийн толгой дээр хэрэм шиг үсрэн гараад зууж явсан бяслагаа мэрж вангийн нүүр лүү хог бураахдаа ер эмээсэн шинжгүй байлаа. Энэ бол нүд чилж, сэтгэл тарчилсан үед амьсга а авч болох тайван үзвэр байжээ. Өвгөний ярьсан юмыг дор сийрүүлье

- Ван, Мерлин хоёр аяны замд гарч бодь сэтгэлт, их домч нэгэн даяанч дээр очжээ Даяанч, вангийн шархыг үзэж тун сайн эм өгөв Ван тэнд гурав хоноход шарх нь эдгэрч аян замаа үргэлжлүүлэв Артур замд гарсан хойноо миний сэлэм алга гэхэд Мерлин д ажгүй би чамайг сэлэмтэй болгоно гэж я всаар нэг их гүн нуур дээр очиж Артурыг харсаар байтал нуурын тэг дундаас хоргой бээлий т эй нэг гар сэлэм барьсаар цухуйжээ Тэгэхэд нь Мерлин

миний олж өгнө гэсэн сэлэм чинь энэ шүү дээ гэлээ., Нуурын эргээр нэг эмэгтэй явахыг хоёул олж харсан байна. Энэ чинь юун хүүхэн вэ? гэж Артур асуухад Энэ бол нуурын эзэн Нуурын дунд нэг хадан хясаа бий, хадан хясаан дээр энэ дэлхийд хамгийн сайхан нэг шилтгээн бий Одоо тэр хүүхэн чам уруу ойртож ирнэ, аятайхан ярилц тэгвэл тэр сэлмээ чамд өгнө гэжээ, нээрэн өнөөх хүүхэн дэргэд нь ирж мэнд усы нь асуухад Артур ч угтан мэндэлжээ хүүхэн минь, хэний сэлмийг усан дээр барина вэ? Над сэлэм байхгүй учир тэр сэлмийг авах юмсан гэж би хүсэж байна. гэхэд хүүхэн Артур ноён, ван минь, энэ бол миний сэлэм, хэрэв чи миний гуйх юмыг надад өгвөл энэ сэлэм чинийх болтугай гэжээ. Артур чиний гуйсан болгоны чинь өгөхийг би тангарагъя гэсэн байна. за тэгвэл энэ завинд суугаад тэр сэлмийг очиж ав даа би цагаа болохоор очиж авах гэсэн юмаа авна гэж тэр хүүхэн хэлжээ Ноён Артур, Мерлин хоёр мориноосоо бууж хоёр модонд хоёр морио уяд завинд сууж сэлэм барьсан гарын зүг сэлэв Артур ноён сэлэмний бари у лаас шүүрэн барьж, нөгөө гараас нь салган авчээ Гар ч усандаа буцаад орчихож, өнөө хоёр маань ч газар дээрээ гарч ирээд цааш аялан явжээ. Артур ноёны нүдэнд хээнцэр сайхан майхан харагдахад Энэ хэний майхан бэ? гэхэд Мерлин Пөллинор ноёны майхан чи тэр дайчин эртэй эртээдхэн байлдсан шүү дээ, одоо тэр эр энэ майхандаа байхгүй, алдарт дайчин эр Этлемтэй байлдаар явсан, тэр хоёр их удаан тулалдаж Этлем гарцаагүй үхэхийн даваан дээр амь зулбан зугатжээ. Тэгээд Пөллинор ноён түүнийг бүр Карлион хүртэл үлдэн нэхсэн байна. Одоо хоёул түүнтэй их замд уулзана даа гэжээ Тэгвэл би баярлах байна., одоо би сэлэмтэй болсон Түүнтэй чинь би уулзаад өшөөгий нь авдаг хэрэг гэж Артурыг хэлэхэд Мерлин Ноён чи, түүнтэй үзэлцэх хэрэггүй, цаадхи чинь байлдаж байлдаж, хөөгдөн туугдсаар бүр тамирдсан байгаа, тэгэхлээр тийм юмтай тулалдах нэрийн хор болно., түүнээс тадна түүнтэй эн зэрэгцэх баатар эр байдаггүй юм. тэгэхлээр тэрнийг хөндөлгүй өнгөрөөчих, тэгвэл чамд өөрөө алба сайн хааж, өөрий нь үхсэн хойно хэдэн хүү нь чамд бас алба хаана Ер нь чи түүнд охин дүүгээ гэргий болгон өгөх тийм баяртай сайн өдөр ирэх болно. гэхэд нь Артур т эрүүнтэй чинь уулзахдаа чиний зөвлөснөөр болгоё гэжээ Артур ноён сэлмээ эргүүлж тойруулан үзээд санаанд таарч байна. гэжээ Сэлэм хуй хоёрын аль нь чамд илүү сайхан санагдаж байна. гэж Мерлин асуухад, Сэлэм нь илүү санагдаж байна. гэхэд Мерлин чи онож хэлсэнгүй Хуй нь сэлэмнээсээ арав дахин илүү үнэ цэнэтэй, энэ хуй чамд байсан цагт чи юунд ч шархдахгүй, чиний дусал цус ч алдагдахгүй, энэ хуйнаас хэзээ ч бүү салаарай гэж хэлэв Карлио ны хавьд тэр хоёр Пөллинор ноёнтон тааралджээ гэвч Пөллинор Артурыг ажилгүй, нэг ч үг хэлэлгүй өнгөрөөд явчихав Мерлин ид шидээрээ ингэж аргалсан байна. Хачин юм. даа, энэ цэрэг эр яагаад юу ч хэлсэнгүй вэ? гэж Артур асуухад Мерлин Ноёнтон, тэр чамайг үзсэнгүй, үзсэн бол та тийм амар салахгүй байсан шүү гэлээ. Тэгээд мань хоёр, Артурын хүлэг баатруудын найрлаж байсан Карлионд хүрч ирэх нь тэр Вангийнхаа адал явдлыг сонсоод тэд, ван маань тэгж удмынхаа цусыг зөнгөөр нь аюулд оруулдаг хачин юм даа хэмээн гайхжээ гэвч тэдний дотроос гойд шалгаран тодорсон үлэмжийн алдар цуутай хүлэг баатар нь вангаа тэгж э г эл ядуу хү лэг баатрын адил тэнүүчлэн адал явдал хайж явдагт нь бишрээд түүндээ амь насаа зориулан зүтгэхэд бэлэн буйгаа илэрхийлж байжээ.

Дөрөвдүгээр бүлэг

АЛИА НОЁН ДАЙНАДЭН

Энэ хачин худал юмыг тэр хүн хэзээ язааны сурамгай сайхан ярилаа гэж би бодсон а нх сонсож байсан миний хувьд өөр байх л даа Тэднүүс ч гэсэн залхахаасаа өмнө сонирхож

байсан нь эргэлзээгүй Алиа ноён Дайнадэн хамгийн түрүүн сэрээд бусдыгаа өөрийнхөө болхидуу алиа явдлаар сэрээлээ мань эр, нэг нохойн сүүлэнд домбо зүүгээд тавьчилаа . Нөгөө нохой нь ухаангүй айгаад лавиран дотуур тойрон давхихад бусад ноход ульж хуцан араас нь давхилдаж замдаа тааралдсан юм. хумыг дайран унагаж ундуй сундуй болгон үймээн шуугиан, тар няр, пажиг пижиг чимээ гаргалаа . Эр, эмгүй инээлдэн хөхрөлдөж нуднийх нь нулимс дусалж байлаа. Элгээ хөштөл инээж, суусан сандлаасаа унаж тусан шалан дээр хөлбөрч хөхрөлдөх хүн олон харагдана . Яг л жаахан хүүхдүүд гэмээр Дайнадэн ноён з охи осон ухаандаа бүр додийж ийм үхэлгүй мөнхийн бодол толгойдоо яаж орсон тухай байн байн ярин бүр улиг боллоо Бусад улс амьтан аль хэдүйн больчихоод байхад мань эр байн байн пардхийн инээх юм. Энэ ч угаасаа тэр зэргийн алиа марзан хүмүүсийн зан л даа Тун их хөөрч дөвийчхөөд алиа үг хэлнэ гэж дөвчигнөлөө Улиг домог болсон марзан яриаг тийм олон дахин нуршихыг би насандаа тэнд л сонсож билээ. Үдэшлэг концертийн ямар ч алиа шог, алиалагчийн алиных нь ч чигчий хуруунд хүрэхгүй байлаа л даа Өөрөө ертөнцөд мэндлэхээсээ мянга гурван зуун жилийн өмнө тэнд суугаад, хожим бүр жижигхэн жаал байхад минь ч, мянга гурван зуун жил өнгөрчихөөд байсан хэр нь сонсохоос чөмөг хүйт оргидог байсан тийм балай дэмий марзан үгийг, өг хорхойд идүүлсэн новшийг дахин сонсох юутай зэв үүн байв. аа . Шинэ соргог алиа марзан үг зохиох бололцоо нэгэнт үгүй болжээ., хөөрхий гэж би бараг лавтай итгэх дөхөж байлаа. Балар эртний тэр алиа үг сонсоод бүгд л инээлдэж байлаа. Яана гэх вэ? балар эртний алиа үг сонсоод инээдэггүй тийм улс хаа байх вэ ийм байдгий нь би бүр хэдэн зуун жилийн хойно ажиж мэдсэн юм. Харин жинхэнэ алиа хүн нь инээхгүй байсан юм. . Тэр бол нөгөө жаал шүү дээ мань хүн, нөгөө алиа хүнийг дооглон даапаалж байлаа. Ер нь дандаа хүн бүрээр даапаа хийж байлаа. Дайнадэн ноёны алиа марзан үгний ихэнх нь тэнэг мүнхаг үг, бусад нь ёстой нэг тартагтаа тулсан новш гэж хэлдэг чинь тун таарсан мэт санагдаж байна., ер нь балар эртний алиа марзан үгийг геологийн мөчлөгөөр ангилан үзвэл таарна гэж намайг хэлэхэд тэр жаал миний тоглоомын үгийг олигтой ойлгосонгүй, яагаад гэвэл тэр цагт геологийн ухаан гэж гарч ирээгүй байсан юм. хэзээ нэгэн цагт миний бие арван есдүгээр зуундаа эргэж ирдэг юм. бол нийгмийнхээ азыг сорих хүн гэж тэр оносон зүйрлэлийг тэмдэглэлийнхээ дэвтэрт биччихсэн юм. Эд мэдэхгүй хүн эдийн нэр гутаалаа гэхэд тэрнээс болж сайн сайхан юмаа хаяж болохгүй шүү дээ Кэй ноён дахин босож худал үг урсгах үйлдвэрээ удаад мань гайхал намайг үйлдвэрийнхээ зуухны түлшинд хэрэглэж гарсан юм. Тэгэхлээр миний алиалж марзганах хөг нэгмөсөн өнгөрөх нь тэр ид шидийн хүчээр бүтэж өмссөн хүнээ юунд ч дийлдэхгүй болгодог . Яг ийм хувцас өмсдөг тийм зэрлэг бүдүүлэг алс холын нэг оронд надтай хэрхэн тааралдсанаа Кэй ноён ярихдаа тэр ид шидийнх нь хүчийг тарни болон гурван цаг үргэлжилсэн тулалдааны хүчээр устгаж арван гурван баатар эрий нь алж, ван болон ордныхонд энэ гайхаж барамгүй хачин юмыг амьд баримтаар харуулах гэж амий нь үлдээн олзолж ирлээ гэв . Ярихдаа мань эр намайг үлэмж аварга, тэнгэрт тулсан биетэй мангас, соёо савартай махчин гэх мэтээр байн байн дэгс өргөмжлөн нэрлэж байлаа. хараажийн ийм дэмий ярианд цаадуул нь толгой дараалан итгэх бөгөөд миний өчүүхэн биеийг тийнхүү илт хэтрүүлэн ихэсгэж байхад ганц нь ч инээд алдах байтугай яг үнэн юмыг нүдээрээ харж буй юм. шиг жишим ч үгүй чагнан сууна . Намайг зугтан амь зулбах гэж хоёр зуун тохой өндөр модны орой дээр үсрэн гарахад нь үхрийн чинээ том чулуугаар шидэж буулгаад хамаг хавирга сүврэгий нь хугачиж байж Артур вангийн өргөөнд очиж хэргээ шүүлгэх ам тангаргий нь авсан юм. гээд цаазлах л оноосон, цаазаар авах ажлыг 2ний их үдэд товлосон гэж мань эр яриагаа дуусгалаа . Ингэж ярьж байхдаа миний хувь заяаг өчүүхэн төдий ч бодох нь бүү хэл, цаазлахаар то влосон өдөр цагийг хэлэхдээ

залхуу нь хүрсэн янзтай эвшээж байлаа. Тэд намайг ямар аргаар яаж цаазлах тухай маргалдаж эхлэхэд миний бие тун их бачимдаж чухам юу гэж байгааг нь анхааралтай сонсож чадсангүй ид шидтэй хувцас өмссөн болохоор энэ ер алагдахгүй байх гэж сэтгэл түгших хүн олон гарч байлаа. гэтэл миний хувцас маань бэлэн хувцасны мухлагаас арван таван доллараар авсан жирийн л нэг костюм шүү дээ миний бие хичнээн бачимдаж байсан авч нэг зүйлийг ажсан юм. юу гэвэл улс орондоо хамгийн дээгүүр суурь зээлдэг тэр ноёд, хатадын амнаас гарах үг нь хамгийн ээрлэг омгийн зэрлэг удирдагчийн чихэнд чийртэй санагдаж нүүрийг нь улайлгамаар байв. тэдний үг их бүдүүлэг юм. гэхэд дэндүү зөөлдмөөр гэтэл би бол том Жонс, Родерик Рэндом гэх мэтийн адил барилын ном уншсан болохоор Английн хамгийн их сурвалжит язгуур, хатад ноёдын ярьдаг үг нь ч, үйл дд эг авир нь ч зуун жилийн өмнө мөн л тийм зүдэг, балай муухай байсан юм. гэдгийг мэдэж байлаа. гагцхүү манай энэ арван есдүгээр зуунд, Англид, ер нь Европд анхны жинхэнэ хатагтай ноёд бий болсон юм. Хэрэв эрхэм ноён Вальтер Скотт өөрийнхөө хэлэх үгийг зохиолынхоо баатруудын аманд хийж өгөхийн оронд тэднийг яг ярьдгаар нь гаргасан бол ер юу болох байсан бол? Рөвекка Айв еngo, эелдэг хатагтай Ров е на нар ярьдгаараа л ярьж эхэлсэн бол манай үеийн ямар ч тэнүүлчний нүүр түлэгдэнэ шүү юманд учир бий ухамсаргүй бүдүүлэг ааш бол бүдүүлэг юм. бишээ Артур вангийн шадар хүмүүс өөрсдийгөө хүмүүжилгүй улс гэдгээ ухаарахгүй байсан учраас би ч гэсэн ийм гэдгийг тэдэнд огт мэдэгдэхгүй сүрхий заль гаргасандаа миний хувцсыг ид шидтэй гээд сэтгэлийн бөөн зовлонд учирч байсан тэд өвгөн Мерлинийхээ зөвлөх мэргэн үгийг сонсоод дотор нь ихэд онгойв . Тэнэг малууд минь , та нар чинь хувцсы нь тайлах ухаанаа олохгүй яагаад эргүүтээд байна. гэсэн юм. Хагас минутын дотор намайг өлгийтэй хүүхэд шиг шалдаллаа Тэр хүмүүсийн дотор өөрийнхөө нүцгэн шалданд ичиж зовох хүн ганц би л боллоо Тэднүүс намайг нэг муу толгой байцаа үзэж байгаа аятай тал талаас минь харцгаан ямар ч эрээ цээргүй үг хэлэлцэнэ Вангийн хатан Гиневра бусдынхаа нэг адил жишим ч үгүй ажин харж байснаа харин ч бүр насандаа ийм хөл үзээгүй юм байна. гэлээ. тиймэрхүү үгийг магтаал гэж тооцвол миний сонссон магтаал ердөөл тэр дээ Тэгж, тэгж намайг лавирангийн нэг талд, хувцсыг минь нөгөө талд аваачлаа Намайг хав харанхуй, давчуу гянданд хорьж хоолны оронд шавхруу, дэвсгэрийн оронд тэвэр хэртэй ялзмаг сүрэл, хэлцэх хүний оронд хулгана хархаар нөхөр хийхэд хүргэлээ

Тавдугаар бүлэг

УРАМ

Хичнээн аймшигтай, түгшүүртэй байсан боловч даанч их ядарсан учир тэр дорхноо унтчихсан байлаа. Сэрсэн хойноо л их удаан унтсанаа мэдлээ Ямар хачин сонин зүүд зүүдлэв ээ Сая л сэрээгүй бол намайг дүүжилчих юм. уу , галд шатаах, аль эсхүл Яндан дуугартал дуг хийгээдхэе, тэгээд зэвсгийн үйлдвэрлүү явж Гейсулестэй нэгийгээ үзнэ гэж хамгийн түрүүнд бодлоо, Тэгтэл зэвтэй г инж гох харчигнаж, нүдэнд гэрэл нэлсхийн туссан чинь нөгөө жаал Кларенс ирээд зогсож байх юм. би бүр мэл гайхаж амаа антайж арай л амьсгаа багарчихсангүй

- юу вэ? чи энд байгаа юм. уу ? Зүүд дуусаад байхад чи энд байдаг чинь юу вэ? тонил гэхэд угаас хөнгөмсөг тэр эөвхөн инээгээд миний өрөвдмөөр байдалд орсныг даапаалан шоолж гарлаа би цөхрөнгөө барахдаа

- за яана гэх вэ, зүүд минь үргэлжилж л байг би яарахгүй гэлээ.

- юун зүүд?

- юун зүүд? би ер хэзээ ч байгаагүй Артур вангийн өргөөнд байна. гэж зүүдэлж байна., бас гагцхүү миний санааны зохиол чамтай ярьж байна.

- Аа, тийм бий Маргааш чамайг галд шарах бас зүүд үү? Хө хө чи одоо юу гэх нь вэ? ийм үг сонсоод би арга буюу давхий л ээ. Зүүд мөн ч бай, биш ч бай, ямар ч болтугай би тун аягүй байдалд орсноо ухаарч эхэллээ яагаад гэвэл туршлагаас бодоход зарим зүүд үнэн байдалтай тун төстэй байдаг болохоор зүүдэн дундаа галд орно гэдэг зүүд ч гэлээ. тоглоом биш гэж бодоод үнэн худал хэлж байгаад ч болтугай үүнээс ангижрах хэрэгтэй гэж бодлоо. Тэгээд нөгөө зарц залууг

- Ай, Кларенс жаал минь миний ганц нөхөр чи минь над сайн биз дээ, тийм үү, үгүй юу? Намайг энд бүү орхи, эндээс гаргаж аль гэж гуйж эхэллээ

- чи юу гэнээ? Оргохы? энд тэндгүй харуул зогсчихсон байхад, —Тийм байх л даа, үнэн Гэхдээ хэдэн хүн байна., Кларенс аа тийм олон байна. гэж уу? ,, хориод хүн Оргож гарах ямар ч горьдлого байхгүй гээд түр дуугай болсноо шийдсэн янзтай Оргоно гэхэд болохгүй өөр бүр ч сүрхий шалтгаан байна. гэж нэмж хэлэхэд

- Өөр ямар шалтгаан гэж? Ямар, ямар? Ярилцах нь Үгүй, би чадахгүй нь Ердөөч чадахгүй нь

- Жаал минь , юу юм. бэ? юунд царай чинь цайна вэ? Яагаад ингэж чичирнэ вэ?

- Ай, чичрэлгүй яах вэ? би чамд бүгдий нь ярьж өгмөөр л байна. Даан ч

- за, за дажгүй, жаахан зориг гаргаж үз Эр хүн шиг бай гаа д бүгдий нь ярьж аль, сайн жаал минь Ярьж өгөх гэж хүсэх боловч айгаад яаж ч чадахгүй гуйвж байснаа үүд рүү сэм х эн очиж гадагш шагайж харан юмны чимээ чагнаснаа миний дэргэд тулан ирж чихэнд минь жигтэйхэн аймаар юм. шивнэлээ. Тэгснээ нэрий нь нэг дурсахад л амь нас алдах аюултай тийм юм. ярьсан юм. шиг хачин их айн бэмбэгнэлээ

- Мерлин уурандаа тэсрэх дөхөж энэ гянданг тарнидсан болохоор одоо чамтай хамт үүний босгыг алхаж орох тийм бүдүүн зүрхтэй хүн энэ вант улс д аяар алга за би чамд бүгдийг хэлчихлээ, намайг бурхан тэнгэр өршөөх болтугай Чамд сайныг хүссэн өчүүхэн золгүй намайг өршөөж уучлах болтугай Намайг хэлсэн гэж хэлчихвэл би өнгөрөх нь тэр Энэ үгий нь сонсоод миний инээд хүрэв Үнэн голохоо тэгж инээлгүй их удсан байжээ. . Тэгээд Гянданг Мерлин тарнидсан гэнэ ээ? Мерлин гэдэг чинь ер нь юу юм.? Тэр муу сохор зоосны үнэгүй өгөр худалч, чалчаа адсагын илжиг үү дээ хорвоод байхгүй, хамгийн ёстой дэмий балай юм. байхгүй юу? Хамгийн гэнэн, солиотой дэмий балай, аймхай, мунхаг явдлын дотроос энэ чинь л миний бодоход хамгийн тэнэг нь юм. . Тэр ёрын муу Мөрлинг чөтгөр алгадаасай Намайг ярьж дуусаагүй байхад Кларенс сөхрөн унаж аашлах нь айсандаа болж галзуурах нь уу гэмээр байлаа.

- Ай, бүү үзэгд Үг чинь дэндүү хатуу байна. Ингэж яриад байх юм. бол энэ хана нурж дарж алж мэднэ Одоо ийм үг ярихаа боль Түүний тийнхүү айж мэ г дсэн явдлаас болж миний толгойд оновчтой бодол орж ирлээ энд хийн хүмүүс Мерлиний луйварчин заль мэхийг Кларенсын адил үнэн голохоо итгэн биширч тийм их айдаг юм. бол миний мэтийн эрүүл

саруул ухаантай хүн давуу байдлаа яагаад ашиглаж болдоггүй юм. бэ? гэж би бодоод хэрхэх талаар төлөвлөж эхэллээ Тэгээд

- Бос, биеэ барь н ад руу эгцлэн хар би яагаад инээж байгаа учрыг чи мэднэ үү, үгүй юу? Үгүй, мэдэхгүй байна. Бурхан шүтээнээ бодож дахин тийм үг бүү цухуйлгаач

- Яагаад инээд хүр ч буй учрыг хэлж өгье юу гэвэл би өөрөө ид шид шүү дээ

- чи юу? тийм гэж огт бодоогүй байсан тэр жаал мэл гайхаад надаас давхийн зайлж гагалзлаа ийм юм. сонсоно гэж тэр бодоогүй нь илт Намайг ер бусаар бишрэн хүндлэх сэтгэл нэн даруй төрсний нь би ажлаа Тэр галзуугийн газар худалч хүнээс ямар ч баталгаа баримт сэлт шаарддаггүй, яагаад гэвэл худалчийн хэлсэн үг бүрт бүгд итгэдэг байна.

- Мерлинг мэддэг болоод долоон зуун жил болж байна. Тэр чинь

- долоон зуу

- Яриан дундуур битгий юм. асуу Тэр чинь арван гурван удаа үхэж, арван гурван удаа Смит, Жонс, Робинсон, Жексон, Питерс, Хаскинс, Мерлингэх мэт өөр өөрнэртэй хувилж байсан юм. . Хувилах бүрдээ шинэ нэртэй Гурван зуун жилийн өмнө би түүнтэй Мис оронд таван зуун жилийн өмнө Энэтхэгт тааралдсан Намайг хаана ч очсон зам дээр минь хөндөлдөх шиг дандаа тааралдсаар байгаад намайг бүр залхаачихсан юм. Муу илбэч л дээ Хэдхэн улиг болсон хуучин мэхтэй, тэрнээсээ цааш ахисан юм. нэг ч үгүй, ахих үгүй л дээ Хөдөө гадаа ганц нэг амьтныг дөнгөх байх Харин илбэчингэж ялангуяа жинхэнэ илбэчний дэргэд сайрхах юм.гүй хүн, худалч юм. болохоороо л тэгж ичгүүргүй дэмийрч мэднэ Кларенс , дандаа сайн нөхрийн ёсоор ханадаг байсан чи ч бас Надтай тийм янзаар хандах ёстой Надад чи тус бол чи ванд намайг жинхэнэ ид шидтэн, ид шидтэнгүүдийн удирдагч, агуу их чадалтан, одоо тэр чинь их гал тарьж манайхныг үзэх ч үсгүй болгох гэж сэмхэн бэлтгэж байна. . Кэй ноёны үгэнд орох юм. бол үнсгүй хийснэ гээд хэлчих чи ванд намайг ингэж байна. гэж үгий минь дамжуулах уу? Тэр хөөрхий жаал над юу гэж хэлэхээ ч бараг мэдэхгүй, даанч их айж, бажгадан тэвдэж байх нь үнэхээр өрөвдөлтэй гэвч намайг сайн нөхрийн журмыг алдахгүй, хэзээ ч илбэ жилбэ миний эсрэг хэрэглэхгүй гэсэн ам тангаргаа өг гэж надаас шаардаад өөрөө миний гуйсныг ёсоор болгоё гэлээ. . Тэгээд толгой, нь эргэж хөл дээрээ тогтож чадахгүй байгаа аятай гараараа хана тулсаар гарч одлоо . Тун болгоомжгүй юм. хийснээ би төдхөн ухаарав Тэр жаал уужирч, ухаан сэхээ гүйцэд орсон хойноо тийм хүчирхэг илбэчин байж гяндангаас гарах гэж над мэтийн жаалыг гуйдаг нь хачин юм. гэж гайхан, юу юу болсныг эрэгцүүлэн, зүйрлэн бодсоор намайг худалч амьтан гэж ойлгож болох байлаа. тийм тэнэг юм. хийсэндээ би харамсаж бүхэл цагийн турш өөрийгөө байдаг муу үгээр хараан зүхэж билээ. гэвч тэр малууд бол юмыг бодох гэж байхгүй, нэг юмыг нөгөөтэй нь холбож үзнэ гэж байхгүй, зүйрлэх гэж байхгүй, тэдний яриа хөөрөөг санаад үзсэн ч тэдэнд аливаа үг ярианы утга учир согогтой байгаа эсэ хийг ялгах ухаан огт байхгүй шүү дээ гэж над гэнэт санагдан дотор онгойх шиг боллоо Нэг юм.ан дээр дотор онгойвч нөгөө талаар сэтгэл зовох гэдэг бол хорвоогийн жам л даа Бас нэг алдаа хийснээ би ухаарлаа . Тэр жаалыг эзэн хаан уруу нь жигтэйхэн айлган сүрдүүлсэн үгтэй явуулчихжээ . Очоод намайг энд гав ганцаар суухдаа аймшигт гал зовлон бэлдэж байна. гэж сүртэй ярина . Гайхалтай хачин юманд итгэдэг улс гэдэг чинь гайхалтай хачин юм. хийхээс ч буцдаггүй шүү дээ Намайг Ямар нэгэн гайхалтай юм. хийж үзүүлээч гэж гуйвал яана Жишээ нь намайг ямар гай гамшиг буулгахаар

зэхэж байна. даа гэвэл юу гэх билээ.? Нэгэнт алдаа хийсэн болохоор тийм юм. асууж гэж хариулах нэг юм. урьдаас бодож боловсруулах хэрэгтэй боллоо Яах вэ? Цаг хожихын тулд тэдэнд юу гэж хэлэх вэ? Ингэж бодохоос дахиад л санаа зовж эхэллээ , хачин их зовж эхэллээ . Хөлийн чимээ гарлаа и рж байна., янз нь Бодоход ганц хором үлджээ б элээн б одчихлоо Дажгүй н ар хиртэлт намайг аварна . Колумб ч билүү, Коргес билүү тиймэрхүү л хүмүүсийн нэг нь зэрлэгүүдэд баригдчихаад нар хиртэх үзэгдлийг завшин амь мултарсан байдаг даа тэгээд дотор минь жаал онгойж, амь зулбах найдлага төрөв . Тэр үзэгдэл миний аминд орно, яагаад гэвэл би түүнийг тэднээс бараг мянган жилээр түрүүлж завших учраас намайг дууриалаа гэж хэн ч зэмлэхгүй билээ. . Тэгэхлээр надад айх юм. алга Кларенс унжийж уруу царайлан орж ирээд,

- би чиний үгийг өөрийнхөө ван эзэнд бушуухан хүргэхэд тэр намайг нэн даруй дуудууллаа . Ван үхтлээ айж, чамайг нэн даруй суллан хээнцэр гоё хувцаслан, зохих тохилог орон гэрт оруул гэж зарлиг буулгах гэтэл Мерлин орж ирээд хамаг юм. биш болгож орхилоо чамайг хэлж буй үгийнхээ учрыг ч үл ойлгох ухаангүй тэнэг, тэгж занаж байгаа нь маанаг бөгөөд хоосон сагсуурал гэлээ. Тэр хоёр баахан маргасны эцэст Мерлин ёжтойхон хэлэхдээ Биднийг яаж сүйтгэнэ гэдгээ яагаад хэлүүлсэнгүй вэ? Яагаад гэвэл тэгж хорлож ч чадахгүй юм. чинь гээд вангийн амыг тагличихлаа . Ван түүний урдаас юу ч гэж хэлж чадахгүй байна. гэвч ван аргагүйн эрхээр чамайг эвгүй байдалд байлгах боллоо, харин бидэнд хэдийд ямар гээч гал зовлон зэхэж буйгаа нэрлэж өгнө үү? гэж гуйж байна. за, чи минь түргэлж үз Удвал хар то лгойд чинь учрах аюул хоёр дахин, гурав дахин ч нэмэгдэнэ шүү . Аяа бидэнд буулгах тэр гал зовлонгоо нэрлэж үз, чи минь би хэлүүлэх үгээ сонсох хүний чихэнд сүртэй болгохын тулд бодсоор нэлээд удсанаа

- би энэ нүхэнд суугаад хэдий хугацаа өнгөрөв?

- Чамайг энд өчигдөр орой оруулсан Одоо өглөөний есөн цаг

- Аа тийм үү би мөн нойроо ханатал унтжээ . Одоо өглөөний есөн цаг гэнэ ээ Шөнө дунд шиг л харанхуй байна шүү дээ Тэгвэл өнөөдөр чинь арван хоёрон уу ?

- тийм ээ, арван хоёрон

- Маргааш намайг амьдаар шатаах гэл үү? Жаал энэ үгийг сонсоод давхийв

- хэдэн цагт билээ.

- Яг их үдэд за тийм байж Вандаа хэлэх угий чинь хэлж өгье гээд би жаалын өмнө тун ёозгүй муухай байдалтай удаан гэгч нь зогссоноо, бүдүүн, жигд, ерийн дуугаар эхлээд дуугаа улам чангаруулан бүх тэнгэр ниргэх адил тачигнуулан насандаа хэзээ ч гаргаж үзээгүй сүрлэг, жавхлант дуу хоолойгоор, сэтгэл туйлын өрнүүн байдлаар ингэж хэллээ Ван дээрээ очиж намайг ингэж байна. гэж хэл Маргааш их үдэд би нарыг унтрааж, үүрд гийх гэрэлгүй, бүх ертөнцийг хав харанхуй шөнө болгож, газрын өвс ургамал, гэрэл дулаангүйдэн үхэж, хүн төрөлхтөн, ганц ч хүн үлдэлгүй бүгд турж үхэх болно. Өнөөх жаал айн ухаан алдсан тул би түүнийг өөрөө босго давуулж хуяг нарт өгөөд гяндандаа буцаж орлоо

Зургадугаар бүлэг

НАР ХИРТЭВ

чив чимээгүй, хав харанхуйн дотор би толгойгоо ажиллуулж гарлаа Аливаа юмыг мэднэ гэдэг бол тийм их даамай юм. биш, харин түүнийг бодитой төсөөлөхөд огт өмнөө то в тодорхой болдог ажээ. хүнийг зүрх рүү нь хутга шаачхаж гэнэ гэж сураг сонсох, өөрөө тэгж байхыг нь нүдээр харах хоёр бол огт өөр зүйл юм. би чив чимээгүй, хав харанхуйн дотор үхлийн аюулд орсноо бодохоос эл бодол улам улам батжин, тийм аюул байна. гэх бодол хамаг судас шөрмөст тоо тоогоор нэвтэрч чөмөг нэвт хөрөх шиг болж байлаа. гэвч хүний сэтгэлийн халуун хүйтний хэмжүүр дэх мөнгөн ус унаж ирснээ дахин өгсдөг тийм ёсыг өгөөмөр байгайь маань заяасан байна. найдвар бий болж, найдварын хамт сэтгэл сэргэн, хүн гэгч амьтан маань туслах боломж байвал өөрөө өөртөөтус болж эхэлдэг байна. . Төдхөн сэтгэл минь сэргэж, нар хиртэх намайг аварна, намайг энэ вант улсын дотор хамгийн хүчирхэг хүн болгоно гэж амандаа хэллээ . Халуун хүйтний минь хэмжүүрийн мөнгөн ус дээш ухасхийж, сэтгэлийн бүхий л түгшээ замхран алга болов. Над шиг аз завшаантай хүн хорвоод байхгүй мэт санагдав Тэгээд маргааш л бушуухан болоосой хэмээн хүлээж ядах болж, өөрийнхөө агуу их ялалтанд жаргалаа эдлэн, бүх хүн ардын гайхан бишрэхий нь үзэж магнай тэнэгэр, маш жаргалтай болно. гэхээс шүлс гоожиж байлаа. Түүнээс гадна олз омгийн талаас нь аваад үзсэн ч энэ явдал над а д багагүй олз өгөх байлаа. Ингэх зуур сэтгэл санааны үзүүрт шив шинэхэн таавар төрж эхлэв . Тэр мухар сүсэгтэй хүмүүс ямаршуу аюулд учрах гэж буйгаа сонсмогц айж сандран арга зүйг эрэх болно. гэдэгт миний бие бараг баттай итгэж байлаа. Хүний хөлийн чимээ гарахад аргадах гэж ирлээ дээ за яах вэ, ашигтай санагдвал зөвшөөрч л орхиё ашиггүй санагдвал өөрийнхөөрөө зүтгэсээр эхэлсэн тоглоомоо эцэст нь хүргэдэг хэрэг ээ гэж би бодлоо үүд нээгдэж цэргүүд гянданд орж ирлээ Дарга нь

- Гал бэлэн Явья гэлээ. Галы? Хамаг бие минь алцарч хөл минь гуйвж арай л унасангүй Амьсгаа давчдан багтарч үхмээр санагдлаа гэвч биеэ дайчлан ялимгүй сэхээ авч

- Та нар эндүүрч байна. м аргааш цаазална гэсэн шүү дээ гэв

- Тушаал өөрчлөгдөж өнөөдөр болгосон т үргэл, түргэл миний үхэл иржээ . Одоо юу ч аминд минь орохоосоо өнгөрч, би ч биеэ барьж чадахыг больж, сүхээр цохиулсан юм. шиг ухаан балартаж байна. . Нэг булангаас нөгөө булан уруу үсчин галзуу хүн шиг аашилж байлаа. цэргүүд намайг барьж аван газар доогуурхи урт хонгилоор чирсээр дээр гаргаж өдрийн хурц гэрэлтэй золгууллаа шилтгээний өргөн цэлгэр хашаанд орж ирмэгц нүдэнд юм. юм.наас түрүү хашааны тэг дунд ёрдойх багана, дэргэдэх хуурай мөчир, лам гурав харагдахад бие агзасхийв . Дөрвөн зүгт эгнэн жирийсэн суудлууд дээр эрээн мяраан хувцастай хүмүүс пиг дүүрэн бөгөөд ван, хатан хоёр ширээн дээрээ залран суусан нь олны дотроос онцгой харагдлаа миний нүдэнд хамгийн түрүү тэр бүгд туссан юм. Дараа нь хаанаас ч үү мэд Кларенс миний хажууд ирчихсэн баяр баясгалант нүдээр харж миний чихэнд

- Цаазлах ажлыг өнөөдөр болго гэж би эднийг ятгасан юм. . Үгэнд орж өгөхгүй мөн ч их ядсан шүү . Чамайг ямар гал тарих гэж байгааг чинь хэлмэгц эд нар хулчийгаад явчихлаар нь одоохон л янзлахгүй бол болохгүй гээд байлаа. Маргааш л ид шид чинь бүрэн боловсорч илбэ жилбэ чинь хүчээ авч гэрэлт нар, гэгээн хорвоог сөнөөх юмыг наана нь амжиж өнөөдөр устгавал таарна гэж би эднүүсийг бараг бүгдэд шивнэж байж ийм болголоо . Ингэж би худал үг зохиогоод хэлчихсэн чинь эднүүс ухаан алдтлаа айж байсан болохоор чухам тэнгэр бурхан өөрөө аврах ийм аргыг бидэнд илгээлээ гэж миний зохихон үгийг уу хайн тас хүлээж авах нь тэр э хлээд би өөрөө баярлан инээдээ барьж чадахгүй байлаа., дараа нь бурхан өөрийнхөө бүтээсэн өчүүхэн амьтдын дотроос чамайг аюулаас аврах зэвсгийг олдог байна. гэж түүндээ

бишрэн залбирлаа хичнээн их аз завшаантай юм. болов. оо чи нарыг үүрд мөнх унтраах хэрэггүй, үүнийг бүү мартаарай жаахан харанхуй болгоод, жаахан бүдэгрүүлээд дахин хуучин хэвээр нь болгочих Ингэвэл болох нь тэр Тэд намайг худал хэлж дээ гэж өөрийн эрхгүй бодно, тэгээд ялимгүй харанхуй болмогц айгаад ухаан алдана Нар дахин мандахад эднүүс чамайг чөлөөлж тахин бишрэх болно. Одоо ялах үйлсээ хий Харин, хайрт нөхөр минь миний гуйсныг битгий мартаарай, ая буянт наранд хор битгий хүргээрэй Үнэнч нөхөр болсон намайгаа бодож битгий чингээрэй сэтгэлийн гасланд автсан миний бие нарыг хайрлана гэж арай ядан хэлээд жаалын нүдэнд үгээр илэрхийлье гэхэд үг дугам гүн хайр талархал тодроход сайн санаат тэнэг явдлаараа намайг сүйдлээд үхлийн амсар дээр аваачсан түүнийгээ харааж зүхэх ч зүрх хүрсэнгүй цэргүүд намайг хашаан дотуур туун явахад огт чимээ аниргүй байх нь хэрэв миний нүд боолттой байсан бол би эгнэн ярайж суусан дөрвөн мянган хүний дундуур биш харин эзгүй цөлийн дундуур явж байна. даа гэж бодохсон Тэр үй олон хүний царай нь зэвхий дааж, нүдэнд нь айдас илрэн эгээ л шавар баримал шиг огт хөдөлгөөнгүй дүнсийлцэнэ . Намайг баганад хүлж, миний өвдөг, шагай, гуя, их биеийг хуурай мөчрөөр хучиж дуусан дуустал тэд тийнхүү огт чимээгүй байж гартаа дүрэлээн асах бамбартай хүн хөлд ирээд бөхийхөд тэднүүс амьсгаа ч авахаа больсон мэт таг болсноо хүзүү сунган урагшаа ухалзан байснаа өөрийн эрхгүй суудлаасаа босцгоов . Лам миний толгойг хоёр гараараа нэг үрээд, хөх тэнгэр лүү ширтэж латинаар нэг юм. бувтнана Нэлээд удаан бувтнаж байгаад гэнэт дуугай болов. би хэдэн агшин өнгөртөл дуугай хүлээж байснаа ламын нүүр лүү ширтэн харахад лам багтраад явчлаа сэтгэлийн нэг догдлолд автсан тэр олон хүн нэгэн зэрэг дэрхийн босож тэнгэр өөд ширтлээ би ч харлаа, нар хиртэж эхэллээв шүү сэтгэл сэргэж урам бадрал . Нар зээрэнцэх хар гархинаа улам улам үнхэгдэхүйд зүрхний түг түг тонгочих нь нэмэгдсээр авай Харцас олон, хувраг нар зогссон газраа хадагдсан юм. шиг хөшин зогсоод тэнгэр ширтэнэ . Одоо л над уруу харна гэдгий нь би мэдэж байлаа. харахад нь би яахаа зэхээд байсан юм. . Энэ биендээ эрхэм ихэмсэг байдлыг аль болохоор их болгож нарны зүг гараа сарвайлаа . Сүртэй ч юм. болсон шүү Үй олон хүн дагжин чичирч байна. хоёр хүний дуу ар араасаа залган сонсдох нь

- Шатаа

- Шатааж болохгүй гэв Эхнийх нь Мерлиний, дараачийнх нь вангийн үг байлаа. Мерлин суудлаасаа огло харайн босов Өөрөө түүдэг шатаах гэсэн бололтой Тэгэхэд нь би

- Бүү хөдөл миний зөвшөөрөлгүй хөдөлсөн хэнийг ч, ван ч бай хэн ч бай, тэнгэрийн гялбаагаар цохиулан үнсэн товрог болгоно шүү гэлээ. Үй олон хүн бүгд үг дуугүй эргэн суулаа Тэгнэ гэдгий нь би мэдэж байсан юм. Мерлин л ганцаараа хэдэн хормын хэртэй яая даа гэх адил тээнэгэл з эн зогслоо би ч түүнийг түгшин харж байв. Тэгээд суухад нь дотор онгойлоо . Одоо би айдагүйгээ авдартаа хий л ээ Ван хэлэхдээ

- Сайн Сайхан ноён минь , энэ аймшигт гай гамшгийг зогсоон өршөөгтүн чиний увьдас маргааш л төгс хүчээ олох юм. гэж бид сонссон болов.ч,гэхэд миний бие

- Танд худал хэлжээ гэх гээ юу ? Таных зөв гэлээ. Энэ үг туйлын их нөлөө үзүүлж хүмүүс бүгд вандаа залбиран гал зовлонг зогсоолгохын тулд энэ хүнд юу дуртайгий нь өгч соёрх хэмээн гуйцгаав . Ван дуртай зөвшөөрч Эрхэм ноёнтон, юу хүссэнээ хэлтүгэй миний вант улсын хагасы нь авья гэсэн ч өгөх байна., гагцхүү энэ гай гамшгаа зогсоож нарыг хайрлан өршөөгөөч гэв Одоо би тэднийг нэгэнт дийлсэн байлаа. юу авч өгөх талаар даруй тохиролцож

болох байсан боловч нар хиртэлт үргэлжилсээр байсан гул би ямар болиулж чадах биш Тэгээд над бодох хугацаа хэрэгтэй гэв Ван, намайг бодь сэтгэлтэн ноён та удаан бодох уу ? Улам л харанхуй болоод байна шүү дээ . Та чухам хэдий удаан бодох вэ, хэлж соёрхохгүй юү гэхэд нь би нэг их удахгүй, хагас цаг юм. уу , цагаас хэтрэхгүй гэлээ. их удах нь гэж галзуу мэт хашгиралдах дуун гаравч хиртэлт хэдийчинээ хугацаатай үргэлжилснийг би санахгүй байсан болохоор бага зэрэг эрэгцүүлэн бодох хэрэгтэй байсан юм. . Нар хиртэлтийн хувьд олигтой юм. болсонгүй, үүнд би нэлээд зовлоо миний бодсон тэр нар хиртэлт биш байх юм. бол би үнэхээр зургадугаар зуунд шилжиж үү, аль эсвэл зүүднээс цаашгүй хоосон юм. уу гэдгийг яаж мэдэх билээ.? Зүүд л байгаасай, бурхан минь Над горьдлого төрлөө Нөгөө жаал өдөр сар будлиагүй, өнөөдөр үнэхээр хорин бол, би зургадугаар зуунд байсаа биш болно. би сэтгэл үймрэн ламын ханцуйнаас шүүрэн авч өнөөдөр хэдний өдөр вэ? гэж асуулаа Ай лүд Өнөөдөр хорин нэгэн гэсэн хариу сонсоход бие агзасхийж билээ. Андуураагүй биз гэж дахин асуухад өнөөдөр хорин нэгэн гэдэгт огт эргэлзэхгүй байв. Тийнхүү нөгөө жаал маань дахиад л будлиулсан байлаа. Надаас холгүй байсан элсэн цагийг ажихад нар хиртэх цагтаа яг хиртэж эхэлсэн юм. би Артур вангийн хашаанд байгаа маань үнэхээр үнэн байсан учир энэ байдлаа ашиглан аль болох их олз олохын төлөө чармайх хэрэгтэй байлаа. харанхуй өтгөрөх тусам хүмүүс бачимдах нь ихсэж би

- Эзэнтэн, би бүгдийг бодож үзлээ би таныг хашраахын тулд харанхуйн тархахад саад хийхгүй, бүх ертөнц харанхуйлна . Нарыг үүрд унтраах уу , буцааж авчрах уу гэдэг танаас л шалтгаална Та өөрийн төр улсдаа эрх дархаа төгс эзэмшсэн бүрэн эрхт ван хэвээр үлдэж, харин миний биеийг өөрийнхөө гүйцэтгэх засгийн бүрэн эрхт ээлжгүй сайдаар томилж хөлсөнд минь төр улсад миний оруулах илүүц орлогын нэг хувийг өгвөөс хүрэлцээ муутай байлаа. ч би нэмэр гуйхгүй байх тийм бол зол тавих байна. . Таны сана анд таарах уу гэхэд алга нижигнүүлэн таших чимээ гарч ван хүлээсийн тайлж сулла энд буй эгэл харцас, язгуурт тайж, баян ядуус бүгдээр энэ хүнд хүндэтгэлийг өргөгтүн, учир нь энэ хүн Энэ мөчөөс эхлэн миний баруун гарын сайд болж, засгийн бүх эрхийг эзэмшиж ван хааны ширээний хамгийн дээд суудалд гарах болно. Энэ айсуу харанхуй шөнийг сарниаж бидэнд гэрэл гэгээ, аз жаргал, бүх хорвоог буцаан өгч соёрх хэмээн хашгирах сонсоглоо . Ерийн хүнийг олны өмнө ингэж гутаан доромжилсон бол бас гайгүй Вангийн сайд шалдан байхыг харсан хүмүүс, мөн түүнийг доромжлуулсныхаа хариу авахыг эс харвал ван өөрөөл нүгэлд унаж болох юм. Хувцас хүнары минь аваад ир гэтэл ван Хэрэггүй, одоо чамд тийм хувцас таарахгүй Өөр хувцас авчирч өг хунтайж шиг хувцаслаатах гэлээ. санас а н маань сэтгэлчлэн бүтэж эхэллээ Нарыг бүтэн хиртэхээс нь өмнө яаж ийн цаг уях хэрэгтэй байлаа. Тэгэхгүй бол харанхуйг арилгаж аль гэнэ, би чадахгүй юм. чинь хэцүү шүү дээ . Хувцас авчруулах гэсэн маань цаг уясан хэрэг, гэхдээ бас л багадлаа Дахиад нэг арга сүвэгчилж эхэллээ Ван сэтгэлийнхээ цочир хөдөлпөөнөөр гаргасан шийдээ гэнэт өөрчлөхөд хүрч магадгүй гэж болгоомжилж байгаа учраас дахин нэлээд харанхуй болгоод дараа нь замхраая гэхэд энэ болзлыг ван ч бусад нь таашаасангүй, гэвч би шаасан гадас шиг хөдөлж өгсөнгүй . Намайг тийнхүү зургадугаар зууны үеийн тойвтой хувцас өмсөх гэж зовж байх зуур улам улам харанхуйлан, пад харанхуйлах дөхөж байлаа., тэгсээр тас харанхуй болж, тэнгэрт од мичид гялалзан, шөнө дүлийн сэрүүн салхи сэвэлээн эхлэхэд өнөөх олон хүн айж сандарсандаа улын хуцах адил дуу тавьж эхлэв нар бүтэн хиртэх нь тэр Бусад бүх хүн бачимдан багтрах дөхөж байхад би ганцаар баярлаж байсан маань аргагүй билээ.

- Ван нэгэнт дуугүй байгаа хойно хэлсэн үгэндээ бүрэн эзэн болно. гэсэн хэрэг гэж би

хэлээд гараа ,тэр лүү хэдэн агшин өмгөртөл сарвайлгаж байснаа болох сүрлэг жавхлантайгаар Илбэ жилбэ сарнитугай хор га й тарилгүй арилтугай гэхэд эргэн тойрон хав харанхуй чив чимээгүй болов. Харанхуйн дундаас нар цухуйхад тэр олон хүн чанга чангаар хашигралдан намайг сайн сайхнаар ерөөн хязгааргүй их талархав Өрөөн талархагчдаас Кларенс ч хоцроогүй нь мэдээж хэрэг

Д ол ду гаар бүлэг

МЕРЛиний цамхаг

би төрийнх нь бүх эрхийг гартаа авч вант улсын дотор вангийн дараа л орох хоёрдугаар зэргийн их хүн боллоо хүн амьтан над сүйд болдог боллоо Өмсдөг хувцас маань дан торго, хилэн, алтан саатай хоргой болохоор гоё ганган ч гэж хачин, эвгүй ч гэж тамтаггүй Яваандаа хувцас хүнартаа дасах биз гэж бодож байлаа. Вангийн өрөө лавиранг эс оруулбал би тэр шилтгээний хамгийн шилдэг хэдэн тасалгааг эзлэн суусан юм. Ханы нь алаг эрээн торгоор хулджээ Харин чулуун шалан дээр нь хивсний оронд гараар сүлжсэн хийц тун муутай, бас муруй саруй сийрс дэвссэн байна. . Үнэнийг хэлэхэд хүний тух тохид таарсан юм. бараг үгүй байлаа. Аж төрөхөд аятайхан чимэг, тохь тухтай болгодог тийм жижиг сажиг юмны тухай би ярьж байгаа юм шүү дээ Ур муутай сийлбэрээр чимсэн асар то м царсан сандал нь овоо аятайхан ч гэсэн ганц сандал сайхан байгаад юу базаах билээ. . Хувинтай усанд харснаас өөрцгүй нэг муу төмөр толиноос өөр толь, саван, чүдэнз гэх мэт огт үгүй Даатгалын пүүсний ганц ч эрээн зарлал гэмээр юм. хананд харагдахгүй Эрээн мяраан зарлалд олон жилийн турш дассан болохоор тэр талаар учры нь нэг их гүнзгий мэдэхгүй ч гэхнээ урлагт дурлах хорхой мах цусанд минь шингэж энэ өчүүхэн биений м а ань салшгүй нэг хэсэг мэт болсон байлаа. ихэмсэг ганган хээнцэрдүү боловч үхээнц байдалтай тэр хана туургы нь харахаас эх нутгаа санан мөрөөдөх сэтгэл аргагүй төрж зүүн Харт фордод байдаг байшингаа санагалзлаа Уг нь нэг их гойдгүй боловч өрөө бүрт нь даатгалын зарлал юм. уу , наана хэлэхэд гурван өнгөөр хэвлэсэн э нэ гэрийн өлзий бадартугай гэсэн е рөөл харагдана шүү дээ . Манай зочны өрөөнд эрээн өнгөт зарлал ес байдагсан гэтэл энд сайд хүний ёслолын өрөөний хананд ганц ч ширхэг зураг байхгүй, харин хамаг будаг, хэлбэр дүрсий нь бүгд буруу гажуу болгосон, гараар нэхэж хийсэн юм. хатгамалдсан юм. уу хэд хэдэн газраа нө хөөстэй аль нь ч мэдэгдэхгүй хөнжлийн дайтай нэг юм. байлаа. том гэдэг нь цадигүй, Рафаэль ч гэсэн Хэмптонкортын алдарт картон гэж нэрлэсэн өнөөх аймшигтай зургуудаа зурсны дараа ч түүнийг томхон болгож зур ж чадахгүй байсан билээ. Рафаэль лут хүн шүү дээ . Манайд түүний зурсан хэд хэдэн зураг нь байсан Нэг нь загас барих сайхан гэсэн зураг Тэрүүн дээрээ өөрөө гайхамшиг үйлдэх гэж хэт цэцэрхсэн байдаг . Нэг муу завинд суусан гурван эр хүнийг дүрслэхдээ тэр завинд нь нэг л нохой нэмж орвол хөмөрчихөөр болсон тийм зураг байлаа. Рафаэлийн зурсан зураг шинэ сэргэг, зохиомол биш байдаг болохоор би хэзээд сэтгэл хөрөн судалдаг байсан юм. Бүх шилтгээний хэмжээгээр ганц ч хонх ганц ч ярих утас байхгүй Над зарц гоцго олныг өгсөн Жижүүр хийж байгаа нь гэж үүдний өрөөгөөр дүүрэн шахуу олон юм. байх хирнээ дуудах хэрэг болж гэхэд би өөрөөл босож очно Халуун хий, лаа аль нь ч байхгүй Тавилгатай өрөөнд хоолонд өгдөг тосоор тэг дунд нь хүртэл дүүргэсэн гуулин гүц, хайлмаг тосон дунд шатах даавуун алчуур ийм юмыг дэн гэдэг байв. тийм гүц ханаар олон хатгасан нь харанхуйг замхраах зорилготой боловч үнэндээ улам ч харанхуй болгодог шиг санагдана . Үдэш оройн цагаар гадагш гарвал зарц гоцго нар бамбар барин газарч ил на . Ном, ү з эг, цаас, б эх аль нь ч байхгүй ц онх гэж нэрлэдэг нүхнүүд нь шилгүй Шил гэгч хэрэг багатай зүйл шиг санагдавч

байхгүй газраа болохоор хэрэгтэй л зүйл байдаг юм. Гэсэн ч элс э н чихар, кофе, т а мхи, ца
йгүй байна. гэдэг юмны адаг Робинзон Крузотой адилавар байлаа. над гэрийн т эжээмэл
амьт ан л хань болж байсан болох оор амьдралыг ялимгүй дөм өг болгох ын тулд юм.
санаачлан зохиох, бодож олох, б уй болгох тархи гар хуруугаа байнга ажиллуулах хэрэгтэй
байлаа. хүн б үхэ н намайг ер бишийн их сонирхон шохоорхох нь лав сайн биш гэж би
анхандаа баахан зовдог байв. хүн болгон л намайг нүд хужирлах гээд байгаа юм. шиг
санагддаг байсан юм. Нар хиртэх үед Британ и , даяар амин сүнсээ зайлтал, айн тэвдэж,
ертөнцийн мөхөл ингээд ирдэг байж хэмээн уйлан орлилдох хүмүүс сүм дуган, мөргөлийн
газраар дүүрч улс орны өнцөг булан нэлдээ хязгааргүй бачимдан мэгдэж байсан юм. санжээ,
хожим нь Артур вангийн өргөөнд одоо ам ь дран суудаг харь нутгийн нэг их хүчирхэг эр тийм
аймшиг т ай гамшиг буулгахыг завдсан бөгөөд тэр хүн бол нарыг дуртай цагтаа чүдэнз шиг
унтрааж чаддаг, тэгээд унтраах гэхэд нь хүмүүс аргадан гуйхад тэр илбэ жилбээ буцааж
хорвоо ертөнцийг мөхлөөс, хүн ардыг үхлээс аварсан юм. гэж тэд сонсжээ . ийм юманд
үнэмшсэн, үнэмшихдээ ямар ч сэжиггүй үнэмшсэн Британ орны хэн ч атугай миний барааг
өөрийн нүдээр олж харахын тулд тавин бээр газар ч явган явахаас халшрахгүй байсан юм
шүү хүн бүрийн ярьдаг юм нь миний тухай болж, өөр хэнийг ч ярихаа больж, вангаа ч нэг их
шохоорхон сонирхохгүй, тоох нь бага болсон байв. хорин дөрвөн цаг өнгөрөв үү, үгүй юу
төлөөлөгчид цувж гарах нь тэр Бүхэл хоёр долоо хоног өдөр алгасалгүй цувдаг хэрэг шүү Ойр
хавийн гацаа тосгоноор хүн хар пиг дүүрэн гэнэ миний бие тэр олон б и шрэн хүндэтгэх
олонд бараагаа харуулах гэж ганц хоногт л арван хоёр удаа гардаг байлаа. Ингэхэд цаг
гарздаж бие их чилэх боловч нөгөө талаар бодвол, тэгж хүн ардаар бишрүүлэн хүрээлүүлж
нэр цууд гарна гэдэг тун сайхан байлаа. Өгөр өвгөн Мерлин атаархан багтарч үхэх шахсан
амьтан явахы нь харах над тун таатай байлаа. Надаас гары н ү с г ээ зурж өгөөч гэж гуйх хүн
ганц ч гарахгүйд нь би гай х даг байлаа. Тэгээд энэ тухай Кларенсэд дурдсан чинь түүнд
гарын үсэг гэж юу болохыг тайлбарлаж өгөхөөс өөр аргагүй болж билээ. Тэгсэн чинь тэрний
хэлснээр тэр улсад хэдхэн хар ламаас бусад нь уншиж бичиж чадах хүн ганц ч байдаггүй юм.
гэнэ мөн сүрхий улс орон байгаа биз Бас нэг зүйлд миний сэтгэл баахан түгшдэг юм. Тэр
олон хүн надаас шинэ гайхалтай илбэ жилбийн хүч олж үзэхийг шүлс залгин хүлээдэг байв.
арга үгүй юм даа хол газар явж гэртээ ирээд тэнгэрийн нарыг за хирдаг хүнийг нүлээрээ
үзлээ гэж гайхуулан ярьж айл хөршийнхөндөө биеэ товойлгох, ялангуяа гайхамшгийг бүтээж
байхыг нь хоёр нүдээрээ үзлээ гэж ярьсаар харын гэм бүр ч даамай юм. болно. шүү дээ
Намайг үзэх гэж бүр алс хол нутгийн хүмүүс ч ирэх нь гарцаагүй Ер нь намайг зүгээр суулгах
ян з гүй Сар хиртэх дөхөж байсан цаг би чухам хэдний өдөр, хэдэн цагийн алдад хиртэхийн
нь яг мэдэж байсан, гэтэл сар хиртэх хүртэл бас тун их хугацаа хоёр жил үлдээд байсан юм.
зах зээл дээр нар, сар хиртэхийн шэард лага тун их байсан тэр үед би тэр үзэгдлийг
ойртуулах бололцоо байдагсан бол одоо л ашигла х ын тулд мөн ч их юм. өгөх байлаа. Хэнд ч
ашиг олз оруулахгүй, дэмий үед болно. гэж бодохоос харуусалтай байж билээ. Хэрэв нэг сар
орчмын дараа сар хиртэх байсан бол би түүнийг урьдчилан, хөлөөр нь ч гэх юм. уу даа,
худалдчихаж болох байлаа. гэтэл хирт эх хугацаа тийм хол байгаа цатт ямар ч нэмэр алга, би
тэр тухай бодохоо ч больсон юм. гэтэл Мерл и н өвгөн ард түмний дотор н амайг сэмхэн
муухэлж байна. гэж Кларенс над хэллээ Намайг зал ь хай луйвар чи н, ямар ч гайхмаар юм.
хийж чаддаггүй дээ л юу ч үзүүлэхгүй байгаа юм. гэсэн цуу үг тарааж байсан болохоор би
нэг юм. бодохоос горьгүй боллоо Удсан ч үгүй би хэрхэхээ мэдлээ э рх мэдлээ дали м дуулан
Мерлийг урьд намайг хор ьж байсан гянданд хийгээд дараа нь миний бие ойрын хоёр долоо
хоногт төрийн хэргээр хөөцвлдөж хоёр долоо хоногийнхоо хугацааг дуусмагц буух галын

дөлөөр Мерлиний цам х гийг устгах гэж улаач, элч зарлага нар давхиулан ард түм э нд мэдээллээ миний талаар хорлонтой худал үг тараагч хү мүүс хэр чадлаа мэдвэл таарна гэж сануулан одоо үйлдэх ер бишийн шид хувил г аан сүүлчийнх нь болтугай гэлээ. гэвч ид шид маань хэн нэгэнд дутагдалтай санагдаж элдэв муу үг тараах ажлаа үргэлжлүүлвэл тийм этгээдүүдийг адуу болгон хувиргаж тэргэнд, зүтгүүлэх болно. гэж мэдэгдэхэд тайван байдал сэргэн тогтсон юм. Кларенст зарим нууцаа хэлж, хоёул ажла а бэлдэж эхэллээ миний рид хувилгаан нэлээд бэтг э лийг ша а рд а х учраас энэ талаар чалчиж Үг алд вал нэн даруй амь насы чинь тонилгоно гэж Кларенст хэллээ Энэ үгийг сонсоод мань эр аманд а а ус балгасан мэт болох нь тэр Бид хоёр Нууцаар тэргүүн зэргийн хэдэн пүү дарь сэм зэхэж, зэвсгийн дархнууд миний удирдлагаар аянга зайлуулагч утас бэлдэв Тэр хуучи н чулуун цамхаг хэдүйвээрнэлээд эвдэрч муудсан ч уг нь дөрвөн ч зууны өмнө ромчуудын босгосон барилга тул яггүй бөх байлаа., Тэр цамхаг болхидуу боловч овоо гоё мэт бөгөөд ёроолоос дээврийг хүртэл ороонго өвс хучин ургах нь эгээл хайрслал гархин хуяг гэсэн үг Вангийн өргөөнөөс хагас бээр заятай ухаа толгойн орой дээр ганцааранг нь босгосон учир цонхоор тод сайн харагдана Бид шөнийн цагаар ажиллаж, цамхгийн хана, ёроолоос хэд хэдэн том чулуу авч, гарсан нүхэнд нь дарь чихлээ тиймэрхүү цэнэг арав гаруйг зэхсэн юм. Манай бэлдсэ н дарь Лондонгийн Тауэрыг дэлбэлсэн ч хүрэхүйц их байлаа. Арван гурав дахь шөнөө бид Цамхгийн дээр аянга зайлуулагч босгож доо д талын нэг үзүүрийг нь цэнэгүүдийнхээ нэгтэй холбон, бусдын нь хооронд нь утсаар холболоо Намайг а рд түмэнд М е рлиний цамхгийг устгана гэж тунхагласан цагаас хойш тэр цамх г ийн хавиар хүмүүс дандаа эргэлааг болсон тул арван дөрөв ний өглөө элч зарлага давхиулан одоо тэр цамхагт хэн ч дөрөвний нэг бээрээс дотогшлон ойртож болохгүй гэж зар тарааж, рид хувилгаан ы г ойрын хорин дөрвөн цагийн дотор үзүүлнэ, чухам хэдийд, өдөр үү, шөнө үү гэдгийг одоо хэлж мэдэх г үй, тийм учраас тухайн үед дохио өгнө, өдөр бол цамхагийн дээр туг хатгана, шөнө бол тэнд бамбар шатаана гэлээ. . Сүүлийн үед цахилгаантай бороо их элбэгшсэн учраас сэдсэн хэрэг маань бүтэхгүй болов. уу гэж санаа нэг зовохгүй байлаа. Болохоо байлаа. гэхэд төрийн хойшлуулшгүй ажлын эрхээр рид хувилгааны явдлыг ганц хоёр өдөр хойшлуулах болов. гэж ард түмэнд дэгдэж болох байлаа. Гурван долоо хоногт анх удаа л нартай цэлмэг байдаг шүү дээ би өргөөндөө орогнон байдлыг ажиж байхад Кларенс хааяа хааяа орж ирэн ард олны сэтгэлийн догдлол улам улам нэмэгдэж байна. гэх бөгөөд харвах нүхээр харахэд хүн хар олноо рнэ мэгдэн хурж буй нь ил байлаа. Үдшийн харуй бүрий олж эхлэхэд чух а м цаг үеэ олсон юм. шиг яг тэндээс л үүлтээсэй гэсэн чигээс борооны хар үүл хурж эхэллээ холын тэр үүлс улам багшран бараантса а р байх тул би одоо эхэлдэг цаг боллоо гэж шийдэв Бамбар асааж, Мерлинг над дээр ирүүл гэж тушаалаа Хугас цагийн дараа би гадагш тагт дээрээ гарлаа . Ван вангийн өргөөнийхөн бүгд гадаа гараад Мерлиний цамхгаас нүд салгалгүй ширтэцгээж байна. Хав харанхуй болсон тул холын юм. огт үзэгдэхийг болив . Цугласан олон түмэн, тэдний дээр сүндэрлэх тэдгээр хуучин барилга цамхгийн зарим нь харанхуйд хучигдаж, зарим нь бамбарын хурц гэрэлд тодрох учир ер бишийн урлагтай харагдал ажээ. Мерлин нэлээд уруу царайтай хүрч ирэхэд нь би

- Ч а мд муу юм. огт хийгээгүй атал чи намайг а м ьдаар минь шатаах гэсэн Сүүлд нь чи миний мэргэшсэ н алдар нэрийг бузарлах гэж оролдлоо Ингэсний т ө лөө чинь би тэнгэрээс гал буулгаж цамхгий чинь устгана . Гэхдээ чамд миний рид хувилгааны чадлыг замхра ан үгүй хийх увидас байгаад тэнгэрийн дөлийг эсэргүүцэн чадах аваас би шударга ёсыг бодож одоо чамайг тэр увида са а гаргахыг соёрхож байна. г эхэд Мерлин

- Үзэсгэлэнт ноёнтон гуай, би чиний рид хувилгааныг з а храаж чадна, одоо л гарцаагүй замхраана гэлээ. Тэгээд чулуун хавтан дээр цагариг зурж буй бай д ал үзүүлэн дотор нь атга нунтаг юм. асааж хүжний шингэн уу таа суунаглахад хүмүүс айн сүрдэж загалмайлан залбирч тал бүрт ухарлаа Мерлин нэг юм. амандаа хэлээд гараар урайлан даллаж байна. . Я ваа яваандаа мань мань эр галзуу хүн авирла х мэт б олж гар нь сал хин тээрмийн далбан шиг эргэлдэж байлаа. Энэ үед дуут бороо бүр ойртон сэвэлээх салхи бам барын дөлийг шав х уурдахад том х ар сүүдрүүд гуйван найгах харагдана. Борооны эхний дусал пад пүд унаж нүд сохлом харанхуйг тэнгэрийн гялбаа гэнэ гэнэ замхраана миний хийсэн аянга за йл уул агч ажиллаж эхлэх ёстой байлаа. Одоо удаж болохгүй байсан тул би ингэж хэллээ чи б ишгүй оролд ох шив дээ би чамд илбэ жил гаргах бололцоо олгож, чамд саад хийсэнгүй чиний увида с огт чадалгүй болох нь бүгдэд ил боллоо Одоо миний ээлж шүү дээ Намайг г а раа гурван удаа занган даллахад чих дөжрөм дуу нижигнэлээ галт уул дэлбэрэх шиг юм. болж, тэр хуучин цамхгийн мод чулуу бут үсрэн тэнгэрт цойлон бөөн гал дөл болоход эргэн тойронд өдрийн гэгээ тусах адил болж, энд тэндгүй цуглан хурсан олон мянга түмэн хүн ухаан алдан унаж тусан байх харагдлаа Дараа нь бүтэн долоо хоногийн турш элс зомлголоор бороо орсныг яриад ч яах билээ. Нэ лээд дэг с дүүлсэн цуу яриаг сонсоход ийм л юм. дуулдаж байлаа. Энэ явдал туйлын хүчтэй сэтрэгдэл терүүлсэн учир юманд шалиглан шохоорхогчид тэр дороо саваагүй зангаа татжээ Маргааш өглөө нь харахад шавар шав хайн дундуур цаашаа харайлгасан олон мянган хүний мөр чийрлэсэн байв. Дахин нэг рид хувилгаан үйлдэнэ гэж би зарлах юм. бол ирж ажи г лах хүн цуглуулах гэж цагдаагийн хүч хэрэглээд ч ирүүлж чадахгүй байсан биз ээ Мерлиний санаан санаа бүрмөсөн балрах нь тэр Ван түүнд цалин пүнлүү өгөхөө больж, тэр ч байтугай улс орноосоо хөөн зайлуулах гэхэд нь би тэгж юугаа хийх вэ гэсэн Мерлин, т эн гэр аргалах мэтийн аар саар юм. хийж ява г , тэр муу илбэ жилбэрхүү юм нь бүтэж өгөхгүй бол би жа а хан тусалж байя гэлээ. Түүний цамхгаас бүтэн тоо с го ч үлдээгүй учир би засгийн газра а с ш аа рдаж байгаад дахин нэг цамхаг бариулж өгсөн боловч тэр хүн угаас туйлгүй шартай этгээд учраас над талархлаа ч гэж хэлээгүй Ёстой нэг чулуу шиг зүрхтэй, мөс шиг цэвдэг дот о ртой хүн байсан болохоор ялангуяа өөрий нь албанаас нь мултал сан хү нд нааштай байна. гэсэн номгүй хэрэг юм.

Наймду га ар б ү л эг

ЭЗЭН

Хязгааргүй эрх мэдэлтэй байна. гэдэг тун сайхан, тэгэх тусмаа тийм эрх мэдэлдээ сэт гэл ө е г дуртай байна. гэдэг бүр ч даамай хэрэг Цамхгийн явдал миний эрх мэдлийг бататган ган х ашгүй болгосон юм. Над атаархан, өө сэв эрдэг байсан хүмүүс бүгд номхорчээ Одоо

миний ажил төрөлд хөндлөн гөө с оролцох гэж б одох хүн вант улсын хэмжээнд ган ц ч үгүй болжээ. би өөрийнхөө болон орчин тойрныхоо байдалд төдхөн дасав . Анх нь өглөө сэрээд зүүдээ бодохоос инээд минь хүрч үйлдвэрийн яндан дуугарахыг хүлээн хэвтдэг байлаа. Энэ байдал яваандаа арилж, галзуугийн газар биш , харин зургадугаар зуунд Артур вангийн өргөөнд буйгаа бүрмөсөн ойлгосон юм. . Тун удалгүй тэр зууныхаа байдалд хаанаас ч дутахгүй идээшиж, хэрэв намайг өөрөө м эдэж сонго гэх юм. бол хорьдугаар зуунаар л лав солихгүй гэх байсан юм. мэддэг, ухаал аг , ажилсаг хүнд улс орныхоо хамт урагшлан ахь я гэхэд хичнээн их бололцоо бай дгийг бодох хэрэгтэй юм шүү юу л бол юу хийж болох асар их бололцоо над ганцааранд минь олоод өрсөлдөх ганц ч хүн байхгүй, эрдэм мэдлэг, төрөл авьяас билгээрээ надтай зүйрлэхэд балчир хүүхэд шиг биш тийм ганц ч хүнгүй орон байлаа. гэтэл хорьдугаар зуунд бол над ямар хувь оногдох вэ? их үсрээд л би нэг үйлдвэрийн газар мастер болохоос хэтрэхгүй тэгээд ч бас ямар ч гудамжаар хөлхөлдөх олны дотор намайг дагуулахгүй амьтад зөндөө байг аа шүү дээ би мөн ч их дээр гарчээ Өөрийн амжилтыг бодохоос зүгээр сууж чадамгүй, яг л газраас нь газрын тос орги л сон хүн тэрнийгээ хараад хараад ханадаггүй л байлаа. би өөрийгөө зүйрл эх гэж үүх түүх нэхэн сана хад Иос иф бид хоёр л н элээд төстэй баймаар гэ х дээ Иосифийн хувь тавилан миний х тэй яаж зүйрлэх билээ. Яагаад гэвэл Иосифын санхүүгийн гайхамшигт авьяас билэг нь хаад ноёдоос өөр хэнд ч олз ашг оруулаагүй, т эг эхлээр өргөн олон түмэн түүнд дургүй байсан бол би тэнгэрийг нарыг өршөөн хайрлаж хи шиг буянаа дэлгэрүүлсэн хүн болохоор хотол олны хайрыг таталгүй яах вэ

Би Ван гийн сүүдэр байсан биш, мөн чанар нь болж, ван өөрөө сүүдэр байлаа. миний эрх мэдэл асар их байсан маань зөвхөн цол хэргэмийн хүч биш байлаа. г ол цуул цол хэргэмийнхээ хүчинд их эрх мэдэлтэй байдаг шүү дээ би бол жинхэнэ ёсоор их эрх эдэлж байлаа. миний бие даян дэлхийн түүхт их хоёр дуг а ар үеийн яг эхлэл дээр нь байсан болохоор түүхийн өчүүхэн нарийхан горхи улам гүнзгийрэн өргөсөж хүчирхэг урсгалаа алс холын үе рүү түлхэхий нь ажиглаж чаддаг байсан юм. тоолж барамгүй олон хаан ширээдийн халхавчийн дотор над мэтийн балмад адалтан де Монфор, Гэвстон, Мортнмор, Вильберс байхыг нь би хардаг байлаа. Дайн хийгчид, францын жанжид аян дайн удирдаж яваа их Карлын нууц амрагууд улс орныг хэрхэн удирдаж байгааг би хардаг байсан болов. надтай эн зэрэгцэх амьтан тэдний дотор ганц ч байдагүй байлаа. би бол цорын ганц байжээ. ийм баримтыг мянга гурван зуун тавиад жилийн турш хэн ч нууж, хэн ч үгүйсгэж чадахгүй гэж бодохоос цээж дүүрэн, магнай тэнийн баярладаг билээ. Үнэхээр, миний эрх мэдэл вантай адил байсан юм. гэвч улсын дотроо ван, бид хоёроос хоёуланга а с ч илүү хүчтэй бас нэг засаг байлаа. Тэр бол сүм хийдийн засаг билээ. би энэ баримтыг нуугаад яах вэ? Нуух гээд ч чадахгүй юм. чинь гэсэн ч тэр тухай одоо яри хын хэрэг алга Энэ тухайг би зохих цаг т нь , зохих газраа ярих болно. Эхний үед сүм хийд над Ямар нэг эвгүй юм. хийхгүй байсан Ер нь тун сонин хачин орон шүү хүн арды нь ч гайхмаар Цагаан цайлган, эгэл даруу, чандага туулай л гэсэн үг Эрх чөлөөтэй орчинд төрсөн хүнд амьсгаа давчдам Ард олон нь ван, сүм хийд тайж язгууртан д аа чин үнэ н ээсээ номхон хүлцэнгүй зүтгэхээ тангараглаж байх нь даанч харамсмаар гэтэл тэдэнд ван, шажин, тайж нараа хүндэтгэх үндэс гэвэл боол хүн зодуулдаг ташуураа хайрлан энхрийлэх буюу нохой зоддог явуулын хүнд нохой хайртай болж хүндэтгэх үндэс хэр зэрэг байхаас илүүгүй билээ. Ай дар эх минь , хамгийн хүлцэнгүй хаант засаг ч гэлээ., х амгийн эгэл даруухан тайж нар ч гэлээ. хэзээд эвэрхий билээ. Гэхдээ эзэн хаант төр, тайж язгуурт н ы засаг төрийн эзэрхийлэлд төрж өссөн хүн бол өөрийнхөө д о ромж байдлыг

хэзээ ч ойлгохгүй бөгөөд ийм байна. гэж хэн нэг хүн хэлсэн ч үнэмшдэггүй Ямар ч эрх, ямар ч хууль есны үндэсгүй мөртлөө хаан ширээнд дандаа л усан т э нэг, мал шиг юмнууд залран сууж, хамгийн олхиогүй муухай новшнууд тайж язгууртан байдгийг бодохоос ард түмнийхээ өмнөөс нүүр хийх газар ч олдо мгүй ичдэг юм. Хэрэв тэр бүх хаад, түшмэдийг өөрсдийг нь, өөрсдөөс нь хавьгүй лут эрхэм хүмүүсийн буй байдалд оруулаад орхи чих юм. бол тэд гуйлгачин түүлэгчин, нэрчүгүй усчүгүй байдлаас хэзээ ч ангижирч чадахгүй улс юм. Артур вангийн өргөөний хэвийн британ хүмүүсийн ихэнх нь жинхэнэ ёсны боолууд байлаа. Тэд боол гэгдээд түүнийхээ тэмдэг болгож хоолойдоо төмөр хүзүүвчтэй байна. Бусад нь боол гэдэг нэр зүүхгүй боловч үнэндээ бас боол юм. Тэд өөрсдийгөө эрх чөлөөтэй хүмүүс гэж боддог болохоор нь тэднийг чөлөөт хүмүүс гэж нэрлэнэ. Үнэнийг хэлэхэд, үндэстэн бүхэлдээ ван, сүм хийд тайж нарын өмнө сөгдөн бишрэх, тэдэнд боолын ёсоор зарагдах, тэдний төлөө цусаа асгаруулах, өөрсдөө өлсөж тэднийг гэж ээх ажил хийж тэдэнд цэнгэн жаргах боллоцоо олгоос, өөрсдөө элдэв гал зовлонг тэвчин амсаж тэднийг жаргаах, шалдан нүцгэн явж байгаад ч гэсэн тэднийг торго өмсгөх, эрдэнийн чулуу эдлэх боломжтой болгох, өөрсдөө татвар төлж тэднийг аливаа ажлаас чөлөөлөн, насан турш тэдэнд аашлуулж загнуулан тэднийг бүр онгироож, өөрсдийгөө газар заларч мэндэлсэн бурхад гэж боддог болгохын тулд ламь зуудаг юм. шиг байна. Тэгж зүтгэж ач тус болсныхоо оронд зөвхөн зодуулж жанчуулж, хараалгаж зүхүүлнэ, ер нь тийм доромж байдалдаа даамай дассан болохоор тэгж харьцахыг анхаарал халамжаа хүртээж буй ач буятай явдал гэж үзнэ гээч Үе уламжилсан санаа бодол гэгч зугаатай элдээ, тийм зүйлийг ажиж, судлах хэрэгтэй юм шүү Надад өвлөж уламжилсан санаа бодол байсан, ван болон түүний ард түмэнд ч бас өөрийнх нь гэсэн тийм үзэл бодол байсан Эдний аль аль нь цаг хугацаа, хэвшлийн эрхээр бий болсон маш гүнзгий гуйлгалын дотуур урсаж байлаа. тийм юмыг билэг ухааны хүчээр өөрчлөх гэсэн Хүнмэх аа иднэ. Жишээ нь Цол хэргэм, олон үед уламжилсан язгуур угсалгүй л бол тийм хүн байгайиас хичнээн их аьяас билэг заяасан байлаа. ч адгуус амьтан, хорхой шавьж, бясанаас хэрхэвч дээргүй гэсэн нэг үзэл тэр ард түлмэнд ягштал шингэсэн байна., гэтэл миний өвлөн уламжилж шингээсэн үзлээр бол үе залгасан эрхэм хүндэтгэл, байгуулсан гавьяагүй мөртлөө өндөр хэргэм цол эдэлж тогосын өдөөр чимсэн хүн дүрстэй хон хэрээнүүд бол хүн амьтны элэг доог байхдаа л таарсан этгээдүүд гэж үзнэ Тэгэхлээр, намайг нэгл хачирхмаар үздэг нь бас зүйн хэрэг Адгуус амьтны эзэн, эгэл харц нар зааны гюу гэж бодов, намайг мөн тиймэрхүү байдлаар үздэг байв. Тэд зааны мундаг том, ер бишийн хүчтэйг нь өөрсдийнх нь хийж чадах олон юмыг хийж чаддагт бахархан шагширч, уураа хүрсэн цагт олон мянган хүнийг ч айлган хөөчшх чадалтай хэмээнбас л бахдал болгон ярилцана гэсэн ч зааныг тийм учраас өөрсөдтэйгээ адилхан зиндааны амьтан гэж үзэх үү гонж өвдөг цоорхой адгийн муу гуйлгачин ч тэгж бодохгүй толгойд нь тийм бодол хэзээ ч орохгүй тиймэрхүү бодол байдаг ч гэж зүүдлэхгүй Ван, тайж, бүх хүн ард нь, боол гуйлга чингүй бүгд намайг тийм заан төдий л амьтан гэж бодож байгаа Намайг шагшин гайхаж, надаас айдаг байлаа. Гэхдээ намайг шагшин аймаар л амьтан гэж бодоцгооно. Амьтанд биширдэггүй, тэгэхлээр надад бишрэхгүй, ер нь намайг хүндэлдэггүй байлаа., Над удам судар, үе залгах хэргэм цол байгаагүй болхоор вангийн болон тайж нарын нүдэнд би хөгийн дор ой хогийн төдий үзэгдэнэ. Ард түмэн нь намайг гайхан, айж сүрдэх боловч олгогч хонч хүндэтгэхгүй тэд үе уламжилж авсан үзэл бодлоороо тайж язгуур, удам угсаанаас өөр юуг ч хүндэтгэдэггүй юм. ийм болох явдалд нь ром католик ийн аймшигт хүчирхэг шашны нөлөө илт байв. хоёр гуравхан зуун жилийн дотор бүхэл бүтэн ард түмнийг өг хорхой болгож чадсан байна. шашин, хорвоог ноёрхохоос өмнө хүн хүн нэрээ хадгалж, толгой мэдэлтэй явах дуртай, сэтгэлийн

зори г той, толгой дээгүүр, хү ний ёсоор байжээ. . Алдар нэр, алба тушаалыг тэд гарлаараа биш, байгуулсан гавьяагаараа эдэлдэг байж Тэгтэл шашин бий болж бодий нь хөтөлж эхлэх нь тэр Шашин , өөрөөр хэлбэл, ард, арьсыг хэрхэн хуулах олон аргатай, зальтай, байж Шашин вангийн бурхан эрх, гэгчийг зохиож с айхан байшингийн тоосгоноос авч муухай нэгийг торддог шиг Вангийн эрх мэдлийг арван номлол оор бат атгажээ . Эгэл түмнийг номхон томоотой байх, дарга даамлынхаа үгэнд ордог, өөрөө хохирох их уян бай гэж номноно эгэл түмнийг хүлцэнгүй, билгээр гуйланч, дарлагч ноёдын захиргаанд үг дуугүй ордог байхыг номлоно үе залгамжлах алба, тушаал , хэргэм цолыг буй болгож дэлхий дахины христос мөргөлт өн бүрт угсаатныг хүндэтгэн биширдэг үзэл шингэжээ. Энэ хор, христос мөргөлтний цусанд миний төрж мэндэлсэн хорьдугаар зууныг хүртэл нэвчсэн хэвээр байсан бөгөөд тиймээс ч Ангелийн ард түмний шилдэг төлөөлөгчид, өөрсдөөс нь долоон дор муу хүмүүс хүртэл лорд, ван гэх мэт өдий төдий цол хэргэм эдэлдэг хийгээд улсын дотоодод мөрдөх тэнэг хуулийн уршгаар хамгийн шилдэг сайн хүн ч тийм юм. эдлэх эрхгүй байдаг явдлыг хүлцдэг байна. англи хүн тийм санаанд багтамгүй хачин юмыг тэвчин эвлэрээд зогсохгүй бахархдаг гэж биеэ хуурч байна. Хэрэв хүн шударга а бус явдлын дотор төрж бойжсон бол аливаа тийм шударга биш юмыг тэвчин хүлцэх чадалтай байдаг ажээ. алба тушаал , цол хэргэмд бишрэх сөгдөх энэ халдварт өвчин манай америкчуудын цусанд ч байсан цаг бий л дээ, америк орноо орхих үед тийм өвчин арилсан байж билээ. зарим нэг эр, эм хээнцэр хээнцэр амьтад л зах сэжүүрий нь хадгалж үлдсэн төдий байсан халдварт тахал тийм хэмжээнд хүртлээ багассан байхад түүнийг нэгэнт үгүй болсон гэж хэлж болох билээ. за одоо Артур вангийн төр улсын дотор би ямар шуу хачин байдалд байснаа ярья даа би одойн дунд орсон аварга, хүүхдийн дунд орсон томхүн, ухаантай төрсөн сохор номингий дунд орсон сэтгэгч юм. уу даа гэж л боддог байсан юу ч гэж бодсон хамаагүй , ямар ч болтугай би бол бүх британ ертөнцийн до троо цо рын ганц үнэхээр их хүн байлаа. гэсэн мөртлөө хон и ны тархитай ямар нэгэн гүн өөрийгөө вангийн Лондонгийн хонигилуудын нэгнээс гар дамжуулан олж авсан нууц амрагуудын нь нэгнээс гарсан гэж нотолж чадах юм. бол над мэтийн хүнээс хамаагүй их хүндэтгэлийг олдог байсан миний үеийн английнхтай л адилаар байлаа. тиймэрхүү хүнийг хомс ухаанаасаа дээрэлхэх юмгүй харах царай нь лоймол, ёс суртхуун нь удам гарал шигээ бузар булай ч гэсэн Артурын хаанчлалын дээрхи хүн бүхэн хүндэлнэ, тийм хүнийг хааны хажууд урин суулгах атлаан ямаг т тэнд суулгахгүй явдал ч гардаг байлаа. Би, хааны өөрөө хүртээд цол хэргэм олж авъя гэвэл ядаж цөхөх юмгүй байсан, тэгвэл миний нэр хүнд бүхний нүдний өмнө, ванд ч гэсэн их өсөх байлаа. гэвч би цол хэргэм горилоогүй, цол хэргэм олгоё гэхэд нь аваагүй юм. миний мэтийн үзэл бодолтой хүн цол хэргэмд баярлахгүй Түүнээс гадна миний удам сударт тайж язгуурын холбоо хэлхээ байсан эсэх нь мэдэгдэхгүй болохоор цол хэргэм хүртэх нь хуульд харшлах байлаа. Аливаа эрхт засгийн жинхэнэ эх булаг болдог ард түмэн өөрөө над хэргэм цол хүртээх юм. бол би тийм хэргэм цолыг бахархан авах билээ. тийм гуншин олж гавьяа байгуулахыг би найддаг байсан, яваа яваандаа олон ил үнэнч шударга рга зүтгэсний үрээр тийм гуншин хүртэх гавьяа байгуулж түүнийгээ ихэд хүндэтгэн бахархаж явдаг байлаа. Хөдөөний нэг төмрийн дархны амнаас анх гарсан тэр гуншинг бусад нь тун оновчтой болов. хэмээн хөөрөлдөн сайшааж тэр нь ам ам дамжсаар аравхан хоногийн дотор бүх улс орон даяар тархаж ванийн нэрд тэр дорхноо дасдаг шиг бүгд дассан юм. Түүнээс хойш ард түмний дотор ч, вангийн зөвлөлийнхний дунд ч, төрийн чухал асуудлыг марган ярилцах үед намайг тэр шинэ нэрээр л дууддаг болж билээ. . Тэр гуншин г орчин үеийн хэлээр орчуулах юм. бол Эзэн гэсэн үг байлаа. Ард түмэн намайг тэгж нэрлэсэн юм. болохоор би тэр нэрэнд нь дурт ай байсан юм.

. Энэ бол угтаа цорын ганц хамгийн дээд гуншин байлаа л даа Гүн, зайсан, х а мба гэж ярилцахад чухам хэнийг хэлж буй нь тэр болгон мэдэгд э хгүй Зөндөө олон гүн, зайсан, хамба байдаг шүү дээ, алиныг тэр гэх вэ? Харин ван, вангийн ха т ан, эз э н гэхэд хэн ч андахгүй Ван над аятайхан санагддаг, би ч түүнийг хүндэлдэг байсан, цолы нь ч хүндэлдэг байсан, хүндлэхдээ ер нь наад за х нь аливаа хоосон зүүс э н цол хэргэмийг хүндэлдэг шигээ л хүндэлдэг байлаа. харин хүнийх нь хувьд гэвэл ванг ч, түшмэд ийн нь ч, дотроо тоо доггүй байсан л даа Ван, түүний түшмэд ч гэсэн намайг т ө рийн зүтгэлтний хувьд хүндэлдэг байсан, гэвч нэг энт төрөл язгууртгүй хүн болохоор намайг нууж хаах юм.гүй дор т ө рөлтөн гэж үздэг байсан би ч тэдний тухай, өөрийнх өө бодлыг ойлгуулья гэж чармайдаггүй байсан, тэд ч миний тухай юу гэж боддогоо мэдүүлэх гэж чармайдаггүй байлаа. тийм учраас бид ана ман а байдалтай, х а рьцаа маань тэ нц үү ачаатай дэнсний таваг шиг байв. Тэгээд ч бие биендээ гэм халгүй байлаа.

Есдүгээр бүлэг

тэмцээн

Камелотод том том тэмцээн байнга зохионо хүмүүсийг үхэр мал шиг тулалдуулдаг тэр тэмцээн нь их хор шартай, үзэмж, зугаа ихтэй гэхдээ ажил төрөл боддог хүнд бол ба ах ан залхмаар талтай гэсэн ч би дор дурдах хоёр шалтгаанд хавчигдан тэрий нь дандаа очиж үздэг байлаа. Н эг дүгээрт, төрийн зүтгэлтэн, тэгэх м ө ртөө бусд ад тоогдох санаатай байгаа хүн, хань н ө хдийнхөө х а йр хүндлэл хүлээсэн, дотор нь өөрөө эргэлдэж байгаа хүн тул тийм юм.наас нь дөлж явах ёсгүй хоёрдугаарт ашиг хонжоо харагч бөгөөд төрийн зүтгэлтний хувьд миний бие тийм тэмцээний нь судалж бага сага ч болов. сайжруулах арга юу байна. гэдгийг хайх ёстой байлаа. харин би төрийн албанд орсон ан х н ы хаа өдөр зохион явуулсан төрийн ч ан арт ай ганц нэг арга хэмжээг дурдахаа мартсан байна. юу гэвэл сонгогчдын эрх а шгийг хамгаалах хатуу хууль дүрэм, Патентын товчоогүй орон гэдаг бол гагцхүү хажуугаараа юм. уу , эсвэл гэдэргээ хөдөлж чадахаас биш урагшаа ахиж чаддагүй, хавч хорхой адил гэдгийг мэдэж байсан учраас миний бие Патентын товчоог үндэслэн байг уулсан юм. . Тэмцээнийг бараг долоо хоног бүр зохиодог байсан бөгөөд манай хэд Ланселот ноён болон бусды нь би ингэж хэллээ шүү намайг түүнд оролц гэж байсгээд л ятгадаг байлаа. би оролцоно гэж амлах боловч яарах юу байхав, одоохон түргэн засаж янзалж байгаад ажиллуулах чухал шаардлага бүхий төрийн машинаа тос л оод толгой дээш татах завгүй байна. гэж хэлээд хой ш т а вьдаг байлаа. Нэг удаагийн зохихон тэмцээнд хамгийн алдар цуутай морьтон э р ээс өгсүүлээд жулдрай банди нар нийл сэн таван зуун эр оролцож тэр тэмцээн өдөр хоног сунжирсаар долоо хоног гаруй үргэлжлэв Тэмцээнд оролцогчид бүр хэдэн долоо хоногийн урьд ирцгээж байлаа. Тус орны алс холын өнцөг булан г аас морьтой ирцгээнэ, зарим нь бүр далайн тэртээгээс ирнэ зарим нь авгай хүүхэдтэйгээ, бүгд шадар цэрэг, өдий төдий зарц шивэгчинтэйгээ ирж байлаа. Цадигаа алд ан хөгжилдөх, эрээ цээр, ичих зовохы г мэдэхгүй ярилцах, ухаан жолоогүй гоёж гангалан ихэмсэг хямсгар зантай таахалзах, аливаа ёс дэг журам гэгчийг хумсын чимээ ч бодохгүй тийм хүмүүс гэр орондоо тэр цаг үедээ яг л таарсан амьтад юм даа Зодолдох, эсвэл зодоон сонирхолгүй өнгөрөх өдөр гэж нэг байхгүй дуудуулан, тоглох, бүжи г , архидахгүй өнгөрөх шөнө гэж ганц байхгүй Ингэхийгээ тэд дээд зэргийн жаргал цэнгэлээр цаг өнгөрөөлөө гэж үзнэ би ийм хачин жигтэйхэн улсыг насандаа ер үзээгүй Хэтэрхий ян з гүй муухай гангал сан царайл аг хатагтай нар сандал дээр ёнтойлгоод, эрчүүлийн зарим нь н эгнийхээ махан бие рүү жад бүлэн цусы нь садруулан мориноос нь

унагаж байхад Тэр эмс муурч муужрах нь бүү хэл, харин хээвнэг алга ташицпаан олигтойхон харах гэж бие биен дээрээ харайлгах нь дутуу байлаа. хаа яа зарим нэг нь айсан хүн болж нүүрээ алчуураараа дарж харамсаж гасалсан байдал харуулна. Тэгж буй нэг нь бол цаад эртэй заавал чиг шали г лад аг, тэгээд тгийм байж хээвнэг байх юм. гэж хүн муу хэл ж маг ад гүй гэсэндээ л айж зовсон цар ай гаргаж байгаа юм. гээд та ямар ч дэнчин тав и ад бооцоогоо лав алдахгүй дээ. Шөнийн цага а р үймж шуугилдахад би тун ч дургүй Харин тухайн байдал үймээн шуугианд нь би баярла ж байлаа., яагаад гэвэл өдөр нь эрэмдэг зэрэмдэг болсон хүмүүсийн хөл гарыг эмч домч, нар нь шөнийн цагаар тайрч буй хөрөө ний хяхнах дүү дарагдаж байлаа. Тэд миний тун хурц са йх ан хуучин хөр өө г м и нь ирий нь мох оо сноор барахгүй и ший нь хугалчихаад өгөхөд нь би юу ч хэлэлгүй өнгөрсөн юм. Харин тэр м э с засал чи д сүхий минь авбал уу нөгөө зуунда а шилждэг хэр эг гэж шийдэж билээ. би тэр Тэмцээний нь едөр болг он үзэх байтугай ни йг мийн хэв зүй, газар тариалангийн яаманда а нэг овоо ухаалаг х а р лам олж аваад тэр Тэмцээний т ал аар тоо цоо гаргах даалгавар өгсөн юм. , яагаад гэвэл ард түмнээ бага зэрэг иргэншүүлж чадсан цагт а а би нэг сонин гаргая гэж бодож байсан юм. Ш и нэ ул с оронд оччихсон хүн давын түрүү Патентын товчоо байгуулж дараа нь сур г ууль нээж , тэпсэн хойноо сонин гаргах ёстой билээ. Сони н д ч цөөнгүй дут аг д ал байдаг, гэхдээ үхмэл үндэстнийг авснаас нь гаргах чадалтай байдаг, үүнийг хэзээ ч мартаж бол ох гүй . Сонингүйгээр үхмэл үндэстнийг сэргээн босгож чадахуй, өөр зэвсэг байхгүй Тэгээд би туршиж үзэ э д, зургадугаар зуунд хэрэв над хэрэгтэй болж гэм ямар шуу маягийн мэдээлэл орж ирэхий нь үзээсэй гэсэн юм. Лам м а ань үнэндээ муугүй ажиллаж байлаа. тодорхойлон бичих зүйлээ маш дэл гэрэнгүй тодорхойлдог байлаа. Орон нутгийн мэдээллийн хэсэгт чухам тодорхой байх нь чу х ал байдаг, тэгэхлээр болох нь тэр шүү дээ мань эр залуудаа өөрийн х өө сүмд оршуулгын тэмдэглэл х өтөлдөг хүн байж Оршуулгын хэрэгт орлогын гол нь тодорхой тэмдэг л э с нээс ордо г байна., хичнээн л тодорхой бол төчнөөл их мөнгө өгнө, авс м ө рл өгч , бамбарч, дэн ч , мөргөл бүгдийг тооцоонд бичнэ . Талийгаачийн төрөл нь цөөн унш л ага захисан байв.ал, д э н г ий нь тоог хоёр да хи н нэмчихнэ, тэгэхлээр тооцоо нь подхийгээд л явчина . Түүнээс гадна, ашигтай зарлал үгүй? юу гэх юм. бэ дээ, вангийн өргөөнд нөлөө бүхий цэрэг эрийн тухай дөвийл гө н магтсан юм. энд тэнд нь оруулахдаа тун овжин хүн байлаа. Ер нь мань эр, нэг үе үхрийн хашаанд сууж рид хувилгаан үзүүлдэг агсан нэг сүрхий даяанчийн донир байсан болохоор юмыг дэгсдүүлж давсла х даа авьяастай байлаа. Эхлэн бичи гч түүний тайланд сүржин, сүр бадруул сан юм. уу , хуучин үг хэрэглэсэн газар байхгүй нь арга байж уу , тэг э хлээр бага зэрэг сэргээж өгвөл уг нь зүгээр, гэхдээ хуучин ц аг ийн арга а яс нь сонин, эгэл, зөөлөн, цаг үеэ бүрэн тус г а х тул тийм сайн тал нь нөгөө их дутаталууды нь бага зэрэг зөөлрүүлж байлаа. Тайлан г аас нь нэг хэсгийг с ийрүүлэе

Тэгэхэд Бралэн дө л еэ Айлс ноён ба Груммор Грум морсум, ордны хүлэг баатрууд Эглов е л ноён ба тор ноён хоорондоо т улалдсан ба тор ноён Груммор Грумморсум ноёныг газар унагасан чингэхэд Карадос ноён Уйтгарт цамхгаас гар ч ирсэн ба тойсвин ноён, ордны хүлэг баатрууд мөн гарч ирсэн ба ах дү ү хо ёр Персивэл дө Гайис ноён ба Ламорак де Гайис ноёнтой тулалдсан Персивэл ноён, Карадос ноёнтой үзэлцсэн ба хоёул жадаа хугалсан, харин тойсвин ноён Ламорак ноёнтой үзэлцэж хоёул жадтайгаа газар ойчсон, гэвч тэдэнд хүмүүс туслаар ирж дахин моринд нь мордуулсан Арноль ноён ба Гогер ноён, ордны хүлэг баатрууд Брэндайм ноён ба Кэй ноёнтой тулалдсан, эдгээр дөрвөн эр галзуу мэт үзэлцэж бие биений гараас жадыг мулт унагаж байлаа. Дараа нь Петролон ноён, ордны хүлэг

баатрууд гарч ирж Лайонлл ноёнтой үзэлцэв Пертолон ноён, ногоон хүлэг баатар Лайонал ноёныс морин дээрээс нь унагав Энэ нь Ланселот ноёны дүү байлаа. Ариун үйлст элч нар түүнийг ялагч хэмээн тунхаглаж нэрийг нь сэргээн мандууллаа Дараа нь ноён Блербарж жса даа Гарет ноёнд тулган махийлгасан боловч өөрийнхөө хүчинд дийлдэн газар ойчлоо Үүнийг үзээд Гайиходин ноё Гарет ноёныг үзэлцсүгэй гэсэн боловч Гарет түүнийг мөн л газар ойчуулав чингэхэд нь Гайихуд ноён жадаа өргөж дүүгийнхээ хариуг авна гэхэд Гарет ноён түүнийг мөн л бас Дайнодэн ноёныг ба түүний ад и л Котм элтэлийг ба хүсүүшт Саграмон ноён, бас догшин додинас ноёныг, бүгдийг ганц жадаар ялав Ирландын Эгвизэнс ван, Гарет ноёныг хараад гайхаж ханахгүй байлаа. Тэр хүлэг баатар түрүүхэн ногоон байснаа одоо гэнэт цэгээн болов. Гарет ноён тулалдах бүрдээ өөр өнгийн өмсгөлөөр хувцаслаж байсан ба ван ч, хүлэг баатрууд ч түүнийг шуу д таних нь үгүй байлаа. Тэгээд Ирландын ван Эгвизэнс ноён, Гарет ноёнтой үзэлцсэн ба Гарет ноён түүнийг морин дээрээс нь эмээлтэй нь унагав чингэхэд Шатландын карадос ван тулалдахаар гарч ирэхэд Гарет ноён мөн л түүнийг өөрийг нь ба морийг нь газар унагав Бас уу лын орны Уриэнс ноёнтой тулалдаж мөн тэгж ялсан болой,, чингэхэд Багдемагус ноён гарч ирэхэд Гарет ноён түүнийг өөрийг нь ба морийг нь газар бас унагав Дараа нь Багдемагусын хүү М е лиганус зоригтой эрэлхэг тулалдаж жадаа Гарет ноёны биед хугалав чингэхэд нь ариун хуантайз Галахолт ноён өндөр дуугаар Олон өнгөт дайчин эр чи сайн тулалдаж байна. гэвч би чамтай тулалдахыг зэхэж байна., чи бэлдэгтүн гэж хаширав Үүнийг Гарет ноён сонсон жадаа илүү урт жадаар солиод, хоёул үзэлцэж гарлаа Хуантайз түүний зүг өөрийн жадыг чиглүүлэхэд Гарет ноён түүний дуулганы зүүн тал уруу маш хүчтэй дэлссэн тул мань эр гуйван унах байсан боловч зарц гоцго нар түшин авлаа Олон өнгөт энэхүү ноён бол үнэнхүү гайхамшигт дайчин эр гэж Артур ван хэлэв, Тэгээд Артур ван Ланселот ноёныг дуудаж тэр ноёнтой үзэлцэнэ үү? гэв гэтэл Ланселот ноён Ноёнтон минь ө нөөдөр миний бие түүнтэй тулалдахаас татгалзах хэрэгтэй гэж зүрх минь хэлж байна., яагаад гэвэл энэ хүлэг баатар бишгүй их зүтгэв Алдарт хүлэг баатар тийм их гавьяа байгуулахад өөр хүлэг баатар тэрний нь булаах явдал зохимжгүй ялангуяа түүний ийнхүү туйлын их мэрийн үзэлцэний дараа тэгж болохгүй, юмыг яаж мэдэх в э, эдгээр эрсийн дотор өрсөлдөгч их байж мэднэ, бас тэр өрсөлдөгч нь түүн и й сэтгэлт хатагтайн зүрх сэтгэлийг илүү татдаг болоод энэ эр хамаг хүчээ шавхан ийм их гавьяа байгуулж байж ч мэднэ ийм учраас миний бие түүний алдар гавьяаг өнөөдөр үгүйсгэж чадах байлаа. ч гэсэн түүнийг байгуулсан бүх гавьяатайгаа үлдэхийг хүсэж байна. гэжээ Тэр өдөр нэг туйлын базаахгүй явдал гар с ныг миний б ие улсын х аа эрх аш г ийг бодож хар ламынхаа тайлангаас х ассан юм. . Тэр тулалдаануудад Гарри л хэн хэ н ээс Илүү их тулалдсаныг т а бүхан гарцаагүй мэдэж авсан байх би Гарет ноёны Гадой гэж байгаа юм шүү Зүгээр л Гарри гэж нэрлэдэг маань би түүнд их сайн болоод тэгж буй х эрэг гэсэн санаа та нарт төрж буй байх, үнэхээр тийм байсан юм. шүү . Бусад хүн и й дэргэд юм. уу ялангуяа өөрийнх нь дэргэд өөрийг нь и нг эж богинохон, энхрий нэрээр дуулдагүй байлаа. Түшмэл хүн байсан бол ох оор нам а йг тэгж дуудахыг хэрхэвч тэвчихгүй байсай бизээ . Цааш нь үргэлжлүүлбэл намайг вангийн сайд гэж тусгайд минь олгосон с уудал д би сууж байлаа. Гарч тул ал дах ээлж нь болж байсан Дайнад э н ноён миний дэргэд ирж суугаад чалчиж алдав . Намайг шинэхэн ирсэн хүн болохоор юм. л бол над дээр ирнэ, яагаад гэвэл өөрийн х өө ярьдаг и н ээдтэй юмыг борлуула х шинэ зах зээл хэрэгтэй байдаг ажээ. Ярьдаг юм нь бүр нуруугий нь авсан улиг домог болсон зүйл б олохоор яригч ганцаараа л инээхээс биш б усды нь бөөлжис цут г ана гэлээ. ч гэсэн би түүнтэй э е лдгээр харьцдаг байсан маань түүнийг өнөөх ям а р гайтаар сонссон юм. тэр нэг шо г яр и а шиг юм.ы нь яр и улах г үй санаатай л

тэгдэг байсан юм. Ярьдаг юм нь гэж миний наснаасаа олон сонссон, адгийн новшийн, бүр ёрын шаар шиг юм. байлаа л даа Колум баас Артимос Ворд хүртэлх амери к нутагт байсан марзан яриатай хүн болгоны л тэр шог яриаг а н х г аргасан гэдэг Уг нь уран хошин ярьдаг нэртэй нэг хүн мунхаг мулгуу хэсэг амьтдад бүхэл цагийн турш тун их ухаалаг ярилаа гэсэн чинь ганц ч хүн инээлг э ж чадсангүй, харин гар а ад явхад нь хэдэн өт гө с г а ры нь талархан барьж насандаа ийм инээдэмтэй юм. сонсоогүй, мөр гө лийн цагаар инээдээ арай чар ай барьж байлаа. гэсэ н гэд эг , Т э р инээдтэй яриаг дахин хэзээ ч яр и агүй юм. гэдэг, гэтэл ми ний чихэнд зуу, мянга, түм, бу м ан удаа сонсдож а ль муугаар хараан зүхэх, халширч нулимс таргахад хургэсэн тохиолдол насан турш сал аагүй юм. Лантанцыг ч саяхан өө д болсон гэж хэлж болох байсан бөг өө д загалмайтныг мэндлэх хүртэл бас таван зуун жил үлдээд байсан, түү хи йн туяа гэгээрэх, азай буурал хуучин үеийн үнэгэн харанхуйд тийм юмыг тэр хуя г тай илжиг ярьж эхлэхэд надад ямаршуу байсныг т а нар одоо төвөг г үй ой л гох бизээ Яриагаа дуус г ахч аа болмогц нэг жаал ирээд тулалдах цаг тань бопов гэв Чөтгөр шиг инээгээд, шуудайд х ийсэн төмрийн өөдөс хангинах харжигнах шиг болоход нь би ухаан алдаж билээ. хэдэн хормын д а раа сэхээрч нүдээ нээвэл Гарет ноён түүнийг нам цохиж харагдахад нь би өөрийн мэдэл г үй Бурхан минь , апчихсан ч зүгээр юмсан гээд хэлчихэв гэтэл га й болоход намайг яг тэгж хэлж байхад Гарет ноён Саграмор хүслэнт ноёны бас дайран морин дээрээс нь унагажээ Саграмор ноён т ийн х үү уна ж бай х даа миний хаш га рахыг сонсож өөрийг өө тэглээ гэж бодсон байна. Тэд нэг юм. бодчих юм. бол юу гэж учирлаад ч нэмэргүй, тийм улс л даа тиймий нь нэгэнт мэдэх хойно би учирлаж тайлбар хэлсэн ч үгүй С аг рамор ноён биеэ гайгүй болмо г ц та б и д хоёр хоорондынхоо бага саг а тооцоог нэг т ийш болгоно байха а гээд өдөр товлож, гурав дөрвөн жилийн дараагаар өөрийгөө үгээр дайруулсан яг тэр газар ү з элцэнэ гэлээ. Буцаж ирэхий нь хүлээж байя гэж хэлсэн мань эр, ариун Граалийн э рэлд мордо х гэж байсан юм. . Манайхны эрчүүл бүгд л байсгээд ариун Граальд очно гээд явдаг юм. хэдэн жилийн аян болдог байсан Хэн нь ч тэр ариун Грааль гэгч чухэм ,хаана байдгийг мэддэггүй байсан болохоор са й н дураараа б аахан төөрч яаж явж ирдэг байлаа. Е р нь тэд дотроо оло х гүйч гэж боддог байсан байх, санаандгүй та а ралдчихаж гэм яах ийхээ ч мэдэхгүй амьтад гэж би боддог байсан . Манайханд Баруун хо йгуур г арц олно гээд эрэл хайгуул х ийдэгрхүү тийм л юм. байсан Ариун Граалийн эрлийнхэн гээд жил бүр нэг хэсэг хүн явна, хойтон жил нь тэднийхээ хойноос эрэлд г а р на Тэр аянд алдар нэрийг олох боловч олз омоггүй байна. . Намайг явья явья гэлцдэг б айсны нь яана би инээдээр л өнгөрөөдөг, байлаа.

Аравду гаар бүлэг

ИРГЭНШЛИЙН ЭХНИЙ СОЕОЛОЛ

Надтай халз тулалд а х болсон ту х ай яриаг Дугариг Ширээнийхэн сонсчээ тиймэрхүү юманд их дуртай улс болохоор элдэв дээдийн яриа хөөрөө тарж э хэ лжээ . Өөртөө нэг алдрыг олж, Сагромор ноёнтон ана мана ч тач үзэлцэхий тулд адал явдалийн аяндаа мордох чинь зүйтэй , гэж ван над одоо хэлэх боллоо би уучлал гуйгаад ингэж хэлдэг байв.

- Бүхнийг тохинуулж, ажиллуулахын тулд над бас гурав дөрвөн жилийн хугацаа хэрэгтэй байна., чи нг эсэн хойно хаашаа ч явсан болох байна. Тэр болтол Саграмор ноён Граалиа эрсээр байх биз, тэр хооронд нь би алдар нэрийг амж и н олохын тулд алт шиг цаг хугаца аг алдахгүй ашиглана, төрийн хэрэгт зүтгэснээс хойш зургаа до лоон жил өнгөрч, төрийн ажил нэгэнт төвхнөсөн байх тул миний бие ажил төрөлдөө хор болохгүйгээр амралтаа авч хийж бүтээсэн зүйлдээ би сэтгэл ө е г байлаа Улс орны алс бөглүү янз бүрийн өнцөг буланд үйлдвэрийн янз бүрийн салбар байгуулж байсан маань мийн ой ры н и рээдүйн иргэншлийн асар то м үй л двэр, төмөр, ган элчдийн маань үүсгэл болж байлаа. Б и хамгийн а вьяаслаг залуусыг цуглуулж тийм хүмүүс улам олныг олох гэж өөрийн төлөөлөгчдийг орон нутгаар илгээж байлаа. юу ч мэдэхгүй олон хүнийг янз бү ри йн үйлдвэр, уха ан ы мэргэжилтэн, мэдлэгтэн болгож хувиргав . Тус улсын алс бөглүү нутаг газраар нууцл ан байгуулсан сургуулийн газар эрдэм номд сургах ажил нам тайван ээдрээгүй явагдаж, хэн ч саад тотгор хийхгүй байлаа. Яагаад гэвэл хэнийг ч тийм газраар зөвшөөрөлгүй гээр оруулдаггүй байсан . Шашнынаас л бүр их болгоомжилдог байлаа. юуны өмнө, багшийн дээд сургууль, ням гаригийн олон сургууль байгуулсан юм. Түүний үрээр ардын боловсролын нэгдмэл сайн с йстем нууцаар бий болж, бас улам хөгжмн дэлгэрэх протестант ы н салбарууд бий болж байв. Шашны асуудлаар би бүрэн эрх чөлөө опгож байсан болохоор христосын ямар салбар, х э н хэн баримтл а х нь өөрийн дурны хэрэг байсан Харин бурхны хуулийг сүм хийд, ням г аригийн сургуулиудаар заалгах явдлыг би хязгаарлаж, бусад сургуульд шашныг ерөөс заалгадаггүй байлаа. гагцхүү өөрийнхөө үзлийг илүү өргөж бүгдийг пресвитериа н шашинтан болгож чадах байсан боловч тэгээгүй, чингэвэл хүний мөн ч анарыг муйхраар хүчлэн дайрсан хэрэг болох билээ. хүн хүний о ю ун санааны хэрэгцээ дур сонирхол бол хүн хүний б и е махбодын хэрэгцээ, арьс, тэдний нүүр царайн байдлаас ял г аагүй олон янз байдаг бөгөөд хүний сэтгэл санааны байдал д өнгө, м а яг, оюун би л гээрээ аль нь илүү таармаар тийм шашнаа хүн шилж сонгон баримтла х ёстой Түүнээс гадна нэгдмэл шажин бий болгохоос би айдаг байв. тийм шажин бол хүчирхэг засаг, аль ч засгаас илүү хүчирхэг засаг юм. Шажны эрхийг хуваа х эрх аш г ийг бодсо н этгээдүүд гартаа авч ирсэн түүхтэй, тэгэхлээр нэгдмэл Шажин бол хүний эрх чөлөөг алж, хүний сэтгэхүйг зэмдэглэдэг Бүх хүдрийн уурхайг вангийн өмч хэмээн тооцдог байсан ба тийм уурхай олон байлаа. Надаас өмнө туйлын бүдүүлэг аргаар боловсруулдаг байжээ. . Газар малтаж арьсан уутанд хийж авдаг байсан нь өдөрт ганц торхоос хэтрэхгүй байж Тэгээд би уурхайн ажлыг аль болох шинжлэх ухааны үндэстэй болгох гэж оролдлоо Сагрэмон но ё н над хорсон ирүүлд дуудах үед би үнэхээр их юм. хийж амжсан байлаа. Дөнгөж дөрвөн жил болоход хичнээн их юм. хийсэн гэж санана . Ухаанд ч багт х ааргүй санагдах вий Хэмжээгүй эрхт засаг найдвартай хүний гарт байвал тун сайхан эд гэдэг нь мэдэгдсэн юм. . Тэ н гэрлэг хаант гүрэн бол төрийн шилдэг хэлбэр юм. Дэлхийн хаант засаг, хаан нь Хамгийн шилдэг хүн бөгөөд мөнөс настай хүн байх юм. бол мөн өөрцгүй төрийн шилдэг хэлбэр байхсан, гэтэл дэлхийн хамгийн төгс сайн хүн ч гэлээ. ү хэх тавилантай бөгөөд хойчийг зал г агч нь огт тийм төгс хүн б айх үгүй болохоор дэлхий н хаант засаг бол төрийн муу хэл бэр төдийгүй ер нь урьд хожид байсан төрийн хамгийн адаг нь юм. Вант улсын бү х ий л баял г ийг эзэмдсэн хаан хүн юу хийж

чадахыг би өөрийнхөө хөдөлмөрөөр харуулсан юм. . Арван есдүгээр зууны соёл иргэншлийг яг улаан нүүрэн дээр нь дэлгэрүүлж байхад балар харанхуй гэр орон сэжиг ава аг үй юм. Иргэ нш лийг олны нүднээс далдуур байлгасан боловч тэр бол няцагдашгүй том баримт болж байсан бөгөөд би үхчихгүй, азын тэнгэр цааш харчихдаггүй п юм. бол тэр тухай сонсогдоно . Иргэншил үнэхээр байсан, далд хэлбэртэй байсан нь утаагүй оргилоо хөх тэнгэрт гэмгүй цоройлгох сөнөсөн гал т уулын г үнд гадаа т и йш аюулт дөл уулгалах мэт нууц байсан юм. миний сургууль, сүм хийд дөрвөн жилийн өмнө нялх балчир байсан бол одоо насанд хүрсэн хүн шиг болж, дархны газрууд маань том том үйлдвэр болюв Сургууль тай арав хор ь хон ажилчинтай газар одоо мянгаараа а жилладаг болжээ Нэг сайн мэргэжилтэн б а йсан газар, одоо тавьтай болжээ. Ямар ч агшинд шөнө шиг харанхуй ертөнцийг нүд гялбам гэр л ээр нэлсхийн гэрэлтүүлб е гэвэл асаалтаа дарах ад л чадах хүн шиг байлаа. Гэхдээ би гэрлээ гэнэт асаах гэж бодоогүй юм. Гэнэт гэдэг бол миний бодлоо р биш Ард түмэн тийм гэ н эт юмыг дава х гүй, бас ч ноёрхо гч ром католинийн шажин намайг тэр даруй дайрч мэдэх байлаа. би тун хашир болгоомжтой ажиллаж байсан юм. . Итгэлтэй төлөөл өгч дөө дав х иулж хүлэг баатрын байдалтайгаар явж му х ар сү с гийг алх а м алхма а р сулруулж, түүгээрээ улс орноо төгс сайн зохион байгуулалд оруул а х бэлтгэл хийх ийг тэдэнд заа ва рладаг байлаа. Зүйрлэж хэлбэл миний бие гэрэл гэгээгээ эхлээд ганц лааны гэрлийн хэмжээтэй асааж цааш нь ал гуу раар нэмэх бодолт о й байв. Тусгай чи глэлийн сургуулиудыг улс орон даяар нууцаар байгуулсанд тэдгээр маань тун сайн ажиллаж байлда Намайг хэн ч айгаад байх г үй бол ийм ажлаа би улам ө ргөтгөн явуулах бодолтой байсан юм. Вест Пойнгт гэдэг цэргийнхээ дээд с ургуулийг би т ун их нууцалж байв. Түүнийгээ бусдын нүднээс хал хл ах гэж мэрийдэг байсан холын тэн г и си йн нэг боомт хотод байгуулсан усан цэргий нхэ э дээд сургуулийг бүр ч их нууцалдаг байлаа. хоёр дээд сургууль маань хоёу л санаанд хүрэхүйц цэцэглэн хөгжиж байв. Кларенс хорин хоёр нас хүрч миний баруун гар болж, заавар заалты г минь биелүүлдэг болов. юм. бүхнийг хийж чаддаг арван хуруу тэгш тун сайн залуу сонин гаргах ц аг болж байсан болохоор сүүлийн үед би түүнд сэт г үү л чийн мэргэжил заалаа Эхлээд том сонин гаргахгүй, зөвх ө н өрнөөн тү г ээх иргэншлээ сорин дэлгэрүүлэх зорилгоор өдөр тутмын х ууд а с га ргая гэж бодов, К алере нс жинхэнэ сонины ажилтан хүвий н авьяаст ай байсан үчир Энэ ажлыг санаснаараа хийж чадах байв. Тэр маань яр их даа зургадугаар зууны хэлээр, юм. бичихдээ арван есдүгээр зууны хэлээр бичдэг хоёрдмол маягийн хүн бол с он юм. сэтгүүлчи й х нь авьяас билэг зогсолт цуцалтгүй хөгжсөөр байв. Алабамын алс бөглүү нутгийн жижигхэн хотуудад гардаг сонины хэл найруулгын хэмжээнд хүрч тэргүүн өгүүллүүд нь агуулга хэлбэрийнхээ алинаар ч тэнд и й сонинуу д аас дутахаа байсан юм. би дний г арт байсан бас нэг мундаг ажил бол цахилгаан мэдээ, харил ц ах утас байлаа. Энэ талаар бага бага юм. хийж анхны шугамы нь өөрснөө ашиглаж нэг хэсэгтээ нууц байлгасан юм. Голдуу шөнийн цагаар а жилл ад аг тусгай бүлэг ажилчдыг э нэ тал а ар ажиллуулж хүний нүд н ээс далдлахын тулд багана ил босголгүй утсаа газар доо г уур тавьж байв. Газар доогуур тавьсан шу г ам бусдад мэдэгдэхгүйн дээр миний зохио со н тусг а арл агч тун сайн болсон учраа с утасны ажиллагаа г ойд сайн байсан Утас тавих ажилчдыг замаас хо л уур шууд шулуун тавихыг тушааж, галын дохиог ашиглан том хо туудын хооронд холбоо тогтоож шугамыг хянан харгалзахын тулд мэргэжилтэй хүмүүсийг энд тэндгүй тавьж байлаа. Ямар нэгэн га з ар хүрье г ээд зам а с уух юм. бол хэлээд өгөх мэдэх хүн улсын хэмжээгээр ганц ч олодохгүй, я аг аад гэвэл хэн ч ,гэсэн урьдаас тэ нд очно гэж явдагүй, зүгээр л тэнэсээр байгаад нэг хотод ч юм. уу г ацаанд очно, тэгээд ямар гэгч г а зар ирэв гэж асуух бодол толгойд ордоггүй ажээ. . Газрын зураг гаргах санаатай хэдэн удаа хүмүүс гаргаж

явуулсан боловч хар лам нар хөндлөн гөө с оролцож садаа болоод болж өг сөнгүй . Тэгэхлээр нь тэр ажлаа түр хойш тавьсан маань сүм хийд ийг өөр с д ийнх өө эсрэг болгохын хэрэггүй гэж бодсоных билээ. . Улс орон маань үндсэндээ намайг анх ирсэн үеэс өөр болсон юм.гүй хэвээр байлаа. би бага б ага өөрчлөлт хийсэн боловч хийсэн зүйл маань аргагүйн эрх эн д т ун шалих г үй, нүдэнд өртөхөөргүй байв. Вангийн санд ордог алба татвараас бусад алба гувчуурыг хараахан өөрчлөөгүй байсан боловч алба татварын ажлыг эмхэлж, шударга, ажил хэргийн үндэстэй болгосон у ч раас орлого дөрөв дахин нэмэгдэв . Алба татварыг нэлээд жигд хуваарилан тогтоосны ачаар хүмүүс н ийтдээ сэтгэл амсхийж миний засаглалыг сэтгэл зүрхнийхээ угаас магтдаг болов. Одоо би ээлжийнхээ амралтыг авья гэж өөрөө ший дсэн, яагаад гэвэл өөр таарч тохирох үеийг олох үнэхээр хэцүү байсан юм. Урд нь би ажил хэргийнхээ төлөө сэтгэл зовоод гадагш хол д он гарч чаддаггүй байсан бол одоо а жил маань найдвартай гарт, санасан зүйл сэтгэлчлэн бүтэж байлаа. хойшлуул а хыг гуйсан дөрвөн жилийн хугацаа чинь дуусаж байна. гэж ван олон уда а сануулах болсон явдал бол намайг адал явдал хайж ,алдар нэр олж Саграмор ноёнтон сэлэм зөрүүлэх зиндаанд хүрэх цаг болсон гэсэн н хэрэг юм. . Тэр ноён, өнгөөх Граалиа хайсаар ажээ. Ноёны хойноос хэд хэдэн аврах нэхүүл явуулж олохыг завдан авай миний бие чөлөөгөөрөө явахын тулд хангал т тай бэлтгэж, балмагд ан мэгдэхгүй байсан маань ил байна шүү д ээ

Арван нэгдүгээр бүлэг

ЯНК АДАЛ ЯВДАЛ БЭДРЭВ

Энэ хорвоо г ийн аль ч оронд эр э мгүй бүгд худал хэлдэг тийм олон тэнүүлч худалч нартай газар хэзээ ч байгаагүй Дандаа л ичих нүүргүй болсон, үлэмж биетэн, Ямар нэг хааны охин юм. уу , сурвалжит хатагтайг Ямар нэг холын шилтгээн цамхэгт хорьчихоод тамлаж байна., түүн и йг ү л эмж б ие тний гараас салгах хэрэгтэй гэж х удал юм. ярьсан Ямар нэг тэнүүлч амьтан наана хэлэхэд са рд нэг удаа ирнэ гээч . О г т танихгүй хүний амнаас ткиймэрхүү юм. сонсоод тэр чинь хаана Ямар газар вэ, тэнд чинь я а ж хүрч очих вэ, чи ер хэн гэгч хүн бэ гэж ван асууж лавладаг байх гэж та нар бодож байгаа бизээ . Тэгвэл, үгүй шүү, тиймэрхүү энгийн, эрүүл ухаантай хүний бодол толгойд нь орох зангүй . Ямар ,ч худал юм. ярих ад юу ч асууж лавлалгүй ховдоглон зал г их шиг болно. Намайг нэг яваад ирэх хооронд бас л Нэг тийм амьтан, тэр удаа Нэг бүсгүй хүн ирж улиг домог болсон худал юм. ярихдаа м анай эзэн хатагтай өөр бусад хаад ноёдын дөчин дөрвөн залуу үзэсгэлэнт хүүхнүүдийн хамт асар то м харанхуй шилтгээнд хоригдсоор хорин зург аан жил эрх чөлөөгүй зовж байна., ,тэр шилтгээний эзэд нь ах дүү гурван үлэмж биетэ н гэнэ Үлэмж биетэн бүр дөрвөн гартай, духан дундаа жимсэн чи н ээ ганц нүдт э й гэнэ, чухам ямар жимсний дайтай юм. бол гэдгийг хэлсэнгүй, ер нь тиймэ р үү нарийн ширийн юм. тоодоггүй улс л даа Үнэмшихэд бэрх Ван, Дугараг ширээний бүх хүлэг баатрын х а мт тийм балай юм. сонсож сэтгэл нь хөөрөөд адал явдал хайн мордох болох нь тэр хүлэг баатрууд нь бүгд тийм бололцоог завших санаатай ухасхийж хүн бүр намайг л явуулаад аль, намайг л явуулаад аль хэмээн гуйхад, тийм нэр алдар горилоогүй байтал минь ван намайг сонгон томилоход цаадүүл ихэд зэ в үүцэн урам хугарчээ . Тэгж шийдсэн тухайг Кларенс над хэлэхэд нь би сэтгэлээ арай ядан барьж билээ. гэтэл тэр м а ань сэтгэл э э барьж чадсангүй . Ван тийнхүү намайг илгээх гэж соёрх с онд нь мань хүн туйлын их талархан баярлаад хөөрсөн сэтгэлээ барьж чадаагүй хөл нь газар хүрэхгүй баярлан суух нь бүү хэл өрөөн дотуур дэвхцэж байлаа. би вангийн тэр соёрхлыг дотроо хараан зүхэвч ёс горимыг бодож б а ярласан царай гаргалаа

Дуртай байна. гэж хэллээ Цуст тоног авахуулсандаа баярладаг бол "тийм байх биз Нэгэнт тийм болсон хойно ямар ч байдлыг дээрдүүлэхийг хичээх ёстой, тэгээд дэмий харамсан цаг үрэхгүйн тулд хэрэг явдлын үнэн чанарыг мэдэж юу ашиглаж болохыг олох хэрэгтэй байлаа. Ямар ч худал юм.ан д хумсын чинээ ч бол үнэн юм. байдаг Тэр хумсын чинээ үнэний нь олох ёстой Нөгөө хүүхнийг дуудуулан ирүүлэв Харахад нүдэнд дулаан , царайлаг, даруухан хүүхэн байлаа., харин мэдүүлгийнх нь үнэн зөвийг эмэгтэй хүний цагтай зүйрлэхэд л болмоор аж

- Эрхэм минь , чамаас нарийн ширийн юм. лавласан уу ? гэж намайг асуухад тийм юм. асуугаагүй гэлээ. тийм байх гэж би лавгай бодсон би чамайг шалгахын тулд хэдэн юм. асууя, би тийм зантай хүн Өөрийн чинь баахан удаах нь , битгий гомдоорой, бид чинь бие биеэ танихгүй улс Та т үмэн юм. ярьж байж болох юм. би тиймгүй гэхгүй, гэвч ажил хэрэгт аливаа зүйлийг хүний хэлсэн үгээр итгэж болохгүй Та үүнийг өөрөө ойлгож байгаа байх би танаас хэдэн юм. асууна, та шууд л хариулаарай Та үлэмж биетэнтэй тааралдахын өмнө хаана байсан бэ?

- М одер оронд, ариун ноёнтон минь ,

- М одер оронд гэнэ ээ? би тийм улс орны тухай ер сонсоогүй юм байна. Эцэг эх чинь амьд уу ?

- Амьд эсэхийг мэдэхгүй би өчнөөн олон жил шилтгээнд хоригдсон хүн шүү дээ

- тань нэрийг хэн гэдэг вэ?

- Ноёнтон минь , намайг Алисанда ля Карте луаз гэдэг

- энд таныг таних мэдэх хүн бий юу ?

- Хай бүү мэд, би чинь энд ер ирж байгаагүй хүн шүү дээ, ноёнтон минь

- Таныг итгэж болно. гэмээр захидал, баримт бичиг, Ямар нэг баталгаа танд байна. уу ?

- юу байх вэ би хэлтэй хүн, өөрийн хөө тухай өөрөө бүгдийн нь ярьж чадна шүү дээ

- Та өөрөө өөрийнхөө тухай ярина гэдэг нэг хэрэг, таны тухай өөр хүн ярина гэдэг өмнө өхөөрх шүү дээ

- Ямар ялгаа байна. би таныг ойлгохгүй байх шиг байна.

- ойлгохгүй байна. гэж үү? Золигийн орон за, тэр ч яана гэх чөтгөр, тийм амархан юмыг ойлгохгүй байна. гэж үү? хоёр юмны ялгааг ойлгож чадахгүй гэж үү? Яагаад чийм гэмгүй маанаг царай гаргана вэ?

- би юу ? Бүү мэд Бурхан л мэднэ

- Бурхан мэднэ гэдэг чинь үнэн, үнэн Намайг жаахан уурлаж гэж санаж байна. уу ? гэвч бүү гомд, би огт уурлаагүй үй Өөр юм. ярилцъя Тэр шилтгээн чинь гурван үлэмж би етнийх юм. байж, тэнд дөчин таван ноёгтой хоригддог байж Хаана байдаг юм. тэр татвар эмс?

- Татвар эмс ээ?

- за яахав тэр шилтгээн чинь , тэр шилтгээн чинь хаана байдаг юм. та миний үгийг ойлгож байна. уу

- Аа, уу х ай Тэр шилтгээн бол асар том, орохын аргагүй, гоё ганган, алс холын орон газар байдаг юм. эндээс тун олон лиг газар

- Чухам хэдэн лиг юм.?

- Аа, ариун ноёнтон минь , хичнээн гэж хэлэх тун хэцүү, яагаад гэвэл тийм олон, яагаад гэвэл нэг нь нэг дээрээ давхцсан, бас яагаад гэвэл бүгд нэг дүрстэй, нэг өнгөтэй учраас нэгийг нөгөөгөөс нь ялгах арга байхгүй, тус бүрийг тусад нь тоолох юм. болохоор хэн тоолж барах вэ, тийм ажлыг бурхан л барахаас биш, хүн барахгүй, яагаад гэвэл та өөрөө мэднэ шүү дээ, юу гэвэл

- за боль, боль, тэр зайн тухай яриад яах вэ? Шилтгээн чинь аль зүгт байна. даа? эндээс аль чигт байна.

- Аа, ноёнтон минь өршөөгөөрэй, зам нь дандаа дугуйрч байдаг болохоор аль ч чиг гэж заах арга алга, ийм замын чигийг мэдэх арга алга нэг тэнгэрийн доогуур явснаа өөр нэг тэнгэрийн доогуур орно зүүнтээ явж байна. гэж бодож байтал хагас дугуйрч яваад баруун тийшээ болчихно, ийм хачин юм. байн байн болсоор олон удаа болно., тэгээд сүүлд нь хүний ухаан гэдэг чинь дэмжжэе юм байна. гэж бодогдож эхэлнэ, яагаад гэвэл цааш мэддэг нь зааж өгье гэвэл шилтгээн хүрэхэд ямар чигээр явахыг заагаад өгнө, заах дургүй бол газар дээрх бүх шилтгээн, бүх чиглэлийг устгачихаад хов хоосон юм. үлдээнэ, энэ өөрийн мэдлийн амьтад ер нь хүсвэл хэлнэ, үгүй бол үгүй гэдгээ н отлох гэж

- Энэ бүгд чинь үнэн, үнэн харин би жаахан амс хийгээтхэе чигээр яах юм. чиг хэрэггүй, чөт гөр гэж өршөөгөөрэй, бурхан минь , өнөөдөр миний бие базаахгүй байна. . Би, ганцаараа яриад байвал анхаарах хэрэггүй миний сурсан зан, хуучин муу зан, төрөхөөсөө өмнө хичнээн ч жилийн урьд юм. бүү мэд, бэлэн байсан хоол идэж байж биеэ алсан тийм хүн ийм зангаа орхих тун яхир даа Мянга гурван зуун настай дэгдээхэйний мах идсэн хүний ходоод муудаж цөхөх юу байх вэ? за цааш нь ярь даа хачирхах хэрэггүй, цааш нь ярьдаа . Энэ хавийн чинь газрын зураг байна. уу ? Сайн зураг

- Эртүүд буруу номтонгууд их тэнгисийн тэнчээгээс авчирчихаад сонгино, давстай холбож чанах ёстой гэж нэг юм. ярилцаад байсан тийм юм. асууж байна. уу ?

- Газрын зураг чанах гэж үү? Та юу ярина вэ? Газрын зураг гэж та мэднэ биз? за, за тэр яах вэ, би тайлбарлахгүй, тайлбарлахад би ер дургүй, бүгдийг холион бантан болгочоод дараа нь юу ч ойлгох аргагүй болгодог юм. за, яв даа хонгор минь , баяртай Кларенс, хүргээд өг Энэ илжигнүүд тэр худалчдаас яагаад юу ч лавладагүйн учрыг би сая л ойлголоо Тэр хүүхэн, зарим нэг үнэн баримт мэдэж байсан байж болох юм. гэвч тэсрэх бодисоор л тэслэхгүй юм. бол ямар ч хөөрөг, тэр ч бүү хэл дариар ч гаргаж авч боломгүй ажээ. . Жинхэнэ балар мунхаг амьтан атал ван, түүний хүлэг баатрууд түүнийг ариун с удрын жишэнэ хуудаснаас дутахгүй хүн гэж бодсон байна. Ер нь бүхнийг тэгж бодох зантай улс Ордон хавийнхны зан заншил нь жигтэйхэн борог бааз байдаг болохоор тэр тэнүүлч хүүхэн вангийн ордонд түн зовлонгүй нэвтрэн орлох нь миний орон газар, манай үед юм. бол шөнийн унтлагын гэрт хэв ороод ирнэ гэсэнтэй адил юм. Ван,ч түүний орж Ирэхэд нь

баярлаж, чалча хыг нь сонсохдоо баярлаа л даа өнөөх балай адил явдлын талаар баа х ан худал юм. бурах нь шинжилгээний хүн хүүр олсон доо баярладаг шиг ванд бас тийм баярламаар юм. болно. . Намайг бодож гүйцэхийн алдад Кларенс буцаж ирэхэд нь би, тэр хүүхнээс юу ч мэдэж авч чадсангүй, уг шилтгээнийг хайж ол о ход над тус болох ганц ч юм. хэлж өг сөнгүй гэ хэ д залуу маань нэлээд зовсон байдалтайгаар ер нь та яах гэж юм. асуусан юм. гэх нь тэр

- Чөтгөр алгадмар, би тэр шилтгээний нь олох юмсан Хаана байгаагий нь мэдэхгүй байж яаж олж очих юм.?

- Эрхэм ноёнгон минь , юу хан байх вэ хүүхэн өөрөө тантай цуг явна Т эг дэг юм. Тантай цуг явна

- Надтай цуг уу ? дэмий юм. бүү ярь

- Явалгүй яах вэ Цуг явна Харж л байгаарай

- юу ? би өөр хүнтэй бараг сүй тавьчихаад байхад надтай ганцаархнаа уул тайгаар тэнэ нэ гэж үү? Тун б азаахгүй хэрэг хүн амьтан юу гэх вэ? Нүдэнд минь ямар хөөрхөн царай харагдах шиг болсон гэж санана . Кларенс ч миний зүрх сэтгэлийн явдлыг шалгааж гарах нь тэр Мини й ярьсныг хүнд хэлж болохгүй гэж ам тангаргий нь авч чихэнд нь Пусс Фланаган гэхэд мань эр гонсойж тийм гүн ахайг дуулаагүй юм байна. гэлээ. Тэр дор нь цол гуншин олгодог гэж ордны зарц боддог байж, аргагүй юм даа Тэгээд хаана байдаг юм. гэхэд нь би Хар ... ,ын гэснээ гэнэт и чи нгүйрэн зовж түгдэрснээ Одоо энэ талаар ярих хэрэг алга би хожим чамд яримз гэв мань хүн түүнтэй уулзаж чадах юм. бол уу ? хэзээ нэгэн цагт түүнийг би нүд хужирлуулах бол уу ? Мянга гуравхан зуун жил гэдэг юм.гүй хугацаа учраас би амлахад айх юм. алга байсан болохоор тэгнэ гээд хэл чихлээ хэлчихээд сүүрс алдлаа Төрөөч үгүй байсан хүний төлөө сүүрс алдах маань утгагүй хэрэг, Ер нь бид сэтгэл санааныхаа хүчинд автахлаар бодож шүүхийн оронд мэдэрдэг зантай төржээ . Намайг явах гэж байгаа гэсэн яриа өдөр шөнөгүй тарж, миний талын залуучууд над тус болох гэж өрсөлдөн, өөрсдийнхөө хэргийг орхин намайг л эргүүлдэж, мөнөөх үлэмж биетнүүдийг дарж, хүүхнээрээ өтөлж буй эмсийг суллаж чадах бол уу , үгүй бол уу гэмээн өөрснөөл гавьяат тэр үйлсээр мордох гэж буй мэтээр уйман байлаа. Тэр залуус маань сайн хүүхдүүд, үнэхээр л балчир амьтад байсан юм. . Үлэмж биетнүүдийг яаж хөөн мөрдөх, яаж дайрах, ид шидий нь дарах хараал тарни зааж шарх олбол анагаагаарай гэж эм зэм, элдэв новш зөндөө өгөв Тэд намайг үнэхээр рид хувилгаантай хүн гэж боддог атлаа алс хол хийн ердийн махчинтай байтугай, тэнгэрийн галаар амьсгалдаг луу юм. уу эрлэг н омуун хааны чөтгөр шуламтай дайтаха а р явсан ч эм дом, хараал тарни, зэвсэг, дуулга хэрэггүй гэсэн бодол тэдний нэгнийх нь ч толгойд орохгүй байсан юм. . Өглөө зрт хоол ундаа идэж уучихаад үүрээр морддог журамтай байсан боловч би тэр хуяг дуулгатай нь баахан мунгинаж нэлээд саатав . Өмсөж зүүхэд м ая гтай, аар саар олон юм.ы нь тогтоох бэрх юуны өмнө биеэ хөнжлөөр ороож хүйтэн мэснээс хамгаалах жийрэг болгоод дээр нь гархин хуяг өмсөнө, энэ нь бол жижиг ган цагираг хэлхэж сүлжиж хийсэн ханцуйтэй цамцарх уу юм. хари н уян хатан гэдэг нь тун гайхалтай учир шалан дээр хаях юм. бол усанд н о рсон тор шиг бөөн юм. овойно, харин дэндүү хүнд болохоор шөнө бол тэрүүн шиг дэмий эд ер үгүй биз гэтэл татвар хураагчид, шинэтгэгчид болон ганц морь хийгээд үнэн худал цол гуншингаас өөр юм.гүй ван нар мэт олон хүн түүнийг хэрэглэнэ . Дараа нь ган судалтай жийрэгтэй гутал өмсөж, нүсэр муухай давируул хийнэ Тэгээд хөлийн хуягийг өвдөг даруулан өмсөж бүдүүн гуяндаа гуявч хийнэ тэгсний сүүлд цээж, нурууны хуяг зүүхийн алдад

л хү н ачаагаа ихдэж буйг мэдрэх болно., Цээжнийхээ хуягт өргөн ган туузаар хийсэн оготор банзал зүүж унжуулан хөлнийхөө дээд хэсгийг хаах ба ар талдаа оноотой байдаг нь суухад эвтэй болно. Тэр банзал нь нүүрсний хөмөрсөн хайрцаг шиг бөгөөд өмсөхөд тун ч эвгүйг зүйрлэвэл түүгээр гар арчина гэсэнтэй адил тохиромжтой Дараа нь юлд агсаж гартаа ханцуйвч хэмээх зуухны хоолой зүүж мөн төмөр ханцуй хийнэ, толгойдоо дагз хамгаалах ган тортой төмөө Углааш өмсөнө, ингээд тусгай бэлдэж ороосон лаа шиг юм. болно. доо тийм гоёлтой хүнийг бүж гэвэл доромжилсон хэрэг болно. . Тэгж ороож б о о л г осон хүн г олдоо идээ гэх юм.гүй ц ө мөх хэрэгцээгүй зузаан хальстай самар л гэсэн үг залуус маань намайг хамжин хувцаслав . Тэд туслаагүй би дангаараа санах биш ажил байв. Дөнгөж хувцаслачихаад байтал Бедивер ноён орж ирлээ Намайг урт удаан аянд таарахаар хувцаслаагүй байна. гэж бодож буй нь илт байв. Бедивер ноён өмсгөлөө зүүчхээд байгаа нь үнэхээр өндөр, ханхар, данагар харагдана Зөвхөн чихээ хүрсэн шовгор төмөр дуулга өмсөж, нүүрэндээ багны оронд ердөөл дээд уруулаа хүртэл хамраа хамгаалсан нарийн ган тууз унжуулжээ Шилнээсээ өсгийгөө хүртэл гархин хуягаар хийсэн өмд цамц өмсчээ мөн гарх и хуягаар хийсэн цув давхарла с ан нь түүний мөрнөөс шагай хүртэл унжсан харагдана Цув нь тэг дундаасаа доош ар өвөргүй оноотой учраас Бедивер ноён мориндоо залрахад цув нь хоёр тал руу гаа морины бөөр рүү унжиж байлаа. Тэр ноён мөн л Граалийн хойноос хөөцөлдөх аянд мордож буй тул хувцас хүнар нь аян замд тун таарсан байв. Би тийм цамцтай болохын тулд юм. хайрлахгүй байсан боловч ца г т хавчигдаад амжсангүй . Нар гарч, ван, ноёд ынхоо хамт гарч ирээд намайг аян замдаа эс эн мэнд явахыг өрөөн үдэх ажилд бэлдээд байсан тул би хожимдвол ёс алдсан болох билээ. . Мори н доо мордох гэтэл тэднүүс наранд цохиулсан хүнийг эмнэлгийн газ а р сугад ан авчирдаг шиг тал талаас чирээд эмээл дээр гаргасан хо й ноо хөл дөрөөлүүлнэ Ер нь огт өөр хүн болчихсон шиг бие ч даамгүй болж, э с хүл саяхан гэрлэсэн хүн юм. уу , аль эсхүл аянганд нир г үүлээд одоо хүртэл нүд нь юм. харахгүй, хэл нь үг хэлж чадахгүй, чих дүлийрчхээд ухаан сэхээ ороогүй хүн шиг л байлаа. Тэгээд зүүн хөлийн доод тавиур дээр жад гэж нэрлэдэг нэг их урт юм. т а в ь магц түүнээ нь ухахийн барилаа хамийн сүүлд шилэй дээр бгубэй өмсгөдөг юм байна. . Одоо би зангуугаа өргөөд тэнгисийн аялалд гарахад бэлэн болов. Бүгд надад сайныг е рөөж, т эр ч бүү хэл х эргэмт нэг авгай замдаа сайн яваад ирээрэй хэмээн нэг цом гардуулсан . Одоо нөгөө хүүхнийг надтай сундлуулахад нөгөөдөх чинь унахаас бо л гоомжлон араас минь тас тэвэрлээ Тийнхүү биднийш аян замдаа гар а хад тэднүүс сайн явахын е рөөл тавьж алчуур, дуулга а раа даллаж байлаа. Гүвээ даван уруудаж нэг тосгоны дундуур гарахад ойр хавийн хэдэн ноорхой жаалаас бусад нь биднийг хүндэтгэн ёсолж, жаалууд бидэн үрүү

- чихмэл, чихмэл хэмээн хашгиралдаж бөөн бөөн шороо шидэж байв. Жаал хө в гүүд гэг ч аль ч зууны үед адилхан улс болохыг би нэгэнт мэдэх билээ. Тэдэнд хүндэтгэх хүн, хайрлах юм. гэж байх биш Хэнд ч муу юм. хийлгүй мөрөө хөөж явдаг байсан балар эртний үеийн зөнчийг хараад тэд Балай минь нүднээс то н ил гэж хаш г ирал дд аг л байсан Тэднүүс намайг дундад зууны ариун бүдэг бадгийн дотор өдөж доромжилж байсан Бьюк е н е нийг ерөнхийлөгч байхад нь бас л тэгдэг байсан би өөрөө тэр үед бас дүрсгүй жаалын нэг байсан болохоор сайн санаж байна. Зөнчид баавгайтайгаа явдаг байсан болохоор тэр үеийн жаалуудыг сүйдэлдэг байсан би мориноосоо бууж эдүгээгийн жаалуудыг болгож тавья гэж хүсэвч эргээд мордож чадахгүй байсан учраас боломжгүй байлаа. Өргөх цамхаггүй балай орон шүү

Арван хоёрдугаар бүлэг

УЖИГ ТАМ

хотын захад төдхөн гарахад эрт намрын сэрүүхэн өглөө хүн амьтангүй тэр ой хээр хичнээн сайхан, хичнээн гоё байлаа. уул толгодын орой дээрээс гайхаж барамгүй үзэсгэлэнт ногоон тал хөндий цэлийх агаад дундуур нь гол горхи мушгиралдан урсаж, энд тэнд бөөн бөөн төгөл мод, ганц ганцаар ургасан дүнхэр дүнхэр царс, тэдгээрийн сүүдэр нь гүн хар толбо мэт харагдана нуга хөндийн тэртээ цаана тэнгэрийн хаяа хүртэл униартах хөхөвтөр манан хучсан уул нуруу дол гиотох адил зэрэглээтнэ Тэдгээрийн оройгоор зар и мдаа цагаан, заримдаа боровгор толбо жирс жирс хийх бөгөөд тэр бол шилтгээн болохыг бид мэдэж байлаа. Шүүдэр тjalалзах өргөн өргөн нуга хөндийг туулахад газрын хөрс нь нэн зөөлөн учир морины туурайн чимээ ч үл гарах тул бид сүнс мэт бөгөөд нарны туяа навч мөчрийн завсраар ту са ж ногоон гэрэлд жирийх ойн жимээр зүүд нойрон дундаа явах адил ахихад нэн ту н галаг, нэн хүйтэн булаг горхийн ус морины маань туурайн дэргэдүүр хад чулуун дундуур жирэлээн урсах шоржигнох чимээ нь хөгжим мэт чимэгтэй байна.м нуга хөндийг гатлаад сүрлэг сүрлэг ойн төгөл дундуур аялахад ойн харуй бүрий биднийг нөмөрч,хачин хачин ээрлэг амьтад тун хурдан жирсхийн ө н гөрөхөд чухам хаанаас сүрдхийсэн зүгий нь ч мэдэхгүй, чухам хаана эртэч шувууд сэрээд юу юу гүй жиргэн донгодож, хоорондоо маргаж буй, чухам тэр нэвтэршгүй өргөн шугам аль модных нь хаана нь шавьж хорхой хачин жингэнэн жүнгэнэж буйг ч мэдэхгүй явлаа Цааш нилээд явтал ой си йрэгжин бид дахин нарны гэрэлтэй золголоо . Нар гарснаас хойш хоёр цаг орчмын дотор гүн шугуй дотроос нарны гэрэлд дөрөв таван удаа гарч ирэхэд анхныхаа бодвол сүүл сүүлдээ тийм аятайхан санагдахыг болив Халуун болж нар төөнөж эхэллээ Яг тийм нарнаар гал шиг хоргодох сүүдэргүй цэлий сэн тал тааралаааг байна. Ялимгүй тойвтой байсан юм. цаашдаа улам даамжирч газар авахыг ажихад сонирхолтой, анх ажаагүй юм. ажиглагдаж, цаашлах тусам даамж и рна . Эхний арав арван таван удаа нусны алчуур хэрэгтэй болоход би нэг их анзааралгүйг алчуургүй болно. гээд цааш явахдаа бүр ч санаандгүй байлаа. гэтэл сүүл сүүлдээ алчуур маань улам улам үгүйлэгдээд мартагч нь бүү хэл бүр тэсэх арга тасарч хуягт халаас хийдэггүй хүмүүсийг аль муугаар хар а аж эхэллээ миний нусны алчуур бас бус аар саар юмны хамт дуулга дотор байсан юм. гэтэл дуулгыг бусдын туслалцаагүйгээр тайлж болохгүй байв. Алчуураа тэнд хийж байхдаа ийм юм. болно. гэж бодсонгүй, үнэн д ээ мэдэхгүй байсан юм. чинь Тэнд хийх нь хамгийн эвгэй хэн газар гэж бодсон юм. гэтэл одоо алчуур маань хичнээн ойр байгаад ч авах аргагүйдээ би бүр их бухимдлаа . Ер нь бол бид болохгүй юманд зүтгэдэг Амьтан, үүнийг хүн бол г он андахгүй Дуулгаасаа өөр юу ч бодохоо болилоо бээр бээр газар өнгөрч л байна., миний бодлоос алчуур маань гарахгүй, хүслэн болсоор байв. Давстай г аш уун хөлс нүд үрүү ороод эхэлдэг, арчих юу ч байдаггүй, тун базаахгүй ийм юм. уншихад зовох юу байх вэ, өөр дээр ирвэл яана ё с той зовлон болоогүй бол би ийм юм. дурсах ч үгүй байсан Дараа л би хүн хар юу ч гэж муулсан хамаагүй эмэгтэй хүний цүнх авч гарна гэж өөртөө андгайллаа . Дугариг Ширээний голгүй тэнэгүүд ёсонд үл нийцнэ гээд намайг элэглэж дооглох л доо, гэсэн ч над гадаад өнгөнөөс эв хав хэзээд Илүү санагддаг болохоор яавал ч яаг гэж бодож байлаа. Цааш явах тусам замын тоос ихсэж амар хоолойгоор чихэхэд би бүр найтаалгаж, нүдний нулимс гоожиж байлаа. би хэн хүнээс дээргүй Амьтан болохоор хэлэх хэлэхгүй үг хэлж явлаа Тэр Британы цөлд ганц ч хүн амьтан, хүн иддэт мангас ч тааралдахгүй бололтой тиймэрхүү байдалтай явсан надтай нэг мангас, тэгэхдээ, нусны алчууртай мангас тааралдвал баярлах байлаа. Өөр бусад хүлэг баатрууд мангастай тааралдаад давын өмнө ээр зэвсгий нь булаа х ыг бодно, гэтэл би бол нусаа

нийхийн тулд алчуурыг нь л авахыг хичээж бусад төмөр хэрэгслий нь өөрт нь дуртай үлдээх байлаа. Улам халуу шатаж төөнөсөөр авай . Нар өгсөх дутам улам хүчтэй цоонож, миний төмөр хуяг дуулга улам хүчтэй төөнөнө Халууцахад хал болохгүй юм. гэж байхгүй Хатирган явахлаар уутанд хийсэн сав суулга харжиг таржиг хийх шиг чимэ э гарахаар миний уур бүр хүрнэ бамбай хэнхдэг, ар нурууруу байн байн дэлсэж уур хүргэнэ алхуулахаар хамаг үе мөч модон тэрэгний дугуй шиг чихарч нажигнаад ядахнаа, жаал сэрүүцэх салхигүй болж халуун зууханд шарах шюг болно. бас хичнээн удаан яваа тусам өмсгөл төмөр маань улам хүнд санагдаж, хором тутам хэдэн тонноор хүндрэх мэт Нэмэрт нь бас ганц гартаа бариад явахад дэндүү ядаргаатай учраас жадаа байнга сэлгэн бар ьж , хөл дээрээ ээлжлэн тав и на . Хар хөлс цутгахтай зэрэг хамаг бие загатнаж хорсож эхэлдэг ,уучлаарай, эвгүй муухай үг хэллээ их бие чинь дотуур, гар чинь гадаа, гар бие хоёрын хооронд төмөр байна. гэдэг бол амар хэрэг биш санагдана даа Нэг газар загатнаснаа өөр газар, бас нэг өөр газар загатнаж гарна энд тэндгүй загатнаж эхлээд сүүл сүүлдээ биеийн бүх талбайг эзлэн загатнахад ямар шүү хэцүү болохыг төсөөлөхөд ч бэрх ингэж зовж тарчилж явгал дуулганы нүүрэвчин доогуур ялаа орж х а мар дээр суулаа Нүүрэвчийг сөхье гэвч сөхөгдөхгүй хөшүүн болохоор би толгойтоо сэгсрэхэд өнөө х ялаа аюулгүй байдалд байгаагаа мэдсэн ца аш хэрхдэгийг та бүгд юу а н да х билээ. хамар дээрээс нисээд уруул дээр бууж, уруул дээрээс чих эн дээр бууж дүн г энэж дүнгэнэж час хий т эл хазлаа, тэртээ тэргүй зовсон би тэвчээр бүрмөсөн алдлаа Тэсэлгүй, Алисандыг миний дуулгыг тайлж, ялааг гарга гэхэд дуулга дотор байсан бүх юмыг аваад дуулгаар ус утгаж өгөхөд нь би ханатлаа ууж үлдсэний нь гархин хуягийнхаа дотуур цацлаа хичнээн сайхан сэргэснийг үгээр хэлэх арга алга Алисанд ус авчирч мин и й энгэр заам уруу байя гэтэл ус хийгээд амарч тайтгараж яасан сай х ан бэ? гэвч төгс тайтгарч, т өг с жаргахыг бид насандаа үздэггүй шүү дээ аянд мордохоосоо өмнө би нэг ганстай болж, бас тамхирхуу юм. хийсэн маань нэг их сайн болооггүй ч гэсэн индиан нарын уд модны навч хата а ж тагдаг азуй байсан юм. Гаанс, там х и маань дуулга дотор байсан болохоор одоо утаа гаргах бололцоо олдсон боловч чүдэнз байдаггүй, Бас нэг тун базаахгүй зүйл байсныг төдхөн м э дэж авсан, юу гэвэл бид хоёр аливаа тохиолдлын чанартай юмны эрхэнд орох байжээ. Хуяг өмссөн шинэ хүн бол мориндоо заавал хүнээр сугадуулж мордоно Лав п намайг мордуулна гэхэд ганц Сэнди хүчрэхгүй байлаа. Өөр хүн хар ирэхийг хүлээхэд хүрэв би баахан юм. бодож боловсруулах зорилготой байсан болохоор нам гүмд бясалгал хийх гэж тийнхүү хүлээхийг дуртай зөвшөөрөх билээ. ийм тойвтой төмөр өмсгөлийг бүтэн ухаантай биш гэхэд ядахнаа хагас ухаантай хүн яаж өмсөж дассан юм. бол, миний ингэж тамаа цайх шиг өдөр бүр тамаа цайх мөртлөө олон зуун жилийн турш ийм хэв журмыг яахлаараа сахидаг байна. гэдгийг би бясалгахсан гэж бодохоос гадна яавал энэ гайг засаж ийм тэнэг маягаас хүмүүсийг яавал ангижруулах вэ гэж бодовч С эн д ийг хажуудаа байсан цагт тийм юм. бодох бололцоо огт олохгүй байв. Сэнди бол бодь сэтгэлтэй, үгнээс гарахгүй сайн хүүхэн байсан, гэхдээ зогсоо зайгүй ч алчиж донгосоод эцэс сүүлд нь хот газрын олон тэрэгний чимээнд толгой тархи дүйрэх шиг хэл амаараа залхаана Амы нь лонхны бөглөө шиг юм.аар таглачихвал улам сайн хүүхэн болох байж дээ гэж бодогдоно гэтэл тийм хүмүүсийн амыг бөглөнө гэдэг бол амий нь авсантай өөрцгүй хэрэг болдог, тэгэхлээр энэ тухай бодовч толгой тархины гарз Өдөржин зогсоо зайгүй дуржигнуулсаар байгаад нэг л биш болох вий дээ гэж би зовсон боловч тийм юм. хэзээ д ч тохиол дд оггүй юм. байж Ярих үг дутахын зовло н гүй, бэлэн л урсаад байна. . Бүтэн х эдэн долоо хоногийн турш ч дуржигнуулан бурж до н гослоо гэхэд нь тэргийг бол тосолж цэвэрлэ х сэн гэж бодье, "мань хүнд тэгэхийн зовлон байхгүй дээ, Харин тэгж их дуржигнуулан донгоссоны нөлөөпөөр салхи хөдлөх нь тэр Ярьдаг юманд

нь учир у т га гэж байхгүй, зүгээр л манан будан гэсэн үг Жинхэнэ чалчаа амьтан байсан болохоор чалчаад л, чалчаад л, чалчаад л байдаг, донгосоод л, донгосоод л, донго ооод л байдаг, дуржигнуулаад л, дуржигнуулаад л, дуржитнуулаад л байдаг ер нь гэхэд энэнээсээ ч бүр даамай донгосож чадах хүн л дээ Өглөө босоод би түүний тасардаггүй донгосоог ажих ч сөгөөгүй, өөр өдий төдий олиггүй юмтай тулгарсан юм. Харин үдээс хойш нэг л удаа ингэж хэлсэн Дуугүй болж үз, охин минь , чи эндхийн агаарыг ингэж зарцуулах юм. бол вант улс маань , тэртэй тэргүй хоосорч буй сан хөмрөгөө шавхаж гадаадаас агаар авахад хүрнэ шүү

Арван гуравдугаар бүлэг

ЧӨЛӨ ӨТ ХҮ МҮҮС

Х үн түр зуур л хачирхмаар түр зуур л сэтгэл өөг байж чадна . Дөнгөж түрүүх э н үйлээ үзэж тамаа цайж явсан гэхэд одоо ширүүвтэр урсгалтай булгийн эрэг дээр анир чимээгүй аглуун энэ газар түр амран, тайтгараад гархин хуягийнхаа цаагуур ус байн байн цацаж байгаа маань диваажинтай өөрцгүй мэт санагдана гэтэл аль хэдүйн чүдэнз ний үйлдвэр байгуулсан мөртлөө биедээ чүдэнз авч гаралгүй, одоо там хи а асааж чадахгүй, бас идэх юм.гүйдээ бухимдаж эхэлсэн юм. Тэр үеийн, тэр ард түмний хүүхэд шиг гэнэн хонгорын биетэй жишээ болсон юм даа аянд мордох цэрэг эр хүнс хоол авч явах номгүй, замдаа олж идэх учиртай болохоор идэх юмтай хүүдий сав хүнд жаданд нь нэмэр болгохыг хэн ч дурлахгүй гэдэг байж Эмээл дээрээ тийм юмтай явснаас турж үхсэн дээр гэж Дугариг Ширээний хүлэг баатруудын хэн нь ч бодох ажээ. Үү н ээс илүү ухаалаг юм. байх уу гэж бод о гдмоор би хоёр хэсэг хачиртай талх дуулгандаа хийчих санаатай о ролдсон боловч баригдаж уучлалт гуйгаад нохойд хаясан билээ. Шөнө болж дуутай бороо цутган харанхуйлж эхлэхэд хоноглох оромж хэрэгтэй болов. Охиныг нэг хадан цохион дор, өөрөө холхон нэг цохионы дор хоргодлоо Хуяг дуулгатайгаа унтахаас ар гаг үй болсон, яагаад гэвэл би өөрөө тайлж чадахгүй, Алисандаар тус луулж болохгүй, хүний дэргэд хувцсаа тайчиж яаж болохов Хуяг дуулганы дотуур би ердийнхөө хувцастай байсан боловч сурсан дадсан заншлаас тийм амархан салдаггүй санж богино төмөр банзлаа тайлахад над тун ичгүүртэй гэж бодлоо Дуутай бороо орох дусам агаар ,тэнгэрийн байдал өөрчлөгдөж салхи улам ширүүсэж, бороо улам шавхуурда н , улам хүйтэн болов. Бороонд норохыг үл хүсэн цох, шоргоолж, ө т хорхой тал бүрээс миний нөмөр бараадаж гархин хуяган доогуур чихэж гарлаа з арим нь хувцасны завсар заалхайгаар ороод тэр чигээрээ томоотой байхад зүгээр байж чаддаггүй нь илүү олон бөгөөд өөрснөө ч зорилгоо мэдэхгүй дэмий л нааш цааш гүйлдэнэ Ялангуяа шоргоолжнууд нэг үзүүрээс нөгөө тал уруу тойвгой нь аргагүй аялал хийж бие сэрвэгнүүлэн үйл барлаа . Дахиад шоргоолжтой хамт унтахгүй юм.сан . Байн байн эргэж хөрвөх юм. уу , биеэ үдэх энэ тэр хэрэггүй юм. тэгэх тусам ойр хавьд буй хорхой шавьжийн анхаарал татдаг, тэгээд нэг бүр нь энэ хавьд юу болов. хэмээн үзэхийг хүсээд байдлыг улам хүнд болгож хараал зүхлээ чадах чи н ээгээрээ бар а хад хүрдэг юм байна. лээ шүү гэж би над шиг байдалд орсон хүмүүст зөвлөмөөр байна. гэвч эртэж хөрвөж, биеэ нүдэхгүй бол үхнэ шүү дээ, тэгэхлээр яамаар байна., өөрөө л мэдэхээс биш, өөр арга үнэндээ байхгүй дээ би бүр бээрчихээд байхдаа ч бие сэрвэгнэхийг мэдэрч цахилгаан гүйдэлд хүүр татвалздаг шиг татганаж байлаа. аянаас буцаж очоод амьдралдаа хуяг өмсөхгүй гэж би дотроо тангарагласан . Нэг талаар хүйтэнд даарч, нөгөө талаар сэрвэтнэх, загатнаж халуу оргих тэр зовлонт хугацаанд миний алжаасан толгойд хүмүүс яаж ийм галт хуяг дуулга өмсөж чадна вэ? тийм олон үеийн турш тэвчиж яаж чадна вэ? Дараа өдрийнхөө амсах тамаас сүрдэлгүй яаж өдрийг өнгөрөөж чадна вэ? гэсэн асуулт л эргэлдсээр байв. Тэгж

тэгж үүр цайхчаа болоход би бүр танагаа алдаж тойргүй хоносных урвайж улбайн ямбийж, шөнийн турш биеэ нүдэж ядарсан, гуринхатсан, нүүр гараа угаах, хорхой шавьж устгах хүслэнд автсан, үе мөчний өвчин хөдөлж тарчилсан амьтан болсон байлаа. харин язгуурт гаралтай, цол гуншин хүртсэн хүүхэн Алх и санда ля Карт е луаз ямар байв.аа? Өө, бүр Давгүй, амарч өнгө орчихсон хэрэм дүүлэх адил гялалзаж байлаа. шөнөжин үхсэн юм. шиг л унтсан гэнэ . Тус орны язгуурт хүн бүхэн нүүр гараа у г аах за ншил сураагүй учраас үгүйлэх дутсан юм. түүнд үгүй байв. орчин үеийн байдлаас харвал тэр үеийн хүмүүс үнэн дээзэрлэг байжээ. Намайг дагалдан яваа тэр язгуурт эмэгтэйд өглөө түргэхэн шиг хоол унд идэж уух гэсэн өчүүхэн ч хүсэл илрэхгүй байсан нь бас л зэрлэг хүмүүсийн нэг шинж юм даа Тэр үеийн б ир танчууд аянд явахдаа хоол унд хэрэглэхгүй удаан тэсдэг байж Мордохынхоо өмнө тэд индианчууд болон удав могой н адил хэд хоног өл авахаар баахан идэж уучихдаг байна. Сэнди лав л гурав хоног даахаар идэж уусан нь эргэлзээгүй Бид хоёр нар гарахаас өмнөхөн замд гарлаа Сэнди морь унаж, би араас нь гэлдрэхчээ аядав Хагас цаг хэртэй яваад зам нэртэй юм. засаж буй хэдэн ноорхой ядуу хүнтэй тааралдлаа . Тэд миний өмнө адгуус шиг номхон гарын дор байх бөгөөд хоол унднаас чинь идэж болох уу гэхэд миний туйлын дарууг гайхан анхандаа итгэхгүй байв. Хатагтай маань ярвайн хямсганаад холдон зайлж, аливаа муусайн малуудтай хамт тоол унд идэхгүй гэж чанга дуугаар хэлэхэд тэр хөөр хий ядуучуул тэр үгэнд гомдох байтугай харин ч айж байв. Тэднүүс бол боол ч биш, хамжлагын тариачид биш юм. өөрснөөр нь зориуд доог то х уу хийх гэсэн шиг чөлөөт хүмүүс гэж нэрлэжээ чөлөөт хүмүүс гэдэгт нь тус орны хамжлага биш хүн амын аравны долоо нь байдаг биеэ даасан жижиг аж а х уйтан, гар урчуул гэх мэт хүмүүс орж Өөрөөр хэлбэл, тэднүүс ард түмэн, жинхэнэ үндэстэн нь байлаа. тэр давхаргын дотроос тэр үндэстний хамгийн ашигтай, хүндэлбэл зохих хүмүүс төрнө, тэднүүсийг үндэстний бүрэлдхүүнээс хасчихвал гагцхүү эвдэж сүйдлэхээс өөр юу ч хийж чаддагүй, ер нь зохистой тевхмөсөн нийгэмд ямар ч үнэ цэнэгүй, ямарч ашиггүй, залхууван, тайж, язгууртан мэтийн хог шаар, новш үлдэнэ гэтэл алтаар өнгөлсөн тэр цөөнх нь ов мэхийнхээ үчээр магнайд нь туг намируулан явна, уг нь тэднүүс хамгийн сүүлд нь сажлах ёстой билээ. Тэр цөөнх этгээдүүд өөрснийгөө үндэсний жинхэнэ гол нуруугэж үзэж тоо то мшгүй х өдөлм ө рчин олон нь түүнд итгэж тийм үл бүтэх байдлыг хүлцэхээр үл барам зүй ёсны шударга ёс гэж итгэнэ Хар лам нар тэднүүс болон тэдний өвөг эцэг өвгөдөд бурхал тэгж доромж явахыг заяасан гэх б өгөөд цаадуул нь бурхан хүнээр тоглоом хийж тийм хөөрхий болгох ёсгүй баймаар гэж бодох ч үгүй гээр лам нарт итгэж номхон хүлцэнгүй байх болжээ. Салхан арван есдүгээр зууны америк хүн байсан хүн тийм хүлцэнгүй номхон хүмүүсийн яриаг сонсоход хачин санагдана Тэд чөлөөт хүмүүс гэж тооцогдох боловч өөрийн ноён буюу хамбынхаа зөвшөөрөлгүй нутаг газраасаа гарч явах эрхгүй, Тэд өөрснөө тариагаа цайруулж, талхаа хийх эрхгүй, өөрсдийнхөө тариа будааг ноёны тээрэм дээр аваачиж, бүх гурилаа ноёны талхны газар оруулж тэр бүгдийн төлөө их хөлс төлнө Тэд ноёндoo ихэнх мөнгий нь өгөхгүйгээр алгын чинээ газраа зарах ч эрхгүй, бусдаас газар худалдаж авбал худалдах зөвшөөрөл өгсөн гэж ноёндoo мөнгө төлнө Ноёны тар и аланг хурааж өгнө, ноёны дуудсан цагт бол бороо шуурга болох гэж байсан ч өөрийнхөө тариаланг орхиод очих ёстой Тэд өөрийн газар, ноёны жимсний моды нь тарьж өгч, хожим жимс хураагч нар тариаланг нь т а хчин гишгэлэхэд уур хилэнгээ барьж ядна Тэд, ноёноо гийчдийнхээ хамт авд мордож тэдний хүч хөдөлмөрөө зарж босгосон хамаг юм. тариала н гийнх нь талбайг сүйдлэхэд дотроо эгдүүцэ в ч дараад өнгөрнө . Тэднүүс тагтаа т эжээх эрхгүй байхад хэрэв ноёны тагтааны үүрнээс сүрэг тагтаа ирж тариа будаагий нь цуслаж эхэлбэл уурандаа нэгий нь ч алах эрхгүй, яагаад гэвэл чингэсний төлөө хамгийн хатуу

цээрлэнэ Тэднүүсийг тариа будаагаа хурааж дууслаа гэмэгц төрөл бүрийн махчингууд хувиа авах гэж дайрч эхэлнэ дээ эхлээд сүм хийд хамгийн олигтойгоос нь шилэн сонгож арван хувий нь авчихна, дараа нь вангийн тахар нар хорин хувий нь авч, үлдсэн хэсгээс нь өөрийнх нь ноёны хүмүүс хотойтол авна Тэгж тонуулж тонуулчихаад юм. үлдвэл тэднийгээ хөмрөгтөө аваачлж хийнэ Тэгээд л тийм ч татвар, ийм ч татвар, эндхийн ч татвар, тэндхийн ч, татвар гээд татаад байна. Татвар төлдөг нь чөлөөт, биеэ даасан гуйлгачин л байхаас биш түүний ноён, хамба, үрээчин тайж нар, хамгийг и дэж цусладаг сүм хийд биш Хэрэв ноёны нойр шөнөдөө хүрэхгүй бол чөлөөт хүн өөрийнхөө хөдөлмөрийн дараа шөнө дөл цөөрмийн дэргэд мэлхий вааглуулахгүйн тулд усы нь нүдэж нойргүй хононо . Хэрэв чөлөөт хүний охин нь ингэхэд энэ бол ер хаант төрийн захиргааны хамгийн бузар булай, хэлье гэвч хүний амаас гарамгүй тийм бузар булай явдал юм. Хамгийн сүүлд нь хэрэв гаслан зовлонд нэрвэгдсэн чөлөөт хүн бүр цөхрөөд хүлцэн тэсвэрлэх аргагүй амьдралаа Дуусгаж амиа хорлох гэж үхлээс өршөөл гуйж хоргодох зай гуйх аваас номхон дүртэй сүм хийд тийм хүнийг тамын мөнхийн зовлон амсуулж, номхон дүртэй хууль түүнийг шөнө дунд ар нуруу руу нь гадас шааж ня д аан замын тэг дунд газар булаад, түүний эзэн болох ноён буюу хамба лам эд хөрөнгий нь авч бэлэвсэн авгайг нь өнчин хүүхэдтэй нь гадаа хөөж гаргана . Өөрийн Эзэн болох хамба ламдаа замы нь хөлсгүй засаж өгөх гэж Тэр хэдэн чөлөөт хүн үүр цүүрээр ирээд байгаа нь тэр ажээ. . Өрхийн тэргүүлэгч, хүүгийнхээ хамт гурван өдөр зүгээр ажил х и йж өгөх ёстой, харин зарц нь нэг өдрөөр илүү ажил хийж өгөх ёстой гэнэ . Мянга, мянган жилийн туршид ард түмнийг удаанаар тамлаж, тамын газарт ч эрээд олдохгүй худал, буза р тамын аргаар шахан гаргаж байсан торх дүүрэн цусных нь төлөө хагас дусал цус төлсөн ганц удаагийн цус урс г асан долгионоор мянга мянган жилийн тийм бузар булайг арчин арилгаж, эртний ер төлсөн үүрд мөнх дах, а риун өлзийг хувьсгалын өмнөх франц болон ,франц хүмүүсийн тухай ном унш и ж байна. уу даа би чинь гэж над сана гдаж билээ. хоёр маягийн хядлага байсныг марталгүй санаж явбал зохино Нэгнийх нь үед уур омог буцалсан цагтаа хүн ална Нөгөөдөх нь бол урьдаас бодож айвуу тайвуу хядна . Нэг нь хэдэн сар, нөгөө нь мянган жил үргэлжилнэ нэгд нь түм бума н хүн нөгөөд нь живаа дүнчүүр хүн хядна гэвч бидэнд нэг дэх нь , цөөн хүн хяддаг, хормын зуурын гэх юм. уу даа, тийм хядлага нь яагаад юм. илүү аймшигтай санагдана гэтэл насан туршдаа өлсөж цангаж, хөрч даарч, доромж луулж муугаа үзэж, ширүүн дарлалд зүрх сэтгэлээрээ тамл а гдахтай зүйрлэвэл сүхээр ганц дэлсүүлээд хоромхон зуур үхэх ямар аймшит байх вэ? галд амьдаараа шаруулж удаан үхэхийг аянгаад цохиулж дороо ү х эхтэй зүйрлэхэд хурдан үхэх юу байх билээ.? Биднийг айлган сүрдүүлж нус нулимсаа г оожуулахын хи ч ээнгүйлэн мэрийж муулдаг байсан тэрхүү нэг улаан хядлагаар амь үрэгдсэн бүх хүнийг хотын оршуулгын нэг газар л багтааж болох байгаа юм. гэтэл тэр эртний жинхэнэ, хэлж баршгүй хэрцгий, аймшигт хядлагаар амь хэлмэгдэгсдийн хүүр бүх франц нутаг т ч багтахгүй бизээ . Тийн атал тийм хядлагын хамаг аймшгийг ойлгож хэлмэгдэгсдий нь өрөвдөм сэтгэл зүрх өвдөх талаар бидэнд хэзээ ч хэн ч зааж байгаагүй . Надтай өглөөнийхөө хоол, ундыг хуваалцаж яриа хөөрөө болсон тэр чөлөөт нэртэй ядуу хүмүүс ван, ша ш и н , тайж язгууртныг туйлын гүн хү н дэтгэж байсан тул тэдний ясны заналт дайсан нь ч тэрнээс илүү муу юм. юү хүсэх билээ. Тэднийг харахаас инээд минь хүрч, гуниг төрж байлаа. чөлөөтэй сонгох эрхтэй мөртлөө эрх баригчдаар ганцхан Тэр бүлийг сонгож тэр нь үеийн үед угсаа залган авьяаслаг ч бай, унхиагүй мунхаг ч бай өөрсдийг нь эзэрхэж байх, бас өөр ганц ч г эр бүл, сонгогчийн г эр бүл ч гэсэн хэзээ ч хүрч чадахгүй тийм хүчин чадлыг олгох гэж сонгодог тийм ард түмэн байж болох уу , бас толгой эргэмээр өндөрт гарган магтан шагших гэж, мөн бусдыг доромжилсон бөгөөд улиран дамжих эрх ямба, хүндэтгэлээр тэднийг гоёж чимэх гэж,

бас улс орны доторхи бусад г эр бүлд, сонгогчийн г эр бүлд ч тийм эрх ямба, хүндэтгэлийг хүртээхгүйн тулд хэдэн зуун г эр бүлийг сонгох тийм ард түмэн байж болох уу ? гэж би тэднээс асуусан . Тэд миний үгийг хайн г адуу сонсоод ийм юм. огт мэдэхгүй, энэ тухай ер бодож үзээгүй, төрийн хэргийн талаар ард түмэн санал онолоо хэлдэг тийм орон байдаг гэж санахгүй байна. гэв тийм нэг орныг үзсэн, тийм ард түмэн өөртөө зонхилох нэгдмэл нэг шажныг буй болгохоос нааш эрхээ алддаггүй юм байна. лээ гэхэд тэд бас л хайнга сонсов Харин нэг нь миний өөдөөс ширтэн харж миний хэлсэн үгийг ухаарах санаатай удаанаар давтан хэлж байлаа. Тэгэхлээр нь би дахин хэлж өгөхөд тэр хүн төдхөн ойлгоод гараа зангидан зангаснаа сонгох эрхтэй ард түмэн хэзээ ч сайн дураараа тийм бузар булай байдалд орохгүй, сонгох эрхий нь хасаад ард түмнийг дээрэмдэнэ гэдэг бол гэмт хэргүүдийн дотроос хамгийн хүнд нь юм. гэлээ. би дотроо

- Энэ бол хүн юм. Иймэрхүү хүн олхон байвал эмэ орныг энх тунх болгож, засаг захиргааных нь бүхий л журмыг өөрчлөн энэ оронд үнэнч зүтгэж буйгаа нотлохсон гэж бодлоо Ингэхлээр би үнэнч зүтгэл гэдгийг эх орны албан газар, эрх баригч нарт биш, чухам эх оронд өөрт нь үнэнчээр зүтгэхийг хэлж байна шүү дээ Эх орон гэдэг бол жинхэнэ, багтай, мөнхийн юм. . Эх орныг хайрлөж, энхрийлэх хэрэгтэй, түүндээ үнэнч байх ёстой засаглал гэдэг бол гаднын, хувцасархуу зүйл, тэгэхлээр хувцас гэдэг чинь элэгдэж, урагдаж, өмсөхөд эвгүй болж, биеийг хүйтнээс өвчин үхлээс хаацайлж чадахгүй болж мэднэ Хуучин даавуунд үнэнч байх, хуучин даавууг магтан мандуулах, хуучин даавуунд сөгдөн мөргөх, хуучин даавууны төлөө үхэх гэдэг бол хаад нарын зохихон, хааныг хамтаалсан тэнэг, адгуусны үнэнч чанар мөн тийм үнэнч чанар хаант засагтай газраа л байгаасай билээ. би бол үндсэн хуулинд нь Улс төрийн бүх эрх ард түмний гарт байх бөгөөд аливаа бүх ч өлөөт төрийг ард түмний сайн сайхны төлөө байгуулж, түүний нэр төрөөр оршин тогтноно, ард түмэн хэрэгтэй гэж үзвэл хэзээ ч захиргааны хэлбэрийг өөрчлөх маргашгүй, салшгүй эрхийг эдэлнэ гэсэн үгтэй Конмек тикут нутагт төрсөн хүн билээ. Энэ үзлийн үүднээс үзвэл улс орных нь улс төрийн хувцас хүнар урагдчихаад байхад юу ч хэлэхгүй, шинэ хувцас хийх талаар үхуулахгүй байна. гэдэг бол эх оронд үнэнч иргэн биш, харин ч урвагч мөн х увцас нь урагджээ гэдгийг ганцаараа олж харсан хүн байлаа. ч гэсэн түүнийг уучлах арга алга Түүний үүрэг бол ямар ч болтугай ухуулах л ёстой, харин бусдынэс нь үүрэг бол хэрэв түүнтэй санал дүйхгүй бол саналаа өгөхгүй байх ёстой ч миний явсаар оччихсон оронд маань төрийн захир гааны талаар саналаа хэлдэг хүн гэвэл мянган хүн тутмаас зургаа байсан юм. Нөгөө есөн зуун ерэн дөрөв нь засаг захиргааны хэлбэрт дургүйцэн өөрчлөх нь зүйтэй гэвэл сонгомол зургаагийн эгдүү нь хүрч юү гээчийн бузар, ямар найгүй, яасан үнэргүй урвана вэ хэмээн дөвчитнөнө Өөрөөр хэлбэл, есөн зуун ерэн дөрөв нь бух ажлы нь хийж байхад нөгөө зургаа нь өөрсдийгөө захиргааны халагдашгүй гишүүд гэж сонгочихоод бүх орлогы нь авчихдаг байсан тийм нэг хувь нийлүүлсэн нэгтгэлийн хувь нийлүүлэгч байсан юм. Молиго үмхсэн есөн зуун өрэн дөрөв нь хөзрөө дахин холиод дахин хуваах ёстой мэт над санагддаг байсан би Эзэн гэдэг их хэргэмээ хаяад бослого зохиож хувьсга л болгоосой гэж хорхойтох боловч ямар нэгэн Жэк К э д юм. уу , Вот Тайлер урьдчилан хамтран зүтгэгчдээ бэлтгэлгүй хувьсгал эхэлбэл гарцаагүй дарагдана гэдгийг мэдэж байлаа. гэтэл би тийм бүтэлгүй юманд дасаагүй хүн тийм учраас миний бодсон хөзөр хуваалт бол КэдТайлерынхныхаас огт өө р маягийнх билээ. Х а р тапх зажлан гударч байсан хоёр хөлтэй танагт ү й мунхаг, дарлуулж нухлуулсан олны дотроос миний өөдөө с харж суух тэр хүнд би цус урсг а х, бослого гаргах тухай яриагүй, тэгээгүй, харин түүнийг хажуу тийш нь аваачаад огт өөр юм. ярьсан Ярих юмаа дуусгаад б и түүнийг г

үрээнийхээ бэхнээс над жаахан өгөөч хэмээн тэр бэхээрээ модны холтос дээр нарийхан савха а р *Үүнийг хүний үйлдвэр лүү илгээ* гэж бичээд түүнд өгч

- чи үүнийг Камелот дахь ордонд очиж Кларенс гэж миний дууддаг Алмас де Пулетэд өөрийн биеэр гардуул, тэр хүн аяндаа ойлгоно гэж хэлэхэд

- Тэр хүн чинь хар лам юм. шив дээ гэж хэлээд урам нь баахан хугарав бололтой

- юун лам? би тэр үйлдвэртээ сүм хийдийн боолуудыг ч, тэдгээрийн зарц лам, хамба нарыг ч оруул даггүй гэж би чамд ярьсан шүү дээ чиний шашин шүтлэг ямар ч байлаа. гэсэн түүнийгээ хувийн шүтлэг болгох юм. бол чамайг өөрийг чинь тэнд оруулж болно. гэж хэлсэн шүү дээ

- Ярих нь ярьсан, таны үгийг сонсох сайхан байсан, харин одоо тэнд тийм лам байна. гэхлээр сэжиг төрөөд явчлаа

- Тэр хүн бол лам огт биш гэдгийг чамд андгайлан хэлье гэвч мань эр над итгэхгүй байгаа нь ил байна. Тэгээд

- У н шиж чаддаг хүн яагаад лам биш байх вэ? гэж асуудаг байна шүү

- ийм учиртай лам биш атлаа уншиж чадна, бичиж ч чадна би өөрөө зааж өгсөн юм. Чамайг ч гэсэн тэр үйлдвэр дээр юуны өмнө бичиг уншдаг болгоно гэхэд мань хүний урам сэргэв

- Намайг уу? тийм сайхан юм. сурахын төлөө би цусаа бүгдий нь ч өгөх байна. Таны боол больё, боол тань

- Тэгэхгүй ээ, чамайг хэний ч боол б олгоогүй, б оол болгох хэрэгцээгүй т эр е р нь ноё ньгоо аваад замдаа гар чиний эзэн хамба чинь бага сага хөрөн г ийг аваг л даа хар буух хэрэггүй Кларенс чамд шан өгнө

Арван дөрөвд үгээ р б үлэг

НОЁН ТОН, БИЕЭ ХАМГААЛ

хоол н оос нь идсэндээ би гурван зоос төлсөн Тэр нь арван хоёр хүн хооллох юм. худалдан авах мөнгө байсан болохоор би их өгөөмөр гар гаргажээ гэвч би амарч бие тэнхэ рснээ с гадна угаас м өн гө үрэмтгий хүн билээ. Түүн э эс гад на тэр улс над хоол ундаа эүгээр өгөх гэсэн болохоор тэрэнд нь үнэн голохоо баярлаж арвин мөнгө өгч талархлаа илэрхийлэх гэсэн юм. Тэр үед зоосыг мөнгөөр хийдэг байсан болохоор хагас доллар төмөр зоосны хүнд гэдэг нь сүрхий Бас тэр зоос миний дуулг ан д байснаас тэдэнд байвал илүү их тустай байв. Тэр үед би үнэнээ хэлэхэд ер нь дэндүү үрэмт г ий байсан хүн юм. би Британд ирээд удсан мөртөө тухайн байдалд дасаж бас л амжаагүй, тэгээд Коннектикутэд хоёр доллараар авах юмыг Артурын вант улсад ганц зоосоор авч болох, мөнгөнийх нь ханш тийм гэдгийг бодолцоогүй явдал нөлөөлсөн бай х хэрэв би Камелотаас хэд хоногийн хойно гарсан бол би тэр хү м үүст өөрийнхөө цутгаж хийсэн цоо шинэ сайхан зоос өгөх байсан, тэгсэн бол надад ч, тэдэнд ч улам урамтай байх байлаа. би америк мөнгөний систем хэрэглэхээр шийдэж ганц хоёр долоо хоног болохоц цент, арван цент, хорин таван цент, тавин центын зоос бас алтан зоос гаргаж вант улсын худалдааны бүх салбар хэсгүүдээр нар ий н зурвасаар

шавхагдашгүй урсгал мэтээр оруулж бүх амьдралыг шинэ цусаар сэлбэх мэт сэргээнэ гэж бодсон юм. Аль түрүүний тэгж бодож бойсан юм. Тэр хүмүүс, миний өгөөмөр гар гаргасны хариуд заавал юм. өгө х гэж хэт, цахиур бэлэглэхэд нь аваха а с яах вэ, тэгээд Сэнди бид хоёрыг морин дээр сундлуулахад би гансаа нэрж гарлаа Нүүрний халхавчнаас тамхины утаа дөнгөж манаран гармагц нөгөөдүүл бүгд ойн зүг гүйлдэж Сэнди мориноос уналаа Намайг тэд дайчин эрс б олон мэргэжлийн бусад худалч нарын ярихаас сон с сон галаар амьсгалдаг лууны нэг нь гэж б оджээ Учир явдлыг тэдэнд үнэнээр нь тайлж өгөх гэж дуугаа дуулдах газар арай чарай дө х өж очлоо Энэ бол миний дайснаас бусад хэнд ч аюу л үл у ч руулах өчүүхэн рид хувилга ан ы зүйл гэж хэлээд хэн над муу юм. саналгүй ойртож ирнэ тэр зүгээр, харин надад ойртож ирэхээс татгалзсан нэг нь тэр дороо үхнэ х а рж л байгаарай гэж гараараа ер зүрхээ даран байж хэлэхэд бүгд нэгэн зэрэг хөл мэдэн гүйлдэж ирлээ Оч их гүй үлдвэл нээрэн яадаг юм. бол гэж сониучлан зүрх лэх х үн гараагүй учир золгүй явдал тохиолдсонгүй Тэр сахалтай жаалууд айхаа больсон биш м и ний га л , ута а гаар амьсгалж чаддагийг туйлын их гайхан би ши рч дахин дахин үзүүлэхийг шалг а ан салалгүйд нь би хоёр дахин гансаа нэрж нэлээд цаг гарзадсан юм. гэвч тэгж саатсан маань ашиггүй өнгөр сө нгүй юу гэвэл Сэнди ганс тамхинд овоо даслаа Энэ бол хамтын маань аялалд чухал хэрэг юм. Бас за х гүй бурдаг машинаа түр зогсоосон явдал нь чамламгүй ашигтай байлаа. хамгийн чухал нь одоо би нэлээд юм. сурч, ямар ч мангас, махчинтай уулзахад давгүй болсон юм. Нэг даяанч хуврагийн дунд үдийн алдад туршлагаа хэрэг дээр сор ьж үзэх бололцоо олдов Бид өргөн тал дундуур явж байсан бөгөөд гүн бодолд автан явтал Сэнди аль өглөө эхэлсэн яриагаа таслан Ноёнтоон биеэ хамгаал Аминд чинь аюул учирлаа гэв Тэгээд мориноос буун хажуу тийш гүйгээд зогсов . Эргэж харсан чинь нэлээд хол, мод нь дор зэвсэгтэй х э дэн эр харагдана Тэд хирдхийх хөдөлж мордохыг завдан олмоо чантайж байна. Би гансандаа тамхи чихлээ Уг нь би энэ орныг талхинаас чөлөөлж, болж гэм хэнд ч гэм хүргэлгүйгээр ард түмэнд нь алдагдсан эрхийг нь олгож өгье гэж бодоогүй бол тамхиа аль хэдийн татчих байлаа. Тамхиа нэрээд утаагийг нь амандаа х адгалан тэднүүсийн дайран ир эхийг хүлээлээ Тэд дайчин эрсийн журамнаас гажиж бүгд нэгэн зэрэг над уруу давхилдан ирж байна. Тэднийг хүн р ү ү дайрахдаа аль дөнгүүр үхдэл нь журмын даг уу халз тулалдаж бусад нь зай болон харж зогсдог гэж номд огт худал бичсэн байдаг юм байна. Тэд жадаа зэхэн барьж, салхинд дэрвэгнэх өд сөд хатгасан малгайт толгойгоо бөхийохийн бүгд нэг зэрэг хуй салхи шиг дайран ирж байлаа. Энэ байдлыг модны орой дээрээс сонирхон харах юм. бол сайхан, тун сайхан, хараад баймаар үзэгдэлсэн би жадаа буулгаж, тэр төмөр долгионы ойртон айсуйг зүрх түгшин хүлээлээ, Тэгж байгаад нүүрнийхээ халхавчны торон дотор өтгөн цагаан утаагаа г а ргалаа Өнөөх төмөр долгион жирэлээн жижгэрээд эргэн хумирлаа Үүнийг харахад түрүүчийнхээс ч илүү ганга н хар а гд а на гэвч тэд, надаас гурван зуун тал алхам хэргтэй очиж зогсоход нь миний сэтгэл түгшиж эхэллээ Баярлаж байсан маань айдсаар солигдож, үхэл маань иржээ гэж бодов гэтэл Сэнди магнай тэнийж юм. ярих гэхэд нь би үгийг нь сонсолгүй, рид хувилгаан маань бүтэлгүй боллоо, чи моринд морд, зугтахаас өөр мөргүй боллоо гэхэд зугтах хэрэггүй, рид хувилгаан чинь Тэр цэрэг эрсийг хүч чадалгүй болгосон, цаашаа яагаад явахгүй байна. гэвэл тамир нь барагдаж орхиод тэр Жаахан хүлээзнэвэл тэд мориноосоо унаж морь, хуяг дуулга нь та бидний гарт орно гэхэд нь би түүний гэнэн бодлын үрийг завших гэж бодсонгүй, тэгээд надаас г а рдаг галын дөл алахаа хүрвэл дор нь алдаг юм. гэтэл тэр улс үхээгүй байгаа хойно миний машинд согог суусан байна., ясныг би өөрөө мэдэхгүй, аль болох түргэн зугтсан маань зөв болно., тэд ингэсгээд дахин уулгалан ирнэ гэхэд Сэнди хөхөрч

- Ноёнтон минь , Тэд тийм амьтад биш Ланселот ноён л луутай ч тулалдах хүн дийлэн дийлтлээ, устгаж сөнөөх хүртлээ лууг дахин дахин дайрсаар устгах хүн Пеллинор ноён магадгүй, бас эс г э вэл ноён, бас Карадос ноён, бас хэд хэдэн ноён магадгүй юү гэхээс биш бусад нь хоосон ханхалзан бардамнахаас цаашгүй, яавч тэгж чадахгүй Тэр муусайн бузар амьтад ингэж нэг чадуулчихаад дахин таны өөдөөс гар сарзайна гэж бодож байгаа юм. уу ? Тэгвэл юугаа хүлээнэ вэ? Яагаад тонилохгүй байна. Тэднүүсийг бариад байгаа хүн алга би тэдэнтэй нэгийгээ үзэж нэхийгээ тайлахад хүрье гээгүй,

- Та тэднүүсийг яваг гээд байгаа юм. уу ? Цаадуул чинь явж чадахгүй Яваасай гэж хүсэх ч үгүй, таны эрхэнд орохыг л хүсэж байгаа

- нээрэн үү? Тэгвэл түргэлэхгүй яагаа юм. бол?

- Энэ газар луу г хичнээн их хүндэлдгийг та мэддэгсэн бол тэдэнд буруу өгөхгүйсэн танд ойрто х оосоо айцгааж байна.

- Тэгвэл би өөрөө дөх ө х үү дээ Хэрэггүй хэрэггүй хэрэв таныг байрнаасаа а хөдөлб ө л цаадуулын чинь үнхэлцэг хагарч үхнэ би тэдэн дээр өөрөө очъё Тэгээд явлаа, түүнд тийн х үү явж очих нь аят й хан байж би бол тиймэрхүү ажлыг зүрхлэн хи йхгүй байсан биз Жаахан байзнаад харсан чинь нөгөө эрс давхилдан явж, Сэнди буцаж ирж байв. дотор онгойлоо Олигтой юм. лав болсонгүй, дөнгөж ярьж эхлэмц яриа нь тасарсан байлгүй тэрнээс биш тийм түргэн салахгүй байсан гэж би бодлоо гэтэл мань хүн сүрхий амжуулсан байв. энд эзэн чинь явж байна шүү дээ гэж хэлтэл цаадуулын сүнс нь зайлах дөхсөн гэнэ Тэд бүр ухаан алдатлаа айчхаад яа гэсэн ч яахаар л байсан гэнэ Тэгэхлээр нь та нар хоёр хоногийн дараа Артур вангийн өргөөнд очиж агт морь,

з эр зэвсэ г тэйгээ бууж өгөөд үүнээс хойш түүнээс цааш үг дуугүй з а хирагдан яв гэжээ
Сэнди надаас хавь гүй дээр юм. хийсэн юм. г а й х алтай сэнди

Арван та вду гаар бүлэг

С ЭНД ИЙН ЯРИА

- би одоо хэдэн морьтон эрийн эзэн боллоо Тийм юмтай болно. гэж огт бодсонгүй Одоо тэдний чинь яах билээ. мэдэхгүй л байна шүү, Сугалаанд өгчилтэй нь биги Хэд байсан бэ, Сэнди? гэж би цааш хөдөлсөн хойноо хэллээ

- Зэвсэг баригчды нь эс оролцуулбал долоо байна. лээ, ноёнтон

- Овоо хэд юмаа юун улс вэ, тэд ер нь ? Хаанаас гараад ирсэн бэ?

- Хаанаас гараад ирсэн гэнэ ээ?

- тийм, хаана байдаг юм. бол?

- Өө, би таны үгийг буруу ойлгож, одоо хэлээд өгье гээд гүн бодол болон зөөлөн дуугаар үгээ тод тод хэлэн ярилаа

- Хаанаас гараад шрэв, гараад ирэв гэлүү? Хаанаас гараад ирэв гэл үү? нээрэн, нээрэн л хаанаас гаараад ирээг гэмээр юм. аа? мөн сүрхий сайхан өгүүл бэр, үгийг сайхан холбосон байгаа биз? би энэ үгийг цээжилтлээ да в тах болно. Хаанаас гараад ирэв? Зүйтэй Одоо энэ үг хэлэхэд амар болж, бас

- чи энэ малчдын тухай ярина гэснээ мартаагүй биз, Сэнди?

- Малчдын тухай?

- за яах вэ, тэр морьтон эрсийн тухай чи тэдний тухай ярих гэсэн шүү дээ Шилжсэн утгаар хэлбэл чи эхнийхээ алхмыг хийсэн

- Эхний алхам?

- тийм ээ, тийм Бөмбөлгөө цохь чи ярих юмаа ярь, галаа ноцо о хдоо олон чүдэнз битгий гарзад гэж би хэлж байна шүү дээ чи тэр м орьтон эрсийнхээ тухай ярьж аль

- Ярьж өгье, одоо эхэлье Тэгээд тэд хоёул замд гарч, асар их бин битүү ой дотор оржээ Тэгээд

- Чөтгөр ав би алдаа хийснээ дороо мэдлээ би өөрөө сэндийн уран үгийн урсгалынх нь цуггаланг хагалчих нь тэр миний л буруу одоо жинжэнэ баримттай юм. ярьгал нь лав нэг сарын хугацаа өнгөрнө юм. ярихдаа ор шилгүй эхлээд дүгнэлтгүй дуусгадаг хүн дээ Ярианых нь хоорондуур орох гэвэл, нэг бол агт ан з аарахгүй, эсвэл хоёрхон үгээр хариулж буцаад бүх ярьснаа давтаж эхэлнэ Иймд, яриан дундуур нь орвол байдлыг улам доройтгоно гэсэн үг гэвч би амь насаа бодож хоорондуур нь нэг биш олон удаа үг хаяж байсан, я а гаад гэвэл, нэг янзаар урсах усны шоржигнооныг бү ү хэл өдөржин чагнавал үхэж мэдэх билээ. бүр арга тасрахлаараа

- Чөтгөр ав гэчихсэн чинь нөгөөдөх маань дорхноо буцаж

- Тэгээд, тэднүүс хоёул замд гарч асар их бин битүү ой дотор оржээ тэгээд гээд л дахин ярилаа

- Тэд гэдэг чинь хэн юм.?

- Говэн ноён, Вэн ноён хоёр Тэр хоёрыг лам нарын газар очиход найрсгаар угтжээ Өглөө нь өтлөөний мөргөл үйлдээд дахий замдаа гарч асар их ойд очоод явтал гэнэт хээр хандийн нэг цамхгийн дэргэд арван хоёр үзэсгэлэнт хүүхэн Говэн ноёны мэлмийд тусчээ Тэдний хамт асар том морьтой хоёр хүлэг баатар байна. гэнэ хүүхнүүд томоо гэг ч ийн нэг модны д эргэдүүр зугаалж явах юм. гэнэ, Тэгсэн чинь тэр моны дэ э р нэг ц а гаан бамбай өлгөөстэй байх бөгөөд тэд дэргэдүүр нь явж өнгөрөх бүрдээ нулимж шавар шороо цацаж байхыг Говэн ноён харжээ Энэ оронд тиймэрхүү муу зан араншин байдгийг би нүдээрээ үзээгүй бол би чиний үгийг үнэмшихгүй байсан байх, Сэнди гэвч би тэр хүүхнүүд бамбайн дэргэдүүр явангаа нулимж буйг нь яг харж байгаа юм. шиг төсөөлж байна., эндхийн бүсгүйчүүл галзуу солиотой мэт байх юм. Хамгийн шилдэг гэгдэх ихэс дээдсийнхний эмэгтэйчүүд нь ч тийм юм. гэж байгаа юм шүү Түмэн бээрийн тэртээ, утас залгагч, хамгийн жир эмэгтэй ч гэсэн Артур вангийн орны хамгийн дээд язгууртны гүн ахайг эелдэг ааш, хүлцэнг үй даруу, хүн шиг намбатай байх талаар багшилж чадах юм.

- Утас залгагч хүүхэн?

- тийм Надаас тайлбар бүү хүс Тэр бол шинэ ертөнцийн хүүхэн, тийм хүн энд байхгүй заримдаа түүнийг ямар ч буруугүй байтал нь муухай аашлаад Дараа нь энүүндээ ичиж арван гурван зуун жилийн турш харамсана, яагаад тэр вэ гэвэл муухай аашлах, ялангуяа ул үндэсгүй муухай аашлах гэдэг бол бузар булай явдал юм. Хэдийвээр би, ... би үнэнээ хэлэхэд ганц ч жинхэнэ тохитой томоотой хүн утасны хүүхэнд муухай аашлах номгүй

- Тэр хүүхэн өөрөө

- Хаанаас даа, хөөрхий, би хичнээн тайлбарлалаа гэсэн чи түүнийг ойлгохгүй

- за тийм юм. бол тийм болог, өөрөө мэд Тэгээд Говэн ноён, Вэн ноён хоёр тэдэнд дөхөж очин мэнд амраа мэдэлцсэн даруй энэ бамбайг юуны учир та нар ингэж их зэвүүцэх болсон юм. бэ гэж асуухад хүүхнүүд Эрхэм нөөд минь , бид та нарт хариу хэлье Энэ цагаан бамбай, манай оронд байсан нэг дайчин эрийнх юм. Тэр бол эрэлхэг эр байсан юм. гэвч манай орны бүхий л хатагтай, язгууртан эмэгтэйчүүдийг үзэн яддаг байсан, тийм учир бид түүний бамбайг зүхдэг юм. гэхэд нь Говэн ноён Алдар цуутай дайчин эр хүн, х а тагтай, язгууртан эмэгтэйчүүдийг үзэн ядах нь зохисгүй хэрэг, гэвч түүнд чингэх шалтгаан байсан байж болно., өөр Ямар нэг улс гүрний хатагтай, язгууртан эмэгтэйчүүд сэтгэлтэй байсан байж мэднэ шүү дээ Та нарын ярьж байгаа шиг тийм эрэ л хэг б а й с а н юм. бол

- Эрэлхэг Ер нь эмэгтэйчүүл гагцхүү эрэ лх эг хүмүүсийг үнэлдэг юм. Сэнди Ухаан нь мөчид угс том Сейэрс, Жон Хинэн, Жон л Сэлливан, та нар энд байхгүй нь харамсалтай хорин дөрвөн цагийн д а р аа та Дугариг Ширээний дор хөлөө барьж ноён цол зүүх эрх олж болох байсан биз Бас хорин дөрвөн ц а г болоод та ордны бүх нөхөртэй гүнж, гүн ахай на р ыг хооронд нь холын хутгаад өгөх байсан биз эндхийн есгөө бол бүсэндээ цуст тоног аль илүү олныг х а вчуулсан тийм аливаа лужир эрээр хань нөхрөө солиход хззээд бэлэн байдаг индиан хүүхнүүдийн байдлыг илтгэнэ

- Тэр хүн та нарын хэлж байгаа шиг тийм эрэлхэг юм. бол нэрий нь хэл л дээ гэж Говэн ноёны хэлэхэд цаадуул Ноёнтон минь , Майсауз гэдэг юм. Ирландын ван хүү гэлээ.

- Ирландын в ангийн хүү гэж хэлэх хэрэгтэй чи буруу хэлж байна. за одоо сайн барьж байгаарей, энэ гуун дээгүүр харайлгана шүү уухай Манай морь циркэд таарах агт байна., даанч эрт төрж дээ

- Тэр дайчин эрийг би сайн танина, одоо оршиж байгаа эрсийн хэний ч дор орохгүй гэж Вэн ноён хэлэв

- Одоо оршиж байгаа Сэнди, чамд нэг дутагдал байна. чиний яриа нэлээд хуучивтар юм. гэвч я а х вэ, нэг их сүйдтэй юм. биш

- Нэг тэмцээнд олон дайчин эртэй тэмцэлдэ хэ д нэг нь ч дийлэхгүй байсан Ээ, хүүхнүүд ээ, миний бодоход та нар томоогүй юм. хийж байна. э н д бамбайгаа орхисон тэр хүн чинь мөд эргэж ирнэ тэгэхэд та нар, тэр хоёр дайчин эр, түүнтэй зүйрцэх нь үү үгүй нь үү та нар үзнэ тэг э хлээр энэ бамбайг ингэж харааж зүхсэнээс хүндэлж мөргөвөл дээр байх Дайчин эрийн бамбайг бузарлан гутаах ийм юм. үзэж энд байх хүсэл над алга гэж Говэн хэлэв Вэн ноён, Говэн ноён хоёр цаашханаа явтал Мархауз ноён маш том морьтой яг өөдөөс нь давхин и рэхийг тэр хоёр гэнэт харав . Мархауз ноёны барааг х а рсан өнөөх арван хоёр хүүхэн цамхагийн зүг хол мэдэн харайлган сандр а хдаа хэд нь бүдэрч унаж байлаа. Тэгэхэд цамхгийн Д а йчин эрсийн нэг нь бамбайгаа өргөж омогтойгоор

- Мархауз ноён, амиа хаацайл гэж х а шгирав, Тэр хо ё р тул а лдаж эхлэхэд нөгөө дайчин эр М арха узыг ж а длах а д ж а д нь хуг а рч, х а рин Мархдуз ноён түүнийг морин оо с нь унагахад н уг а с нь т аса рч, мор ь ны нь нуруу хуг а р а в .

- яас а н муухай з а ншил вэ хичнээн морь дэмий ална вэ

- Ц а мхгийн б а с нэг дайчин эр үүнийг х а ра а д довтолгон ирж Мархдузыг д а йрлаа Маш галзуу тулалдаж ца мха гийн дайчин эр мориныхоо хамт үхэтхийн унав

- Бас нэг морь үхжээ ийм заншлыг устгавал таарах юм. Ямар уха а нтай улс болоод тийм з а ншлыг тэвчин шагшина вэ?

- Тэгээд тэр хоёр дайчин эр бие биеийг галзуу мэт д а йрчээ Би, нэг хэсэг дугхийж бүхэл бүтэн бүлэг сонсолгүй өнгөрөв бололтой, гэвч энэ тухай Сэндид хэлээгүй Ирл а ндын дайчин эр б а с хэд хэдэн д а йсантай байлдаж амжс а н байлгүй гэж бодсон маань яг тийм байлаа.

- Вэн ноён, М арха уз ноёныг тун хүчтэй жадалж байж жада а хуга л аад М а рхауз ноён Вэн ноёныг тун хүчтэй цохисон учир ц а адхи нь морьтойгоо газар уна хад зүүн сүвээрүү нь цоо хатгажээ , --- Үнэнийг хэлэхэд, Али сан ад чиний энэ хуучны туужууд чинь тун эгэл юм. Үг чинь дэндүү цөөхөн, тэгэхлээр дүрслэх юм.гүй, нэг янз байна., бүгдээрээ дан нүцгэн Сах а рын цөл шиг хо осон б а римт байна., ямар ч тодорхой нарийн шириин юм.гүй, д а н нуршуу ганц юм. болж байна., бүх тулалда а ныг д а ндаа л ав адилхан болж, хоёр хүн бие биеэ г а лзуу мэт д а йрл а а гэх юм. Галзуу мэт гэдэг чинь сайхан үг, гэхдээ энэнээс чинь яавч дутахгүй улангас а н гэх юм. уу , гал дөл мэт, э с хүл араатан мэт гэх мэт олон зуун үг байдаг даа, гэтэл юм. л бол, чөтгөр алгад гэж, яал а а гэнэ вэ бие бие рүүгээ галзуу мэт дайрлаа, жада а хуг а лла а , нэг нь нэгнийхээ бамбайг цооллоо, Ц а адах нь морьтойгоо газар уналаа

гэх юм. уу , мориныхоо хондлой дээгүүр давж унаад нугасаа тасаллаа, дараа нь а мьд үлдсэн үрүү нь өөр нэг нь галзуу мэт д а йрл а а, бамбайгий нь цоо хатгалаа, м ө н л морьтойгоо хамт ойчлоо, аль эсхүл мориныхоо хондлой даг а н ойчоод нуг а саа тасаллаа, дараа нь бас нэг нь галзуу мэт дайрч, бас нэг нь , бас нэг нь гээд л хамаг юм. дуусаж байна шүү дээ Дүнгий нь гаргая Гэвэл нэг нь нөгөөгөөсөө ялгаагүй болохоор хэн ялсны нь мэдэх арга алга улангасан уулгалан дайрсны нь нүдэнд үзэгдэх мэт ярихын оронд манан будан дотор хий үзэгдэл тулалдсан юм. шиг бодогдож байна. Ромыг Нерон хэрхэн галдсан мэт томхон явдлыг ярих болбол ийм ядуу хэдхэн үгээр яаж чадах вэ? хот шатсан, даатгалын мөнгийг төлдөгүй нэг хүүхэд цонхы нь хагалсан гал унтраагч ну г асаа тасалсан гэж ярих нь байна шүү дээ гал түймрийг ингэж дүрсэлж яаж болох вэ? би зөндөө их юм. ярьж өгсөн боловч Сэндид өчүүхэн ч сэтгэгдэл төрсөнгүй намайг дөнгөж дуугүй болмогц хоёр гуравхан үгтэй хоосон урсгал үгийнх нь таг онгойх шиг боллоо

- Тэгээд Мархауз ноён морио эргүүлэн Говэн үрүү давхин очиж жадаа зэхэв Говэн ноён үүний нь үзээд бамбайгаа өргөж хоёул бие биеийнхээ өөдөөс хар хурдаараа давхин очиж бие биеийн бамбай руу дэлсэхэд Говэний жад хугарав

- Ингэнэ гэж би түрүүний мэдсэн

- харин Мархауз ноёных хугарсангүй тэгээд Говэн ноён мориныхоо хамт газар уналаа

- Тэгээд бодвол нугасаа таслаа л биз

- гэвч Говэн ноён хөл дээрээ амархан босож Ирээд сэлмээ суга татан барьж Мархауз ноён уруу явган дайрахад цаадхи нь бас шаламгайлан бэлтгэж хоёул тун галзуу мэт тулалдааад хоёулангийн бамбай нь зад зурагдаж хэсэг хэсэг болж, хуяг дуулгууд нь хамх хэмх болж, хоёул шархаджээ Есөн цаг болоход тэр хоёр гурван цагийн турш тулалдчихаад цаг өнгөрөх тусам Говэн ноёны хүч улам нэмэгдсээр сүүлдээ гурав дахин хүч оржээ хоёул шархадсан байхад Говэн ноёны хүч чадал нэмэгдэхэд Мархауз ноён маш их гайхаж байжээ. тэгсээр их үд болжээ. Түүний гунигтай дуу хоолой нь миний багадаа байнга сонсож байсан нэг дуу хоолойтой адил санагдсан юм. нь ю ун... Хейвэн *Арван минут зогсоно Хөдлөхөөс хоёр минутын өмнө үйлчлэгч хонх цохино . Тэнгис хавийн замаар явах зорчигчид сүүлчийн вагонд орно уу Энэ вагон цааш явахгүй Алим, зүрж, гадил, хиамтай талх, чихэр аваарай* тэгээд их үд болж өдөр орой тийш хэлбийлээ . Тэгэхэд Говэн ноёны хүч чадал барагдаж эхэллээ доройтсоор цааш нь тулалдаж чадахаа болиход Мархауз ноён улам улам асар том болж байлаа. . Хуяг нь багадаж эхэллээ , гэвч тийм улс тиймэр хүү яльгүй юмыг тоодогүй юм. Мархауз ноён ноёнтон минь , та эрэлхэг дайчин, ер бишийн хүчтэй хүн, гэхдээ хүч чадал чинь барагдаж байна., муудах нэг их үндэс та бидэнд байхгүй учраас одоо би өөрийг чинь алахаас өрөвдөж байна., та бүр чадалгүй болжээ. гэхэд Говэн ноён Аа, ноёнтон минь , хэрэв би тан шиг байсан бол яг ингэж хэлэх байсан гээд тэр хоёр дуулгаа тайлж үнсэлцэн ах дүү хоёр шиг бие биеэ хайрлаж явья гэжээ гэвч би яриа ных нь учигны үзүүрийг алдчаад зүүрмэглэхдээ өөрснийгөө төмөр хуягт баглаад зургаан цагийн турш бие биеэ жадалж, цавчиж, нүдэж байх тийм ер бусын чадалтай хүмүүс тэр хүчээ өөр ашиг тустай юманд хэрэглэх тийм цаг үед хайран хэрэг юм даа гэж би бодож байлаа. Жишээ нь илжгийг аваад үзэхэд болно. илжиг бол чухам тийм хүчтэй амьтан, тэр хүчий нь ашигладаг, тэгээд ч хорвоо ертөнцөөрөө тэр амьтныг илжиг учраас л үнэлдэг шүү дээ Харин ордны тайж илжиг ч гэсэн түүнийг хэн ч үнэлдэггүй Ордны тайж, илжиг хоёрыг хослох юм. бол огт олигтой юм. болж өгөхгүй, тэгэхлээр ордны тайж хэзээ ч болтугай илжигний хүчийг тэргүүн зэрэгт гаргаж байх хэрэг алга гэсэн ч яана гэх вэ, нэгэнт алдаж эхэлсэн хойно гайг засах аргагүй, юугаар ч төгсөхий нь хэн ч мэдэхгүй Сэрээд чагна в ал Алисанда бас нэг бүлэг ярьчихаад ца а ш нь баатруудаа их ахиулсан байлаа.

- тэд явж явж, Нэг г үн жалганд хүрчээ, жалган дотор дүүрэн чулуу байна. гэнэ, доогуур нь тунгалаг булаг урсаж байна. гэнэ булаг нь нэг усан оргилуураас эх авсан байна. гэнэ усан оргилуурынх нь дэргэд гурван хүүхэн сууж байна. гэнэ Мархауз ноён ярихдаа Энэ нутаг Христосын номд орсон цагаас хойш энд ирсэн аливаа дайчин эрд хачин хачин адал явдал заавал тохиолддог болжээ.

- Алисанда, чи тэрний хэлсэн үгийг буруу хэлж байна. Ирландын вангийн хүү Мархауз ноёны үг чиний ярьж буй маягаар бусдынхтай адилхан байна. Ирланд аялгы нь гаргах юм. уу , ер нь нэрин нь дахин давтахын оронд үгий нь хэлэхэд л танихаар тийм шинж тэмдэг гаргах ёстой Энэ бол б и чгийн том хү мүүсийн хэрэглэдэг нэг ерөнхий арга Жишээ нь түүний Энэ нутаг христос маргөлд орсон цагаас хойш нааш ирсэн аливаа дайчин эртэй цоо хатгалдсан ч хачин хачин адал явдал заавал учирда г байв. цоо хатгасан ч гэж хэлбэл нэлээд дөмөг болж байгаа биз дээ цоо хатгасан ч нааш ирсэн аливаа д а йчин эртэй хачин хачин адал явдал заавал учирдаг байв. Ариун төрөлт ноён минь , үнэхээр домог болж байна. хэлэхэд над хэцүү байна., гэвч яваандаа дасна би Тэгээд тэд тэр хүүхнүүд дээр очиж мэнд усаа мэдэхэд эг чмэд

хүүхнийх нь толгой дээр алтан титэм гялалзана, нас нь гурван удаа хорь, хори ос ч илүү өвлийг үзсэн

- Тэр хүүхэн үү?

- тийм ээ, эрхэм ноёнтон, титмийнх нь доогуур цагаан үс цухуйна

- Бодвол шүд нь цийлэнцрээр хийсэн, эрүү нь есөн долларынх биз, юм. идэхэд цонхны хөшиг шиг дээш доош болдог, инээхэд амнаас нь гараад ирдэг тийм шүдтэй байгаа биз

- хоёр дахь хүүхэн толгой дээрээ жижигхэн алтан титэмтэй, төрсөөр гучин өвлийн нүүр үзжээ Гурав дахь нь дөнгөж арван тавтай өдий төдий дурсамж санагдаад . Сэндийн дуу хоолой хулжих шиг боллоо Арван таван нас ер зүрх минь өмрөх нь Үүрд алдагдсан хонгор минь Арван тавтай, тийм эелдэг зантай, гоо үзэсгэлэнтэй, хайр сэтгэлий минь хорвоод ганцаараа булаасан тэрүүнтэйгээ хэзээ ч үулзахгүй болжээ. Түүнийхээ тухай бодож эхэлмэгц миний ухаан санаа олон зуун жилийн хойд ох аз тэнгэртэй цагаа нэхэн санаж, зуны найрсаг өглөө түүний тухай сайхан зүүднээсээ сэрээд байна. уу ? Төв станц уу ? гэдэг байсан маань бишрэх сонсгол минь гэгээн зайн хөгжим мэт санагдаж байна. уу , Хэнк гэсэн үг л сонсох гэж тэр билээ. Алисанда цааш ярьснаас бидэнд олзлогдсон тэр морьтой эрс юун улс байсныг би ойлгож чадсангүй, Алисанда ч тайлбарлаж өгөхийг хүссэнгүй Сонирхол маань унтарч, санаа бодол минь гунигт автаж алс хол хулжлаа . Ярианаас нь ажихад тэр гурван эр нэг нэг хүүхнийг мориндоо сундлаад нэг нь хойш, нэг нь зүүн тийш ,нэг нь урагш адал явдал хайхаар явж жил нэг хонго гийн дараа яг нэг өдөр тус бүр худал ярьсаар ирэх гэж өөр өөр зүг давхисан бололтой . Ямар ч бэлтгэлгүйгээр нэг жил нэг хоногийн аянд гарна гэдэг нь эндхийн хүмүүсийн хичнээн эгэл боровтрын нэг жишээ юм. даа . Нар нэгэнт жаргаж байлаа. Алисанда бидний олзолсон малчдын тухай үдээс хойшхи гурван цагаас авахуулан ярьсан гэхэд угаас урт яриатай хүн ч гэсэн нэлээд ахисан гэхэд болох байлаа. хэзээ нэгэн цагт тэр яриагаа дуусгах байх л даа харин тэрүүн шиг тийм хүмүүсийг яаруулж болдогүй юм байна. лээ Бид хоёр явсаар нэг ухаа дээрх шилтгээний дэргэд хүрч очиход тэр нь асдаг өвсөнд гайхмаар хучигдсан бор бор цамхагтай сүрлэг том барилга байлаа. Шингэх нарны туяанд үлэмжийн том тэр барилга улам ч сүрлэг дуниартана Бидний замд тааралдсан бүх шилтгээний дотроос хамгийн том нь энэ байсан болохоор би бидний эрсэн шилтгээн маань энэ биш байгаа? гэж бодсон билээ. гэтэл Сэнди биш гэсэн атлаа хэний шилтгээний нь ч мэдэхгүй байна. Камелот уруу аялж байхдаа энд зогсолгүй дэргэдүүр нь өнгөрөөд явсан юм. гэнэ

Арван зургадугаар бүлэг

МОРГАН А ДАГИНА

Тэнүүчилдэг дайчин эрсийн үгийг үнэн гэж бодвол шилтгээн бүр зочломтгой биш ажээ. Манай орчин үеийн үзлээр үнэн гэдэг ойлголтыг авч үзвэл тэнүүлч дайчин эрс бол үгэнд нь итгэвэл зохих хүмүүс бишээ Харин тэдний цаг үеийн үүднээс бодож шүүж тунгаах юм. бол бага сага үнэнийг ялган авч болно. Тун амархан өрөн есөн хувий нь хасчих, тэгвэл үнэн баримт нь үлдэнэ ийм тооцоо хийчихээд хонхы нь дарахын урьд, үгүй, манаачий нь дуудахын тулд урьд тэр шилтгээн ер нь юу юм. гэдгийг нь мэдэх хэрэглэй гэж бодлоо шилтгээний тэндээс тахиралдсан замаар нэг морьтой хүн бидний өөдөөс айсуйг хараад би их баярласан Бидний хоорондын зай ойртоход морьтой хүн өд хатгамал дуулгатай, ган хуягтай, ган хуягныхаа дээр хэнхдэг, нуруундаа эарлал бүхий дөрвөлжин дөрвөлжин самбартай харагдах нь

зугаатай байв. Ойртож очоод харсан чинь би мартамхайгаа санаж инээд алдаа Самбар дээр нь *Персиммоны саван Гоцлон дууч эмэгтэй чүүд цугаараа үсээ угаадаг* юм. гэсэн үг бичээстэй байв. Энэ бол миний өөрийн зохиосон зүйл байсан юм. Зорилго нь хүн ардыг иргэншлийн замаар ялимгүй ч болтугай ахиулах санаа юм. Нэгдүгээрт, энэ бол тэнүүлч дайчин эргэдэг дэмий балай юмыг цаагуур нь чадаж буй хэрэг юм. энэ тухайг надаас өөр хэн ч мэдэйгүй байв. Тэгж буулгаж авсан цөөнгүй баатарлаг эрсийг дээр нь зарлал наасан хуяг дуулга өмсгөн хий амтай талх шиг болгоод тал тал тийш мордуулдаг байсан юм. тийм хүмүүс олон болж ирэх хийн үед инээдэмтэй харагдахаа больж харин ч зарлалын самбаргүй явах намба орхигдох учраа ган хуяг өмссөн аливаа илжиг амьтны инээдэм болох болно. гэж би бодсон юм. хоёрдугаарт, тэдгээр элч хэнийг ч айлгаагүй, хэнд ч сэжиг төрүүлэхгүй байж ариун шударга байхыгн хамгийн наад захын дүрмийг тайж нарт сургаж, тайж нараас ард түмэн сурах болно., харин лам нар л саад хийж мэднэ Энэ ажил бол шажны эсрэг ажил юм. бүр үнэнээр хэлбэл тийм ажлын эхлэл юм. Дараа нь боловсрол, дараа нь эрх чөлөө сурталчилна, тэгэхийн алдад сүм хийд сүйрч эхэлнэ Ноёлогч сүм хийд бол ноёлогч гэмт хэрэг, боолчуудыг ноёлогч шорон мөн учраас түүнд хор болох аливаа зэвсгээр тэмцэх хэрэгтэй гэж миний бие итгэж байсан юм. Яагаад гэвэл эхийнхээ хэвлийд хөдлөөч үгүй байсан урьд үеийн ирээдүй цагт чөлөөт оронд төрсөн гэж боддог хуучин Англичууд байсан юм. Эрх чөлөөт орон гэдэг нь ноёлогч шашинд үл хамаарах хүмүүсийн төрийн хэрэгт оруулахыг хорьсон хууль, хоршооллын тухай хуудийн хэмээх бороохойгоор хүний эрх чөлөөг хавчиж нэр сүрийг их даран готой байсан юм. би өөрийн элчид ийм самбар дээр алтан үсгээр бичсэн зүйл уншиж сургадаг байв. Үсгийг нь алтадсан явдал тун сайн болсон юм. тийм зарлалтай самбарыг ван өөрөө ч зүүхээс буцааргүй байсан, тийм л бузар сайхан болсон юм шүү Элч нар өөрсдийнхөө зарлалыг ноёд хатагтай нарт уншиж саван гэгч юу болохыг гайлбарлах ёстой Ноёд, хатагтай нар саванг хэрэглэж үзэхээс айх юм. бол нохойгоо угааж үзэх ёстой Дараа нь элч хүн тэр айлын хэргийг цөмийг нь байлгаж байгаа ад савангийн ажиллаах нөлөөг өөрийн бие дээр туршиж үзүүлэх ёстой Саван бол огт хоргүй зүйл гэдгийг тайж язгууртан нарт үзүүлэхийн тулд элч нар ямар ч бэрхшээл, ямар ч туршлагагаас буцалгүй мэрийх ёстой Хэрэв тэгээд ч тус болохгүй бол ой тойгоор дүүрэн миегнэж байдаг даяанч нараас нэгийг нь барьж аваад турших ёстой Даяанч нар туйлын их шүтлэгтэй, өөрснийгөө ариун амьтад гэх ба хүмүүс ч тэдэнд итгэдэг тэд янз бүрийн гайхамшигийг үзүүлж, хүмүүс түүнд нь бишрэн мөргөдөг юм. тийм хүнийг гүнгийн дэргэд савангаар угааж даяанч амьтад гажрахыг үзсэн мөртлөө саванд итгэхгүй бол тийм гүнг тэр хэвт нь орхиод одоох ёстой байв. Бидэнтэй тааралдсан элч дайчин эрийг Ля Котмэл Тэл гэдэг байв. шилтгээнд Уриэнс вангийн гэргий, Артур вангийн дүү, Моргана дагина суудаг бөгөөд вангийнх нь бүх нутаг Колумбийн тойргийн чинээ учраас тэг дунд нь зогсож байгаад хөрш орон луугаа чулуу шидэж болох оор юм. гэж хэлсэн Британд ван, вант улс тун олон, яг л ийсус Навины үед Палестинд хичнээн байсан төчнөөн байлаа., тэгэхлээр хүн ам нь унтахдаа эрүү өвдгөө нийлтэл эвхрэн хэвтдэг байсан, яагаад гэвэл гадаадын паспортгүйгээр хөлөө жийж болохгүй байжээ. Тэр шилтгээнд Ля Кот бүх аяллынхаа туршид хамгийн муугаар дийлдсэн болохоор тун их уравгар байв. Хамгийн сайн элч төлөөлөгч, хүний хийвэл зохих бүхий л арга чарга үйлдэж адаг сүүлд нь нэг даяанчийг угаасан чинь цаадхи нь мажийчихсан болохоор мань эргэн ч ширхэг саван худалдаж чадаагүй ажээ. Үнэхээр бүтэлгүй явдал болсон байна., яагаад гэвэл тэр мал даяанчийг зовлон амссан амьтан гээд ром каталогийн сүм хийдийн сударт бичих болно. гагц дайрч ланчигт өртсөн золгүй ноён Ля Котм тэгж бидэнтэй тааралдсан юм. Түүнийг өрөвдөхөөс зүрхэнд минь цус хурах шиг болж сэтгэлийг нь засаж зогоохыг оролдож

- Ариун төрөлт дайчин эр минь , бүү гунь , энэ бол дийлдсэн хэрэг биш чи, бид бол тархитай улс Тархитай улс дийл дд эгүй юм. Тэд гагцхүү ялдаг юм. харахгүй юу , бид энэ золгүй мэт санагдах юмыг зарлал болгон хувиргасан байна., савангаа зарлах зарлал болгосон л байна шүү дээ Энэ зарлал маань энэ өчүүхэн бүтэлгүй явдлыг ч устгах зарлал болно. Вашингтоны ухаагийн чинээ ялагдлыг Маттергорны оргилын чинээ ялалт болгон хувиргана чиний самбар дээр Ариун зо в лонтын Ивгээл дор буй гэж бичимз Зүгээр биз?

- Зүгээрээр барах уу Мэргэн санаа

- Ганц мөрөөр үүнээс илүү яаж хэлэх вэ, яг оносон байна шүү Г у тарч явсан элчийн гуниг дорхноо сарнин алга болох нь тэр Баатар эр байсан болохоор тулалдааны та л бар дээр олон удаа ялж байжээ. Ял а нгуяа эд ү гээ миний бие үйлдэж буй тийм Нэг аяныхаа үед их алдаршсан эр юм. Тэр үед Маледиэнт гэдэг нэг хүүхний хамт аянд явсан гэнэ Тэр нь Сэнди шиг бас нэг яриа хүүхэн байсан, гэхдээ Сэнди гэм халгүй чалчдаг байсан бол тэрний хамт аялагч нь зан муутай өөдгүй амьтан байжээ. би түүний түүхийг сайн мэддэг байсан болоод тэр биз, надтай салах ёс гүйцэтгэхдээ нүүр царайд нь өрөвдсөн шинж ил байв. Надад ч амаргүй байгааг мэдэж байсан биз З а мд гарсан хойноо түүний тухай Сэндитэй ярилцахад Ля Кот ноён мордохын хазгай гэгчээр эхлэхээсээ аваад бүтэл муутай байсан гэнэ Вангийн алия салбадай түүнийг аянд мордсон анхных нь өдөр морин дээрээс нь унагаажээ заншлын дагуу бол хүүхэн нь түүнийг орхиж ялагчийн талд очих ёстой байсан боловч Маледизанта Ля Котоос салсангүй, цаашид ч хичнээн их ялагдаж дийлдэвч түүнээс халширсангүй

- Ялагч нь тийм олз авахгүй гэвэл яах вэ? Тэгвэл юу болох вэ? гэж би хэлбэл ялагч нь тийм олзыг заавал а ва х ёстой учраас тийм асуудал гарах учиргүй, тэгвэл ёс горим зөрчсөн хэрэг болно. гэж Сэнди х ариуллаа би юу боловч Сэндийн ингэж хэлснийг сайн тогтоолоо Хэрэв Сэндийн чалчих нь тэвчих аргагүй бол бол би Ямар нэг дайчин эрд дийлдье, тэгвэл энэ хүү хэн тэр дийлсэн эр дээр очих юм байна. гэж бодсон шилтгээний хананаас бид хоёрыг хүүе юун улс вэ? гэж хашгиран байцаасны хойно дотогш орохыг зөвшөөрлөө энэ айлчлалын тухай сайрхан ярих юм. огт гараагүй юм. Моргана дагины тухай аль хэдүйн сонссон болохоор ер олитой юм. горьдоогүй, тэгээд ч гонсойх юу байх билээ. Өөрийгөө агуу их рид хувилгаан тан гэж бусдад үнэмшүүлсэн болохоор улс орных нь бүх хүн сүрдэн айна, х амаг хүсэл мөрөөдөл, хамаг үйл явдалд нь шуламсын хорон санаа нь шингэсэн байна. хүйтэн цэвдэг сэтгэл нь эгээ л мөс Хамаг амьдрал нь хойно хойноосоо зал г асан гэмт хэрэг юм. Чухамхүү чөтгөр л ийм байдаг буйзаа гэж би сонирхон ажсан юм. Г оо үзэсгэлэнтэй нь хачин санагдлаа . хорт санаа нь нүүр царайгий нь ой гутам болгосонгүй, нас нь толигор арьсы нь атираасангүй, өнгө толио г ий нь ч хөндсөнгүй Өвгөн Уриэнсийн зээ охин юм. уу даа гэж бодмоор харагдана Төрсөн хүүгийнхээ эгч шиг санагдана . Бид хоёр шилтгэ эний хаалгаар ормогц нааш нь оруулаад ир гэжээ . Ороход зовхио өргөхийг эс зо ри глох номхон дөлгөөн өвгөн ван Уриэнс, түү н ий хү ү Вэн Ля Бланшмэн ноён хоёр харагдлаа Вэн ноёнтонд учрах тун сонин санагдсан учир гэвэл нэгдүгээрт, мань хүн нэг удаа гучин дайчин эрийг дийлсэн тухай домог б а йдаг, хоёрд у гаарт, Сэнди над ярьж байсан Ровэн ноён, Мархауз ноён хоёртай хамт аянд явж байжээ. гэвч би Морганаг хамгаас илүү сонирхсон л доо эндхийн хүн бүхнийг атгандаа барьдаг нь шууд мэдэгдсэн юм. Биднийг суу лгаа д их л э е лдэгхэн байдалтайгаар элдвийн юм. шалгаж эхлэх нь тэр Ай бүү үзэгд Дуу хоолой нь жигүүртний хоолой, цоорын аялгуу шиг сонсдоно . ийм эмэг т эйг худал гүтгэдэг юм. уу даа гэж над бодогдлоо Солонго мэт эрээлтэл гоёсон нэг хөөрхөн гоцго залуу долгион мэт туялзан алтан тосгуур дээр юм.

авчирч өгөн өгтөл тэр хүүхэн дуржигнаад л байдаг, дуржигнаад л байдаг . Нөгөө зарц нь сөхрөх гэж дэндүү хичээж байж тэнцвэр алдаад өвдгөнд нь ялимгүй хүр чих эв ээ Тэгэхэд нь тар авгай оготоно алж байгаа мэт чинжаалаар хээвнэг хутгалчихлаа . Хөөрхий муу жаал ш алан дээр өнхрөн унаад торгонд ороолттой бие нь татгавнан байгаад үхлээ . Өвгөн ван тэсэлгүй Ай хөөрхий хэмээн дуу алдав гэтэл Моргана жигтэйхэн ширэв татахад өвгөн ван таг болж дахин ам нээхээс зүрх алдана Моргана сүрхий хатуу эзэн юм. ярих зуура а , за рц нар орж ирээд хүүр авч гарахад тэднийг нүд салгалгүй ширтэж, шинэ алчуур авчрахад нь буцааж өөр алчуур авчрахыг тушааж, шал арчаад гарах гэхэд нь тэдний харалгүй орхичихсон өчүүхэн цусан толбо руу нүдээрээ заалаа Ля Кот Тэл Мэл энэ айлын эзэн авгайт ай уулзаж чадаагүйг нь би мэдлээ хүний хэлээс илүү тов тод баримт сэлт цөөнгүй байдаг Моргана дагины дуу хоолой түрүүчийн адил х өг жмийн эгшиг мэт уянгалсаар байна. Гайхмаар эмэгтэй н үдий нь ямар гэж санана зарц нар нь нүднийх нь харцаас хиртхийн цочих нь аймхай улс тэнгэрийн дуу наас давхийн цочих мэт би ч гэсэн арай л давхийсэнгүй Хөөрхий муу өвгөн Уриэнс дандаа л бөгснөөс нь зүү хатгах шиг дав давхийн ганц ч хормын төдий тайван суухгүй, бүр ширэв татахаас нь өмнө давхийж байх юм. би яриан дундаа энэ авгай төрсөн ахаа хичнээн их үзэн яддагийг нь мартчихаад Артур вангийн талаар нааштай хэдэн үг хэлчихсэн чинь бүр гай боллоо Авгайн царай борооны хар үүлтэй тэнгэр шиг барайн, харуул манаагаа дуудаж

- Энэ луйварчдыг гянданд хорь гэлээ. Эдний гяндан нь улс орон даяар нэр гарсан аюултай нүх учраас миний бие хөрөх шиг боллоо би юу хэлэх яах ийхээ ч мэдэхгүй балмагдав Харин Сэнди тэвдсэнгүй цэргийн хүн миний гараас барих гэтэл Сэнди гэнэт аймшигүй, тайван жингэнэх дуугаар

- Ухаангүй мал чи үхэхийг хүсээ юү Өмнө чин ь нь Эзэн чинь байна. гэв Гайхмаар онож хэлсэн шүү Энгийн үгээр ийм санаа миний толгойд орж ирээгүй юм. би төрөлхийн даруу , тэгэхдээ дандаа ч биш л дээ, түр зуур Энэ удаагийнх маань яг л тийм хэдэн хоромд болсон юм. Ван ахай дорхноо өөр болов. Нүүр царай тавирч, инээмсэглэл нь мяралзаад ирлээ Өнөөх гайхмаар сайхан ааль нь буцаж ирлээ Харин булай их айснаа нууж чадахгүй ингэж хэллээ

- чиний шивэгчин яасан дэмий юм. чалчина вэ? би зүгээр тоглоомоор тэгж хэлсэн юм шүү дээ Мерли н ийг ялагч чамайг ирэхий чинь би рид хувилгаанаараа мэдсэн, ороод ирмэгц чинь рид хувилгаана а раа чамайг таньсан юм. Чамайг бажга алдуулж, ур чадлы чинь гаргуулах санаатай зориуд тэгж тоглосон юм. чи ид шидэт гал дөлөө асааж энэ цэрэг эрсийг дор нь түймэрдэнэ байх гэж би найдаж байсан юм. би өөрөө тийм ид шид гаргаж чадахгүй Тэгээд тийм увьдасыг үзэх юмсан гэж хүссэн юм. би чинь хүүхэд шиг сониуч хүн шүү гэв цэргүүд нь төдий их со н иуч хүмүүс биш байсан бопохоор ийм үг сонсмогцоо бушуухан гарч одов

Арван долдугаар б үлэг

ВАНГИЙН НАЙР

Намайг уурлаж гомдол гаргахгүй болохоор ван а вх ай мэхэлж дөнгөлөө гэж бодсон нь гарцаагүй Айхаа бүр болих мөртлөө ид шидээ үзүүлж хэн нэгий нь алж аль хэмээн шалгааж э х лэхэд нь би яаж тэрнээс ангижрахаа мэдэхээ байлаа. Аз болоход бид бүгдийг мөргөлд дууда х ад тэр амьтан дуугүй болсон юм. Тайж язгуурт ан нар хүн алах, тамлах дуртай, ховдог шунахай, завхай зайдан ч гэлээ. жигтэйхэн гүн шүтлэгтэй байдаг юм. Сүм хийдээс гүйцэтгэж

бай гэсэн аливаа ёс дэгийг тэд ямар ч болтугай ёсчлон биелүүлнэ Тайж хүн дайснаа гэнэдүүлэн барьж аваад багалзууры нь огтлохын өмнө заавал мөргөл үйлдэ х ий нь би өөрийн нүдээр ганц биш удаа үзсэн Түүнтэй зүйрлэхэд Бенвенуто Челлини өөрөө тун ч т өөсөөтэй хувраг мэт бөгөөд тийм гүндүүгүй ариун явдалд хүрэхийн төлөө зүтгүүлэ х мэт санагдана Британы тайж язгуурт айл бүхэн өглөө үдэш Тэр орноороо өөр өөрсдийн сүм хийдэд мөргөл үйлдэхэд бай х аас гадна хамгийн тэнхээ тамиргүй тайж нар ч нийг м ийн мөргөлд тав зургаа дахин ордог юм. Үүнийг сүм хийдийн гавьяа гэж үздэг байж таарна би католик шашны талын хүн биш ч гэсэн тийм гавьяагий нь үгүйсгэж чадахгүй Шашин байгаагүй бол энэ орон ер яах байсан бол гэж өөрийн эрхгүй бодох явдал цөөнгүй байлаа. Мөргөлийн дараа бид найрын нэг их том өргөөнд хоол идэв . Тэр өргөөнд ван ноёдын дэндүү хээнцэр ганган, эв хавгүй нүсэр чимэглэлтэй, олон зуун өөхөн дэн асаалттай байв. Өргөөний хамгийн хүндтэй захад тусгай тавцан дээр ван, в ан ахай түүний хүү хунтайж Вэны ширээ байна. Шалан дээр өрөөний нэг захаас нөгөө захыг тултал нийтийн ширээ засчээ Түүний тэр тээгүүр, давсны савны дээд талаар түшмэд, ер нь вангийн ордныхон болох тэднийхний насанд хүрсэн хүмүүс бүгд жаран нэгэн хүн заларчээ . Давсны савны доод талаар вангийн чухал гоцго нар зарц нарынхаа хамт суусан байна. . Нийтдээ зуун найман хүн суух бөгөөд тэдэнд ү й лчлэх төдий чинээ зарц нар тусгай хувцастай зогсож байна. Харахад сайхан гэдэг нь Янчир, бүрээ ятга гэх мэт аймаар хөгжмөөс бүрдсэн хөгжимт н а йрал дуу эхлэхэд найр эхэлж би диваажинд, би дуулн а гэж алдаршсан үгтэй дуу болж хувираад ирэх олон зуун жилийн турш хүн бүхний чихэнд чийр болсон хайрын дууны анхны бадаг цууриатав Тэр үед энэ дуу цоо шинэ байсан болохоор хөгжмийн чуулга нь дагаж олигтой сураагүй байсан бололтой Энэ шалтгаанаар юм. уу , аль эсхүл өөр юм.наас болсон уу , бүү мэд будаалганы дараа тэр хөгжмийн зохиолчийг ван ахай дүүжилж алахаар тушаажээ . Хөгжим зогсоход вангийн ширээний ард зогсож байсан нэг хувраг уртаараа хүн гомдоохгүй нэг номлол латинаар уншлаа Дараа нь суман суман цэрэг шиг зарц нар зогсож байсан газраасаа дэрхийн сандчин мэгдэн хөдөлж аяга тавагтай хоол унд хурдлан зөөж их найр эхлэх нь тэр хоолондоо үхэлдээд нэг нь ч үг хэлэхгүй боллоо Эгнэсэн олон эрүү нэгэн зэрэг нээгдэн хаагдан, зажилж зуурамдах чимээ нь газар дор ажиллаж буй машины битүү хүнгэнэх дуу мэт сонсдоно . Тэгж цу с лах ажил бүтэн хаг а с цагийн турш үргэлжлэхэд хичнээн их хүнсний зүйл устгасныг хэмжээлэх боломжгүй . Ширээний дунд тун сүр жавхлантай ихэмсэг голийж байсан гол идээ болсон асар том бодон гахайнаас өргөн банзлын цагираг мэт хэдхэн хавирганы яснаас өөр юу ч үлдсэнгүй Бусад бүх идэх уух юмны хувь заяа иймэрхүү байдлаар шийдэгдсэнийг үүгээр үлгэр болгов Тансаг идээ рүү орсны дараа архидаж эхэллээ , архидмагц яриа хөөрөө нь эхэлдэг байна. Дарс, бал торх торхоороо алга болж байлаа. Эр эмгүй бүгд малилзан байснааг жаргалд умбаж, дараа нь галзуу мэт шууги л дан нижгэнэж гарлаа Эрчүүл нь сонсоход аймаар марзан заваан юм. ярихад ичиж улайх амьтан ганц ч үгүй, марзан яриа болгоны дараа пар пар хөхрөлдөх тул шилтгээнийх нь чулуун хана туурга доргино . Хатагтай нар мөчөөгөө өгөхгүй ван ахай Маргирита Наваррск байтугай английн их хатан хаан Е лизавет ч алчуураар нүүрээ таглахаар хачин шалиг юм. ярина гэтэл энд нүүрээ алчуураар таглах хүн гарах байт у гай бүгд улин хуцах адил инээлдэж байлаа. Бүх үлгэрий х нь баатар бараг дандаа хувраг хүн гарах боловч энд байсан цогчин дуганч ичих зовох бүү хэл, бус ад тай хамт инээж байлаа. Тэр ч байтугай, мань эр бусдын хүсэл тээрнэгэн дууг хоолой мэдэн хашгирч дуулсан чинь тэр оройн дуулсан дуунуудын дотроос шалигаараа дутаагүй юм. . Ш ө н ө дунд болоход бүгд ядарч, инээж хөхрөлд сөө р сульдаж, бүгд согтжээ зарим нь уйлж, зарим нь үнсэлцэж, зарим нь хэрэлдэж, зарим нь ширээн доогуур ороод үхсэн юм. шиг унтсан байв. Эмсийн дотроос нэгэн царайлаг

гүн ахай л хамгийн намбагүй аашлав . Ер нь тэр оройн найрыг тэр эмийн хуримыг угта х ад зориулсан байжээ. Хараад баймаар юм. их гарсандаа Эрт урьдны мартагдашгүй холын өдрүүдэд Орлеоны засаг баригчийн залуухан охин алдарт нэгэн найран дээрээс шал согтуу, агсан тавьж, арчаагаа алдан орондоо хүргүүлж байсныг дүрслэн зурахад энэ хүүхэн тохирахуйц загвар болмоор байлаа. Гэнэт, өнөө хувраг гараа өргөхөд ухаан арай алдаагүй байсан нэг нь хуврагийг шөнийн адис хүртээх нь гэж горьдож байтал их өргөөний хаалгаар насандаа дарагдаж бөгтийсөн, таяг тулсан, цал буурал эмгэн орж ирээд таягаараа ван ахай руу зааж

- Өрөвдөх сэтгэлгүй чамд бурхан хилэгнэж, бүр хан чамайг цээрлүүлэх болтугай, чи юу боллоо гэж миний ачийг алж, энэ хорвоод өөр түш их тулах, өөр сэт г эл зогоох юм.гүй настай эмгэний зүрхийг зүсэв гэж хашгирахад тэр үеийн хүмүүс хараалаас үхтлээ айдаг байсан болохоор бүгд загалмайлан айж сандарч байхад ван ахайн нүдэнд нүглийн муу х ай гялалзан сүртэйгээр босож ирээд мөрөн дээгүүрээ харж

- Барь галд шатаа гэж тушаалаа цэргүүд нь эмгэнийг үг дуугүй дайран барилаа тийм хэрцгий эзэрхий юмыг харахаар эгдүү хүрлээ гэсэн ч яах билээ.? С энди над уруу харлаа Бас нэг он г од нь орж дээ гэж бодоод Явал яа, өөрөө мэд гэхэд мань хүн шууд босож ван ахайн дэргэд очиж над уруу за ан

- Эрхэм минь , Эзэн соёрхоогүй байна. Тушаалаа өөрчлөхгүй бол шилтгээнийг хэмх бутраагаад зүүд нойрны юм. шиг агаар тэнгэрт замхраах нь байна шүү гэв. ван ахайг маш балмагдан ямар ч эсэргүүцэл гүйгээр тушаалаа өөрчиллөө гэдгээ цэргүүдэд дохин, исэр дээр лүгхийн суухад нь мин и й зовнил дорхноо замхра в Тэр хатагтайн архины согтуу нь ч гарчээ Архиных нь согтуу гарсан хүн олон байв. Бүгд суудлаасаа дэрхийн босож, ё с горимоо мартан үүдний зүг бөөнөөрөө ухасхийж мөр дээрх ширээ сандлаа унаган, са в суулга хагачин, бие биеэ түлхэн чихэлдэж, намайг шилтгээний нь хорвоогийн хя з гааргүй уудамд хумхийн тоос болгон цацчихаас өмнө гарч амжих гэж үхэлдэж байна. мөн ч мухар сүсэгтэй амьтад шүү тийм хачин мухар сүсэгтэй нь ой тойнд багтамгүй санагдана Золгүй тэр ван ахай жигтэйхэн айж номхроод миний зө в шөөрөлгүйгээр нөгөө хөгжмийн зохиолчоо ч дүүжлүүлэх зоригүй болсон байв. Тэр эм үнэхээр тарчилж эхэлсэн болохоор би өрөвдөж эхэлсэн юм. хэн ч бай өрө вд өх л байлаа л даа би жаахан найр тавьж, хэрэг явдлын эцэст нь тулгаад яах юм. гэж бодлоо Нэлээд бодож байснаа хөгжимчдий нь дуудуулж би диваажинд, би дуулж байна. гэдгий нь дуулууллаа Вэн ахайнх зөв байж гэж итгээд хөгжимчдийг бүгдийг дүүжлэх зөвшөөрөл олгов Энэ өчүүхэн мөр алгадалт ван ахайд тун ээлтэй нөлөөлсөн юм. Аливаа бүхэнд нугаршгүй, хатуухан байх юм. бол төрийн эүтгэлтэн юу ч хожихгүй, яагаад гэвэл эрх мэдэлдээ буй хүмүүсийн юм. голон бардам занг доромжилж улмаар өөрийнхөө хүч чадлыг ганхуулахад хүрнэ . Хэрэг явдалд хор болохооргүй бол хааяа энд тэнд найр тавьж байх явдал бол хамгийн мэргэн бодлого юм. Эдүгээ, ван ахай дахин тайвширч, тэр ч байтугай жаргалтай болоон үедээ уусан дарс нь толгойд нь дахин гарч хуучин янзаараа аашилж эхэллээ Дарс, хэлий нь даруулгагүй болгохлоор тэр нь мөнгөн хонх мэт жингэнэж алдах нь тэр я рина гэж ёстой алаад өгдөг эм байлаа. Орой бо лс он байна.,би ядарч байна., нойрсмоор байна. гэж түүнд сануулах эвгүй байсан учир эртхэн л яв ж унтдаг байж хэмээн амаа барьж билээ. . Одоо н эгэн т ийм болсон хойно тэвчихээс өөр замгүй байв. Тэгээд нойрхон шилтгээний нам гүмийн дунд тэр эмийн дуу ганца а раа жингэнэж, жингэнэж, тээр дороос яс хазталзам тарчлах хүний орь дуу бүдэгхэн сонсдоод в ан ахай сая дуугаа түр татан нүдэнд нь баярын цог золбоо

гялалзаж, хөөрхөн толгойгоо шувуу шиг далжийн чих тавин чагнав чив чимээгүйн дундаас нөгөө чимээ бидний чихийг дэлсэхэд би

- юу вэ? гэж асуулаа

- Бөх амиа яасан гол нь тасардаггүй амьт ан бэ? мөн ч олон цаг боллоо

- юун гол нь тасардаггүй гэж?

- Тамлуулсан хэр нь Очье, чамд сонин юм. үзүүлье Одоо хүртэл гэмшиж буруугаа хүлээхгүй байг аа бол тасчаад өгнө дөө, харж л байгаарай Тамын газрыг сүрхий зохиожээ Тамлуулж буй хүнийг харахаас нүд хальтарч байхад тэр эм жишим ч үгүй байна. . Дүрэл з эн асах бамбар барьсан зэвсэгт цэргүүд дагуулсаар хөгц ханхлах, олон зуун жилийн турш гя н дангийн харанхуйд автсан чийг гудам дамжин чулуун шатаар явлаа Тамлуулж буй золгүй тэр хүний тухай, үйлдсэн гэмт хэрэг нь ийм тийм гэж илбэч эхнэр баахан бурах боловч газар огт хорогдохгүй, байдал огт дээрдэхгүй, муухай ёозгүй, зовлонтой, урт аян хийж тэнд нь хүрч билээ. Ү л танигдах нэг хүний мэдэгдсэнээр тэр хүн вангийн цаазат ойд буга алчихсан юм. байжээ.

- Үл таних хүний хо в чинь эрхэм минь б а т ал гаа хараахан болохгүй Яллагдагчийг яллагчтай нь нүүрэлдүүлбэл илүү зөв болно. гэж би хэллээ

- ийм өчүүхэн хэрэгт би тэр тухай бодсонгүй Бодлоо ч гэсэн ,тэр хов хүргсэн хүн нь шөнө ойн ц а гдаад нүүрэндээ багтай ирж хэлж ө г чихөөд алга болсон болохоор ойн цагдаа тэр хүнийг танихгүй, тэгэхлээр тэртэй тэргүй нүүрэлдүүлж чадахгүй байсан л даа

- Тэгэхлээр буга алахыг ха рс ан хүн нь ганц Тэр үл танил хүн юм. уу?

- Ээ, бурхан минь Буга алж байхыг нь харсан хүн ганц ч байхгүй Харин тэр үл таних хүн энэ гөжүүд этгээдийг тэр бугын үхсэн газрын ойролцоо байхад нь хараад үнэнч иргэнийхээ хувьд ойн цагдаад мэдэгдсэн байна.

- Тэгэхлээр, үл таних хүн өөрөө бас үхсэн буганаас холгүй явж шүү дээ? Өөрөө алчихсан байж мэднэ шүү дээ . Шударга иргэний байдал гаргасан, бас багтай и рнэ гэдэг чинь тун ч сэжигтэй хэрэгдээ Эрхэм та, юун төлөө энэ баригдсан хүнийг тамлуул а хаар шийдсэн юм. бэ? Ингээд ямар ашиг байна.

- Гэмшихгүй байгаа юм. Гэмшихгүй бол сүнс нь тамд явах учиртай Үйлдсэн гэмт хэрэгт нь хууль цаазаар авна Ялаас мултраахгүй байх талаар би га йгү й хичээлгүй яах вэ Харин үүнийг буруугаа хүлээж, бүүр нүглийг арилгуулалгүй үхүүлчих юм. б о л өөрийнхээ сүнсийг тонилгоно шүү Энэний мөр дээрээс тамд унах тийм хүн биш ээ би

- Энэ хүн чинь гэмшихээр юм. хийгээгүй байвал яах вэ, эрхэм ээ?

- тийм эсэхий нь одоо л мэдье Хэрэв би үүнийг амь тавьтал нь тамлахад бас л гэмшихгүй, гэмших юм. гүй байгаад үхэх юм. бол тэр тусмаа л сайн Яагаад гэвэл гэмших юм.гүй учраас гэмшилгүй байсан хүнээс болж би тамд унахгүй шүү дээ Тэр үед бүгд ингэж боддог байсан юм. . Түүнтэй мар гаад огт нэмэргүй, Хар нялхаас нь тархи толгойд нь шингээстэй юм.ыг яаж ч учирлаад авч хаяна гэж байхгүй, аливаа учир начир элгэн хад мөргөх усны долгиол гэсэн үг Түүний толгойд тэр орны хүн бүхний толгойд шингэсэн юм. шингэжээ

. Түүний сэтгэцийн эмзэг талыг тус орны хамгийн ухаантай толгойтонгууд ч олохгүй вий Эрүү шүүлтийн гянданд ороод миний харсан юм. одоо хэр нүдэнд минь ил байна. тийм юм. нүдэнд минь бүү үзэгдээсэй, гэвч салахгүй юмаа Гуч дөнгөж гарч буй лужир эрийг царвуу, шагайнаас нь олсоор уян дэгээнд тэлж цо вд олсон байв. Тамлуулж тарчилсан нүүр царай нь хөд ө с шиг цайж, духан дээр нь хөлс бүрзайна . Нэг лам түүнийг бө хий н ширтэх бөгөөд хажууд нь зандалчин, зандалчинг хамгаалсан цэргүүд зогсоно . Хананд шигтгэн зоосон бамбарууд улалзана . Тэртээ буланд нүүр царай нь хачин болж, зовж тарчлан ухаан балартсан харцтай залуухан эмэгтэй атиран суугаа харагдах бөгөөд өвөр дээр нь нялх хүүхэд унтана . Биднийг босго алхан орж ирмэгц яргачин дугуйг аяархан эргүүлэхэд тамлуулж буй залуу нөгөө эмэгтэй хоёр нэг зэрэг хашгирлаа гэвч би боль гэж яргачинд хашгирахад чухам хэн тушаал өгч байгааг ч харалгүйгээр оосрыг султгав би тийм аймшигтай юмыг тэвчин харж чадахгүй, үхэх байлаа. Ван ахайг гяндангаас гарч байхгүй юу , би хоригдолтой ганцаарантай нь ярилцъя гэхэд ван ахай мэтгэхийг завдсан боловч энд зарц гоцго нарын дэргэд маргах хэрэг алга, нөгөө талаар би бол Артур вангийн төлөөлөгч шүү гэж хэлэхэд мань авгай арга буюу буулт хийх ёстойг ойлгов Тэгээд та намайг хэн болохыг энэ хүмүүст хэлээд өөрөө гар даа гэхэд энэ нь түүнд тун эвгүй байсан боловч тэр доромжлолыг тэвчээд миний бодсоноос ч илүү юм. хийгээ би зөвхөн түүний эрх мэдлийг л ашиглах гэж бодож байсан атал тэр авгай ингэж хэллээ шүү

- Та нар энэ хүний юу гэснийг биелүүл Энэ хүн бол Эзэн шүү дээ Энэ үг тэдэнд тарни мэт санагдаж, шоронтийн харх хулганууд миний өмнө нугасгүй юм. шиг бөхөлзөж эхлэх нь тэр Ван ахайн цэргүүд эгнэн жагсаад хойноос нь бамбар дүрэлзүүлэн гарч одлоо Тэдний холдон холдох жигд алхаа газар доорхи хонгилд бүдэг сонсдоно би тэр хоригдлыг цовдноос нь тайлж орон дээр хэвтүүл гэж тушаалаа түүнд дарс өгүүлж шарханд нь эм хийлгэлээ Нөгөө эмэгтэй дэргэд нь мөлхөж ирээд шуналтай хайртай нүдээр харах боловч айж буй нь ил байлаа. Өөрий нь хөөгөөд гаргачих байх гэж л айж буй бололтой, Духы нь сэмхэн илэх санаатай гараа сунгасан боловч намайг санаандгүй хармагц даруй гараа татан авч арагш үхасхийв Харахаас өрө вд мөөр

- Зүгээр, надаас бүү зов, толгойгий нь ил, яавал яа, охин минь гэж намайг хэлэхэд өхөөрдүүлсэн мал шиг нүд нь сэргээд явчлаа хүүхдээ газар тавиад залуугийнхаа хацарт хацраа нааж үеий нь илж баярын нулимс гаргаж байв. Цаадхи нь ухаан орж хайрын зөөлөн нүдээр харах боловч түүнийгээ энхрийлэх тэнхээгүй ажээ. Гяндангаас хүмүүсийг гаргах цаг боллоо гэж би бодоод хоригдлын эхнэрээс бусдыг гар гэлээ. Тэгээд

- за нөхөр минь , ингэж яллаж байгаа явдлыг чи өөрөө юу гэж үзэж байгаагаа надад ярьж аль, бусад хүн юу гэж үзэж байгааг би мэдэж байна. гэв Тэр залуу толгойгоо сэгсэрлээ гэтэл хүүхэн нь миний ойлгосноор тэгж шаардсанд минь баярлаж буй мэт байв.

- чи намайг таних үү?

- Таньж байна. Чамайг Артур ноёны вант улсын дотор мэдэхгүй хүнгүй, бүгд мэднэ

- Хэрэв чи миний талаар худал гүтгэлэг сонсоогүй бол надтай ярихаасаа айх ёсгүй гэхэд бүсгүй нь яарангуйгаар

- Ариун үйлст эзэн минь энүүнд үнэнийг тайлж өг үнэн и йг та ойлгуулж чадна, таны л мэдлийн хэрэг их зовлон амссан хүн шүү наадхи чинь миний төлөөл, миний төлөөл энэ би

энүүний тарчлахыг тэсэж чадахгүй нь Бушуухан, хөнгөн үхлээр л үхээсэй билээ. хо н г ор минь , би чиний тарчлахыг тэсвэрлэн байж чадахгүй нь , яагаад ч чадахгүй нь гээд цурхиран уйлж миний хөлд сөхрөн унаад гуйж гарлаа юу гэж гуйсан бэ? Нөхрийгөө ал аад аль гэсэн үү? юу болж буйг би сайн ойлгож байлаа. гэвч Хьюго түүний үгийг тасалж

- Дуугү й чи юу гуйж байгаагаа ч мэдэхгүй байна. амархан үхэх гэж хайрт хүнээ өлсөөж үхүүлэх хүн би биш юм шүү би чамайг чинь намайг сайн мэдэх байх гэж б од ож байсан юмсан гэв

- би учры нь ойлгохгүй юм. та нарын чинь оньсыг тааж чадахгүй байна. чи гэж би хэллээ

- Аяа, эрхэм хүндэт ноён минь , та үүнд ойлгуулж аль Зовлонд нь хичнээн их тарчилж байгааг минь бодож үзээч тийм гэж ухаарахыг хүсэхгүйдээ л энэ маань дуугарахгүй байна шүү дээ Түргэн үхлээр ө нгөрвөл би яасан их б а ярлах билээ. — чи юу гэж чалчаад байна. вэ? эндээс эрх чөлөөтэй хүн болоод гарах болно. . Үхэхгүй залуугийн цонхигор царай өнгө орж бүсгүй нь учиргүй их баярлан над уруу дуу алдан, "

- Амь аврагдлаа Артур ван өөрийнхөө зарлагынхаа амаар ярьж байна., Артур вангийн үг алт гэв

- Ингэхлээр, чи намайг итгэж болох хүн гэж яваа яваандаа ойлгов шив дээ чи юунд надад итгэж ядаад байсан юм. бэ?

- Хэн чамд итгэхгүй байсан юм.? Бид хоёрын аль маань ч сэжиглээгүй

- чи надад яагаад юу ч ярихыг хүсэхгүй байсан бэ?

- чи надад юу ч амлаагүй шүү дээ, амласан бол шууд л ярих байсан — Ойлголоо, ойлголоо гэсэн ч бас л гүйцэд ойлгоогүй байна шүү чи тамлахыг тэвчээд хэргээ хүлээхгүй б а йсан, энэ бол чамд хийсэн хэрэг байхгүй гэдгийг нотолж байна. .

- Надад уу яалаа гэж? Бугы нь би алчихсан юм.

- чи юу ? Ай бурхан минь яасан ч будлиантай хэрэг вэ?

- Эрдэнэ болсом ноён минь , би үүнийг үнэнээ хэл гэж евдөг сөхрөн гуйгаад байсан юм. гэтэл —Хүлээ гэж чи гуйгаад байсан гэнээ Хэрэг явдал улам маапаантай санагдаж байна. чи яагаад үнэний нь хүлээлгэх гээд байсан юм.?

- Бушуухан шиг үхүүлж зовлонгоос нь ангижруулах гэж л

- Бас ч аргагүй юм даа гэтэл өөрөө түргэн үхэхийг хүсээгүй байна шүү дээ

- Энэ үү хүсэлгүй яах вэ, хүсэж байсан

- Тэгвэл яагаад үнэнээ хэлээгүй юм.?

- Аяа бурам шиг ноён минь , би яаж эхнэр хүүхдээ хоол унд, Гэр оронгүй орхих вэ?

- Өө, би одоо л учры нь ухаарлаа Ёстой ал т шиг зүрх сэтгэл юм даа Хэргээ хүлээж шийггүүлсэн хүний эхнэр хүүхдийг хоол ч үгүй, хоргодох орон ч үгүй болгодог харгис хууль

юм. . Чамайг тамласаар байгаад алчихсан байлаа. гэхэд үнэнээ хүлээгээгүй байвал эхнэр хүүхдий чинь арай цөлмөх ёсгүй юм. биз дээ чи жинхэнэ эр шиг тэвчээр гаргаж, харин чи жинхэнэ хүний хань , жинхэнэ бүсгүй хүн шиг байж, өөрөө өлбөрч үхэхээс айхгүй эр нөхрийгөө тамлуулахаас ангижрах гэжээ . Үнэхээр, бүсгүй хүн амиа хайрлахгүй байж чаддаг улс би та хоёрыг хоёуланг өөрийн харьяа газар аваачна, тэнд та нар идээшинэ Тэнд би балар сохор мунхаг мал шиг амьтдыг хүн болгож хувиргадаг үйлдвэртэй хүн

Арван найм д угаар бү лэг

В АН АХАЙН ГЯНДАНД

Б и бүгдийг янзалж тэр хүнийг чөлөөлөн гэрт нь хариулах болгоод оронд нь тэр зандалчинг л цовдлуулж орхи ос ой гэж бодож билээ. Өөрийнхөө үүргийг шударга сайн биелүүлж байсан, хүн хичээнгүйлэн тарчилгадаг сайн түшмэл байсны хувьд нь түүнд буруу өгөх үндэс байгаагүй харин ялтныг дур мэдэн ямар ч шалтга ан гүйгээр зодож, эхнэрий нь янз янзаар доромжилдог байсны нь хувьд л тэгээсэй гэж бодс он Лам нар тийм юм. над ад хэлж зандалчинг за лхаа вал т а арн а гэж байсан юм. . Л а м Н а р бол Х амгийн олигүй муух ай амьт ад мөн боловч заримд аа сайн т ал харуулдаг юм. . Л а м бүхэн бүгдээрээ луйв а рчин, гаг цх үү ха р амиа бодсон этгээдүүд байсан биш, зарим нь , ялангуяа ард түмэнтэй адил амьдарч байдаг нэг нь хүмүүсийн Г аслан зовлонг үнэн сэтгэлээсээ ш аш ин шүтлэгийнхээ үүднээс нимгэтгэх гэж ча рмайж байсан энэ тэр б а римтыг би нотолгоо болгон дурдсан ч чадах билээ. Энэ нь надад маш харамсалтай сана гдах боловч би юу ч хийж чадахгүй байсан болохоор энэ талаар ухаан бодол их зард а гүй юм. . Нэгэнт өө рчлөх гэсэн ч чад ал мөхөсдөх тийм юмны Тал аа р дэмий бодол болох за н Над ад үгүй Ард түмнийг ноёлогч Ш ашинтай дотно болгож байсан учраас би тийм лам нарт тун дургүй байсан юм. Нэгэнт шашингүй байж чадахгүй байгаа хойно хараахан яая гэх вэ, харин миний үед Нэгдсэн улсын сүм хийд дөчин хэсэг болчихоод дайсагн а ж байсан цаг Надад х а мгаас сайхан санагддаг юм. . Улс төрийн байгуулл а гын мэдэлд засгийн эрх мэдэл бөөгнөрөх нь хэзээд муу зүйл байсан бөгөөд ноёлогч шаши н гэдэг бол улс төрийн байгууллага мөн, Тэр бол улс төрийн тусгай зорилгоор л байгуулагдс ан хэрэг тийм улс төрийн байгууллага бол зорилгынхоо төлөөл бэхжин бат а жс ан хэрэг тэр бол эрх чөлөөний д а йсан, харин үйлээ улам сайн хийе гэвэл олон салбар болон хуваас ан байвал зохино Энэ бол заавал ч а риун суд а рт бичигдсэн зүйл шиг гарц а агүй байх зүйл биш л дээ, энэ бол миний л бодол, би гэдэг маань нэг л хүн, ганц хүн, тэгэхлээр миний бодол бол папын бодлоос илүү ч үгүй, дутууч үгүй бодол шүү дээ Тэр зандалчинг цовдлуулахыг би хүссэнгүй, гэхдээ лам нарын зүй ёсны гомдлыг зүгээр орхиж чадаагүй юм. Түүнийг шийггэж зандалчдынх нь албана а с халж шинээ р байгуулагдаж байсан хөгжлийн чуул г ын Кдпөл мейстрын а лбанд томилон ший т гэсэн Хөгж и мдөж чад а агүй, өршөөж хайрл а ач гэж нада а с гуйж гувшсан боловч би түүний т а йлбар хэдийгээр үнэнтэй а вч тэр үед тус орон даяар хөгжимдөж чадах тийм хөгжимчин гэж байг а агүй тул тухайн тохиолдолд ямар ч хама а гүй хэмээн үл хэрэгсэж билээ. Маргааш өглөө нь ван ахай, Хьюгогийн амь н а сыг ч эд хөрөнгийг ч авч чадалгүй өнгөрснөө мэдээд г алзуурахаа дөхсөн юм. гэвч би түүнд ингэж тайлбар л ав хууль болон тогтсон заншлын ёсоор та энэ хүний амь нас, эд хөрөнгийг авах эрхтэй боловч түүний х э рэгт хөнгөрүүлэх шалтгаан байсан учраас миний бие Артур вангийн нэрийн өмнөөс түүнийг өршөөлөө, та энэ ланчгаа тэвчээртэй давах хэрэгтэй Тэр буга энэ хүний тариалангийн талбайг цөлмөхөөр нь ц у халдсанд аа алчихсан юм байна., тэрнээс биш юманд шунасандаа т эг ээгүй юм байна. . Дараа нь алснаа мэдэгдэхгүйн эрхэнд

вангийн ойд аваачиж орхижээ Цухалдах уурын му н хаг бол амьтан, хүнийг алахад хөнгөтгөж үзэх шалтгаан болдог гэдгийг тэр шуламсын муу ван ахай я аг аад ч ойлгохгүй байсан болохоор хичнээн л уурлад а гсан уурлаж байг гэж бодоод би дахин тайлбарлаагүй юм. Түрүүн тайлбарлаж байхдаа ингэж ч хэлж үзсэн та жишээ нь нөгөө зарцыг алахдаа бас л уурын мунх а г орсон учраас хөнг ө тгөх талтай байсан ялт хэр эг г эх эд хашгичин Гэмт хэрэг гэнэ шүү Бурхан тэнгэр минь тэрний төлөө би ял эдлэх болох нь ээ гэв Түүнийг ятгаад ятгаад ямар ч нэмэргүй байв. Хар нялхаас нь шингээсэн үзэл бодлыг нь орхиулах гээд дийлэхгүй, хүмүүжил гэдэг бол бүхнийг шийддэг зүйл шүү дээ, Бид зан араншингийн талаар ярьцгаадаг тэнэг явдал зан араншин гэх юм. ер байдаггүй зан а р а ншин гэдэг бол зүгээр л уламжлал, хүмүүжил Ман а йханд өөрийн сэтгэц, өөрийн санаа бодол гэх юм. б а йхгүй Бидний сэтгэц, санаа бодол бол бидэнд үламжлан өвл ө сөн, хүмүүжлээр шингэсэн зүйл Тэгэхлээр б идний гавьяа юм. уу гэм гэж хэлж болох хамаг зүйл м а ань бүгд л нэг зүүний үзүүр дээр багтахуйц тийм шалихгүй юм. байхад бусад үлдэх нь медуз юм. уу д эвх рэг юм. уу эсхүл маш олон живаа дүнчүүр жилийн турш их зовлонтой сургамжтай төвөгтэй хөгжлийн замыг туул саар одоо бидний хүмүүсийг буй болгосон м и чнээс эхэлсэн учиргүй урт унжруу, дээдсийн үгэс ул а мжла л өвлөсөн зүйл юм. миний хувьд гэвэл энэ хоёр х эцүү зовиуртай мөнхийн мэт үеийн хооронд даяанчл а хдаа чухамхүү би гэж хэлж болох тэр өчүүхэн бичил жижиг хэсгээ ха дг алж амьдралын цэвэр, өөгүй, эрхэм н а ндинаар өнг ө рөөхийг л хичээж буй бөгөөд биеийнхээ бусад бүх чанарыг хаана ч тонилж байсан, тамын х а ранхуй нүх р ү ү ч орж байна. уу над падгүй гэж боддог юм. Тэр ван ахай нүглийн ёрын муу жингэр толгой дахь ухаан нь чамлахааргүй боловч хүмүүжлээрээ илжиг болон хувирсан амьтан гэж олон зуун жилийн хойно төрсөн хүмүүс хэлэхээр золиг л доо зарцыг алсан нь гэмт хэрэг биш, Түүний эрхийн биелэл гэж шударга биш зүйлд эргэлээлгүй итгээд тэр эрхээ хамгаалан мэтгэж байлаа. Дуртай цагтаа харьяат нараас алж хядаж байх нь түүний зөв бөгөөд шударга хэрэг гэж эргэлзээ гуйвалтгүйгээр хүмүүжүүлсэн байна л даа Яая гэх вэ, чөтгөрийг ч гэсэн зөвгөх тал байдаг хойно яана гэх вэ Ван ахайг үнэндээ магтан шагшвал зохих байжээ. Харин миний хувьд түүнийг магтах гэхлээр хэл минь аманд гацчихаад огт болдоггүй байлаа. зарц залууг алах эрхтэй, тэрний төлөө ял эдлэх ёс огт үгүй байж хүн алсан хүнийг шийггэх хууль байх боловч, тэр авгайд хамаагүй байж Тэр хүүгийн төлөө төлөөс өгөхдөө тэр аагай тун их уужуу ариун үйл хийж байна. хэмээн ухамсарч байсан болохоор миний бие шударга ёсыг бодож түүнийг тийм үйл хийсэнд нь магтах учи р тай байсан боловч хэл минь гацчихаад ер болоогүй юм. Элж зовж элэг нь эмтэрсэн тэр нэг настай авгай, ариун цусанд бялдсан тор г он чимэгтэй тэр сайхан хүү хоёр миний дотроос ер гарахгүй байлаа. тийм хүний амь насыг нөхөж гүйцэх юм. байх уу ? Төлбөрий нь хэнд өгөх вэ? Ван авгайн хүмүүжлээс нь бодвол үнэхээр магтах байтугай бишрэх юм. хийж буй хүн боловч би бас өөр хүмүүжилтэй хүн болохоор түүнийг магтаж хэрхэвч чадахгүй байлаа. Биеэ хүчилж байж л таныг бусад хүн магтах юм. гэж хэлснээс илүү үг миний амнаас г а раагүй юм.

- Эрхэм минь үүний төлөө танай хүн ард т а ны бурхан шиг үзэх болно. миний хэлсэн үг үнэн байсан боловч тэр ариун үйлийнх нь төлөө тэр авгайг дүүжлэх өдөр ирэхийг үзээсэй гэж чин зүрхнээсээ хүсэж байсан юм. Даанч муу, дэндүү танагүй муу хууль олон байсан юм. Ноён хүн боолоо ямар ч шалтгаангүйгээр уурандаа, бухимдсандаа юм. уу , зүгээр л зугаа болгож алах эрхтэй байсан бөгөөд титэм зүүсэн хүн ч өөрийнхөө боолыг, өөрөөр хэлбэл хэн дуртай хүнээ алах эрхтэй байлаа. Тайж хүн эгэл ардыг алах эрхтэй байсан боловч алсны төлөөсөнд нь мөнгө буюу тариа будаа төлдөг байв. Тайж хүн тайж хүнээ ямар ч

төлөөсгүйгээр алах хууль ёсны эрхтэй байсан боловч өс хонзонгоор өөрөө алагдаж болох байлаа. Хэн ч гэсэн, эгэл ард буюу боолоос бусад хэн ч гэсэн хэн нэгийг алах эрхтэй байсан юм. Эгэл ард боол хоёр л тийм эрх эдэлдэггүй байлаа. Хэрэв тэд хүн алчихвал хүн алсан хэрэг гэж үздэг байсан бөгөөд хуулиар хүн алахыг хориглосон байдаг нь тэр л дээ Алагдсан хүн нь алснаасаа илүү удам судартай байвал алсан хүнийг Тэр орныхонтой нь хатуу ширүүн цээрлүүлдэг байв. Эгэл ард тайж хүнд амь насанд нь огт халгуй жаахан ч болтугай маажиж орхисон байхад тэр хүнийг морины сүүлнээс чирэн тасчидаг байлаа. тийм явдал болоход үй олон хүн цуглаж тэр зугаатай үзэгдлийг харж цаг сайхан өнгөрөөх гэж улайрдаг байлаа. Тэр сүрхий дэгжин хүрээлэнд багтдаг хүмүүсийн зарим зугаа цэнгэл нь XV Людовигийн нэг дайсныг хэрхэн дөрвөн мөчөөр нь цовдолж алсан тухай амнаас ч гарамгүй айхтар зэрлэг явдалтай нэгэн адил тийм зүйл байлаа. би тэр аймшигт шилтгээнийг ханатлаа харж Мэдсэн болохоор тэндээс бушуухан зайлахыг хүсэж байсан боловч нэгэн зүйлийг гүйцэтгэлгүйгээр яваад өгнө гэхэд дэндүү хүншгүй юм. болмоор санагдсан юм. Хэрэв намайг хүнийг дахин зохио гэх юм. бол би түүнд нүнжиг гэж нэг юмгүйгээр хийх билээ. Нүнжгээс болж хүн хичнээн олон эвгүй юманд орно вэ нүнжигт олон сайн тал байх боловч түүнийг эцсийн эцэст нөхөх юм. байхгүй Уг нь сайн юм. бага шиг, аятайхан юм. иххэн л байвал т аарах юм л даа гэсэн ч энэ бол миний хувийн бодол бөгөөд би бол нэг л хүн шүү дээ миний амсаж өнгөрүүлсэн зүйлийг амсаж үзээгүй хүмүүс өөрөөр бодож болох юм. Тэд өөрсдийнхөө санаа а бодлыг баримтлах бүрэн эрхтэй л дээ би өөрийнхөө нүнжгийг олон жилийн турш ажиглаад байхад нүнжиг маань мөн ч олон удаа зовоож тарчлаах юм. Энэ бол үнэн гэдгийг л би хэлэх байна. Бид үнэ цэнэтэй юмыг үнэлдэг хойно анхандаа би тийм чанараа үнэлж байгаа биз гэтэл одоо нүнжгээсээ болж зовлон үзэхийг үнэлэх маань хичнээн тэнэг хэрэг вэ гэж бодно Энэ асуудлыг нөгөө талаас нь авч үзвэл түүний хамаг утга учиргүй тал нь улам тод харагдана миний дотор төш байсан бол түүнийг үнэлж үзэх байсан бол уу ? Хаанаас даа Тэгвэл яг үнэнээр нь хэлэхэд эвтэй эвгүй талаас нь бод в ол хүнд нүнжиг, төш хоёрын аль нь ч байсан өөрцгүй юм. Үүнийг би мянга түм дахин мэдэрч авсан юм. Түүгээр ч барахгүй төш эвгүй оргиод байвал хүчлээр идүүлчи хэж болно., гэтэл өөрөөл унтарч алга болохгүй боя нүнжгийг арилгах ямар ч арга байхгүй, ямар ч бол тугай надад л тийм арга олдохгүй юм. Нэг үгээр хэлэхэд би тэндээс явахынхаа өмнө нэг тун базаахгүй юм. хийсэн дэг Ямар ч болтугай тэр тухай бодохоос миний санаа тэр өглөө жингөө зовоод болохгүй байлаа л би тэр тухай өвгөн вантай ярилцаж болох байсан, гэвч ярилцаад нэмэргүй гэдгийг мэдэж байлаа., яагаад гэвэл ван бол сөнөсөн галт уул шиг болчихсон юм. Цагтаа тэр галт уул бишгүй л дүрэлээж байсан байлгүй, гэвч одоо дөл нь аль язгуурын унтар чихсан зөвхөн сүр ихтэй бөөн үнэсэн чулуул үлдсэн байлаа. Ван уг нь сайн санаатай, эелдэг зантай, хүний үг ойлгох хүн байсан боловч ашиг нь нэгэнт өнгөрсөн байв. Энэ газар ван гэгчийн нөлөө огт байхгүй, хамгийг гагцхүү тэр ван авгай мэддэг байсан байна. Тэр бол жинхэнэ Везуви байсан юм. Сайн зангаа хөдлөхөөр бидэнд бүхэл сүрэг болжмор шарж өгөөд тэр байдлаа далимдуулан ёстой галт уул дэлбэрэх адил юм. болгож бүхэл хот орныг сөнөөн авслахаас сийхгүй амьтан байсан юм. зарилдаа тун муу юм. болох нь гэж дандаа бодож байвч хэрэг дээрээ нааштай юм. болох явдал байдаг л даа би зориг орж ван авгайд хэллээ Саяхан Камелот болон ойр орчмын шилтгээнүүдийн шорон гянданг эр гэж үзлээ, хэрэв та зөвшөөрвөл таны шоронгийн хоригдлуудыг үзье гэлээ. Үзүүлэхгүй гэх байх гэж миний бодож байсанчлан зөрж гарлаав шүү гэсэн ч төдхөн зөвшөөрсөн, тэгнэ гэдгийг нь би бас мэдэж байсан боловч тийм амархан зөвшөөрнө гэж харин бодоогүй юм. дотор жаал онгойлоо Авгай бамбар барьсан цэргүүдээ дуудаж бид гяндангаар нь орохоор доош буулаа Гяндан нь шилтгээний доод нүхэнд орших бөгөөд шууд элгэн хад

хонхойлж гаргасан олон жижиг тасалгаануудаас бүрджээ заримд нь гэрэл гэгээ огт орохгүй хав харанхуй Нэг тасалгаанд навс болсон хувцастай эмэгтэй хүн дэвсгэр ч үгүй цулгай газар суух бөгөөд нэг ч үг хэлэхгүй, асуусан үгэнд ч хариу хэл эхгүй байлаа. гагцхүү амьдрал нь болж хувирсан тэр гунигт харанхуй нүхэнд гэрэл гэгээ татуулан дуу шуу болон орж ирдэг ямар улс вэ гэж харах санаатай л нүүр лүүгээ буусан ширэлдсэн үс хялгасныхаа цаанаас ганц билүү хоёр дахин харсан Тэгснээ толгойгоо доош буулган өвдгөө хир буртаг болсон хумс бүхий гараараа тэврэн огт хөдөлгөөнгүй болов. Харахад хэлхээтэй хэнхэрцэг яс шиг болсон тэр эмэгтэй дөч орчим насны хүн гэмээр байлаа. харахад л тийм болохоос уг нь гянданд орох үедээ арван наймтай байсан, энд суугаад есөн жил болж буй ажээ. Тэр бол эгэл ардын хүүхэд юм. Түүнийг Брез Санс Пите гэдэг ноён эндхийн гянданд ирүүлсэн юм. байж Эцэг нь тэр ноёны гоцго байжээ. Тэр охин хурим хийх шөнөө хожим ноёны эрх гэж нэрлэх болсон нэгэн зүйлийг зөвшөөрсөнгүй, хүчирхийл э лийг хүчирхийл э лээр хариулаад ариун цуснаас нь хагас х у ндгыг асгаруулжээ Амь нас нь аюулд орлоо гэж бодоод суух гэсэн залуу нь гүйж, хүрээд, ноёныг зочны өрөө рүү түлхэн оруулжээ гэтэл тэнд нь баахан гийчид тиймэрхүү үзэгдлийг хачирхан хараад айн сандарч чичрэн дагжиж ноён нь туйлын хорссон ажээ. Ноёны өөрийнх нь гяндан хэрэгтнээр пиг дүүрэн болохоор тэр хоёр хэрэгтэнг өөрийнхөө гянданд багтааж үзээч гэж ван ахайг гуйжээ Тэр цагаас хойш тэр хоёр эр эм авгайн гянданд сууж буй хэрэг байжээ. Тэр хоёрыг хэрэг хийсэн гэж үзээд нэг цаг өнгөрсний дараа энд хорьсон, тэр цагаас хойш бие биенийхээ барааг ч хараагүй ажээ. Есөн жилийн турш тэр хоёр тийнхүү элгэн хадан гяндангийн харанхуйд бие биенээсээ хэдхэн алхмын зайтай хоригдсоор ажээ. Есөн жилийн турш тийнхүү нэг ханаар хоорондоо халхлагдсан боловч хоёр биенийхээ тухай юу ч мэдэхгүй байжээ. Эхний хэдэн жил цээлийн чулууч хагармаар хөөрхийлөлтэйгээр нулимс асгаруулан Амьд байгаа бол уу гэж бие биенээ сурагладаг байж дээ гэтэл чулуунаас ч хагуузүрхтэй хүмүүсийн амнаас тэд юу ч сонссонгүй Тэгээд хожмоо тэгж асууж сураглахаа, ер нь юу ч асуухаа больжээ Тэдний тухай тууж сонсоод хар хүүгий нь үзье гэлээ. Гучин дөрөвтэй гэх боловч харахад жар хүрсэн хүн гэмээр байлаа. Өвдгөө тохойлдон толгой унжуулан тэг дөрвөлжин чулуун дээр сууж байлаа. Урт ургасан үс нь нүдий нь таглана амандаа нэг юм. бувтнаад толгойгоо өндийлгөн биднийг нүд хэсүүлэн гунигтай утгагүй харцаар удаан харж бамбарын гэрэлд нүд нь гялбан дальдран зовуурлаж байснаа толгойгоо буулгаж нэг юм. бувтнаад дахин биднийг огт анзаарсангуй гэвч ямар их зовлон амссаны нь гэрчлэх үгүй тод гэрч илхэн байлаа. Царвуу шилбэнд нь бараг ээнэгшсэн хуучин шарх сор в и харагдах бөгөөд доодхи чулуунд нь бэхэлж тогтоосон гинж гав бас харагдана Г а в гинж нь зузаан зэвд идэгдэн газар хөглөрнө хоригдол санаагаар нэгэнт унасан үед гав хэрэггүй болдог байна. Би тэр хүний ухааныг сэхээрүүлэх гээд чадсангүй, тэгээд урьд нэгэн цагт энэ хорвоогийн хамаг сайн сайхны биелэл, сарнай цэцэг, шүүдэр, сувд, байга лийн га й хамшигт зохиол бүтээл, бие махбодыг олсон гайхамшиг нь болж байсан хэнд ч заяагаагүй тийм сайхан нүдтэй, хэнд ч заяагаагүй тийм сайхан дуу хоолойтой, гагцхүү хүсэл мөрөөдөлд л байх тийм гуа уян налархай хонгороо гэж бодож байсан тэр эмэгтэй дээр нь аваачиж оруул гэж би тушаалаа Түүнийгээ, түүнийгээ үзээд бараг бүлэгнэж гүйцсэн цус нь дахин оргилон сэргэх байх гэж Гэсэн ч миний урам хугарсан билээ. Тэр хоёр газар зэрэгцэн суугаад Ямар нэгэн бүүр түүрээр гайхах төдий бие биеэ харж дөнгөж адгуусан амьтны шохоорхол төдий байснаа хоёр биеэ мартаад нүдээ буулгах нь бидний огт үл мэдэх зүүд нойрын тийм е ртөнцийн дотор ухаан бодол нь дахин төөрөлдөж орхисон нь ил байлаа. би тэр хоёрыг гяндангаас гаргаж найз нөхөд дээр нь очуул гэж тушаасан юм. Энэ явдал ван авгайд таалагдсангүй Энэ хэрэг өөрт нь хамаагүй байсан боловч ноён Брез Санс Питэгийн хувьд баахан тусгүй юм. болно. гэж бодсон

байна. Тэр ноён санаа зовоод байвал би тайвшруулаад өгөх арга олно гэж би ван авгайд хэллээ Харх хулганы тэр харанхуй нүхнээс би ганц ноёноос бусад д ө чин долоон хоригдлыг суллан тавиулсан Тэр ноён бол в ан а вгайн холын с а д ан бас нэг ноёныг алсан ноён байлаа. Алагдсан ноён нь энэ ноёныг алах санаатай отож байсан боловч өөрөө дийлдэж хоолойгоо тас огтлуулж үхсэн юм. байж би Тэр ноёныг хүн алсанд нь гянданд нь орхисон юм. биш, харин тэр этгээд уур хорондоо ядуучуулын нийтийн худгийг нураан Дарж байсан хэрэгт нь үлдээсэн Садангийн минь алсан хүн гэж түүн ийг ван авгай дүүжл э х гэхэд н ь би хүн алах г э сэн хүнийг алах нь ялт хэрэг биш гээд дүүжлүүлээгүй юм. Харин худаг дарж нурааж байсных нь төлөө түүнийг дүүж л эх явдлыг би дуртай зөвшөөрөхөд ван авгай ч огт юу ч үгүй өнгөрснөөс ортой нь дээр гэж бодох шиг болсон Бурхан тэнгэр минь , тэр дөчин долоон эрэгтэй эмэг тэй хүнийг ямар шүү өчүүхэн зүйлээр гянданд хорьж байсан гэж санана зарим нь өрөөсөө ямар ч гэмгүй, зүгээр л хэн нэгийг уурлуулсан, ва н авгайг биш, Ямар нэг найз нөхрий нь уурлуулсны нь төлөөл хоригдож байсан байх юм. Хамгийн сүүлд орж ирсэн нэг хоригдол бол болгоомжгүй хэдэн үгээс л болсон байжээ. хүн бүхэн адил, гагцхүү өмсдөг хувцсаараа л ялгагддаг гэсэн байж Хэрэв бүх хүнийг нүцэглээд харийн хүнээр үзүүлэх юм. бол ван, домч хоёрыг, гүн зарц хоёрыг ялгахгүй дээ гэчихжээ Балай хүмүүжил нь тэр хүни й толгой тархийг чанасан будаа шиг болгож арай амжаагүй байсан бололтой би түүнийг гяндангаас гаргаад үйлдвэр лүүгээ явуулсан зарим тасалгааг гүн хавцал руу өнгийсөн хадан хясаанд хийсэн байна. тийм тасалгааны аль нэг галаас нарны нарийхан зурвас гэрэл орох сүв гаргажээ тийм тасалгааны нэгэнд байсан хоригдолд тун хэцүү байсан байна. Тэр хараацайн үүр шиг жижиг хонгилынхоо за в сар заальхайгаар шагайхад нь тэр нь өндөр хадан хясаанд байсан болохо о р тэртээ тэр дор хөндий тал газар өөрийнх нь г эр харагддаг байжээ. хорин хоёр жилийн турш гэрийнхээ барааг зүрх шимшрүүлэн гуниглан харж суусан байх юм. Шөнө болоход цонхны гэрэл асаж өдөр болохоор хүн хөр орж гарах нь харагдах бөгөөд чухам хэн ямар хүн орж гарч байгааг нь ялгаж чадахгүй байсан боловч эхнэр хүүхдээ гэдгийг мэддэг байжээ. Гэр орондоо баяр найр болохыг тэдгээр жилийн дотор ганц биш удаа харж заримдаа хурим хийж байгаа хэрэг биш биз дээ гэж боддог байжээ. заримдаа хүн оршуулгын ёслол болж байхыг хараад зүрх сэтгэл нь хачин болдог байж Авс байгааг олж харах боловч хэмжээ дамжааг нь багцаалж чадахгүй эхнэр хүүхдийн хэн нь нас бараа юм. бол гэж зовдог байж Тийнхүү тайлж үл чадах нууцыг нь аваад лам нар уйлж хайлах олон хүн дагалдуулсаар явах о ршуулгын цувааг ёс дүрэмтэй явахыг хардаг байж Гэрт нь таван хүүхэдтэй эхнэр нь үлдсэн юмсанж Арван есөн жил болоход таван оршуулгыг харахад лав л зарц хүн оршуулж буй биш нь хэр хэмжээнээс нь тодорхой байж Тэгэхлээр лав л таван эрд э нээ нэгэнт алдсан хэрэг ажээ. Одоо үнэлж цэгнэж баршгүй ганц л эрдэнэ үлдсэн, харин эхнэр үү хүүхдийн нэг нь үү гэдгийг яаж мэдэх билээ. Энэ асуудал түүнийг унтавч, сэрүүн байв. ч өдөр шөнөгүй зо в оодог байж Амьдрал нь арай ч бүр хов хоосонгүй, гянданд орж ирдэг нарны гэрэл бие бялдар, оюун ухааны нь сүйдэхээс сайн хамгаалж эрүүл мэнд нь дажгүй байжээ. Түүний гуниг дүүрэн яриаг сонсоод хэн бүхэнд байдаг ялимгүй сониуч зангаар сонирхож бас гэрийнхнээс нь чухам хэн нь амьд үлдсэн бол гэдгийг түүнээс өөрөөс нь ч дутахгүй сонирхсон билээ. би түүнийг өөрөө гэрт нь хүргэж өгөхөд төрөл төрөгсөд нь хэлж баршгүй гайхан баярлаж баяр ын нулимс гол мөрөн гэмээр урсаж байхыг нь нүдээр үзсэн юм. Бурхан тэнгэрийн өршөөлөөр тэднийхэн бүгд амар мэнд, урьд залуу за ндан байсан авгай нь одоо тавь хүрсэн буурал хөгшин болж үр хүүхэд нь өсөж томроод өөрснөө г эр бүлтэй болсон байлаа. Ван авгай ямар шиг шулам мэт хорон муу санаатай нь ганц тэр хоригдлыг л чадах гэж тийнхүү худал оршуулга үйп дүүлж элгий нь эмтэлж тарчлаах, ганц хүн үлдсэн гэж ганц өнчин хүний төлөө тарчлаах гэж тийм

юм. зохиож байсны нь бодохоос хүн зовоохын төлөө суут ухаан гаргаж шуламсын хорон санаа өвөрлөдөг нь яг ил байлаа. би л аминд нь ороогүй бол Тэр хүн тэгээд л үхэх байсан хэрэг Моргана дагина түүнийг хамаг зүрх сэтгэлээрээ үзэн ядаж хэзээ ч үл өршөөх билээ. гэтэл тэр эр хорон муу санаагаар бус хөнгөмсөг зангаар Морганаг хүрэн үстэй гээд хэлчихжээ Үнэхээр тийм байсан хойно энэ тухай ярихын ч хэрэг алга хүрэн үстэй хүмүүс нийгэмд дээгүүр байр эзлэхэд нь тэднийг хүрэн шаргал гэж нэрлэх хэрэгтэй юм. Тэр дөчи н долоон хоригдлоос т а вынх нь хэзээ шоронд суусныг ч, ямар гэмт хэрэг үйлдсэний нь ч, хэн гэдгий нь ч мэдэж чадаагүй юм. Тэдний нэг нь эмэгтэй, дөрөв нь эрэгтэй хүн байсан бөгөөд эрүү өвдөг нь нийлэхээ шахсан нүүр нь б өө н атира а болсон ухаан санаа нь балартсан тийм улс байлаа. Тэд өөрснөө ч тиймэрхүү жижиг зүйлсийг м а ртаад удаж буй бө гөөд өөрсдийнхөө тухай ч тодорхой юм. мэдэхийг больж б ү үр түүр юм. ярих болгондоо өөр өөрөөр ярьж байв. Гянданд хоригдлуудын дэргэд лам нарыг байлгаж тэд нь өдөр бүр хоригдлуудын хамт мөргөл үйлдэн тэднийг бурхны тааллаар энд орсон гээд бурхан алдаж э ндүүрдэггүйгээрээ тэдний яахыг хэнээс ч илүү мэддэг тэгэхлээр та нар бол мөлжин дарлагч нартаа үг дуугүй захирагдан хүлцэнгүй номхон байвал зохино хэмээн сургамжлан ятгадаг байж Тэгж байх нь бурхны таалалд илүү тохирно гэдэг байж, Тэр тавыг гянданд суух хооронд лам нар нь хэд дахин солигдсон болохоор хүний хөөрхийлэлтэй оронцог болсон тэдний урьдын амьдралын т алаар гагцхүү бүүр түүр зүйл л сонсож болох байлаа. Тэр нь тэгээд бас тэдний ялын хугацааны л талаар болохоос хийсэн хэрэг, эр усных нь талаар биш ажээ. тийм ховорхон мэдээ зэдээнээс ганц нэгэн зүйлийг мэдсэн нь юу гэвэл тэр таван хүн наанадаж гучин таван жилийн турш өдрийн гэгээ огт үзээгүй ажээ. гэвч түүнээс өмнө чухам хэдэн жил өдрийн гэгээ гэрэл үзсэн болохыг тогтоохын арга олдоогүй юм. Ван, ван авгай хоёр тэднүүсийн тухай яаж мэдсэн гэвэл хаан ширээ авахдаа л урьдахаасаа хамтад нь авсан болохоор тийм хүмүүс бий гэж мэддэг байж л дээ гэвч өвлөн авахад хүмүүс нь ирсэн болохоос биш тэдний тухай тодорхой мэдээ хамт ирээгүй, тэгэхлээр үе залгамжлан өвлөгчид нь тэр талаар ч анзаарсангүй, хэрэгтэй зүйл гэж огтхон ч тооцсонгүй л дээ би ван авгайгаас

- ,Та тэгээд эднүүсийг яагаад суллаж орхиогүй юм.? гэхэд мань хүн мухардмал байдалд орж билээ. Үнэндээ яагаад гаргаагүй юм. бол? толгойд нь е рөөсөө тийм бодол ороогүй хэрэг л дээ Тэгээд өөрөө ч таамаглалгүйгээр Иф гяндангийн ирээдүйн түүхийг та а варласан ажээ. Түүний бодлоос үзэхэд тэр хоригдлуудыг өвлөн авсан эд а г уурс л гэж бодож байсан байна л даа Ер нь өвлөн үлдэж байгаа юмыг хичнээн хэрэггүй байлаа. ч гэсэн хүмүүс хаячихдаггүй шүү дээ Нүдий нь гэрлээр сохолчихгүйн тулд боогоод оройн хурц нарны гэрэлд тэднийг гаргахад тэр сарьсан багваахайнуудыг харууштай байсан юм. Бурхны тааллаар, ноёлогч шашны тааллаар бий болсон хууль ёсных нь үрс болох тэднүүсийг хэлхээтэй яс, хий үзэгдэл, шувууны үргээлэг гэж нэрлэмээр байсан юм даа би бүр алмайран

- Зургий нь авахсан гэж аман дотроо хэлж билээ. Ямар нэг аялгуугаар хэлдэг үгийн дотор мэдэгдэхгүй үг байдаг гэдгийг өрөөс зөвшөөрдөггүй тийм хүн байдаг шүү дээ тийм улстай та бишгүй л тааралдсан л байлгүй тийм улс хичнээн тэнэг балай тусмаа мэдэхгүй юм. байхгүй гэж зүтгэхий нь яана Ван авгай чухам тийм хүн байсан болохоор тэнэгийн тэнэг юм. дандаа хийдэг байж миний үгийг сонсоод түр дуугүй байснаа гэнэт нүүр нь өнгө орж миний төлөө өөрөө гүйцэтгээд өгье гэлээ. би чи юу ? чи гэрэл зургийн тухай юу ч мэдэхгүй байж яаж гүйцэтгэж чадах юм. гэж бодож байлаа. гэвч удаан бясалгах хэрэгцээ гараа ч үгүй юм. мань хүн сүх барьчихсан өнөөх хэдэн хоригдол уруу явж байхгүй юу Морганы тэр дагина үнэхээр зугаатай амьтан байсан юм шүү би насандаа мөн ч олон эмэгтэй хүнийг үзсэн,

гэхдээ тэрүүн шиг онцгой амьтныг ер үзээгүй Тухайн явдал түүний шинжийг тодорхойлоход гойд жишээ болно. Гэрэл зургийн талаар тэр хүн мориноос илүү мэдэх юмгүй байсан, гэхдээ мэдэхгүй болохоороо тэр настай хүмүүсийн толгойг сүхээр тас цавчвал зөв болно. гэж бодсон байх нь

а рван есдү гээр б үлэг

ДАЙЧИН ЭРСИЙН ХЭРЭН ЯВАХ НЬ НЭГ ЕСОНДОО АЖИЛ ЮМ .

Маргааш өглөө нь эрт нарнаар Сэнди бид хоёр аяллаа цаашид үргэлжлүүлэн замдаа гарлаа хоёр өдөр, хоёр шөнийн турш тэр шар шувууны үүр шиг үмхий нүхэнд бие сэтгэлээрээ тарчилж байгаад ой модны сай хан үнэр, шүүдрийн чийг амтагдсан цэвэр агаарыг цээж дүүрэн торх торхоор нь амьсгалах хичнээн сайхан байв. Сэнди багаасаа ихсийн амьдралд идээшсэн хүн байсан болохоор тэр шилтгээний дот о р дажгүй байсан болохоор би өөрийнхөө тухайд л ийм байлаа гэж ярьж байг аа юм. Тэр хөөрхийлөлтэй хуухэн тэнд амаа татахаа с аргагүй байсан болохоор хэлээ бвахан амрааж чадсан бөгөөд лай нь над дээр ирнэ гэдгийг би гадарлаж байсан юм. миний бодсон зө в байлаа. гэвч тэр хүүхэн бол тэр шилтгээнд өөрийнхөө Ухаанаар биш тэнэг мунхга а раа л над олон удаа тус болж, олон удаа аварсан юм даа Тэрний хязгааргүй тэнэг нь ямар ч мэргэн ухаанаас илүү хэрэг болсон юм. Тэгээд нэгэнт тийм гавьяа байгуулсан хойно өнөөх цуцахыг мэддэггүй хэлээ санаандаа хүртэл ажи л луулбал ч ажиллуулаг гэж бодсон юм. Тэгээд ч түүний жигтэйхэн яриагаа эхлэхэд нь миний бие д а вхийгээ ч үгүй

- за одоо төрсөөр гучин өвлийг үзсэн нэг бүсгүйн хамт өмнө зүгийг зорьсон өнөөх Мархауз ноёныхоо тухай я рих уу даа

- Энэ тууж чинь тэр малчдын мөр олоход тус болно. гэж чи бодож байна. уу , Сэнди?

- Бодолгүй яах вэ, ариун ноёнтон минь

- Тэгвэл ярьдаа, би хоорондуур нь үг хэлэхгүйг хичээе бүр эхнээс нь эхэл, зоригтойхон эхэл би гансандаа тамхиа чихэж аваад анхааралтай сонсьё

- Одоо төрсөөр гучин жилийн нүүр үзэж яваа хүүхний хамт өмнөдийг зорьсон Мархауз ноёны тухай эргэж ярья Тэднийг балар харанхуй ойд ороход шөнө болжээ. Гүнзгий гэгчийн нэг гуу жалгын ёроолоор явсаар тэр хоёр маань Өмнөд Намгийн гүнгийн шилтгээнийг хүрч тэнд хоноглохыг гуйжээ Өглөө нь гүн нэгэн хүн явуулж Мархауз ноёныг бэлтгэ гэв Ноён Мар хауз босож, хуяг дуулгаа өмсөж өглөөний мөргөл үйлдэн хоол унд идээд тулалдаан хийх газар нь очиж мориндоо мордлоо . Хуяг дуулга өмссөн гүн мориндоо мордчихоод түүнийг нэгэнт хүлээж байлаа., хажууд нь түүний зургаан хүү тус бүр жад барин зогсчээ Тэгээд үзэлцэж хэлэв Гүн хоёр хүүгийн хамт Мархауз ноён уруу жад а а сүлбэхээр явуулсан боловч цаадхи нь жадныхаа үзүүрээр тэднийхийг хориглон биедээ жады нь хугалж х алг аахгүй байлаа. Тэгэхлээр бусад дөрвөн хүү нь хоёр хоёроороо дайран довтолсон боловч цөм л сэлмээ хугалуулав гэвч ноён Мархауз тэднийг яасан ч үгүй Харин гүн үрүү давхин очоод жадаараа цохиход гүн морьтойгоо хамт унав Дараа нь Мархауз ноён зургаан хү ү гий нь бас унагав Тэгээд Мархауз ноён мориноосоо бууж г үн г одоо чи миний захиргаанд орогтун, үгүй бол аллаа шүү гэв Тэр зуур гүнгийн зарим хүү ухаан орж Мархауз ноён руу дахин довтолохыг завдахад ноён Мархауз чи хүүхдүүдээ номхотго, үгүй бөгөөс та нарыг бүгдий чинь цааш нь

харуулна гэж хэлэв, Гүн амь насандаа гарцаагүй аюул тулгарсныг мэдрээд х өв үүдээ Мархауз ноёны эрхэнд орсугай гэлээ. Тэд бүгд сөхрөн мөргөж дайчин эрд сэлэмнийхээ бариулыг тушаахад дайчин эр нь тэдгээрийг нь хүлээн авав. Тэд эцгийгээ түшиж босгоод одоо үүнээс хойш Артур вангийн эсрэг хэзээ ч гар далайхгүй хэмээн нэгэн зэрэг тангараг өргөөд ойрын гурван эрдэнийн дүйцэн өдөр болоход вангийн ордноо очиж өөрсдийгөө үн э нч боолын ёсоор тушаана гэлээ. ийм юм. болсон юм. шүү, ариун явдалт зээнтэн минь Та хэдэн өдрийн өмнө дийлээд Артур вангийн өргөөрүү явуулсан тэр гүн, зургаан хүү чинь тэднүүс гэдгийг та одоо тааварлаж байгаа бизээ, бодвол

- Сэнди, хаанаас даа, худал байлгүй

- би худал хэлсэн байвал энэ худал маань миний толгой дээр эргээд бууг

- Үгүй мөн хачин юм. аа Хэн тэгж бодох вэ? Гүн, зургаан зулзагатайгаа Сэнди, за тийм бололз ихтэй л байгаа юм. гэхээс Бядан аялах дайчин эрийн ажил гэдэг бол ашиггүй бөгөөд маш ядаргаатай боловч харин ам жилт олбол олз омог ихтэй байдгийг нь одоо л ойлгож эхэллээ Тэр ажлыг би өөрөөдуртайдаа хийж байгаа юм. биш, би тэгэхгүй Нэр төрөө боддог, бат бэх суурьтай ганц ч үйлтгэлийн газар панз наймаанд түшиглэхгүй Ха маг тэнэг балай юм.ы нь авч хаяад гагцхүү эрүүл до руу л баримт сэлтийг үлдээх юм. бол бядан аялагч Дайчин эрийн амжилтнаас юу үлдэх юм. бэ? Дайчин эрийн амжилт гэдэг бол гэхайн махны худалдаачны л амж и лт гэсэн үг шүү дээ н эг өдөр, нэг долоо хоног гэнэт хөлжиж мэдэх юм. гэтэл өөрнэгэн гахайн махны худалдаач зах зээлийн газрыг гахайн махаараа дарлаа гэхэд чиний ажил баларна шүү дээ тийм биз дээ, Сэнди?

- миний ухаан чиний үгийг гүйцэхгүй байгаагаас болоод хамгийн энгийн үг чинь ч нэг их урт бөгөөд будлиантай юм. шиг санагдах юм.

- Тэнд маяглах байх юу байх вэ миний хэлснээр л, Сэнди тийм гэдгийг би мэдэж байна. Түүгээр ч барахгүй р нь сайн бодоод л үз х юм. бол бядан аялагч дайчин эрийн ажил бол гахайн махны худалдаачныхаас дор юм. яагаад гэвэл амжилт муутай боллоо гэхэд гахайн махыг хэн нэг хүн идчихнэ шүү дээ, гэтэл бядан ая л агч Дайчин эрсийн бүтэмжгүй болоход ямар эд хөрөнгө үлдэх вэ? Огтлуулж сийчигдсэн бие, хоёр тэрэг төмрийн хог л үлдэх нь байна шүү дээ тийм юмыг эд хөрөнгө гэж үзэх үү? Үгүй л дээ, минийхээр бол гахайн мах нь хол дээр миний ингэж боддог зөв үү, буруу юу ?

- Аяа, сүүлийн үед та бид хоёрын үзэж өнгөрүүлсэн үйл явдал, адал явдлуудын улмаас м и ний толгой, миний толгойгоор ч барахгүй бас таны толгой ч, таны толгойгоор барахгүй та бид хоёрын толгой хоёулаа зовсон байна.

- Үгүй, чиний толгой ер падгүй, Сэнди, чиний толгой зүгээр байна., харин хэрэг явдлын талаар юу ч ухаарах гүйдээ л хамаг гал байна. чи хэрэг явдлын тухай маргах боловч тэр болгондоо будилж орхих юм. за энэ ч яах вэ Бид хоёрын олз омог их байгаа юм байна. тийм их олзтойгоор Артур вангийн өргөөнд ороход ичих зовох юмгүй Далимд хэлэхэд малчид нь сонин юм. эндхийн эрэгтэй эмэгтэй хүмүүс өтөлдөгүй юм байна. Жишээ нь Морганын дагиныг а ваад үзэхэд харах нүүрэндээ бүр Вассарын эм тахиа шиг байх юм. Тэр өмнөд Намгийн гүнг аваад үзсэн ч дээ, тэр чинь одоо хүртэл тийм настай тийм олон үр хүүхэдтэй байж сэлэм жадаар даналзсаар байдаг сүрхий үг шүү би андуураагүй бол Говэн ноён түүний долоон хүүг алчихсан байхад бас Мархауз ноёнд алуулах зургаан хүүтэй, бас надад хүрэлцэх

хүүхэдтэй байсан байх нь Аль эсхүл тэр төрсөөр жаран ө в лийг үзсэн хөгшин хүүхэн чинь авсны хүйтэнд хөрсөн атлаа на с нь талийсан ч гэсэн энэ хорвоогоор тэнүүчилсэн хэвээр л байдаг хэрэг үү Сэнди, чи ер нь хэдэн настай вэ? Сэнди анх удаа л миний асуусан үгэнд хариу

өгөөгүй юм. Салхин тээрэмд нь засвар хийх хэрэгтэй байсан бололтой

хорьду га ар б ү л эг

МАХЧНЫ шилтгээнд

Өглөөний зургаагаас ес хүртэл гурван цагийн дотор бид хоёр есөн бээр газар явжээ Эрэгтэй, эмэгтэй хоёр хүн, төмөр хуяг дуулга гэсэн тийм гурван төрлийн ачаа тээсэн морины хувьд энэ бол чамламаар зай биш юмаа Дараа нь бид тунгалаг устай нэг булгийн дэргэд модны сүүдэрт удаан амарсан . Гэнэт нэг дайчин эр бидний зүг айсуй Ойртож ирээд муу за яандаа гомо рх сон юм. ярьж гарлаа Чагнавал байдаг муу б э лэн ч үгээр х а раал т а в ьж байна. гэвч түүний цээжин дээр алтан үсэгтэй самбар байхыг хараад миний бие ихэд баярласан юм. Самбар дээр алтан үс гээр бичсэн үг нь

Петерсоновын ариутгах шүдний сойз хэрэглэж сур Сүүлийн үеийн цоо шинэ зүйл

гэсэн байлаа. Тэр хүн бол миний дайчин эрсийн нэг байсан болохоор би баярласан юм. Ланселот ноёныг мориноос нь , арай л унагачилгүй өнгөрсөндөө их алдар нэрийг олсон өндөр булиа биетэй Мэдок де ля Монтэн ноён байв. Тэр их явдлынхаа тухай өөрийн танил болсон хүн болгон доо ямар нэг шалтаг олж заавал ярьдаг байж гэвч түүний а мьдралд түүнээс нь ч дутахгүй бас нэг их үйл хэрэг байдаг боловч хүн асуухаас нааш өөрөө ярина гэж байхгүй, Тэр ч бүү хэл, миний үйлдсэн хэрэг биш гэх нь холгүй байдаг ажээ. Тэр хоёрдугаар үйл хэрэг гэдгийнх нь мөн чанар нь юу байсан бэ гэхэд Ланселот ноён өөрөөс нь урьтаад л өөрийг нь унагачихсан болохоор Ланселот ноёныг унагаж чадавгүй юмсанж Тэ р эгэл бор ухаант эр тэр хоёр явдлынхаа тухай ялгаа гаргаж мэддэггүй байж Хариуцсан ажилдаа үнэнч сэт гэлээр ханадаг байсан учраас би түүнд сайн байлаа., Түүний ханхар цээж өргөн мөр, арслангийнх шиг том толгой, толгойдоо хатгасан шувууны өд, шүдний сойз атгасан гарын дүрс бүхий хачин сүлд тэмдэгтэй том б а мбай зэргий нь х а рахад аятайхан б өгөө д нойодонтыг ша а рдаж бай гэсэн лоо з он нь болбоос миний дэлгэрүүлсэн шүдний нойтон оог хэлж байгаа хэрэг юм. ядарлаа гэж хэлэх боловч мо рь ноосоо бүүхыг хүсэхгүй байв. Үнэхээр л ядарсан байдалтай х а рагдана Зууханд зориулсан маажин тарааж буй хүний хойноос нэхэж явна даа гэж тайлбар хэлэв Тэр хүнийхээ тухай санах мөртлөө хараалын үг урсгаж гарлаа Нэг тэмцэ э нд нөгөө гах е рис ноёнтой өөртэй нь тулалдан амжилтгүй болсон боловч түүнээсээ нэрд их гарсан хатан зоригт дайчин эр Оссэз Сюрлюз ноёнд тэр маажинг дэлгэрүүлэх ажлыг гардуулсан байлаа. Тэр бол утас марзан хөөргөн эр учраас хорвоогийн аливаа ажил бүхнийг ултай суурьтай үзнэ гэж ерөөсөө байхгүй тийм болохоор нь ч би түүнд тийм маажин дэлгэр ү үлэх ажил гардуулсан юм. Манайханд төмөр зуух байгаагүй болохоор зуухны маажингийн тухай олигтой ярих яриа ч байхг ү й байлаа л даа тийм учраас тайзан дээр тийм төмөр зуух гарч ирэх агуу их өөрчлөлтийн үед хүмүүсийг түүнийгээ гамтай эдэлдэг болгохын тулд урьдаас аажим болгоомжтой бэлтгүүлэх нь чухал байсан бөгөөд тиймэрхүү ажилд тиймэрхүү төлөөний хүн таарах байлаа. Мэдок ноёны сэтгэл баахан үймж хараал зүхлийг галзуу мэт урсгаж байлаа. Тэгж харааж зүхэх нь сүн сий нь тамын газар хүргэнэ гэдгийг мэдэвч биеэ барин тэвчиж чадахгүй байлаа. Оссэз ноёныг олж түүнтэй нэгийгээ үзэж нэхий дээлээ тайлахаас нааш мань эр мориноосоо бууж ч чадахгүй, ясаа түр амрааж ч чадахгүй, юу ч хүсэхгүй байлаа. Түүний урсгах утгагүй үг нээс драйхийн таавал мань хүн өглөөгүүр үүрээр Оссэз ноёнтой санаандгүй тааралдсан, тэгтэл тэр нь хэрэв чи энэ чигээрээ шулуухан явсаар тааралдах уулс, хөндий тал, тариалангийн газар, шавар намгийг

гатлан явбал баахан жуулчидтай тохиолдоно, тэднүүс чиний шүдний бүх оо, сойзыг бүгдий нь гарцаагүй худалдан авна гэж хэлсэн юм. байж Мэдок ноён угаас албандаа мэрийлттэй хүн учраас заасан зүг үрүү нь явсаар гурван цагийн зовууртай аялал хийсний эцэст нөгөөдүүлээ гүйцэн очжээ Тэгээд яаж вэ? Тэднүүс нь миний өчигдөр өдөр шоронгоос суллан гаргасан насандаа дарагд сан таван хоригдол байсан ажээ. Тэр хөөрхий амьтдын с үүлчийн шүд унасаар хорин жил ө нгөрсөн бөгөөд ёзоор ч үлдээгүй байсан юм.

- би муу нохойг юу ч үгүй талхламз, үзэх үс ч үгүй болгом з Тэр Оссээээс арай цэвэр явдалтай ноён миний замд хөндлөн тааралдсан ч толгойгий нь авна гэж Мэдок ноён хараан зүхсээр байв. барьж л авах нь чухал байна. Би түүнээс өсөө авах их тангараг өргөсөн, өсөө авахдаа л а вна гэж занасаар байв. мань хүн энэ мэтийн баахан үг хэлж хэлж жадаа нэг сүрхий сэгсчиснээ давхин одлоо Бид орой болохын алдад нэг ядуухан тосгонд өнөөх суллагдсан ө в гөдийн нэгтэй нь өөрснөө тааралдсан билээ. Тэр хүн тавин жил уулзаагүй садан төрөл нөхдийнхөө илчинд дулаацаж хэзээ ч үзээгүй ач зээ нар нь түүн үрүү тэмүүлэн байвч түүний ой ухаан нь нэгэнт сөнөсөн байсан учир аль алин нь нэмэр болохгүй байлаа. Хулганы нүх шиг харанхуй хар нүхэнд хүн хагас зуун жил амьд байна. гэхэд үнэмшихийн аргагүй мэт санагдавч түүний эмгэн, амьд мэнд яваа үе тэнгийнх нь хүмүүс үнэхээр ийм явдал болсныг батлан ярьж байлаа. Охиноо үнсээд эхэд нь өгч үүрд алга болох харанхуйд явахдаа хичнээн чадал тэнхээтэй, эрүүл чийрэг хүн байсны нь тэднүүс нь санаж байв. Тэр хүн ямар хэргийн учир хичнээн жил гянданд суугаагий нь ч мэдэхгүй байсан юм. гэтэл хөгшин болсон эхнэр нь , хэдийн хань бүлтэй болсон охид хөвүүд и йнхээ дунд байгаа өтөлсөн охин нь мэдэж байлаа. Бүх амьдралынх нь турш гагцхүү нэр, санаа, биегүй дүр, домог шиг байсан эцэг нь гэнэт амьд хүн болон үзэгдэхэд охин нь түүнээс нүд салгаж чадахгүй ширтсээр байжээ. нээрэн үнэн юм. бол уу ? Сонин юм даа гэвч би өөрийнхөө тэмдэглэлд энэ явдлыг миний бодоход бүр ч сонирхолтой шалтгаанаар тэмдэглэсэн юм. тийм аймшигт хэргийг ч мэдсэн тэр хүмүүс өөрсдийн дарлан мөлжигчдийн эсрэг уур хилэн бадран тэмцэх өчүүхэн ч шинж үгүй байлаа. Тэд өөрснөө, өвөг дээдэс нь хэмжээ хязгааргүй хатуу ш ирүүн дарлал до ромжлолыг олон үеийн турш тэвчин хүлээж ирсэн болохоор гагцхүү сайн үйл хийж өгөхөд л тэд их гайхах шинжтэй ажээ. Боолчлолын ёс ард түмнийг хичнээн дор оруулж дорой болгосныг бодоход ч гайхм а ар тэр хүмүүс өөрсдийн амьдралд тохиолдох алива а гал зовлонг үг Дуугүй хүлцэн тэвчиж эвлэрч өнгөрөөхийг нэгэмт зохицон сур сан байх юм. Тэдний ух а ан бодол нь ч ү хжээ хүний ухаан бодол нэгэнт үхсэн бол тэр хүн хамгийн ёроолд ороод цааш явах газаргүй болсон гэсэн үг, би тэр замаар явсандаа тоогүй юм. боллоо гэж бодсон Хувьсгалыг тайван замаар хийх хүсэлтэй яваа төрийн зүтгэлтэн хүнд тун олигтой сэтгэгдэл төрүүлээгүй юм. Яагаад гэвэл үүний эсрэг зүйлийг нотлох гэж сайн санаа гарган хичнээн ч их чалчивч тийм гүн ухаантангуудын бодол буруу бөгөөд ганц ч ард түмэн эрх чөлөөгөө таатлй бодол, ёс суртхууны нотлох шалтгаанаар хэзээ ч олж авч байгаагүй бөгөөд амжилтад хүрч байсан хувьсгалууд дандаа хүч хэрэглэхээс эхэлдэг байсан гэдэг маргашгүй үнэнийг баталж байлаа. Энэ бол тойрон гарах аргагүй түүхэн хууль юм. Ер нь түүх хүмийг Ямар нэгэн юманд сургадаг бол энэ осууль л юм. Тэгэхлээр, тэр ард түмэн засгийн эрхийг аллага, хяд лагын аргаар л олж авах ёстой гэт эл миний бие тийм арганд таарахгүй хүн байлаа. хоёр өдрийн дараа их үдийн алдад Сэнди нэг юманд сэтгэл нь баахан зовсон байдалтай нэг юм. жигтэйхэн хүлээж буй янзтай өндөлзөөд байв. Бид одоо хүний махчны шилтгээнд ойртон ирлээ гэж тэр хэлэв Үнэнийг хэлэхэд би гайхсан, гайхах мөртлөө до тор нэлээд эвгүй оргисон Бидний аяллын зорилго аажмаар миний санаа бодлоос хаягдаж

байсан боловч одоо түүний тухай надад сануулмагц түүний ер бусын болон ойр болсонд нь сэрдхийн цочих шиг болж билээ. Сэнди улам улам сэтгэл зовоод байхад нь миний ч сэтгэл зовж эхэллээ зүрх түг түг цохиж байв. Зүрхний яахыг хэн ч хориглохгүй, зүрх бол оюун бодолд үзэн ядах тийм зүйлд ч цохилж болох зүйл Сэнди намайг зогсооч гэж гуйгаад мориноос бууж нургийн эрэг дагуу ургасан бут сондуулын зүг бараг мөлхөн ахихад миний зүрх бүр ч хүчтэй дэлсэж эхэллээ Сэнди бут сондуулын дотор орчихоод тэртээх хөндий талын зүг анхааралтайгаар ажиж эхлэхэд нь би бас мөлхөх шахам явж дэргэд нь очих үед ч зүрх минь түг түг дэлссээр байв. Нүд нь жигтэйхэн гялалзан алсыг хуруугаараа зааж амьсгаа давхцуулан

- шилтгээн шилтгээн Харж байна. уу ? Тэр харагдаж байна. хэмээн шивнэв Цөхөрдөхөд бас аятайхан цөхөрдөх гэж байдаг юм шүү

- шилтгээн ий? Энэ чинь гахайн хороо л байна. Сүрэл зангидаж базаасан гахайн хороо байна. гэж би хэллээ Сэнди миний өөдөөс гайхсан гутсан янзтай зэрэвхийн харав, Хөмсгөө зангидаж бодол болон дуугүй байна.

- Урьд тарнидуулаагүй байсан юм. Хачин гайхмаар юм. хачин гайхмаар юм. зарим нь үүнийг ид шидийн хүчээр бузар, ичгүүртэй юм. болон хувирчихсан зүйл гэх, зарим нь урьдынхаа адил хуви рш гүй хүчирхэ г , сайхан бөгөөд эргэн тойрон гүн гуу гангаар хүрээлэгдэж цамхаг дээрээ туг хиур мандуулан хөх тэнгэрийн мандалд умбах зүйл гэж харах юм даа Бурхан биднийг өршөөх болтугай Бусдын эрхэнд тарчилсан сайхан бүсгүйчүүл улам ч шаналан зовсноос нүүр царай нь улам хэчин болсон харагдана даа гэж бодохоос зүрх минь өвдөж байна. гэж Сэнди бодол болон хэлсэн билээ. Бид дэндүү орой ирсэн маань буруу байлаа. би юу гэж хэлэх ёстойгоо ойлгосон юм. шилтгээнийг надад л зориулж тарнидсанаас биш түүнд зориулсан хэрэг биш ажээ. Түүнтэй маргах, түүнийг Ямар нэгэн зүйлд итгүүлэх гэх нь цагийг дэмий үрэхийн төдий хэрэг, тэгэхлээр тийм байж л гэж хэлэхээс өөр аргагүй байлаа. Тэгээд би

- Нэг адил зүйл мөртлөө зарим хүнд ид шидтэй харагдахад заримд нь үгүй байдаг тийм юм. зөндөө сэнди чи тийм юмтай өөрөө тааралдаагүй ч гэсэн бишгүй сонсоо байлгүй гэсэн ч гонсойх юун Харин ч дээр биш үү Хэрэв тэр хатагтай нар хүн бүхэнд гахай шиг харагдаад байх юм. бол бас өөрсөндөөч тийм болчихсон санагдаад байсан бол тэднийг эргүүлж тарнидах хэрэгтэй болох билээ. Буцааж тарнидахын тулд анх яаж тарнидан тийм болгосны нь мэдэх хэрэгтэй болно. Тарнийг буцаана гэдэг бол ихээхэн осолтой ажил, яагаад анх яаж тарнидсан аргы нь мэдэхгүй бол алдаа болж гахайг нохой, нохойг муур, муурыг хулгана болгох мэтээр хувилган хувилгасаар уг материал сүүл сүүлдээ бүр замхарч өнгө ч үгүй, үнэр ч үгүй хий болон хувирах юм. уу , үнэндээ аль нь ч болсон ялгаагүй юм. болно. шүү дээ Тэгэхлээр аз болоход тэднийг гагцхүү надад зориулан тарнидсан болохоор тэднүүсийг буцаан тарнидах хэрэгцээгүй байлаа. Тэднүүс надад ч өөрсөн дөөч хэн бүхэнд хатагтай нар хэвээр харагдаж байж, х а рин миний төөрөгдлөөс болж тэднуус хэлмэгдсэнгүй, я агаад гэвэл би тэр жинхэнэ гахайг үзсэн ч, энэ чинь хатагтай юм шүү дээ гэж бодоод хатагтайтай харьцах ёсоор харьцах байлаа.

- Та бурхан дагина шиг ярьж байна., тэнгэрлэг ноёнтон минь Энэ дэлхий дээр хосгүй хүчтэн эрэлхэг та эднүүсийг чөлөөлөх бизээ гэж би мэдэж байна.

- би гүнж нарыг гахайн хашаанд орхих хүн биш, Сэнди Харин миний сохор мэт болсон нүдэнд маань ядуу малчин мэт харагдах энэ гурав юу вэ?

- Эднүүс чинь мангас д үр нь бас хувирчихсан байх нь ээ? Хачин юм. Есөн тохой өндөр нурууных нь таван тохой нь танд үзэгдэхгүй байхад та өөрийнхөө цохилтыг яаж тааруулах вэ? гэж бодохоос би одоо зовж байна. Ариун явдалт ноёнтон минь , болгоомжтой л байгаарай Одоо таны байгуулах гавьяа миний бодож байснаас хамаагүй хэцүү болж таарлаа

- Бүү зов, Сэнди Махчны хэдийчинээ хэсэг нь үзэгдэхгүй байгааг нь л мэдсэнээс хойш болоо Хамгийн чухал чухал эрхтэн нь хаана хаана байгааг нь төвөггүй мэдчихнэ Энэ муусайн юмны учрыг дор нь олчихно, бүү зов Намайг эндээ л хүлээж бай Сэнди сөхрөн суулаа Нүүр нь хувхай даан цонхийх боловч зүрх нь эрэлхэг зориг итгэл найдлагаар дүүрэн байлаа. Түүнийг би тийнхүү орхиод гахайн хашаанд орж малчид лугаа ярилцсан билээ. Тэд гахайнуудаа бүгдий нь их талархалтайгаар үнэ дүйн бөөнөөр худалдлаа би тэдэнд захын үнээс нэлээд дээгүүр үнэ арван зургаан пөнни төлсөн юм. би цагаа олж очсон байж Малчдын ярих нь маргааш лам нар, ноёд, татвар хураагчид ирж малчдыг гахайгүй, Сэндийг гүнж наргүй болгох байжээ. Одоо тэднүүс татвараа мөнгөөр төлөөд бас бага сага юмтай үлдэх боломжтой болжээ. Малчны нэг нь арван хүүхэдтэй, өнгөрсөн жил лам ирээд арван гахайных нь хамгийн тарган нэгийг авахад эхнэр нь нэг хүүхдээ түүнд барин

- Өрөвдөх сэтгэлгүй араатан чи энэ хүүхдийн тэжээлийг чи надаас булааж байгаа бол энэ хүүхдийг өөрий нь ав гэж хашгирсан гэнэ Гайхмаар адил тохиолдол байдаг юм. бүр эрт дээр үеэс одоо хүртэл ноёрхож байгаа шашинтай Вэлс нутагт намайг байхад яг ийм юм. болж би лээ. Шашин гэгч мөн чанараа өөрчи л сөн гэж боддог хүн олон байдаг боловч үнэндээ гадна талаа л өөрчилс ө н болохоос м ө н чанараа үгүй билээ. би малчдыг явуулчихаад гахайн хашааг нээж Сэндийг даллав Сэнди, ирэх ч гэж гүйж ирлээ, салхи шуурга шиг хурдан гүйж ирлээ Баяры н нулимс урсган гахай болгоныг барьж аван үнсэж өхөөрдөн т эвэрч, үнсэж үлгэж энхрий хайртай нэрээр дуудан сүйд болохы нь харахаас өөрийнх нь болон хүн төрөлхтний өмнөөс ичиж билээ. Тэр гахайнуудыг Тэр өөдөө арван бээр газар туух хэрэгтэй байлаа. мөн ч зөрүүд үг дуулдаггүй хэцүү гүнж нар байсан шүү Гахайнууд их замаар ч явахгүй зөргөөр ч явж өгөхгүй, тал тал тийш гүйлдэн хад хясаа, дов толгодоор харайлган хүн хүрэхийн ч аргагүй хонхор хотгороор орж шургалаад байлаа. Сэнди тэд гээрийг эрхэм хүндэт хатагтайн нэг адил эелдэг зөөлөн харьцахыг шаардах учраас тэднийг зодох эрх надад байсангүй бүр хамгийн адгийн туучий болсон үлхий гахайг ч хонгор минь , эрхэм минь гэж дуудах ёстой байлаа. Гахайн хойноос хүнд нүсэр хуяг дуулгатай хүн байн байн т харайлгах гэдэг чинь тун ч хэцүү, тун ч дэмий хэрэг байлаа. хамартаа төмөр бөгжтэй нэг золигийн жижигхэн хатагтай л ялангуяа миний махыг их идэж билээ. Биедээ бараг хялгасгүй цулдан тэр муу мэгж ёстой шуламс шиг зөрүүд туучий байж билээ. хойноос нь бүхэл цаг хөөцөлдөж байж арай гэж нэг барьж авахад анх зугтсан газраа ирчихсэн ер ганц ч алхам ахиагүй байдагсан . Сүүлд сүүлнээс нь барьж аваад орилж чарлахы нь тоолгүй чирч билээ. Сэнди жигтэйхэн айж гүн ахайг энэ м э тээр хормойноос нь чирэх даанч ёсонд хазгай хэрэг гэлээ. Гахайнуудаа бүгдий нь бус ихэнхий нь нэг газар хөөгөөд ирэхэд харанхуй болж байлаа. Беровенс де Морганор гүнж түүний хоёр хатагтай Анжөла Бөхүн, Элөн Куртман гэдэг хоёр хүүхэн алга байлаа. Тэр хоёрын нэг нь духан дээрээ жижигхэн хар то лботой хар мэгж, нөгөө нь урд нэг хөл нь ялимгүй сүйдэнгэ бор мэгж байлаа. хоёул миний махыг мөн ч идсэн дээ Бас хэд хэдэн баронесс дутсан боловч тэднийг алга бол лоо гээд би өчүүхэн ч тоосонгүй гэвч

хиамны гол болох тэдгээрийг олох хэрэгтэй байсан болохоор уу толгод, ой шугуйг самна гэж бамбар барьсан зарц нарыг эрэлд гаргасан билээ. Сүргээ бүгдий нь байшинд хийсэн л дээ тийм хачин юм. би энэ насандаа үзээгүй, бурхан минь тийм эрхүү юм. насандаа сонсоо ч үгүй тиймэрхүү юм. насандаа нэрлэ э ч үгүй Хийн тоолуур галзуурах шиг болж билээ.

Хорин нэгдү гээ р бүлэг

МӨРГӨЛЧИД

Ор дэвсгэртээ нэг орох аядлаа хэлэхийн аргагүй их ядарсан байсан юм. Хөшсөн мах булчингаа амрааж биеэ чөлөөтэй суниах яасан сайхан бэ Харамсалтай нь энэнээс цааш хэтэрсэнгүй, унтаж дуг хийхийн талаар бодоод ч нэмэргүй байлаа. Тэр язгууртай авгайчуул өрөө тасалгаа, гудам зайгаар үргэлж шуугилдан чарлалдан ороолон чөтгөр шиг аашлаад унтах нойры минь хасаж байлаа. Нэгэнт сэрүүн байхлаар чинь заавал юм. бодох юм. Сэндийн хачин гайхалтай төөрөгдлийн талаар л голцуу бодлоо Уг нь эрүүл хүн атлаа миний бодоход яг л галзуу юм. шиг санагдана хүмүүжил, ятгалга, сургалтын их нөлөө гэдэг л харагдаж байлаа л хүнийг юу ч гэж итгүүлж болох юм. гэвч над эвгүй санагдаж, бүр ч эвгүй байдалд оруузай хэмээн зовж байсан юм. Гахайнуудаа цуглуулж туугаад арилж өгсөн маань л хамгаас зө в болох биз гэж бодлоо Тэгээд

- Сэнди, цаг дэмий үрээд яах вэ я згууртан авгай нараа цуглуулаад замдаа гаръя гэлээ.

- Хаашаа, ариун үйлт Эзэн минь

- юун хаашаа гэж, г эр лүүгээ аваад явахгүй юу

- Энэ хүний ярьж буйг сонсооч Эд нар чинь янз бүрийн газар төрсөн амьтад шүү дээ Тэр гэрт нь хүргэж өгөх хэрэгтэй гэтэл ийм жуулчлалыг үйлдэн хорон санаат могой хааны үгэнд орж хүн төрөлхтний хамгийн анхны муу нүглийг үйлдэж зүрх сэтгэлд хорсголон атаа жөтөөний үүр зассан найз бүсгүйнхээ ятгалгад автан урьд ариун байж тэнгэрийн уудамд ахас дүүсийн хамт ариун явсан сүнсний дүрийг бузарлан гутаасан Адамыг буй болгон амьдрал үхлийг хамтад нь бүтэ э снээр амьдралын богино хязгаар то гтоосон байхад эднүүсийг Гэр оронд нь хүргэн өгч амжина гэж бодож байна. гэж үү?

- Чөтгөр алгадмар

- Ноёнтон минь

- ийм урт удаан цаг шаардах бясалгалд цаг маань хүрэхгүйг чи мэдэж байгаа шүү дээ Бид эднүүсийг хүргэж өгч амжихгүй гэж дэмий ярихын хооронд харин бид хүргэж амжих байна шүү дээ хоосон чалчих хэрэггүй, ажил хийх хэрэггүй амаа тат, тээрмээ зогсоо, одоо бидэнд чалчиж байх цаг алга Энэ тайж язгууртангуудыг хэн Тэр гэрт аваачих болж байна.

- Найз нөхөд нь Дэлхийн өнцөг булан бүрээс л ирцгээнэ ийм мэдээ үүлгүй тэнгэрт цахилгаан цохих шиг гэнэт, хоригдол хүн оршөөлийн зарлиг сонсох шиг амттай юм. боллоо Сэнди тэр гүнж нараа гардуулж тушаахын тулд эндээ үлдэх хэрэгтэй л дээ

- за Сэнди, сонсож байдаалгасан ажлыг бид эсэн мэнд гүйцэтгэлээ, одоо би явж илтгэлээ тавина Хэрэв хэзээ нэгэн цагт

- би бэлэн байна. Би тантай хамт явдаг хэрэг Өршөөлийг буцаан цуцлах нь тэр би өөрийгөө сэн ди шиг нөхцөлд байсан бол яах бол гэж бодохлоор Сэнди солиотой хүн биш гэж бодогдож байлаа. Хэрэв Сэнди миний нөхцөлд байсан бол өөри й гөө сургаж хүмүүжүүлсэн амьтдынхаа нүдэнд галзуу гэж үзэгдэхийг тун амархан ухаарах билээ. Хэрэв би Сэндид ямар ч ид шидгүй мөртлөө цагт тавин бээрийн хурдтай тэрэг байдаг, ид шидгүй мөртлөө сагсанд суугаад үүлийн цаагуур гарчихдаг хүн үзсэн, ид шидгүйгээр олон зуун бээрийн тэртээ буй хүнтэй би ярьж байсан гэж яривал Сэнди намайг солиотой амьтан гэж л ямар ч эргэлзээгүйгээр үзэх байсан Түүний ойр хавийн хүн болгон ид шидэд итгэдэг, хэн ч ид шидэд эргэлздэггүй байсан байна. Артур вангийн харьяаны хүмүүс ч гахайн сарав чийг шилтгээн болгож оршин суугчды нь гахай болгон хувиргаж болно. гэдэгт эргэлзэхгүй байсан нь Коннектикутын хүмүүс утсаар ярилцаж болдогт эргэлздэггүйтэй яг адил хэрэг бөгөөд тиймэрхүү юманд эргэлзэх явдлыг тус тусдаа солиотой хэрэг гэж үзэх нь аргагүй юм. Тэгэхлээр Сэндийг эрүүл ухаантай хүн гэхээс аргагүй байлаа. Сэнди ч намайг эрүүл хүн гэж байхын тулд би ид шидийн бус хүчээр ажилладаг галт тэрэг, ага а рын бөмбөл өг , утсан харилцааны талаарх мэдээг е рөөсөө цухуйлгахгүй байх хэрэгтэй байлаа. Жишээ нь би дэлхий бол хавтгай биш, тулгуур дээр зогсож байгаа юм. биш, тэнгэрийн дээрх бүх уудам нь уснаас ханхалсан халхавчаас бүтсэн гэж бодохгүй байсан л даа Тэр ванлигийн дотор надаас өөр тэгж бузар гэмт байдлаар бодох хүн ганц ч үгүй болохоор хүн амьтанд энэ чинь солиотой амьтан гэж хаа явсан газраа элэг доог болчихгүйн тулд амаа барьж явахаас өөр замгүй байлаа. Өглөө нь Сэнди гахайнуудаа гуанзанд оруулж өглөөний зоог барихдаа тэр нутгийн хүмүүс тайж

угсааган гаралтай хүмүүсийг ухаан ёс журмы нь ялгалгүй гээр эрт дээр үеэс туйлын их хүндэтгэн үздэгийн нэгэн адил тун гүн хүндэтгэлтэйгээр өөрөө үйлчлэн байлаа. Хэрэв миний эдэлж байсан алба маань өөртэйгээ тэнцэх гарал үүсэл удам өндөр байсан бол намайг тэр эрхмүүдтэй хамт суулган хооллох байсан бизээ гэтэл нэгэнт удам төрөлгүй хүн болохоор намайг тусад нь суулгасан тэглээ гэж ч би гомдоогүй л дээ Сэнди бид хоёр тусгай ширээнд сууж хооллосон Гэрийн эзэд гэртээ байгаагүй юм.

- Өнөр айл уу , эсвэл оорцог юм. бол уу , хааччих сан юм. бол, Сэнди? гэж намайг асуухад Сэнди бид хоёрын яриа дор дурдсан байдлаар үргэлжлэв — Айл?

- тийм ,

- Эрхэм хүндэт ноён минь , юун айл?

- энд байдаг айл, чиний бүл

- Үнэнийг хэлэхэд би таны юу асуугаад байгааг тань ойлгохгүй байна шүү Надад е рөөсөө гэр орон байхгүй

- Ердөө г эр бүл байхгүй гэж үү?

- Энэ чинь танайх биш юм. уу , Сэнди?

- минийх яаж байх юм.? Надад ямар ч байшин байхгүй

- Тэгвэл хэний байшин байх нь вэ?

- би мэддэгсэн бол танд хэлээд өгөхсөн

- Энэ байшингийн эздийг чи яагаад мэдэхгүй байх билээ. би днийг наашаа ир гэж хэн урьсан бай х вэ Биднийг хэн ч уриагүй Бид өөрснөө л хүр ээ д ирсэн, ийм л байна.

- Энэ чинь тэгвэл дэндүү дураараа юм. болж байна шүү дээ Бид хүний оронд хамаагүй орж ирээд хэрэгтэй хэрэггүй нь үл мэдэгдэх дан язгууртан нараар пиг дүүргэх мөртлөө эзнийх нь нэр усыг ч мэдэхгүй байна. гэдэг чинь юу гэсэн үг вэ? ийм цадиггүй юм. дур мэдэн хийхийг чи яаж зүрхлээ вэ? би бол үүнийг чиний Тэр юм. байх л гэж бодсон Эзэн нь юу гэх бол?

- Эзэн нь юу гэх бол гэнэ ээ? юу гэдэг юм.? бидэнд талархах л болно.

- Талархана гэнэ ээ? юу боллоо гэж тэр вэ? Сэндийн нүүрэнд огт ойлгоогүй шинж илэрнэ

- Таны хачин үгэнд би зовж байна. Бидний хүчээр тэднийд ийм эрхэм гийчид Гэр оронд нь заларч ирсэн байхад тэднүүс талархан баярлаж олзшоохгүй гэж үнэхээр бодож байна. гэж үү?

- нээрэн ч тийм их завшаан хэзээ ч олдохгүй байж болох юм даа Амьдралдаа анх удаа иймэрхүү гийчдийн бараахарсан гэж би мөрийцсэн ч хэлж чадах байна.

- Тэр талархлаа илэрхийлэг Үг хэлээрээ номхон хүлцэнгүй дагаж явах үйлээрээ талархлаа илэрхийлэг Тэгэхгүй юм. бол тэр хүн нохойноос өөрцгүй болно., нохойн удам

нохойн өвөг болно. гэвч надад нэг л эвгүй санагдаж бүр ч эвгүй байдалд оруузай гэхээс би айсан учир гахайнуудаа аваад арилж өгсөн нь дээр гэж бодоод ингэж хэлэв

- Сэнди, бид цагаа дэмий гарздаж байна. Эдний гээ цуглуулж аваад буцах замдаа оръё

- Эрхэм Эзэнтэн минь хаашаа явах гэж?

- юун хаашаа гэж? Гэрийн зүг аваад явахгүй юу

- юу гэж байгааг нь сонсоорой д элхийн янз бүрийн өнцөг буланд төрсөн амьтад Тус бүрийг нь төрсөн газар нь хүргэж өгөх хэрэгтэй Бид энэ яваа богино насандаа ийм холын аян хийж амжина гэж бодож байна. уу ? ийм богино насыг амьдрал ба үхлийг бий болгосон тэр нэгэн л тогтоогоо шүү дээ Тэр бол гагц хүү эрхэм а ри ун чанартангүүд хүрмасгын алдар нэрийн төлөө үүрийн туяа мэт жавхланта ахан дүүсийнхээ хамт халин нисэж байдаг тэнд ч дүүлэн нисэх заяатай байсан тийм ариун гэмгүй агсан тэр бурхны дүрийг бузарлан бишдүүлсэн, хэзээд үл биелэх ами а бодсон хар муу сана а зүрхэнд нь үүрлэсэн, хорон санаа, атаархлаараа муу үйлд үеийн үед дийлдэшгүй татагдсан, хүн төрөлхтний хамгийн атаат дайсан, могойн хаан чөтгөрт уруу татагдсан эмэгтэй найзынхаа ятгалгад орж нүгэл үйлдсэн Адамыг бий болгосон нэгэн болой

- Ай бүү үзэгд

- Бурхан минь

- Бид хоёрт ийм сунжирсан юм. ярьж байх зав зай үгүйг чи мэдэж байгаа шүү дээ Тарааж өгч амжихгүй гэж ийнхүү хоосон бясалгасаар байтал тарааж амжихуйц цаг алдагдаж байна. дэмий чалчихын оронд юм. хийх хэрэгтэй амаа тат, салхин тээрмээ зогсоо, одоо чалчаа үгэнд зарах цаг алга Бага ярьж их хийе Эднийг хэн г эр гэрт нь тараах вэ?

- Найз нөхөд нь замбуулингийн өнцөг булан бүрээс ирнэ биз Энэ мэдээ цэлмэг тэнгэрт аянга ниргэх шиг боллоо Энэ мэдээ хо ригдол хүн өршөөлийн сур аг сонсох шиг амттай юм боллоо Сэнди, тэднийгээ өөрийн гараар тарааж өгөх гэж эндээ үлдэх бизээ

- за тэгвэл Сэнди минь , ийм л байна. Даалгасан ажлыг нь бид эсэн мэнд туйлд нь хүргэлээ тэгэхлээр би хаан дээр очиж илтгэхээр явах ёстой байна. Тэгвэл хэн нэг нь

- би бэлэн Тантай хамт явна ийнхүү өршөөлөө хү чингүй болгох нь тэр юу надтай хамт явна? Яах юм. бэ?

- Та намайг эрэлхэг дайчин эрээсээ урвах хүн гэж бодоо үгүй биз? Тэгж урвал миний нэр бүрмөсөн хугарах билээ. Тулалдааны талбар дээр таныг ямар нэг баатар эр дийлээд намайг булаан авч чадаагүй байхад ,, би танаас салах ёсгүй гэвч би тийм юм. болно. гэж бодсон байлаа. ч гэсэн буруутан болох билээ. би энэ амьтантай удаан хугацаанд зууралдах юм. байж гэвч үүнээс бага ч болов. ашиг тус олохыг л бодохооо өөр домгүй гэж дотроо бодлоо Тэгээд

- тийм бол одоохон явья гэв Сэнди язгуурт ан бүсгүйчүүлээс салахдаа эхэр татан цурхиран уйлж байлаа. би тэр гахайнуудыг нь зарц нарт даалган орхисон юм. Эдгээр язгууртан нарын байсан Тэр орныг арчиж цэвэрлээрэй гэж зарц нарт миний бие хэлсэн боловч тэднүүс чингэхийн хэрэггүй, нэгэнт тогтсон заншил ёсыг зөрчсөн хэрэг болно., уг хэл

гэргэцгаана гэв тогтсон заншлы баримталдаг байх нь гагцхүү тиймэрхүү юм.наас бус бүхий л гэмт хэр гийг энэ үндэстэн үйлдэх чадалтай байжээ. Бид эрт евраан цагаас дагаж ирсэн заншлаа баримтална гэж зарц нар хэлээд уг байшингийн шалыг шинэ хулсаар хулдаж язгууртан авгайчуул хэмээх мэгж гахайнуудын үлдээсэн мөрийг хадгал а н хайрл а на гэлээ. Байга л ийг хорсголонтойгоор дооглон дайрах шиг л юм. болох нь тэр арга нь Тэр бүлийн түүхийг үечлэн хадгалах шинж лэх ухаан газар судлалын ухаан байлаа. хожим арх е логчид газар малтаж байгаад тиймэрхүү давхарга олох доо Тэр бүлийн хоол ундны байдал олон зуун жилийн турш хэрхэн хувирч ирснийг тодорхойлон тогтоох бололцоотой юм. Бид тэндээс дөнгөж хөдөлмөгцөө баахан мөргөлчинтэй тааралдсан билээ. Бидний явах зам мөргөлчди йх энтэй таарахгүй байсан боловч хамт явлаа, яагаад гэвэл хэрэв энэ орныг мэргэн удирдья гэж хүсвэл Тэр орныг хүний үгээр биш, харин өөрийнхөө биеэр судлах нь чухал гэдгийг миний бие улам бүр ойлгож байсан юм. Тэр олон мөргөлчний цуваа Чосерын дүрслэн бичсэнтэй тун ойролцоо санагдаж билээ. энд тэр үеийн Английн бүхий л мэргэжил боловсрол, зүйл бүрийн хувцас хүнартай хүмүүс оролцсон байдаг залуухогшин эрчүүл, залуухөгшин эмэгтэйчүүл, сэргэлэн золбоотой хүмүүс, гуниг зовлонд дарагдсан хүмүүс бүгд байсан гэдэг зарим нь морь илжигтэй явж байхад эмэгтэй хү ний ганц ч эмээл харагдсангүй, тийм эмээл Англид Түүнээс хойш ерэн жил болсон хойно л бий болж эхэлжээ Тэр мөргөлчид бол найрсаг зантай, сайн санаат а й, хүнд тусархаг олон байлаа. Сүжигтэй, аз жаргалтай, цовоо сэргэлэн, хамаа намаагүй байж гэм халгүй байдал гаргах нь харагдана Тэдний зугаатай сонин гэж үздэг үлгэр яриа нь үргэлж ам ам дамжин яригдах бөгөөд ичиж зовмоор талтай байх нь английн шилдэг давхаргын хүмүүс арван хоёр зуун жил өнгөрсөн хойно л ичиж зовдог болсон тиймэрхүү юм. байлаа. Арван өсдүгээр зууны эхний хорин таван жилийн үеийн Английн цэцэн цэлмэг ухаантны ухаан хүрэх тийм марзан инээдтэй юм. бие биендээ ярьж инээлдэж байлаа. заримынх нь ярьсан сонин марзан үг бүгдийн чихэнд хүрч тэр цувсан олон хүний хамгийн сүүлд яшаа нь хүртэл сонсоод инээд а лдан пар хийж байгаа нь үнэхээр онин марзны гэрч болохыг, ялангуяа луусны нүүрэнд ичгүүрийн туяа гэрэлтэхэд нь бүр сайн мэдэж болох юм. Сэнди тэдний хааш явж байгааг мэдэх учр аа с над ад тэр д а руй хэлж өгсөн билээ.

- Эднүүс Ариуны хөндийд очиж д а янч лам нараас өрөөл аач, аршаан а мса ад нүглээ уг аах гэж ява а улс гэлээ.

- Тэр рашаан нь х аан а байдаг юм.?

- энд э эс хоёр өдөржингийн зайтай, Элэнцэгийн ванлиг хэмээх нутагт байдаг юм даа

- Тэр раша ан ых а а тухай над ярьж аль, их л алдарт ай юм. биз дээ

- Алдартайгаар барах уу Хамгийн ал дартайгаас алд а ртай Эрт дээр цагт тэнд нэг ширээт лам хэдэн лам нарын хамт байжээ. Тэднээс ариун явдалтан энэ хорвоод байхгүй гэлцэнэ Тэднээс ариун судар судалж хэнтэй ч хоорондоо ч ярилцахгүй, гагцхүү өвс идэж, хатуу газ а р унт а ж, үргэлж мөргөл хийж, нүүр г а раа угаадагүй, хувцас хүнараа угаадагүй, хувцас нь элэгдсээр л аянда а мөрөнд нь тогтохгүй унаад өгдөг байж гэнэ Тэдний тийм ариун үйлийн т у хай энэ хорвоод тараагүй газар байсангүй Тэгээд баян хоосонгүй бүгд тэдэн дээр очиж тэднүүсийг ихэд хүндэлдэг болжээ.

- Цааш нь

- Ганц гал нь тэдэнд ус байсангүй Ширээт лам бурхнаас ус гуйхад бурхан ус бэлэглэж

тийнхүү бурхны хишгээр газар дороос хамгийн цэвэр тунгалаг ус гарчээ гэтэл зориг муутай лам нар шуламсын муу сана анд автан ширээт ламд амар заяа үзүүлэхгүй үргэлж усанд орох газар байгуулья хэмээн гуйхад сүүл сүүлдээ Ширээт лам бүр залхаж тэдэнтэй маргахаа больж та нарынхаар болог доо хэмээн зөвшөөрсөн байлаа. Бүрханд таалагдах а риуныг эвдэж хар ертөнцөд таалагдах ариуны төлөө хөөцөлдөх гэгч юу болохыг та одоо мэдэх болно. Лам нар усанд оооод цас шиг цагаан, цэвэрхэн болж гарч ирэхэд бурхан тэр даруй өөрийн тавлаагүйг мэдэгдэн тэднүүсийг залхаажээ Бурхны хишиг болгон оргилуулсан ус гомдоод гарч ирэхээ больжээ Булаг нь ийнхүү ширгэжээ, Тийнэрхүү г эмт хэргийг энэ оронд хэрхэн үздэг жмшаад тун ч гайгүйн г р ч дээ, Сэнди, Магадгүй, гэхдээ тэд н үүс анх удаа л нүгэл хийсэн улс даа Лүүнээс өмнө тэд ямар я гэм нүгэл хийлгүй ёстой бурхан шиг ариун явсан улс хичнээн мөргөж залбираад, химнээн ч уйлж унжаад, хичнээн ч бие мах бодоо залхаан цээрлээд булгийн ус дахин гарсангүй Мөргөлийн вян хийж ч үзэж, зул барьж сан тавьж ч үзэж, ариун дагины дүрийн өмнө лаа барьж ч үзэж огт нэмэр болсонгүйд хотол бүгдээрээ бурхны цээр лэлд гайхаш баржээ

- Үйлдвэрийн энэ салбарт ч гэсэн санхүүгийн хямрал болж юмны үнэ доод цэгтээ хүртэл буугаад зогсож орхидог байх нь , цааш нь ярьдаа, Сэнди

- Нэг жил нэг өдөр өнгөрч байхад ширээт лам бүр цөхрөөд усанд угаадаг газры нь эвджээ Тэгтэл гэнэт бурхны уур хилэн тайтгарч булгийн ус бургилан гарч ирээд өнөөдрийн өдрийг хүртэл урссаар байгаа юм даа

- Тэгэхлээр тэр цагаас хойш тэр усанд ганц ч хүн ганц ч удаа ороогүй хирнээсээ салаагүй байж таарах нь ээ?

- түүнд орж биеэ угаах гэсэн хүн дороо хэдэн хэсэг болон хэрчигдэх билээ.

- Тэр сүм тэр цагаас хойш мандсаар л байгаа юу ?

- Яг тэр өдрөөс хойш Гайхамшгийн тухай алдар цуу энд тэндгүй түгж тарсан юм. Газар бүрээс лам т цувдаг болж, загасны заарцаг шиг сүрэглэн ирэх болсон юм. Лам нарыг багтаан авах гэж тэр сүм хийд шинэ шинэ байшин барилга босгосоор байлаа. Гэлэнмаа нар ч олон иржээ Гэлэн, гэлэнмаа нар найрсгаар амьд а рд аг бейлаа Тэд хүч хөдөлмөрөө нэгтгэн зангидаж хоё р сүмийн яг завсар газар хаясан золбин хүүхдүүдийн төлөө сайхан сайхан байшин бар ьж ээ

- Сэнди, чи даяанч лам нарын тухай ярих гэсэн

- Даяанч нар дэлхийн өнцөг булан бүхнээс урсан ирсэн Мөргөлчин олон байгаа газар даяанч хүн хөлждөг Ариун Хөндийн даяанч нар тун янз бүр Ер бишийн даяанч олъё гэвэл Ариун Хөндийн нүх, агуй, шавар намгийг самнахад л олдоно, ер нь тийм ер би шийн даяанч нар алс холын улс оронд байдаг юм. гэнэ билээ. би нэг махлаг дугариг нүүртэй, нэлээд цовоолог эрийг бараадасхийн явахдаа түүнээр нарийн учрыг яриулах санаатай байсан юм. гэтэл дөнгөж яриа эхлэ в үү Үгүй юу урьд өмнө х Сагромор ноён надтай маргалдаад намайг халз үзэх тулалдаанд өдсөн тэр нэгэн өдөр Дайнадэн ноёны ярьсан ер бишийн марзан яриаг миний бодоход тун болхи үгээр ярьж эхлэхэд нь яс хавталзах шиг болж билээ. би уучлалт гуйгаад уг цувааны хамгийн сүүлд очлоо миний урам хугарч, а юул түгшүүр дүүрэн энэ амьдралаас, нус нулимс дүүрэн энэ зовлонгийн далайгаас зайлах, ядарг а антай тэмцэл,

байнгын дийлэгдэл ёозгүй хар үүл, салхи шуургаар дүүрэн тэр амар заяа ер үзүүлдэггүй богинохон наст амьдралыг төгсгөл болгохыг хүсэж билээ. гэвч мөнхийн чанар гэгч хичнээн урт удаан бөгөөд тэр марзан яриаг сонссон хичнээн олон хүн мөнхийн чанарт одсоныг бодохоос үхлээс айж байлаа. Үдээс хойхно бид бас нэг хэсэг мөргөлчдийг үйцэн очлоо, Харин тэднүүсийн дотор, настангуудын дотор ч, залуучуудын дотор ч тийм марзан шог яриа, элдэв шалдавын алиа шог юм. ярилцахгүй байв. гэтэл тэднүүс бол мөн хөгшин залуу янз бүрийн улс цал буурал өвгөд эмгэд, дунд зэргийн насны идэр булиа эр эмс, залуу эр эм, охид хөвгүүд, хөхүүл гурван хүүхэд харагдана хүүхдүүд нь ч инээмсэглэхгүй б үгд тавиад тооны юм байна. Бүгд л толгой унжуулсан явах бөгөөд н үүр царайд нь урт удаан хугацааны турш э нэ лж зовсон, цөхрөнгөө барсан итгэл найдвараа алдсан шинж харагдана Тэднүүс боол хүмүүс байжээ. Тэдний гар хөлийг г инжлэн суран бусэнд нь хүлсэн байна. Түүнээс гадна жижиг хүүхдээс бусды нь хооронд нь хүзүүгээр нь холбож уясан болохоор ТЭ р золгүй амьтад бие биенээсээ зургаа долоон алхмын зайтай явахаас аргагүй ажээ. Тэд ямагт явгаар гурван зуун бээр газрыг арван найман хоног явж байхдаа цадатлаа олигтой юм. идэж ууж байсан удаа ганц ч үгүй аж Шөнө болоход тэд гинжтэй хэвээрээ гахай шиг овооролдон нэг дор унтацгаана Тэдний хэдэрсэн навтсыг хувцас ч гэж нэрлэхийн аргагүй Хөлийнх нь шагай гинжинд үрэгдэн шалбарч идээлсэн ш а рханд нь ө т язганана Нүцгэн хөл нь энд тэндгүй шалбарч цус нөж болсон бөгөөд бүгд доголлон явна Анх гарахад зуу гаруй хүн байсан бол замда а худалдсаар одоо дундуур нь л үлджээ Боолын худалдаачин морь унаж боолчуудын хажуугаар олон салаа угт бүдүүн хуйв бүхий богинохон бариултай ташуур барьсан явна Ядарч шаналсандаа толгойгоо унжуулах боолчуудыг тэр суран ташуураараа мөр луу нь шавхуурдан ороолгож эгц харж яв гэнэ Тэр этгээд хэнтэй ч ярилцахгүй, түүний барьсан бүдүүн суран ташуур бодол зоргы нь ямар ч үгээс илүү тод илтгэх х эрэгсэл юм. Бид тэдний хажууд очиход нэг нь ч харах сөгөөгүй, хүн дэргэд нь ирж буй эсэхийг ч мэдэхгүй байх мэт үнэхээр хөөрхийлөлтэй харагдана Тэд огт д у у чимээгүй явах боловч тэр дөчин гурван боол хөлөө нэг зэрэг өргөхөд тэднийг туусад нь холбосон гинж хачин муухай ёозгүй чахарна . Бөөн тоос тэднийг булна Нүүр ам нь зузаан хир тоосонд дарагджээ хүнгүй өрөө тасалгаанд байсан зарим тавьц хэрэгсэл дээр л тийм зузаан тоос суусан байхад бид хуруугаараа дэмий юм. эрээчдэг байсан билээ. Хөхүүл хүүхдүүд нь үхэл, эрх чөлөө хоёуланд их ойртож очсон тийм залуу эхчүүлийн хацар дээрх нулимсны ороор, тэдний зүрх сэтгэлээрээ тийм тод бичсэн бичгээр би энэ тухай нэхэн санаж байна. Тэр залуу эхсийн нэг нь бүр өөрөө хүүхэд шиг жижиг хүүхэн атал түүний хацар дээр харагдах тийм бичгийг харахаас элэг эмтэрч билээ. Түүний нулимс бол амьдралын сайхан өглөөг ямар ч зовлон зүдүүргүй үзэж жаргах ёстой түүний хүүхдийн нулимс юм. Тэр эмэгтэйн бүдрэхэд суран ташуурын бүдүүн хуйв нүцгэн мөрөөр нь ороолгож хэсэг арьс үсий нь хуу татлаа Түүнийг биш намайг л ороолгоод авах адил миний бие хгртхийн ихэд цочив Боолын худалдаачид боолчуудыг бүгдий нь зогс гээд мориосоо буулаа Энэ муу хүүхэн залхуу хо йргодоо намайг тамлаж байна. хэмээн тэр яргачин өндөр дуугаар хараал тавин загнаж өнөөдөр сүүлчийн өдөр миний асралд буй учраас одоо би үүнтэй тооцоогоо хийнэ гэж байна. хүүхэн сөхрөн унаж гар сарвайлган өршөөл гуйж цурхиран уйлах боловч цаадхи нь огт үл тоож хүүхдий нь булаан авах мөртлөө ойр гинжтэй байгаа боол эрчүүлийг энэ хүүхнийг дарж унагаад шалдалж бай хэмээн тушаагаад өөрөө түүний шалдан нурууг суран ташуураар шавхуурдаж г а рлаа цаад хи нь өрөвдөлтэйгээр орилон чарл ан сарвалзаж байна. Эмэгтэйг барьж байсан нэг эр хүн нүд хальтран буруу харахад хүүхнийг өрөвдлөө хэмээн өөрий нь загнан ташуурдав . Мөргөлчид харан зогсохдоо боолын худалдаачин ташуураа хэр зэрэг сайн эзэмшиж буй эсэхийг шүүн ярилцах ажээ. Б ү х

насандaa боолын ёсыг үзэж амсаж ирсэн болохоор тэднүүст хүнийг тамлан тарчлаах явдлыг өөр ө ер үнэлэх ухаан чадалгүй болж зүрх нь чулуу шиг болсон байна. Мөргөлчин хүмүүс бол сайн санаат улс байдаг учраас морь адгуусыг ч энэ мэтээр зодож жанчихыг үл тэвчих атлаа хүний сэтгэл ингэтлээ чулуу шиг болно. гэдэг бол боолт ёсны уршиг юм даа би тийнхүү хүн тамлах явдлыг зогсоож боолчуудыг чөлөөлөн тавиасай гэж хүсэвч тэгэхийн хэрэггүй байсан юм. Хууль дүрэм зөрчиж иргэдийн эрх дархад халааг хүн гэсэн нэр зүүчихгүйн тулд бусдын хэрэгт хөндлөнгөөс дэндүү олон удаа орох хэрэггүй байлаа. хэрэв би амьд мэнд, эрх мэдэлтэй байх юм. бол боолын ёсыг цаазаар авах хүн гэж дотроо тангараг тавьсан би боолт ёсны зандалчин нь болно., тэгэхдээ ард түмний хүсэл зоригийн дагуул тийм зандалчин болохыг хүсэж байлаа. замын хажууд нэг дархны газар байлаа. Тэндээс хэдэн бээрийн тэргээд тэр залуу эмэгтэйг худалдан авсан газрын эзэн хүн түүний гинжийг салгах гэж боолчуудын цувааг хүлээн зогсоно Гинжий нь салгасны дараа төмрийн дарханд хөлсий нь хэн төлөх тухайд худалдагч, худалдан авагч хоёр маргаж гарлаа Гинжий нь сулламагц нөгөө хүүхэн өөрий нь зодож байхад нүд хальтран цааш харж байсан залуу эр рүү гүйн очиж цурхиран уйлахад цаадхи нь элгэндээ наач тэвэрч хүүхэд эх хоёрын нулимс болсон нүүрийг үнсэж өөрийнхөө нулимсаар угааж байна. Би таамаглаж асуувал тэр хоёр бол ханилсан эр эм ажээ. гэтэл тэр хоёрыг хүчээр салган бүсгүйг нь аваад явахад зам мурийн далдран далдартлаа галзуу мэт орилж хашгиран тэмцсээр байсан бөгөөд далд орсон хойноо ч тэмцэлдэн байгаа чимээ гарч байсан билээ. Эхнэр хүүхэд хоёроосоо үүрд хагацаж байгаа тэр эр хүн яасан бэ гэвэл би түүнийг харахаас нүд хальтран хараагаа буруулсан боловч тийм юм. миний зүрх сэтгэлээс хэзээ ч салахгүй гэдгийг би мэдэж байсан л даа Одоо ч гэсэн миний нүдний өмнө ил мэт харагдах бөгөөд түүнийг нэхэн санах бүр элэг эмтэрдэг юм. "Бид хөдөөний зочид буудалд хоноод маргааш өглөө нь байшингийн довжоон дээр гарвал үүрийн шаргал туяад нэгэн морьтой хүн давхин айсуй харагдсан нь мнний баатар эрсийн нэг Озануль К ерАрди байхыг т ан ьсан билээ. Тэр бол эрэгтэйч ү үдийн аа р саар эдлэлийн талаар мэргэжсэн, ялангуяа хувин бортгын талаар мэргэжсэн хүн байсан, Өвч ган хуягтай явах бөгөөд түүний хуяг дуулга тэр үедээ туйлын сайханд орж байсан боловч гагцхүү мань хүн дуулга өмсөхийн оронд салмайсан бортого өмсөх тул энэ хорвоо дээр хосгүй хачин хол ьж хутгасан юм. болж байлаа. миний цаад нууц санаа гэвэл дайчим эрсийг инээд хүрмээр олигүй харагдуулж байгаад тэдний нөлөөг султгах бодол байсан юм. Озан ноёны эмээл дээрээс нэхий бүрх малгайны хайрцаг дүүжлээстэй байдаг нь мань хүн Ямар нэг дайчин эрийг дийлэхтэйгээ зэрэг түүнийг миний албанд орохыг тушаан толгойд нь бортого өмсгөдөг байж би хувцас хүнараа өмсөөд түүнд баяр хүргэн сонин сайхан сонсох хэмээн угтан гүйлээ

- Худалдааны ажил амжилттай юу ? гэж асуулаа,

- Дөрөвхөн хайрцаг л үлдсэн Намайг Камелотоос анх гарахад арван зургаан хайрцаг байсан шүү дээ,

- Озан ноён та алдар гавьяа байгуулсан байна. Та хаагуур хаагуур аялан явав аа? би сая Ариун Хөндийгөөс дөнгөж ирлээ, ноён тон минь

- би өөрөө тэ нд чинь явж байна шүү дээ Лам нар нь яаж байна. Түүгээр сонин сайхан юу тай байна.

- Өө, асуух юу байх вэ хүүе жаал аа энэ морийг барьж бай, толгойндоо хайртай бол бушуул Жүчээнд оруулаад тушаасан ёсоор Ноёнтон, би танд тун гунигтай мэдээ сонсох

болжээ. Аа, энд мөргөлчид яваа юм. байж Сайн санаат хүмүүс ээ миний үгийг сонсогтун миний сонсох сонин та нарыг гонсойлгох болно., яагаад гэвэл та нар эрж хайж буй юмаа олохоос өнгөрсөн шүү Эрээд дэмий, худал хэлсэн байдаг бол толгойгоо авахуулахад бэлэн байна. хоёр зуун жилийн дотор огт то хиолдоогүй тийм юм. тохиолдсон байна. хоёр зуун жилийн омо Ариун Хөндийд дээд бурхны соёрхлоор бүгдэд ил, ойлгомжтой шалтгаанаар үүссэн бол харин одоогийнх нь ,

- Гайхамшигт булаг нь ширгэсэн байх нь гэ хэд хорин б аг алзуур нэг зэрэг дуу алдав

- Сайн санаат хүмүүс та нар миний хэлэх гэж байсан юмыг өөрснөө хэлчихлээ шүү дээ

- Бас нэг нь усанд нь биеэ угаачихсан хэрэг үү? зарим нь ийм гэж бодох боловч ихэнх нь Итгэхгүй байна., Өөр л нэг гэм нүгэл болсон бололтой гэх боловч чухам юу болохы нь хэн ч мэдэхгүй байна.

- Тэгээд лам нар тэр гал лан чи гаа яаж эдэлж байна. даа?

- Үгээр хэлэхэд үг дутаж байна. Булаг хатсаар есөн хоног болжээ. Тэд ноорхой цоорхой хувцас өмсөж, толгой түрүүгээ үнсээр булчихаад духаа цоортол мөргөн, амаа зууртал гүрэм ном уншин хөлөө ядөртал холхин мөргөл хийж өдөр шөнийг ялгахгүй залбирсаар эр, эм лам нар золбин хүүхдүүд нь туйлдаа хүртэл ядарч дуу хо олой нь гарахыг больчихлоор мөргөлийнхөө үгийг илгэн дээр биччихээд газар газраас өлгөсөн байна. Тэгээд бүр аргаа бараад Эзэн таныг ирж ид шидээ гарган үзэхгүй юу хэмээн намайг явуулав, хэрэв таныг эс зөвшөөрвөл Мерлинийг зална гэж элч зарсан бөгөөд Мерлин тэнд гурван хоногийн урд очоод ямар ч болтугай устай болгож өгнө, үүний тулд дэлхийн бүх хөрсийг эргүүлж улс орон бүрийг сүйдэлж хөрб өр үүлэхэд ч бэлэн байна. гэж хэлжээ Тэгээд чармайн тарнидаж ад чөтгөрийн хамаг хүчийг ч урин дуудаж туслуулан үүрийн гэгээнээс үүрийн гэгээ хүртэл хар хөлсөө то рх торхоор гоожуулан зүтгэвч зэс тавган дээр амьсгалын уур тогтохын чинээ ч чийг нойтон хий гарч өгөхгүй байна., хэрэв та Бидэнд өглөөний хоол цай өглөө, хоол унд идэж уусны дараа би Озан ноёнд түүний бортгон малгайн дотор талд бичсэн үгийг харуулав Химийн хэлтэлс, шинжилгээний тасаг, Рххр секц Хамгийн томхоёр № 3 ба № 6г чухал бүх эд ангийнх нь хамт түүнчлэн миний туршлагатай хоёр туслагчийг илгээсүгэй

- Одоо, эрэлхэг дайчин эр чи Камелот руу давхиж хүрээд энэ бичгийг Кларенсэд үзүүлж энд дурдсан бүх зүйлийг аль болох хурднаар Ариун Хөндийд ирүүл гэж хэл гэлээ. —Эзэн ноёнтон минь ёсоор биелүүлье гээд давхин одлоо

Хорин хоёрдугаар бүлэг

АРИУН БУЛАГ

Мөргөлчид бол хүмүүс юм. Тэд хүмүүс биш байсан сан бол өөрөөр аашлах байсан бизээ Тэд урт удаан хугацаанд хүнд бэрх зам туулж бараг дуусаад зорьсон юм.андаа тулаад иртэл зорьсон нь нэгэнт байхгүй болсныг гэнэт мэдмэгц бушуухан буцаж ямар нэг хэрэгтэй юм.өөр оролдох гэсэнгүй, тэд адуу мал юм. уу , муур мий юм. уу ө т хорхой адил ааш гаргасангүй . Тэд урд нь гайхамшигт булгийг үзэх гэж шүлэнгэдэж байсан бол одоо тийм булаг байсан газрыг хэрхэн олж харах билээ. хэмээн дөч дахин илүү шүлэнгэдэцгээж байлаа. хүний зан араншин гэж үнэхээр тайлагдашгүй оньсого шиг хачин ч юм. аа даа Бид бушуухан ахиж явлаа Нар шингэхээс хоёр цагийн өмнө бид Ариун Хөндийг тойрсон уул толгодын өндөрт хүрч

түүний үзэсгэлэнт газруудыг сонирхон харж байлаа. Түүний гурван гол барилгыг л хэлж байгаа юм шүү дээ Тэр нүд алдам талын дунд бүртийх барилгууд нь тоглоомын байшин шиг тун ч хэврэг мэт харагдана чимээ аниргүй, хөдөлгөөнгүй үхэл мэт тийм юмыг харахад бидэнд тун уйтгартай байдаг билээ. Алсын салхинд тийм чимээ аниргүй дүнсгэр байдал алдагдавч уг байдал улам ч уйтгартай болов. тэр чимээрхүү юм нь бидний чихэнд дуулдана уу үгүй юу гэмээр тун бядгүй оршуулгын цувааны гунигт дуу байсан тул улам уйтгартай болгосон юм даа Цагаан гэгээ тасраагүй байхад бид эрчүүдийн сүмд хүрч очлоо Эрчүүлийг нь тэнд нь үлдээгээд эмэгтэйчүүдийг нь эмэгтэйчүүдийн сүм үрүү нь явуулав Сүмийн жүн хонхууд ойр байсан болохоор тэдгээрийн дуу чимээ нь аймшигт тамын шүүхийн хонх мэт санагдах ажээ. Лам нар зүрх шимшрэн цөхрөнгөө барж буй нь тэдний туйлдаж ядарсан нүүр царайд нь тодхон аж Тэд хар орхимж нөмөрч, зөөлөн шаахай углаад лавай шиг царайлан дуу чимээтэй нь аргагүй байн байн эргэлдэж алга болж байгаагийн нь ажвал хар дарахад үзэгддэг дүр мэт санагданд өвгөн ширээт лам намайг их баяртай угтлаа, Нүүдэн нь нулимс гүйлгэнэх боловч унагалгүй тэвчлэн барьж байв. Тэгээд хэлэх нь

- хүү минь , удах хэрэггүй, аврах ажилдаа орж үз Хамгийн ахар богино хугацаанд устай болохгүй бол бид сөнөж, хоёр зуун жилийн турш ариун хөдөлмөрөөрөө бүтээсэн эүйлс маань ч мөхнө. Сүм бол өөртөө ашиг тустай байлаа. ч гэсэн чөтгөр шуламсын ид шидийг тэвчдэггүй учраас чиний ид шид ариун байх ёстойг хичээг түн гэлээ. миний ид шид рид хуйлгаанд чөтгөр шуламс ямар ч хамаагүй байдаг юм. шүү, эцэг ламтан минь би чөтгөр шулмын ямар ч ид шид хэрэглэхгүй, харин гагцхүү бурхны гараар бүтсэн эд юмсыг л ашиглах болно. . Мерлин мөн тийм ариун аргаар үйлдэг гэж та итгэдэг үү?

- Итгэдэг Бузар хүчний тус авахгүй гэж надад ам тангаргаа өгсөн

- Тэгвэл тэр чинь хийдгээ хийж л байг

- гэвч чи эүгээр суулгүй, түүнд туслалцах юм. байгаа биз дээ?

- Эцэг ламтан минь , тийм их ялгаатай аргыг хооронд нь холбож хутгаж болохгүй Түүнээс гадна энэ чинь мэргэжлийн ёс зүйг зөрчсөн хэрэг болох билээ. Нэг мэргэжлээр ажилл ад аг хоёр хүн нэг нэгэндээ саад тотгор болох ёсгүй Бид хоёрын алинд ч хийх гүйцэтгэх ажил мундахгүй, харин хэн нь илүү гэдэг нь хэзээ нэг цагт аяндаа мэдэгдэх биз Та Мерлинийг бэлтгүүлсэн байна. Түүнийг өөрийг нь больё гэхээс нааш өөр ганц ч хүн хэрэгт нь хөндлөнгөөс оролцох ёсгүй

- гэвч би түүнийг тууж явуулна Туйлын чухал үйл сийн төлөө би түүнийг хөөж явуулах эрхтэй билээ. тийм эрхгүй байлаа. ч гэсэн хэн шашин сүмд хууль зүй тогтоохыг зориглох вэ, тийм зүрхтэй хүн хаа байх вэ? Сүм шашин бусдад хууль зүйг өөрөө тогтоож өгдөг, тэгэхлээр шашин сүмд юу хэрэгтэй бол түүнийг хийх л болно., ингэлээ гэж хэн ч гомдох эрхгүй би түүнийг хөөж явуулна, чи өөрөө ажилдаа хурдхан ор

- Эцэг ламтан минь ингэж болохгүй Хэн хүнтэй нь дуртайгаа хийж түүний өөдөөс цоролзох эрх хэнд ч байдагүй гэж таны хэлдэг зөв, гэвч зол муутай рид хувилгаант бид бол онцгой тусгай байдалд байдаг амьтад Мерлин, жижиг сажиг зүйлд рид хувилгаан сайнтай учраас орон нутагт алдар нэрийг олжээ Өөрийнхөө чадах ядахаар оролдож хийж чадах бүхнийгээ хийдэг хүн юм. тэгэхлээр өөрөөл үгүй больё гэхгүй юм. бол түүн ий ажлыг булаах нь тун эвгүй хэрэг Ширээт ламын нүүр царай туяараад ирлээ

- гэвч энэхэн зэргийг хийх юу байх вэ Болиулах арга олно доо

- Хэрэггүй, эцэг ламтан минь , дэмий, Та түүнийг х ү чээр болиулж орхивол цаадхи ч и нь ид шидээ хэрэглээд булгийг бүр бүтэлгүй болгочих в ол яана, Тэрний ид шидий нь олж нууцы нь тайлах гэсээр байт ал их цаг үрэгдэнэ Бүхэл сар ч болж мэднэ Надад ч г эс эн т е лэфон гэдэг нэртэй жаахан увидас байхад Мерлин түүний нууцыг олъё гэвэл лав нэг зуун жил хэрэгтэй болно. Тэр намайг бүхэл сараар саатуулж мэднэ, ийм ган гачигтай байхад та бүхэл бүтэн сар хүлээхийг тэвчих юм. гэж үү?

- Бүхэл сар гэнэ ээ Тэгж бодохоос ч хамаг бие минь чичирч байна. хүү минь , чинийхээр болог доо гэвч миний зүрх сэтгэлд нэг л их түгшүүр байгаад байх юм. Есөн хоногийн турш намайг тарчлааж буй зовлонгоо га н ца а р эдлэн үлдье дээ Энэ хооронд мин и й бие амар тайван байдал гэгчийг үэсэнгүй, т а район хэвэж байлаа. ч гэсэн зүрх сэтгэл минь амар үзэхгүй юм. Мерлин өөрийн нэр сүрийг бодож нэрэлхэлгүйгээр тэр ажлыг орхисон бол ухаалаг хэрэг болох байсан Яагаад гэвэл булгийн усыг яагаад ч ундрааж чадахгүй бөгөөд мань хүн бол тэр үеийнхээ жинхэнэ ид шидтэч байсан юм. энэ юу гэсэн үг вэ гэвэл түүний тэгж нэр олж мандсан нь аливаа гайхалтай юмыг бүтээлээ гэж заль мэх хэрэглэн хэнд ч үзэгдэлгүй үйлдсэн зүйл байсан юм. Тэр олон хүний нүдэн дээр булгийн ус г а ргаж чадахгүй байлаа. Нүд салгалгүй ширтэх олон түмэн гэдэг чинь миний үед сүнсийг гайхамшиг үйлдэхэд нь саад хийдэг байсан шигээ илбэчин хүнийг гайхамийг үйлдэхэд нь саад хийж байлаа. Тэдний дотор үл итгэх хүн хэзээд байдаг болохоор яг эгээгтэй үед гэрэл асаагаад л хамаг юм.ы нь баллаад хаячихна, гэвч би өөрөөл аргагүйд эс хүрэхээс өмнө Мерлин намайг оролдог гэхүйдээ гэж зовж байсан юм. Камелотоос хоёр гурван өдрийн дотор надад хэрэгтэй юм. авчирч өгөхөөс нааш би тэр ажлыг гардах боломжгүй байсан л даа Намайг ирснийг лам нар мэдэж санаа нь амарч тэр хоол ундгүй өнгөрсөн есөн хоногийн дотор анх удаа гайгүй сайн идэж уу жээ ходоодоо дүүрэхтэй зэрэг тэдний сэтгэл санаа нь сэргэж бал бурамтай аягыг жороолуулсныхаа дараа бүр ч сээмгэр болцгоожээ Улаан зээрд болсон эцэг ламтан нар таран явахыг үл хүсэж шөнөжин ширээний ард суун өнгөрлөө . Маш зугаатай байлаа. Хуучин цагийн үнэн худал нь төдий л ялгагдахгүй түүх домог ярьцгаан хөхрөлдөхөд лам нарын нүдний нулимс хацраа даган гоожиж, амаа алд дэлэм хэртэй анга й н инээхэд цүдгэр гүзээ гэдэс нь юүлхэс палхас хийлцэж байлаа., Ариун нандин чанартай эсэх нь сайн м э дэгдэхгүй дуу аялан дуулж багалзуур мэдэн хашгралдахад жингийн дууч дуулдахгүй болж байв. Сүүлд нь би жаахан юм. ярьж өгье гэж бодоод ярьсан чинь амжилт гэдэг асар их болов. Эхлээд л яримц хаанаас тийм болох вэ, Тэр орны хүмүүст инээдтэй юм. тийм амархан ойлгогдож тархинд буухгүй гэвч ярьсан юмаа тав дахин давгаж хэлэхийн үед хана доргиж эхэллээ дээ Бараг ч цав гарсан байх Найм дахь удаагаа ярихад энд тэндээс шавар нь унаж эхэлсэн Арван хоёр дахь удаагаа ярихад хэсэг хэсэг болон бутарч эхлээд арван тав дахь удаагаа ярихад хумхий тоос болон бут үсрэн замхарлаа Тэгэхлээр нь шүүр ава ад шүүрдэж орхисон би энэ мэтээр шилжсэн утгаар л ярьж байгаа юм шүү дээ Тэр арлын оршин суугч тэд уг нь хар гар дахийгаа барагтай бол тавьдагүй тун хар а мч амьтад тул хийсэн ажилд чинь г а р бар аг л цайлгахгүй, гэтэл сүүл сүүлдээ юмаа хайрлахы бол и од өгөөм ө р зан гаргасан чинь тэдний өгсөн юмыг бусадтай зүйрлэвээс тэр бусад гэдэг чинь гуйлгачин, хорголоо тоолсон харамч юм. шиг санагдахаар байлаа. Маргааш өглөө нь үүр дөнгөж гэгээрч байхад миний бие булгийн дэргэд очлоо Мерлин тэнд оччихсон минжийн дайтай зүтгэл гарган тарнидаж байх боловч чийг ч алга Түүний зан оёг тун муу байх бөгөөд намайг төдий л их туршлагагүй хүн иймэрхүү ажил амлан авах хэцүү байхдаа гэх бүрд мань хүн хэлэх үгээ

хянамжлахаа больж яг л Жонон Вангийн үеийн францын хамба лам шиг ярьж эхлэв Уг зүйл нь миний бодож байсанчлан байсан Үүнд тэр Булаг гэдэг нь ердийн аргаар лайдаж гаргаад ердийн чулуугаар хашсан зүгээр нэг худаг байлаа. түүнд ямөр ч гайхмаар юм. байсангүй Түүнийг алдаршуулсан худал үгэнд ч гайхмаар юм. байсангүй би ч гэсэн иймэрхүү худал юм. зохиоё гэвэл зохиож л орх и но Ядах цөхөх юм.гүй байлаа. Тэр худаг нь засаж янзлаагүй чулуугаар хийсэн сүмийн хонхны байрлах газрын тэг дунд хав харанхуй байранд байв. Тэр өчүүхэн өмгөр өрөөний хананд хүндэтгэн тахих зургууд өлгөсөн байх ба тэдгээр нь бол нийгмийн даатгалын зарлалд ч бараадахгүй тийм муухай зургууд юм. юу г дүрсэлсэн байна. вэ гэвэл булгийн рашаанаар гайхалтай анагаасан гэж хэний ч үзээгүй тийм юм. дүрсэлсэн байна. Ангөл бурхдаас өөр хэн ч үзээгүй юм. гэнэ, ангөл бурхад л гал хамшигт юм. болоход усан онгоцын дарвуул дээр гарахдаа зурганд орох гэж л тэгдэг бололтой юм. гэтэл тэднүүс үүнийг гал хамаандынхнаас дутахгүй шохоорхон сонирхдог юм. Хуучин зураачдын урласан хоргүү дээр шалгаж болох юм шүү Худгийн байгаа хонхны тэрхүү өрөөнд зулын бүдэг гэрэл сүүмэлээнэ Ус гарч байхад нь лам нар урт оосортой хувингаар татаад нарийхан гууга а р дамжуулагч гадаахи санд оруулдаг байж Худаг нь байдаг тэр өмгөр өрөөнд лам нараас бус өөр хэнийг ч шагайлгадагүй байж гэвч миний бие мэргэж и л нэгт нөхөр бөгөөд мэдлийнхээ хүний соёрхсоноор түүнд нь орсон юм. Тэр маань ажилдаа гагцхүү тарнийн арга хэрэглэхээс биш тархи толгойгоо хэрэглэнэ гэж байхгүй Тэр муу өрөөнд ороод тэртэй тэргүй тамтагүй муу тархиа бясалган зовоохын оронд нүдээрээ сайн харсан бол зүгээр засчих арга олоод дараа нь түүнийгээ ердийнхөө зуршлаар гайхамшигийг үйлдлээ хэмээн зарласан бол болох л байсан гэтэл тэр бол маанаг өгөр байсан бөгөөд өөрөө ч рид хувилгаандаа итгэдэг байсан болохоор тийм мухар сүсэгтэй ид шидтэн гэгч бол хэзээ ч амжилт олдогүй билээ. Ёроолын хэдэн чулуу нурж ус нь өөр т ийш явчаад л гарч өгөхөө больсон байх гэж би бодоод оосрынх нь уртыг хэмжиж үзлээ Урт нь ерэн найман фут байв. Дараа нь хоёр лам дуудаж үүдий нь цоожлов Тэгээд гартаа лаа бариад ховоогоор нь доош буулаа ховооны оосор ч сунаж гүйцэж байна. миний бодож байсан таамаг маань ч зө в нь мэдэгдлээ Хананых нь нэлээд хэсэг нурж том ан цав гаргасан байлаа. Таавар маань яг нотлогдсонд нь харуусах шиг болж билээ. Яагаад гэвэл уг нь гайхамшиг гэж харуулахад арай өөр зүйл байсан болоосой гэж бодсон юм. Америкт олон зуун жил өнгөрсөн хойно н е фтний худаг бөглөрөхөд тэсэрдэг бодисоор тэсэлдэг байсан арга миний санаанд орж ирсэн, Хэрэв тэр худаг харахад ил шалтгаангүйгээр хагчихсан байсан бол нэг үнэ цэнэ нь өнгөрсөн хүнээр тэсэрдэг бөмбөг хаяулж орхих байлаа л даа Тэгээ жигтэйхэн их гайхуулж чадах байсан юм. Түүний тулд Мерлинийг ашиглах юм шүү гэсэн бодол түр төрөөд байсан юм. гэвч одоо бөмбөг хаях хэрэгцээгүй болсныг нэгэнт мэдлээ Нөхцөл байдал тэр болгон бидний хүссэнээр болох нь үгүй билээ. Ажил хэрэгч хүн тиймэрхүү байдалд гонсойлгүйгээр зорьсондоо хүрэх арга замаа л бодох хэрэгтэй байдаг би ч тэглээ Яарах хэрэггүй, жаахан хүлээж болно., бөмбөг тэслэх ээлж ч гарч болно. гэж бодлоо Үнэхээр тийм цаг ирсэн юм. Худгаас татаж гаргуулсан хойноо би лам нарыг хөөн гаргаж худаг уруу загасны тор буулгалаа Худгийн гүн нь зуун тавин фут, одоо усных нь түвшин дөчин нэгэн фут байлаа. би нэг ламыг дуудаад

- Худгийн гүнийг мэдэх үү? гэхэд

- Бүү мэд, ноёнтон минь , надад хэн ч хэлж өгөөгүй

- Усных нь түвшин хэдэд байдаг байсан юм.?

- Энэ хоёр зуугаад жилийн турш ус нь бараг бялхаж байсан Манайхны эцэг өвгөдөөс

уламжилж ирсэн домогт л тэгж байдаг юм. Овоо итгэж болмоор маягтай хэд хэдэн гэрчийн этгээд түүний үгийн үнэн болохыг нотлов оосорных нь хорь, гучин фут нь усанд дүрэгдэж байсан ул мөртэй байна. Бусад хэсэг нь худагт хэзээ ч ороогүй зэвэрч хортонтсон байлаа. Урьд нэг удаа ус нь яаж алга болоод ямар аргаар дахин бий болсон юм. бэ? Ямар нэг ажил төрөлч хүн худагт орж нү х сүвий нь таглаад гарч ирэхдээ усанд ордог газраа устга гэж ширээт ламд хэлсэн байж таарна . Одоо бас л нүх сүв гараад ус нь алга болоход энэ тэнэг амьтад мөргөл үйлдэж мунгинан хонх дэлдсээр өөрснөө хатаад дөрвөн зүгийн салхинд замхран алга болох байсан байна. загасны тор оруулж үзэх юм. уу , аль нэг нь доош буугаад юу болсны нь мэдэх тийм ухаан эднүүсийн нэгнийх нь ч тархинд орж ирсэнгүй . Нэгэнт шингэсэн заншлыг ховх татан арилгах шиг хэцүү юм. энэ хорвоод үгүй билээ. тийм заншил бол нүүр царайн шинж тэмдэг адилаар үеэс үед дамжи н уламжилдаг зүйл Хэрэв тэр үеийн хүний толгойд өвөг дээдсийн үеийнхнээс нь өөр бодол орж ирэх юм. бол тийм хүнийг лав хоноцын хүүхэд байж таарах нь гэж боддог байжээ.

- Мэргэжил нэгтэй эрхэм Мерлин бүтэлгүй болох дээр хүрвэл худагт усы нь эргүүлж ирүүлэх хэцүү гайхамшгийг үйлдэн бүтээхийг л оролдохоос өөр домгүй болох нь ээ Мерлин түнш маань тун авьяаслаг увидасч, гэхдээ мэргэшил нь өрөө тасалгааны илбэ болохоор ийм ажилд амжилт олж чадахгүй байж мэднэ, ер нь бараг л бүтэлтэй юм. болохгүй байхаа даа гэвч тиймэрхүү юм.наас ичих хэрэг юу байх билээ. тиймэрхүү юм. бүтээж чаддаг хүн чинь зочид буудал нээж чадах шүү дээ гэж би тэр ламд хэллээ

- Зочид буудал гэж юу вэ? Ер дуулаагүй юм. байх чинь

- Зочид буудлын тухай юу ? Та нарын буурчийн газар гэж нэрлэдэг юмыг л хэлж байхгүй юу Тэр зэргийн гайхамшгийг бүтээж чадах хүн буурчийн газрын учрыг ч олж чадна Энэ бол миний хүчин үл мөхөстөх илбэ жилбийн зүйл гэвч танаас нуух юу байх вэ, э н э зэргийн рид хувилгаан үзүүлэхийн тулд би хамаг чадал тэнхээгээ дайчилдаг юм.

- Тэгэлгүй яах вэ Мангй сүм хийдийнхэн л мэдэхгүй бол өөр хэн мэдэх юм. уламжилж ирсэн домгоос сонсоход тэр удаад худгийг устай болгох гэж зуун жилийн хугацаа хэрэглэсэн юм. гэнэ билээ. тийм л хэцүү байдаг байна. Ямар ч байлаа. гэсэн бид бурхандаа залбирч таны үйл бүтэлтэй болоосой хэмээн залбирах болно. тиймэрхүү гайхамшгийг бүтээхэд тун амаргүй гэсэн цуурхал тарах нь ажил хэргийн эрх ашгийн үүднээс оновчтой чухал санаа болсон юм. заримдаа тун ялих гүй юм. зарлал магтаалын ачаар сүрхий чухал ач холбогдолтой болдог билээ. Тэр лам миний үйлдэх ажлын хэцүүд гайхшаа баран итгэсэн болохоор бусдыг ч бас тийм болгоно доо хоёр өдөр өнгөрөхөд хүмүүс хотлоороо миний төлөө за лбирах болно. их үдэд би буцаж ирээд Сэндитэй уулзлаа, Даяанч нартай дөнгөж саяхан тааралдсан байж

- би тэдэнтэй чинь биеэрээ уулзах юмсан Өнөөдөр Лхагва гариг Өглөө тэд жүжигтэй байдаг уу ? гэж би асуулаа, — уучлаарай ноёнтон, та юу г энээ?

- Өглөөний жүжиг Өдөр онгорхой байдаг юм. уу ?

- Хэний?

- Даяанч нарынх байлгүй яах вэ?

- Онгорхой ?

- тийм ээ, онгорхой байдаг уу ? юугий нь ойлгож ядаад байсан юм.? Үдэд хаачихдаг юм. уу ?

- Хаачихдаг ы?

- тийм ээ, хаачихдаг юм. уу ? юугий нь ойлгож ядаад байсан юм. бэ? юу ч хэлсэн ойлгодоггүй ийм тэнэг малыг би хэзээ ч үзээгүй Тэд чинь мухлагаа хэзээ хаадаг юм. гэж би чамаас хамгийн энгийн үгээр асууж байна. Хэдийд тэд чинь тоглоомоо дуусгадаг юм. бэ? хэзээ гэрлээ у н траадаг юм. бэ? Мухлагаа хаадаг, дуусгадаг

- за за боль яасан тойвтой юм. чи хамгийн амархан юм. ойлгохгүй байна.

- би таны таалалд нийцэж байвал туйлын их баярлахсан, гэтэл би даанч тэгж чаддагүйдээ гомдон гонсойж байдаг юм. гэвч би бол эгэл нэг охин болохоор надад хэн ч эрдэм ном зааж өгөөгүй, хар нялхаас минь намайг эрдмийн их далайн усанд дүрээгүй юм. гэтэл тийм усанд хамгийн ариун өлзийг нууцыг мэдэх тавилантай бөгөөд номхон дорой, жирийн үхэлт хүмүүсийн бишрэн харах тийм хүмүүсийг угаадаг ажээ. тийм ухаантангууд бол эгэл хүмүүсийн эргүү мунхаг учрыг ойлгон мэдэхдээ тэд нар бол мөн л эргүү тэнэгийн дүр гэж бодоод хүмүүс нь гунихдаа хувцасны оронцог хэдэрч толгойгоо үнсээр булдаг гэх бөгөөд эргүү мунхгийн ухаан бодлыг хучин бүрхсэн харанхуйд гүн их нууцын биелэл болсон мухдаг хаах, тоглоомоо дуусгах, гэрэл унтраах гэх мэтийн үгс нэвтрэн ороход эргүү мунхгийн толгойд үл багтах ухаан билэг, хэл нь хэзээ ч хэлж үл чадах яруусайхан үг яриаг сонсоод атаархаж жөтөөрхөхөөс гагцхүү бурхны өрөвч сэтгэл хаацайлж буй бөгөөд эргүү мунхгийн ухаанд үүсэж буй холион бантан, тэдгээр мэргэн цэцэн үгийн учир хо лбогдлыг үл ухаарах энэ бүхэн нь тэдний нэрэлхүү зангаас болж буй хэрэг огт биш чин үнэнээсээ ойлгохгүй байгаа юм. тэгэхлээр та түүнийг өөрийн мэдээж бөгөөд хэзээ ч үл хувирах, сөгдөн бишрэхийн мөн чанар гэж бодохын тулд та миний болон миний ухаан бодлыг судалсан бол андахгүй бөгөөд би хүсэхгүйдээ биш чадахг ү йдээ л тэр ш үү дээ Нэгэнт чадахгүй хойно юу хийх билээ. хүсэл байгаад ч нэмэргүй, хүслээ ч гэсэн би бол мөрөөдлийг бүтээл болгож дийлэхгүй учраас сайн сэтгэлт, эрдэнэ мэт ноёнтон минь та намайг өршөөж миний бурууг уучилж өрөвч зүрхээрээ хэлтрүүлэхийг гуйя би түүний юу ярьж байгааг ойлгож чадахгүй байсан ч уг санаагий нь гадарлаж ихэд ичсэн Арван есдүгээр зууны үеийн т е хни к ийн үг яриаг зургадугаар зууны эргүү мунхаг охинд хэлэх мөртлөө дараа нь ойлгосонгүй гэж аашлах гэдэг бол нүгэлтэй хэрэг байлаа. Тэр охин миний үгийг ойлгох гэж хамаг ухаан бодлоо дайчилсан боловч ойлгож чадаагүй нь түүний буруу биш болохоор би уучлалт гуйсан юм. Бид хоёр одоо түрүүчээсээ илүү эв түнжинтэй боллоо гэж бодоод тайван ярилцсаар нөгөө аглагч нарын оршдог нүхэнд очихооо муриг сариг нарийхан зөрөг замаар явж байлаа. би тэр охиныг дотроо сүрхий тоож хүндлэх минь ихсэж байлаа. галт тэргээ нэг гайлаж аваад ярьсан үгсээ цувруулан чирсээр хязгааргүй тэв газрууд дамж и н давхих болгонд нь би чинь герман хэлтэлнүүдийн элэнц хуланцын аймшигт нүүр царайг үзэх мэт болдог байз заримдаа тиймэрхүү яриа дэлгэхэд нь би өөрийн эрх үй биширч дуулгаа аваад толгой нүцгэн зогсчихсон байдаг Хэрэв түүний үг нь ус байсан бол миний бие аль хэдүйн живээд алга болсон доо Ер нь яг л ге р манчууд шиг байдаг байлаа. асуусан юманд хариу өгөх, номлохдоо нэвгэрхий толь мэт бөгөөд дайн дажны тухай юм. уу , ер ярих болохоороо бүгдийг заавал ганц өгүүлбэр болгон хэлэх гэж үхэх гээд байдаг юм. Германы зохиолч нар бас тэгдэг нэг өгүүлбэртээ шумбаж эхэлсэн бол уу , тэр чинь өөрийнхөө Атлантын далайн нөгөө талд амандаа үйл үгээ зуусаар л гарч ирнэ бүр орой болтол бид аглагч аглагч дамжин явав Тэр бол

үнэхээр дээд зэргийн хачин гэхэд багадмаар адгуусны хороо байлаа. Даяанч нар балиар бохиороор хэнийгээ да ва х нь вэ, хэн нь ойр хавьдаа хорхой шавьж ихтэй байх вэ гэсэн өрсөлдөөнтэй байдаг мэт санагдсан Тэднийг ажвал биеэ ер бишийн их тоосон амьтад юм. Жишээ нь шавар шавхай дотор нүцгэ н хэвтэж хорхой шав ж инд зулгаалгадгаараа б а хархаж байхад бас нэг нь мөргөлчдийн нүдний өмнө хадан хясааны дэргэд өдөржин зогсож мөргөн өнгөрөөдөг гэх ба бас нэг нь чармай шалдалчихаад дөрвөн хөллөж явдаг, бас нэг нь олон жилийн турш биедээ наян пүү төмөр авч яваа хүн бас нэг нь бусад хүний адил унтдаггүй, харин туйвангийн дэргэд зогсоогоороо унтдаг бөгөөд мөргөлчид ирээд сонирхон харцгаахад нь хухирдаг гэж бахархан ярина Шалдан биеэ саарал үсээр л халхалсан нэг авгай ус уулгүй дөчин долоон жил болсны а чаар то лгойноосоо есгийгөө хү ртэл хав хар болжээ. Тэр хачин хүн тус бүрийн дэргэд мөргөлчид хүндлэн зогсож бурханлиг гавьяа зүтгэлээрээ тэнгэрт нэр нүүр олсонд нь атаархах мэт байна. Бид явсаар хамгийн мундаг аглагч дээр нь хүрч очлоо Тэр бол ер бишийн алдар цуутай, алдар нэр нь бүхий л христос мөргөлтөн ертөнц даяар түгсэн бөгөөд түүнд мөргөх гэж дэлхийн хамгийн алс орон газраас ихэс дээдэс, сурвалжит гэрийнхэн ирдэг ажээ. Тэр хүн уг хөндийн хамгийн өргөн хэсэгт нь суудаг боловч орчин тойрны зай нь хүнээр хэзээд пиг дүүрэн байх ажээ. Тэрбээр дээрээ өргөн талбайтай жаран футын өндөр багана дээр зогсож байна. Сүүлийн хорин жилийн турш хийж буй зүйлээ л хийж байлаа. тэр нь юу вэ гэвэл хөл рүүгээ эрс шуурхай бөхийснөө эргэн эгцэрнэ Тэгж мөргөдөг байж би цагаа харж байгаад тоолсон чинь мань хүн хорин дөрвөн минут дөчин зургаан секундйн дотор мянга хоёр зуун дөчин дөрвөн удаа тийнхүү мөргөх нь тэр тийм их хүч чадал дэмий үрэгдэж байгаа нь харамсмаар байлаа. Түүний хөдөлгөөн бол механикт ёстой эрдэнийн эх болох гишгүүр дараад байгаатай л адил шүү дээ хожим түүнийг зөөлөн бүсний тогтолцоонд тааруулан оёдлын машины дугуйг эргүүлдэг болгох бодолтойгоор тэмдэглэлийнхээ дэвтэрт бичиж авсан юм. даг Үнэхээр сүүлд нь тэгж төлөвлөснөө бие лүүлж чадсан бөгөөд тэр даяанч таван жилийн турш тун сайн ажилласан сан Энэ хугацаанд мань хүн өдөрт арван ширхгээр бодоход гэрээр нэхсэн зоточ даавуун цамц арван найман мянгыг оёсон юмдаг Түүнийг бүтэн сайнд ч ажиллуулдаг байсан Бүтэн сайнд бусад өдрөөс ялгаагүй их мөргөл хийдэг байсан хүний хүчийг тэгж хоосон гарздах хэрэггүй байлаа. Эд агуурсын бага сага зардлыг эс тооцвол тэр цамцнуудыг би бараг зүгээр хийлгэж байсан юм. Эд материалы нь ламаас гаргана гэвэл дэндэх тул би төлдөг байсан Манайх цамцаа нэгий нь бүтэн хагас доллараар мөргөлч дөд зардаг байсан бөгөөд бүтэн хагас доллараар Артур вангийн нутгаас тав арван үнээ буюу сайн үүлдрийн адуу авч болдог байв. тийм цамцыг аливаа нүглээс урьдчилан хамгаалах хэрэгсэл гэж үздэг байсан бөгөөд миний дайчин эрс тэдгээрийг будаг бичгээр чармайн зарлаж байсан учраас төдхөн бүх Англи даяар бүхэл бээр газрын тэртээгээс харагдах бичиггүй ганц ч хадан хясаа, ганц ч чулуу, ганц ч хана үлдсэнгүй, тэр зарлалынх нь үг гэвэл энэ ч Ариун баганачаас л цамц авч байгаарай ихэс дээдэс бүгд л өмсөж буй юм шүү Патент зарлав Энэ ажил маань туйлын их орлоготой учраас орсон мөнгөө багтаах шингээх газаргүй шахам байлаа. Үйлдвэрээ нэлээд өргөтгөсөн хойноо бид вангуудын өмсөх цамц, гүн ахай нарт зориулсан дэгжин гоё цамц, мөн бусад авгай хатагтай нарт зориулсан энгэр хэсэгтээ хүниастай, ар хэсэгтээ хажаастай, аврах тойрогтоо хатга малтай, зүүн талын энгэртээ янзтай цамц хийдэг болсон Тун дэгжин эд байлаа. гэтэл яг тэр үеэр миний хөдөлгүүрийн нэг хөл нь эвгүй болж ганц хөл дээрээ зогсоод байх болсныг би ажив Тэгэхлээр нь үйлдвэрлэлээ хорогдуулж уг ажлаас гарахад түүнийг Борс Де Ганис ноён худалдан авч өөрийн хань хамсаатны хамт ажиллуулсан боловч хувраг зүтгэлтэн нь таалал төгссөн учир нэг жилийн дараа арга буюу хаахад хүрчээ Хаахаас аргагүй болсныг би нотолж

чадах байна. гэвч анх уулзахад түүний зан араншинг үгээр энд тодорхойлон өгүүлэх бололцоо алга Үнэхээр сонирхоё гэвэл санваартны Амьдрал гэсэн бүлгийг уншина уу

Хорин гуравдугаар бүлэг

БУЛГИЙГ СЭРГЭЭВ

Бямба гаригийн үдэд миний бие чухам юу болж буйг нь үзэхээр худаг уруу явлаа Мерлин бас л баахан хуж асаачихсан гар хуруугаа сарвалзуулан амандаа Ямар нэг дэмий балай юм. хичээнгүйлэн бувтнах боловч ганц ч дусал ус гаргуулж чадсангүйдээ нэгэнт сэтгэлээр унасан харагдах бөгөөд эцэст нь би

- за түнш минь ажил чинь юу болж байна. гэж асуу в

- би одоо дорно дахины хамгийн дээд мэргэдийн мэдэх хамгийн чадалтай рид хувилгааны хүчийг хэрэглэнэ харж л байгаарай, тэгээд тус болохгүй бол е рөөс юу ч дийлэхгүй юм. гэж бодох хэрэгтэй Намайг дуустал үг бүү дуугарцгаа Тун их утаа байгиулж тэр нь орчин тойрноо харанхуй болгож салхины аяс тааран аглагч нарын зүг манарсан учраас тэд нүхэндээ бүтэж үхэх дөхөн нэлээд сандрав Мерлин тун их юм. үглэх бөгөөд бүгдий нь бичих юм. бол хэд хэдэн боть ном болно. Тэр биеэ мурилзуулан хөдөлгөж гараа зогсоо зайгүй сүртэй хүчтэй нь аргагүй савчин сарвалзуулна хориод минут болсн ы дараа газар хөсөр унаад багтарч үхэх дөхөн амьсгаадан амь тавих шахав . Гайхамшгийг үйлдэх тэр өтгөн утаанаас болж сэтгэл зүрх нь догдолсон ширээт лам, олон зуун гэлэн гэлэнмаа нарынхаа болон мөргөлчид, золбин ж аалуудынхаа хамт цугларан ирэх нь тэр Ширээт лам сэтгэл нэлээд төвдсөн байдалтайгаар бүтэх янз байна. уу гэж асуухад Мерлин

- Усы нь хөдөлгөхгүй барьчихсан рид хувилгаан хүчийг үхлэнт хүний хүч чадал замхруулан арилгаж чаддагсан бол булгийн ус гарч ирэх л байна. гэвч тэр дийлдсэнгүй Тэгэхлээр миний хамгаас илүү айж байсан тэр зүйл үүдлээ дорно дахины ид шидтэнгүүдийн сайн мэдэх бөгөөд хэн нэрий нь хэлбэл тэр хүн үхэх тийм аймшигт асар их хүчтэй нэгэн рид хувилгаан тарнидсан байна. Тэр ид шидийн нууцыг мэдэх ганц ч амьд хүн байхгүй бөгөөд нэгэнт нууцы нь эс тайлбал ид шидий нь яаж арилгах билээ. Сайн сэтгэлт эцэг ламтан минь , энэ булгийн ус хэзээ ч дахин, гарч ирэхгүй нь ээ, би амьд хүний хийж чадах бүхнийг хийгээ Ингээд миний биеийг одохы г соёрхоно уу гэв Ширээт лам аргагүй л бачимдан цөхрөлд орлоо Урам нь хугарсан тэр, надад хандаж ийн хэлэв

- чи түүний хэлсэн үгийг сонсов уу ? Үнэн юм. ярьж байна. уу ?

- зарим нь үнэн

- Үнэн, гэхдээ зарим нь худал байх нь уу юу нь үнэн юм.?

- Үнэхээр дорно дахины нэртэй рид хувилгаанд тарнидуулсан нь үнэн байна. Бурхан минь өршөөх болтугай Бид мөхөх боллоо гэж үү

- Магадгүй

- Арай ч гарцаагүй биш үү Гарцаагүй биш гэж хэлэх гэж байгаа юм. биш биз дээ?

- тийм ээ, гарцаагүй биш

- Тэгвэл, энэ хүн тэр ид шидийг амьд хүн яа вч арилгаж чадахгүй гэж хэлэхдээ

- Худал болж болох тийм юмыг хэлж байна. Тэр рид хувилгааны хүчийг замхраан алга болгоно гэхэд маш өчүүхэн зарим нэг горьдлого байгаа учраас тусгай болзлы нь тааруулах хэрэгтэй

- Болзол

- Болзлыг биелүүлэхэд хэцүү юм. огт байхгүй Ямар болзол гэвэл худаг болон түүний орчны хааш хаашаахагас бээрийн зайтай газрыг өнөө оройн нар шингэх цагаас эхлэн миний бүрэн мэдэлд олгож намайг тарни хийж гүйцэхээс нааш миний зөвшөөрөлгүйгээр ганц ч хүн оруулахгүй байх хэрэгтэй

- Ердөөл энэ үү?

- тийм ээ

- чи тэгээд оролдоод үзэхээс айхгүй байна. уу ? — Өө, үгүй ээ минийх бүтэлгүй болж ч мэдэх шүү дээ Харин амжилттай болбол, оролдоод үзэхгүй байхыгн хэрэг юу ? Оролдоход би бэлэн байна. миний тавь сан болзлыг та зөвшөөрч байна. уу ?

- би ямар ч болзол тавьсан зөвшөөрнө, би одоохон чиний шаардлагыг биелүүлэхийг тушаана

- хүлээнээрэй Энэ ид шидий нь арилгах гэж байгаа хүн тэр сүнснийхээ нэрийг мэдэж байх ёстой гэдгийг та мэднэ биз? гэж Мерлин хэлээд хорслонтойгоор ярвайн инээмсэглэв

- би нэрий нь мэдэж байна.

- Нэрий нь мэдэх нь бага хэрэг бас яаж хэлдгий нь мэдэх учиртайг мэдэж байна. уу ? Ха ха Та мэдэх үү?

- Нэрий нь хэл гэж үү? болно. шүү Нэр валли нэр байсан ч би хэлж л орхино

- Тэгвэл та талийгаач болох нь тэр, үүнийг би Артур ванд дуулгалаа шүү

- за болоо дэмий балай яриагаа татаад эндээс тонил Тэр лүүгээ харь, Жон У Мерлин, тэнгэр ямар болохыг л таадгаараа тааж суу энд чиний хэрэг огт байхгүй би ёстой аминд сүнсэнд нь онох шиг болсон учраас Мерлин арга буюу духаа атируулах нь мань хүн бол тэнгэрийн байдлыг урьдаас хэлэхдээ тун муу гэж ванлигийнхээ дотор нэр гарсан хүн Далайн эрэг дээр салхи шуурганы дохио хатга гэж түүний тушаасан үе хамгийн нам гүн байдал эхэлж долоо хоногоор үргэлжилж байсан удаа бий Тэнгэр хур тундасгүй цэлмэг байх болно. гэсэн үед нь үер бороо асгаж байсан удаатай ажээ. гэлээ. ч гэсэн тэрний нэрийг хугалах санаагаар түүнийг агаарын байдал ажиглаж хэлэх товчоо руу явуулах гэсэн юм. миний хэлсэн үгэнд уур нь шатаж Тэр рүүгээ хар ьж миний үеэхийг сонсгохын оронд эндээ үлдэж миний хэрхэн үхэхийг харж бах таваа ханана гэлээ. миний мэргэжилтэнгүүд замда а огт амралгүй явсан тул тун их ядарсан амьтад үрч ирсэн юм. Тэд надад хэрэгтэй багаж хэрэгслэл, хөөрөг, хартугайган хоолой, бөнгаль, гай, том том пуужин холбоос, ром лаа, цахилгаан батарей гэх мэт ёстой баялаг, бийлэгжүү гайхамшигийг харуулж болох юм. Бүхнийг луусан дээр ачиж авчирсан Тэд маань идэж уугаад бага зэрэг нойроо авсан хойно бид гурвуул худгийн дэргэд очиход ойр хавьд амьтай голтой ганц ч амьтан байхгүй хов хоосон мэт таг чимээ аниргүй байлаа. би тийм байлга гэж ч шаарда аг үй л дээ Бид тийнхүү худаг болон хавь ойрынх нь газрын бүрэн эзэн нь болжээ. залуус маань чулуугаар хана нүүрлэхээс өг сүүлэн нарийн хэрэглэл байгуулахыг хүртэл бүгдийг хийж чадаж байв. Нар мандахаас өмнөхөн усны урсгалыг тагл ан зогсоож амжсан тул усны т ү в шин нэмэгдэж эхэллээ . Тэгэхлээр нь бид сумийн бунхны тэр газар т үү дэг галаа бэлтгэн хаалга үү дий нь цоожлоод унтахаар явцгаав Өглөөний мөргөл хараахан дуусаагүй байх үеэр бид дахин худаг дээр очсон, яагаад гэвэл хийх ажил бас л их байсан бөгөөд миний бие дор дурдсан ажил хэргийн чанартай бодлогын улмаас өөрийнхөө ид шидийг заавал шөнө дундаас өмнө үзүүлж амжъя гэж бодсон билээ. Сүм хийдэд ашигтай ид шидийг бүтэн сайнд үйлдвэл энгийн өдөр үйлдсэнээс зургаа дахин илүү эрхэмлэн үнэлдэг юм. Есөн цагийн дотор худгийн ус хуучин хэвийнхээ хэмжээнд хүрсэн байлаа. Өөрөөр хэлбэл худгийн амсраас хорин футын зайд ирээд байсан юм. Нийслэл хотын ойролцоо байгуулсан миний нэг үйлдвэрийн хийсэн анхны нэг төмөр хөөрөгний нэгийг бид худгийн усанд дүрж үзлээ Бид бунхны газрын гадна талын хананы дэргэд байсан чулуун резервуарыг цоо өрөмдсөн нүхээр нь тугайган хоолой богинохныг шургуулсан нь нэг үзүүрээрээ үүдэнд хүрч, тэндээсээ олонд харагдахуйц ус садруулан хонхны газрын эргэн тойрны, миний багцаалахад, хоёр зуун тавиас доошгүй гектар газрыг усалж чадах байлаа. Бид хоосон торхны ёроол салгам бунхны хавтгай орой дээр аваачиж хадчихаад дотор ямхын төдий з у заан дарь цацаж дариндаа бидэнд б аг а сага байсан элдэв төрлийн пуужин зоосон юм. Дариндаа бас халаасны цахилгаан батарей хийж дараа нь бүх өнгөт гэрлийнхээ зүйлсийг байшингийн оройн дөрвөн ө нц өг т нэг өнцөгт нь хөх, нөгөөд нь ногоон бас нэгэнд нь улаан, дөрөө дэхэд нь ягаан өнгөтэйг байрлуулаад тус бүрийг батарейгаар хооронд нь холбосон юм. Бунхнаас хоёр зуугаад алхмын тэртээ банз, гулдан модоорнэг тавцан хийв Тэр тавцангаа түр хөлс өө р авч хэрэглэсэн тод өнгөтэй Хивсүүдээр бүтээж тэг дунд нь ширээт ламын суудлыг

засав Харанхуй бүдүүлэг хүмүүст ид шид үзүүлэхдээ хамгийн жижиг сажиг зүйлийг их анхаарах хэрэгтэй байдаг Аар саар юм. бүхэн тэдний гайхаш татахад чиглэх ёстой Хамгийн хүндтэй гийчдээ тух та в алдуулахгүй байх талаар ч багагүй анхаарах хэрэгтэй ийм нөхцөл байдлыг бүрдүүлж чадсан бол зорьсон ажилдаа зоригтой орж болдог би хүний мөн чанарыг мэдэх учраас аар саар зүйл, тух тавьж ач холбогдлыг ойлгодог билээ. Сүр бадрууллаа гээд ид шидийн үнэ цэнэ буурдаггүй Сүр бадруулахад их ажил, их хөдөлмөр, заримдаа их ч мөнгө хэрэгтэй болдог, гэхдээ сүүл сүүлдээ тэр бүхний хариу аян даа орж ирнэ Тийнхүү бид бунхны газраас өнөөх зассан тавцангаа хүртэл газар доогуур утас татаж тавцангийн доор багарейгаа нуучихлаа . Олон түмнийг зайтайхан байлгах гэж тавцангаасаа хааш хааш зуун шоо фут газар утсаар хориг татаж ажлаа үндсэнд нь дуусгасан юм. миний төлөвлөснөөр бол хүмүүсийг 030д оруулж үзвэрээ яг 25д гаргах, Үзүүлсний хөлс авч болох байсан боловч эвгүй мэт санагдаад больсон юм. би өөрийн хүмүүсийг хүн амьтан ганц ч ирээгүй байх арвон цагаас хожимдолгүй бунхны газар хүрч ирэхийг тушаасан маа нь хөөргөө цаг тухайд нь ажиллуулах гэсэн санаа байсан юм. Тэгээд бид оройнхоо хоолонд явцгаасан Булгийн тухай харамсалтай мэдээ тус орны аль хол нутагт ч түгж тархсан учраас сүүлийн гурван хоногийн дотор Онгодын Хөндийд хүрч хүсэн хүмүүсийн тоо замаа алджээ Хөндийн доод биеэр нэл хуарагнан буусан хүн ардаар дүүрсэн байлаа. Үзэх харах хүний тооны хувьд гэвэл санаа зоволтгүй үнэхээр хангалттай байв. Оройн бараг бүрий дөнгөж эхэлмэгц зарлал тараагч элч нар хөндий даяар давхилдан усыг эргүүлэн авчрах оролдлого хийх гэж байна. хэмээн өндөр дуугаар зарлахад тэр цагийг тэсэж ядан хүлээх нь туйлдаа хүрч байлаа. Элч нар зарлахдаа ширээт лам өөрийн бараа бологчдын хамт сүмээсээ яг 030нд сүрлэгээр гарч өгссөн тавцанд суудлаа эзлэх тул тогтоосон хүрэнээс дотогш хэн ч орж үл болно. гэж байна. Ширээт ламыг суудлаа эзлэхэд хонх дуугарахаа зогсох бөгөөд гагцхүү тэр мечид дөхөн очиж болно. гэжээ миний бие гийчдийг хүлээн авахад бэлэн болж тавцан дээр хүлээж байв. Тэгж байтал ширээт лам тэргүүтэй сүрлэг цуваа гарч ирлээ шүү Тэнгэрт од мичид ч харагдахгүй хөө харанхуй шөнө болчихоод байсан болохоор тэднийг татсан утасны дэргэд ирэхэд нь л бие таньсан юмдаг Бамбар асаахыг бие зөвшөөрөөгүй Ширээт ламын хамт Мерлин хүрч ирээд тавцангийн эхний эгнээнд суухыг харвал мань хүн энэ удаа хэлсэн үгэндээ хүрсэн байна шүү Татсан утасны цаанахь юм. харагдахгүй байсан учир тоймгүй олон хүмүүс үзэгдэхгүй боловч ирчихсэн байх ёстой гэж бие бодсон хонхны дуу т зогсмогц тэр үй олон хүн багширсан хар давалгаа мэтээр урсан, зай завсартай бүх газраар пиг дүүрч, бас дахин хагас цагийн турш нэмж цувсаар сүүлдээ нам гүй болон зогсоцгоов хүний толгойгоор зассан замаар хэдэн бээр газар явья гэвэл тэдний толгой дээгүүр алхахад болохоор ажээ. Үр нөлөөг улам хүчтэй болгох гэж бие бас хориод минут хойш татсан Олныг бага зэрэг хүлээлгэж зовоох хэзээд эшигтай байдаг Тэгж тэгж нам гүмийн дотор гэнэт эрэгтэй хүмүүс латины сайхан гэгчийн сүлд дууг аяархан аялж эхлээд чангарсаар чангарсаар баяр ёслолын эгшиг аялгуу болон хувирч шөнийн нам гүмд сүрлэгээр цууриатлаа Энэ бол миний зохихон сүр бадруулах арга хэмжээний дотроос хамгийн олигтой нь болсон юм. Сүлд дуудуулаад дуусмагц бие тавцан дээр гарч эгцлэн зогсоод хоёр гараа өргөн тэлж толгойгоо гэдийлгэн хоёр минут хэртэй хөдөлгөөнгүй зогсов ийм аргаар хүмүүсийг хэзээд таг чимээгүй болгож болдог юм. Дараа нь хүн бүхэн сонсмогцоо давхийн цочиж, эмэгтэйчүүд муурч унах аймшигтай үгийг аажмаар хэлэв Тэр хэлсэн үг маань энэ л дээ

- Константинополитанишердудельзакспфайфөнма хөрсгезөллешаффт Энэ үгийнхээ сүүлчийн үгийг уянгалуулан хэлж дуусмагцаа цахилгаан утаснуудынхаа нэгд хүрвэл хав

харанхуйн дунд живсэн үй олон хүнийг сүүмгэр х ө х гэрэл гэнэт гийгүүлэв мөн ч сүртэй юм. болсон шүү Олон хүмүүс уулга алдан хашгирсан бөгөөд эмэгтэйчүүл тал тал тийш г ү йлдэн тэнэмэл хүүхдүүд бөөн бөөнөөрөө мууран унаж байлаа. Ширзэт лам болон санваартан бүгд хиртхийн цочиж аманд а а уншлага бувтнан запбирал үйлдэж эхлэв Мерлин биеэ барих боловч тиймэрхүү юм. энэ насандаа ганц ч удаа үзээгүй хо й но жигтэйхэн хачирхаж судасных нь цус хордох шиг болжээ. дээрээс нь дахин сүр бадруулах хэрэгтэй байв. Би хоёр гараа өндөр өргөж амь тав ьж буй амьтны ад ил орь дуугаар

- Нигилистөндинамигтеатейсестхөнсшепрөнгунгсат төнтэтсферзухүнгөн гэж уянгалуулан улаан гэрлээ асаав . Хөх цэнхэр гэрэл дээр тамын ув улаан гэрэл нэмэгдэхэд Атлентын дал ай шиг тэр ү й түмэн хүн орь дуулалдан орилолдон хашгиралдахыг сонсууштай мэт билээ. Жаран секундийн дараа дахин

- Трансваалырупнөнтролөнтранспорттранпельтир трайбертрауунгстрэнөнтрагеди гэж хашгираад ногоон гэрлээ асаав Энэ удаа дөчхөн секунд хүлээгээд хоёр гараа дэлгэн бүдүүн чанга гэгчийн дуугаар МеккамузельманөнмассөнМеншенмердөрмьрөнмут термармормонумөнтөнмахөр гэсэн үгийн үе болгоныг сүртэйгээр хэлж дуусгахдаа цайвар шар гэрлийг гэнэт асаалаа . Тийнхүү улаан, хөх, ногоон шар дөрвөн гэрэл нэгэн зэрэг асаж д ө рвөн омголон галт уул нүд гялбам өнгөтэй ө тгөн их утаа оргилуулан уудам хөндийн нэг захаас нөгөө за хыг хүртэл солонгорох туяагаараа гэрэлтүүлэн үд дундын саруул өдөр мэт болгов Алсад тэнгэрийн дэлгэц дээр баганачин маань байх ёстой газраа хөдлөлгүй зогсох нь амьдралынхаа хорин насанд анх удаа маанаглан м ө ргөдөг ёсыг хаясны шинж байлаа. миний хүмүүс хөөрөгнийхөө дэргэд аль хэдүйн дохио хүлээн байгааг би мэдэж байсан болохоор ширээт ламд

- Эцэг ламтан минь , цаг нь боллоо Одоо би аймшигт нэрийг зарлаад ид шидий нь сарниая Бэлэн байгаарай Нэг юм.наас сайн барьж аваарай гээд олны зүг өнд ө р дуугаар

- Одоо сонсоцгоогтун нэг минутын дараа ид шидийг замхраана, аль эсхүл амьд биетэй төрсөн хэн болтугай ч хэзээд замхраан үл чадна, Хэрэв миний бие рид хувилгааны хүчээр ид шидийг арилгаж чадвал бунхны үүд хаалгаар ус цутган гарах учир та нар нэн даруй чадсан эсэхийг нь мэдэх болно. гэлээ. Арын эгнээний хүмүүс дуулаагүй байж магадгүй, тэдэндээ миний үгийг дуулгаж дуусаг гэж бодоод би нэг хэсэг хүлээж байснаа ялимгүй бөгтийсхийн гараа хачин савчиснаа ингэж хашгирлаа

- Ариун булгийн усанд шүглэсэн үхээрийн сүнс чамайг булагт хадгалан буй чөтгөр шулмынхаа галын дөлийг тэнгэрийн уу дамд цутган гаргаж ид шидээ замхрааж эндээс бушуузайлан тамын газар очиж мянган жил хүлээстэй хэвтэгтүн Чамайг түүний аймшигт догшин нэрийг барин хараая Бдвджджиликк гэж хэлэнгүүтээ пуужинтай торхонд холбосон утсаа залгав . Нүд гялбам гялалзсан өдий төдий галан сум чих дөжрөм шунгинан жингэнэн эгц дээшээ тэнгэр өөд цоройлон дэгдэж тэнгэрт алмасаар бороо орох адил сацран, бутарч байлаа. Шороон түмэн хүн орилолдон хашгиралдсан боловч төдөлгүй бунхны үүд хаалгаар сая дөнгөж чөлөөлөгдсөн ариун ус ид шидтэй галын гэрэлд мяралзан цутган урсахад хүмүүсийн ухаангүй баярлан хашгиралдах дуу чимээ ноёрхлоо Н өгөө ширээт лам үг ч хэлж чадахгүй нулимсандаа хахаж цацаж байна. Намайг үг дуугүй чанга тэвэрч арай л багтраачихсангүй Түүний тзпж чанга тзврэх ямар ч үгээс илүү хүчтэй байлаа. Гэр оронд сохор зоосны ч үнэтэй ганц ч эмч байхгүй юм. болохоор бүр ч их осолтой байлаа. хүмүүс

бөөнөөрөө гүйлдэн очоод усыг эгээ л амьд юм. шиг үнсэж таалан өхөөрд ө ж, сурагуй алга болж үхэж үрэгдсэн байх гэж байсан нэг нөхөр нь гэнэт эргээд ирсэн юм. шиг элдэв дээдийн энхрий нэрээр дуудах мэтээр баярлан байхыг нь үнэхээр харууштай, нээрэн харахад тун аятайхан байсан учраас түүнээс хойш би тэр хүмүүсийг урьд урьдынхаасаа илүү сайнаар боддог болсон юм. Мерлинийг Тэр лүү нь дамнуургаар хүргүүлсэн Намайг сүнсний аймшигт нэр хэлмэгц мань хүн ухаан алдаж е рөөсөө дахин сэхээрч чадахгүй байлаа. би ч гэсэн урьд нь сонсоогүй байсан тэр г эрийг мөн гэж бодоод Мерлин тийнхүү ухаан алджээ Намайг ямар ч тэнэг балай нэр хэлсэн өнөөхийн жинхэнэ нэр мөн гэж бодох байж л дээ Сүүлд над хэлэхдээ сүнсний төрсөн эх нь ч хүүгийнхээ тэрнэрийг чам шиг тийм цэвэрхэн яруу тод хэлж чадахгүй гэсэн билээ. Намайг ямар аргаар амьд үлдсэнийг мань эр хэрхэвч ухаарахгүй байсан бөгөөд би ч нууцы нь хэлж өгөөгүй тиймэрхүү нууцыг гагцхүү залуувидастангууд тайлж чадах билээ. Тэрнэрийг хэлэх мөртлөө амьд үлдэх аргыг ид шидээр сурах гэж Мерлин гурван сарын хугацаа зарсан юм. Даанч бүтэж өгсөнгүй, яаж ч бүтэх билээ. Намайг бунхны зүг алхахад түм түмэн хүн хүндэтгэн малгалгаа авав .Дундуураа ярагдан зай тавьж намайг ёстой л дээд тэнгэрийн амьтан шиг үзэж байв. үнэндээ ч дээд амьтан байлаа л би хэд хэдэн лам шилж аваад хөөрөгний учрыг заан өгч ус татахыг зарлиг болгов Тэнд шөнөжин байх гэсэн хүмүүс зөндөө тул хүрэлцэх ус хэрэгтэй байсан юм. Лам нар хөөргийг ч гайхалтай хачин юм. гэлцэж байв. Гайхаад гайхаад гайхаж барахгүй яасан сайхан ажилладаг юм. гэлцэнэ Тэр бол ер бишийн агуу их үйл явдалт туйлын чухал шөнө байлаа. Тэр шөнө миний алдар нэрийг нэн их цууриатуула в. Бахдах сэтгэл цээжээр дүүрчихээд унтаж чадахгүй удаан сэрүүн байв.

ӨРСӨЛДӨГЧ шид

Онгодын Хөндийд одоо миний нөлөө хязгааргүй их болов. Тэгээд ч түүнийхээ ид шидийг Ямар нэгэн ашигтай ажилд гаргах хэрэгтэй байлаа. Саван тараах ажлаар явж байсан миний нэг элч маргааш өглөө нь тэр сүмийн дэргэд ирэхэд л ийм санаа толгойд буусан юм. даг хоёр зуун жилийн өмнө эндхийн лам нар ертөн цийн юманд их татагдаж савантай усаар нүүр гараа угаадаг байсан гэж түүхэнд өгүүлнэ тиймэрхүү бузар явдлынх нь ул мөр бага боловч үлдсэн байж мэднэ Тэгээд нэг ламаас

- Усанд угаах хүсэл байна. уу ? гэж асуув Булгийн усанд ямар шуу аюул учрахыг ухааран хиртхийн цочсон боловч сэтгэл догдлон ингэж асуулаа

- хүүхэд цагаасаа авахуулан ариун угаал үзээгүй энэ муу биед тийм юм. гуйх хэрэг юу н? Бурхан минь , усанд орох хичнээн сайхан билээ. гэвч ариун явдалт ноёнтон минь надад таарахгүй, хориртойгоос хойш тийм сайхан юм. ярих хэрэггүй юм даа гэв Тэгээд маш харамсалтайгаар сүүрс алдахад нь би түүнд газрынхаа хөрсний ядаж нэг давхрыг боловч арилгах бололцоо олгоё, үүнээс болж миний нэр сүр унаж сүм хийд сүйрлээч дүүрсэн хэрэг, түхийсэн гүзээ гэж бодлоо Ширээт ламын дэргэд очиж энэ ламыг усанд орохыг зөвшөөрнө үү гэхэд хамбын царай цайж царай нь цайсныг би үзсэн юм. шиг цайлаа гэж хэлэх гэж байгаа хэрэг биш шүү, яагаад гэвэл түүний царай цайхыг үзье гэвэл нүүрнийнх нь номны хавтсын дайтай зузаан хирийг арилгах хэрэгтэй болох байсан тийм ажил хийхийг би хүсээгүй билээ. гэлээ. ч тэр үг сонсмогц дагжин чичрэхийг нь би мэдсэн л дээ Түүний хэлэх нь

- Аяа хүү минь , би чиний шаардах бүгдийг талар хан өгнө, гагцхүү үүний чинь л хэрхэвч

үгүй Ариун булгийн усыг дахин алга болгоход хүргэх гэж үү? гэв

- Үгүй, эцэг ламтан минь , би булгийг ширгээхгүй би нэгэнт нууцы нь мэдсэн болохоор лам нар бие угаах газар бий болгосны улмаас булгийн ус алга болсон хэрэг биш өвгөн сонирхсон маягтай болгоомжлов бие угаах газраас болоогүй, харин огт өөр нүглийн улмаас тийм г ай түйтгэрийг дээрээс илгээсэн гэж бурхан надад хэлж өгсөн

- Үг чинь үгүй гэхийн арга алга, хэрэв хэрэв үнэн болсонсоход таатай байна.

- Үнэн байлгүй яах вэ, эргэлээх хэрэггүй Эцэг лам тан минь бие угаах газар дахин байгуулахыг соёрхоно уу Хуучны нь сэргээхийг соёрхоно уу , булгийн ус мөнхөд урссан хэвээр байх болно.

- чи амлаж байна. уу ?амлаж байгаа юм. уу ? Амлаж буй эсэхээ л хэлчихгүй юу ?

- Амлаж байна., амлаж байна.

- Тэгвэл би өөрөө хамгийн түрүүнд орж биеэ угаая Ажлаа эхэл, эхэлж үз, удах хэрэггүй, бушуухэч шиг би залуусынхаа хамт тэр даруй ажиллаж эхэллээ Бие угаах газрын нурсан ором ганц ч чулуу дутуугүй хэвээрээ сүмийн дор байлаа. тийм олон жил өнгөрсөн байхад зүрх гарган түүнд ойртож очих ганц ч хүн байсангүй Түүнийг чөтгөр шүглэсэн газар мэтээр үзэж байсан болохоор үнэн зүрхнээсээ сүрдэн айдаг байж Бид хоёрхон өдрийн дотор лайдан засаж дуусаад усч оруулж амжсан юм. чөлөөтэй шумбаж болох цэвээ тунгалаг устай асар то м усан сан бий болох нь тэр Эрт дээр үед тавьсан орох гарах хоолойтой байсан учраас ус нь урсгал байв. Өвгөн хамба хэлсэн үгэн дээ хүрч өөрөө хамгаас түрүү усанд шумбалаа чичирч дагжсан хав хар амьтан орсон бол цав цагаан, магнай тэнэгэр хүн болоод гарч ирсэн билээ. Вас нэг сүрхий ялалт, бас нэг сайхан амжилт боллоо Онгодын Хөндийд явуулсан бидний бүх ажил амжилттай болж байсан учир миний санаа хангалуун байлаа. Явахыг завдаж байтал надад нэг гал тохиолдов . Надад хамрын ханиад сүрхий хүчтэй тусаж үе мөчний архаг хууч хөдлөө . Үе мөчний өвчин хүний заавал эмзэг газраар барьж тусдаг золиг юм. чинь намайг бас тэгж зовоосон юм. Надад талархсан хамба ламын үг дуугүй чанга тэврэн арай л багтраачихаагүй тэр газ ра ар барьж тусах нь тэр Арай гэж нэг юм. хэвтрээсээ өндийхтэй боллоо гэсэн чинь яс арьс хоёр болсон байж билээ. гэвч хүн б ү р туйлаас ачлан хандаж намайг бөөцийлж байсны хүчинд миний бие түргэн сайжралыг олсон билээ. Сэнди намайг бөөцийлөх гэж үйлээ барж Маш их ядарсан байсан учир түүнийг эмэгтэйчүүдийн сүмд орхиод би ганцаараа одохоор шийдэв Хувцсаа сольчихоод энгүүнээр хувцаслаж орон нутгаар ганц хоёр долоо хоног тэнэе гэсэн санаа толгойд орж ирсэн юм. чингэвэл надад тус орны чөлөөт иргэдийн хамгийн ядуу доо рд ангийн хүмүүстэй хамт хооллож хоног өнгөрөөж явах бололцоо олдох байсан юм. Тэдний өдөр тутмын амьдрал болон хууль дүрэм ямар нөлөө үзүүлж байгааг мэдэж авах өөр арга надад байхгүй байсан . Хэрэв би эгэл хүмүүсийн дотор тайж хүний хувцас хүнартай хэсэх юм. бол тэд надаас ичиж зовон дөлөөд өөрсдийн баярлах зовох юм. бүхнийг нууж ажсан харсан зүйл маань огт дэмий өнгөц хуурамч юм. болох билээ. би нэг өглөө алсын аянд гарах бэлтгэлээ хийж хө лийнхөө чилээг гаргахаар хөндийн хойтыг эмжсэн уулсын хярд гараад надад аль түрүүний үзүүлж байсан нэг хиймэл агуйд очлоо Тэр бол хатуу до гшин, бузар булайгаараа нэрд гарсан нэг даяанчийн агуй байж Арслан, шумуул элбэгтэйн улмаас аглагч нарын амьдралд маш хэцүү гэгддэг Сахарын газар то м албанд орно угэж түүнийг саяхан урьсан юм. гэнэлээ Тэгээд явсныг нь гарцаагүй мэдсэн болохоор хүмүүсийн ярьснаар

түүний агуй үнэхээр тийм их үмхий самхай нь үнэн бол уу мэдэх санаа а тай орлоо . Агуйг цэвэрлэж шүүрдэн орхисон байхыг нь үзээд ихэд гайхаж билээ. Харанхуй агуйн дотор хонх жингэнэж бас

- байна. уу , тө в өө Камелот уу ? Баяр хүргэе гал хамшигт итгэхгүй байж яаж болох билээ. одоо биднийг огт санаагүй газраас эргэн тойрон бүслээд идээ үзүүлж байхад яаж итгэхгүй байх вэ, энд миний хажууд хүчирхэг Эзэн өөрийн биеэр хүрч ирлээ Хэрхэн дуугарах дуу хоолойг нь сонс гэх чимээ гарахад миний бие туйлын их гайхлаа юу гээчийн эрс шийдмэг эргэлт вэ Гайхмаар ер бишийн юм.с яаж ингэж нэгэн дор хуралдана вэ юу гээчийн гал ус шиг харшилдааны хослол ухаанд үл баг тахаар ингэж үүснэ вэ Худал хуурмаг гэгчийг бүтээг чийн орогнодог газар жинхэнэ гайхамшиг, бий болж, дундад зуумы даяанчийн үүр төлефон станц болон хувирсан байх Утасны хүн гэрэлд гарч ирэхэд нь харвал миний залуу туслагчдын нэг байлаа. Тэгээд

- Ульфиус ээ, энд хэзээ төлефон станц байгуулаа вэ? гэж асуув Ариун Эзэн минь , очигдөр шөнө дунд Хөндийд тун олон гэрэл асахыг ажаад томхотод л тийм олон гэрэл асдаг болохоор төлефон станцаа энд байрлуулсан юм.

- Та нар зөв юм. хийжээ энд томхот байхгүй ч гэсэн төлефон станц байгуулахад тун тохиромжтой га зар байгаа юм. Та нар ямар газар байгаагаа мэдэж байна. уу ? би хараахан асууж лавлаж амжаагүй байна., намайг жижүүрлэж бай гээд нөхөд маань яваад өгөхөөр би эхлээд амарч жаал унтаад дараа нь лавлаж мэдэж аваад энэ газрынхаа нэр усыг К а м е лотод мэдэгдье гэж бодсон юм. „ э нэ б ол Онгодын Хөндий гэдэг газар мэдэж ав Ойлгосонгүй тийм нэр сонсоод баярлан дэвхцэнэ дээ гэж бодож байсан чинь харин жишим ч үгүй

- Тэгээд л дамжуулчихья гэлээ.

- Энэ хавийн газар сүүлийн хэд хоногийн турш болсон гайхамшгийн дуулианыг чи мэдээгүй байна. гэж ҮҮ дээ

- Бид чинь шөнийн цагаар л явдаг улс хүн Амьтантай ер ярилцдагүй шүү дээ Камелотоос л юу мэдээлнэ вэ, тэрий нь мэдэхээс цаашгүй

- Камелотынхан бүгдийг мэдэж байгаа шүү дээ Ариун булгийн усыг сэргээн урсгасан агуу их гайхамшгийн тухай чамд яриагүй гэж үү?

- Ярилгүй яах вэ, харин тэр хөндийн чинь нэр огт өөр юм байна. билээ. тийм хачин будлиантай юм. ер байдаг эсэх

- Ямар нэртэй хөндий гэж сонссон бэ?

- Бузарын Хөндий гэсэн

- Одоо л ойлгомжтой боллоо Энэ муу телефоноос л болох нь тэр Ойролцоо дуудах үгийг дандаа будлиулж утгы нь шал ондоон болгочихдог юм. за яах вэ, ямар ч болсон чи одоо хөндийн нэрийг мэдэх боллоо Камелотоо дууд даа Камелотыг дуудахвд утсан дээр Кларенс ирж ярилаа Тэр жаалынхаа дууг сонсох яасан сайхан байв. Гэртээ харьчихсан юм. шиг санагдаж билээ. Бие биеийн хээ эсэн мэнд байгааг найрсаг, энхрий үгээр мэдэлцэж саяхан бие өвдсөн тухайгаа яриад

- Сонин юу байна. даа? гэж асуулаа

- Ван, ван ахай хоёр ордныхоо олон хүнээр бараа болгон одоо таны тэ р хөндий рүү очихоор мордон таны сэргээсэн булагт мөргөж нүглээс цэвэршээд, шуламсын сүнс жинхэнэ шуламсын гал дөлийг үүл манан мэтээр цацруулж байсан газрыг үзэх гэнэлээ Хэрэв та сонсох юм. бол би дотроо инээдээ барьж ядан догиож даажигнаж байсан юм. яагаад гэвэл тэр дөлийг чинь агуулахаасаа би биеэрээ гарган авч танд таны тушаалаар явуулсан шүү дээ

- Ван нааш ирэх замыг мэддэг байсан юм. уу ?

- Ван уу ? Мэдэхгүй байсан л даа Ер нь хэн ч мэдэхгүй Харин миний нөхөд л, яагаав, танд тусалсан тэд л замчин болж хаана буух, хаана хоноглохы нь зааж өгнө дөө

- Хэдийд хүрч ирэх бол?

- Нөгөөдөр, оройн мөргөлийн үеэр гэнэлээ

- Өөр сонин юу байна.

- Ван таны зөвлөснөөр байнгын их цэрэг байгуулж эхэлсэн Нэг хороо цэрэг бүр байгуулчихаад дарга нары нь томилчихсон,

- Тун тусгүй хэрэг байна. даа би өөрөө дарга нарыг нь томилъё гэж бодож байсан юм.сак, Энэ ванли гийн дотор байнгын армийн дарга нарт тохирох ганц хан бүлэг хүмүүс л байдаг юм.

- тийм байх Таны Академиас ганц ч хүн тэр хороонд ороогүй нь хачин юм. болсон доо

- юу гэнээ? чи тоглоогүй биз?

- би үнэнийг хэлж байна.

- чи миний сэтгэлийг зовоочихлоо Хэнийг томилсон юм.? Тэнцэх тэнцэхгүйгий нь юугаар бодсон юм. бол Бодвол уралдаант шалгалт зохихон биз дээ?

- Энэ тухай надад мэдэх юм. огт алга Дарга нар нь бүгд тайж язгууртны гаралтай хүмүүс болсныг л би мэдэж байна., Тэднийг та юу андах билээ. хонин толгойтонгууд шүү дээ

- Арай ч тийм биш байлгүй, Кларенс

- Тайвширч үз, та ванг дагаж яваа хоёр залуу язгууртан дэслэгч болох юм. Хэрэв та хүлээвэл тэд асуусан болгонд хариу өгнө

- Энэ бол чухал мэдээ байна. Ямар ч болтугай ядаж курс төгссөн ганц хүнийг ч гэсэн дарга нарын бүрэлдхүүнд оруулна Академи руу миний тушаалыг аваад морьтой элч одоохон давхиул арван морь ч хэрэглэнэ үү, хамаагүй тэнд өнөөдөр нар шингэхээс өмнө заавал очуулах хэрэгтэй

- Тэгэх хэрэг байхгүй би академитай телефон холбоо тогтоосон Та залгуулаад ярих уу ? ийм үг сонсох хичнээн сайхан байв. аа Ярьдаг утастай алс холын хошуу нутгуудтайгаа утсаар харилцах байнга бололцоотой болсон үед цээж дүүрэн чөлөөтэй амьсгалдаг байна. Дөнгөж сая л миний бие, энэ оронд ирээд өдий олон жил болохдоо хичнээн гунигтай, аймшигтай,

арчаагүй, амьсгаа авахад давчдаж бүгчим байдалд нь бага багаар дасаж ядаж байснаа ухаарав би академийн д аргад өөрийн биеэр тушаал өгөх нь тэр, Түүний хамт надад бага сага цаас, то с он балтай харандаа, хэдэн хайрцаг чүдэнз ирүүлээрэй гэсэн тийм аар саар юм.гүй байх чинь тун зовлонтой шүү Одооби дахин хуяг дуулга өмсөхгүй болохоор халаасандаа тийм юмтай явах бололцоо бий болно. Сүмд эргэн ирэхэд тун зугаатай юм. олж үзлээ Ширээт лам, лам нарынхаа хамтаар дөнгөж саяхан ирсэн нэг илбэчний илбэ жилбийг хүүхэд шиг сонирхон итгэн үнэмшиж байв. Өмссөн хувцас нь энэтхэгийн домч нарынх шиг жигтэйхэн хачин алаг эрээн ер бусын муухай юм. Эргэлдэн үсэрч амандаа үг үглэн гараа хий агаар болон шалан дээгүүр явуулан элдэв нууц тэмдэг дохиолон, ер нь л илбэчин бүрийн хэрэглэдэг арга хэрэглэж байгаа харагдлаа Ази даяар алдартай хүн гэж өөрийгөө зарлаж байсан нь ч хангалттай байлаа. Хэгж хэлэх нь хэзээд үнэд, жинхэнэ алтны ч үнэд хүрч, худалдагдах зах зээлээ хааяагүй олдог юм. хойно Агуу их илбэчин гэдэг алдар цолыг тэр хүн мөн ч амархан аргаар олжээ Түүний мэргэшил нь юу байсан гэхэд энэ дэлхийн бөмбөрцгийн хүн болгоны гухайн үед хийдэг зүйлийг ярих, түүнчлэн урьд юу хийсэн, ирээдүйд юу хийх вэ гэдгийг л ярих ажил байлаа. дорно дахины эзэн хаан одоо юу хийж байгааг асуух мэдэх хүсэлтэй хүн байна. уу гэж асуугаад нүд нь гялалзаж, гараа баяртайгаар үрчин байгаа байдлы нь ажихад үгээр хэлэхээс ч тод байлаа. Тэгээд зогсдог бол бас яамай Тэр эзэн хаан үнэхээр одоо юу хийж байгааг нь шударга ол о н түмэн мэдэхийг хүсэлгүй яах вэ Хууран мэхлэгч аман д аа нэг юм. бувтнаснаа

- дорно дахины эрхэм дээд эрэлхэг хүчит эзэн хаан одоо ариун явдалт ядуу нэгэн санваартны алган дээр нэг, хоёр, гурван, бүгд гурван мөнгөн зоос тавьж байна. гэж сүржин байдалтайгаар хэлэ в. Үй олон хүн сэтгэл ихэд хөөрч

- Хачнаа Гайхмаараа ийм ер бусын хүчийг олохын тулд мөн ч их юм. сурч, мөн ч их ажилласан байх ёстойгоо, хөөрхий хэмээн хүнгэнэлдэв Энэтхэгийн эзэн ноён одоо чухам юу хийж буйг эц нар хүсэж байгаа бол уу ? хүсэж байгаа л даа, Тэр, одоо Энэтхэгийн эзэн ноён юу хийж буйг хэлж өгчээ Дараа нь Мисирин султан хаан юу хийж байгаа болон Алс холын тэнгис далайн хаад юу хийх гэж буй тухай гэх мэтээр баахан юм. донгосчээ Ярих бүрт нь шинэ гайхалтай юм. мэдэж байна. хэмээн тэдгээр хүмүүс б и ширч байлаа. зарим хүн түүнийг мадлахыг оролдовч мань хүн тэгүүлэх гэж санахгүй асуудал бүхэнд бэлэн зэлэн хариу өгч бүрэн итгэлтэй байхыг нь яана . Энэ мэтээр үргэлжлэх юм. бол миний бие давуу байдлаа төдхөн алдаж тэр гайхал хамаг юм. эзэлж би хов хоосон үлдэж мэдэхээр байлаа. тийм учраас түүний тэрэгний д у гуйн хигээсэнд аль болох бушуухан мод хийж зогсоох хэрэгтэй байлаа. Тэгээд би

- Нэг хүн одоо юу хийж байгаа бол, мэдэхсэн гэ в

- Асуу, асуу Бүү зов, би одоохон хэлээд өгнө

- хэлэхэд ягүй байх шүү Тэр ч байтугай хэлэх боломжгүй

- миний а вьяас урлаг боломжгүй гэхийг мэддэгүй юм. Асуудал хичнээн хэцүү болох тусам би төчнөөн дуйтай хариулдаг юм. би хүмүүсийн сонирхлыг татах гэж л тэгж асуусан юм даа Тэр зорилго маань ч биелэв бололтой Эргэн тойрон байсан хүмүүс чих та ви н шил сунган амьсга а юугаа даран сонирх ож гарав Нэгэнт сон ирх лын нь татсан хойно одоо тэрний нь шатаах хэрэгтэй байлаа.

- Хэрэв та андууралгүй, хэрэв та зөв хариулж чадах юм. бол би танд хоёр зуун мөнгөн зоос өгье

- Тэ р мөнгө ч минийх болжээ. Таны мэдэхийг хусэж байгаа бүхний чинь хэлээд өгөмз

- Тэгвэл би одоо баруун гараараа юу хийж байна.

- Аа хүмүүс бүгд ер бусаар гайхжээ эндээс түмэн бээрийн бус зайтай газар оршиж буй хүний тухай асуух ухаан тэр олон хүний нэгний нь ч толгойд орсонгүй Илбэч баахан балмагдаж, хэн ч түүнд ийм асуудал тавьж байгаагүй нь илт байлаа. Яаж мултрах аргаа мэдэхгүй барьц алдаад ганц ч үг хэлж чадахгүй болов.

- Та юу хүлээгээд байна. Та чинь Энэ хорвоогийн нөгөө нэг захад байгаа хүний юу хийж байгааг ямар ч бэлтгэлгүйгээр шууд хэлж чаддаг гэх мөртлөө Өөрөөсөө хэдхэн алхмын зайтай байгаа хүний юу хийж буйг хэлж мэдэхгүй байна. гэж үү дээ? миний ард зогсож буй хүмүүс намайг баруун гараараа юу хийж байгааг харж байна., хэрэв та зөв хэлэх юм. бол батлаад өгнө гэж би хэллээ мань хүн дуугүй байсаар а ва й .

- за би хэлээд өгье та мэдэхгүй учраас л дуугүй байна шүү дээ ийм илбэч гэж хаа байх вэ? Нөхөд минь энэ бол тэнүүлч хууран мэхлэгч худалч л этгээд Лам нарын урам хугарч айж мэгдэж байна. Тэд бол илбэч нарыг харааж зүхэх зоригтой хүнийг насандаа ч үзээгүй учраас гайтай юм. болно. гэж эмээж байлаа., Амьсгалтай амьд амьтан байхгүй юм. шиг чив чимээгүй болж мухар сүсэгт хүмүүсийн мунхаг ухаанд ёрын муу юм. бодогдож эхэлжээ Энэ хооронд илбэч сэхээ авч тайван жишэмгүй байдлаар инээмсэглэхэд хүн бүхний дотор онгойх шиг болов., яагаад гэвэл нэгэнт инээмсэглэж байгаа хойно сүйдлэхгүй нь гэж бодно

- Энэ хүний үг хэрцгий байна., тэгээд л хэлэх үг амнаас минь герч өгөхгүй байлаа. миний мэтчйн зэрэг зндананы илбэчид бол гагцхүү хаад, хүнтайж, эзун хаад, ер нь алт эдэлж, торгонд хөлбөрөх хувьтай төр сөн дээд язгууртны тухайд л таадаг болохыг мэдээгүй байсан хүн бгйвал мэдэж твсугай их ван Артур одоо юу хийж байна. гэж асуух юм. бол би та нарт х а риу хэл эх байна., харин түүний захиргааны хүмүүсийн явдал мад падгүй гэлээ.

- Өө, тэгвэл би таныг буруу ойлгосон байх нь Таныг чинь ямар ч хүний тухай асуусан болно. гэж хэл лээ гэж дуулсан шүү Тэгэхлээр хүн гэдэг чинь хүн л шүү дээ Бүх хүн л гэж бодсон юм.

- тийм л дээ, аливаа язгуурт хүн, вангийн гаралтай бол бүр ч сайн

- Надад тийм шиг санагдсан юм. ийм гайхалтай авьяас билэг сүр жавхлангийн оргилд төрөөгүй хүмүүсийн ажил төрлийг ажиглах гэж заяагаагүй байлгүй дээ маней Артур ван гэж ширээт лам хажуунаас одоо п маргеаныг зогсоож гал түйтгэрийг зайлуулах бололцоо олдлоо гэж бодох шиг хэлэхэд илбэч үгийг тасалж

- Одоо түүний юу хийж буйг нь мэдмээр байна. уу ? гэв

- Өө, тэгэлгүй яахав, танд их талархаж байна. Дахиад л бүгдээрээ түүний үгийг ам ангайн жигтэй хэн сонирхож эхлэх, ёстой засаршгүй солиотой амьтад шүү Тэд, илбэчийн хөд ө лгөөн бүрийг сэтгэл догдлон харах б өг өөд түүний

- Ван ан а вд явж чилээрхээд ордондоо зүүд ч зүүдлэхгүй хоёр цагийн турш бөх унтаж

байгаа юм байна. гэхэд чи одоо юу хэлэх вэ, хэлэх үг байна. уу, чамд? гэх шиг над уруу харцгаалаа

- Бурхан өршөөг Тэгж унтаад бие сүнс нь бөхжиг гэж ширээт лам өрөөл тавиад загалмайлав

- Ван унтаж байсан бол тийм л байх байлгүй, гэтэл ван маань унтаагүй мориор довтолгон явж байна шүү дээ гэж би хэллээ хоёр их нэртэй, цуутай амьтад мөргөлдөхөд бүгд дахин хиртхийн балмагдаж эхлэв би бас нэр сүрээ хараахан алдчихаад байсан биш болохоор алиных нь үгэнд итгэхээ ч мэдэхгүй эрг ү үтэж байна. Илбэч намайг ярвайн харснаа

- би энэ амьд яваа насандаа гайхалтай олон зөнч мэргэд, илбэч нарыг үзсэн, гэхдээ тэдний ганц нь ч тарнигүйгээр юмны мөн чанарыг мэдэж байхыг үзээгүй гэлээ.

- Та бүх насаараа ой хөвчийн зэлүүд буйд газар байсаар олон юм.наас хоцорчээ би заримдаа тарни үйлдэх боловч тийм өчүүхэн дэмий юмны төлөө үйлаагүйг эндхийн энэ олон ах дүүс андахгүй мэднэ, Ажил явдал доог тохуун дээрээ хүрвэл намайг дийлэх тийм ч амаргүй билээ. Илбэч хар хөлсөө цувуулан зүтгэх дээр хүрэв Ширээт лам, вангийн ахай болон ордныхон юу хийж байна. гэхэд цаадхи нь вангаас дугуугүй ядарсан болохоор бүгд унтаж байна. гэсэн хариу авлаа

- Дахиад худал хэлж байна. зарим нь найрлаж байхад зарим нь ван ахайн хамт давхилдаж байх чинь Тэгвэл одоо ван, ван ахай нар чухам хаашаа явж байна. хэлээтэх дээ? гэж би өдлөө

- Одоо тэд унтаж байна. гэж хэлсэн, харин маргааш давхилдах болно., яагаад гэвэл далайн эрэг рүү явах гэж байна.

- Нөгөөдөр оройн мөргөлийн үед тэд хаана байх бол?

- Камелотоос бүр хойш хол, тэнгис орох замынхаа тэг дунд очоод байх болно.

- Бас мундаг худал хэлж байна.

- бүтэн хагас зуун бээрээр хадуурч байна. Тэд нааш явах аянаа дуусгаад энэ хөндийд ирсэн байх болно.

- Энэ ч бүр ягүй сайхан боллоо Ширээт лам, банди нар сэтгэл нь ихэд хөдөлж байхад илбэч бүр сүйрч гүйцлээ

- Ван ирдэггүй юм. бол би шилбүүр унаад гүймз, ирэх бол чамайг унуулна шүү гэж дээрээс нь би нэмж хэлээд бүр болиож авах нь тэр Маргааш нь телефон станц дээр очиж лавлавал ван замд байдаг хоёр хотыг нэгэнт өнгөрөөд явж байгаа сурагтай Маргааш нь дахиад л утсаар ярьж энэ мэтээр юу болж буйг мэдэж байлаа. Гэхдээ энэ тухайгаа хэнд юу гэж хэлэх билээ. Нөгөөдөр нь авсан мэдээнээс үзвэл Ямар нэгэн саад гарахгүй бол үдээс хойш дөрвөн цаг гэхэд хүрч ирэх байлаа. гэтэл сүмийнхэн ванг угтах талаар ямар ч бэлтгэл хийгээгүй байгаагий нь бодоод би үнэндээ их гайхсан Бодвол өнөөх илбэч л намайг дөнгөх санаатай байснаас болов. уу даа гэж санасан маань яг тийм байлаа. би нэг найз бандиас асуувал үнэхээр нөгөө илбэч тарни үйлдэж ордныхныг хаашаа ч аян зугаалга хийлгүй Гэр орондоо байхаар болгосон гэжээ Энэ оронд алдар нэр гэдэг хэр зэргийн үнэ цэнэтэй байдаг эсэхийг

өөрсдөө бодоод үз л дээ Тэдний яг харж сонсож байхад нь миний бие түүхэнд үл дурдсан хамаг бүх гайхамшгаас хол давуу гайхамшгийг үйлдээд үзүүлээд өгсөн байхад л, ёстой үнэ цэнэ, үнэн мөн чанар нь ажил хэрэг дээр дороо батлагдсан тийм гайхамшгийг бүтээгээд өгсөн байхад л ямар ч баталгаа нотолгоогүй гагцхүү өөрөө үнэн гэж хоосон хэлэхээс цаашгүй, хүч чадлаа өөр юугаар ч нотлож үл чадах өөдгүй нэгэн зальхай этгээдийн төлөө надаас урвахад хэзээд бэлэн байдаг байна шүү дээ Ямар ч байлаа. гэсэн ванг сүмд гэнэт ирэх гэж байхад баяр ёслол, сүр бараагүйгээр байна. гэдэг бол тэнэг хэрэг, тийм учраас миний бие мөргөлчдөөс жагсаал зохиож бас хэдэн аглагчийг нүхнээс нь утаж гаргаад тэдэнтэй хамт ванг угтахаар өдрийн хоёр цагт гаргалаа Өөр ванг угтсан хүн ер байсангүй миний бие хамба ламыг байшингийн тагтан дээр гаргаж улсын эзэн сүм үрүү орж байгаа, түүнийг ганц ч лам угтаагүй байгаа, сүмийн хашаа хороо нэн эл хуль байгаа, ядаж хонх нь ч дуугарахгүй байгааг харуулбал ширээт лам уур хилэн эгдүүцсэн хоёроосоо болоод хэл нь гацаж байлаа. хамба хармагцаа л хар хурдаараа хөл мэдэн харйлгах нь тэр Ганц минутийн дараа хонхнууд солирсон мэт жингэнэлдэж эр эм лам нар гүйлдэн гарч загалмайтны жагсаалаар жагсав . Тэдний хамт нөгөө илбэч ч гарч ирлээ Ширээт ламын зарлигаар түүнийг шилбүүр у нуулсан байх бөгөөд түүний нэр алдар шаварт унаж байхад минийх тэнгэрт тулам мандаж байлаа. тиймэрхүү газар явж байсан ч худалдааныхаа нэр төрийг бодож байх хэрэгтэй, гэхдээ чингэхийн тулд ямагт хөдөлмөрлөж ямагт сонор сэрэмжтэй, хэр баргийн юманд давагдахааргүй бэлтгэлтэй байх хэрэгтэй юм шүү

Хорин тавд уг а ар бүлэг

УРАЛДААНТ ШАЛГАЛ Т

Ван зугаа цэ н гэл хөөж орон нутгаар аялах буюу аль нэг хол нутаглах хошуун ноёныхоор айлчлахаар очиж цөлмөхдөө орд х а вийнхаа өдий төдий том түшмэдийг дагуулан явдаг ажээ. Тэр үеийн заншил нь тийм байсан юм. Энэ удаа ч гэсэн вангийн хамтаар Онгодын Хөндийд тусгай комисс хүрэлцэн ирсэн нь армийн дарга нарт нэр дэвшсэн хүмүүсийн мэдлэгийг шалгах даалгавартай байлаа. Яагаад гэвэл тэд энд байхдаа ч өөрцгүй тэнд байх лугаа адил амжилттай ажиллах ажээ. Ван энэ удаагийн аяллыг сэтгэл сэргээхэд зориулсан боловч өөрөө бас ажил хэргээ явуулсаар байв. Тэр бол муу юмтай ямагт тэмцэж байсан хүн юм.

Ванлагийнхаа дотор дээд шүүгч нь байсан болохоор мань хүн өглоо болгон үүрээр үүдэндээ суугаад хэрэг шүүдэг байлаа. Шүүх ажлаа тун амжилттай гялалзуулдаг байсандаа Угаас мэргэн, хүнлэг чанартай хүн болохоор ухааныхаа хэрээр хэргийг шудрагаар шийдэхийг хичээдэг байв. гэтэл ийм тайлбарын цаана их юм. бий л дээ Түүний гаргасан шийдвэрт хар багынх нь хүмүүжлийн ул мөр харагдах нь цөөнгүй Хэрэв тайж, эгэл ард хүн хоёрын хоорондын маргаан байх юм. бол өөрийн мэдэлгүйгээрнэг мэдэхнээ тайжийн талд л заавал байх жишээтэй Өөрөөр ч байх аргагүй юм даа Боолын ёс бол боолын эздийн ёс суртхууныг мулгуу муйхар болгодгийг хүн болгон мэдэх бөгөөд тайж язгууртан нар бол өөр л нэртэй болохоос биш боолын эздийн холбоотон шүү дээ Ингэж хэлэх чихэнд чимэг муутай боловч хэн ч гэсэн бүр тайж язгууртан ч гэсэн гомдох ёсгүй, яагаад гэвэл би биетэй бодитой баримт л дурдаж байгаа юм. Иймээс уг баримт заримд нь гомдмоор санагдаж болох юм шүү Боолын ёсны мөн чанарыг бид зэвүүцдэг болохоос биш нэрийг нь тэгдэгтээ биш Тайж язгууртан хүн доорд ангийнхны тухай ярьж байгааг нь сонсоход л түүний үг нь ялимгүй зөөлөрснөөс биш яг л боол эзэмшигчийн яриа байдаг шүү дээ Тэгэхлээр боол эзэмшигчийн хэлний цаана боол эзэмшигчийн санаа, боол эзэмшлийн ёсонд мулгуу муйхар болсон сэтгэл нуугдаж байгаа шүү дээ хоёр тохиолдлын алиных нь ч шалтгаан нэг л байна. өөрийгөө дээд үүлдрийн төрөлтөн гэж мах ясандаа эртнээс шингээсэн дарлагчийн архагшсан заншил байгаа юм. Вангийн шийдвэр шударга биш байх нь олонтоо тохиолдох авч буруу нь гэвэл хүмүүжил, түүний зүй ёсны бөгөөд хувийнгүй алагчлан талархах үзлийн уршиг билээ. Өлсгөлөн жилүүдэд хүүхдэд сүү хуваарилахдаа өөрийнхдөөл илүү өгдөг шиг ван шүүгчийн үүрэг г үйцэтгэхдээ мөн тийм байж таарахгүй юм. Нэг удаа ван нэлээд сонирхолтой нэгэн хэргийг шийдэх болов. их хөрөнгө, газартай залуухан өнчин хүүхэн хоосон залуутай суужээ хүүхний өмч нь сүм хийдийн феодалын хараат байдалд байж Орон нутгийн жасын хамба тайж язгууртай ихэмсэг яравгар нэг гэлэн тэр хүүхнийг сүмд мэдэгдэлгүй нууцаар гэрэлсэн, тийнхүү сүмийг эзний эрх хэмээгчээс салгав гээд хөрөнгий нь хураахыг шаарджээ Тэр эрхээс нь татгалзсан юм. уу , зайлсхийсэн байвал тийм хүний хөрөнгийг хурааж авах ёстой юм. байж хүүхэн өөрийгөө хамгаалахдаа тухайн тохиолдолд эзэн ноён биш хамба лам байгаа учраас тэр эрхийг эзнээс өөр хэн ч эдлэх ёс г үй, хэнд ч шилжүүлэх ёсгүй хэмээн мэтгэж байсан бөгөөд түүнээс бүр эртний гаралтай мөртлөө сүм хийдийн зүгээс тогтоосон бас нэг хуулийн ёсоор бол хамба ламд тийм эрх эдлэхийг эрс хориглосон хууль байв. Уг хэрэг нэлээд будлиантай байжээ. Тэр хэрэг миний бага байхдаа Лондоны хотын зө в лөлийн гишүүд Меншенхаузыг байгуулахын тулд заль зохиож мөнгө цуглуулсан тухай уншсан нэг өгүүллийг санагдуулсан юм. Англикан шашны ёсоор сахил хүртээгүй ганц ч хүн Л ондоны шүүхийн ажилтан болох эрхгүй байжээ. Тэгэхлээр сонгуулиар дэвшсэн бурууно мын хүн ч гэсэн шерифын албанаас арга буюу татгай захад хүрдэг байж хотын зөвлөлийн гишүүд зүсээ өөрчилсөн янки нар ийм нэг заль

хэрэглэсэн байна. Үүнд шерифын албанд нэрээ дэвшүүлэхийг татгалзах хүнийг дөрвөн зуун паундаар, харин сонгогдсон атлаа тэр албанаас татгалзсан хүнийг зургаан зуун паундаар тогтоож байх хууль гаргажээ Тэгээд тэд буруу номтонгуудыг олноор сонгож тус,бүрээс тогтоосон торгууль авсаар арван таван мянган паунд болгоод түүгээрээ өдгөө сүндэрлэн харагдах сүрлэг М е н ш е н Хаузыг бариулсан нь түүнийг харж царай нь улайх иргэн бүхэнд энэ бол эрт урьдын гунигт явдлын хөшөө хэмээн санаж Лондонд шургалан орсон бүлэг дээрэмчин янки ов мэх зохиож байснаар өдгөө дэлхийн бүх шударга хүний дотор тийм луйварчны бузар нэрийг олгосон болохыг санадаг юм. миний бодоход хүүхнийх зөв мэт санагдах боловч хамба ч бас хувьдаа зөв юм. Ван тэр байдлаас хэрхэн гарахы нь би ухаараагүй Гарах аргаа олжээ, олохдоо яасан гээч

- энд хэцүү юм. ер алга, ийм хэргийн учрыг нялх хүүхэд ч олно Хэрэв хүнд очих хүүхэн үүрэг ёсоороо өөрийн феодал ноён захираги, хлмгаалагч хамбадаа цаг тухайд нь гэрлэх гэж буйг а а мэдэгдсэн бол ямар ч хохиролгүй өнгөрөх байсан, яагаад гэвэл нэр дурдсан хамба нь ёнзон хамбаас дээр дурдсан эрхийг түр эдлэхээр байсан бол хүүхний эд хөрөнгө өөрт нь үлдэх л ажээ. Анхдугаар үүргээ биелүүлээгүй тэр хүүхэн бүх талаар буруутан болжээ., яагаад гэвэл оосроос барьж буй хүн барьж буй гарынхаа дээхнүүр оосроо огтлох юм. бол гарцаагүй ойчно шүү дээ Тэгээд үлдсэн хэсэг нь бөх бат гэж хичнээн өгүүлэвч нэмэр болохгүй Тү үн ийг аврахгүй Энэ хүүхний хэрэг ийнхүү уг үндсээрээ буруу байна. хүүхний бүх хөрөнгийг ганц ч улаан зоос үлдээлгүйгээр дээр дурдсан хамбад шилжүүлж шүүхийн зардлыг хүүхнээр төлүүлэх шийдийг гаргасан байлаа. Тийнхүү залуу хо с янагийн анхны зугаалгын сар эмгэнэлтэйгээр төгсчээ Хөөрхий амьтад х өрөнгө баялгийн амтыг удаан эдлээгүй ажээ. . Сайхан ху вцасласан, хээнцэр эдлэл гоёл чимэглэлийн ё с дагуу сайхан гоёсон залуус байлаа. Эмэгтэй нь сайхан хувцастайгаа эр нөхрийнхөө мөрийг түшин уйлахад цаадхи нь цөхөрч мөхсон байдалтай авч сэтгэлий нь заса х ыг оролдсон үг хэлж байсаар шүүхийн өрөөнөөс гарч толгой хоргодох Гэр оронгүй, өлсгөлөн ертөнцийн хүрээлэнд шилжиж очиход замын дэргэд суух хамгийн гуйлгачин ч гэсэн тэр хоёроос ядуугүй байлаа. Ван тэр будлиантай хэргийн учрыг тийм маягаар нэг болгосон нь сүм хийд болон тайж язгууртан нарт таатай болжээ. Хаант төрийг хамгаалах үнэн мэт гоё үг хичнээнийг ч хэлж болно. Гэхдээ улсын иргэн бүр нь сонгуулийн эрхтэй оронд бол адгуусны зэрлэг хууль байдаггүй гэдэг бол гарцаагүй баримт л даа Артур ван гийн ард түмэн хэмжээгүй эрхт хаант ёсонд ухаанаа мунхартал дэндүү өнө удаанаар талхиулсан учраас бүгд найрамдах улс байгуулахад таарахгүй боловч дөнгөж саяхан вангийн хэрэглэсэн хуулийг хэрэв уг зүйл нь нийтийн чөлөөт сонгуулиас шалтгаалдагсан бол халах ухаан тэр ард түмэнд хүрэлцээтэй байгаа юм. Байнга хэрэглэсээр холбогдол, утга санаа бүхий болсон мэт боловч огт утга учиргүй нэг холбоо үг байдаг, тэр нь ямар үг вэ гэвэл энд тэнд байн байн хэрэглэдэг өөрөө захирах чадал гэсэн үг юм. Үүнд Ямар нэг газар өөрийгөө за хирах чадалгүй ард түмэн байгаа буюу байсан байж магадгүй хэрэг болж байна. өөрсдий нь захирч байгаа буюу захирч чадна гэж үдэг мэргэжилтнүүд шиг үн дэстэн бүхний шилдэг ухаангангууд нь үеийн үед ард түмнээс, ард түмний гүн дотроос төрдөг байсан болохоос биш эрх ямбат ангиудын дотроос гарч байгаагүй билээ. Тэгэхлээр тухайн ард түмний ерөнхий түвшин нь өндөр байсан ч гавихгүй байсан ч авьяас билэг нь нэрд эс гарсан ядуучуудын дотор нуугдаж байдаг бөгөөд тун олон учраас ард түмнийг, өөрийгөө захирахад нь туслах өдөр хэзээ боловч ирэхэд тийм хүнээр дутна гэсэн номгүй билээ. ийм учраас хамгийн сайн, хамгийн гэгээрсэн эрх чөлөөт хаант ёсны төр ч гэсэн ард тү мэнд өөрийнх нь захирахаас илүү юм. өгч ердөөч чадахгүй юм. Ялангуяа эрх

чөлөөгүй, гэгээрээгүй хаант төрийн тухайд бүр ч ярих юм. алга л даа Артур ванг армийн талаар тийм яаралтай арга хэмжээ авна гэж би огт бодоогүй байсан юм. Намайг эзгүй хойгуур тийм ажлаас барьж авна гэж бодоогүй байсан болохоор цэргийн дарга болохыг хүсэгч бүхэнд тавих шаардлагуудаа бэлтгэж амжаагүй байлаа. Дарга болох улсыг тун хатуу шалгах хэрэгтэй гэж л хэлж байсан миний цэргийн Академийг төгссөн хүн л эзэмшиж чадах цэрэг дайны эрдэм мэдлэг шаардана гэж дотроо бодож байсан юмсан Явахаасаа өмнө шалгалтынхаа программыг боловсруулж өгөөгүй минь дэмий болжээ. байнгын арми байгуулах санаа ванд туйлын чухал санагдсан тул мань хүн хүлээж чадалгүй гардан хийж эхэлсэн байна. Өөрийнхөө чадах хэрээр л нэг программ боловсруулж л дээ Тэрэнтэй нь бушуухан танилцаж шалгалтын комисст миний оруулах гэж бодож байсан программаас хичнээн дор болохы нь нотлохы г би тэвчин ядан хүлээж байсан юм. Энэ тухайгаа ванд аядуулан хэлэхэд ван Өөрөө их л сонирхож байлаа. Комиссынхныг цугламагц вангийн дараахан би очиж, дараа нь дарга болох санаатай хүмүүс ирэв Тэдний нэг нь миний цэргийн Академийг төгссөн залуухан тун сайн оюутан хоёр профессор дагуулсаар ирсэн байв. Комиссынхныг үзээд би уйлах инээх хоёрынхоо алиныг ч мэдээгүй юм. Дарга нь мэдээ дамжуулагч гол зарлага байлаа. Комиссын хоёр гишүүн нь түүний хэлтсийн, тасгийн эрхлэгчид байх юм. Уншиж бичиж чаддаг хүн гэвэл лам хүн байдаг болохоор тэр гурвуул лам байлаа. Намайг хүндэтгэж миний дэвшүүлж буй хүнийг дуудлаа Комиссын дарга их л сүрлэг байдлаар асуулт тавьж эхлэв

- Нэр хэн?

- Мализ Хэний хүү вэ?

- Вебстерийн

- Вебстер, Вебстер Хм тийм нэр санахгүй байх чинь юу болж байна. Цол хэргэм нь ?

- Нэхмэлч

- Нэхмэлч ий? Бурхны минь аврал Ван жигтэйхэн хиртхийж, комиссын нэг гишүүн мууран унаж нөгөөдөх нь юу юу гүй унах гэж байв. Комиссын дарга сэхээ орж зэвүүрхэлтэйгээр

- Боллоо, эндээс бушуу тонил гэлээ. гэвч би ванд хандаж миний нэр дэвшүүлсэн хүнийг шалгалтад оруулаач гэж гуйлаа Ван зөвшөөрсөн боловч комиссын бүх гишүүн дээд язгууртангууд сүрхий амьтад, нэхмэлчний хүүг шалгах тийм доромжлолтой ажлаас биднийг ангижруулж өгнө үү хэмээн гуйв Тэд өөрснөө юу ч мэдэхгүй улс учраас хүнээс ямар балтуушаа шалгалт т авч чадах билээ. тийм учраас би тэдний хүсэлтийг мөн дэмжиж шалгалт авах ажлыг вангийн зүгээс миний профессоруудад даалгах талаар юм. хийгээ би урьда а с нэг хар самбар бэлтгээд байсан болохоор одоо түүнийгээ оруулж ирүүлэн ажиллахыг тушаал болгов шалгалт ч эхэллээ миний тэр залуу, цэргийн шинжлэх ухааны талаартодорхой ярьж, тулалдаан, бүслэлтийн тухай, ханган нийлүүлэх болон цэрэг шилжүүлэн хүч хаях тухай, мин болон эсрэг миний тухай, цэргийн жи ж иг анги, том нэгтгэлүүдийн стратеги, тактик, дохионы апба, явган, морьт цэрэг, их бууны анги, бүслэд болон хээрийн их буу, их бага гарын бууны тух а й, гар бууны тухай хичнээн яруу тод ярих ад чихнээ чимэгтэй байлаа., тэр маанагууд ганц ч юм. ойлгохгүй байлаа. толгой эргүүлэм тоо самбар дээр бичиж Лха тэнгэр нарыг боловч мухардуулах бодлого бодож, нар сар хи ртэх, сүүлт од, нар голлох, од хойг, үд

дундын цаг, шөнө дундын цаг, үдийн хоолны цагийн тухай, ер нь д а й с н ы г тамиры нь барж муугий нь үзээд, хэрэггүй л эднийг довтолжээ гэж харамсан үүлний дээд болон доод талд байдаг юм. болгоны тухай ярьж тооцоолон гаргаж байгааг нь харахад урамтай байв. Ярих юмаа дуусгаад цэргийн хүний ёсоор ёслон хажуу тийш болоход нь би түүнийг бахархан тэврэхэд бусад маань бүр гайхаш барагдан бут ниргүүлээд түүнийг а рхи уусан хүний утгагүй харцаар гөлөрч байлаа. Зорьсон маань нэгэнт бүтэж олонхийн саналаар оруулах боллоо гэж би бүр бодсон билээ. боловсрол гэдэг бол агуу их зүйл юм даа миний академид тэр залуу анх ирж байхдаа Унаж байсан морий чинь дайсан алчихвал ахмад офицер хүн яах ёстой вэ? гэсэн миний асуултад

- Босоод шороо гөвөх ёстой гэж гэнэн хариу өгч байж билээ. Дараа нь нэг залуу тайжийг дуудаж оруулав

- Эрхэмсэг та уншиж чаддаг уу ? гэж намайг асуухад тэр хүн жигтэйхэн уурсан зэвүүрхэж

- Та намайг тахилч ингэж бодоогүй биз? миний судсаар урсдаг цус тийм ч гэв

- Асуусан асуултад л хариул Тэр хүн уураа арай ядан барьж

- Үгүй гэлээ.

- Бичиж чаддаг уу ? Бас л омогдох санаатай зэхэхэд нь би

- Асуусан асуултанд л хариул, илүү өөр төөр юм. бүү яриач Та энд өөрийн цус, гарлаар гайхуулах хэрэггүй, энд тэгүүлэх газар биш, бичиж чаддаг уу , үгүй юу ?

- Үгүй

- Үржүүлэхийн хүснэгт мэддэг үү?

- Та юу асуугаад байна., ойлгохгүй байна шүү

- Есөн зургаа хэд болох вэ?

- Энэ бол надаас нуугдсан нууц, яагаад гэвэл миний бүх амьдралд түүнийг мэдэх хэрэгцээ гараагүй, нэгэнт хэрэгцээгүй болохоор нь мэдэх гэж оролдсон ч үгүй

- Хэрэв А, Бушель нь хоёр мөнгөний үнэтэй нэг торх сонгиноо дорвөн мөнгөний үнэтэй хонь , нэг мөнгөний үнэтэй нохой хоёроос арилжаад, нохойг нь худалдан авагчид хүргэж өгөхийн өмнө алчихвал, яагаад алчихсан бэ гэхэд нохой нь Сыг Д гэж бодоод урчихлаар нь алчихсан байг, тэгвэл В нь ад аа хичнээн өртэй болох вэ? Нохойн ө ртгийг С, Д хоёрын аль нь төлөх ёстой вэ? Тэр мөнгийг хэн нь авах ёстой вэ? Хэрэв тэр мөнгийг авах ёстой болбол нохойн үнэ болох нэг мөнгөнд сэтгэл нь ханах уу , аль эсвэл нохой өөрийнх нь өмч болсны хойно оруулах ёстой орлогын үнэ өртөг гэж нэмэлт юм. шаардах ёстой юу ?

- Ертөнцийг нууцаар захирч байдаг жинхэнэ мэр гэнээс мэргэн дээрээс буушгүй тэнгэрлэг зөн билэг бол хүнд иймэрхүү асуулт хэзээ ч т авихгүй, энэ бол хүнийг төөрөгдүүлж ухаан санаагий нь самууруулах гэсэн ганц зорилготой асуулт байна. ийм учраас та тэр хачин бөөгийн нэр устай нохой, сонгино, хүмүүсийг өөрсдийнхөө тэр гайхмаар хөөрхийлөлтэй, арчаагүй төөрөгдлөөсөө миний туслалцаагүйгээр гарч үз гэж орхисон дээр байх, яагаад гэвэл

хэрэв би тэдэнд туслахаар оролдох юм. бол уг хэргийг улам будлиулаад тэднийг оруулах гасланд байдлын улмаас би өөрөө ч мэнд мултран гарахгүй болж мэдэх нь

- Та таталцах, түлхэлцэх хүчний хуулийн тухай юу мэдэх вэ?

- Хэрэв тийм хууль байгаа бол эрхэмсэг ван ноён маань намайг энэ оны эхээр хэвтэрт ороод юу ч сонсох бололцоогүй байсан тэр хойгуур гаргасан юм. байлгүй

- Та оптик шинжлэх ухааны талаар юу мэдэх вэ?

- би төлөөний амбан сайд нарын муж, шилтгээний захирал, гүнлэгүүдийн шериф нары г мэднэ, бусад арай бага шиг олон алба, тушаал хэргэм мэднэ, харин таны тэр Оптик гэж хүндэтгэн нэрлэж байгааг чинь хэзээ ч сонсоогүй юм байна., бодвол шинэ хэргэм байж таарах нь ээ гэлээ. .

- тийм ээ, энэ л орны хувьд ийм нялцгай биет нялаахай л цэргийн цол хүртэх билээ. хэмээн омог бардам аашилж байгаагий нь бодоод үз л дээ Түүний авьяас нь гагцхүү бичгийн машин балбахад хүрэлцэх нь юу байдаг бол гэхдээ тийм юм. сурахын тулд бас хэл зүйн болон цэг тэмдгийн талаархи шинэ хуучин зүйл саад болоод байх байлгүй. Тэрээр битүү ой шугуйгаас мангас эрж хайн давхих тэмцээнд хэрхэн үзэлцэх гэх мэтийн харанхуй бүдүүлэг юм. ярьсан нэгэн байлаа. Дараа нь бас нэг язгууртан залууг дуудаж оруулав. Тэр нь түрүүчийнхээсээ авьяасгүй юу ч мэдэхгүй байв. би тэр хоёрын хөг өнгөрлөө гэж бүрэн итгээд хоёуланг комиссын гишүүдийн мэдэлд үлдээв.

Комисс тэр хоёрыг дахин шалгав.

Нэр алдар хэн билээ..

Пертиполь, Пертиполь ноёны хүү, барон ноён Солод

Өвөө чинь :

Пертиполь ноён, барон ноён Солод

Элэнц чинь :

Нэр алдар цол хэргэм нэгэн адил

Хуланц чинь :

Хуланц байгаагүй манай овог тийм олон үе дамжаагүй

Тэр яах вэ дөрвөн үе байхад үндсэн болзол хангалттай байна..

Юун болзол гэж би асуулаа

Нэр дэвшигдсэн хүн бүрийн удам судар нь дөрвөн үе дамжсан тайж язгууртай байх ёстой. Тэгвэл дөрвөн үе удам тайж язгууртан биш бол цэргийн дэслэгч болж болохгүй хэрэг үү Хэрхэвч үгүй дэслэгч болж болохгүй ер нь ямарч дарга болж болохгүй. за би мэтгэхээ болиоос өөр арга алга. Тайж язгууртны хэрэг эрхэлсэн комиссын дарга та цааш нь үргэлжлүүл дээ гэлээ..

Таны их язгуур удмынхан хаан ширээ болон эзэн хааны алдар нэрийн төлөө ямар гавьяа байгуулж британы тайж хэмээх эрхэм ариун цол хүртэхэд хүрсэн бэ? гэж дарга асуув

- Пиво эсгэх газар байгуулсан

- Эзэн хаантан, энэ хүн бүх шаардлагыг хангаж цэргийн дарга болох бүрэн чадвартай юм байна., харин эцсийн шийдвэрийг үүний өрсөлдөгчийг шалган байцаах хүртэл хойшлуулна Өрсөлдөгч нь урагш гарч ирээд мөн л дөрвөн үеэрээ тайж язгууртан байсан гэдгээ нотлов Тэгэхлээр хэнийх нь цэрэг дайны мэргэшил илүү байх нь вэ? Энэ адармаатай зангилааг тайлах тун амаргүй байлаа. Түүнийг хажуу т ийш болоход комиссын дарга нь Пертиполь ноёнд хандаж

- Танай удмыг үндэслэгчийн хатагтай я мар язгуурын хүн байсан бэ? гэж асуулаа

- их баян чинээлэг боловч тайж биш Тэр бүлээс гаралтай байсан гэнэлээ Үзэсгэлэн гоо, цэвэр нямбай, угсал зөөлон ааш зантай, бүх насандаа өө сэвгүй явсан болохоор тус орны хамгийн дээд язгуурт хатагтай нартай мөр зэрэгцүүлж болох юм.

- за болно., болно., зай болж үз . Дарга хоёр дахь тайжийг дуудан асуув

- Танай их овгийг үндэслэсэн бөгөөд тайжийн зэрэг хүртэж байсан хүний чинь , гэргий, таны хуланц эмэг чинь ямар язгууртай буюу цол хэргэмтэй байсан бэ?

- Вангийн нууц амраг байсан ба тэр гялалзсан байдлаа бусад хэний ч туслалцаагүй гагцхүү өөрийнхөө хувийн чанараар олж авсан бөгөөд тийнхүү анх төрсөн муу усны суваг шуудуунаасаа дээш гарсан хэрэг юм.

- Аа, энэ чинь жинхэнэ тайжийн язгуур байна шүү таны судсанд ван нарын цус гүйж байна. даа Ариун лорд танд дэслэгчийн цол хүртээсүгэй Та битгий голоорой Энэ бол таны дээд гаралд таарах цаашид илүү их хүндэтгэлд хүргэх анхны алхам юм шүү би ёроолгүй их ан цав шиг доромжлолд өртлөө Уг нь нүд гялбам гялалзсан амжилттай болно. гэж бодож байсан маань бүгд ийм байдлаар төгсөх нь тэр доромжлуулж муугаа үзэж буй шавийнхаа нүүрийг ч харж чадамгүй их ичлээ Гэртээ хариад тэвчээртэй хүлээж л бай, ингээд төгсөхгүй гэж би түүндээ хэллээ би вантай хувиараа уулзаж шинэ санал тавилаа хорооны дарга нарт гагцхүү тайж нарыг томилдог тань хамгийн мэргэн шийдвэр гэдгийг би зөвшөөрөөд тэр хороонд бас т а ван зуу орчим тайж д а р гаар то милж бүр ч тийш нь е рөөс вант улсын харьяаны бүх язгууртанг тэдний төрөл саданг бүгдий нь томилбол муугүй юм. болох юм байна. Тэр хорооны дарга нар нь цэргээсээ тав дахин олон байсан ч муугүй хэрэг болно. Тэр хороо цэрэг вангийн хувийнх нь хамгийн өнгө жавхаатай, хамгийн ихээр нийтийн атаа жөтөөг өдсөн, хэзээ хаана дуртай цагтаа дайн хийж байдаг, хэнд ч захирагддагүй, бүр биеэ би гэсэн тийм хороо болог, Тайж нар бүгд тэр хороонд маш дуртай алба хааж бүгд сэтгэл хангалуун, аз жаргалаа эдэлж байг Харин байнгын армийнхаа бусад хэсгийг нэлээд эгэл хүмүүсээс бүрдүүлж дарга нараар нь гагцхүү цэрэг дайных нь бэлтгэлийг харгалзан дээд удам төрөлгүй хүмүүсийг томилоё, тийм хороог маш хагуу сахилга багтай байлгаж, тайж язгууртны ямар ч эрх ямба дураараа аашлах явдлыг эдлүүлэхгүй, байнга сургууль дасгал хийлгэж байя Эрхэм ван өөрийн тань хороо алжаагаад юм. уу , ер нь өөр бусад юм.аар оролдох дур хүрч мангастай тулалдах, ан авд мордох болбол ажил хэрэг, улсын аюулгүй байдал найдвартай гарт байгаа гэж хатуу итгэн тэр дуртай ажилдаа санаа амар явж байг л даа гэхэд ван миний энэ санаанд

бүр биширсэн байлаа. Тэгж бишрэн сайшааж байгааг нь мэдээд миний бие бас нэг чухал санаа гаргалаа . Аль эртний бөгөөд ихээхэн адармаатай нэг зорилтыг одоо л нэг т ийш болгож болох нь гэж би бодлоо Вангийн удам судар Пондра гоньхон бол маш олон үе улирсан, үр сад гэж тоймоо алдсан овог байсан юм. Тэдний аль нэгэнд хүүхэд төрөх явдал тун элбэг байсан тул тэр болгонд бүх улс үндэстэн өнгөн дээрээ баярлалдавч зүрхнийхээ угт гонсойдог байжээ. Вангийн бүлд шинэ хүн нэмэгдэхэд алба гувчуур шинээр нэмэгддэг учраас гонсойж урам гутрах нь мөн үнэн боловч зөвхөн өнгө нүүрний үзэмжийн төдий баяр хөөр болох нь чин үнэн юм. Вангийн овгийнхны нэр усыг жагсаавал учиргүй их урт юм. болно. эд үргэлж олширч улсын санд хүнд дарамт болж вангийн засаг төрд ч аюул занал учруулдаг болжээ. гэтэл вангийн фондыг өөрчлөх янз бүрийн төс ө л оруулахад ван тийм юм. болж буйд итгэхгүйгээр үл барам сонсохыг ч хүсэхгүй байлаа. холынхоо садангуудад өөрийнхөө хувийн сангаас хааяа ч болтугай тус болгож байх нь зүйтэй юм. гэдэгт ванг итгүүлж чадах аваас ард түмэнд тун сайн сэтгэгдэл төрүүлэх байлаа., гэтэл энэ талаар ван үг дахин сонсохыг ч хүсэхгүй байв. Ван фондоо бараг л шашны дайтай хүндэлнэ Фондоо Ямар нэг ариун олз гэж үзээд тэр эрхэм хүндтэй юманд нь хүрэх гэсэн өчүүхэн оролдлого илэрвэл галзууртлаа уурладаг байв. Англид гуйлга гуйн малгалгаа тосдог өөрийгөө до ромжилдог ганц ч айл г эр байдаггүй юм. гэж хүртэл би бүр, улаандаа тулан болгоомжтойхон хэлэхэд ван миний үгийг нэлээд ширүүнээр тасалж ер яриулдаггүй байсан юм. гэвч би зорьсондоо хүрэх нь гэсэн горьдлого гэнэт төрж билээ. Тэр сайхан хороо цэрэг гэгчий нь ганц ч жагсаалын цэрэггүйгээр дан дарга нараар байгуулахаар шийдэв хорооны бүрэлдхүүний дундуур нь хошууч генерал хүртэлх бүх цол хэргэм эзэлсэн тайж нар байх ба тэд үнэ төлбөргүй алба хааж өөрснөө зардлаа гаргах, нөгөө хэсгий нь гагцхүү ариун цустан хэмээгчдээс бүрдүүлэх тул тэд мэдээж баяртай байх болно. Тэр ариун цустангууд дэслэгч генералаас фельдмаршал хүртэлх цол эдэлж өндөр цалин авч хоол, хувцас сангаас хэрэглэнэ Түүнээс гадна хамгийн гол нь тэр хороонд алба хаа хыг зөвшөөрөх цусны хунтайж нар нь сонсохоос сүрдэм гуншин би тийм гуншин цол зохиоё гэж бодсон хүртэх бөгөөд тэд л тийм гуншин цол эзлэх эрхтэй байх болно. Цусны хунтайз нарын өмнө шилж сонгох ажил гарах байлаа. эсхүл тэр хороонд орж хамгийн сүртэй гуншин цол хэрэглэж вангийн фондноос юм. хэрэглэхгүй болох, эсвэл фондноос юм. хэрэглэж хороонд орохгүй, цол гуншин хэрэглэхгүй байх ёстой байлаа. Тэгэхлээр хараахан төрөөгүй боловч төрөхөд бэлэн цусны хунтайз нарыг эцэг эхийнх нь хүсэлтээр хороонд бүртгэн авч болох байсан бөгөөд тэднүүс нь ертөнцөд мэндлэв үү, үгүй юу их цалин, өндөр цол гуншин эдлэх байв. хунтайз нар бүгд хороонд орно гэдэгт би эргэл з эх гүй байсан болохоор бэлэн буй бүх фондыг халж, шинээр төрөгсдийг бүгдийг нь хороонд урьдаас бүртгэн а вч байх болно. гэдэгт эргэлзээгүй хоёр сар дөнгөж өнгөрөх ө д оангийн фонд байхгүй болж инээд хүрмээр хачин юм. болоод өнгөрсөн үеийн марзан юмнуудын дотор зохих байр сууриа эзлэх юм.

Хо рин зу ргаадугаар бүлэг

АНХНЫ СОНИН

би энгийн хувцас өмсөн хөдөө явж хүмүүсийн амьдралтай ойр дотно танилцах аянд гармаар байна. гэж намайг хэлэхэд, ван даруй тэр бодлогын шинэ сэргэгт жигтэйхэн сонирхож, чамтай хамт явна, хэн ч намайг хориглож чадахгүй гэв, Тэр төлөвлөгөө тун таа лагдсан учир хамаг ажлаа одоохон орхиод явна гэж байлаа. Одоо даруй явья гэж дэвдэгнэхэд нь , тэгж болохгүй гэж би зөвлөө Шарлагаа өвчнөө эдгэрмэгц явна гэдгээ бүр товлочихоод

байсан хийгээд тийм юм.ан дээр хуураад дэмий тул чухам ганц шөнөөс илүүгүй саатах болоод байсан нь бүр ч горьгүй байлаа. Түүнээс гадна явах гэж байгаа тухайгаа ван ахайд урьдчилан мэдэгдэх нь зүйтэй гэж би бодсон Энэ тухай ванд хэлбэл вангийн урам нь хугаран царай нь хувирав Ван ахайн тухай дурссандаа, ялангуяа вангийн ярьсныг бодохоос би түүнийг өрөвдөж билээ.

- Ланселот энд үлдэхийг чи мартаж байна. Ланселот энд байгаа цагт ван ахай ванг хэзээ явж хэзээ ирж байгааг огт анзаарахгүй гэж билээ. Ингэж хэлэхээр нь би шууд өөр юм. ярьж эхэлсэн л дээ Гиневра маргаангүй үзэсгэлэн гоо, гэхдээ хөнгөмсөг авгай юм. Надад падгүй юманд би хөндлөнгөөс хэзээ ч ордогүй гэвч хатны араншин зан миний манаанд нийцдэггүй байсан болохоор энэ тухай хэлэхэд надад ичиж зовох юм. алга Эзэн ноён та Ланселот ноёныг хараагүй биз? гэж надаас бишгүй олон асууж байсаан Ганц нэг удаа надаас ванг хаана байна. гэж асууж байсан бол магадгүй би ойр байгаагүй үед л тэгсэн байх Шарлагаа эдгээх бүх нөхцөл байдлыг тун нямбай, зөв бэлтгэжээ Ван хаан ширээндээ залрахад хоёр хажуугаар нь бүрэн хувцастайгаа эгнээ жигдэрчээ домч эмч нарын нэг байсан Маринэл бүхний нүдний өмнө ихэмсгээр зогсох бөгөөд өвчтөн нарыг ванд танилцуулж байлаа. шалан дээр шав шарангуй зүстэй өвчтөн нар үүд хүртэл жигүүрлэн суух нь сууж, хэвтэх нь хэвтжээ . Энэ бүхэн нь тайзан дээр зориуд зохихон мэт харагдавч хэн ч тэгж тусгайлан зохиогоогүй ажээ. Тэнд най ман зуун өвчтөн ирсэн байв. Урьд нь би ийм явдлыг нэг биш үзсэн болохоор надад сонирхолгүй, тун ужиг удаан ажил санагдаж байлаа. би бүр залхаж байсан боловч ёсыг бодож тэйчин суухаас өөр замгүй байв. Эдгэрүүлэх явдал нь юун дээр үндэслэсэн бэ гэвэл тэр өвчтөн хэмээгчдийн дотор өдий төдий худал өвдсөн хүн байх нь вангийн гараас зоос авахын тулд буюу Зоос нь алт учраас долларын гуравны нэгтэй тэнцэнэ Тэр үед энэ оронд тэр алтан зоосоор зөндөө юм. худалдан авч болох бөгөөд авсанд ороогүй амьд яваа хүмүүсийн дотроос шарлагаагаар жил бүр хичнээн хүн өвд сөн болж байсныг санавал улсын санд мөн ч их хүнд болж, зардлыг нөхөхийн тулд татвартөлөгчдийг дахин дахин шахах явдал урган гардаг нь илт билээ. Учир тиймд улсын санг шарлагаанаас эмчлэх аргыг миний бие бодож байв. Адал явдал хайхаар Камелотоос явах аа саа нэг долоо хоногийн урьд би өвчин эдгээх зардлын долооны зургааг улсын санд үлдээж, үлдэх долоо дахь хэсгийг таван центын диц зоос цутгахад зориулж тэд гээрийг шарлагааны хэлтсийн ахлагчийн гарт шилжүүлж цаадхи нь алтан зоосны оронд диц зоос тавин олгох байлаа. Диц бидэнд нэг их байгаагүй ч хүрэх бол уу гэж би найдаж байсан юм. мөнгийг хуурамчаар хийхийг би огт үл сайшаадаг хүн билээ. гэвч тэр тохиолдолд бол зовох хэрэггүй, яагаад гэвэл зүгээр л бэлэг зэлгийн холбогдолтой байсан юм. Дарсыг бэлгэнд өгөх дөө бага зэрэг шингэлж болдог, би мөн хэзээ ч ингэдэг Улс орны дотор эргэлтэнд байсан хуучин алт, мөнгөн зоосны гаралүүсэл голцуу мэдэгдэхгүй аж Тэнд ром зоос үзэгдэж байв. Тэдгээр нь ойвон цойвон хэл бэртэй, тэргэл сар долоо хоногийн дараа ямар шиг бол дог вэ тиймэрхүү л байна. Тэрийг цутгаж хийгээгүй давгаж хийсэн бөгөөд хэрэглэгдээд туйлын их удсан учир дээрх бичиг нь зөвхөн сараачиж зурсан мэт, үг үсэг нь огт мэдэгдэхгүй болжээ. Нэг талдаа ван, нөгөө талдаа Гиневрын нэлээд тод дүрстэй бөгөөд бас аятайхан үсэгтэй тийм диц зоос маань бүрэн жинт ар а в т ын зоосноос шарлагаатнуудад илүү аятайхан санагдах байх гэж бодсон маань үнэхээр тийм болов. Тэр бүлэг өвчтөнд анхныхаа зоосыг туршсан маань их л амжилтт ай болов. Арвилан хэмнэлт нэлээд гарсан тоо бари мт дурдъя Найман зуун өвчтөний долоон зууд нь ван адис хүртээсэн, энэ нь түрүүчийн үнэлгээгээр улсын сангаас хоёр зуун дөчин доллар зарлаа гэсэн үг, Шинэ үнэлгээгээр бид гучин таван доллар зарж ганц удаагийн ажиллагаагаар хоёр зуу гаруй доллар хэмнэлээ Энэ

өөрчлөлтийн бүх ач тусыг ойлгохын тулд дор дурдсан тоо баримтыг ан хаарч үзэх хэрэгтэй Тус орны хүн амын хүн бүрийг насанд хүрсэн эр гэж бодвол үндэсний засгийн газрын жилийн зардал нь бүх хүн амын гурван өдрийн дундаж цалинтай тэнцүү Нэг хүн нь өдөрт дунджаар хоёр долларын цалинтай жаран сая хүн бүхий улсыг аваад үзье Гурван өдрийн нийг цалин нь 360 000 000 болно. ийм мөнгөөр засгийн газрын хоёр жилийн зардлыг таглаж болно. миний үед эх оронд маань тийм мөнгийг гаалийн аргаар хурааж олдог, х а р и н хүн ам нь тэр мөнгийг таваар тээж ирдэг гадаадынхан төлж өгч байна. гэж ухаардаг байсан, тэгж санаа нь амардаг байж Үнэн хэрэг дээрээ бол тэр мөнгийг чинь амери к ийн ард түмэн өөрснөө төлдөг байсан юм. Тэр их мөнгийг тун зал ьж ин хуваадаг байсан болохоор зуун сая долларын эзэн, хар ажилчны нялх хүүхэд хоёр жилдээ яг адил зургаа зургаан доллар төлдөг байлаа. Иймэрхүү нарийн тэнцэтгэл өөр байдаггүй байх аа гэтэл Ирланд, Шотланд бас Артур вангийн албат байсан учраас Британы ардын нийг хүн ам нь бараг нэг сая байв. Гарын уран дархан хүн өдрийнхөө хоолонд гурван центын хөлс авна Тэгэхлээр үндэсний засгийн газрын жилийн зардал нь ерэн мянган доллар буюу өдөрт хоёр зуун таван доллар байлаа. Тийнхүү шарлагаанаас ангижраах зардалд алтан зоосыг диц зоосоор сольсноор би хэнийг ч гомдоож хэнийг ч хохироогоогүйгээр үл барам, харин ч сонирхогч хүн бүрийн сэтгэлд таалалтай болгож тэр өдөр улсаас зардаг зарлагын тавны нэгийг улсын санд үлдээсэн маань миний үеийн Америкт бол найман зуун мянган доллартай тэнцэх билээ. би тийм өөрчл ө лт хийхдээ маш дээр үеийн мэргэн цэц э н арга ухааныг удирдлага болгосон юм. хүүхэд ахуй цагийнхаа мэргэн ухаан л даа е рөөс төрийн жинхэнэ зүтгэлтэн бол ямар ч гарзлтай байсан аливаа мэргэн ухааныг удирдлага болгох ёстой, миний бие багадаа зэрлэг хүмүүст зориулан элчийн аяганд шиддэг зоосны оронд тосч шидэж хэмнэдэг байсан му н х аг б ал ай зэрлэг э т гээдэд зоос, то вчн ы ялгаа байхгүй байсан юм. гэтэл надад бол зоос нь то вч ноос илүү үнэтэй байлаа. ийнхүү бүгд сэтгэл өөг үлдэж хэн ч хохироогүй юм. Өвчтө н ийг Маринэл хамгийн түрүүн хүпээн а вч байлаа. мань хүн хүн болгоныг шалгаж байв. тохироогүй нэгий нь шууд хөөн гаргаж байлаа. Хувраг е рөөл хэлэхдээ Зовлонд ө ртсөн чамайг мутраар адислан эдгээсүгэй гэж байв. Тэгэхэд ван яр шарханд нь гар хүрнэ Тэгээд эмчилгээ шувтрах нь тэр Ван, өвчтөний хү з ү үн д диц зоос зүүгээд гаргаж байлаа. ийм аргаар эд гэдэг байсан уу , үгүй юу та юу гэж бодож байна. Гарцаагүй эдгээж байсан юм. Хэрэв өвчтөн нь чин үнэнээсээ итгэвэл аливаа мэх эдгээж чаддаг Нэг удаа галуу хариулж явсан охин дээр ариун дагина ирсэн байж, ингэж тэр охин өөрөө ярьсан байлаа. Тэр газар нь Астолатын дэргэд бунхан байгуулсан юмсанж Бунханд тэр явдлыг дүрсэлсэн зураг тавьсан нь өвчтөн ойртвол аюул учрам харагдах атал жил бүр олон мянган зовлонт, дутуу тахир амьтад ирж мөргөөд эдгэрэн буцдаг байжээ. Эрүүл хүмүүс ч түүнийг харахлаараа үхэхгүй байп Анх надад тэгж ярихад нь яаж итгэх билээ. гэвч түүнийг хармагцаа буугаад өгсөн юмдаг хүн худал биш жинхэнэ эдгэрэхийг би нүдээрээ үзлээ л дээ Камелотын хавьд олон жил таягтай тааралдаж байсан хүмүүс тэр хөргийн өмнө ирж мөргөөд таягаа хаяад явчихаж байхыг бишгүй харсан Бунхны хувьд ундуй сундуй овоолоостой олон таяг бол бодит нотолгоо юм. зарим газар үг хэлэлгүйгээр өвчтөний еанаа бодолд шууд нөлөөлөн анага а на зарим газар өвчтөнийг нэг тасалгаанд цуглуулаад залбиран мөргөж итгүүлэн анагаана Хэрэв шарлагааг анагааж чадахгүй ван тааралдах юм. бол угаасаа засгийнхаа эрхийг бурхны гаралтай гэж итгэдэг, хаан ширээнийхээ түшиг гэж боддог хамгийн үнэ цэнэтэй мухар сүсэг нь сарнина Энүүнд эргэлээх юм. байхгүй Намайг идэрт Английн хаант засгийнхан шарлагааг адислан анагаахаа больсон нь дэмий юм. болсон тавин тохиолдлын дөчин тавы нь эдгээж чадах байсан Хувраг гурван цагийн турш тасралтгүй гуншигнаж сайн сэтгэлт ван гарынхаа хурууг яр шарханд хүргэ н адисласаар байхад өвчтөн

олон шингэрч өгөхгүй цувахад залхуу хүрч тэвчихийн аргагүй болов. Вангийн ойролцоо задгай цонхныдэргэд би сууж байлаа. Вангийн дэргэд таван зуу дахь өвчтөн ирж харахаас нүд хальтрал яр шарханд нь ван гараа хүргэж, зовлонд өртсөн чамд мутраараа адис тавьж эдгээсүгэй гэсэн үг таван зуу давтагдахыг сонслоо гэтэл цонхны цаана гэнэт хүүхэд чарлах мэт чимээ гарахад дотор жигтэйхан болж намайг арван гурав зуун жилийн урагш аваачих шиг боллоо

- Камелотын өдөр дутмынхаа, Утга зохиолын галт уул Сүүлчийн дугаар хоёрхон центын үнэтэй Онгодын хөндийд болсон гайхамшгийн тухай бүрэн тайлан Энэ бол вангуудаас хамаагүй агуу их хүн, сонины ажилтан хүү байв. гэвч тэр олны дотроос миний бие л сонины агуу их ач тусыг мэдэх бөгөөд тэр хүчирхэг илбэтэн дэлхийд юу хийж чадах увидастай болохыг нь ойлгох байлаа. би цонхоор ганц зоос хаяж сонин авлаа Сонины хамгийн анхны ажилтан

- Адам надад хариулт мөнгө авчирч өгөх гэж цаашаа булан тойрон алга болов. Булангийн цаанаас буцаж ирээгүй л байна. Сонин гэгчийг дахин олж үзэх ер бишийн таатай санагдав үнэнийг хэлэхэд анхных нь хуудсыг гүйлгэн хармагцаа тун их хиртхийсэн юм. Дараахь зүйлийг уншихад удаан хугацаанд олноор хүндрүүлж, бишрүүлж байсан болоод тэр үү зоо нуруугаар хүйт оргиод явчсан онгодын

Хөндий дэх агуу их явдал Ус цацагч нь хогтжээ өвчтөн Мерлин бүх ураг гаргавч тус болсонгүй дөл, утаа, гялбааны дундуур гайхамшигт булгийн ус оргилоо. Харин эзэн ганцхан дал айлтаар бүгдийг аргайчихав. Ад чөтгөрийн аймишигт гал утаан дундуур гайхамшигт булгийн ус оргилов үүр тухиа тэр ая араа балмагдав Ухаанд багтамгүй сэтгэлийн донслол

гэсэн байв. Энэ мэтчилэн зөндөө их юм. байлаа. Дэндүү сүржин болсон байж магадгүй Урьд тиймэрхүү гарчиг зүгээр санагддаг байсан атал одоо нүдэнд хэтэрхий гял цал харагдан а Тэр бол Айсанзасын сонин сэтгүүлийнхний арга барил мөн байлаа., гэвч энд Айсанзас биш шүү дээ Түүгээр үл барам сүүлчээсээ хоёр дахь гарчиг нь аглагч нарыг гомдоож болох учраас тэд зарлалаа бидэнд өгөхгүй болж мэднэ. Ерөнхийдээ л сонины байдал арай хөнгөн хөвсөргөн санагдсан Янз нь би ч гэсэн өөрөө мэдэлгүй нэлээд өөр болсон бололтой миний амьдралын анхны үед бол гоёмог үг найруулгын холбоц гэж бодогдож тийм жижиг сажиг шазруун ширүүн зүйлүүд нь надад дэмий санагдаж байв. Тэр дугаарт байсан тэмдэглэлийн чанартай олон зүйл надад аятай санагдаагүй Жишээ нь

НУТГ ИЙН УТАА БОЛСОН ҮНС Өнгөрсөн долоо хоногт намгийн цаана, Бальмароль ла Мервеис ноёны гахайн хашааны урд ноён Ланселот гэнэт Ирландын Агриванс өвгөн вантай тааралджээ Бэлэвсэн авгайн сонорт хүрчээ Ирэх сарын эхээр хүслэнт ноён Саграморын эрэлд 3 дугаар х а йгуул гарах гэж байна. Хайгуулыг Улаан нугын нэрт даймин эр толгойлно түүнд ажил сайн мэддэг, ухаалаг э е лдэг ноён Энэтхэгийн Порсант, бас мөчөөгөө өгөхгүй Паламид Сарацин ноён бараа болон явна тиймэрхүү хүмүүстэй явахад сул зугаалга болохгүй, жинхэнэ ажил болно. г э дэгт итгэж болно. Ма н ай хотын Амбан шар, ха в тгай загас гэдэг буудалд дөрв ө н долоо хоног болохдоо усгал зөөлөн ааш зан, уран гоё үгээрээ бүгдийн сэтгэл зүрхийг татаж чадсан хамгийн гоолиг бөгөөд нэрд гарсан ноён Гайлын Чароле мөд гэрийн зүг я ва х гэж байгааг Ханны уншигч нартаа харамсалтай мэдээлье, Дахин манайхаар ирээрэй Чарли минь Ө н гөрсөн долоо хоногийн мягмар гаригт Увидаст Хөндийн захад

зангилаархаг Мунын мангастай байлдаж амь алдсан Корнвал гүнгийн хүү талийгаач ноён Дамансын оршуулгын эцсийн үгийг эг н эшгүй авьяаслаг, авсчдын сор нь болсон морь нохой мэт з үтгэгч Мембл хэлнэ Түүнийг сонирхоно уу Амссан хүн болгоч талархсандаа нулимс мэлтэгнүүлэх тийм гойд чанарын хэд э н таваг мөхөөлд ө с өгсөн ордны э рхл эгч ноёны бойдаагийн гуравдагч туслагч и д Ханны бүх конторынхон редак то раасаа өг сүүлэн хамгийн сүүлчийн ө р өгчөө хүртэл чин зүрхнийхээ талархлыг дэ вш үү лж байна., Б и д ачий тань хариул на Дарга нар алба тушаал дэвшүүлэх, хү м үүси й н нэрсийг т ө лөвлөх үед манай сонин зохих тус л алцаа ү з үүлнэ өмнөд Астолатын Демулз е ль ир Дьюл е н манай хотын Элэгний доголд байдаг м алын худалдаачдын Дэн буудлын эелдэг ноён, өөрийн нагац ахынд айлч л ах гэж байна. Үлээлгэх хясааны засварчин бага Бернер ээлжийнхээ амр ал таар ойр хавийн т ө мрийн дархны газар ажиллаж байгаад ур чадвараа маш их дээшлүүлэн одоо гэртээ буцаж ирээд байна. зарлалыг нь ү зм үү,

Эхлээд иймэрхүү байхад дажгүй, гэхдээ миний урам нэлээд хугарч билээ. Ордны мэдээ гэсэн хэсэгл надад хамгаас илүү аятайхан санагдсан Түрүүчийн эрээ цээр багатай дэмий үг олонтой зүйлсийг бодвол хүн дэтгэх амьсгал гүн шингэсэн энгийн үгтэй энэ хэсэг уншихад тун зүгээр байлаа. гэсэн ч бас л дутагдалтай байлаа. Ордныхны мэдээний талаар хичнээн оролдовч олон янзаар бичиж болдоггүйн зовлонг би мэдэлгүй яах вэ Ганц оновчтой арга байдаг нь юу гэ в эл гогцхүү хэлбэрий нь олон янз болгох аргаар нэг зүйлийг л да в тах хэрэгтэй байдаг Баримт сэлтийг чармаа нүцгэн болгоод, дараа нь шинэ хувцас ө мсгөх хэрэгт э й , Тэг в эл нүд хууртаж баримт нь шинэ мэт харагдана ордны амьдрал гэдэг чинь оргилж байдаг мэт санагдана Шохоорхон үзэж бүхэл бүтэн үеийг нь амтархан уншдаг болох нь хувинтай шөлийг дан буурцгаар хийснийг анзаарахгүйн адил бүлгээ Кларенсын хэл найруулг а эгэл сайн, шударга, ажил хэрэгч боловч миний бодоход дээд зэрэг болж чадаагүй байсан юм. ордны мэдээ

Даваа гаригт ван цэцэрлэг дотуураа унаагаар зугаалсан

М ягмарт Лхагвад Пүрэвт Баасанд Бямб ад Нямд

Ер ө нхийдөө тэр сонин мин и й сэтгэлд таарч байсан юм. зарим нэгэн арга барилын өө сэв байсан боловч Бүхэлдээ Артур вангийн үеийн байгугай айсанзасын хянагч нарт ч бишгүй хангалттай байх байсан юм. Дүрмийн талаар доголдолтой, санаа гаргах т а лаар ч бас доголдолтой байсан гэхдээ би тэр талаар нэг их голчлон анхаарахгүй билээ. би ч гэсэн тэр талаар дутагдахгүй байж бусдыг хазгай ташаа зогслоо гэж өө эрэх хэрэггүй билээ. би ном зохиолоор дэндүү ө лссөн болохоор сонины бүх хуудсыг бүхэлд нь залгичих дөхөж байсан юм. гэтэл лам нар намайг бүчиж Энэ чинь юу гээч хачин юм. бэ? Яадаг юм.? юунд хэрэглэдэг юм.? Нусны алчуур юм. уу ? Нэмнээ юм. уу ? Цамцны тасархай юм. уу ? юугаар хийсэн юм.? яасан нимгэн, яасан хэврэг, үгүй тэр шажигнаж байгаагийн нь гэхчилэн элдэв бусын юм. шалгааж гарлаа Бөх юм. уу ? Бороонд норохоороо урагдахгүй юу ? Бичи г тэй юм. уу , чимэг зураг юм. уу ? гэж ч байх шиг зарим нь латинаар уншдаг, зарим нь грекээр бага сага үсэглэдэг байсан болохоор зарим үсэг төстэйгий нь таниад энэ бичиг байж магадгүй гэж бодсон боловч чухам юу болохы нь бодох ухаан нь хүрэхгүй байлаа. би тэдэнд арай хялбар аргаар тайлбарлаж өгөхийг хичээлээ

- Энэ бол нийтэд зориулсан сонин гэгч Энэ маань чухам юу болохыг би та нарт дараа ярьж өгье Энэ бол да а вуу биш, цаас Цаас гэж юу байдгийг та нарт би нэг тайлбарлаж ө г нөө

ү үн дээрх үеүдийг уншихад зориулсан буй Гараар бичээгүй, хэвлэсэн зүйл Хэвлэх гэж юу болохыг би хожим та нарт хэлж өгөмз ийм хуудас нэгий нь нөгөөгөөс нь ялгагдахгүйгээр мянгаар нь гаргасан байгаа Тэд нэг дуугаар уулга алдан гайхаж

- Мянга гэнэ мөн ч их ажил аа Олон хүн бүхэл жил хийвэл барахаас биш санахгүй их ажил орно

- Үгүй тийм биш том жижиг хоёр хүн нэг л өдөрт хийчихнэ Тэд загалмайлан залбираад амны уншлага хэлэв

- Үгүй мөн ч гайхатай юм даа Илбийн хүч гэгч үү би тэдэнд итгүүлэхийг бодсонгүй би нэг их ч а нга биш, зөвхөн мулзан толгойгоороо надад тун ойрхон буй хүмүүст дуулдахаар өнөөх булгийг хэрхэн сэргээсэн тухайг уншихад тэд жигтэйхэн бишрэн сонирхож, шагшин г а йхалдаж байлаа.

- аа , ёстой үнэн Гайхмаар, гайхмаар Бүгд яг үнэн, яг л тийм байсан хэвээр нь гээч эр хачин юмыг тэдний гарт өгч, тэмтрүүлж болох уу ? их болгоомжтой үзэх байх Бололгүй яах вэ Тэд, сонинг тэнгэрээс бууж ирсэн Ямар нэг ариун нандин зүйл мэтээр маш болгоомжтой бишрэнгүй маягаар авч үзээд аяархан тэмтэрч, илж, урьд хожид үзэгдээгүй үг үсгий нь гайхсан нүдээр тал талаас нь ажиглан харна толгой гудайлгасхийн, бишрэн харахы нь бодохоос баярлам Сонин маань миний бүтээл, тэдний тийнхүү үг хэлгүй гөлрөн бишрэх, шохоорхон сонирхох, гайхах нь сонины эрхэм сайн нөлөөний илрэл мөн биз дээ? Төрсөн үрий нь найз нөхөд нь юм. уу , бусад ямар ч гэсэн бүсгүйчүүл үзээд магтахад эх хүн түр зуур ертөнцийг мартталаа баярладгийг би мэднэ Энэ бол сэтгэлийн их баяр, ямар ч ван, ялагчийн буюу яруунайрагчийн хангалуун хөөрүү сэтгэлээс давуу, тэдгээр тэй зүйрлэхгүй аз завшаантай, хязгааргүй дүүрэн жаргалтай зүйл гэдгийг би мэдэж байлаа. миний сонинг тэр том тасалгаанд байсан олон хүн дамжуулан үзэж гайхан байхыг суудлаасаа хөдлөлгүй нүд дагуулан баярлан харж суулаа ёстой л дива а жингийн жаргал гэгч тийм байдаг байх, дахиж тийм жаргал юун эдлэв гэж

Хорин долду га ар бүлэг

ЯНКИ, ВАН хоёр танигдалгүй аялсан нь

Унтахынхаа өмнө би амрах өрөөндөө ванг оруул а ад үсий нь тайрч эгэл хүн шиг хувцас өмсгөө Тэр үед дээд ангийн хүмүүс үсээ урд талаас нь духаа хүртэл хяргуулж, арталы нь м ө рөө хүртэл ургуулдаг байхад эгэл хүн ар өврөөс нь тайруулдаг байлаа. Боол хүн үсээ бүр хяргачихдаг байсан болохоор ямар шүү янзаар ургах нь падгүй байсан би вангийн толгой дээр хөлтөг углаж байгаад бултайсан үсий нь хяргачихсан Бас сахал самбайгий нь хуссан ү сий нь аль болох муухай хусахыг хичээсэн маань зэгсэн санаснаар болсон шүү Аль болох хөндлөн гулд, ташуу хазгай хайчилсан Хөлд н ь муухай шаахай углаж биенд нь хүзүүнээс нь шагайгий нь хүрсэн хүрэй өнгийн зотон даавуун цамц өмсгөөд өгөхөд вант улсынхаа дотор хамгийн голшиг эр болдог байсан тэр хүн маань одоо хамгийн даржин мууха й эрэмдэг амьтан болж хувирав Бид хоёрын өмссөн хувцас маань ядуучуудын хямд бөх хувцас, үс толгойгоо ч аялуулсан янз маань ядуучуудынх болохоор бид хоёрыг жижиг худалдаачин, жижиг пүүсний зээн, эсхүл малчин, эсвэл дэлбэгч, эсвэл хөдөөний дархчуул гэж бодох биз Тэр хувцсыгаа би ядуу хүнд таарах хямдхан хувцас гэж хэлж байгаа юм. биш, эд нь гар хийцний нэхмэл юм. болохоор эр хүнд тэрнээс хямдхан хувцас яаж байх билээ. гэдгийг л хэлэх гэснээс тэр Бид

хоёр нар гарахаас нэг цагийн өмнө сэмхэн гарч одлоо Нар төөнөж эхлэхээс өмнө бид найм есөн бээр яваад хүн цөөтэй нэг суурин газар хүрч очсон юм. миний үүрсэн шуудайтай юм. сүрхий хүнд байв. Ван, гагцхүү яваа яваандаа алгуураар тариачны хоол унданд дасах учраас сэлбэж идэж байх хүнсний зүйл тэр шуудайд байсан би замын хажууд аятайхан газар олж ванг суулгаад бага сага идэх юм. өгө в. Тэгээд ус олъё хэмээн явав Үнэнийг хэлэхэд би ганцаараа жаал амарч суухыг бодсон юм даа Ванг байгаа цагт би дандаа зогсоо байдаг байсан, бүр зөвлөлийн хурал дээр ч гэсэн өөрцгүй, гэхдээ хурал олон цагаар үргэлжилбэл арай тийн зогсоод байдаггүй байсан л даа Хурал их сунжирсан цагт надад аргүй намхан сандал тавьж өгдөг байсан нь хөмөрсө н онгоцны тайрдас шиг, суухад шүдний өвчин шиг юм. байсан би тэр заншлы нь шууд з ө рчихийг хүсэлгүй ванг аажмаар дасгах гэж бодсон маань Тэр л дээ Гадны хүний дэргэд бол хоёул адилхан сууж л байхгүй бол хүн амьтан ажиг авчихна шүү дээ Харин хоёулхнаа байгаа цагт тийм шаардлага байхгүй учраас ав адилхан байдал гаргах дэмий санагдсан би гурван зуугаад метрийн зайтай газар ус олж тэндээ хориод минут амарч байтал хүн ярилцах чимээ гарлаа Тариачид л ажилдаа гарч байгаа байлгүй, тариачнаас өөр хэн ингэж хар өглөөгүүр явах вэ, санаа зоволтгүй гэж бодож байсан юм. гэтэл нэг минут хир тэй болсны дараа замын эргэлтээр ачаатай луус, дагуулсан зарц гоцго нар бүхий хувцас хүнар сайнтай, язгууртан нар морьтой гарч ирлээ би босон харайж бут бударган дундуур хөл мэдэн харайлгалаа Надаас өмнө ван дээр оччих вий дээ гэж би айсан юм. Сандрахад хүч нэмэгддэг, гүйсээр амьсгаа дээр гаран хүрлээ, зохих цагтаа ч хүрлээ

- Хаантан минь уучлаарай, та бид хоёрын хоорондын ёс төр өнгөрсөн, бушуухан босоорой Босоорой, язгууртан хүмүүс ирж байна шүү Тэгээд яадаг юм.?ирж л байг

- Эзэнтэн минь , тэднүүсийг харахад та сууж байж болохгүй Бос, бос Өнгөртөл нь номхон зогсоно шүү Та чинь одоо тариачин хүн шүү дээ нээрэн тийм л дээ, мартчихжээ Гайлитай хийх их дайны тухай бодол болчихоод гэ с нээ боссон боловч тийм байдалд тариачин хүний адилаар бушуухан биш их л ёсорхуу байдалтай босов тийм агуу их бодол гэнэт орж ирээд одоо сарниаж

- Анхаараарай, эзэнтэн Анхаараарай толгойгоо гудайлга бүр доош нь бүр бүр Бүүр доош нь мань хүн үнэнээсээ оролдсон боловч төдий л болж өгсөнгүй Номхон томоотой байх байдал нь пизаны нурж буй цамхгийн төдий байлаа. өөрөөр хэлье ч гэсэн боломгүй санагдана Номхон дорой байх байдал нь даанч болж өгөхгүй байсны гайгаар морьтон ноёд бүгд царай хувирган ярвайж хамгийн сүүлд явж байсан нэг сүрхий гоцго ташуур далайн ухасхийхэд нь би биеэ тавьж хаацайллаа Тэднүүсийн пардхийн инээлдэх чимээг далимдуулан иймэрхүү юманд давгүй байгаарай гэж ванд сэм хэлж амжлаа Ван биеэ тун ч их хүчлэн барьж байна. Болдогсон бол тэр морьтонгуудыг бүгдийнх нь махыг зулгаахсан гэж бодож байх шиг байв.

- з эр зэвсэг г үй та бид хоёр зэвсэгт дээрэмчидтэй яах ч арга алга Адал явдал харах гэсэн аялал м а ань бүр эхэндээ бүтэхгүй болбол тоогүй яа Та бид хоёр санаж яваадаа хүрье гэвэл гагцхүү тариачинтай гадна өнгөөрөө адилхан байх төдийгүк, авир зан маань ч тэдэн шиг байх ёстой гэж би хэлсэн юм. Энэ зөв Чамтай маргах арга алга Цааш явнаа, Яваад байдаг хэрэг би чиний зөвлөснийг санаж аль болох бүтэхээр нь хэрэглэхийг хичээнэ хэлсэн үгэндээ хүрч байлаа. чадах чинээгээрээ хичээвч тэрнээс нь илүү чадах хүн мундхааргүй байв. хэрэв та нар тун дүрсгүй, болгоомжлохыг ч мэдэхгүй нялх хүүхэд өдрийн турш дүрсгүйтэж заримдаа усанд унаж үхэх гээд, заримдаа юм.ан дээрээс унаж нугасаа тасалчих гээд эх нь

хажуунаас нь огт салахгүй байдгийг үзсэн бол ван бид хоёрыг харсантай өөрцгүй гэж бодоорой Алсдаа юу болохыг би урьдаас мэдсэнсэн б ол ү гүй, хэрэв ванг тариачин болгож авч яваад хоолоо олж идэх дуртай хүн байвал тэгэг, харин би эм бар, арсланг тээж я в ъя, тэгвэл аюул багатай гэж хэлдэг байж дээ, Эхний гурав хоногт би түүнийг айлд оруулахгүй байлаа. Эхний үед замаас зайдуу орших, хүн цөөн орж гардаг тиймэрхүү дэн буудал бар а адасхийн явахаас өөр домгүй байв. мань хүн овоо л хичээж з сан, гэхдээ нэг л болж өгөхгүй байсан Сураагүй юм. гэдэг тун хэцүүдэг ээ Тун эвгүй газар болгонд шахам намайг гэнэт цочоож айлгахыг нь яана замд гараад хоёр хоног болж байсан орой гэнэт хормойноосоо чинжаал хутга гаргаж ирлээв шүү

- Эзэн хаан минь , та чинь энэ хутгыг хаанаас авга вэ?

- Өчигдөр орой, дэн буудлын газар байхдаа дамын наймаачнаас

- Ямар үлийгээ хийх гэж ийм юм. аваа вэ?

- чиний арга залиар чи бид хоёр олон аюулаас мултарлаа, гэвч зэвсэгтэй явлаа гээд муу болох нь юу билээ. гэж бодсон юм. чиний арга ухаан хүнд хэцүү үед гэнэт орж ирэхгүй болбол яана

- Бид мэтийн доод улс биендээ зэвсэгтэй явах хориотой байдаг Тариачин хүн чинжаал хутгатай явж байгааг ноён юм. уу , өөр хүн мэдэх юм. бол яана? Тэр үед бид хоёрын ойр хүн хар байгаагүй нь аз болсон юм. би тэр хутгы нь хаяулсан, хаяулах гэж ёстой л биеэ төхөөрч мэдэх хөөрхөн эрээн ал аг тоглоомы нь хаялгүй болохгүй гэж хүүхэд ятгахын дайтай юм. болсон доо Бид хоёр цааш юу ч ярилцалгүй дув дуугүй зэрэгцэн алхаж явлаа Тэгж явтал ван ам нээж

- Хэрэв намайг ямар нэгэн осолтой юм. хийх гэж байгааг чи түрүүний мэдсэн бол намайг түрүүний хорихгүй яагаа вэ? Энэ асуултад нь би тулгамдаад эхлээд юу хэлэхээ мэдэхгүй байсан боловч сүүлд нь хамгийн зүй ёсны хариу болгож

- Эзэн хаан минь , би танай юу бодож буйг яаж мэдэх билээ.? гэв Ван зогсож намайг гайхсан янзтай ширтлээ би чамайг Мерлинээс илүү гэж боддог байсан юм. чи илбэдэх талаараа түүнээс илүүгээ харуулсан, харин зөгнөн мэдэх гэдэг бол илбэнээс ч чухал шүү дээ Мерлин зөнтэй хүн би алдаа хийснээ мэдлээ Аргы нь олж мултрах хэрэгтэй байлаа. Гүн их бодол болсныхоо дараа миний бие цаашид хэрхэх тухай төлөвлөж буйгаа хэллээ Эзэнтэн, та миний үгийг ойлгосонгүй одоо би бүгдий нь тайлбарлаж өгье хоёр маягийн зөн байдаг юм. Ойрын үйл явдлыг урьдчилан хэлэх авьяас гэж байдаг, бас зуун жилийн дараа юу болохыг урьдаас мэддэг авьяас билэг гэж байдаг Та алий нь чадалтай гэж бодож байна.

- хоёр дахь нь байлгүй яах вэ?

- зөв Мерлин тийм а вьяас билэгтэй юу ?

- зарим талаар тийм авьяас бий шүү Намайг ван болно. гэдгийг тэр чинь хорин жилийн өмнө тааж мэдсэн юм шүү

- Цааш нь яахыг бас хэлсэн үү?

- хэлье ч гэж бодоогүй байх

- Бодвол чадлынх нь хэр хэмжээ тэр биз дээ 3 ө нч болгон хэр хэмжээтэй байдаг зарим их зөнчийн хэр нь зуун жил байдаг

- тийм нь цөөн байх даа

- Дөрвөн зуун жил, зургаан зуун жилийн өмнөхийг мэддэг хоёр их зөнч, бас долоон зуун хори н жилд ойртсон тийм бас нэг зөнч байсан юм.

- Бурхан минь , мөн ч гайхалтайяа

- Надтай зүйрлэх юм. бол тэднүүс чинь юу ч биш шүү дээ, юу ч биш

- тийм үү? чи тэгвэл ёстой цаглашгүй алс холын юмыг харах чадалтай байх нь ээ долоон зуун жил үү? Эзэнтэн минь , миний бичгийн хараа бүргэдийн нүд шиг хурц бөгөөд энэ дэлхий одоогоор мянга гурван зуун жилийн дараа ямар болохыг би бүр алган дээрээ тавиастай юм. шиг үзэж байна шүү дээ Вангийн нүд хичнээн бүлтийж гайхсаныг та нар харсан ч болоосой Арай л ухархайгаасаа бүлт үсэрчихээ гүйдээ Мерлин түншийн хөг өнгөрөх нь тэр Ер нь энэ х ү мүүст юм.ын үнэн худлыг батлах хэрэг байдаггүй юм. хэлсэн үгэнд итгэдэг амьтад Ямар ч хоосон юм. ярьж байсан худал гэж бодох хүн ганц ч үгүй юм. хол, ойрыг харах хоёр зөн надад байдаг нэгээс нь нөгөөрүү сэлгэн шилжих хэрэгл гардаг Ойрыг хэлэх нь миний билгээс доогуур учраас би голцуул алсыг мэргэлдэг Шодон сү ү лт гэж бид ярихдаа Мерлин мэтийн тийм шодонгууд л ойр зуурын юм.аар оролдож байвал таарна гэлцдэг юм. заримдаа зугаа болгож ойр зуурын юм. хэлэвч нэг их олон удаа бол нажид санагддаг юм. Таныг Онгодын Хөндийд ирэх гэж байна. гэдгийг хоёр гурван хоногийн өмнөөс мэдээд хэлсэн гэж хичнээн их яриа хөөрөө болж байсныг та санаж байгаа байлгүй

- санаж байна., саналгүй яах вэ

- Хэрэв таны тэнд ирэх хугацаа хоёр гуравхан хоногийн дараа биш, харин таван зуун жилийн дараа байсан бол над дөч дахин амар байх байсны дээр би мянга дахин тодорхой нарийн ширийн юм. мэдэх байсан л даа

- Үгүй мөн хачин ч юм даа

- нээрэн, туршлагатай хүнд таван зуун хормын Дараа болох юмыг мэдэхээс таван зуун жилийн дараахи нь амар байдаг

- Бодоход бол шал ондоо баймаар юм. Ойрхон юм. гэдэг чинь ойрхон л байдаг болохоор энгийн хүн ч гэсэн мэдэж болмоор, хол ирээдүйн юмыг мэдэхээс таван зуу дахин амар баймаар Зөгнөн мэдэх увьдас гэдэг чинь таамаглалд хамаагүй болж хэцүүг амархан, амархныг хэцүү болгон ид шидээр хувиргадаг байх нь ээ Уг нь ухаантай толгой байсан юм. Тэгээд ч тэрий нь тариачны малга й гаар нуух хэрэггүй байлаа. Тэр толгой дээр усчны хонх зүүсэн ч тархий нь яльгүй ажиллуулбап вангийн толгой гэдэг нь дороо мэдэгдэнэ Одоо надад бас шинэ зовлон бий болов. Ван өөрөө амьдарч үзэх юм. шиг л одоогоос мянга гурван зуун жилийн дараа чухам юу юу болох вэ хэмээн шалг а агаад салахыг байх нь тэр би түүний аяг дагуулах гэж байдгаараа л хичээж байлаа. би өөрийгөө зөнч хүн гэж итгүүлэх гэж байж ингэж гоомой юм. хийх гэж, урьд нь гоомойтох явдал байсан, гэхдээ ийм юм. л арай болж байгаагүй юм. Гэхдээ бас ч сайн тал байсан юмаа Зөнч хүнд тархины хэрэгцээгүй Өдөр тутмын амьдралд ашиглаж болох юм. харин зөгнөхөд ямар ч хэрэг байхгүй учраас тархигүй дөнгөөж

байна. Зөгнөн мэдэх гэдэг бол дэлхий дээрх хамгийн тайвуу алба Зөн санаа ороод ирмэгц нь бодлоо дайчлаад гашилгаж орхихгүйн тулд сэрүүн газар хадгалчих хэрэгтэй, тэгээд л хэлээрээ ажиллана шүү дээ хэл бол сэтгэхүйн дэмгүй аандаа ажиллаж гарна Тэгээд л зөн бий болдог юм даа Өдөр болгон бид хоёртой бядан явагч дайчин эрс тааралдаж байсан бөгөөд тэр болгонд вангийн дайчин омог оволздог байлаа. Хэрэв би замаас холуурхан дөлж яваагүйсэн бол мань хүн хэзээний мартчихаад л одоогийнхоо байдалд эс нийцэх дэмий үг хэлж золигтох байсан байх тийм эрсийн барааг харахдаа зогсчихоод нүд том болгон ширтдэгсэн нүдэнд нь омог дээрэнгүйн оч бадарч, ам хамар нь сарталзах нь эгээ л дайчны хөлөг мэт харагдана Тэдэнтэй үзэлцэхсэн гэхээс хорхой нь асаж буй нь ил байдаг байлаа. Уг нь би ташуурдуулж муугаа үзэж байсан хоёр хоногийн өмнө л бодвол зохих байсан хянах аргыг гурав дахь өдрийн үдээс хойш шийдэхээр зогссон билээ. Надад дэмий санагддаг болохоор би тийм юм. хийхээ больсон ч , аятайхан боловч нэг явдал санаа өгө в тархиараа ажиллашгүй дан хэлээрээ ажиллан санаа амар зон билгээ гаргаж явж байж модны хожуулд зүдэрч газар хамраараа шааж ойчлоов шүү Айсандаа арай л ухаан алдсангүй, дараа нь сэхээ авч аяархан босож цүнхээ онгойлголоо цүнхэнд маань ноосонд ороогоод жижигхэн хайрцганд хийсэн тэсрэх бөмбөг байсан юм. Н а д тийм юм. авч явах маань туйлын чухал байсан, юу гэвэл маш чухал гайхамшгийг үйлдэх хэрэг гарах ч юм. бил үү, тэгвэл тэрнийгээ хэрэглэнэ шүү дээ Харин тийм юм. дандаа авч явах тойвтой санагдаж байсан боловч ванг авч яваач гэхийг би хүсээгүй Нэг бол нэг газар хаях, эсвэл аюул осолгүйгээр нэг хэрэглэх ухаан сийлмээр байлаа. Тэгээд цүнхнээсээ гаргаж халаасандаа хийгээ Яг тэгж байх зуур хоёр дайчин эр гарч ирлээ Ван тэр хоёрыг хараад омог бардам байдалтай зогсоод ширтэн харах нь өөрийнхөө шинэ үүргийг бас л мартсан бололтой хажуу тийш болоорой гэж намайг хэлэхээс өмнө өөрөө зайллаа Тэр хоёр эрийг хажуугаараа тойроод гарна гэж бодсон бололтой, гэтэл хаанаас чингэх билээ. замаар хөл нүцгэн алхаж яваа заваан тариачин хүнийг няц гишгэчихгүйсэн гэж тойрч гарах гэж хаанаас байх вэ Урьд өөрөө тиймэрхүү тохиолдолд замаасаа гарч тойрч байсан удаа бий гэж ү ү, тариачин хүн түүнийг хармагцаа ум хумгүй замаас нь зайлдагүй байсан гэж үү Тариачин байтугай эрхэм дайчин эрс ч гэсэн замаас нь зайлж байгаагүй гэж үү? Дайчин эрс ванг огт тоохгүй байсан болохоор өөрөөл амиа аргалахгүй бол өнгөрөх байсан, үнэндээ өөрөө оглохарайн хажуу тийш болоогүй бол хэмх даруулаад нэмэр т нь баахан дооглуулж хөх инээдий нь барах л байсандаа Вангийн уур хилэн бадарч ёстой ван хүнийхээ янзаар зэвүүцэн хамгийн муу муухай үгээр тэднүүсийг харааж зүхлээ Дайчин эрс нилээд холдоод байсан боловч маш их гайхсан байдалтай зогсон алдаад эмээл дээрээ эргэж энэ новшнуудтай нооролдох хэрэг байна. уу , үгүй юу гэсэн янзтай тээнэгэлээх мэт болсноо жолоогоо бидний зүг эргүүлэн уулгалан довглов Ганц ч хором алдаж болохгүй байлаа. би гүйж очоод вангийн хэлсэн хараалтай зүйрлэхэд ёстой п ар в ан гурван давхар байшинг ч нурааж мэдмээр голы нь гогодмоор муухай хараал тавилаа би тэрнийг зүхэл сайн ернөсөн арван есдүгээр зууны хараалын сангаас гаргаж ирсэн билээ. Дайчин эрс давхиан дундаа яг зогсож чадалгүй вангийн дэргэд бараг хүрч очсон боловч уурандаа галзуурах шахан морьдынхоо хур дэлийг сүртэй босгон хийсгэсээр миний зүг эргэж довглон айсуй би тэднээс дал наяд метрийн зайтай байсан тул замын хажуудахь нэг үхэр чулуун дээр мацан гараад байтал мань эрс гучаад метрийн орчим ойртож ирснээ урт жадаа зэхэж, дуулгатай толгойгоо дарахад морины хялгасан нөмрөг н ь л харагдаж байв. Сүртэй хоёр юм. над руу довтолгож гарлаа Арван тав орчим метр ойртоод ирмэгц нь өнөөх бөмбөгөө зантайхан шиг тааруулж шидэхэд яг морьдынх нь хошуун дор газар туслаа харууштай, бахадмаар сайхан юм. боллоо Миссипи мөрөн дээр л галт онгоц дэлбэрч байгаа юм. шиг юм. болох нь тэр Дараа нь хагас цагийн

турш бид хоёрын дээрээс нөгөө хоёр дайчин эр, төмөр, адууны махны цөвдлөөр бороо асгалаа
Бид хоёрын дээрээс гэдэг маань яагаад гэвэл ван маань миний дэргэд гүйж ирсэн юм.
Дайчин эрсийн байсан газар том нүх буй болсон болохоор тэр хавийнханд мөн ч их ажил
гарлаа гэдгийг би мэдсэн Тэд учир шалтгааны нь олох гэж ядрана гэсэн утгаар хэлж байгаа
юм. шүү, харин булж дарахын хувьд гэвэл хэдүйхэн ямар зовлон байх вэ, орон нутгийн ноёны
цөөхөн тариачны л төлбөргүй хийчих ажил юм. чинь Ванд би хамаг учрыг тайлбарлаж өглөө
энэ н ү х тэсэрдэг бөмбөгний улмаас үүссэн гэлээ. , ван нэгэнт учрыг ойлгохгүй учраас ингэж
тайлбарлах нь түүнд хор болохгүй байсан Ван энэ явдлыг шинэ маягийн нэг гайхамшиг,
Мерлинийг чадаж буй бас нэг цохилт гэж үзжээ Иймэрхүү гайхамшиг ховор байдаг, түүнийг
агаар тэнгэрийн тун таатай нөхцөлд үйлдэж болдог юм. гэж ванд хэлэх нь зүйтэй гэж бодсон,
яагаад гэвэл дуртай цагтаа тийм гайхамшгаа үзүүлээч гэж шаардаад салахгүй болно., гэтэл
надад дахиад б ө мбөг байгааг үй юм. чинь балрах нь тэр шүү дээ

Хорин най мдугаар бүлэг

ВАНГ СУРГАХ АЖИЛ

Аяныхаа дөрөв дэх хоногийн өглөө үүрээс өмнө сэрүүнд бүхэл цагийн турш алхаж явахдаа мин ий бие ванг сургаж дасгах ажил хийхээр нэгэнт санаа шийдсэн юм. Энэ маягаар цааш үргэлжилж хэрхэвч болохгүй, түүнийг гартаа оруулж сайн номхотгохгүйгээр ганц ч айлд орохын нөхцөл алга, энэ лав зүсээ хувилгасан хүн гэдгийг муур ч андахааргүй байв. Ванг эндээ түр зогсоё гээд

- Эзэнтэн минь , таны хувцсыг харахад хар авах юм. огт алга, таны хувцас зан араншин хоёр минь тун харш болоод горьгүй нь ээ цэрэг эрийн ганага н байдал, хааны төрх намба чинь горьгүй нь Таны нуруу дэндүү ганагар, харц чинь хурц омголон байх юм. хүнийг бөөцийлдөг учраас хаан бол нуруу бөгтийх, толгой унжуулж, газар шагайх буюу толгой гудайх, хөл туйврах зүрх шимшрэн айн зовох, эргэлээж тээнэгэл зэхийн зовлонг амсдаггүй шүү дээ доод төрөлтэй хүн бүх насаараа гашуун зовон амсаж нуруу тэнийлгүй бөгтийдэг Та тийм юманд сурах хэрэгтэй байна. хүнийг хүн биш болгож ноёныхоо нүдэнд баясал цэнгэл төрүүлдэг, хүлцэнгүй номхон, үнэнч боол болон хувирга даг ядуу хүний түмэн зовлон, доромжлол дарлал амсдаг бүхий л байдлыг шингээх нь чухал байна., чингэхгүй бол талыг та бид хоёрын орох анхны тариачин айлын жаахан хүүхэд ч зүсээ хувилгасан ноён гэдгийг мэдээд сэдэж бодсон хэрэг маань балрах болно. шүү Та ийм маягаар явж сурахыг оролддоо Ван намайг анхааралтай харж байгаад оролдож үз лээ

- Болж байна шүү, тун догь болж байна. Эрүүгээ ялимгүй доошхон болго, уухай, иймэрхүү зүйтэй Нүдний харц дэндүү омголон байна. Тэнгэр газрын савслага руу биш, өөрөөсөө арваад л алхмын төдий зайтай газар луу харж үз уу хай, зүйтэй, аанг Байз, байз, явахдаа дэндүү тэвхгэр, тэв тав гэсэн байдалтай байна. Болхи янзтай алхаж гишгэх хэрэгтэй Над руу хар даа Иймэрхүү маягаар яваарай Болж эхэлж байна шүү иймэрхүү л маягаар за, за, бараг л болж байна. Гэсэн ч бас л нэг юм. дутагдаад байна., юу вэ, би ч хэлж мэдэхгүй байна шүү Та гуч, дөчин алхам газар явах г үй юу , би харая, ямар болж байна. хажуунаас тань харахад толгой зөв байна., мөр бас зүйтэй, эрүү болно., алхааны хурд яг л ийм байхад болно., намба төрх харц бүгд болж байна шүү Харин бүгдий нь хамтруулаад харахлаар нэг л биш дээ Дүндээ тэнцвэржиж өгөхгүй л байна. Бас жаахан яв даа Аанха, одоо учры нь оллоо Танд чин үнэн гуниг гашуудал алга хамаг шалтгаан нь тэр юм байна. нэг л зохиомол, хиймэл юм. болоод болдогүй Нарийн ширийн бүх талаар хэнд итгэгдэж болмоор, гэтэл тийм биш байлаа.

- Яах билээ.?

- Жаахан бодъё доо Ухаанд орж ирэх юм. алга Үнэнийг хэлэхэд дадлага тус болох байх Алхах гишгэх маягаа өөрчлөхөд өвсний үндэс идэж, чулуун дээр унтвал таарна Бидэнд саад болох юм. алга, эргэн тойрон мэлгэр талын дунд ганц овоохой харагдаж байна., өөр юм. алга, тэндээс бид харагдах ч үгүй, хол юм. Эзэн тэн минь , замаасаа гарч энэ өдрийг сургууль хийж өн гөрөөө жаахан сургуулилж байгаад Одоо эзэнтэн минь , та бид хоёр тэр овоохойд очлоо гэж бодъё Та гэрийн эзэнд юу гэх вэ? гэхэд ван ч улуун хөшөө шиг өөрөө мэдэлгүй гаанайж, жигтэйхэн ширүүнээр —

- Тариачин чи надад сандал авчирч өг идэх уух юм. өгөөдөх гэнэ

- Аяа, эрхэм эзэнтэн минь , яаж ингэж болох билээ.

- Яагаад болдоггүй билээ.? Тэднүүс бие биенээ тариачин гэдэг үй,

- Тэгдэггүй гэж үү?

- Тэднээс дээгүүр улс л тэгж нэрлэнэ

- Тэгвэл дахиад нэг үзэх үү, хамжлага гэж хэлнэ дээ

- Үгүй, болохгүй, чөлөөт хүн байж мэднэ

- За яахав тэгвэл сайн санаат хүн гуай гэе

- Эрхэм хаантан минь энэ чинь нэлээд таармаар үг байна., уг нь найз юм. уу , нөхөр минь гэвэл бүр сайндаа

- Нөхөр минь гэх гэж үү тийм балай новшийг уу

- Та бид хоёр чинь зүс мүсээ хувилгаад тэдэнтэй адилхан балай новшнууд шүү дээ

- чинийх зөв Нөхөр минь надад сандал болон идэх уух юм. өгөөч гэ ж болно. биз дээ?

- Болох ч гэж дээ, болохгүй л юм даа Та ганц өөрийнхөө өмнөөс гуйж байна., надад сандал, надад хоол унд өгөөч гэж байна. Ван над уруу сүрхий гайхсан байдалтай харна

- толгой нь удаан ажилладаг, юм. ухаарахдаа төдий л шаламгай тархитай хүн байсан юм. Шинэ санааг хурдан ойлгохгүй, бага багаар чимх чимхээр тусгана

- Чамд сандал хэрэгтэй гэж үү? чи суух юм. гэж үү?

- би суухгүй бол тэр хүн та бид хоёрыг дүрсээ хувилгасан адил царай гаргаж яваа боловч тийм ца райлж чадахгүй улс гэж бодно шүү дээ чи зөв ярьж байна. Үнэн гэдэг ямар ч байдлаар и лэрлээ гэсэн гайхалтай зүйл юм даа Тэр хүн чинь чи бид хоёуланд сандал, хоол унд авчирч өгөөд аль алинд маань гар угаагуур, алчуур хүндэтгэн авчирч өгөх ёстой л доо Нэг засвар хиймээр зүйл байна шүү Тэр хүн юу ч авчирч өгөх ёсгүй Овоохойд нь ороод очиход зөндөө б охир новш байх л байх, муухай заваан юм. их харагдана байх, гэвч та бид хоёр орж очоод, тэр айлын Ширээнд сууж юу өгсний нь идэж ууна, хоёул яг л адил тэгш байдалтай байлгүй болохгүй, ялангуяа гэрийн эзэн нь боол хүн биш байвал бүр ч хичээнэ шү ү. Гэрийн Эзэн нь боол ч бай, чөлөөт хүн ч бай гар угаагуур, алчуур гэж байхгүй байх вий Эзэн хаан минь та дахиад нэг сургуулилаад орхихгүй юу уу хай дээр болж байна., овоо дээр болсон байна. даа, Тэгэхдээ л нэг биш дээ Мөр тань унжиж өгөхгүй байна., гархин х у ягнаас өөр юм. тавьж үзээгүй мөр аргагүй ч юм.даа Алив шуудайгаа надад өгөөдөх Муухай ачаа гэж юу байдгийг би нэг үүрч үзээдхэе Жин нь мөр дард аг үй, бузар нь л д а рдаг юм. чинь Гархин хуяг хүнд ч гэсэн ариун тээш шүү дээ Түүнийг өмсөж явдаг хүн нь естой Зүгээр, зүгээр, би үүрч үзье Шуудайтай юмаа өгөөдөх Нуруун дээр тавиатах Мөрон дээрээ шуудайтай байгаа ванг харахад одоо л ван биш шиг харагдаж байлаа. Вангийн мөр илжиг шиг зөрүүд байлаа. өрөөс унжиж өгдөггүй, унжлаа гэвч жинхэнэ есоор унжгар болохгүй байв. Сургуулиа үргэлжлүүлж вангаа засаж чиглүүлсээр удлаа

- Та өрөнд баригдаж, авлагатай хүмүүс өдөр шөн өг үй ер нэхээд суулгахгүй байна. гэж бод Та төмрийн д а рхан байтал таныг ажлаас халж та одоо ажилгүй болоод байна. гэж бод Авгай тань ө вчтэй, хүүхдүүд тань хоол ундгүй өлсөөд юм. нэхэн орилолдож байна. гэж бод

Энэ мэтчилэнгээр сургуулилж байлаа. Янз бүрийн ха вч лага дарлал, гай гамшгийн эрхээр тарчлан зовж буй хүний зовлонг дууриах сургууль хи йлгэж байсан юм. гэвч энэ бол зөвхөн үг байснаас биш жинхэнэ з овлон байгаагүй болохоор исгэрэхийн төдий л юм. түүнд санагдаж байсан биз Уг үгсийн илэрхийлэх зовлонг өөрөө биеэр амсаагүй хүнд бол үг ямар нөлөөтэй байхав дээ Нэг их юм. мэдсэн царайлаад ажилчин ангийн тухай хөөрхийлөн ярих мөртлөө о ю уны хөдөлмөр биеийнхээс хэцүү гээд илүү Цалин авч суудаг тийм мэргэд байдаг Тэд оюуны хөдөлмөр хийж үзээд биеийн хүчнийхийг хийж үзээгүй болохоор үнэхээр тэгж боддог юм. Харин би бол аль алины нь хийж үзсэн хүн, тэгэхлээр мэднэ Намайг хорвоогийн бүх мөнгийг чамд өгье чи нэг сар төмөр хүрз бариад ажил хий гэсэн ч би тэгье гэхгүй, харин хамгийн хэцүү оюуны ажлаар бараг цалин авалгүй зүтгэгэсэн ч дуртай, бүр сэтгэл өег зүтгэх болно. гээч оюуны хөд ө лмөр гэж буруугаар хөдөлмөр болгон нэрлэжээ Энэ бол жаргал, зугаа учраас тийм юм.аар оролдох нь өөрөө шан хишиг юм шүү Хамгийн бага цалин а вд аг барилгын ухаантан, инж е нер, генерал, зохиолч, барималч, зураач, илтгэгч, өмгөөлөгч, депутат, жүжигчин, номлоочингууд тэр тэр ажлаа хийхдээ диваажинд жаргалаа эдэлж байгаа хэрэг юм. томчуулын дунд хөгжмийн хөвч татасхийн бурханлаг ая эгшгийн дунд умбах хөгжимчнийг юу гэж бодож байна. Түүнийг та бүхний дуртай хэрэглэдэг үгээр хэлэхэд мөн л хөдөлмөрлөж байгаа хүн, гэхдээ үнэнийг хэлэхэд тэгж нэрлэнэ гэдэг бол хөдөлм өр гэдэг ойлголтыг до ромжилж байгаа хэрэг юм. Хөдөлмөрийн хууль гэгч тун шударга биш, тийм байдлаар үүссэн болохоор түүнийг өөрчлөх бололцоо байхгүй хөдөлмөрчин хүн хөдөлмөрлөөд хичнээн их баяр хөөртэй байна., төчнөөн их мөнгө авна . Иймэрхүү хуулинд үе уламжлах язгуурын ёс, вангийн засаг гэх мэт илэрхий луйварч тогтоол чиг бас багт а ж байгаа юм.

Хорин есдүгэр б үлэг

БОДОО

Бид хоёрыг тэр овоохойд хүрэхийн алдад үдэш болох дөхөж байв. Амьд амьтан байгаа шинж о г т байсангүй Тариаг хурааж талбайг ёстой л улаан халцгай болгосон байна. Хашаа, саравч нь бүгд майжийж жайжийгаад жинхэнэ ядуугийн янз илэрхий Ойр хавьд амьд амьтан алга Нам гү м гэж үхээрийн газар мэт дээр нь цагийн улиралд ха в харлан нэвсийсэ н нэгэн давхар овоохой харагдана Үүд нь дутуу хаалттай, бид хоёр ямар нэг бүүр түүр зөнд хөтлөгдөөд амьсгаа даран өлмий дээрээ гишгэсээр үүдэнд нь чимээгүйхэн ойртож очлоо Ван ха ал гы нь цохив Хариу байдаггүй Жаахан хүлээлээ Хариу байдаг үй Дахиад нэг цохилоо, бас хариу байдаггүй хаалгы нь сэмхэн нээгээд харсан чинь харанхуйд нэг юм. хөдлөн, нэг эмэгтэй сүүдийн босож над уруу зүүд нойрон дунд байгаа юм. шиг ширтлээ Тэгснээ ө рөвдөж үзээч, бүгдий нь авчихсан, юу ч үлдээ гүй гэсэн донгио Дуу сонсдов

- би юугий чинь ч авах гээгүй байна.а, ядуу эмэгтэй минь

- чи лам биш юм. уу ?

- биш ээ

- чи ноёны эдлэнгийн хүн үү?

- Үгүй, би явуулын хүн

- Гэмгүй хүн амьтныг гуйранч, үхлээр цээрлүүлдэг бурхны төлөө эндээс зайлж үз Энэ

чинь бурхан, сүм хийдэд хараалгасан газар би ороод чамд туслая чи өвчтэй, ядарч зүдэрч байгаа хүн байна., Нүд минь харанхуйд дасаж доторхийг овоо харахт ай боллоо Над руу ширтэн гөлөрч аньсага нь буусан нүдий нь олж харлаа хичнээн туранхай, яс арьс хоёр болсны нь харлаа

- Энэ газрыг сүм хийд цээрлүүлэн зүхсэн юм. гэж би чамд хэлж байна. хүн хараад энд ирсний чинь мэдэгдчихвэл яана бушуухан зайлж үз, гүй гүй, бушуухан

- чи бүү зов Сүм хийдийн хараал зүхэл намайг яах ч үгүй би чамд тус больё л доо

- за тэгвэл ийм сайхан үг хэлж байгаа чамайг сайн санаат бурхан гэж байдаг бол харж хайрлаг Уг нь балга ус л байвал сайнсан за за, миний үгийг мартаж бушуу за йл Сүмийн өмнө бидний үхлээр үхэхийн хэрэг байхгүй Явуулын эрэлхэг зоригт сайн санаат хүн чи явж үз, хараал зүхэл өртсөн хүний өрөөл болдог бол сэтгэл зүрхнийхээ угаас сайныг билэгдэе Түүний үг хэлж дууса аг үй байхад би б у лэг руу гүйлээ Булаг нь хориодхон алхмын зайтай байв. Нам а йг буцаад ирэхэд ван тэднийд орчихсон цонхных нь хаалтыг нээгээд нар салхи оруулах гэж байв. Овоохой дотор нэгш и нгэ эвгүй үнэртэй байна. Би тэр эмэгтэйн аманд аяга ус ойртуулахад шувууны савар шиг туранхай гараараа шүүрэн авлаа Яг тэр үеэр цонх онгойж гэрэл нүүрэн дээр нь нэлсхийн тусахад бодоо буюу цагаан цэцэг хэмээх өвчинд хэлмэгдсэн нь тодорхой болов. би вангийн дэргэд очиж чихэнд нь Эзэнтэн минь , та эндээс холд, бушуухан холдож үз Уржнан жил Камелот хавийн хүн ардыг хүйс тэмтрэх шахсан тэ р өвчнөөр энэ авгай үхэх гэж байна. гэхэд ван байрнаасаа ч хөдлөлгүй

- Үгүй, би эндээ үлдэж тус болохыг оролдож үзье, эндээс хэрхэвч явахгүй гэлээ.

- Ван минь , ингэж болохгүй, та гарсан дээр гэж би дахин шивнэв

- чи сайн үйлийн зүг тэмүүлж, үг чинь мэргэн байна. Х а рин ван хүн аймшгийн өмнө чичирвэл ичгүүртэй, дайчин эр хүн хүнд тус болохоос татгалэвал ичгүүртэй Бүү зов, би эндээс явахгүй Харин чи л явбал таарна Сүмийн хараал надад халдах ёсгүй, гэтэл чи эйд байх учиргүй Шашин чамайг ёс зөрчлөө хэмээн хүнд гараар цээрлүүлнэ шүү Тэр аймшигт оромжинд байж ван амь насаа алдаж мэдэх байсан боловч түүнтэй яаж ч маргаад нэмэргүй ажээ. Дайчин эрийнхээ чанарт хүрсэн цагт юу ч нэмэр болдогүй юм. үлдэхээ л үлдэнэ, гаргах гээд ямар ч боломж олдохгүй болно., би тэрнийг нь туршлагаараа мэдэх юм. чинь Тэгээд цааш нь зүтгээгүй Нөгөө авгай

- Сайн санаат минь энэ шатархуу юм.аар дээш гараад юу харагданав надад хэлээд аль даа юу ч харагдлаа гэсэн надад айлтгүй хэлээрэй, яагаад гэвэл эх хүний элгийг эмтрэхээс айлгүй бүгдийг хэлж болдог, минийх тэртэй тэргүй эмтэрсэн юм. гэв чи эндээ үлдээд эмэгтэйд идэх уух юм. өг, би дээшээ өгсье гэж ван хэлээд шуудайтай юмаа лангуун дээр тавилаа Намайг эргээд харахад ван маань шатан дээр оччихсон байв. мань хүн харанхуйд хэвтэж буй нэг эр хүнийг олж хараад жаахан зогсох аядав Тэр хүн ч биднийг мэдээгүй байгаа бололтой Энэ чиний хар хүн үү? гэж ван асуулаа

- тийм ээ у нтаж байгаа юм. уу ? тийм ээ, бурхны минь аврал, унтаад гурван цаг Болж байна. түүнд залран ирсэн энэ сайхан нойронд нь бишрээд зүрх минь дэлбэрэх дөхөж байна. Болгоомжтой хөдлөө, сэрээчхээд юу хийх вэ гэж намайг хэлтэл тэр авгай с эрэхгүй, цаадхи чинь үхчихсэн юм. Үхчихсэн? үхнэ гэдэг яасан сайхан бэ хэн ч энэ хү н ийг од оо дарлаж

зовоохгүй Одоо дииаажинд очоод жаргалаа эдэлж байгаа, тамд очсон байлаа. ч гэсэн тэнд ямар лам, хамба байх юм. биш сэтгэл гонсойхгүй л дээ Бид хоёр багаасаа ижилдэн дасаж сууж аж төрөхчөө болоод хорин та ван жил ердөөч хоёр биенээсээ холдож үзээгүй Бид хоёр хичнээн олон жил бие биеэ хайрлаж, хичнээн удаан хугацаанд хамт тарчлав даа Өнөө өглөө халуурч бүлээрч дэмийрэхдээ бид хоёр дахин хүү, охин хоёр болчихоод эзгүй хээр тал дундуур тоглож явна гэж байсан Балчир бага хүүхдийн гэм халгүй үг ярьсаар л холдон холдсоор яваад өгсөн Мэдэгдэлгүй шахам тэгж явсаар, ярьсаар өөр нэг цэлгэр талд ороод үхэх тавилант бидний хараанд үл үзэгдээчин болон алга болох юм. Хагацан одож байна. гэж тэр минь бодоогүй, харин миний залуу насны маань зөөлөн булцгар гарыг, энүүн шиг шувууны савар шиг юм. биш шүү, булцгар гары минь барьсаар хамт явж байна. гэж дэмийрч байсан юм. Үхэх боловч үхэж буйгаа мэдэхгүй, хагацаж буй авч хагацаж буйгаа мэдэхгүй байж талийх шиг тайван юм. гэж байж болох уу ? Энэ бол хэцүү бэрх зовлонг тэвчээртэй, номхон томоотой туулсны нь шан Шат байгаа харанхуй буланд нэг сулхан дуугарлаа Ван бууж ирж яваа юм. байж Нэг гараараа нэг юм. тэвэрч нөгөөгөөрөө шатны хэрсэг тулсаар бууж байна. Гэрэлд орж ирэхэд арван тав орчим насны туранхай гэгчийн охин байна. Бараг ухаан алдсан, мөн л босоогоор үхэж байв. Энэ бол ван гийн баатарлаг явдлын хязгаар нь байлаа. Энэ бүхний эсрэг, ямар ч шан горьдлогогүй, тийм үед ээр зэвсэг г үй гар хоосон байж үхэлтэй халз тулалдана гэсэн үг байсан боловч торго дурдан эдэлж, алт мөнгөөр чимдэг хөл нь газар хүрэхгүй баярлалдан алга ташиж нүдээ хужирладаг тийм хүмүүс хажууд байхгүй байлаа. гэтэл ванг а жвал адил ээр зэвсэгтэй хоёр дайчин хоорондоо айвуу тайвуу үзэлцдэгийн адил байж буй төрх намба нь мөн л амгалан тайван, эрэлхэг зоригтой харагдана тиймэрхүү үед мань эр ёстой агуу их, сүр жавхаатай ажээ. Түүний уд а м угсааны бүдүүлэг баримлуудын дотор бас нэг нэмэгдэж ордны үзмэр нь баяжих болно., энэ талаар би алгуурлахгүй, Харин энэ нь мангас буюу лууг дарж буй гархин хуягт вангийн дүрс биш , тариачин эмэгтэй өөрийнхөө төрсөн үрийг үхэхийнх нь өмнө нэг үзээд сэтгэл нь тайтгараг гэж тариачны хувцас өмссөн ван хүн үхлийг гар дээрээ барин яваа дүрс байх болно. Ван эхийнх нь дэргэд охиныг нь авчран тавимагц эх нь хөөрхийлөн энхрийлэхэд охины нүднээ сулхан гэрэл тодорсхийгээд дорхноо унтарлаа Эх нь үнсэж үлгэг энхрийлэн хөөрхийлж, ганц ч болтугай үг хэлээч гэх боловч охины уруул сулхан хөдлөвч дуугарахгүй байна. Би шуудай дотроосоо цавиртай дарс гаргаж ирсэн боловч тэр эмэгтэй

- юу хийх вэ, тарчлаагүй байна., ингэж байсан нь дээр Дарсны хүчээр амьдарч мэднэ, тан шиг сайн санаат хүн энүүнд минь хатуу сэт гэл гаргахгүй л дээ, гэхдээ амьд явахын хэрэг юу байна.а, та бодоод үз л дээ Ах нар нь боол, эцэг нь үхчихлээ, эх нь үхэж байна., сүм хийдийн хараал дээр нь дарамтлаад байхад энэ амьтныг зам дээр үхэж хэвлээ ч гэсэн аааад гэртээ орогнуулах тийм зүрхтэй хүн олдохгүй шүү дээ Ингээд л үхэг Сайн санаат хүн таныг би дүү нь амьд байна. уу , үгүй юу ч гэж асуугаагүй шүү дээ Амьд байсан бол та дахин дээш гарч авчрах л байсан, би мэдэж байна., та ганцааранг яавч орхихгүй гэв

- Тайван нойрссон байна. лээ гэж ван нам дуугаар өгүүлэхэд авгайн дуу тасрав

- би ч өөр юм. хүсээгүй юм даа ө нөөдөр аз ихтэй өдөр юм даа Ай хөөрхий Эннис минь эгчийнхээ хойноос мөдхөн гүйцэж очно, зөв замаар үр минь явж байна. Энэ элбэрэлт сэтгэлтэй хүмүүс чамд саад хийхгүй Тэгснээ охиноо тэвэрч үс толгойгий нь илж хацар н үүр эн дээр нь үнсэж байхад цаадхи нь тэгсгээд талийгаач болон нүд нь шил шиг цийлэгнэн гөлрө в. Вангийн нүдний нулимс хацры нь даган урсахыг би үзлээ Нөгөө авгай чингэж буйг

нь ажаад Бодвол хөөрхий чи бас л эхнэр хүүхэдтэй хүн, талхныхаа сүүлчийн хагуу хальсыг хэд э н хүүхдэдээ өгөөд өөрснөө өл авалгүй унтдаг л биз, зовлон мэдэх хүн л ингэж элэг эмтрэнэ билээ. би мэднээ Ядуу хүний зовлонг мэдэх хүн өөрөөсөө дээгүүрхэн язгууртанд яаж дарлуулж сүм хийдэд яаж хэлмэгддэгийг мэдэх хүн байна. санамсаргүй оновчтой үг сонсоод ван давхийсэн боловч биеэ барьж өөрийнхөө то глох ролийг санаж эхлээд тун дүй муутай байсан бол энэ удаа сүрхий догь жүжиглэв би өөр юм. ярин эхлэж эмэгтэйг юм. хүм идэж уу гэхэд үгүй гэлээ. Үхэх хугацаагаа хойш татахыг хүсэхгүй байна. Би дээр байсан хүүхдийнх нь шарилыг авчраад хажууд нь тавилаа . Энэ байдлыг тэсвэрлэн эс чадсан тэр хөөрхий эмэгтэй зүрх эүсэм орь дуу тавилаа би яаж ийж анхаарлы нь сарниулж байгаад өөрийнх нь үүх түүхийг яриулсан юм.

- Энэ Британ оронд язгууртан нараас бусад хэн ийм там зовлон амсахгүй байх вэ, та өөрөө мэдэж, өөрөө амсаж буй хүн Сонсоход уйтгартай улиг домог болсон түүх шүү Бид тэмцэж тэмцэж амжилтад хүрсэн юм. ямар амжилт гэвэл амьдарч ч чадахгүй, үхэж ч чадахгүй болсон юм. Тэгээд бас яасан гээч? Энэ оноос өмнө дайрсан гайг манайх давж чадсан юм. гэтэл энэ жил бүх гал зовлон зэрэг зэрэг дайраад нухчихлаа л хэдэн жилийн өмнө нутгийн ноён манай хамгийн сайхан газар жим с ний мод тарьсан юм. Даанч нүгэлтэй, даанч хүний үнэргүй юм шүү

- өөрийнх нь эрх шүү дээ гэж ван хажуунаас нь хэлэв Үүнийг үгүй гэж байгаа хүн алга, хуулийн утга санаа нь гэвэл ноёны юм. ноёных, мкний юм. ч ноёных болж байна. Би энэ газры нь түрээсэлж авсан боловч ноён дуртай юмаа хийж байсан юм. Саяхан гурван моды нь огтолчихжээ Манай насанд хүрсэн гурван хүү жигтйхэн айж тэр гэмт хэргийн тухай ноёнд мэдэгдсэн юм. Гурвууланг харанхуй нүхэнд барьж хийгээд хэргээ хүлээхгүй бол тэндээ ялзарч үх гэжээ Тэд юугаа хүлээх юм. хийсэн хэрэг байхгүй юм. чинь , тэхлээр тэдэнд тул гасан ял нь тэр гурвыг тэнд нь үхэн үхтэл нь хорино гэсэн үг л дээ Яаж юугаар төгсдөгийг та андахгүй дээ за биднийг яасан гээч нөхөр бид хоёр хоёр охиныхоо хамт тариалсан газраасаа ургацаа хурааж бас гурван эр хүн өдөр шөнөгүй тагтаа, янз бүрийн араатан хөөж туух гэж үйлээ барж байлаа., тийм амьтан, жигүүртнийг алж ч болохгүй, ай бүү үзэгд Яг тэр үеэр ноёны улаан буудай боловсорч хонхоо дэлдээд биднийг дуудлаа Талбайнх нь тариа будааг үнэ төлбөргүй хураах болж намайг охидтойгоо очиход болохгүй, хүн дутаж байна. Гурван хүүгээ н ө хөж чадахгүй та нар, нэгийнх нь оронд нэг п е н төл гээд өдөрт нэгийг авдаг байна. Тэр үеэр бидний өөрийн маань тариа будаа хураах хүнгүй хойно алдагдаж эхэллээ Тэгсэн чинь лам, эрхэм ноён хоёр Та нарын бүтэлгүйгээс болж бидний авах хувь хохирч байна. гээд пөнийн торгууль тавилаа торгуулийнх нь пөнийг төлсөөр байтал хурааж авах будаа тариагаа оронд нь өгөөд, өгөх мөртлөө өөрснөө үйлээ барж хурааж, ачиж өгөөд ганц ч зоос бидэнд өгсөнгүй, идэх юм. ч үлдээсэнгүй, тэгээд бид өлбөрч үхэж байгаа маань энэ шүү дээ Энэнээс ч долоон дор юм. боллоо би өлсөж даараад, гурван хүүгийнхээ хойноос гутарч эр нөхөр, өчүүхэн охидынхоо ноорхой цоорхойг бодохоос сэтгэлийн гүн зовлон тамд орж солиорч эхэлсэн байна. Сүм хийд түүний үйл ажлыг харааж зүхжээ арван хоногийн өмнөх явдал шүү Бурхны цээрлүүлэн залхаах үйлийг тэвчихгүй байна. гэж нэглам ирээд намайг аашилж загнахад нь би сүмийг хараачихжээ Лам цааш нь намайг ховлохгүй юу би хэлсэн үгээсээ буцаагүй юм. Тэгээд миний толгой дээр, миний үр хүүхэд, эр нөхөр, миний хамаг л мах цусны тасархайн толгой дээр Ромын хараал зүхэл буулаа Тэр цагаас хойш бид нээс хүн амьтан бүгд дөлж бүгд зугтах болов. Бид ний үхсэн амьдыг ч мэдэх гэж энэ овоохой руу шагайх хүн алга Нөхөр, хоёр охин минь бүгд өвдлөө би ханилсан эм нь төрсөн эх хүн

болохоор шүд зуун босож эднийгээ бөөцийлж гарлаа идэх юм. гэж хэн нь ч нэхээгүй, манайд юу ч байхгүйг мэдэх юм. чинь дээ Ус байсан, ус өгч байлаа. Ус хичнээн ховдог ууцгааж байв. Усанд шүтэж усыг бишрэхий нь яана гэтэл миний тэнхээ бүр тасарч өчигдрөөс яах ч домгүй боллоо Өчиг д өр би сүүлийн удаа нөхөр, отгон охин хоёроо харсан Өчигдөр, өнөөдрийн туж, энэ урт удаан зуу зуун жил шиг хугацаанд хэвтэртээ чимээ чагнан чагнан хэвтлээ их охиныгоо сэрвэсхийн хар а ад Ээ, хөөрхий минь хэмээн дуугарснаа хөрч буй биеий нь салганах турь гүй гараараа бие рүүгээ татна Үхэл ясанд нь хэрхэн ТҮГ түг хийхийг сонсов уу даа

Гу ч ду га ар бүлэг

ЭДЛЭНГИЙН ГАЗРЫН ЭМГЭНЭЛ

Шөнө дунд болоход бүгд нас барж бид хоёр дөрвөн хүүрийн дэргэд зэрэгцэн сууж байлаа. Бид хоёр, тэйдээс г а рт тааралдсан даавуу шувууны уранхай тасархайгаар тэднүүсийн хүүрийг хучаад гарахдаа үүдий нь түгжлээ Сүмд тэрсэлсэн хүмүүсийг христосын шашны ёс горимоор оршуулах учиргүй болохоор тэдний оромж нь тэр чигээрээ булш нь болох ёстой ажээ. Тэд уяман өвчинд баригдсан, зэрлэг адгуус, нохой шиг хаягдсан бөгөөд мөнхийн амьдралд итгэдэг ганц ч хүн тэр ад шоо үзэгдэж хараалгаж зүхүүлсэн хүмүүстэй ойртохыг яавч хүсэхгүй ажээ. Биднийг холдож амжаагүй байтал хөлийн чимээ гарахыг би сонслоо зүрх минь булгилж эхлэв Тэр байшингаас бидний гарахыг хүн харчихвал болохгүй учирта й би вангийн хормойноос татаж ухраад овоохойн нөгөө буланд нуугдав

- Одоо дажгүй гэж би ванд хэлсэн боловч арай л мэдэгдчихээгүй билээ. Шөнө нь ялимгүй гэгээтэй байсан бол уу тийм ойрхон дэргэдүүр гарсан тэр хүн бид хоёрыг лав харах байсандаа

- Амьтан биш, адгуус ч байсан байж болох уу ? Магадгүй хүн ч бай, амьтан ч бай, ямар ч гэсэн өнгөрөх хэрэгтэй

- чимээгүй Наашаа ирж байна. Вангийнх зов байлаа. Алхах чимээ нь шууд овоо хойн зүг бидэн рүү дуулдана Амьтан бололтой, айх юм.гүй мэт Тэгээд явахыг завдтал ван миний мөрөн дээр гараа тавьж зогсооход чив чимээгүй болсон боловч хэн нэг хүн үүдий нь аяархан тогшлоо Бие зарсхийв Дахин тогшоод

- Ээж ээ Аав аа Бид чөлөөтэй болж гараад та нарт мэдээ сураг хүргэж ирлээ Сургий нь дуулаад та нарын царай цайж цонхийх боловч зүрх сэтгэл тань баярлах болно. шүү хормын төдий ч саатаж болохгүй, одоохон зугтах хэрэгтэй Яа ... Яагаад хариу дуугарахгүй байгаа юм. бол? Ээж ээ Аав аа хэмээн сэмээрхэн дуугарав би ванг үүднээс холдуулж я вья Одоо замд орж болно. гэж шивнэв . Ван хоргодоод явахгүй байв. гэтэл ч үүд нээгдэх чимээ гарахад нь хөөрхий амьтан үхсэн хүүрүүдтэй л золголоо гэдгийг ойлгосон билээ.

- Явья, эзэнтэн минь Одоо гэрэл асааж үзээд зүрх дэлбэрмээр уй гашуу болно. Ван зөрсөнгүй зам дээр гаруут би гүйлээ, ван ч хэргэм зэргээ мартчихсан гүйж байна. Овоохойн дотор одоо юу болж байгаа бол гэж бодохоос тун хэцүү санагдаж байлаа. санахаас эвгүй юмыг замхруулах гэж хамгийн түрүү орсон юмны тухай ярих болж

- Энэ хүмүүсийг алсан өвчин урьд надад тусаж байсан болохоор одоо айх юм. алга, харин та өвдөөгүй бол гэв сэтгэл их зовж хэцүү байна. гэж ван миний ярих зуур хэлэв

- Тэдний ярьж байсан залуус суллагдаж дээ юу гэж бодно? Ноён өөрөө суллаа бол уу даа, хай юу л бол?

- Аа, хаанаас Өөрснөө оргосон, эргэлзээгүй

- тийм байх гэж бодохоос сэтгэл зовоод байна., мкний сэжиг таны үгээр н о тлогдож байна.

- би бол сэжиг гэж нэрлэхгүй, харин оргоо болов. уу яагаа бол гэж бодож байна. Оргосон бол зовох юм. алга

- Надад ч зовох юм. алга, харин

- Яагаа вэ? юунд нь түгших билээ.?

- Тэд оргосон юм. бол бид тэднийг барьж Эзэн ноёнд нь өгөх ёстой, язгууртай тайж хүн доорд хүмүүст хүнд доромжлуулна гэдэг муухай шүү дээ уу хай, бас л Ганцхан юм. бодохоос цаашгүй байдаг байна шүү хүмүүжил нь тийм хойно, яана гэх вэ, түүний судсаар олон үе удам дамжин улам улам хор нь даамжирсан хүйтэн ц э дэг зүрхгэнгүүдийн цус гүйдэг байна л даа хийсэн хэргийн ямар ч баталгаа нотолгоогүйгээр тэр хүмүүсийг шоронд хийж эцэг эхий нь ө лбөрүүлэн алж буй явдлыг гай гамшиг г э ж үзэхгүйг яагаад гэвэл тэд нь тариачин хүмүүс учраас л ямар ч аймшигтай аюултай байспн ноёны л ая, араншингийн дагуу байх ёстой ажээ. Харин тийм шударга бусаар зүүс э н гав дөнгийг хэн нэгэн хүн тас цохих аваас өөрийнхөө ариун ангийн өмнө хүлээсэн үүргээ мэддэг журамт ганц ч хүн тиймэрхүү дүрсгүй явдлыг тэвчин өнгөрөөх ёсгүй ажээ. би түүнийг энэ бодлоос нь салгах гэж ихээхэн оролдсон боловч нэмэр болсонгүй Харин өөр завсрын нэгэн я вдал түүний анхаарлыг сарниулав, юу гэвэл намхавтар нэгэн толгойн орой дээр гартал алсад улаан туяа харагдахад нь би

- Түймэр байна. гэсэн билээ. Ер нь би хожим гал хамаанд бий болнох бодолтой гоор морь мал, машинаар дадлага хийж даатгалын ажил зохиох санаатай байсан болохоор гал түймрийн асуудлыг их сонирхож байсан билээ. гал түймэр болон гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлж даатгай бий болгох гэсэн миний төлөвлөгөөг лам нар энэ бол бурхны дур зоригийн хэргийг саатуулах гэсэн танхай санаа хэмээн намайг эрс эсэргүүцэж байлаа. би угтаа бурхны дур тааллын эсрэг явах гээгүй харин түүний илрэлийн горьг арай зөөлөн болгох гэсэн юм. гэж хариулахад энэ бол бүр ч танхай хэрэг гэлцэж байлаа. Тэд надад саад хийж байсан боловч да а тгалын ажлаа би ямар ч болтугай цэгцэлж байсан юм. Дайчин эрс гэгч мунхаг бүдүүлэг амьтад байсан болохоор мухар сүсгийн наймаачин тэднүүсийг хамгийн наад захын шалтагханаар итгүүлж болох байлаа. гэтэл дайчид хүртэл заримдаа ажил хэргийн амьдралын талыг ойлгохтой байдаг байна., Тэгээд ч сүүлчийн зохион явуулсан тулалдааны Дараа цуглуулсан дуулга малгай бүрийн дотроос миний даатгалын байгууллагын гэнэтийн ослоос даатгах тасалбар гарч байлаа. Алсад улайран харагдах галын туяаг ширтэн бид хоёр гүн бодолд автан чив чимээгүй зогсохдоо тэртээ хол нэг нирхийн нэг намжин сонсдох дуу чимээ юуных болохыг бодолхийлэн ухаарах санаатай байв. заримда а ойр дуугарах шиг болохоор нь учир шалтгаан нь одоо л олдох нь гэж бодтол нууцаа алдахгүй гэсэн юм. шиг аанай алс хол хүнгэнэх ажээ. Бид хоёр өнөөх толгой руу уруудан буугаад тэр чимээ гарах зүг мурий зөрөг даган алхлав харанхуйн дунд хоёр хажуугаас өндөр эгнээ мод ханалан шахна Ти й нхүү уруудан хагас бээрийн хэртэй явахад өнөөх хүнгэнэх дуу улам ойртож улам тодроод үе үе сэвэлээх чийгтэй салхи, цахил гаан цахих бүдэгхэн гэрэл, тэнгэрийн хүжигнэх алсын дуу

чимээнээс үзвэл дуу цахилгаантай бороо гэдэг нь илрэн авай би түрүүлэн алхаж байтал гэнэт нэг зөөлхөн юм. мөр дээр тээглэн дөлрөх яг тэр агшнаа цахилгаан цахил л аа модны мөчрөөс нэг хүн дүүжлэгдэн нүүр царай нь хачин болсон харагдав дотор зарсхийлгэсэн тун муухай юм. ажээ. чих дөжрөм тэнгэрийн дуу тас хийж усан гайба мэт үер астайж эхэллээ гэвч тэр дүүжлээстэй хүн амь тавьсан эсэхий нь бид магадлан олсы нь тас огтлох ёстой билээ. Нүд нялбам цахилгаан Дараа дараагаар угсран гялалзахад нэг үе үдийн цэлмэг тэнгэр шиг, нэг үе саргүй шөнийн хав харанхуй шиг болно. . Дүүжилсэн хүн нэг тодорсноо дахин үзэгдэхгүй болно. Оосры нь огтлоё гэж ванд хэллээ гэтэл ван татгалзаж

- Өөрөө дүүжилж үхэхээр шийдсэн бол эд хөрөнгөө эзэн ноёндоо өгнө гэсэн үг Тэгэхлээр үхэдгээрээ л үхэг Харин хүнд дүүжлүүлсэн бол дүүжлэх учиртай, эрхтэй болоод л цаадуул нь дүүжилсэн хэрэг байгаа л даа Тэгэхлээрээ дүүжлээстэй л байг гэв

- гэвч

- гэвч мэвч гээд байх юм.гүй, дүүжлээстэй нь орхи Өөр шалтгаан ч байна. Цахилгаан цахихад нь урагшаа хар Бид хоёроос тавь жараад алхмын газар бас хоёр хүн дүүжлээстэй савлаж харагдлаа

- Тэнгэр ийм байхад үхээрүүдэд тус хүргэх гэж оролдох шиг дэмий юм. байхгүй Талархал тэнхээ ч үгүй болсон байна., явья цаашаа Цаг дэмий үрээд юу хийнэ, хэлсэн үг нь зүйтэй учир цааш явлаа Нэг бээрийн төдий явахад цахилгааны гэрэлд бас зургаан хүүр мод ноос дүүжлээстэй байх нь үзэгдэв Энэ удаагийн аялал маань даанч базаахгүй боллоо Түрүүчийн бидэнд сонс дож байсан тэнгэрийн дуу, одоо хүмүүсийн орилолдон е нгэнэх дуу чи мээ болон хувирлаа харанхуйн дундуур бид хоёрын хажуугаар нэг хүн харайлган өнгөрөө хойноос нь олон эр хөөжээ Тэдний бараа тасрахад бас нэг хүн зугадаж хойноос нь бас хөөгүүл явцгаана Энэ мэт чилан байн байн хөөгүүл туугуул болж байх юм. Зөрөг зам маань гэнэт нэг тий ш муруйхад дагаж явтал бид гал гарч буй газар хүрч очлоо Газрын эзний том суурин газар шатаад бараг юм. үлдээгүй байв. энд тэндгүй л зарим нь зугатаж, зарим нь хөөж буй энд чинь явуулын хүнд осолтой байж мэдэх газар байна шүү гэж би ванд хэлэв Гэрлээс холхон харанхуйд хүлээсэн нь дээр байлаа. Тэгээд зайлж ойн цоор хойд нуугдав Тэндээс эр эм хүмүүсийн араас олон хүн мөшгөн хөөж харагдана Тэр аймшигт үйл бараг үүр цайтал үргэлжлэв Тэгтэл ч гал унтарч аюул өнгөрөн хүмүүсийн хашгиралдах чимээ намдаж дахин хав харанхуй чив чимээгүй байдал ноёрхох боллоо Бид хоёр тун мэдээтэй урагшиллаа их ядарч нойр хүрч байсан боловч тэр их гал түймрээс холдтолоо явсаар л байлаа. Бид хоёр нүүрсчний овоохойд орж тэдний гарт хувь заяагаа атгуулав . Нүүрсчний авгай боссон байна., харин нүүрсчин өөрөө сүрлэн дээр унтсан хэвээр Сүрэл нь мөн дэвсгэр болдог ажээ. Бид хоёроос гэрийн эзэгтэй баахан айж буй бололтой, гэвч бид шөнийн турш төөрч ядарсан явуулын улс байна. гэхэд яриа хөөрөөтэй болж Аббласурын сууринд болсон аймшигтай явдлын тухай юм. дуулав уу гэж асууж байна.

- Дуулсаан, дуулсан, харин бид хоёр одоо унтаж л амармаар байна. гэж намайг хэлэхэд ван нэмэр болгож

- Биднээс өвчин халдаж магадгүй, байшингаа бид хоёрт худалдчихаад өөрснөө эндээс явцгаахгүй юу Бид саяхан толбот үхлийн улмаас үхэж байсан хүмүүсани дэргэд байсан улс шүү гэв э нэ бол ариун санааны явдал мөн боловч илүү юм. байлаа. Түүний харьяат нарын

царай нь голцуу өрмөнцөрийн сав шиг цоохор байдаг билээ. Тэр эмэгтэй болон нөхрийнх нь нүүр бас цоохор байхыг би ажсан юм. Тэр эмэгтэй бид хоёрыг найрсгаар хүлээн авч айж цочихгүй байв. Вангийн хэлсэн үгийг сонсоод маш их гал хах шиг байна., яагаад гэвэл ганц хоног болохын тулд Тэр орны нь худалдаж авах юм. ярьдаг тариачны хувцастай тийм хүн үзэх үнэхээр гайхмаар байлгүй яах вэ тийм үг сонссондоо бид хоёрыг ихэд хүндлэх сэтгэл төрж тав тухтай унтуулах гэж чадах ядахаараа махарч байлаа. Бид хоёр бараг өдөржин тэднийд унтаад сэрэхэд өлссөн гэдэг тамтаггүй болж тариачны хоолбага бэгөөд олон янз биш ч гэхнээ ванд их амттай санагджээ Ер дөөл сонгино, давс, овъёосны хар талх шүү дээ Бид хоёрт гэрийн эзэн өчигдрийн явдлын тухай ярьж өгөө Оройн ара в , арван нэгийн алдад хүн бүхэн унтсан хойно эдлэн шатаж эхэлжээ Ойр хөршийнхөн нь тусалж тэднийхнийг галаас аварсан боловч ноён өөрөө алга болжээ. Бүгд ихэд сандран ноёны амь хамгаалагч хоёр хүн гал дундуур орж эрж байгаад шатаж үхжээ Тэгсэн чинь эдлэнгээс гурав дөрвөн зуугаад алхмын зайтай газар ноёны аманд юм. чихэж гар хөлийг нь хүлж баахан хутгалж алсан байжээ. Ямар хүн ин гэв? Эр т ээдхэн ноён өөрөө их ширүүлж байсан нэг дорой айлынхныг хардаж тэрнээсээ уламжлан тэдний садан төрөл үрүү орцгоодог байна. Хар даж сэжиглэх хүн зөндөө олон болж ноёны зарц гоцго нар тийм хүмүүсийн эсрэг загалмайтны аянд мордон ойр хавийнхаа хүмүүсийг хамарчээ Бид хоёрын хоно сон айлын хар хүн ч гэсэн тэр аянд мордоод үүрээр л буцаж ирсэн байж Одоо тэр чухам юу болж төгссөнийг мэдэх гэж гэрээсээ гарав Тийнхүү ярилцаж суутал ч эргээд ирлээ Аймшигтай юм. ярилаа Арван найман хүнийг дүүжилс э н буюу алсан, хоёр бие хамгаалагч арван гурван хоригдол галд шатаж үхжээ

- Газар дор хичнээн хоригдол байсан юм. бол?

- Арван гурав

- Бүгд үхэх нь тэр үү?

- тийм, бүгд

- Ноёны Тэр орныхныг хүмүүс гаргаж чадсан байна шүү дээ Ятгаад хоригдлуудын ганцы нь ч аварсан гүй вэ? Манай эзэн гайхаж ингэж асут

- тийм цагт шоронгийн хаалгыг хэн нээх юм. бэ? хоригдлууд тал тал т ийш ээ алга болоод өгнө шүү дээ

- Шоронг хэн ч онгойлгосонгүй гэж чи хэлэх гэж байна. уу ?

- Үүдэнд нь очсон хүн байхгүй цоож нь бөх байсан бөгөөд хэн нэгнийг оргохоор завдвал дор нь барихын тулд цагийн манаач харгалзагч тавибал болох нь тэр Хэнийг ч барих хэрэг гарсангүй, тэхлээр хэн нь ч оргохыг бодоогүй л дээ

- Үгүй, гурав нь оргосон, чи үүнийг зарлаад араас нь мөрдсөн бол зүйтэй байж, яагаад гэвэл тэд л тэр ноёныг алж байшингий нь шатаасан байна. гэж ван хэлэв Тэрнийг би ингэх л хүн гэж мэдэж байсан юм. Эхлээд нүүрсчин авгайнхаа хамт тийм юм. сонсоод ихэд догдлон тэр тухай айл х ө ршүүддээ зарлахаар гарахыг яарч байх шиг байсан боловч гэнэт тэдний нүдэнд өөр байдал илэрч биднийг шалгаж эхлэхэд нь би өөрөө хариу өгч тэднийг анхааралтай ажиглав, Оргосон гурав нь ямар улс болохыг тэр хоёр мэдээд айл хөршдөө бушуухан мэдэгдэх гэж зөвхөн дүр үзүүлж буйг нь би ажаад их баярлаж билээ. Ван тийм өөрчлөлт гарахы нь мэдээгүйд нь надад аятай байлаа. би урьд шөнийнхөө үзсэн харсан

явдлыг ярьж эхлэхэд гэрийн эзэд санаа нь амран сүүрс алдаж байв. нийтийг дарлагч этгээдээ өмөөрөн ямар ч хань нөхдөө төхөөрөхөд бэлэн байдаг нь тэдний хамгийн харамсалтай чанар байсан юм. Тэр эр, эм хоёр, өөрийн ангийн ямар нэг хүнийг эзэнтэйгээ маргалдаж байхад эзний талд орох нь зүйн хэрэг бөгөөд ашиг тустай гэж бодохдоо хэн нь зөв, хэн нь буруу гэдгийг огтхон ч анхаарахгүй Тэр нүүрсчин өөрийн хөрш нарыг дүүжлэх явдалд идэвхтэй махран туслахдаа тэдэнд илэрсэн үнэн хэрэг байхгүй, зөвхөн хар сэрээр чингэж байна. гэдгийг бол сайн мэдэж байсан л даа Эр нөхөр, эхнэр хоёул тийм явдлыг аймшигтай гэж тоохгүй байж тиймэрхүү явдал бүгд найрамдах төрийн төлөө явж буй хүнд туйлын хүнд зүйл билээ. Боолын эздэд үргэлж нүд үзүүрлэгдэж ад шоо болж байсан Өмнөдийн цагаан ядуус чухамхүү боолт ёсонд байснаар ядуурах зүдрэхийн зовлон амсаж байсан атлаа боолт ёсыг хадгалан насы нь уртасгахыг эрмэлээж байсан боол эздийн улс төрийн бүх хөдөлгөөний нь хулчийн дэмжиж байсан төдийгүй сүүлдээ бүр ээр зэвсэг барин босож өөрсдийгөө хавчин хяхаж байсан байгууллагыг сөнөөхгүй билээ. хэмээн цусаа урсгаж байсныг мянга гурван зуун жилийн хойно би нэхэн санасан юм. Цагаан ядуус сэтгэлийнхээ гүнд боолын эздийг үзэн ядаж, тэднийг дэмжсэнээр өөрсдийгөө бузарлалаа гэж амаа барьж байсан нь л тэр гунигт түүхэнд ганц өлгөж авах юм нь байлаа. Тэр сэтгэлийн шаналгаа хэзээ чг ил гарч байгаагүй боловч боол эзэмшлийн ёсны хамгийн таа ламжтай нөхцөлд ч гэсэн илрэн гарах болзошгүй байсан Энэ бол бага юм. биш, яагаад гэхэд хүн гэгч Амьтан хүн чанараа гадна талаараа алдаж байвч сэтгэлийнхээ гүнд хүн хэвээр үл дд эгийг батлаж байгаа юм. Нөгөө нүүрсчин маань өмнөдийн цагаан ядуусын холын садан байсныг бид сүүлд мэдсэн билээ. Ван овоо тэсэж байснаа сүүлдээ тэвчээр нь алдагдаж ингэж хэлэв

- Хэрэв та энд өдөржин чалчиж өнгөрвөл шударга хууль хохирох байна. Хэрэгтэн этгээдүүд эцгийнхээ гэрт ингээд санаа амар сууж байх болно. гэж та бодож байна. уу ? Тэд хүлээлгүй арилаад өгнө шүү Тэдний мөрөөр морьтой хөөгүүл явуулах талаарта хөөцөлдөх ёстой Эмэгтэйн царай ялимгүй хувьсхийж, эр нөхөр нь нэлээд тэвдэн яая даа байз гэс эн байдалтай болж байв. Тэгэхэд нь би

- за нөхөр минь хоёул гарья би аль замаар хаагуур явахыг чинь заагаад өгье Татвар төлөхөөс хойш суусан юм. уу , өөр төөр ялимгүй хэргээр мөрдөгдөж байгаа бол яамай гэхсэн, тэднийг хаацайлж ч болохсон, харин тайж язгуурт хүнийг алж Тэр орны нь шатаана гэдэг бол огт өмнөө хэрэг гэлээ. Сүүлчийн өгүүлбэрийг бол вангийн сэтэлийг онгойлгох зорилготой хэлсэн хэрэг шүү дээ замдаа нүүрсчин биеэ барьж дуртай яваа мэт алхах боловч нэг их мэрийхгүй буй нь мэдэгдэж байв. Би огт санаандгүй гэнэт цаадуул чинь таны садан биш биз? гээд асуучихсан чинь мань хүний царай хачин их цонхийн , цайх нь хар нүүрс болсон арьс нь ч нууж чадахгүй болж өөрөө салгалан чичирхийлж

- Ай, бурхан минь чи яаж мэдэв? гэнэ

- би юу ч мэдээгүй санаандгүй л тааварласан юм.

- Хөөрхий тэд өнгөрчээ хичнээн сайхан амьтад гэж санана

- чи тэднийг үнэнээсээ ховлох гэж байна. уу ?

- миний үгэнд ямар хариу өгөхөө сайн мэдэхгүй тээнэгэлээж байснаа Т ... тийм дээ гэв

- Тэгвэл чи чинь ёстой өөдгүй амьтан байна. даа ийм үг сонсоод өөрийг нь бурхан шиг

амьтан юм даа гэж магтсан мэтээр туйлын их баярлаж билээ.

- Саяныхаа хэлдэг сайхан үгийг дахиад нэг хэлээч, дүү минь Намайг үүргээ эс биелүүллээ гэж чи үнэхээр хэлэхгүй гэж байна. уу ?

- Үүрэг? Дуугүй байсаар цаадуулыгаа холхон зайлах бололцоо олгох л ганц үүрэг чамд байна. Тэднүүс шударга үйл үйлджээ Тэр хүн сэтгэл нь зововч туй дуртай байлаа. т хараад өөр хүн хар алга байсан болохоор надад ингэж шивнэв

- Дүү минь , чи ямар орноос ирсэн хүн бэ? ийм осолтой үг хэлэхээс айдагүй хүн юм. уу ?

- ийм үгээ би нэгэн язгуурын хүнтэйгээ ярилцахад аюул байдагүй юм. чи надаас ийм үг сонслоо гэж хэнд ч хэлэхгүй биз дээ?

- би юу ? Тэгвэл намайг зэрлэг адуу сэглээд хаяг .

- Тэгвэл би юу бодож буйгаа хэлье би хэлсэн үгээ давтаж хэлэхээс айхгүй Та нар өчигдөр гэмгүй улсыг дүүжилж чөтгөр шулмын муу юм. хийжээ Хөгшин ноёны хохь болж Ми ни й сана ага а р болдогсон бол тиймэрхүү амьтдыг бүгдий нь тэгэхсэн, тэгвэл таарах юм. миний хамт байг а а хүний нүүр царайнаас айх сандрах, хулчийх доромж байдал нэгмөсөн ариллаа сэтгэл нь сэргэж нүднийх нь оч гялалзаад ирлээ

- чи тагнуул, ярьж буй үг чинь урхи байлаа. ч гэсэн тийм үгийг дахин дахин сонсохын тулд дүүжлүүрт очсон ч би бэлэн байна. тийм үг чинь өлсгөлөн бидэнд найр хурим, будаа гэсэн үг чи ховч нь юм. бол одоо миний хэлэх үгийг сонсоод очиж хэл би ноёноо хамгаалахад хичээл эс гаргавал би өөрөө алагдах байснаас хөршүүдээ дүүжлэхэд тусалсан хэрэг Бусад маань ч өөрцгүй тэгж бодоод л тусалсан хэрэг Н о ёныг үхсэн болохоор бүгд өнөөдөр баяртай байгаа, гэсэн ч гунын гутарсан гашуудсан царай гаргаж худал нулимс гаргаж биеэ хамгаалж байгаа би хэлэх гэсэн үгээ бүгдий нь хэжлээ, бүгдий нь хэллээ хэлэх үг аманд минь хэзээ ч ийм сайхан амттай байгаагүй юм. энэ чинь л шан болж байна. Одоо намайг дуртай зүгтээ аваад яв, дүүжлүүр лүү ч аваад явсан, бие минь бэлэн байна. Харахгүй юу хүн гэгч хэзээ боловч хүн чанараараа үлааэг юм. Олон зуун жилийн туж дарлаж хавчиж муугий нь үзэж байлаа. ч хүн чанары нь арилгадагүй юм. Үүнийг алдаа гэж бодвол өөрөө алдаж байгаа нь тэр Ямар ч ард түмэн, хамгийн их дарлагдсан орхын ард түмэн ч, туйлын аймхай хулчгар германы ард тү мэн ч гэсэн бүгд найрамдах төр байгуулах хүрэлцэ хүйц хүч чадалтай байгаа юм. Царцаж хөшсөн мэт байдлаас нь гаргаад л орхивол ард түмэн гэдэг бол ямар ч хаан ширээ, ямар ч тайж язгууртанг хөл дороо хийгээд шавар шавхайн дунд дэвслээд хаячихна Бидэнд үзэж ханах юм. их ч буй, итгэж найдах юм. ч их байна. Эхлээд Артурын нас барта л зөөлөвтөр хаант засагтай байх болно. Дараа нь хаан ширээг буулгаж тайж язгууртныг устгаж тайж нарыг ашигтай тустай ажилд оруулах болно. Дараа нь нийтийн сонгуулийн журам тогтоож ард түмэн болдог эр, эм хүмүүсийн гарт засгийн эрхийг үүрд өгөх болно. Үнэхээр, миний бие өөрийн хүсэл мөрөөдлөөс татгалзах үндэс хараахан алга даа

Гучин нэгд үгээ р бүлэг

МАРКО

Нүүрсчин Марко бид хоёр дуртай юмаа зоволгүй ярилцан баахан зугаалан алхлаа Бид

хоёр Аббласур хэмээх жижигхэн гацаа хүрч алан хядагчдын хойноос хөөгүүл мордуулаад эргэж ирэхэд орох цагийг үрэх хэрэгтэй байсан юм. Тийнхүү алхаж зугаалахдаа би Артурын улсад ирсэн цагаас хойш сонирхохоо ер зогсоо гүйчлэн явуулын хүмүүс бие бие лүгээ тааралдахдаа мэнд усаа хэрхэн мэдэлцэхийг сонирхож байв. Нүүр нийх нь хөлс хацраа даган цуггах тарган, үсээ мулзай тал хуссан ламтай тааралдахдаа нүүрсч маань газар сөхрөх шахам мэхийн ёслол Тайж хүнтэй тааралдах даа боолын ёсоор бөхөлзөж байна. Жижиг аж ахуйтан, гар урчуудтай уулзахдаа яриа хөөрөө тэй бөгөөд элэгсэг дотно байдалтай харагдана Харин боол хүн хүндэтгэн ёслол өнгөрөхөд нүүрсчин маань түүнийг үзсэн царай ч гаргахгүй ярвайн ихэмсэглэн өнгөрнө тиймэрхүү инээдтэй балай юмыг харахаас хүн төрөлхтөнг хүйс тэмтрэн дүүжлүүстэй санагдана Гэнэт бид хоёрт сонирхолтой нэг юм. тааралдав Ойн дундаас гэнэт шалдан нүцгэн айж сандарсан баахан эрэгтэй эмэгтэй хүүхэд хашгиралдан гүйлдэн гарч ирлээ Хамгийн ахмад нь арван хоёрарван дөрвөөс хэтрэхгүй Тэд туслаарай гэж хашгиран гуйх боловч чухам юу болоод байгааг нь ойлгосонгүй Бид хоёр тэдний хойноос ой дотор бушуухан ороход төдхөн учир нь ил болов. Тэд нэгийгээ хусны дурсаар модноос дүүжлчихсэн цаадхи нь мултрах гэж зүтгэн байж оосроо бүр чангаруулан боож үхдэгийн даваан дээр очоод байлаа. Бид түүний нь буулгаад ухаан о р уулж өглөө хүүхэд гэгч томчуудыг дандаа дууриадаг амьтад, хаана ч өөрцгүй хүн төрөлхтний ерөнхий нэг шинж юм даа Тэд олон хүн болж тоглож байсан болохоор тог лоом нь хэтэрч дэмий юм. их болж мэдэх байжээ., Тэр зугаалгын үеэр би уйдаагүй юм. хэдэн цаг зарсан маань талаар өнгөрөөгүй . Олон хүнтэй танилцаж өөртөө т сонирхсон олон юмыг гаднаас яваа хүний хувьд сураглан мэдэж авлаа Төрийн зүтгэлтний хувьд миний бие юуны өмнө цалин хөлсий нь сонирхсон тийм богино цагт цалин хөлсний тухай бүгдий нь мэдэж авсан юмдаг Туршлага багатай буюу юмыг олон талаас нь эрэгцүүлэн боддогүй тийм хүн бол Ямар нэгэн ард түмний амьдралын хэр хэмжээг цалингийнх нь дундаж хэмжээгээр багцаалах гэдэг юм. цалин нь өндөр бай вал тэр ард түмнийг цэцэглэн хөгжиж байна., доогуур байвал тэр ард түмнийг ядуу амьдарч байна. гэж үзнэ гэтэл энэ бол худал юм. Авч байгаа мөнгөний тоо нь чухал биш харин авч буй мөнгөөрөө юу худалдан авч чаддаг нь илүү чухал байдаг Үүгээр л цалин хөлс нь их үү, бага уу гэдгийг тодорхойлно . Арван есдүгээр зууны дундуур иргэний их дайн манай оронд болж байх үеийн цалингийн байдал ямар байсныг би санаж байна. Умар зүгт мужаан хүн алтаар тоо цоход гурван доллар өдөрт авдаг байсан байхад Өмнөдөд ганц Бушель будааны үнэтэй цаасан мөнгөөр бодож тавин доллар өгдөг байлаа. Умардад ажилчны ажлын хувцас гурван долларын үнэтэй байсан нь ганц өдрийх нь цалинтай тэнцэж байсан бол Өмнөдөд далан тавгай буюу хоёр өдрийнх нь цалинтай тэнцэж байсан Бусад эд барааны үнэ мөн тиймэрхүү харьцаатай байв. Тэгэхлээр, Умардын цалингийн хэмжээ өмнөдөөс хоёр дахин их байсан, яагаад гэвэл худалдан авах чадал нь хоёр дахин илүү байж Тэр тосгонд би олон хүнтэй танилцсан Тэндхийн гар урчууд, тариачдын гарт бидний гүйлгээнд оруулсан шинэ зоос мильрейс, милль, цент, диц, мөнгө олон байхыг үзэхэд баярламаар байлаа. Аль ч гэсэн нэлээд байсан, тэгэхдээ банкинд буюу өөрөөр хэлбэл инжааны мэдэлд байлаа. Маркогийн хүү нүүрсчин Марко мухлагийн эзэнтэй хагас фунт давсны мөр дээрээс наймаацаж байхад нь би тэнд орлоо хорин долларын алтан зоосыг бутархай болгож өгөөч гэхэд нь задалж өгсөн билээ. Тэгэхдээ мань хүн эхлээд хазаж шүдэндээ цохиж үзэж, лангуун дээрээ хангинуулан лаяж үзэж, тэгснээ хүчлээр шалгаад намайг энийг хаанаас авсан, та юун хүн бэ, хаанаас явж байна., аль орох нь вэ хэзээ зорьсон газраа хүрэх гэж байна. гэх мэт өдий төдий юм.аар хоргооход нь би хариулах мөртлөө өөрийнхөө сайн дураар нэмэрт нь нэлээд юм. дуулгалаа надад нэг манаач гэдэг нохой байдаг, миний авааль эхнэр баптын шашинтай байсан, өвөө

маань архи дарс хориглох талын хүн байсан, хоёр гарынх нь эрхий хуруу хоёул салаа тийм гартай, бас дээд уруулынхаа дотор талд үүтэй тийм нэг хүн байж байгаад хожим азтай одонд дахин төрнө гэж найдаад үхэж байсныг мэдэж байна. гэх мэтийн тун олон юм. ярьж өгч билээ. Тэгж тэгж хөдөөний тэр бан к ны эзэн маань сонссон юм. эндаасанаа өөгшиж тэр ч байтугай бага зэрэг гуниглах маягтай байлаа. Над мэтийн баян гэгдэх хүнтэй хүндэтгэлээр харь цаж, уурлах уцаарлах номгүй боловч уураа доод хүмүүстээ гаргаж байлаа., тэр нь ч зүйн хэрэг юм. миний хорин долларын зоосыг буталж өгөх нь өгсөн боловч тэр нь арван есдүгээр зууны үеийн хөдөөний нэг өчүү хэн жижиг бэнк хорин мянган долларын дэвсгэртийг задлахтай адил тийм ч амар юм. биш байсан даг аа Мухлагийн эзэн тийм мөнгөн тэмдэгтийг бутлах байсан байлгүй, гэхдээ жижиг аж ахуйтай хүн тийм их мөнгө тэй явна гэж гайхах байсан ийм ч учраас тэр инжаан тэгж их гайхаа биз Намайг гарахад үдээд миний араас ихэд бишрэн гайхаж байв. Манай гаргасан мөнгө тэр үед газар сайгүй тарах болж ердийн мөнгө болж байсан учраас зарим нь хуучин мөнгөнийхөөнэрийг ч мартаж эхэлсэн байв. Төдөн доллар, төдөн цент ч гэх юм.уу, өчнөөн миль, төчнөөн мильрей гэж ярилцах л болсон байлаа. Тун аятайхан санагдаж байсан бөгөөд дэвшин буйн нэг баталгаа мөн билээ. би гарын уртай олон хүнтэй танилцсаны дотроос хамгийн сонийрхолтой нь төмрийн дархан Даули байсан юм. их цовоолог, яриа хүн байсан бөгөөд хоёр туслах, гурван шавьтай байгаа хэр нь ажлаа бардаггүй тийм их ажилтай байдаг ажээ. Харин өдөр ирэх тоолонд эд хөрөнгө нь зузааран баяжаад олны хүндэтгэлийг олж гэ энэ тийм хүнтэй танилаараа Марко бахархаж байна. Өөрөөс нь их нүүрс авдаг тэр хүний чадалтай үйлдвэрийг үзү ү лнэ гэж намайг түүн дээр аваачсан боловч үнэндээ тийм их хүнтэй хичнээн дотно танил болохоо үзүүлэх гэсэн байж л дээ Даули бид хоёрын санал нийлж билээ. миний зэвсгийн Гар буу ү йлдвэр дээр тиймэрхүү сайн залуус олон ажиллаж байлаа. би түүнийг Маркогийн ням гаригийн орой ирж бидэнтэй үдийн хоол зооглохыг урьсан юм. Маркогийн сэтгэл жигтэйхэн хөдөлж баяныг урилга хүлээн авахад баярласандаа соёрхохы нь ч анзаарсангүй Марко оодрон байсан боловч төдхөн гонсойж бодол болов. Чулуучин Диккон, дугуйчин Смуг хоёрыг бас урина гэж намайг Даулид хэлж байхыг тэр сонсоод нүүрс шиг хар царай нь шохой шиг цайж сэтгэлээр бүр унав Яагаад тэгсэн шалтгааны нь би мэдсэн юу гэвэл их зардал гарах нь гэж айсан хэрэгл дээ Өөрөө одоо үгүйрч жаахан хөрөнгөө барав гэж боджээ Тэгээд би бусдад урилга явуулахдаа

- миний нөхдийг урихыг зөвшөөрөөрэй зардлы нь би өөрөө даах юм шүү гэж хэлж байлаа. мань эрийн хөмсөг тэнийгээд тун улайж

- Бүгдий нь яалаа гэж, бүгдий нь болохгүй, чи яаж ганцаараа барах вэ гэхэд нь би

- Өвгөн найз минь намайг ойлго би фермийн л удирдах хүн, гэхдээ би тийм ч ядуу хүн биш Энэ жил би их азтай байгаа юм. хичнээн мөнгө олсныг дуулбал чи гайхах байх би иймэрхүү урилга цайлгах арав хориор нь зохихон ч зардлы нь яах бол ийх бол гэж бодохооргүй, тэр бол огт юм.ан чинээ юм. биш санагдана гээд хуруугаа инчдэв миний хэлэх үг болгон намайг Маркогийн нүдэнд агуу том болгож буйг би мэдэж байсан бөгөөд сүүлчийн өгүүлбэрийг хэлж дуусахад цамхгийн дайтай болсон байлаа.

- ийм учраас чи минийхээр болгооч Энэ найранд чамаас ганц ч центийн зардал гаргуулахгүй, энэ бол шийдсэн хэрэг гэв

- чи их сайн санаатай бодь хүн

- тийм биш ээ чи өөрийнхөө гэрийн үүд хаалгыг надад болон Жонст уужим сэтгэлээр нээж өгсөн хүн Жонс өөрөө надад ингэж хэлсэн Жонс үг цөөнтэй зовомтгой хүн болохоор чамд өөрөө ингэж хэлээгүй л дээ, гэвч сэтгэл зүрх нь ариун бодь учраас өөртөө сайн байгаа хүнийг зөв ухаардаг үнэлж чаддаг хүн чи авгайтайгаа хоёул биднийг найрсгаар хүлээн авсан шүү дээ

- Ай, дүү минь , найрсгаа ч алд даа Хэдий юу ба заах вэ

- юу гэсэн үг вэ, тун их учиртай хүн өөртөө байгаа өөдтэй гэсэн юмаа л өгнө гэдэг чинь нэн сайхан хүнтайз ч гэсэн өөртөө байгаа хамгийн дөмөг юм. наасаа илүү дөмөг юм. өгч чадахгүй шүү дээ Одоо хоёп гадуур дэлгүүр мухлагаар орж юм. хүм худалдаж авья чи надаас гарах зардалд бүү зов би чинь хорвоод хогүй үрээчин байгаа юм. заримдаа ганц долоо хоног, за за хэлэхээ больё доог чи яагаад ч үнэмшихгүй Бид хоёр тийнхүү тосгоны мухлагуудаар хэсэн үнз хэлцэн өчигдрийн болсон явдлын тухай ярилцан явлаа Эцэг эхий нь алж дүүжлээд Тэр орны нь булааж авсан өнчин өрөөсөн үлдсэн хүүхэд шуухад энд тэндгүй таа ралдах тул өчигдрийн явдлыг минут тутам санагдуулмс байсан юм. Марко болон түүний авгай хоёрын хувцас нь зотон, сермяг даавуугаар зүйж хийсэн болохоор өөдсөөр наасан газрын зураг шиг эрээн тарлан харагдана Тав зургаан жил сэлэлгүй өмссөн болоод анхных нь да а вуунуудын өөдсөөс ал гын чинээ ч үлдсэнгүй Гийчдийн өмнө нэр хугалахгүйн тулд би тэр хоёрт шинэ хувцас худалдан авч бэлэглэн барья гэж бодовч өөрийнхөө талархлыг эд бараагаар илэрхийлье гэсэн бодлоо ванд яаж зөв ойлгуулах ухаанаа олоогүй байсан болохоор яаж аялуулахаа мэдэхгүй байлаа. Тэгээд би

- Марко би чамаас бас нэг гуйх нь , Жонсыг бодож, чи тэрүүнд дэмий юм. бодогдуулаад хэрэггүй шүү дээ Чамд баярлаж талархсанаа хэлэхийг хүсэвч зовоод хэлж чадахгүй байна., цаадхи чинь бүрэг хүн байгаа юм. Тэгээд чамд, бас хатагтай Филлист өөрийнхөө м ө нгөөр юм. авч бэлэглээрэй гэж намайг гуйсан юм. тэгэхдээ хэн юм. бэлэглэсний нь та нар мэдэхгүй байвал зохих юм. битгий намайг гэж хэлээрэй гэсэн юм. л даа юманд амархан гомддог хүн болохоор би уг нь нуух ёстой байсан юм. гэвч намайг хэлчихгүй биз дээ Та нарт шинэ хувцас хүнар авч өгвөл л дээр гэж байна. лээ

- Өө, юун их юм. Яах юм. яах юм. дүү минь хичнээн их мөнгө орно, бодоод үз э эч

- за, яадаг юм. үнэтэй байвал байж л байг Жаахан дуугүй бай, чи дэндүү олон юм. ярьж байна., өөр хүн амьтанд ганц ч үг цухуйлгах хэрэггүй чи ер нь илүү үг ярьдаг өвчнөө эмчлүүлбэл таарах хүн байна шүү Марко энэ муу шүү, илүү үг чалчдаг чинь чамайг баллана, урт хошуу хүзүү орооно гэгч л болж мэднэ шүү ээ ороод тэрдаавууны үийг асууя, Жонст юу ч мэдэгдэж болохгүй жигтэйхэн өөнтагч омогтой бардам эр шүү, цаадхи чинь Фермийн эзэн, баян хүн, би бол түүний аж ахуйн дарга нь , тэрний толгойд ордог бодол гэвэл маягтай даа заримдаа хамаг юмаа мартчихаад чалчиж байхыг нь ажихад хүн төрөлхтний сор гэгч ийм л байх гэж бодогдмоор байдаг юм. Тэрний ярихыг, ялангуяа хөдөө аж ахуйн талаар ярьж эхлэх юм. бол чи түүнийг зуун жил сонсоод ч ферми й н эзэн хүн гэж итгэхгүй Дэлхий дээр хөдөө аж ахуйг хамгийн сайн мэддэг хүн гэж өөрийгөө тоо цно гэтэл энүүхэндээ гэхэд мань эр хөдөө аж ахуйн талаар мэддэг юм нь ван лигийн талаар хэр зэрэг мэддэгээс нь хэтэрдэгүй юм. Гэхдээ ярьж эхлэхэд нь ийм мэргэн цэцэн яриатай хү нийг энэ насандаа ер үзээгүй мэт амаа ангайн ганц ч үгий нь хаялгүй авах гэж байгаа юм. шиг л байгаарай Тэгэх юм. бол Жонс их дуртай байх болно. Марко тийм марзан амьтны тухай сонсоод хагдана тал инээж одоо хэр

баргийн юманд гэнэдэхээргүй болов. Харин би бол вантай хамт аялан явахдаа ван маань хэн болж яваагаа мартчихаад байн байн золигтдог болохоор иймэрхүү байдлаар хаяагаа манаж байхгүй бол горьгүй байсан шүү дээ, үнэндээ Тэгж, тэгж бид хоёр тэр гацааны хамгийн дөнгүүр мухлагт орлоо Алх цүүцнээс өгсүүлэн даавуу шуувуу, загас жараахайн мах, далайн хөөс хүртэл юм. юм.наас бага сага байх юм. . би тэндээс авах гэсэн болгоноо авчихья, өөр хаашаа ч орохгүй юмсан гэж бодсон Тэгээд хамгийн түрүүн чулуучин, дугуйчин хоёрыг урих ажилд Марког явуулж, ганцаараа болж аваад дуртай гаараа туйлах болов. шүү дээ би бол аливаа юм. хийхдээ зүгээр чимээгүй өнгөрөөдөг хүн биш заавал жаахан а м т шимт оруулдаг зантай Эхлээд би мухлагийн эзний анхаарлыг татаж биеэ хүндэтгүүлэхийн тулд лангуун дээр нь мөнгөө гарган хайш яйш хаялаа Тэгээд авах юм.ныхаа нэрсийг жагсааж бичээд энэ ер нь бодож чадах хүн үү, үгүй юу хэмээн тэнсэхээр өгөө Тэгсэн чинь чаддаг хүн байж, чаддагаа харуулах гэж сүрхий баяртай байв. Нэг ламд шавь ороод ном уншиж бичиж сурсан гэнэ . Жагсаасан юмны нэрсийг гүйлгэн уншиж үзээд гайгүй юм. их авах нь гэж сэтгэл хангалуун байлаа. Үнэндээ овоо их, ялангуяа тийм жижигхэн мухлагаас бол тун их юм. авч буй хэрэг байлаа. идэж уух юм.аар зогссонгүй өөр юм. ч авсан юм. чинь Тэр бүх авсан юмаа Маркогийн хүү Маркогийн тэргээр бямба гаригийн орой хүргэж өгөөд тооцоог нь нэг дэх ч өдөр үдийн хоолны алдад ирүүл гэж тушаалаа Манай ферм цаг хатуу баримталдаг, нямбайгаараа нэртэй газар учраас та сэтгэл бүү зов гэж мухлагийн худалдагч хэлэв Маркод үнэгүйгээр хоёр түрийвчгар буу өгнө, одоо тийм юм. их хэрэглэдэг болцгоосон юм. гэж тэр хүн нэмж хэлэв Тэр мэргэн зохихон зүйлийг тун их тоосон байна. Тэгээд би Дундуур нь хүртэл тэр хоёрыгаа дүүргэж орхиод тооцоондоо оруулаарай гэхэд дуртай зөвшөөрч дүүргэхэд нь би аваад явсан юмдаг Энэ бол миний өөрөө зохихон зүйл бөгөөд ванлигийн харьяаны бүх мухлаг дэлгүүрт бэлээхэн байлгаж сангийн үнээр, өөрөөр хэлбэл санд биш ч гэсэн мухлагийн худалдаачдад хямд тусах жаахан үнээр худалдаж бай гэсэн гэж түүнд хэлж чадаагүй билээ. Бид тийм юмыг үнэ төлбөргүй нийлүүлж байсан юм. Бид хоёр орой нь буцаж очиход ван мэдээгүй байв. Эрт унтаж өөрийнхөө их цэргийг удирдан Гайли руу дайран орж байна. гэсэн сүртэй зүүдээ зүүдэлсэн болохоор тэр өдрийн хагасыг мэдэлгүй шахам өнгөрөөжээ

Гучин хоёрду га ар бүлэг

ДАУЛИЙН ШИВШГИЙГ ТАРЬСАН НЬ

Бямба гаригийн орой нар шингэх үеэр нөгөө ачаа ирэхэд Марко эхнэрийн хамт муурч унаад намайг нэлээд зовоолоо Тэр хоёр, Жонс бид хоёрыг ингээд үгүйрлээ гэж бат итгээд тэгж үгүйрэхэд нь өөрснөө д араа болов. хэмээн өөрснийгөө хараан зүхэж байлаа. би үдийн будаалганд хэрэглэх хүнсний зүйлд мөнгө их гаргасны дээр гэрийн ээдэд хожим ч хэрэг болох олон зүйл авсан, жишээ нь шуудай улаан буудай Тэдний ангийн хүмүүс хоолондоо цагаан талх хэрэглэнэ гэдэг бол аглагч хүн зөөхий тэй м ө хөөлдөс хэрэглэх адил тун хо в ор нандин зүйл юм. бас хоолны том ширээ, хоёр фунт давс давс бол тэднүүст мөн л хээнцэр зүйл ажээ. сав суулга, хэдэн исэр, хувцас хүнар, нэг жижгэвтэр торхтой шар айраг гэх мэтийг худалдан авсан юм. Гийчид гайхаж худал дэмий юм. бодох магадгүй гэж бодоод Марко, авгай хоёрыг хүнд ердөө битгий хэлээрэй гэсэн Шинэ хувцас хүнар үзээд тэр эр эм хоёр нялх хүүхэд шиг баярлаж байлаа. Шинэ хувцсаа өмсөхсөн гэхээс шөнөжин нойргүй хонож үүр цайхыг хүлээж үүр цайхаас бүтэн цагийн урьд босон хувцасласан байж би лээ Тэдний тэгж их баяр хөөр болж байхыг харахаас нойр дутуусэрсэндээ ч гонсойгоогүй юмдаг Ван угийн зангаараа үхсэн юм. шиг дугжирч байлаа. Ванд талархсанаа мэдэгдэж болохгүй гэж би тэр

хоёрт захисан болохоор тэр хоёр тэгж чадахгүй байсан боловч тун их талархалтай байгаагаа харуулахыг хичээж байв. гэвч цаадхи нь юу ч мэдэхгүй байсан болохоор хэнэг ч үгүй байв. Зургаан сарын тэр нэгэн өдөр ер бишийн цэлмэг дулаан сайхан бөгөөд гадаалахад диваажин мэт санагдах тул дотогш ормооргүй байлаа. Зочид үдийн алдад хүрэлцэн ирлээ нэг том модны сүүдэрт сууцгаан хэзээ ёзооны хуучин танил нар шиг яриа хөөрөө ихтэй байв. Ванг хүмүүс эхлээд зүгээр л Жонс гэж дуудахад дасна гэдэг амаргүй байсан боловч сүүл сүүлдээ овоо гайгүй болж бала, Ван өөрийгөө фермийн эзэн хүн гэж ярьж байгаарай, тэгэхдээ нэг их тодорхой юм. ярих гэсний хэрэггүй, тийм л хүн гэдгээ хэлчихээд олон таван үгүй байж болно. гэсэн юм. Ван Маань угаас хэл нь дэндүү уян хатан, ухаан нь дэндүү идэвхтэй, сонсож мэдсэн нь тал түл тийм маягийн хүн болохоор сануулж сургаж байхгүй бол хамаг юм. баллаж орхих гээд болж өгдөггүй юм. Даули тогос шиг ганган хувцаслажээ Түүнийг би шүүрхэж зоволгүй ярьж үүх түүхээ дэлгэхийг гуйгаад байх зовлон надад гараагүй модны сүүдэрт суу ч хаад чалчихыг нь сонсох таатай байв. Өөрөө өөри й нхөө аз жаргалыг олсон гэнэ тийм хүмүүс ярьж ч чаддаг л даа тийм хүмүүсийг хүндэтгэх нь зүйтэй, өөрснөө ч хүндэтгүүлэхийг шамддаг Анх амьдралын замд түрийв чиндээ мөнгөгүй, хажуудаахань нөхөд гэх юм.гүй ор сон гэнэ зарим ноёны боолоос ч дор амьдарч явсан гэнэ Өдөрт арван зургаа, арван найман цаг ажиллаж ганц хар талхаар амь зуун, бас ч ө л мөлхөн л явд аг байсан гэнэ Тэгж явтал гэнэт нэг сайн санаат төмөрчин түүнийг тоож хоол хүнс, хувцас х у нары чинь даая, чи миний шавь бол хэмээхэд нь баярласандаа арай л мууран унаагүй, тэгээд төмрийн дархан л Даулийн үгээр тэр нууцаа зааж өгсөн гэнэ Энэ бол түүний анхны дэвшилт, анхны гялалзсан амжилт байжээ. Одоо ч гэсэн тэр тухайгаа бахархан ярих бөгөөд хамгийн жирийн хүнд тийм ер бишийн аз тохиол таарна гэдэг мөн ч сонин хэмээн өөрөө гайхаж барахгүй байна. Шавь орсон цагаасаа хойш хувцсаа ер сэлээгүй явсаар шавилах хугацаа дуусах өдөр ирэхэд эзэн нь сермяган цоо шинэ хувцас өгсөн гэх ба тийм хувцастай болоход хэлж барамгүй баян, ганган санагдсан гэнэ

- би тэр өдрийг хэзээ ч мартахгүй гэж сэтгэл өрнүүн хэллээ

- би ч гэсэн Тэгэхэд би чамайг тийм хувцастай болсон юм байна. гэж итгээгүй шүү нээрэн итгээгүй гэж чулуучин хажуугаас нь хэлэв,

- Хэн ч итгээгүй би хулгай хийгээгүй юм шүү гэж би айл амьтныхандаа итгүүлэх гэж үйлээ барж байсан юмдаг Агуу их өдөр, мартагдашгүй дурсгалтай өдөр байсан юм шүү гэж Даули нүд гялалзуулан хашгирч байна. Эзэн нь үнэхээр сайхан хүн байж, ажил нь өөдрөг байсан болохоор жилд хоёр удаа мах, цагаан гурилтай, ёстой цав цагаан гурилтай хоол амаараа гартал иддэг, ер нь үнэнийг хэлэхэд ноён хүн шиг амьдардаг б а йсан юм. гэнэ Сүүл сүүлдээ Даули түүний үйлдвэрийн газрыг өвлөн авч охинтой нь суусан юм. байж

- Одоо хар л даа, юм. бүхэн мөн ч их өөр болжээ. Сард хоёр удаа шинэ мах идэх боллоо гэж мань хүн шамдангуй хэлээд сонсогчиддоо өөрийнхөө үгний учир утгыг сайн ухааруулах бололцоо олгохын тулд түр дуугүй болсноо үхрийн давсалсан мах сард найман удаа идэх боллоо гэв

- Энэ ч үнэн гэж дугуйчин амьсгаа даран хэлэ в.

- би нүдээрээ үзсэн гэж чулуучин хүндэтгэсэн байдалтай хэлэв

- Манайх жил тойрон ням гариг болгонд цагаан талх иддэг, нөхөд минь , энэ чинь үнэн

шүү дээ гэж төмрийн дархан ихээхэн хөөрүү байдалтай хэллээ

- Үнэн байлгүй яах вэ, толгойгоороо тангараглая гэж чулуучин хашгирав

- Манай гэрийн тавил хэрэгсэл ямрыг та нар хэл л дээ, юу хэлмээр байна., хэл л дэр, намайг энд байхгүй байгаа гэж бодоод хэл гэж Даули хоёр гараа алдлан үг хэлэх эрх чөлөө олгож буй мэтээр хэлэв

- Танайх гурван хүнтэй мөртлөө сайхан хийцтэй таван исэртэй байна. гэж дугуйчин гүн хүндэтгэлтэйгээр хэлэв

- идэж уухын тулд танайх зургаан модон аяг а , зургаан модон тавапай, бас хоёр цад байна. Үнэнээр нь хэлж байна шүү, худал хэлсэн бол бурхан намайг Аймшигт шүүхийн өмнө хариуцуулаг гэж чулуучин хөөрүү байдалтай хэлэв

- за одоо, Жонс дүү минь , чи миний ямар хүн болохыг мэдэв үү, тэгээд тийм хүнийг хүндэтгэх ёстой, тийм хүн Таньж мэдэхгүй хүнтэй шаанпаан гэхгүй, хэн болохы нь мэдэхээс нааш чингэх ёстой гэдгийг мэдэ биз дээ, гэвч чи зовох явдалгүй, хүн нь хүн шиг сайн бол энэ хорвоод ямар ч доогуур байр эзлэж байсан тийм хүнийг би өөртэйгээ адил үзэж, найз нохрөө гэж бодно Энэний маань баталгаа энэ гэж гараа барья, ий бид хоёр адил, эрх тэгш, ав адил гэдгийг би өөрөөхэлчихье гээд инээх нь бурхан буянтай сайн үйл үйлдээд тэрнийгээ өөрөө ойлгосон мэтээр төмрийн дархан маань малилзаж гарлаа Ван түүний гарыг цаанаа их дургүй байдалтай атгаснаа хатагтай хүн гараасаа могой загас алдах шиг бушуухан тавилаа Энэ нь онцгой сайхан сэтгэгдэл төрүүлэв, яагаад гэвэл их хүний сүр жавхланд автсан хүний ичиж зовохын тэмдэг гэж боджээ Нүүрсчний авгай будаа зассан ширээг модон дор авчирч тавилаа Ширээ нь цоо шинэ, хийц сайнтай байхыг хараад зочид гайхаж байна. Филлис хатагтай тун жишимгүй байдалтай байхыг оролдовч нүдэнд нь онгирон сайрхах оч тусаж байх ба ширээг нүд гялбам цагаан даавуугаар яарамгүй бүтээхэд зочдын гайхаш туйлын ихсэж ирэв Төмрийн дархных хичнээн догь ч гэсэн тийм бүтээлэгүй байсан болохоор ягүй цохилт үзэх нь ил байв. Харин Марко бүр диваажинд оччихоод жаргалаа эдэлж буй мэт хар аг дана Филлис цоо ши н э хоёр исэр авчирч тавихад гийчдэд дуулиантай шиг юм. болов. Дараа нь бас хоёрыг сэтгэл догдопсон ба й дл а а далдлахыг хичээсээр авчрав Бас л дуулиантай юм. болов. хоорондоо биширсэн янзтай шивнэлдэх сонсдоно Бас хоёрыг авчрахад бүр хачин болох бөгөөд Филлис х ө л нь газар хүрэхгүй хий агаарт дүүлэх мэт харагдана Гийчид гайхалдаж чулуучин

- ийм хээнцэр ганган юм. үзээд өөрийн эрхгүй биширч байна. гэв Филлисийг Тэр лүүгээ эргэхэд нь Марко төмрийг халуун дээр нь давт гэгчээр өөрийн сэтгэлийг барьж ядан байж

- Одоо болно., бусды нь авчрах хэрэггүй гэлээ. Бусды нь гэнэ Бас цаана нь байх нь Сүрхий нөлөөлж чадав, би ч тэгж нөлөөл ө х ухаанаа олохгүй байх шүү Дараа нь сонирхлын халууныг сүүдэр газар зуун тавин градус хүртэл нэмэгдүүлсээр сүүлдээ хэлэх ч үгүй болгон бүгд л аах, ээх хэмээн гайхалдаж байснаа дуу шууч тасарч гагцхүү тэнгэр өөд гар нь сарвайж, нүд нь ширтэх болов. Авгай, гэрээсээ цоо шинэ сав суулга, шинэ шинэ модон аяга таваг, түүнчлэн шар айраг, за гасны мах, тахианы мах, нугасны мах, өндог, үхрийн шарсан мах, хонины шарсан мах, гахайн мах, шарсан торой, том том цагаан гурилын талх авчирч тавилаа тийм сайхан юм. үзсэн хүн тэднүүсийн дунд ганц ч үгүй ажээ. Тэднүүсийг тийнхүү гайхсандаа нүд нь бүлтийлцэн толгой нь эргүүтэн мансуурсан байдалтай сууж байхад миний бие гараараа санаандгүй сэвчийх байдалтай хөдөлтөл миний өмнө мухлагийн эзний хүү газар

дороос гараад ирэх шиг болорд мөнгөө авахаар ирлээ гэв

- за өгье гэж би тайван хэлээд Бүгд хэд болсон байна. Дүнгий нь хэлээтэх гэлээ.,

- Түүнийг дор дурдсан байдлаар тоо цоог дуудахад гийчид цочиж, миний дотор бөөн баяр хөөр оргилж байсан бөгөөд Марко дотор нэг харанхуйлж, нэг цэлсхийн баярлах сэтгэл цээжинд нь багтан ядаж байлаа.

2 фунт давс 200

Модон торхтой н а йм ан дюжин пинг пиво 800

3 Бушель ула ан буудай 2700

2 фунт загас 1 00

3 тахиа 400

галуу 400

36 ө ндөг 150

Үхрийн шарсан мах нэг хэсэг 450

Хонины шарсан мах нэг хэсэг 400

Гахайн гуя нэг 800

Х ө хүүл торой нэг 400

Х оолны төрөл б үрийн хэр эг сэл , 2 э элж 6000

Эр хү ний хувцас хоёр ээл ж дотуур хувцас 2800

б анз ал, н оосон цамц, дотуур ху в цас 1600

8 модон ая га 800

Гал тогоон ы иж бүрийн хэрэглэл 10000

Ширээ 3000

8 исэр 4000

Цэнэгтэй хоёр т ү рийвч гар буу 3000

Ингэж уншаад зогсоход ха чи н муухай чив чимээгүй болж, хэн ч хөдлөх зүрх хүрээгүй, хэн ч амьсгаагаа ч ширүүхэн авах зүрх хүрэхгүй байлаа.

- Бүгд энэ үү? гэж би тун тайвнаар асуув

- Бүгд, жавхлант ноён минь би зарим жижиг сажиг зүйлийг янз бүрийн хэрэглэл гэсэн хүснэгтэд багтаагаад хийчихсэн юм шүү Хэрэгтэй бол тусад нь

- тийм илүү ажлаар яах юм. гэж би огт жишимгүй байдалтай хэлээд дүн нь хэд болов.

доо? гэж асуулаа Даамал х ө л дээрээ лавтай зогсохыг бодож мод түшиж зогссоноо

- Гучин өсөн мянга зуун тавин мильрейс гэлээ. Дугуйчин сандал дээрээсээ унав, бусад нь суудлаасаа ойччихгүйн тулд ширээнээс барьж нэг зэрэг

- Бурхан минь , биднийгээ галт өдөр харж үзэлгүй бүү орхиоч гэж хашгиралдав Даамал баахан яарч

- Таныг нэгмөсөн төл гэж хэлэх зүрх хүрэхгүй байна., таныг зөвхөн юу гэж аав хэлсэн гэхэд нь би түүний хэлж буй үгийг хажуугийн салхины төдийд бодож огт жишимгүй байгаа янзтайгаар м ө нгөө гаргаж ирээд дөрвөн долларыг ширээн дээр шидлээ Тэднүүс тэр алтан зооснуудыг хараад нүд ам нь хичнээн хачин болон мэлэрч байгаагий нь харууштай байлаа.в шүү Даамал жигтэйхэн гайхаж цөхөрсөн байдалтай болсноо намайг хот орж задлуултал та нэг доллар барьцаанд орхино уу гэж г у йхад нь би

- Хариултын есөн центийн төлөө юу ? дэмий ажил Хариулты нь чи өөрөө а в гэлээ. Энэ үгийг сонссо н тэд гайхалдан шивнэлдэв

- мөнгө нь багтахаа больсон хүн юм даа мөнгөө хог новш шиг хамаагүй үрж байна. гэлцэв Төмрийн дархны сүнс зайлах шиг болов. Даамал мөнгөө шүүрч аваад баярласандаа мансууран ухаан жолоогүй юм. харайлган алга болов. Би, Марко, авгай хоёрт Сайнсеиаат та нартаа өчүүхэн энэ бэлгийг барья хэмээн түрийвч, буугаа гардуулахдаа дотор нь ерван тав, арван таван цент буй боловч т ун шалихгүй юм. аятай юм. өгч буй мэт царайлан өгсөн билээ. Тэр ядуу хүмүүс баярлан талархаж хэлэх үгээ олж ядан байх хооронд нь миний бие бусдад нь хандаж цаг асууж буй мэт тун тайван жишимгүй байдлаар

- Хэрэв та нар маань бэлэн бол хоол унд ч бэлэн болсон гэж бодож байна., зооглож эхлээ гэв Т э р бүхэн маань тун сайхан болсон юм. хэзээ ч би тийм үр дүн ихтэй нөлөөлж, гартаа буй юмсыг чингэж чадамгай ашиглаж байгаагүй юмаа Төмрийн дархан үнэхээр сүйд болох шиг болсон би л бол тийм болсон бол тэсэхгүй болох байсан мань эр жилд хоёр удаа маханд цаддаг, бас сард шинэ загас хоёр удаа иддэг, гурван хүнтэй айл атлаа сайн өдөр болгон үхрийн давсалсан мах иддэг байсан гэж онгирч байсан шүү дээ Тэр бүгд нь нийлээд жилд 69 2 6 жаран есөн цент, хоёр милль, зургаан мильрейс болдог байж гэтэл нэг мөсөн дөрвөн доллар гаргаад ширээн дээр шиддэг тийм хүн гараад ирдэг байна., тэгэх мөртлөө тийм мөнгийг тун тоохгүй байдалтай байхыг нь яана Даули ч үнээнд гишгүүлсэн хийлсэн бөмбөлөг аятай ө нхөрч хумиралдаж ямбийгаад явчих нь тэр

Гучин гур а вдугаар бүлэг

ЗУРГ АД УГААР ЗУУНЫ ҮЕИЙН УЛС ТӨРИЙН УХААН

Гэвч би түүнийг сэтгэл санааны талаар чармайн дэмжсэний үрээр мань өвгөн будаалгын гуравны нэг цаг ч болоогүй байхад дахин сэргэж цог золбоотой болов. Зэрэг дэв, анги бүлэгтэй оронд түүнийг тийнхүү сэргээх төдий хэцүү биш байлаа. Ер нь зэрэг дэв анги бүлгээр ялгадаг улс оронд хүн гэгч амьтан маань бү хэл хүн чигээрээ биш хагас хугас нь болсон байдаг л даа Алба тушаал, зэрэг дэв, эд хөр ө нгөөрөө илүү гэж л хүн ойлговол тэр хүн таны өмнө толгой унжуулаад өвдөг сөхрөөд өгнө чингэсний дараа та тэр хүнийг гомдоох эрхгүй болно. би ингэж хэлэхдээ та тийм хүнийг гомдоож болох л доо, гэхдээ их л зүдэрч байж гомдооно, тэгээд бас зав чөлөө багатай бол чингэх гэж оролдохын ч хэрэггүй Намайг ер

бишийн баян хүн гэж бодсон болохоор т ө мөрчин намайг хүндэтгэх болсон Хэрэв би дээрээс нь Ямар нэг өг өр тайж язгууртан гэх мэтээр ярьсан бол ч намайг бүр бурхан шиг үзэх байсан бизээ Ганц тэр ч биш, ер нь би адгийн муу новш байлаа. ч гэсэн ухаан билэг, эрхэм чанар, зан аалиараа үеийн үед байсан хүн төрөлхтний дотроос сор нь болсон эгэл хүн ч гэсэн нэгэнт л эгэл хүн болохоор тэгж үзэх ёстой байсан л даа Англи орон байгаа цагт тийм байсан, байгаа, тийм ч байх болно. би нэгэнт зөн би лэгтэй хүн болохоор ирээдүйг нэвт мэдээд Англи орон өөрийнхөө адгийн новш болсон Георгий нар болон ер нь вангийн болон тайж язгууртны цустай бас бус хүний оронцгууддаа хөшөө дурсгал босгож, харин энэ хорвоог бүтээхэд бурхны дараа шууд орох Гутенберг, Вагт, Айсрайт, Витни, Мбрзе, Стефенсон, Белла нарыг ямар ч хүндэтгэл ёслолгүй оршуулж байхыг нь үзсэн юм. гэтэл тэр хооронд ван мал болтлоо уугаад дайн байлдаан, ялалт, халз тулааны тухай ярилцаж байсан болохоор нойр нь хүрч төдхөн хурхиран дугжирч гарлаа Марко авгай ширээ цэвэрлэж бидэнд шар айраг авчирч өгөөд өөрөө нэг газар ганцаархнаа бидний шавхруугаар гэдэс гарах санаатай явав бололтой Бид өөрснийх өө зэрэг дэвд таарсан ажил хэрэг, цалин хөлс нийхөө талаар баахан ярилцлаа Багдемагус вангийн толгойлдог тэр жижигхэн вант улс оронд хэрэг явдал нэлээд өөдрөг аятайхан байгаа мэт өнгөндөө буюу миний захирдаг газрынхантай зүйрлэхэд нэлээд өөдрөг аятайхан мэт санагдаж байв. энд протекционизмын бодлого биеллээ олсон байхад манай тэнд чөлөөт худалдааны талаар анхны алхам хийж зөвхөн замын хугаст очсон байлаа. Даули бид хоёр л яриад байдаг, бусад маань бид хоёрын амыг харан анга й н сонсож байлаа. Даули ам нь халж сүүл сүүлдээ надаас давуу байдалтай болов. хэмээн бодоод надаас баахан юм. шалгааж эхэлсэн бөгөөд ухаандаа намайг мэдлэх санаатай байсан нь үнэхээр ч заримдаа ягүй байв.

- Танай оронд захирагч, бойдаа, адуучин, малчин, гахайчин ямар хөлс аваг Өдөрт хорин таван мильрейс, өөрөөр хэлбэл центын д ө рөв н ий нэг Т ө мөрчний царай тавирч хэлэхдээ

- Манайханд бол хоёр дахин илүү авдаг байна. Харин гарын ур хийдэг мужаан, чулуучин, будагчин, төмрийн дархчуул хэдий авдаг вэ дээ?

- Дунджаар өдөрт тавин мильрейс, хагас цент, өхө Манайханд бол зууг авна Манайд сайн дархан хүн өдөрт цент ч авна шүү Оёдолчиноос бусад нь өдөрт нэг цент авах гээд л байдаг юм даа Цаг нь таарсан үед өдөрт тэрнээс ч илүү, зуун арав, тэр ч бүү хэл зуун арван таван мильрейс авах өдөр ч байдаг би саяын өнгөрдөг долоо хоногт өдөр болгон зуун арван таван мильрейс өгч байлаа л Протекционизм мандаж, чөлөөт худалдаа хөгжих болтугай Царай нь үдийн цэлмэг тэнгэр шиг гялалзана гэсэн ч би мөчөөгөө өгсөнгүй би мундаг шонгуудаа лавхан шаах гэж алхаа авч арван таван минутын турш төмөрчнөө газарлуу лантуутсаар зулайгий нь ч цухуйхааргүй болтол шаачихлаа Яаж эхэлсэн гээч

- Танайд фунт давс ямар үнэтэй байх вэ? гэж би асуулаа

- Зуун мильрейс

- Манай тэнд дөч Мах иддэг өдөртөө хонь , үхрийн маханд хичнээнийг төлдөг вэ? Асуулт маань тун эмзэг газраар нь туссан учир төм ө рчний царай улайлаа

- Үнэ хэлбэлздэг Гэхдээ нэг их бишээ Дунджаар нэг фунт нь далан таван мильрейс байх жишэ энтэй

- Манайд гучин гурав байдаг Танай энд өндөг ямар үнэтэй байх вэ?

- Арван хоёр нь тавин мильрейс

- Манайд хорь, танайд шар айраг ямар үнэтэй вэ?

- Нэг пинт нь найм хагас мильрейс,

- Манай тэнд дөрөв, хорин таван шил нь нэг цент Улаан буудай ямар үнэтэй вэ?

- Бушель нь есөн зуун мильрейс

- Манайд дөрвөн зуу Сермяг дээл, эр хүний, дээл ямар үнэ хүрэх вэ?

- Арван гурван цент

- Манайд зургаан цент байдаг Ажилчны буюу гарын уран дархны авгайн бошинз?

- Найман цент дөрвөн милль

- Ялгаагий нь хар л даа танай энд найман цент дөрвөн милль байхад манайд зөвхөн дөрвөн цент байдаг юм. Одоо цохилт өгөх цаг боллоо гэж бодоод би ингэж хэлэв

- за эрхэм минь сонсож бай, саяхан чиний сайрхан ярьдаг тэр цалин хөлс чинь юу болохыг би одоо харуулаад өгье гээд мань эрийг мэдээ ч үгүй байхад нь тэр хөлий нь хүлэх мэт болгосноо мэдэж бусад хүмүүс юу гэж бодож буйг нь ажиглах гэж нүднийхээ булан гаар харж алдаршуулан магтсан цалин хөлсөө юу болохыг одоо үз, дэндүү дөвийлгөсөн байдаг шүү Ингэж хэлэхэд гайхаж байснаас биш өөр юу ч хэлээгүй гэхэд надад та нар итгэнэ үү, байна. уу тэгсэн л юм. Өөрт нь урхи тавиад хаашаа ч хөдөлгөхгүй хавхалсан мэт болгосон байхад тийм байдлаа ойлгохгүй, ан хаарах ч үгүй байлаа. миний уур хүрч алчихмаар санагдаж билээ. Тэгсэн чинь өөдөөс тэнэгээр харж ха ши н тархиа ажиллуулж ядан

- Надад мэдэгдэх юм. алга Манай эндхийн цалин хөлс танайхныхаас хоёр дахин их гэж л баталсан шүү дээ гэтэл тэр хачин үгий чинь би зөв хэлсэн бол дэндүү д ө вийлгөсөн байна. гэж хэлэх хэрэг юу байна. Үнэнийг хэлэхэд би их гайхсан яагаад гэвэл зарим талаар түүнийг тийм хачин тэнэг гэдгий нь мэдлээ, нөгөө талаартэрний зарим үзэл бодлыг үзэл бодол гэж үзэж болох аваас зөвшөөрч байсан юм. миний үзэл бол туйлын тодорхой, туйлын эгэл байсан боловч тэрнээс илүү амархан болгох арга юу байна. Хялбарчлах арга сүвэгчлэх л хэрэгтэй байлаа.

- Даули, чи үнэхээр мэдэхгүй, ойлгохгүй байна. гэж үү? Танай энд цалин хөлс манай тэндхээс илүү гэж нэрийн төдий юм байна., үнэн хэрэг дээрээ тийм биш байна.

- Үгүй, энэ чинь юу ярина вэ? Манайд цалин хөлс танайхаас хоёр дахин их гэж өөрөө хүлээсэн биш билүү?

- тийм ээ, тийм би үгүй гэж хэлэхгүй гэвч энэ бол юу ч биш Зоосны тоо гэдэг бол юу ч биш Хөлсөнд авсан мөнгөөрөө юу юу худалдаж авч чадах вэ гэдэг л хамгийн чухал нь Танайд сайн ажилладаг дархан хүн жилд гурван доллар хагасын хөлс авдаг, гэтэл манай тэнд нэг доллар далан та ван ,

- аан г Дахиад л үнэнээ хэллээ Дахиад үнэнээ хэллээ за тийм байг, тийм биш гэж хэлээгүй байна. Би өөр юм. ярьж байна. Манайд хагас доллараартанайд бүтэн доллараар авах

юмыг авч байна., тэгэхлээр эрүүл саруул ухаантай хүн бол манайд цалин хөлс танай эндхээс илүү юм байна. гэж ойлгох ёстой бүр мэл гайхаж цөхөрсөн янзтайгаар

- Үнэнээ хэлэхэд би ойлгохгүй байна. чи дөнгөж сая манайд цалин хөлс илүү байна. гэсэн амаа хааж дуусаагүй байж амаа буцлаа шүү дээ

- чи үнэхээр иймхэн юмыг ухаарахгүй эргүүтэж байна. гэж үү? Тэгээд би чамд жишээгээр хэлж өгье, Бид эмэгтэй хүний ноосон бошинзыг дөрвөн центээр авдаг Тэгтэл танайд яг тийм бошинз найман цент дөрвөн милль үнэтэй байна., өөрөөр хэлбэл хоёр дахин илүү үнэтэй бас дөрвөн милль илүү үнэтэй байна шүү дээ Танай фермийн харц хүн ямар хөлс авах вэ?

- Өдөрт хоёр милль

- Аа тийм үү, тийм хүн манайханд хоёр дахин бага авдаг, өдөрт центийг арав хуваасны зөвхөн нэгийг авна, тэгсэн хэрнээ

- Дахиад л чи үнэнээ хэллээ ,

- за, хүлээж бай чи, одоо чи ойлгоно Өдөрт хоёр милль цалин авдаг танай эмэгтэйчүүд ноосон бошинз авахын тулд дөчин хоёр хоног ажиллах хэрэгтэй болох нь

- энэ чинь яг долоон долоо хоног гэсэн үг, гэтэл манайд бол дөчин хоног ажиллах хэрэгтэй, өөрөөр хэлбэл долоон долоо хоног гэхэд хоёр хоног дутуу байх нь шүү дээ Нэг бошинз худалдан авна гэвэл долоон долоо хоногийнхоо бүх цалинг бүгдий нь өгч таарах нь , гэтэл манайд бол тийм бошинз худалдан аваад бас хоёр хоногийн мөнгө өөрт нь үлдэх нь байна шүү дээ, түүгээр аар саар юм. авч болно., одоо ойлгож байна. уу ? гэхэд мань хүн баахан тээнэгэлээж байна., бусад нь ч бас юу билээ. гэсэн янзтай байлаа., тэгэхлээр би ухаанд нь бага зэрэг юм. ойлгуулах дөхсөн байна шүү дээ Өөрсний нь б о дог гэж бодоод би нэг хэсэг дуугүй байсан чинь Даули ярихчаа болсон нь бас л аль түрүүний өнөөх дадал болсон төөрөгдлөөсөө ангижирч чадаагүй байлаа. Тэгээд шийд муутайхан шиг ингэж хэлэв

- Ямар ч гэсэн өдөрт хоёр милль авна гэдэг чинь нэгийг авахаас илүү гэдгийг чи тийм биш гэхгүй биз дээ гэх нь тэр тэнэг малуудаа гэвч би за яршиг, больё гэж бодсонгүй, өөр нэг аргаар оролдоод үзье гэж бодсон юм.

- за ингэлээ гэж бодъё Таны нэг шавь нэг фунт даас, а рван хоёр өндөг пинт шар а йраг, нэг Бушель буудай, нэг сермяг цамц, таван фунт ү хрийн мах, таван фунт хо н ины мах худалдаж авлаа гэж бодъё Энэ бүгдийг авахад гучин хоёр цент болно. Өдий мөнгө олохын тулд гучин хоёр өдөр буюу таван долоо хоног бас хоёр өдөр ажиллах хэрэгтэй болно. Хэрэв манайд очоод энд авдгийнхаа тэн хагастай тэнцэх цалин авч гучин хоёр ө дөр ажиллаг гэж бодъё Саяын хэлдэг зүйлсийг авахад арван дөрө в хагас цент т ө лөх хэрэгтэй болно. Тэгвэл төдий мөнгө олохын тулд манайд хорин есөн өдөр л ажиллах хэрэгтэй болно., тэгэхлээр бараг долоо хоногийн цалингийн хэмнэлт өөрт нь үлдэх нь байна шүү дээ жилд хичнээн болох, нь вэ бодоод үзээч хоёр сар дутам бараг бүхэл долоо хоногийн цалин хэмнэж чадна, гэтэл танай энд тэгж хэмнэх бололцоо алга байна шүү дээ Манайд жилд тавзургаан долоо хоногийн цалин хэмнэн өөртөө үлдээж чадах байхад танай энд юу ч үлдээж чадахгүй болох нь Одоо чи өндөр цалин, бага цалингэдэг бол хичнээн юу худалдан авч чадахы нь мэдэхгүйгээр ярих юм. бол ямар ч утга учиргүй зүйл гэдгийг ойлгосон байх гэж би итгэж

байна. Энэ бол хиар цохилт байсан юм. гэтэл юун хиар цохилт мохилт болохтой мантай би тэгээд л орхихоос өөр замгүй болсон юм. Тэд өндөр цалин гэдгийг л илүү үнэлж үзэхээс биш чухам хэдий мөнгөөр хэдий чи нээ юм. худалдан авч чадах вэ гэдгийг боддогүй юм. Тэднүүс протекционизмыг баримталж түүнд биширч байв. Яагаад гэвэл түүнд сонирхолтой этгээдүүд нь протекционизм бол өндөр цалин бий болгодог хэмээн маллан мэхэлдэг байна л даа хорин таван жилийн дотор юмны үнэ зуун хувиар нэмэгдсэн байхад та нарын цалин хөлс зөвхөн гучин хувиар нэмэгджээ гэж би тэднүүст батласнаас гадна манай тэнд тэрнээс богино хугацааны дотор цалин хөлсний хэмжээ дөч гаруй хувиар нэмэгдсэн хэрнээ юмны үнэ нэлээд буурсныг хэлсэн юм. Гэв тэднүүс төдий л үнэмшихгүй байв. Тэдний гайхан г ө лрөх харц огт өөрчлөгдсөнгүй билээ. Тийнхүү миний бие ял аг дсан билээ. дэмий үндэсгүй ялагд ал боловч ялагдал л байсан юм. даа, Ямаршуу н ө хцөл байдалд тэгж ялагдсаныг минь бодоод үз л дээ Цаг үеэ э зэлсэн хамгийн том төрийн зүтгэлтэн, даян дэлхийд хамгийн их эрдэм боловсролтой, олон зуун жилийн туршид үзэгдээгүй хамгийн ухаантай, титэм өмсөөгүй ухаантай толгой байж хөдөөний балар харанхуй нэг төмөрчинд тийнхүү бут цохиулдаг байна шүү дээ хүн бүхний нүдний өмнө миний бие хөөрхий санагдаж би ч шатах шиг болж сахлаас минь хярвас ханхийж байлаа. миний оронд өөрснийгөө гэж бодоход ичиж зовоод нүүр хийх газар олдохгүй мөн ч хэцүүдэх болоход эсрэг этгээдийнхээ бүснээс доогуур хориотой цохилт хийхгүй өнгөрч чадах уу даа? хэлээтэх л дээ Дэлсээд авч таарна шүү дээ хүний мөн чанар гэгч тийм хойно яах ч аргагүй шүү дээ би ч дэлсээд авсан л даа би өөрийгөө цагаатгах гэж оролдож байгаа юм. биш, би галзуурахад ганц хуруу дутсан болохоор миний оронд байсан хэн ч гэсэн аргагүй л тэгнэ шүү дээ гэж хэлж байгаа юмаа би нэгэнт л дэлсээ гэж бодсон бол илж байгаа юм. шиг няслаад өнгөрөх хүн биш, нэгэнт дэлсээ гэж бодсон бол дэлсэх шиг дэлсдэг хүн байгаа юм. би бол хий цохиод замынхаа хагаст шургачин унахаар алсаас уулгалдаг хүн биш харин хажуу т ийш хэн зайлж байгаад гайгүй сайн бэлдээд дайсан этгээдээ цохих гэсэн өчүүхэн ч сэжиг өгөлгүй байж байгаад гэнэт нүд ирмэхийн ч зуургүй довлон хэзээний тарайлгачихад ө рсөлдөгч маань яаж унаснаа өөрөө ч мэддэгүй юм. Даули ахыгаа ч гэсэн мөн тийм болгосон л доо би зүгээр л цаг нөгцөөх гэсэн юм. шиг яарамгүй жишимгүй байдлаар ярин эхэлсэн бөгөөд яах гэж тэгж буйг минь энэ хорвоогийн хамгийн мэргэн ухаантан ч болтугай таа ва рлах ян з гүйгээр

- за нөхөд минь , хууль зүй, хэв заншилд сонин хачин юм. мөн чих байдаг юм шүү хүний бодол санааны талд ч гэсэн зугаатай сонин хачин юм. мөн ч чамламгүй их байдаг юм. Бичиж зохи ос он хуулиуд байдаг, яваандаа тиймий нь хүчингүй болгочих явдал байх Харин бичиж зохиогоогүй хуулиуд байдаг тийм нь бол мөнхийн чанартай, хэзээ ч өөрчлөгдөхгүй Жишээ нь цалин хөлсний талаарх бичиж зохиогоогүй хууль байдаг Тэр хуулинд өгүүлэхдээ цалин хөлс зуун жилд тутам аажмаар боловч байнга ө сөх учиртай нээрэн ч энэ хууль ямар их з ө в байдгийг харахгүй юу Янз бүрийн газар я нз бүрийн цалин хөлс өг дгийг бид мэдэж буй болохоор энэ жилийн цалингийн дунджийг гаргаж болно. Зуун жилийн өмнө, хоёр зуун жилийн өмнө хичнээн байсныг бид бас мэдэж байна. Цааш нь мэдэх гээд яах вэ, мэдэж байгаа маань цалин хөлс бол байнга үргэлж байдаг гэдгийг тогтооход хангалттай байна. тийм хуулийг нэгэнт мэдэж байгаа учраас гартаа ямар ч баримт байхгүй хэрнээ гурав, дорөв, таван зуун жилийн өмнө хичнээн байсныг ч мэдэж чадах байна. за, ингээд болох нь тэр үү? гэвэл тийм бишээ Бид өнгөрснийг харах гээд яах вэ, нэгэнт тийм хуулиар зэвсэглэсэн болохоор ирээдүйг ямар болохы нь мэдэхийг оролдьё за нөхөд минь , ирээдүйд, олон зуун жилийн дараа цалин ямар байх вэ гэдгийг би одоо та нарт хэлж өгч чадах байна.

- Яана гэнээ, сайн санаат хүн минь ? Ойрын долоон зуун жилийн дотор цалингийн хэмжээ зургаа дахин нэмэгдэнэ Фермийн зарц хүн өдөрт гурван цент, гарын уртай хүн зургаан цент авдаг болно.

- Одоо үхээд тэр үед амьд байж болдог ч болоосой гэж дугуйч Смуг нүд гялалзуулан шүлс гоожуулах шахам байж хэлэв

- Тэгэхдээ өөрийнхөө хоолыг биш эзнийхээ хоолыг иднэ, эзний хоол идээд шингэдэггүй гэдэг үг бий нь бий л дээ Харин хоёр зуун тавин жил болсны дараа юу болно. гээч анхаараарай, би санаанаасаа зохиогоогүй, энэ бол жинхэнэ хууль, тэр үед гарын дүйт хүн өдөрт хорин цент авах юм шүү гэхэд бүгд гайхалдан сүүрс алдаж чулуучин Диккон тэнгэр лүү нүд ширтэн гар сарвайн амандаа нэг юм. бувтнаж байлаа.

- гэвч өдөр ажиллаад гурван долоо хоногийн цалин авах нь ээ

- Баячуул болох нь , баячуул болох нь гэж Маркогийн амьсгаа нь бүр давхцаж орхисон байн байн хэлж байна.

- Цалин цагаа мод ургах мэтээр бага багаар нэмэгдээд л байх учраас дахи ад гурван зуун д ө чин жил болоход энэ хорвоо дээр уран хүн өдөрт хоёр зуун цент авдаг нэг улс лав бий болно. гэхэд тэд үг ч хэлж чадахгүй хэл нь татчих шиг болж билээ. Тэд яаз л хоёр минутийн турш амьсгаа ч аваагүй юмдаг Тэгж тэгж байснаа нүүрсчин

- Тэр цаг хүртэл амьд явахсан гэлээ.

- Гүнгийн олдог орлоготой адил байх нь ээ гэж Смуг хэлэв Гүнгийн гэнэ үү? Гөрцогийн гэсэн ч болохоор байна шүү дээ тийм орлоготой ганц ч гүн бүх Багд е мсгус даяар эрэвч олдохгүй Гүнгийн орлого Бишээ, дагинын орлого гэсэн үг гэж Даули хэлэв

- Цалин ингэж нэмэгдэх юм шүү дээ Тэр үеийн хүн ганц долоо хоногийнхоо цалингаараа тануусын тавин долоо хоногийнхоо цалингаар авч чадахгүй юмыг худалдан авч чадах юм шүү Тэрнээс өөр ч гайха ад барамгүй юм. их бий болно. Даули, дүү минь , танайд уран хүн зарц буюу барлаг хүн тэр жилдээ хичнээн хөлс авахыг хавар нь ямар хүн тогтоодог юм. б э?

- заримдаа шүүхээс, заримдаа хотын зөвлөлөөс , голцуул магистратаас тогтоодог юм даа

- Тэр хэмжээг тогтоохдоо ажилчин ядуу а рда ас оролцуулж хэлэлцэнэ гэж е р байхгүй юу ?

- юун дэмий юм. бодно вэ? Г ан цхан л э зэн ц ал ин хөлс өгдөг хүн л хэдий байхыг нь мэдэх сонирхо х , учир тайг чи мэдэхгүй байна. гэж үү Я ал аа гэж

- миний бодоход цалин хөлс авч б а йг аа хүн тэр ний эхнэр, хөөрхий үр хүүхэд нь ч бага зэрэг сонирхох ёстой биз дээ эзэд гэдэг чинь язгууртан, чи нээ жиж явав хүмүүс Цөөнх нь ажиллахгүй байж бүгд ий н төлөө ажилл адаг олонхийн цалин хөлсийг тогтоож байна. Яагаад гэвэл б а ячуул ядуу до рдост хичнээни йг өг вөл болох вэ гэж өөрснийхөө бодсоноор тогтоохын тулд өвөр хоорондоо мэргэжлийн гэж хэлж болох тийм холбоо б а йгуулсан байна шүү дээ Бичиг дээгүй хуулийн ёсоор бол а рван гур ван зуун ө н гөрсний д а раа хөдөлмөрчид өөрснөө нэгдээд баячуул нь үйлд э р чн ий эвлэлүүдийн дархан эрхэнд шүд зуун з эбүүцэн бай х болно. гэсэн буй Арван есдүгээр зууныг хүртэл м аг исрат үнэхээр хөдөлмөрийн хөлсийг дуртайгаараа тод ор хойлж байх болно. Дараа нь хөдөлмөрчин хүн за одоо болоо, хоёр мян г ан жилийн турш та нар мэдэм Сайлав, энэ хооронд тануус ганц тал баримталж б айсан гэж дургүйцээд өөрснөө өөрснийхөө цалингийн хэмж ээг тогтоох болно. Тэгж их дарлуулж доромжлуул ж байсныхаа хариуд тэгж тэвчиж үй л ээ баран зовж байсныхаа хариуд ихээхэн тооцоо гаргах болно. доо

- чиний бодлоор

- Өөрийнхөө цалинг хэд байхыг шийдэхэд өө рөө мэдэлцэх гэж үү? Тэгэлгүй яах вэ Тэр цагт хөдөлмөрчин хүн гэдэг чинь чадалтай ч, ухаантай ч болсон байх л даа

- Жигтэйхэн сайхан цаг байх нь гэж баян төмөрч тургив

- Бас нэг нарийн зүйлийг хэлье Тэр цагт эзэн хүн өөрийнхөө эв боломжоор ажилчин хүнийг долоо хоногоор, сараар, тэр ч байтугай ганц өдрөөр ч хөлсөлж болно.

- юу гэнэ ээ?

- Үнэн шүү Энэ ч бага хэрэг тэр үед магистрат одоогийнх шигээ хүн дуртай байсан ч үгүй ч хүнийг нэг хүнд бүхэл жилжин ажиллуулдаг бол тэр үед тийм эрхгүй болох болно.

- Тэр үед хууль д ү рэм ч үгүй, эрүүл саруул бодол ч гэж болох юм. гэж үү?

- Аль аль нь байлгүй яах вэ, Даули Тэр үед хүн өөрөө өөрийгөө мэддэг болохоос биш одоо шиг Эзэн буюу магистратын мэдэлд байхаа болино Цалингаа бага байна. гэж бодвол тэр хотоо орхиод өөр т ийш явсан ч дурны хэрэг, тэглээ гэж хэн ч хүний мууг үээж чадахгүй болно.

- тийм балай цаг бүү ирээсэй гэж Даули жигтэй хэн зэвүүцэж хашгираад

- Нохойн цаг байх нь Ах за хаа ч мэдэхгүй, эасаг төрөөч хүндлэхгүй болох нь ээ Шившигтэй гэв

- Байз, нөхөр минь , чи шившигийн баганыг бүү хамгаал тийм юмыг устгах ёстой гэж би үздэг

- Хачин юм. боддог хүн юм. Яагаад?

- Я агаад гэдги й н учрыг чамд хэлж өгье их том гэмт хэрэг хийсэн хүнийг шившгийн багананд хүлж болох уу ?

- Үгүй ээ,

- Тэгвэл ялимгүй юм. хийсэн хүнийг ялимгүй ший т гээд дараа нь алах шударга хэрэг үү? Хэн ч хариу дуугарсангүй Энэ бол миний анхны ялалт байлаа. Төмрийн дархан анх удаа мухардаж миний үгэнд хариу өгч чадахгүй болов. Бүгд үүнийг ажигл а в, Сайн сэтгэгдэл төрүүлэв

- чи яагаад дуугарахгүй байна. чи д өнгөж саяхан шившгийн баганыг алдаршуулж ирээдүй зуунуудыг зүхэж байгаагүйсэн бил үү Шившгийн баганыг устгах нь зүйтэй гэж би үздэг Ямар нэг ялихгүй зүйлээс болж ядуу хүнийг шившгийн багананд хүлэхэд юу болдог билээ.? Цугласан олон хүн түүнийг доромжлон бахладаг биз дээ?

- тийм ээ

- хүмүүс бөөн шороогоор шидэж эхлэхэд тэр хүн нэгнээс нь бултаж ядахад нөгөө талаар нь шидэхэд цохиулан сандрахад инээдээ баран хөхр ө лааөг биз дээ

- тийм ээ

- Бас үхсэн муураар хүртэл шиддэггүй гэж үү?

- Шиддэг ээ

- Тэр олон хүний дотор урьд нь Ямар нэг юм.ан дээрээс болж гомдсон, тэгээд хонзон санасан жишээ нь зангаасаа болоод ч юм. уу эд хөрөнгөнөөс болоод ч юм. уу өөр бусад юу хнаас ч юм. болоод өс санах болсон хүн байхыг хэн байг гэх билээ. тийм улс чинь үхсэн муур, бөөн шорооны оронд чулуу тоосгоор гэнэт шидвэл яах вэ?

- Гарцаагүй тэгнэ

- тийм хүнийг бүх насаар нь эрэмдэг зэрэмдэг амьтан болгоод хаячихдаг биз дээ? Эрүүгий нь хуга цохих, шүдий нь булга цохих, хөлий нь хугалаад тэр нь яр шарх болж сүүлдээ огтлуулдаг, эсхүл өрөөс ө н нүдий нь заримдаа хоёр нүдий нь бүлтлээд таг сохор болгочдог шүү дээ

- Үнэн, бурхан мэлмийгээрээ хардаг

- Тэр хүнд бүр дургүй байсан бол тэр чигээр нь алчихдаг явдал ч байсан шүү дээ

- тийм юм. гарч мэднэ Үгүй гэхийн газаргүй л дээ

- Та нарын хэн нь ч давилуун ихэмсэг зан, дээрэл хүү ааш, эд хөрөнгө юм. уу , юугаар ч гэсэн өөрийн тосгоны хог новшнуудын атаа жөтөөтөрүүлж дургүй хүргэж өөрсөндөө муу хүн бий болгоогүй байх, та нарт хүмүүс бүгд сайн байх гэж би итгэж байна. Хэрэв та нарыг шившгийн багананд хүлж гэмээнэ та нар дажгүй зүгээр өнгөрнө гэж боддог юм. шив дээ? Даулийн нүд онивол зож байв. мань хүн япагдсан нь ил байлаа. гэвч үгэн дээрээ бас ялагдсанаа хүлээхгүй байсан Харин бусад нь шившгийн багана гэдгий чинь нажид болтлоо

үзсэн, тийм аймшигтай юманд орсноос шүүд дүүжлүүлж үхсэн маань дээр гэж илэн д ал ангуй үнэн голоо с оо хэлэв

- Шившгийн баганыг халж устгах нь зүйтэй гэдгийг би тодорхой н отолсон учраас одоо ярианыхаа сэдвийг өөрчлөө Манайд шударга биш хууль олон байдаг Жишээ нь , би шившгийн багананд хүлэгдэх Ямар нэг гэм хийг, тэгтэл чамайг нуугаад өнгөрөг, гэтэл тэр нуусан хүнийг өөр нэг хүн матаж орхивол чи хүн нуусан гээд шившгийн багананд хүлж байна.

- Тэр зүйтэй Өөрөө матах ёстой байсан шүү дээ Хуулинд тэгж заасан байгаа гэж Даули хэлэв Бусад нь түүний хэлсэн үгийг дэмжив

- Тануус бүгдээрээ тэгж бодож байгаа бол тийм болог л доо гэвч бага сага шударга биш юм байна. Гарын уртай хүний өдрийн цалинг магистраас нэг ц е нтээр тогтоосон байг . Хуулинд эзэн хүн ганц өдөр ч гэсэн, ажлын чухал шаардлагаас болоод ч гэсэн ажилчныхаа цалинг нэмсэн байвал тийм эзнийг шившгийн багананд хүлбэл зохино Харин үүнийг мэдсээр байгаад хэлэлгүй дарсан хүнийг мөн торгож шившгийн багананд хүлэх ёстой гэсэн байдаг Энэ л надад шударга биш юм. шиг санагдаж байна., Даули, бас ч маш аюултай мэт, яагаад гэвэл чи өөрөө дөнгөж түрүүхэн бүхэл долоо хоногийн турш нэг цент арван таван миллиэр төлж байсан гэж өөрөө ярих чинь билээ. Энэ ёстой мундаг цохилт болсон шүү Бүгдийг бут ниргэх нь тэр миний хиартал дэлсэх цохилт бууж тэнцвэр алдуулах хүртлээ миний бие тэр биеэ тоон инээмсэглэн малилзаж байсан Даулийн дэргэд огт мэдэгдэлгүй, чимээ анир гаргалгүй, ямар ч сэжиг авуулалгүй мяра ан очоод аваад хаячих шиг юм. болгосо н доо мөн ч мундаг нөлөөтэй юм. болсон доо тийм ахар хугацаанд тийм их амжилт олж байснаа би огт санахгүй байна. Харин хормын төдий өнгөрсөн хойно харж байвал би давсы нь ялимгүй хэтрүүлчихсэн байлаа.в шүү Тэдэнд цохилт өгөх гэсэн болохоос биш няхчихая ч гэж санаагүй юм. л даа гэтэл тэд үхэлд тун дөхөж очсон байв. Тэд шившгийн багана гэгч юу болохыг мэдээд одоо тэр зүйл нүдэнд нь ив илхэн харагдаж зүс мэдэхийн төдий хүн алтан хошуу хүргэхэд өөрснөө тэр цээрлэлийг биеэрээ амсах нь гэж бодохоос сүнс нь зайлж байх шиг байна. Нүүр царай нь цайн, хамаг бие нь дагжин, хэл нь орооцолдон, арчаагаа алдсан хараг дана Айсандаа үхсэн амьдын хооронд үлгэн салган болсон арчаагүй амьтад болов. Тун аягүй юм. болж би лээ Тэд намайг амаа мэдэж яваарай гэж гуйгаад гар хөлөө барилцан зүгээр болж идэх уухдаа инээж ханиан орно биз гэж би бодож байсан юм. Тэгсэн чинь Тэгдэгүй би бол харь газрын хүн байсан, тэд бүх насаараа хатуу дарлалд нэрвэгдэн хэнд ч итгэхгүй болж, хүн арчаагүй байдалд орсон үед зүгээр орхихгүй харин ч хазайсан дээр нь түлхэнэ гэдэг ёсонд байж сурчихаад өөрийн төрсөн ах дүү садангаас бус ямар ч хүний зүгээс шударга буюу сайн санааны юм. гарч ирнэ гэж огт боддогүй ажээ. Намайг сайн сэтгэл гаргаж шударга ёсыг баримтлана уу гэж гуйх хүслэн байвч тэгж гуйх зүрх зориг нь хүрэхгүй байжээ.

Гу чи н дөрөвдүгээр бүлэг

ЯНКИ, ВАН ХОЁР БООЛ БОЛОН ХУДАЛДАГДАВ

Одоо яах билээ.? Яарах л хэрэггүй өөрөө нэг тойруу дасгуулах арга бодох цаг зав олох, тэднүүсийг жаал сэхээж ухаан оруулах хэрэгтэй байлаа. Түрийвч гар буугаа ажиллуулах гэж оролдоод чулуу шиг хөшиж тэр тоглоомоо гартаа атгасаар буй Марко миний өөдөөс харж сууж байлаа. Тэр буугий нь гараас нь авч нууцы нь таниулж өгье гэлээ. Нууц гэнэ ийм жаахан юманд ямар нууц байдаг юм. гэвч тэр цагт тийм оронд энэ мэтийн зүйл ч нууц юм. байсан

юм. Онсон ажиллагаатай юм. эдэлж огт мэдэхгүй гайхмаар улс байсандаа Өөрсөнд нь ямар ч онсон механизм байгаагүй юм. чинь яаж ч тийм юм. мэдэх билээ. Түрийвч гар буу гэдэг маань зузаан шилээр хийсэн давхар хоолой байсан юм. дотроо пүрштэй, тэрний нь дарахлаар пан хийн буудна Тэгж буудахад ямар ч хор хүргэхгүй, үрлэн сум нь гарын алганд л үлдэнэ Үрлэн сум нь янз бүрийн хэмжээтэй, зарим нь го ю уны үр шиг, зарим нь арай том, түүгээр зоос орлуулна Го ю уны үрний дайтайг нь мильрейсээр, арай томхны нь миллиэр сольдог байсан Тэр гар бууг түрийвч болгон хэрэглэдэг байсан, тэгэхэд тун эвтэйхэн түрийвч болно. Харанхуй байхад ч гэсэн тооцоо алдахгүйгээр ер төлбөр өгч болно. Хантааз чинь халаастай бол хантаазныхаа халаасанд буюу хажуу хацарт нь авч явж болно. би олон янзаар хийсэн болохоор хамгийн том нь нэг доллар хүрэх олон үрлэн сум багтана Зоосны үрлээр солих нь засгийн газарт тун их ашигтай байсан юм. яагаад гэвэл төмөр бол үнэ цэнэ гэх юм.гүй, хуурамч зоос гарах бол уу гэж айх явдалгүй байсан, яагаад гэвэл тэр вант улсынхаа дотор надаас өөр үрлэн сум хийж чадах хүн байгаагүй юм. мөнгө буудах гэдэг үг нийтэд дэлгэрч мартагдалгүй явсаар одоо хаанаас гарсны нь хэн ч эргэлзэхгүй байгаа хэр нь арван есдүгээр зууныг хүрч ирсэн юм. Яг тэр үеэр бидэнтэй ван хамтарлаа нойроо авч нэлээд сэргэсэн байв. Одоо бидний амьдрал алхам бүр аюулд учрах осолтой болсон учир миний сэтгэл амархан хөдөлж уцаардуу байлаа. Вангийн нүдийг сэжигтэйгээр харахад мань хүн нэг болохгүй юм. хэлэх хийх нь илт байв. Золиг чинь , цагаа олж чаддагүй байх гэж үү дээ би эндүүрсэнгүй Ван юу юу үй хөдөө аж ахуйн талаар ямар ч аа маагүй юм. ярьж эхлэв миний хамаг биений хөлс цувлаа чихэнд нь Та бид хоёр тун аюул осолтой юманд орох нь байна шүү Энэ хүмүүсийн итгэлийг эргүүлэн авахаас нааш минут бүр осол аюулаар дүүрэн байна. Үнэт цаг алдаж болохгүй гэж шивнэмээр л байлаа. Шивнэвэл бид хоёрыг хуйвалдаан зохиож байна. гэж бодох байсан болохоор болохгүй байсан юм. Ванг тэсрэх бөмбөгөн дээр суучаад золигийн сонгины тухай бодлогошрон ярихы нь чагнан молилзан инээж суухаас өөр домгүй болов. Анх нь аюул нөмөрсөн байдалд баахан барьц алдаж байсан болохоор би вангийн ярьж буй үгний учир утгыг нарийн бодож чадаагүй боловч дайны ажиллгааг хэрхэн явуулах төлөвлөгөө боловсруулсан хойно вангийн их бууны хорооны зэрэг зэрэг гайлах чимээ чихэнд дэлдэж гарлаа

- миний бодоход энэ бол хамгийн шилдэг арга биш, мэддэг хүмүүсийн санал зөрдөг боловч зарим нь хэлэхдээ сонгиныг хүний биеийн эрүүл мэндэд хортой гэх, ялангуяа түүнийг болохоос нь өмнө зулгаавал тийм гэдэг ... Сонсогчид амьд байгаагийн шинж тэмдгийг илтгэн бие бие рүүгээ гайхан харж нүдэнд нь түгшүүрийн оч гялалзах болов.

- зарим нь нэлээд үндэстэйгээр нотлох боловч энэ бал төдий л онц зүйл биш, яагаад гэвэл лэгсваа болон бусад тариан зүйлийг болоогүй байхад нь газраас ухаж авдаг Сонсогчид тун их балмагдан айж цочсон байдалтай болов.

- гэлээ. ч гэсэн идэхэд нэлээд боломжтой байдаг, ялангуяа байцааны сэтгэл тайвшруулах шүү си йг хол ёж төрөлхийнх нь яхир чанарыг зөөллөөд өгөх юм. бол Гийчдийн нүдэнд зэрлэг адгуусны айж үргэсэн шинж илэрч амандаа

- Энэ хүн юу ярина вэ? Бурхан энэ тариачны ухаан санааг балартуулсан байна шүү дээ гэв би муу юм. болохыг урьдаас мэдсэн болохоор дороос өргөсөнд хатгуулсан юм. шиг ондогонуу сууж байлаа.

- цааш нь , хэрэв, хэрэв бүхний мэдэх нэгэн зүйлийг анхааран үэвэл, залуу амьтан буюу

өөрөөр хэлбэл амьтны ертөнцийн шинэхэн нахиа нь бүхнээс илүү амттай бөгөөд сэрэх боловсроход үс нь дэндүү халуун болж махныхаа амтыг муутгадаг ийм нэг муу талтай, нэмэрт нь тэр амьтны ой гутам зан авир, буруу номыч байдал Бүгд нэгэн зэрэг суудлаасаа оглохарайн босож муухай чанга дуугаарнэг нь урвагч, нэг нь солиотой юм байна. Алья Алчихья хэмээлдэн бид хоёр луу дайрах нь тэр . Вангийн нүдэнд ямар шүү их цог золбоо гялалзсан гэж бодно Хөдөө аж ахуйн талаар юу ч мэдэхгүй атлаа зодолдохдоо ч ид шидтэй юм. шиг байлаа. Удаан хугацаанд мацаг барьсан амьтан чинь одоо байлдах тулалдахын мөн болсон байжээ. Төмрийн дархны эрүүрүү дэлсэн ар голоор нь унагаж байна. Ариу н Г ео ргий минь ,Британидаа тусла гээд дугуйчныг тэрий хадууллаа Чулуучин ланжгар эр байсан боловч би төдий ядалгүй онхолдууллаа Нөгөө гурав босож ирээд дахин дайрлаа Дахин гурвууланг унагаалаа, дахин босож ирлээ Тэднүүс британы шаргуу эрэлхэг Чанараар унан босон байсаар сүүл сүүлдээ хэрчсэн махархуу юм. болсон дог Ядарсандаа гуйварч, уурандаа ухлан нь манарч дайсан, нөхөр хоёроо ялгахыг болиод бие биенээ гөвшиж гарах нь тэр Тийнхүү бие биесээ гүвдэж эхлэхэд нь бид хоёр хажуу тийш болж тэднүүсийн бух нохой мэтээр ноцолдон дээр дороо орон үс гэгзгээ уралцан бие биенээ хэмлэхий нь ажиж байлаа. Т э д туслах хүч эрье газар нь хол болохоор явуулын хүмүүс тэднийг олж харахгүй байсны дээр өөрсөө ядарчихаад явах сөгөөгүй байв. Тэднийг тийнхүү харж байсан чинь тэдний дунд Марко байхгүй байгааг би санаандгүй мэдлээ ийш тийш харсан чинь байх газар алга Энэ лав базаахгүй хэрэг би В ангийн ханцуйнаас угзарч сэмхэн зайлаад овоохойн дотор гүйлдэн оров Тэнд хүн алга, Марко ч алга, Фил лис ч алга Тэр хоёр лав тусламж олохоор зам уруугүйгээ биз Та бид хоёр одоо оргон зайлах хэрэгтэй байна., учры нь сүүлд тайлбарлаж өгье гэж ванд хэлэв Бид хоёр цагаан талаар гүйсээр арайхийн ойн гүнд ороод эргэж харвал Марко, Филлис хоёр тэргүүлсэн уур хилэн нь бадарсан олон хүн бид хоёрын хойноос н эхэж байв. Тэд дотор зарсхиймээр муухай хашгиралдах боловч бид хоёр айсангүй Ой нь өтгөн шугуй байсан болохоор эвгэйхэн шиг орж очоод модон дээр гарчихлаа, тэд одоо биднийг яаж л олдогсон олог л доо гэтэл өө р дуу чимээ гарсан нь нохойн хуцах дуу байв. Энэ бол огт ондоон хэрэг шүү Бидний зорилт нарийн төвөгтэй болов., урсгал ус олох хэрэгтэй болов. Бид хоёр хөл мэдэн зугатахад хөөгчдийн дуу хо лдон холдсоор сүүлдээ хүнгэнэсэн юм. болон хувирч байв. Нэг горхинд хүрч очоод ус уруу нь үсрэн орлоо Усаар нь уруудан урссаар гуч орчим ярд газар явлаа Мундаг салаа мөчир нь яг усан дээр өнгийх том дүнээн мод тээглэхэд нь бид хоёр мөчрөөр нь дамжин гол уруу нь м ө лхлөө . Мөшгөн хөөгчдийн дуу чимээ улам ойртож улам чангарч байхыг нь бодоход тэд бидний мөрийг олсон байх нь ээ Нэг хэсэг тэр дуу чимээ тун хурдан ойртож байснаа чингэхээ болив Ноход бидний усанд орсон м ө рийг мэдээд бидний мөрийг олох гэж тэндээ баарч эргээр нь давхилдаж байгаа нь эргэлзээгүй Нөгөө модон дээрээ буйртайхан сууж аваад навчаар нь гайгүй сайн халхалсан хойно вангийн дотор онгойж амрах шиг болов. Харин би чингэсэнгүй Нэг мөчрөөр нь д а мжаад өөр нэг модон дээр очих нь зүйтэй санагдаад туршихаар шийдсэн юм. Бид хоёул туршсан маань амжилттай болсон бөгөөд ван л нэг удаа халтирч арай л ус уруу уначихаагүй билээ. Тэндээ тун аятайхан тухлаж навч мөчрөөр нь далдалж аваад нэхэн хөөгчдийн дуу чимээг л чагнаж суух ажил үлдсэн юм. Гэнэт мөшгөн хөөгчдийн дуу чимээ ойртож бүр ч хурдан түргэн ойртоод голын хоёр захаар ангаалах маягтай сонсоглоо Улам улам чанга сонсдож, архирах, чарлах, хуцах улих, хөлийн чимээ гарах зэргээр хажуугаар сүртэй юм. болж салхи шуурганы аюул нөмрөх шиг болов.

- Усан дээр унжих мөчрөөр тэднүүс тааварлах бол уу гэж би айж байсан боловч тэгж бодсон маань буруу байсанд их баярлаж байна. гэж би хэлээд одоо цаг алдаж болохгүй,

ээзэнтэн минь , хоёул цааш явья Та бид хоёр тэднийг төөрүүлж чадлаа Мөд харанхуй болно. Хэрэв та бид хоёр дахин голоо гатлаад Ямар нэг бэлчээр газар хүрч хоёр морь хэдэн цагаар хөлслөн авч чадах юм. бол аюулаас мултрах байна. даа Бид хоёр уруудсаар хамгийн доод талын мөчир хүрч байтал гэнэт өнөөх дуу чимээ дахин ойртох шиг сонсогдов ч агнаад хөдөлж ч чадахгүй зогслоо

- юу ч олсонгүй дээ залхаад буцаж байгаа юм байна. Нөгөө хоргоддог газраа очоод тэднийг өнгөрө хийг хүлээдэг хэрэг гэж би хэллээ Тэгээд дахиад л авирлаа Ван чагнаж байснаа

- Тэд эрсээр л байна. энд ээ байсан дээр гэв Тэрнийх зөв байсан юм. Намайг бодвол ан гөрөөний талаар илүү мэддэг байжээ. Нэхэн хөөгчдийн дуу улам улам ойртсоор байлаа. Ван хэлэхдээ

- Бид хоёрыг явган улс голоос хэдийхэн холдох вэ гэж бодоод эргэсэн байна. гэв

- тийм байж таарах нь ээ ноёнтон минь би уг нь өөрөөр бодож горьдсон юмсан дуу шуугиан бүр ойртож тэдний толгойн сэргийлэх хэсгийнхэн нь хүрч ирээд голын хоёр талаар эргэлдэж байв. Голын нөгөө эргээс нэг нь

- Тэр хоёр ухаантай улс болохоор энэ модны тэр мөчрөөр газар хүрэлгүй авирчихсан байж мэднэ, нэг нь авирвал сайн байна. гэж хашгирав

- Чөтгөр гэж, тэгье байз би өөрийнхөө хаширласанд баярлаж байлаа. хажуугийн нөгөө модонд шилжсэн маань зөв болжээ. гэвч ямар ч хашир алхам маань юунд тээглэж мөргөөд балардгийг та бүхэн андахгүй шүү дээ хүний мулгуу ухаанд тээглэж орхидог шүү дээ Дэлхийн нэгдүгээр зэргийн сэлэмч хоёрдугаар зэргийнхээсээ айхгүй,

- харин гартаа сэлэм хэзээ ч барьж үзээгүй юу ч мэдэхгүй хүнээс айна, яагаад гэвэл мулгуу гэдэг чинь хийхгүй ёстой юмыг л хийнэ, хийх ёстой юмыг хийхгүй, тэгэх лээр туршлагатай сэлэмч нь дийлдэнэ би хичнээн би лэг ухаантай байлаа. гээд тэр харалган, хазгай тэнэг салбадайг андуураад гар гэсэн модон дээр нь гаралгүй нөгөө модон дээр нь гарч орхихыг яаж би мэдэх билээ.? Тэр салбадай чухам тийм юм. хийхгүй юу Тэрний ан дуураад авирсан мод нь чухам авирвал зохих мод нь болчихгүй юу Байдал тун ч осолтой болов. Бид хоёр огт хөдлөхгүй юу болохыг хүлээн суулаа Тэр тариачин арайхийн мацсаар байлаа. Ван өндийж байгаад авирч буй хүн ойртсоор толгой нь тулаад ирэхийн алдад түгхий т эл дэлсээд орхиход дороос уурлан хашгиралдах чимээ гарч олон хүн бид хоёрын амь хоргодон буй модыг тойрон бүчиж байлаа. Бид хоёр тэдний бүслэлтэд орж ол з ных нь хүмүүс болжээ. Бас нэг хүн авирлаа Бидэнд гүүр болж байсан мөчрийг тэд мэдээд тэр мөчрөөр тэр хүн авирч эхлэв Ван намайг тэр мөчрийг Горацаг хамгаалах адилаар хамгаалж бай гэлээ. Дайснууд тал талаас дайрч гарлаа гэвч тэдний толгой дээр цохилт дараалан бууж тэд ч газар пид пидхийн унаж байв. Вангийн сэтгэл санаа сэргэж баярлан оодрох нь хязгааргүй болов. Ийнхүү модоо хамгаалсаар бүсэлсэн дайснаас модоо хам гаалж энэ шөнийг сайхан өнгөрөөнө гэж ван надад үнэмшилтэй ярьж байв. Дайран довглогчид ч өөрснөөтэр байдлыг ойлгож шууран дайрахаа больж өөр төлөвлөгөө боловсруулж байв. Тэдэнд буу зэвсэг байхгүй харин чулуу зөндөө байсан болохоор хэрэглэж мэдэх юм. Бид ч чулуугаа хэрэглэвэл ч хэрэглэг гэж бодож байлаа. Биднийг ганц нэг чулуу онож мэдэх л юм. гэхдээ энэ бол лавгай биш Бид навч мөчрөөр сайн хамгаалагдаж, дороос огт харагдахгүй байсан л даа Тэд чулуу шидэж хагас цагаа гарзадвал

бид хоёрт тус болох байсан, юу гэвэл харанхуй болох байлаа. Тэгж бодоод додигор байлаа. в шүү хо ё ул инээд хүрч хадганатал хөхөрмөөр санагдаж байлаа. гэвч бид хоёр инээгээгүй, инээгээгүй маань ч сайн болсон, яагаад гэвэл удаан инээж чадахгүй байжээ. Б ө мбөгдүүлж эхлээд хорин таван минут ч өнгөрөөгүй байтал нэг хачин үнэр ханхлаад явчдаг байна. хоёр хүчтэйхэн шиг амьсгалаад үзэхэд л утааны үнэр гэдэгт лавтай итгэж болох байлаа. Бидний тоглоомхожигдсон байлаа. хожигдоогүй гэхийн аргагүй болсон Урилга эхүүн утаатай дагалдан ирэхэд хүлээн авахаас өөр яах вэ Бүсэлсэн хүмүүс хуурай мөчир сагсайтал овоолж байгаад гал тавиад өтгөн угаа нь модны гол даган авиран дээшлэхэд тэд баярлалдан хашгиралдав би утаанд нь хахаж цацан

- Эзэнтэн минь урд ороод буугаарай, харьяат нь хэзээд хойно нь явдаг шүү дээ гэхэд ван

- чи миний хойноос дага модны голын нэг талы нь чи, нөгөө талы нь би дагаад бууя Тэгээд тулалдаж гарна шүү хоёул тус тусдаа өөр өөрийнхөө чаддаг аргаар, хүссэнээрээ үзэлцэж эргэн тойрон хүүрээр дүүргээд хаячихья гээд хараал тавин хоолой засан буухад нь би араас нь дагалаа Тэрний хөл газар хүрсэн агшны дараахан минийх ч газардлаа Бид хоёр түрүү төлөвлөсөн байраа эзэлж аваад дайралтыг няцаан цохилт өгч эхлэв Дайралт нь салхи шуурга мэт ширүүн догшин байв. Тэгтэл гэнэт хэдэн морьтой хүн тэр олон хүний дундуур давхин ороод нэг нь

- Больцгоо, аль эсхүл бүгдээрээ үхэхийг хүсэж байна. уу гэж өндөр дуугаар хашгирав Тэр хүний үг хичнээн амтлаг санагдсан гээч Тэр үг хэлсэн хүн бол тайж язгууртны бүхий л шинжийг хадгалсан эр байлаа. Үүнд үнэт эдээр хийсэн ганган хээнЦэр хувцас х у нартай, эзэрхэг дуу хо олойтой, шинж байдал нь самуун шалиг амьдралын ул мөрийг илтгэх догшин ширүүн царайтай харагдана Өнөөх олон хүн сүрэг нохой сүүл хавчин зугадах адил гөлсхийн ухарч байна. Тайж бид хоёрыг шинжсэн янзтай харснаа тариачдаас

- Та нар энэ улсыг яасан бэ? гэв

- Ариун төрөлт ноёнтон минь , энэ хоёр бол солиот о й галзуу улс Хаанаас ч юм. үл мэдэх газраас яваа үмүүс Хаанаас нь мэдэгдэхгүй гэнэ ээ? Та нар эднийг мэдэхгүй царай гаргаж байгаа юм. биш биз? Ариун төр ө лт ноёнтон мин ь бид үнэнийг хэлж байна. Эд эндхийн улс биш, таних хүн ер алга энд Урьд хожид үзэгдэж сонсдоогүй хамгийн хэрцгий, хамгийн шунахай, хүний цусанд хорхойтсон солиотой амьтад

- чимээгүй чи өөрийнхөө ярьж байгаа үгийг өөрөө ч ойлгохгүй байна. Эд галзуусолиотой улс огт биш байна. Та нар юун улс вэ? Хаанаас явна? Яриарай

- Ноёнтон минь , бид хоёр бол хүнд гэмгүй яваа эгэл номхон тэнүүлчид л байна. Өөрснийхөө хувийн хэргээр жуулчилж явна Бид алс холын орноос яваа, таних мэдэх хүн алга Бид хоёрт хийсэн муу юм. огт байхгүй Та ийнхүү эрэлхэг зоригтойгоор оролцож ивгээлээ бидэнд үзүүлээгүйсэн бол эд бид хоёрыг алах байсан байх аа Та биднийг солиотой улс биш гэж зөв хэлэв Бид ширүүн хэрцгий ч улс биш, хүний цусанд хорхойтдог улс биш гэж би хэллээ Тайж, гоцго нарынхаа зүг эргэж тайвнаар

- Энэ нохдыг нохойнх нь хороо руу хөөж явуул гэлээ. Олон хүн нүд ирмэхийн зуургүй сарнин гүйлдэж хойноос морьтой хүмүүс ташуур тачигнуулан элдэж замын хажуумод бургас уруу орох ухаангүй замаар гүйж явсан нэгий нь мориороо гишгүүлэн няц дарж байв.

Хашгиралдах гүүгэлдэх чимээ төдхөн бүдгэрч морьтонгууд буцаж ирцгээв Тэр хооронд тайж маань бид хоёроос баахан юм. асууж шалгаавч бид хоёр олигтой юм. хэлсэнгүй Бид хоёр түүний тусад талархаад бид алс газраас яваа, энд танил нөхөд огт байхгүй гэсээр байлаа. Бараа бологчдыгоо хүрэлцэн ирмэгц өнөөх ноён нэгэнд нь

- Тэрэгний морьд авчраад энэ хоёр хүнийг суулга гэлээ.

- за, ноёнтон минь Бид хоёрыг зарц нарынхаа дунд хөсөгний сүүлд авч явлаа Хурдан явсан учир харанхуй болсноос хойш даан их удалгүй замын хажуугийн нэг дэн буудалд буусан нь бидэнд тохиолдсон өнөөх аягүй явдалт газраас арав, арван хоёр бээрийн тэртээ байв. Ноён өөрийн захисан өрөө тасалгаанд оройнхоо хоол цайг зооглохоорнэн даруй одож дахин үзэгдэхээ болив Өглөө нь хоол цай идэж уугаад замдаа гарахаар зэхэв Ноёны гоцго бид хоёр дээр ирж их л э е лдгээр

- Та нарын барьж яваа чиг биднийхтэй таарч байна. гэсэн болохоор миний гүн Грип та хоёрт энэ хоёр морийг унуулж эндээс хамгийн дөт, хориод бээрийн газар орших Камбенет хот хүргэж өг, тэнд очвол аюулаас мултарна гэсэн юм. гэлээ. Бид хоёр талархлаа илэрхийгээд л уухайн тас тэгье гэлгүй яах вэ Бид зургуул замд гарч аажим ядаргаа багатайгаар дэргүүлж хатируулан явахдаа тэдний яриаг сонсвол Грип ноён бол Камбенетээс өдөржин явах газрыг эзэмдэн суудаг нутаг орондоо нэртэй томхон ноён ажээ. Бид тун удаан явсан болохоор тэр хотын зах зээлийн талбай дээр хүрч очиход өглөө орой болсон байлаа. Мориноосоо бууж ноёнд дахин талархал илэр хийгээрэй гэж тушаагаад олны дотор орохын алдад хүмүүс биднийг сонирхож эхэллээ Тэд бол бид хэд хоногийн өмнө тааралдсан олон цуваа боолуудын сүүлчийн хэсэг байв. Тэр хугацаанд тэд гинжээ тоост замаар чирсээр л явжээ Өнөөх золгүй эр хүн үзэгдэхээ больсон байх бөгөөд бас зүс мэдэх олон хүн алга байлаа. харин хэд хэдэн шинэ нүүр үзэгдэнэ Ван тэднийг хараад огт жишимгүй бушуухан холдон зайлахыг завдаж байхад миний сэтгэл ихэд хөдлөж зүрх шимшрэн өрөвдлөөТэр хөөрхий хүний ядуухан оронцог амьтдаас нүд салгах хэцүү байв. Тэд үг ч үгүй, хэл ч үгүй, дув дуугүй толгой унжуулан бөөн бөөнөөрөө суух нь үнэхээр өрөвдөлтэй Өдөр шөнө шиг хоёр юмыг хар шуулах гэсэн юм. шиг гучаад алхмын тэнд нэг гоёмсог үгтэй эр өөр нэг бүлэг хүмүүсийн дэргэд оччихсон Бри аны агуу их эрх чөлөө хэмээн донгосож байх юм. миний уур хүрээд плебей гэдгээ мартаж хүн гэдгээ л саналаа юу л болбол юу болог, энэ индэр дээр нь гараад гэтэл чинь байдагүй шүү ван бид хоёрыг гавлаад авах нь тэр Биднийг авч явсан гүн Григийн зарц нар бид хоёрыг ингэлээ Грип ноён хэзээний ирчихсэн бид хоёр луух арж байхад вангийн уур шатаж Энэ тэнэг явдлаар юу гэж маяглаж байгаа хэрэг вэ хэмээн хашгирав Н оё н, ерөнхий гоцгодоо хандаж хүйтнээр Энэ хоёр боолыг зах дээр гаргаж худалд гэлээ., Боолыг гэнэ Тэр үг тэр удаа мөн ч дорвитой мөн ч аймшигтай дуулдлаа Ван, гавтай гараа далайж нөгөө н о ёны толгой дээр хар хүчээрээ буулгах гэсэн боловч цаадхи нь бултаж амжив Тэр өөдгүй этгээдийн өдий төдий зарц бид хоёрыг дайрч төдхөн гарыг маань ард хүлж арчаагүй амьтад болгов Бид хоёр өө рсдийг өө чөлөөт хүмүүс хэмээн өндөр дуугаар хичээнгүйлэн зарлахад уран илтгэгч болон түүний эх оронч сонсогчдын анхааралд өртөн илтгэгч ингэж хэлэв

- Та нар үнэхээр чөлөөт хүмүүс бол айхын хэрэггүй Бурхны заяасан британы эрх чөлөө та нарт бамбай болно. гэлээ. а лга ташицгаав Та үүнд үнэмших хэрэгтэй н отолгоо гаргаж ирэгтүн

- Ямар нотолгоо?

- Та нар чөлөөт хүмүүс гэсэн нотолгоо Өө, би гэнэт саналаа Ухааны нь олоод юу ч хэлсэнгүй гэтэл ван догшин шуурга адилаар

- чи солирсон хүн байна. Энэ хулгайч, өөдгүй этгээд биднийг эрх чөлөөт биш хүмүүс гэж нотлог л доо гэв Ван, өөрийнхөө хууль дүрмийг мэддэг байлаа., гэхдээ ихэнх шигээ үг үсгээр нь л мэдэх болохоос ажил хэрэг дээр хэрэглэхийг мэддэггүй байлаа. Хуулийн жинхэнэ учир утгыг ойлгохын тулд түүнийг өөрийн биеэр амсаж үзэх хэрэгтэй юм. Бүгд цөхөрсөн янзтай толгой сэгсэрч, бид хоёрыг сонирхохоо болиод цааш явах хүн олон харагдлаа Илтгэгч энэ удаа ч гэсэн ажил хэргийн чанартай боловч төдий л их сүр сүлдтэй бишээр

- Өөрийн орны хууль дүрмийг мэдэхгүй байгаа бол мэдэж авах цаг болж шүү Та хоёр бол бидний огт үл мэдэх харь хүмүүс байна., үгүй гэхийн газар алга Та хоёр чөлөөт хүмүүс байж ч мэднэ, бид биш гэхгүй Боол ч байж мэднэ Хуулинд тодорхой заасан байдаг боолын эзэн хүнээс та нарыг боол мөн гэсэн нотолгоог шаардахгүй, харин та нараас боол биш гэсэн нотолгоо л шаардана

- Эрхэм ноёнтон, та бидэнд Астолат руу хүн явуулах буюу бид хоёрыг Онгодын Хөндий орох хугацаа өгөөч гэж би хэллээ

- Эрхэм хүн та тайвширч үз, та хэр хэмжээнээс баахан хэтэрсэн шаардлага тавьж байна. ийм шаардлага биелэгдэнэ байх гэж горьдохын хэрэггүй байх шүү их цаг хугацаа хэрэгтэй болж танай ноёнд их төвөг удах болно. шүү дээ

- Ноёнд гэнэ шүү солиотой галзуу новш Надад ямар ч ноён байхгүй, би өө ... гэж ван архирах мэт хэлтэл

- Дуугүй байж үз, бурхан минь би вангийн амыг дор нь татууллаа Тэртэй тэргүй бид хоёрт мундахгүй их гал нүүрлэсэн юм. Бид хоёрыг тэд солиотой амьтад гэж үзээгүй бол бас ч гайгүй байхсан Нарийн ширийн юмны талаар нэг их дэлгэрэнгүй ярихын хэрэг алга Гүн бид хоёрыг үнэ хаялцуулж байгаад худалдсан юм. миний тэр үед өнөөх л золигийн муу гайт хууль манай Өмнө зүгийн нутагт арван гурав гаруй зуун өнгөрсөн хойно ч байсан болохоор тэр хуулийн гайгаар өөрийгөөчөлөөт хүмүүс гэдгээ нотлож чадаагүй олон зуун хүн бүх насаараа боол болон худалдагдаж байсан бөгөөд тэр үед миний бие энэ та лаартөдий л их санаа зовдогүй байжээ. Харин өөрөө үнэ хаялцах хүний зах дээрээс боол болон зарагдахдаа л тэр хуулийн бузар булайг гэнэт ухаарсан билээ. Нэгэнт тийм болсон хойно одоо яана гэх вэ Бид хоёрыг үнэ хаялцах зах дээр яг л гахай шиг худалдчихсан юм. хүн олонтой том зах зээлийн газар бол бид хоёрнэлээд үнэ хүрэх байсан, гэтэл тэр алс хол газар бүр ичмээр хямдхан зарагдаж билээ. Английн ван долоон доллар, түүний тэргүүн сайд нь есхөн доллараар явчих нь тэр Уг нь ванг арван хоёр доллараар, намайг арван таваар авах байсан л даа зах зээлийн газар ер нь тиймэрхүү байдаг шүү дээ, зах зээл нь олигтой биш бол ямар ч сайхан бараа байлаа. гээд хэдийхэн үнэ хүрч байлаа. Үүнийг ер нь санаж явууштай зүйл шүү, Тэр гүнгийн ухаан нь хүрсэн бол Гэхдээ тэрний ажлаа тийм муу хийдэгт би юу гэж гонс о йх билээ. Ямар шүү хүн болохы нь би та нарт хэлсэн, ёстой чөтгөр алгадаж байхдаа таарсан лүд дээ Боолын худалдаач бид хоёрыг хоёуланг худалдаж аваад гавлаж нийтийн цувааны хамгийн сүүлд оруулсан юм. их үд болоход бид хотын зах хүрч байсан бөгөөд тэгэхэд их юм. санагдаж тун хачин юм. бодогдож байж билээ. Английн ван, тэргүүн сайдынхаа хамт гартаа гав, хөлдөө дөнгөтэй болчихоод боолын цуваанд туугдаж явахад дэмий ажиглан харах хүмүүс ямар ч

сэжиг авахгүй байх ба цонхных нь хажуугаар өнгөрөхөд сайн санаат сайхан үзэсгэлэнт авгайчууд ч биднийг өрөвдөх нь бүү хэл сонирхож ч хяламхийхгүй байх ажээ. Тун хачим, тун жигтэйхэн санагдаж байлаа. Ер нь эцсийн эцэст юу харуулж байна.а гэвэл ванг ван хүн гэж л мэдэхээс нааш түүнд ямар ч бурханлаг юм. байхгүй, ямар ч тэнүүлч гуйлгачингаас ялгаагүй байдаг юм байна. гэд гийн л баталгаа юм даа Та нар ванг харж байхад чинь ингэж хэлэх юм. бол зүрх чинь амаараа гарах шахна шүү дээ, ай бурхан минь , Ер нь та бид бүгдээрээ тэнэг амьтад, төрөлхийн тэнэг амьтад юм. л даа

Гу чи н тавдугаар б үлэг

ГУНИ ГТ АДАЛ ЯВДАЛ

Хорвоо эрээн бараанаар пиг дүүрэн байдаг Вангийн нүүр царай барайж гүн бодолд дарагдан яваа нь арга байж уу Та нар ванг ер бишээр тийм дор унаж, өндөр их байдлаа алдаж, бүхнийг чадагч хүчирхэг хүн байснаа өчүүхэн доромж амьтан болж алдарт язгууртан байснаа хэний ч үл мэдэх хүн болж, дэлхийд хамгийн их хүн байснаа хамгийн өчүүхэн хүн болж хувирсан тухайгаа бясалган бясалган байх гэж бодоцгоож байгаа бизээ Тэгвэл чин үнэнээр нь хэлэхэд тэр бүхнээс болж тарчлаагүй, харин тийм хямдхан худалдагдсандаа л тар чилж байсан юм. долоохон долларын үнэтэй байна. гэж огт бодоогүй байжээ. тиймэрхүү юм. бодож л тарчилж байдгий нь би мэдээд бүр итгэхийн аргагүй, даанч ер биш санагдаж билээ. гэвч толгой минь ээдрээ тайлагдаж юмыг дахин зөвөөр боддог болоод ирэхтэй зэрэг би эндүүрснээ ойлгож вангийн чингэх нь зүй ёсны хэрэг гэж бодсон юм. Үнэн хэрэг дээрээ ван гэдэг бол зохиомол ойлголт, тэгэхлээр вангийн мэдрэхүй нь жин хэнэ биш, зохиомол байсан, яг л үйлдвэрийн о нь сон тоглоом шиг юм. байж шүү Харин өөрөө жинхэнэ хүн байсан учраас жинхэнэ хүний мэдрэхүйтэй байсан бөгөөд ердийн дунд зэргийн хүнийг өөрийнх нь жинхэнэ үнээс доогуур үнэлэхтэй зэрэг эвгүй дэмий санагдах нь аргагүй, ван өөрөө дунд зэргээс дээш гарахаар хүн байсангүй л дээ Золиг гэж Жинхэнэ зах дээр бол яагаад ч хорин таван доллараас доогуур явахгүй гэж надад улиглаад байсны нь яанаг шал дэмий, өөрийгөө дэндүү өндөр үнэлсэн балай бодол байлаа. би ч гэсэн төдий үнэ хүрэхээргүй байсан гэсэн ч уг асуудал ихээхэн эмзэг байсан болохоор манж зан гаргаж мэтгээгүй юм. Яана гэх вэ, худал хэлж үнэхээр хорин таван долларын үнэ та хүрэх байсан гэж зоригтой батлахаас өөр домгүй болж билээ. гэвч хорвоо буй болохоос эхлэн одоог хүртэл тийм мөнгөний тал үнэ ч хүрэх ганц ч ван байгаагүй, сүүлчийн арван гурван зууны дотор бол түүний дөрөвний нэгтэй тэнцэх үнэ ч өгөхгүй байсан гэдгийг би дотроо сайн мэдэж байлаа. би бүр залхаж гүйцэж билээ. юун тухай ярьсан ч, агаартэнгэр, хадлан тариалан, улс төр, нохой, ёс сурт хуун, бурхны номын талаар ярьсан ч аливаа бүхий л асуудлыг өнөөх л золигийн долоон долларын тухай болгочихоод болохгүй байсан юм. Олхон хүнтэй газар зогсмогцоо л над уруухарах нь ийм газар байсан бол жинхэнэ үнэд хүрэх байсан шүү дээ гэж хэлж буй нь нүднийх нь харцаас андашгүй байдаг байв. Түүнийг долоон доллараар худалдахад нь би үнэнийг хэлэхэд дотроо нэлээд бахлаж байж билээ. Харин одоо болохоор надад бүр нажид болж зуун доллараар зарагдсан ч дэмий, юу хаанаас ингэж намайг залхаах билээ. гэж бодох боллоо гэтэл тийм найдвар байхгүй байсан, яагаад гэвэл янз бүрийн худалдан авагчид өдөр бүр биднийг үзэж вангийн тухай ихэнх нь

- Энэ балай ч хоёр хагас долларын үнээс хэтрэхгүй, харин омог бардам зан нь гучин таван долларын дайтай юм байна. гэлцдэг байсан юм. Омог бардам з а н ямар ч үнэ хүрдэгүй нь хөөрхий э цсийн эцэст тиймэрхүү үг сайн юманд хүргээгүй ээ Манай эзэн сүрхий хар

ухааны хүн байсан учраас үнэ хүргэхийн тулд вангаас тэр дугагдлы нь арилгах хэрэгтэй гэж ойлгосон байна. Тэгээд эрхмийн омог бардам занг нь арилгах ажилд орох нь тэр би тэр хүнд ажил хэргийн тун оновчтой зөв лөлгөө өгч чадах байсан боловч боолын худалдаачин нарт зөвлөлгөө өгөх гэж байж бүр дэмий юм. болж мэдэх байсан тул болихоор шийдсэн юм. би өөрөө ванг энгийн тариачин болгох гэж махаа багагүй идэж байсан, ван ч дуулгавартай сайн шавь байсан л даа харин түүний ван зан ч ан рыг боолын эан чанар болгох гэж хүч хэрэглэх ер нь бараг л бүтмээргүй ажил бизээ Нарийн ши рийн юмны талаар дэлгэрэнгүй ярихаа больё Та нар өөр с н өө гадарлаж байгаа байх долоо хоног өнгөрөхөд ташуур, муна, эангидсан гар зохих нөлөөгөө ү з үүлж ван гийн бие нулимс гармаар х өө рхий болсон байв. санаа сэтгэлийн ху в ьд яагаа бол? Ө ө , тэр талаар да в ч хийгээгүй шүү Нөгөө мулгуу тэнэг боолын эзэн хүртэл боол хүний зарим нь үхэн үхэтлээ хүн хэ в ээр үлдэх юм. тийм боолын я сыг хугалж болох боловч сэтгэлий нь хугалж дийлдэгүй юм. гэдгийг хүлээхэд хүрсэн юм. даг . Боолын эзэн сүүл сүүлдээ в анг дийлэхгүйгээ мэдээд чигт нь орхисон, ван дийлж гарах нь тэр Ван маань зүгээр нэг ван биш харин хүн байсан болохоор жинхэнэ хүнийг хүн гэсэн шинж чанаргүй болгож болохгүй юм. л даа Бид бараг нэг сарын турш мөн ч их зовж олон газраар чирэгдэж их юм. амссан юм. Тэр үед Англид боол эзэмших асуудлыг хэн илүү сонирхож байв. аа? Эрхэм хүндэт ван тийм шүү Урьд энэ асуудлыг хэдий чи нээн анзаардаггүй байсан бол одоо төдий чинээ сэтгэл нь зовох болжээ. Боолын ёсыг тэгж их үзэн яддаг өөр хүнийг энэ я ва а насандаа үэсэнгүй Тэгээд хэдэн жилийн өмнө өврөөс нь асууж байснаа асуухад мань хүн тун эрс хариу өг сөн болохоор би дахин асуух зүрх хүрээгүй юм. би уг нь боолт ёсыг устгах хэрэгтэй гэж үзэж байгаа юу гэж асуусан юм. Хариу нь урьдын ад и л эрс ширүүн байсан бөгөөд ван гийн бурхнаа зүхэх нь нэлээд болхи, хараалынх нь үг өгүүлбэрийнхээ сүүлд зохих байраа эзлэхийн оронд дунд нь орж байсан боловч миний чихэнд хөгжим шиг сайхан сонсогдсон юм. Тэрнээс илүү сайхан үг түүний амнаас гарна гэж хаа ч байх билээ. Одоо би ч гэсэн эрх чөлөөний талаар бодох боллоо Урьд тэр тухай боддогүй байж, боддогүй ч гэж дээ бодолгүй яаха в , хүсдэг байж, гэхдээ дэмий юмны хойноос хөөц ө лд ө х хэрэггүй гэж үзээд ванг ч гэсэн яах юм. гэж ятгадаг байлаа. харин одоо, юу гэсэн үг вэ, бүх юм. өөрөөр эргэж байна. Би ямар ч их үнээр эрх чөлө өтэй болохыг хүсэх болов. би нэг төлөвлөгөө зо хиогоод түүндээ өө рөө бахдаж байлаа. гагцхүү зав чөлө ө , тэвчээр хоёр л Түүнээс дутахгүй түргэн биелүүлж болох төлөвлөгөө зохиож болох байсан боловч түүнээс илүү урлагтай гоё төл ө влөгөө толгойд орж и рэхгүй байсан юм. тийм учраас бидний чөлөөлөгдөх хугацаа хэдэн сараар ч хойшлогдож мэдэх байсан боловч тэр төлөвлөгөөгөө орхиж чадаагүй юм. . Адал явдалгүй зүгээр ч ө н гөрсөнгүй Нэг удаа бинийг нэг суурин газар луу тууж явтал тэнд хүрэхээс нэг бээрийн төдий зайтай байхад цасан шуург а боллоо Жигтэйхэн өтгөн цас орсон болохоор бид учиргүй ө т гөн манан дотор орох нь тэр Хав харанхуй болж бид төөрөөБоолын худалдаач хохирол гарахыг тааварлан биднийг хайр найргүй шавхуурдаж байсан болоёч, нэмэр болсонгүй улам дор бо л ж шавхуурдаж ташуурдах тусам нь бид замаасаа улам холдон төөрч аливаа тус болох зүйлээс улам холдож байлаа. Сүүл сүүлдээ бид цасанд шигдэн бүр зогсохоос өөр аргагүй болсон юм. Цасан шуурга шөнө дунд хүртэл шуурч дараа нь намдаж эхлэв . Тэр үеэр хамгийн их ядарч явсан хоёр эр хүн, гурван эмэгтэй үхэв . Бусад нь нэг муу амь голтой юм. хөлөө чирч явлаа Манай эзэн уурандаа багтарч үхэх дөхөж байлаа. Биднийг босож, цүсныхаа эргэлтийг сэргээхийн тулд биеэ чимх, алгад хэмээн улам их ташуурдаж байв. Гэнэт орь дуу тавих чимээ сонсодвол нэг эмэгтэй хоёр жижигхэн охины хамт бидэн рүү гүйж ирлээ . Авраач хэмээн м ө ргөн сөхөрч уналаа хойноос нь бамбар асаасан баахан хүн тууж наадхи чинь шуламс байгаа юм. үхэр мал үхүүлж, муур

дүртэй чөтгөрөөр туслуулж буй амьтан гэж хашгиралдана . Хөөрхий тэр эмэгтэйг чулуугаар шидэж шархдуулсаар цус нөжтэй нь хол ьж хүн гэхийн аргагүй болтол сүйд хийсэн байна. Одоо барьж аваад шатаах гэж байгаа ажээ. Манай эзнийг та нар яасан гэж бодно? Бид тэр эмэгтэйг хамгаалах санаатай түүнийг та л талаас нь бучин хаацалтал ван юу болж буйг дор нь ухаараад хэрэв дор нь шатаах юм. бол гаргаж өгнө гэлээ. в шүү Та нар бодоод үз л дээ Цаадуул нь зөвшөөрөх нь тэр Багананд хүлж хуурай мөчир авчрай асаагаад л шатаачихлаа хоёр өчүүхэн охиноо хэнхэдгэндээ тэврэн орилж хашгиран залбирч гуйсаар байгаад л шатах нь тэр Манай чулуун зүрхтэй эзэн гагцхүү ашиг хонжоо бодож явдаг хүн болохоор саяны гэмгүй эх хүнийг шатаасан галын илчинд дулаацаж тэнхээ тамир ол гэсэн боловч бид тэнхээ тамир олж ч чадсангүй зах зээлийн алдагдсан үний нь ч нөхөж чадсангүй, Манай эзэн тийм л хүн байсан юм даа би түүнийг зориуд тэмдэглэлдээ авсан юм. Тэр ца сан шуургын ү е эр мань хүн ар ван боолоо ү х үүл э э д тийм г а рз ан даа жигтэйхэн хар бууж уураа бидэ н д гарг а ж урьд урьдынхаасаа улам ш ирүү л ж байлаа. Нэг адал яадал болоход араас нь залгаад өөр бас нэг адал явдал болж байв. Нэг удаа бидний өөдөөс баахан хүн тааралдаа Тэд тус ван т улсын доторхи бүхий л хог шаар цугласан мэт байсан бөгөөд тэгэх мертлөө бүгд согтуу хөлчүү байв. Урд талд нь нэг тэрэг яах бөгөөд түүн дээр нь арван найм орчим насны эмэгтэй хөхүүл хүүхэдтэй байна. хүүхдээ байн байн элгэндээ тэээрч нүднээс нь дуслах нулимсы нь арчиж явна юу ч мэдэхгүй жаал нь баясгалантайгаар инээж эхийнхээ мээмнээс булцгар г а раараа зууралдахад эх нь ө х өө рд ө н толгойгий нь илнэ Эрэгтэй, эмэгтэй хүмүүс, эрэгтэй эмэгтэй хүүхдүүд тэрэгний хажууга а р х аш гир ал д ан гүүгэлдэн, дэвхцэн бүжиж, ш ал иг самуун муу дуу дуулцаг ан есөн шидийн х а раал та вьж байх нь ой гутам харагдах бөгөөд ёстой л чөтгөр шуламсын баяр ёслол болж буй мэт ажээ. Бид Лондоны хан а , дүүрэгт нэгэнт хүрч очлоо Манай эзэн бидэнд дүүжлүүрийн яг дэргэд аятайхан б а йр олсон байлаа. Тэнд нэг хувраг хэзээний угт а н хүлээж байсан байв. эр хүүхнийг та в цан дээр гарахад нь туслаж сэтгэлий нь засах элдвийн үг хэлж шерифийн туслагчийг исэр а вч ирч өг гэлээ. Тэгээд өөрөө цаазын таацан дээр тэр эмэг т эйн хажууд гарч очоод тэртээ дор өөдөөс нь ширтэн зогсох олны өмнөөс хэдэн хормын төдий харж байснаа золгүй бүсгүйн үүх түүхий г ярьж эхлэв . Дуу хо олойд нь ө рөвчих сэтгэлийн өнгө илэрч байна. . Бүдүүлэг харанхуй гэр оронд хүнийг өрөвдөх үг даанч ховор дуулддаг байж билээ. би түүний ярьсныг нэгд нэгэнгүй санаж байна., гэхдээ чух а м ямар үгээр хэлж байсны нь санахгүй байгаа болохоор өөрийнхөө үгээр ярьсуг ай Хууль шуд рага байх ёстой заримда а алдаа хийдэг я а на гэх вэ яах ч арга байдаггүй Бид гагцхүү даган биширч хүнийг хилс буруу шийт гэсэн байвал харамс ан марг а ж тийм явдал хойшид л б а г а гараасай хэмээн залбирах ёстой Тэр өчүүхэн балчир амьтныг хууль ц а азаар авахаар шийдсэн байна. Тэгэхлээр, хууль заа хэрэг гэвч өөр нэг хуулийн эрхээр эсхүл ялт хэрэг үйлдэх эсхүл нялх хүүхдийнхээ хамт ө лбөрч үхэхээс өөр замгүй болгож байна.

- тийм хууль ч гэсэн бурхны өмнө түүний үйлдсэ н гэмт хэрэг түүни й шившигт үхлийн төлөө бурхны өмнө хариуцах юм. Тун саяхан тэр арван наймхан настай, годгор охин Англид хамгийн жаргалтай эх хүн байлаа. Аз жаргалтай гэм хоргүй цаг а ан сэтгэлт амьтдын заншлаар а м андаа үргэлж дуу а я лж байдагсан залуу эр нөх ө р нь ч гэсэн өөрөөс нь өө рцгүй а з жаргалтай байжээ. Амь зуух арав таван юм. олж үүргээ биелүүлж өгл өө н өө с үдшийн бүрий болтол шударгаар зүтгэн Тэр орныхоо болон хүн олныхоо энх тунх амьдралд хувь нэмрээ оруулж л байсан хүн дээ гэтэл муу ёрын галт хууль ганц агшны дотор тэр ариун голомтыг нураалаа залуу эрийг нь баривчлан авч хараан з үхээд алс холын тэнгис далайд цө л

лөө . Эхнэр энэ тухай огт юу ч мэдээгүй байж Элж цөхрөнгөө барж явсан тэр залуу эмэгтэй хүйтэн цэвдэг сэтгэлтний мөсөн дотрыг боловч дэвтмээр хөөрхийлөлтэйгээр газар сайгүй уйлан хайлан эрэл хийж олон долоо хоног өнгөртөл горь тасралгүй ява вч сүүл сүүлдээ ухаан санаа нь балартаж эхэлжээ Хадгалж хураасан бага сага нөөц мөнгөө ч баржээ Түрээсээ төлөх юм.гүй болоход нь гадаа хөөгөөд гаргасан байна. хүч чадлаа тасран тасартал гуйлга гуйж явжээ Өлсөж өлбөрөхийн алдад хөхний нь сүү шавхрууч үгүй болоход т өрсөн үрээ харангадуулахгүйн эрхэнд дөрвөн эоосны үнэтэй ам зотон ху лг айлс ан ажээ. Зотонгийн эзэн түүнийг барьжээ . Шоронд хийгээд шүүхэд шилжүүлэхэд з отонгийн эзэн уг хулгайн хэргийг гарцаагүй баримтаар тангараглан баталжээ, Өмгөөлөгч өгсөн бөгөөд хэрэгтний л шийтгэлийг хөнгөлөхийн тулд гунигт түүхий нь ярьжээ Эмэгтэй ч үг хэлэх эрх авч ярихдаа ихэд өлсөхийн эрхээр ухаан балартаж сайн муу ямар юм. хийж буйгаа ч ялгахаа байж гагцхүү аймшигтай өлсөж буйгаа л мэдэж байв. гэнэ Эхлээд цаадуул нь тэр эмэгтэйг ганц бие залуу хүн болохоор бас буруу нь гэвэл хууль шударга биш байж гэмт хэрэгт түлхэн оруулсан болохоор өр ө вдөж бүгд сэтгэл уяран өршөөл үзүүлэх я нз тай байсан юм. гэтэл ял лагч нь энэ бүхэн үнэн бөгөөд үнэхээр өрөвдүүштэй боловч сүүлийн үед жижиг хулгай ихэд олширч буй учраас цаг үеэ олоогүй өрөвдөх сэтгэл н ийгүүлгэнгүй ё с нь, бурхан тэнгэр минь , өмчид аюулыг учруулж, айл голомт цөлмөгдөж, үр хүүхэд өнчирч, хүний сэтгэл зурх эвдэгдэн эмтрэх явдал британы хуульд ямар ч үнэ цэнэгүй боллоо гэж үү, тэдгээрийг өмгөөлөн хамглалах хэрэггүй гэж үү?

- ийм учраас шийггэх шаардлагатай байна. гэлээ. Шүүгч нар хар малгалгаа өмсөж гайтай үгээ хэлэхэд зотонгоо хулгайд алдсан хүн босож уруул ам, нүүр нь таталдан царай нь үнс адил хөхрөн өндөр дуугаар

- Ай, хөөрхий амьтныг, хөөрхийг минь би яаж иймхэн юм.наас болж хүний амь насанд хүрд г ийг мэдэх билээ. гэж хашгираад хөрөөдүүлсэн мод шиг ойчоод өглөө . Түүнийг өндийлгөн ирэхэд ухаан мэдрэл нь нэгэнт үгүй болж солиороод нар шингэхийн өмнөхөн амиа хорлон үхсэн юм. Жинхэнэ хүн шиг нинжин сэтгэл зүрхтэй сайн хүн байжээ. Тэр хүний үхэл болон тэнд болж байсан бүхий л явдлыг бодоод үзэхэд Британы эзэд болон хатуухууль цааз ямар шүү хэрцгий нь мэдээж байна шүү дээ Цаг нь болжээ., үр минь доромжлууцж гүйцсэн чиний хөөрхий гэмгүй сэтгэл зүрх, чамайг бодож биш, харин чиний амь насыг авсан ялтан тэдний тухайд би чиний цогцос дээр хойдохы нь уншихаа зориулсугай хойдохы нь уншсаны дараа хүүхний янзган хүзүүнд дүүжлүүрийн олс уях гэхэд залуу хүүхэн хүүхдээ хэн хэдгэндээ тэврэн уйлан цурхиран нулимс асгаруулан хүүхэд нь өөртэй нь тоглож байна. хэмээн хөөрхөн инээж хөл гараа годгонуулан байх тул уг оосрыг хүзүүгээр нь урхидахад тийм ч амаргүй байлаа. зандалчны нүд хүртэл халтирч буруу харахад хүрч байв. Бэлтгэл ажил дуусахад хувраг хүүхдий нь эхийнх нь гараас эелдэг боловч шийдэмгий салган аваад цаазын тавцан дээрээс бушуухан буув Эмэгтэй, гар сарвалзуулан хойноос нь зүтгэнэ, гэсэн ч оосор, шериф хоёрын хүч түүнийг барина Тэгэхэд нь сөхрөн унаад ингэж гуйлаа

- Дахиад ганц үнсье, хүүгээ Ай бурхан тэнгэр минь , ганцхан, ганцхан үнсье гэж үхэж буй тэр амьтан орь дуу тавин гу й в хүүхдий нь өгөхөд үнсэж үлгээд арай л бүтээчихсэнгүй Дахиад авахад тэр залуу эмэгтэй

- Хөөрхий үр минь , үзээд үзээд үзэж ханашгүй үр минь , эцэг эх ч үгүй, Гэр орон ч үгүй, үзэж харах энэрэлт нөхөд ч үгүй амьтан яаж амьд байх вэ, үхнэ дээ, хөөрхий минь гэж хашгирна

- Тэр бүгд нь би боломз Амьд яваа цагтаа аль аль нь больё хүү минь гэж сайн санаат хувраг хэлэв Ху в рагийн үгийг сонссон тэр эмэгтэйн царай ямар болсныг харсан бол уу Талархал гэх үү? Үгээр хэлэхэд үг мөхөсдөх бизээ Үг гэдэг маань зурмал галын дөл л гэсэн хэрэг шүү дээ Харин түүний харцанд жинхэнэ галын дөл дүрэлээж байлаа. Галын дөл мэт тэр харцаа цацраан улалзуулсаар энэ хорвоогийн бус бүхний орших ёстой тэнгэрийн тэр, эрдэнэсийн оронд залрах нь тэр

Гучин зур гад угаар бүлэг

ХАВ ХАРАНХУЙН доТОР уулЗСАН нь

Лондон бол боол хүний нүдэнд ихээхэн сонихон хот буюу " хот ч гэж дээ сүрэл, хог шавар болсон том тосгон шиг санагдана . Гудамж нь мурий тахир, цардаагүй, бохир, хүмүүс нь өөрөг сөөрөг үргэлж хөлхөлдөх, уранхай ноорхой, торгон дурдан хувцастай буюу мал галдаа шувууны өд хатгасан, зарим нь хуяг дуулга хэдэрсэн байна. Хааных нь ордон Лондонд байх Тэр ордонг манай хаан ажиглан хармагцаа ёстой л зургадугаар зууны хүн шиг хүүхэд маягаар хара ал тавив Бидний танил морьтон баатар, түшмэд харагдах боловч нүүр ам нь хөх няц болж өмссөн хувцас нь навгас хир буртаг болсон биднийг тэд яаж мэдэх вэ, мэдүүлэх гээд дуудлаа ч гэсэн гав гинжтэй боол нартай тэд ярих эрхгүй учраас бидний үгэнд хариу өгөх гэж зогсох ч үгүй байсан л даа Надаас арваадхан алхмын зайтай Сэнди явж өнгөрөв, намайг эрж байсан байж магадгүй гэтэл манай муу хуучин байрны өөдөөс харсан талбай дээр хуурамч зоос хийсэн хүнийг амьдаар нь тосонд чанан алж буйг хараад бүр биш болж билээ. Гэнэт сонин гаргагч маань харагдсан боловч түүнийг дуудаж би зүрхэлсэнгүй Кларенс амьд мэнд ажлаа явуулж байгаа байх гэж бодохоос л дотор ялимгүй онгойж байлаа. Түүнтэй мөд уулзаж хамтран зүтгэх байх гэсэн бодол баттай байх тул миний урам зориг хэлэхийн аргагүй бадарч байв. Байшингуудын хоорондуур татсан утас байхыг хараад санаа сэтгэл минь бүр ч их сэргэв Тэр бол ярьдаг утас юм. уу , цахилгаан утас болох нь эргэлзээгүй хэрэг Богинохон ч гэсэн утас олохсон гэж халаглаж билээ. тийм утастай болж авбал оргох төлөвлөгөөгөө биелүүлэхэд чухал байсан юм. юу гэж төлөвлөж байсан гэвэл өөрийгөө хааны х а мт Ямар нэг аргаар шөнийн цагаар чөлөөлөөд эзнээ хүлж аманд нь юм. чихэж хувцсы нь сольж өмсөөд танигдахгүй болтол нь нүдэж нүдчихээд боолчуудын гинжинд гинжлэн, тэднүүсийн эзэн нь болж Камелот руу буцах гэх мэт байсан гэвч та нар миний төлөвлөгөөг ойлгосон Ордонд ямар шүү сүртэй хачин юм. үзүүлэх гэж байсан гээч Хөндлөвч хийх төмөр утасны л нэг жаахан өөдөс олбол бодсон төлөвлөсөн маань бүтэх байв. Тэгвэл цоожийг салгаж болох байсан юм. гэтэл надад төмөр утасны өөдөс олдохгүй тун ч азгүй юм. болж байв. Төдхөн нэг аятайхан тохиолдол учрав Намайг хоёр ч удаа худалдаж авах гээд амжилтгүй болж байсан, ноён хүрч ирэх нь тэр Эзэн маань намайг анхнаасаа дэндүү их дээгүүр үнэлж тэр ноёны зэвүү дургүйг хүргэсэн болохоор намайг худалдаж авахгүй гэж би мэдэж байлаа. Намайг хорин хоёр доллараас доош хэрхэвч өгөхгүй гээд ганц ч мөнгө саахгүй байсан юм. Хааны мундаг бие бялдар бусдын хорхойг хүргэвч ихэмсэг байдалтай гээд худалдаж авахгүй байсан, тийм боол хэнд ч ямар ч хэрэггүй гэдэг байв. Намайг дэндүү их үнэтэй хэлж байсан болохоор тэр бид хоёр Салахгүй явах нь гэж би бодож байв. Харин түрүүчийн миний дурдсан ноён намайг худалдаж авчихна гэж би ердөөч бодоо гүй байсан, уг нь тэрүүнд миний хэрэгтэй нэг юм. байсан, юу гэвэл тэр хүн цэмбэн дээлийнхээ энгэр хормой хавиар урт гэгчийн ган зүү хатгасан харагдсан юм. тийм зүү гурав харагдсан Байн байн ирээд байвал нэгий нь дэлсчихэж болмоор санагдаж билээ. Надад тун ойртож өгөхгүй байсан болохоор

хоёр удаагийн маань оролдлого амжилтгүй болов. Тэгж тэгж нэг завшаан болж хамгийн доод талынх нь зүүг авчихлаа, мань хүн ч тэрнийгээ нэг л газар унагачихлаа гэж бодсон байх би тун их баярласан боловч даанч удаан үргэлжилж чадаагүй юм. Наймаа хэлэлцээд дахин таарахгүй болохтой зэрэг эзэн маань гэнэт нэг юм. хэлсний нь орчин үеийн англи хэлээр өгүүлбэл

- би санаж байгаага танд хэлье Энэ хоёр боол намайг залхааж гүйцлээ Нэгий нь хорин хоёр доллараар өгөөд нөгөөгий нь нэмэрт нь өгч орхье . Вангийн зэ в үү хүрч багтрах дөхөж байв. уухилж ханиаж эхлэхэд нөгөө хоёр ийм яриа явуулж байв.

- Бодох цаг өгвөл чиг

- Маргааш яг энэ үеэр хариугаа өгөөрэй

- за, маргааш яг энэ үеэр хариу өгье гэж өнөөх ноён хэлээд явахад эзэн нь ч явлаа Тэр агшныг ашиглаж хааны чихэнд би ингэж хэлэв

- Эрхэмсэг таныг зүгээр өгөх нь , гэхдээ тэдний бодож буйгаар болохгүй, өнөө шөнө хоёул чөлөөлөгдөнө

- юу гэнэ ээ? чөлөөлөгдөнө гэнэ ээ?

- би энэ хулгайлж авсан зүйлээрээ өнөө шөнө гинжээ таслан хаяна Ес хагаст эзэн шөнийнхөө эргэлтээр бидэн дээр ирэхэд нь барин авч аманд нь юм. чихээд үхтэл нь жанчаад өглөө эрт энэ хотоос энэ боолын цувааг эзэмшин явах болно. Намайг ердөө л тэгж хэлэхэд ван гайхан бахдаж сэтгэл таатай байв. Үдэш боолчуудын унтахыг бид хоёр тэсэж ядан хүлээж байлаа. Тэдэнд итгэж болохгүй байсан, ер нь нууцаа ил гаргаж болохгүй Тэд унтаж нойрсох гэж нэг их мунгинаагүй хэр нь надад бол учиргүй их удаж байх шиг санагдаж байв. Тэдний өнөөх хурхиран унтах дууг хэзээ ч сонсохгүй нь гэмээр л санэгдаж байлаа. Цаг яваад л байдаг, амжихгүй юм. болох нь гэхээс уур хүрч байлаа. гэтэл миний яарснаас болж улам ч удах болж байсан юм. Харанхуйн дунд дөнгө гинжээ оролдож дуу чимээ гаргамагц л хэн нэг нь сэрж эргэж хөрвөхөд нөгөөдүүл нь сэрээд байв. Гэсэн ч тэгж тэгж гинжнээсээ салж чөлөөтэй хүн болов. дотор онгойж гүн гэгчээр амьсгаагаа аваад хааныхаа гинжинд хүрэх гэтэл эзэн маань нэг гартаа лаа, нөгөөдөө бүдүүн муна барьсаар ирдэг хэрэг шүү би гинжгүй байгаагаа мэдэгдэхгүйн тулд унтаж буй хүмүүст шахан хэв т ээд бас ойртоод ирмэгц нь үсрэн босож дайрахад бэлтгэн алхаж гишгэх бүрий нь отож байлаа. гэтэл тэр хүн надад ойртож ирсэнгүй дороо зогсоод Ямар нэг юмны тухай бодсон бололтой тэр харлан хэвтэх боолчуудыг ширтэн авай Тэгснээ лаагаа унтраагаад бодолд дарагдсан янзтайгаар гарц уруу чи глэн намайг яах ийхээ шийдэж чадаагүй байтал гараад үүд түгжив

- Түргэл, б уцаагаад ирүүл гэж ван хэлэв чингэх нь үнэхээр зүйтэй байсан учраас миний бие агшин зуур үсрэн босож хойноос нь харайв Тэр үед гудамжны гэрэл гэж байхгүй байсан Тэгээд шөнийн харанхуйг яана гэлээ. ч хэдхэн алхмын тэнд нэг сүүмэлзсэн юм. харагдахлаар нь дайраад буучихсан чинь сүртэй шиг зодоон болох нь тэр н үдэлдэж өгчилгөж гарлаав шүү Төдхөн олон хүн цуглаж бид хоёрын зодооныг дарвиан жигтэйхэн хөгжилдлөө бас бидний архан талд тэр даруй өөр нэг зодоон үүсэхэд өнөөх олны лавтай тэг дундуур нь хуйлран очиж тэднийг дар в иаж гарлаа . Тал талаас дэнлүү гэрэлтсэн нь харуулынхан ажээ. . Намайг арлуу минь алмасан сүхээр буулгаж байна. юу болж байгааг ч гадарлав, би ч баригдлаа, миний

зодолдсон хүн ч баригдлаа Биднийг хуяг дагуулан шоронд аваачих нь тэр т усгүй юм. боллоо нарийн бодож боловсруулсан хамаг төлөвлөгөө маань балран унах нь тэр Эзэн маань өөртэйгээ ямар хүн зодолдсоныг мэдээд яах бол, бид хоёрыг нэг шоронд хамт хийчихлээр юу болох вэ, архичин хаяа хадрагч муусайн хулгайчдын дотор оруулчихлаар юу болох вэ гэж би ухааран бодож үзэхийг хичээлээ миний зодолдсон хүн маань гэнэт над уруу эргэн харахад түүний нүүр хуягийн дэнгийн гэрэлд тодроход, ай бүү үзэгд, эзэн биш байлаа.

Гу чи н долду га ар б үлэг

АЙМШИГТ БАЙДАЛД ОРОВ

Унтъя гэвч бололцоо алга Архичин, үргэлж хашгирч гуугалсан, хэрэлдсэн тийм амьтдын үймээн шуугианд яаж ч унтаж чадах билээ. Бас миний алдаанаас болж тэр боолчуудын тэнд юу болж байгааг мэдэхсэн гэж бодоод нойр хүрч өгөхгүй байв. Шөнө адаг төгсгөлгүй мэт байсан боловч үүр цайх нь цайлаа Шүүхэд би туй тодорхой мэдүүлэг өгсөн би бол тайж язгууртан гүн Григийн харьяа т боол бөгөөд гүн түүний урд өдөр голын эргийн тэртээ талд байдаг тобард тосгонд хүрч ирээд Ямар нэгэн халдварт өвчний улмаас тэнд хоноглохдоо намайг хот орж хамгийн сайн нэг эмч олж ир хэмээн явуулсан гэсэн болохоор миний бие хамаг чадлаа гарган туйлын их мэрийн явсан шөнө хав харанхуйд энэ нэгэн тэнэг юманд тээглэсэнд намайг багалзуурдан авч нухан эхлэхэд нь би эзэн ноёныхоо амь насыг аврах гэж яаруу яваа хүн шүү хэмээн учирласан боловч болж өгөөгүй юм. Энэ маанаг этгээд намайг ул үндэсгүй худал хэлж байна., намайг зүгээр байхад дайрсан гэж зүтгэлээ

- Дуугаа тат, луйварчин гэж шүүгч зандран

- тайж язгууртан ноёны зарцтай хожим яаж харьцаж байх ёстойг ойлготол нь наадхийгаа гөмпрөгдөөд өг гэв Тэгээд шүүгч надаас уучлалт гуйгаад энэхүү жигшүүрт явдал гарсан нь шүүгчийн буруу биш гэдгийг эрхэм эзэндээ айлтгана гэж найдаж байна. гэлээ. би тэгнэ гэж амлаад гарахаар үүд рүү зүглэв Тэгтэл та анх баригдмагцаа тэр тухайгаа яриагүй юм. аа гэж асуув Хэрэв тэр хүн намайг ухаан санаагий минь баларттал нүдээгүй бол би хэлэх л байсан гэх мэтээр баахан юм. хэлэнгээ үүдээр гарч одов Өглөөний хоол унд идэх гэж ч би тэнд саатсангүй Баярласандаа хөл минь газар хүрэхгүй байсан тул төдхөн боолчуудынхаа байранд хүрч ирсэн билээ. Тэгсэн чинь ганц ч амьтан байхгүй бүгд алга болсон байлаа. харин эзэн нь л үлдчихсэн байв. хүн танихын аргагүй сэглүүлэн, үхтлээ зодуулсан байв. Эргэн тойрон харваас саяхан болсон сүртэй их тулалдааны ул мөр энд тэндгүй үзэгдэнэ Үүдний хавьцаа нэг тэргэн дээр муухай хийцтэй авс байх агаад авсчин нь цагдаагийн хамт дэмий сэлгүүцэх олны дундуур зүтгэн хүүрийг авсанд хийх гэж оролдоно Над мэтийн навс уранхай хувцас хүнартай амьтантай ярихаасаа ичмээргүй тийм нэг даруу амьтнаас энд юу болж өнгөрөө вэ гэж асуулаа

- Урьд шөнө арван зургаан боол эзнийхээ эсрэг босоод няхуулах нь тэр

- Өө тийм бий юунаас яаж эхлээ юм. бол?

- Боолуудаас өөр мэдэх хүн энд байгаагүй юм. гэнэ Хамгийн сүрхий нэг боол гинжнээсээ мултарч тайлагдашгүй нууц аргаар эндээс ангижирсан нь лав тэр хүн ид шидтэй байсан байх, яагаад гэвэл хаалга цоожтой байхад гараад явсан байж гэнэ, өөрт нь түлхүүр байгаагүй гэнэ тийм гарз гарс ан д Эзэн ноён бусад боолыг му н аараа балбаж гарсан байна.

Цаадуул нь өөдөөс нь хариу үзэлцэж нуруугий нь хугалсанд тэр дороо мажийжээ,

- Аймаар юм. болжээ. Боолуудыг шүүх балл ана даа

- Шүүх шүүчихсээн

- тийм бий

- долоо хоногоор үргэлжлэх юм. гэж бодоогүй биз дээ? шийдэж ядах юу билээ.

Иймэрхүү хэргийн учрыг таван минутын төдийд олно шүү дээ

- Хэн буруутайгий нь яаж тийм богино хугацаанд олох билээ.?

- Хэн буруутайгий нь Шүүгч нар тэр талаар ч санав зовоогүй байхаа Бөөнөөр нь хэлэлцээд болсон байх Хууль тийм байдгийг мэддэггүй юм. уу ? Боолын нэг нь л эзнээ ал б ал бүгдий нь устг а х ёстой гэсэн хууль бүр Ромын үеэс уламжлалтай шүү дээ

- нээрэн тийм л дээ хэзээ цаа з лах юм. бол?

- хорин дөрвөн цагийн дараа зарим нь ярихд а а ганц хоёр хоног болох юм. гэнэ Оргосон хүнийг олчихвол юу магад гэнэ

- Оргосон гэнэ үү? Олох юм. бол уу ? миний дотор эвгүй болж байлаа.,

- Шөнө болохоос өмнө олох л доо энд тэндгүй л эрж байгаа хотын ха ал г а үүдээр харуул манаа боолууда а р тавьсан Тэд нь т ан ин а Үзэгдвэл т ан и ад л б а рин а.

- Бусды нь хаана хорьсон юм. бол?

- Гадн а ас нь харж болно., дотроос нь нүд х ал ьтраад хэн ч харж чадахгүй би шоронгийн х а ягий нь мэдэж ава ад т ийш ээ явлаа хүн хар цөөн үзэгдэх догол гудамжинд эхлээд л тааралдс ан нэг хуучин хувцасны нэг мухлагт орж усан цэргийн хуучин хувцас авч шүд өвдөөд гэж алчуураар нүүрээ боож хөх няц болсон газраа д ал длахад би огт танигдахгүй болсон юм. Тэгээд утасны үзүүр олж нөгөө үзүүрт нь хүрэхээр дагаж явлаа Махны мухлагийн дээрх нэг муу жижиг тасалга ан аас цааш явсан байв. Цахилгаан шугамын ажил төдий л хөгжиж база а гаагүй нь мэдэгдэж байлаа. залуухан албан хаагч ширээгээ налан эүүрмэглэж байв. Би үүдий нь цоожлоод том гэгчийн түлхүүрий нь өвөртлөө Нөгөө залуу мэдэж дэрсхийн босож хашгичих гэсэн боловч би

- Аминдаа хайртай бол амаа бүү нээ тонилгож орхино шүү за бушуул Ажлаа гүйцэтгэ Камелотыг дууд гэлээ.

- Итгэх арга алга Чам шиг ийм хүн яаж учры нь олох вэ

- Камелотыг дууд би ууртай хүн шүү Камелотыг дууд Аль эсхүл чи зайлж бай, би өөрөө дууд ья,

- юу ? чи юу ?

- л үд м и нь Ордон руу утсад Тэр хүн ордон руу утасдав

- Кларенсыг утсан дээр дууд

- Кларенс? Овгий нь хэн гэдэг юм.?

- Чамд овгий нь мэдэх хэрэг алга Кларенсыг дууд гэж хэлж байна., чамд цаанаас чинь хариу өгнө мань эр дуудлаа Таван минут, арван ч минут өнгөрч байна. их яарч сэтгэл т эсэн ядан дэнэгэлзсээр яасан их удна вэ Тэгтэл хаалга цохих чимээ гарах нь Кларенс мөн байв. хүнийг дуугаар нь таньдаг шиг, түүний үүд цохихоор нь би таньсан юм. Яагаад гэхэд Кларенс бол миний шавь шүү дээ

- за одоо чи яв Тэд намайг т ан ьж магадгүй байсан, тэгэхлээр чамаар дуудлага хийлгэ е гэж бодсон юм. гэвч одоо би өөрөө янзы нь олох уу даа Тэр намайг суудал дээрээ суулгаад чих тавин сонссон боловч тус болсонгүй би нууц түлхүүр бичиг хэрэглэсэн юм. би Кларенстай мэнд усаа асуулцах гэх мэтээр цаг дэмий үрэлгүй шууд л

- Хаан энд ч гэсэн аюулд ороод байгаа, Бид хоёрыг баривчлан аваад боол болгон худалдчихсан юм. Бид хэн болохыгоо тэднүүст үнэмшүүлж болохгүй байна. Нэгэнт яах ч аргагүй байдалд орсон болохоор би тийм оролдлого хийж ч эүрхлэхгүй байна. Э ндхийн ордонд утасдаж намайг итгүүлэхээр хэл гэхэд

- Лондонгийн ордонд цахилгаан утас байдгийг ч мэдэхгүй Лондон руу саяхан л шугам татсан тийм осолтой юм. хийснээс байсан нь дээр байх Таныг дүүжилбэл ямар сайн байх вэ Өөр юм. бодсон дээр байх гэж шууд хэлэв Биднийг дүүжилнэ гэнэ ээ нээрэн үнэн юм. хэлж байгаадаа эргэлээх ч үгүй байв. Би бодоод бодоод олигтой ухаан сийлж чадахгүй байлаа. гэтэл нэг санаа орж и рэхэд нь ингэсэн үгтэй цахилгаан явуулав

- Ланс е лот тэргүүтэй таван зуун хөлөг баатрыг ирүүл, даруй ирүүл, Тэднүүс хотын баруун урд хаалгаар орж ирээд баруун гараа цагаан даавуугаар боосон хүнийг олог Үүний хариуд товчхон мэдээ ирлээ

- Хагас цагийн дараа мордоно

- Маш сайн байна., Кларенс Одоо эндхийн залууд намайг чиний найз н ө хөр, дүрсгүй хүн гэж хэлээд намайг энд ирсэн гэж хэлчихэлгүй амаа сайн барьж бай гээ Аппаратаар залууг ярьж эхлэхэд миний бие явахаар яаравчлав тоолж үзвэл хагас цагийн дараа есөн цаг болох байлаа. Морьтон баатар, агт морьд хүнд хуяг дуулгатай учраас их хурдан явж чадахгүй, цас орж шавар шавхай болохгүй бол цагт зургаа долоон бээр явна замдаа морьдоо нэг хоёр удаа юүлнэ, тэгэхлээр зургаан цагт юм. уу , хожуухан хүрч ирнэ Гэгээтэй байхад ирэх болно. би баруун гараа цагаан юм.аар уяж орхих учраас тэд намайг дорхноо мэднэ, би ч тэднийгээ удирдаж гарна . Шоронг бүслэн аваад хаанаа гаргаж авна Тэднүүс их үдийн алдад ирвэл бүр ч их сүртэй сайхан болох байсан боловч ямар ч гэсэн тун догь болох байлаа. би хэзээд нөөц хөвчтэй байхыг дээр гэж боддог байсан болохоор урьдынхаа танилуудын нэгээр оръё гэж бодлоо Тэгээд мор ьт он баатруудгүйгээр ч гай зовлонгоос мултрахад тус болж юун магад т ун осолтой ажил учраас тун ч хашир байлгүй горьгүй Зохих хувцас хүнар олж авах хэрэгтэй байсны дээр тийм юм. олж авсны дараа яарч агдахын хэрэггүй байв. Нэг мухлагт ороод ядуу хүний хувцас, нөгөөд нь ороод дунд з эргийн чинээлэг хүний өмсдөг хувцас худалдан авна, тэгээд л мухлаг мухлаг дамжин явж хувцсаа сайжруулсаар то рго дурдан болж огт танигдахгүй болох хэрэгтэй байлаа. Ингэхээр бүр шийдлээ гэтэл төлөвлөгөө маань дороо балран унах нь тэр Гудамжаар ороод дөнгөж нэг булан ороотол хотоор хуяг даган явж буй манай нэг боолтой тааралдчихдаг байгаа даа санаа муу шиг хоолой сэрвэгнэж ханиачихсан чинь өнөөх чинь намайг харчихлаа миний хамаг хөрөх шиг болов. М и ний ингэж хан и

адгийг энэ боол санав бололтой гэж би бодлоо Нэг мухлаг уруу бушуухан шиг орж лангууг нь налж зогсон бараа таваар үзэж үнэ хэлэлцэн байн байн хулгай нүдээр үүд үрүү харж байв. Боол, хуяг хоёр үүдний гадна ирж ярилцан зогсоно би тэр мухлаг араараа гардаг хаалгатай бол тэрүүгээр нь гарч явахаар шийдэж мухлаг и йн Эзэн авгайд танай хашаагаар орж болно. биз, энэ хавийн энэ хашаанд л оргодол боол нуугдаж байгаа бололтой гээд би бол зүсээ хувилгаж хувцасласан хуяг хүн байгаа юм. миний нэг нөхөр хуяг маань эзнээ алсан нэг боолын хамт танай үүдэн дээр гадаа байгаа . Та намайг гарсан хойно тэрүүнд энд байж цаг алдах хэрэггүй гудамжны нөгөө талд очиж бай, тэндээс нөгөө ор годол боолыг угтан барьж ав гэж хэл гэв Мухлагийн эзэн авгай, эзнээ алсан боол гэж нэгэнт алдаршсан хэргийн нэг эзэнг ч гэсэн нүдээрээ үзэх хэмээн учиргүй яарах тул нэн даруй миний даалгаврыг биелүүлэхээр үүд рүүгээ ухасхийх нь тэр би арынх нь хаалгаар бушуухан гарч үүдий нь цоожлон түлхүүрийг нь өвөртлөж инээдээ барьж ядан өөрийнхөө амжилтад ба хархан байсан боловч нэг дор хоёр давхар алдаа хийснээ ухаарч тун ч биш болов. Цагдаагаас зугадах арга олон байсан боловч би хамгийн дөнгүүр аргыг нь шилж авахгүй юу даа юм. л бол хамгийн үзэмж сүртэй гэж өвчигнөдөг маань миний гол дутагдал юм. Уг нь би тэр цагдааг эрхбиш хүн юм. болохоор хүний зүй ёсоор ажиллах биз гэж бодсон гэтэл зүйн ёсоор ажиллахгүй тийм явдал огт санаанд ороогүй байхад тохиолдох явдал байдаг л даа хамгийн зүйтэй ажиллагаа нь гэвэл тэр цагдаагаас өөр амьтан бол миний хойноос л мөрдөн хөөх ёстой байсан, үүд эвдэж орж ирэх гэж оролдох ёстой байсан, тэгж байх хооронд нь би хувцсаа янз бүрээр сольж жигтэйхэн дэгжин нэг ноёны байдалтай болж орхиход Британы ганц ч тагнуул намайг ариун явдалт гэм халгүй хүн гэж бодохдоо хар хумсын чинээ ч сэжиглэхгүй билээ. гэтэл тэгж зүйн ёсоор ажиллахын оронд цагдаа маань миний хэлүүлсэн үг болгонд итгэн миний тушаалыг биелүүлэх нь тэр би мухардмал байдлаас мултран гараад нарийн ухаан сийлж чадс ан даа сэтгэл тун хангалуун гараад явгал нөгөө этгээд чинь булан тойрч гарч ирээд намайг гавлаад авах нь тэр Хэрэв миний бие тэр мухардмал байдлыг гэвч түүгээр биеэ цагаатгах арга алга, Хэрэг нэгэнт нэг т болж одоо ашиг алдагдлаа тооцох цаг ирэв, миний зэвүү их хүрч тэр боолыг молгидох санаатай би бол дөнгөж саяхан алсын далайн аяллаас буугаад явж байгаа хүн гэж тангараглан хэлэвч намайг нэгэнт таньсан болохоор ямар ч нэмэр болсонгүй Тэгэхлээр чи яах гэж намайг барьж өгөө хэмээн зэмлэвэл нөгөөдөх чинь санаа зовох байтугай харин гайхаж нүдээ жигтэйхэн дүрлийлгэн гайхаш нь барагдсан янзтайгаар

- Чамайг дүүжлүүлэхээс аврагдаг гээд тавьчих нь гэж чи арай бодоогүй биз дээ? Чамаас л болж бид бүгдээрээ дүүжлүүлж үхэх гэж байж тэгнэ гэж бодоогүй биз? Дэндэнэ вий? гэв Бид нар яасан инээд хүрмээр юм. ярина вэ гэж хэлмээр тийм тохиолдолд тэднүүс д эндэнэ вий гэдэг юм. . Хачин яриатай хүмүүс шүү миний бодоход тэр хүн хувьдаа бас л зөв юм даа гэж бодоод би түүнтэй олон таван үг маргасангүй ингэж хэлсэн

- Чамайг яавч дүүжилж алахгүй Бидний хэн маань ч дүүжлүүлэхгүй Нөгөө хоёр миний тэгж хэлэхийг сонсоод паржигнатал инээд алдаж боол нь

- Чамайг уг нь тэнэг амьтан гэж бодоогүй Тэгэхлээр чи тэр хүндтэй нэрээ хадгалахыг бод, хадгалах гэж удаан зовох хугацаа үлдээгүй тусмаа олигтойхон хичээ гэв ч

- миний нэр төр наддаа л үлдэнэ Маргааш үүр цайхын өмнө бид шоронгоос гарч чөлөөтэй хүмүүс болцгооно . Мэргэн цагдаа чихээ хуруугаараа ухаж хоолойгоо засаад

- нээрэн, та нар шоронгоос гарч чөлөөтэй хүн болцгооно . Гэхдээ энд биш, доод тивд

очоод тийм улс болно. гэлээ. би уураа барьж ядан

- Биднийг энэ хоёр хоногийн дотор дүүжилж ална гэж чи бодож байгаа юм. уу гэж хэнэтгүйхэн асуулаа

- хэдэн минутийн өмнө тэгж бодож байсан, яагаад гэвэл тийм шийдтэй байсан юм. тэгж зарласан юм.

- Тэгвэл чи одоо өөрөөр бодож байна. уу ? тийм байх аа?

- Одоо өсрөөр бодож байна. Түрүүн ч тэгнэ байх гэж бодож байсан, харин одоо сайн мэдэж байна. миний инээд хүрч жуумалзан

- Хууль сахиулагч эрхэм мэргэн хүн та тэр сайн мэдэж байгаа юмаа бидэнд хэлж соёрхох юм. биш үү

- Та нарыг бүгдийг өөнөөдрийн гурван цагт дүүжлэн цаазлана чи мөн тэвдэж байна. даа, намайг түшихгүй бол унах нь байна шүү би үнэхээр нэг юм.наас барьж авмаар санагдлаа Морьтон баатрууд минь хүрч ирж амжихгүй нь дор хаяад гурван цаг хожигдож ирэх нь Английн хааныг энэ ертөнцөд юу ч аврахаасаа өнгөрчээ Хаанаас ч илүү чухал намайг энэ хорвоод аврах юм. үгүй болжээ. Соёл иргэншил хүртэх ёстой ганц ард түмэнд л өөрөөсөөч илүү чухал хэрэгтэй хүн аврагдах замгүй болжээ. гэж бодохоос тун хачин болж билээ. хэлэх ч үг олдохгүй дуугүй л байлаа. Алга болсон боол олдвол цаазлах хугацааг наашлуулж өнөөдрийн дотор гүйцэтгэх учиртай гэж цагдаагийн хэлсэн үгнээс би ойлгосон а лга болсон боол нь олдох нь тэр байж

Гучин наймдугаар б үлэг

НОЁН ЛАНС ЕЛ ОТ, ХҮЛЭГ БААТРУУД ТУСЛААР ИРЭВ

Их үдийн дөрвөн цагийн алдад билээ. Лондон хотноо уг хэрэг явдал болж байлаа. Наран гийсэн жихүүн мөртлөө найрсаг сайхан өдөр байлаа. тийм өдөр хүн үхэхгүй амьд явахыг хүсдэг зах сэжүүр нь харагдахгүй шороон түмэн хүн амьтан эргэн тойрон пиг дүүрэн хуржээ гэтэл д үүжлүүлэх бидний арван таван хүнд найз нөхөр гэх ганц ч хүн тэр шороон түмэн хүний дотор үгүй ажээ. Тэгж бодохоос лав л миний эүрх шимширч байсан юмдаг Тэр олон амьтан цөм бидний дайсан болж цаазын өндөр довжоон дээр сууж буй бид хэдийг тэднүүс ёжло н доо г х ийж хорсон доромжлох бай болгов Бид тэдний зугаа гаргах жүжиг үзэгдэл болов. Тайж нарт зориулан тусгай суудал зассан байсан тул тэд хатан нарынхаа хамт сүрэглэн суужээ Тэдний олон нь бидэнд танигдаж байсан Тэр олонд ван санамсаргүй зугаатай ааш гаргаж дөвчигнөө Бидний гарын гав, хөлний дөнгийг авгал мань хүн хачин муухай уранхай ноорхой салам хувцастайгаа салбалзан, хүн танихын аргагүй хөх няц болсон нүүр царайгаа язвалзуулан би бол Британы Артур х а ан байна., хэрэв тануус миний ариун тэртүүний ганц ширхэг үсийг ойчих дээр хүргэдэг юм. бол урван тэ рсэлсэн хэргээр тануусыг аймшигтайгаар цээрлүүлнэ гэлээ. Тэгж хэлэхэд нь хүмүүс нирхий т э л инээлдэхэд мань хүн хичнээн их гайхсан гээч хүмүүс түүнийг элдвээр өдөн шүгэлдэж исгэрэлдэн нохой муур мэт хашгиралдан дахиад юу гэнээ, юу гэнээ хэмээн хашгир а лдавч тэгж их доромжлуулсан хаан о г т юу ч дуугарсангүй

- Ярь, Ярь Ван гуай, вантан минь ярь, ярь Таны навс нэвс болсон жавхлант сүрлэг

мэргэн үгий чинь Номхон дорой боол бид чинь сонсох хүслэнгээр бялхаж ядан байна. гэвч тэд юу ч олж долоосонгүй Ван маань элэг доог хийлгэн ихэмсэг хямсгар байдалтай суусаар байлаа. санаандаа бол үнэхээр ихэмсэг их амьтан байлаа л би алмайрсан маягтайгаар нүүрнийхээ цагаан боолтыг тайлж баруун гараа боов Үүнийг ажсан олон Амьтан надаар элэг доог хийж эхлэв —" Энэ далайчныг ээ, сайд нь байж таарах нь , мөрөвчий нь харахгүй юу Тэднийг өөрснөө залхуугаа хүртэл доог тохуугаа хийж л байг гэж би бодоод саад хийхийг бодсо н гүй, тэгээд

- би нээрэн сайд нь шүү, би бол Эзэн Энэ тухай та нар маргааш Камелотоос сураг сонсох болно., тэнд Тэд пар пархийн инээлдэх тул би цааш нь үгээ хэлж чадсангүй гэтэл Лондонгийн шериф нар туслах нартайгаа хүрэлцэн ирсэн тул чив чимээгүй болов. Тэд ирсэн бол цаазлах цаг ирэх нь тэр чив чимээгүйн дунд бидний үйлдсэн гэмт хэргийг сонсгон ялын төлөвлөгөөг уншихад бүгд малгалгаа авч хувраг бидний хойдохийг уншив . Тэгээд боолын нэгний нүдийг боож зандалчин нь хүзүүнд нь оосор уялаа . Бид болон үй олон хүний хооронд цагдаа нарын хамгаалсан зам, хоосон зам ярайн харагдах бөгөөд тэр замаар миний таван зуун морьтон баатар ороод ирдэг ч болоосой . Даанч биелж бүтэмгүй мөрөөдөл байж дээ хөөрхий миний нүдний хараа зам даган алсыг хэсэвч харагдах юм.гүй л байлаа. Нүд ирмэхийн зуур нөгөө боол маань салба с хийн унж а ад хүлээгүй болсон хөл гар нь сарвалзан тэлчлэв зандалчин бас нэг боолын хүзүү оосорлож дүүжлүүрт бас нэг хүн сарвалзлаа . Минут хэр болсны дараа гурав дахь боол агаарт тэлчлэх харагдана . Аймаар байлаа. би эргэж хараад толгойгоо эргүүлэхэд хаан миний хажууд алга байв. Нүдий нь боочихжээ би бүр барьц алдаж хөл гар минь хөдлөхөө больж хоолойд нэг юм. тээглээд хэл амандаа эргэж өгөхгүй байв. Нүдий нь боогоод оосрын дор аваачсан байхад би хөшсөн байдлаасаа гарч чадаагүй байсан боловч хааны хүзүүг оосорлож эхлэхэд миний доторхи бүх юм. эргэж хурган өөрчлөгдөх шиг болж хааны амийг аврах хэмээн түүний зүг ухасхийгээ т эр зуур нүднийхээ булангаар зам руу харвал бурхан тэнгэр минь , таван зуун баатар эр маань дугуй уначихсан жирийлгэж байлаа. Насандаа би тийм сүр жавхлантай сайхан юм. үзсэнгүй . Малгайдаа атгасан өд сөд нь хичнээн сүрлэг намирч, дугуйных нь ган хигээс нарны хурц гэрэлд нүд гялбам гялалзахы нь яана би Ланселот уруу даллахад тэр намайг цагаан боолтоор минь танилаа би вангийн нүдний боолт, хүзүүний оосрыг авч хаяад

- Муусайн зэрлэг адгууснууд вангийн өмнө сөхрөн мөргө, баяр хүргэ Хэн эс дагавал тэр энэ орой тамын газар үдшийнхээ угаадсыг иднэ гэж хашгирлаа би Ямар нэг нүргээнтэй юм. бэлдэхдээ дандаа дээд зэргийн үр нөлөө үзүүлж чадахуйц үг хэрэглэхийг хичээдэг юм. Ланселот н ө хдийнхөө хамт хүрэлцэн ирээд цаазны тавцан дээр гарч шериф болон тэдний туслагч нарыг тэндээс түлхэн зайлуулж байхыг нь харахад үнэхээр аятайхан байсан юм шүү Саяхан дооглож доромжлон ханахгүй байсан өнөөх шороон түмэн хүмүүс өвдөг дээрээ сөхрөн ухаан тавих дөхөн царай алдан өршөөн соёрхохыг гуйж байхыг нь харахад ч багагүй зугаатай байлаа. хаан маань навс нэвс болсон хувцастай хэр нь ихэмсэг сүртэй зогсох бөгөөд хааны зан араншин гэсэндээ бас нэг хоосонгүй байдаг байна шүү гэж бодогдож байлаа. би хэмжээ хязгааргүй сэтгэл хангалуун байв. бүрэлдэж буй болсон тэр үеийн бүхий л байдлыг харгалзан үзвээс миний амьдралд энүүнээс илүү үр нөлөөтэй явдал болоогүй юм шүү Гэнэт Кларенс, Кларенс биеэрээ миний дэргэд хүрч ирэх нь тэр Над уруу харж ирмээд юу ч болоогүй юм. шиг байдалтайгаар Я ггү й аятайхан юм. болоо биз дээ Чамд үнэхээр таалагдах байх гэж бодсон юм. би нөхдөө дугуй унаж суоахыг аль хэдийн бэлдээд ур чад ва ры нь харуулах цаг үеийг хүлээж байсан юм. гэ в.

Гучин есдү гээ р бү лэг

ЯНКИ, ХҮЛЭГ Б ААТРУУДТАЙ ХАЛЗ ТУЛАЛДАВ

би дахин Камелотдоо харилаа Түүнээс хойш хоёр хоноод нэг өглөө өглөөнийхөө хоол ундыг идэж уухаар ширээндээ суутал дөнгөж сая хэвлэгдсэн сонины будаг нь ч хатаж гүйцээгүй хуудас байхыг олж үзлээ Надад холбогдолтой Ямар нэг зарлал гарсан байх ёстой гэж бодоод зарлалаас нь эхлэн харав Үнэхээр тийм байлаа.

Вангийн зарлигаар

Их н оён ал дарт баатар эр хүслэн болсон С аграмор ноён эз э н хэмээн нэршсэн хааны сайд Хэнк лүгээ түүний хуучин ө сийг тайлах халз тулаан хийхийг ний т эд зарласугай Энэхүү тулаан ирэх сарын ар ван зургаа дахь өдрийн өгл өө ний зургаан цагт Камелотын ойролцоо болно. Уг тулаан хо нз он нь угаас үхлийн чанартай учраас хайр н айр гэхийг үл мэдэх бөгөөд хоорондоо эвсэн найрамдахыг үл зөв ш өө рн ө

Кларенс энэ зарлалыг дагалдуулан дор дурдсан тайлбарыг сонины газраас дагалдуулсан байсны нь сийрүүлбэл

М ө д гарамгай тулалдаан болж өнг ө рөхийг сонины зар л ал харсан уншигч аягай нар мэдэж буй Жүжиглэгчдийн нэр алдар нь уг тулаан уйтгартай болохгүй гэдгийн баталгаа болж байна. К а сс 1 3 нд үдэд нээгдэх б ө г өө д орох үнэ 3 ц е нт, сандалд суух суудал 5 ц е нтийн үнэтэй Цэвэр орлого нь эмнэлгийн фондод орох юм. Хамгийн гайхамшигт хатагтай нар болон ихэс түшмэд хүрэлцэн ирнэ Тэднээс гадна хэ в лэлийн болон шашны т ө лөөлгчид байх болно. Тэднээс бусад нь бүгд ниутай орно Дамынхнаас ниу а ва хаас татгалэв ал зохи н о тийм ниутай хүмүүсийг оруулахгүй Бид бүгдээр эзэнг мэдэх бөгөөд түүндээ хайртай, бид бүгд Сагра м о р но ё ныг м э дэх бөгөөд түүндээ хайрт ай билээ. тийм учр а ас ирж тэр хоёрыгоо хөгж өөе. орох орлогыг нь ивгэ эх зорилгод зарцуулах, тэхдээ үндэс угс а а, гарал, нийг м ийн байдал, арьсны ө нг ө ялгахгүйгээр энэ дэлхийд ганцаар бүй бөгөөд улс т ө р шашны ямар ч жийрэггүйгээр гагцхүү зо в лон эдлэгч хэнд боловч тусламжийн гар сунгах энд нэгэн горхи урсаж байна., ангасан цангасан бүхэн наашаа ирж цангаагаа гаргатун? гэж хэлж байх тийм нэгэн и в гээн тэ т гэх газар т шилжих юм шүү Тэгэхлээр мөнгө цэнг э э бү ү хайрлагту н Цаг тун сайхан өнг ө р өх болно. Гонсойн гомдох юм. болохгүй Тулааны газар бин худалдах бөгөөд хагалж идэх чулуу нь ч хамт байх болно. Бас цир к ийн тусгай жим с ний ундаа зарах юм. Тэр бол нэг торх усанд нимбэгийн г урван дусал дусаасан ундаан шүү Энэ бол оролцогч хо ё р этгээд нь хэрэглэх з э в сгээ өөрснийхөө дур хүслээр сонгож а в ах эрх бүхий анх уд аа зохиогдож байгаа тийм шинэ хуулийн дагуу я вагдах т эм ц ээ н юм шүү Үүнийг анхааран толилуулья,

товлосон өдрийг болтол бүх Брит ани ор о н даяар хүн болгоны аманд гагцхүү тэр болох тулааны тухай л я риа байлаа. Бусад бүх сэдэв, эрх ашгийн з үйл тоогдохоо больсон юмдаг хоёр хүний халз тулаан ерөөс тийм чухал ажил байсандаа ч биш, С а грамор ноён ариу н Граалийг олсон учраас ч биш, олж чадаагүй шүү дэ э. Тэр тулаанд улс гүрний дотор хааны дараа ордог хоёр дахь мундаг хүн орох учраас ч биш иймэрхүү явдал бол ердийн хэрэг байсан юм. Болох гэж байсан тулааныг онцгой сонирхон ярилцах тусгай шалтгаан байсан Тэр бол жирийн хоёр хүний хооронд болох тулаан биш, харин ч хүчирхэг хоёр идтэн шидтэний хооронд болох булчин шөрм ө сний биш оюун ух а аны, жир хүний биш, хүний чадлаас

гарамгай дээд зэргийн урлагийн халз тулаан, тэр бол орчин цаг зууныгаа зээлсэн агуу их хоёр шидтэнгийн хооронд болох тулаан гэдгийг хүн бүхэн андахгүй мэдэж байсан юм. тийм юмны дэргэд хамгийн алдар цуутай дайчин баатруудын хоорондын хамгийн сүртэй тулаан ч мөр зэрэгцэн үл очих тийм үзэгдэл болох байсан юм. Бусад нь бол бурхдын аймшигт ид шидэт тулалдаантай зүйрлэв эл хүүхдийн тоглоом билээ. Тэр бол үнэн чанартаа Мерлин бид хоёрын хооронд болох, бид хоёрын ид шидийн хооронд болох тулаан гэдгийг хотол олноороо мэдэж байсан юм. Саграмор ноёны ээр зэвсэг бамбайг довглох болон хамгаалах ер бишийн ид шидтэй болгох гэж Мерлин өдөр шөнөгүй махран ажиллаж, Мерлиний захиалгаар миний дайсан нь надаас бусдад харагдах боловч надад л харагдахгүй байх тийм үүлэн бүрхэвчийг агаар хийн бурхад нэхэж буй болгосныг бүгд андахгүй мэдэж байлаа. Тэгж зэвсэглэсэн, тийм ивгээлийн дор орсон ноён Саграмор мянган баатар эрд ч дийлдэхгүй, одоо хүртэл мэдэгдсэн аливаа ид шидийн ямар ч хүчинд давагдахгүй ажээ. Энэ бүхэн бол биетэй бодитой зүйл байв. түүнд эргэлзэх юу ч үгүй байсан, эргэлзэх ямар ч үндэс байгаагүй юм. Саграморын бүрхэвчийг надад нэвт харагдах болгох, түүний шившилтэй хуяг дуулгыг миний зэр зэвсэг дийлэх болгох тийм ид шид Мерлиний үл мэдэх ид шид байдаг эсэхийг л тайлбарлах асуудал үлдэж байв. Энэ асуудлыг гагцхүү халз тулаан л харуулах ажээ. Тэгээд хотол олноороо тэр халз тулааныг хүлээж байв. Тийнхүү маш олон зүйл үхлийн даваан дээр очоод байна. гэж бүгд бодож байсан бөгөөд үнэхээр ч тийм байсан юм. Тэдний бодож байснаас ч илүү их олон юм. үхэх сэхэхийн сорилд ороод байсан юм. л даа Тэнэн хэрж явах морьтон баатрууд гэж байхыгн хэрэг цаешид байх уу, үгүй юу гэсэн асуудал шийдэгдэх байлаа. би бол үнэхээр л аврага байсан, тэгэхдээ бүдүүлэг, бөөгийн ёсны аварга биш харин нялуун биш хатуу, эрүүл саруул ухаан санааны аварга байсан юм. Эсхүл тэнэн хэсүүчилдэг морьтон баатрууд гэгчийг устгах, эс хүл түүнд устгуулах хатуу шийдтэйгээр тэр тулалдаанд орж билээ. Үзэх хүмүүст хангалттай талбай гаргаж өгсөн боловч арван зургааны өдрийн өглөөний есөн цагт тэнд ганц ч сул зай үлдсэнгүй Асар том том индэр барьж туг хиур, гоёмсог даавуу шуувуугаар чимсэн бөгөөд тэд гэрт хараат хаад ван, тэдгээрийн шадар хүмүүс, британы тайж язгууртан нар пиг дүүрэнчихсэн байлаа. их амгийн тэртүүний эгнээнд хаан хатныхаа хамт гялалзаж, хажуу бөөрөөр нь Миссисипи мөрөн, хойд туйлын туяа хоёрын өнгө булаалдах лугаа л зүйрлүүлж болом торгон магнаг хилэн ноломын өнгө солонгорон булаалдуулсан олон хүн жигүүрлэн залрана Өнгө өнгийн цацар майхан хуарагнан бууж үүд бүрт нь нарны туяанд гялбалзах жад бамбай бүхий харуул манаа зогсож, дээр нь туг хиур намилзах нь бас л сүртэй Тэнд нэр сүрээ өчүүхэн төдий боловч бодож өөрийн язгууртаа өчүүхэн төдий боловч бахархаж явдаг морьтон баатар бүгд цугларан ирсэн байгаа нь аргагүй юм. яагаад гэвэл морьто й баатруудын талаар миний юу гэж бодож байдгийг тэд андахгүй байсан болохоор тохиолдсон тэр аятайхан завшааныг үзэлгүй өнгөрөөхийг хэл нь ч хүсээгүй ажээ. Хэрэв би Саграмор ноёныг дийлчих юм. бол намайг л зөвшөөрдөг юм. бол тэр баатар эрс надтай дараа дараагаар ирж үзэлцэх эрхтэй байсан юм. Талбайн надад оногдох талд хоёр цацар байсан нь Нэг нь минийх, нөгөө нь миний зарц нарынх байлаа. товлосон цагт хаан дохио өгөхөд зарлан тунхаглагч нар тулаанд орох хүмүүсийн нэрийг болон тулах болсон учир шалтгааныг зарлан мэдэгдлээ Нэг хэсэг чив чи мээгүй болж дараа нь тулааныг эхлэх бүрэн дуугар лаа хүмүүс амьсгаа даран хүлээх бөгөөд нүүр царайд нь шунаглан сонирхох шинж тэмдэг тодорхой Төмөр цамхаг шиг хөдөлгөөнгүй сүрлэг мундаг том агуу их ноён Саграмор ноён цацраасаа гарч ирлээ хүчирхэг гартаа атгасан лут жад нь ч шув шулуухан хөдөлгөөнгүй ёрдойно асар том мориных нь хоншоор, цээж ган хуягаар хамгаалагдсан бөгөөд их бие нь га зар шүргэм гоёмсог нэмнээгээр бүрхжээ Харахаас сүр жавхлантай гэдэг нь хүмүүс хашгиралдан баяр хүргэлээ Дараа нь

намайг гарч ирэхэд хүмүүс хашгиралдан баяр хүргэсэнгүй Эхлээд хүмүүс тун их гайхсан болол той хачин чимээ аниргүй юу ч гэхээ мэдэхгүй дүгжир чихсэн мэт байснаа гэнэт дуу алдан пардхийн хөхрөлдөж эхлэхэд ингэж болохгүй гэсэн бүрэн дуу тасхийв би биед эвтэйхэн энгийн цэрэг цамц, хүрэн шаргал өнгөтэй трико өмд, хөх торгон богино гоё цувцаа өмссөн юм. Малгай өмсөлгүй толгой нүцгэн байлаа. миний унасан морь биеэр нэг их том биш ч гэсэн хурдан шаламгай, булчин шөрмөс нь пүрш адил уян налархай хурдан гэж тайган нохойн адил билээ. Эмээл хазаараас өөр тээшгүй торгомсог сайхан үстэй ганган сайхан холэг байсан юм. Хэгэртлээ гоёж чимсэн том морин дээрх тэр том цамхаг миний зүг нүсэр байдалтай нүүглэхэд би өөдөөс нь угтан явлаа Тэгээд дор дороо зогсож том цамхаг надад мэхэсхийхэд би хариуд нь мөн мэхэсхийа, Тэгээд бид хоёр ван, ван ахайн хамт залран суух хүндэт суудлын зүг тэдэнд мөргөхөөр зэрэгцэн явлаа Ван ахай

- Эзэн ноён та жад ч үгүй, сэлам ч үгүй, гар хоо сон, юу ч үгүй байлдах юм. гэж дуу алдана гэтэл ван үгий нь тасалж энэ чамд хамаагүй гэдгийг эелдэг байдлаар ойлгуулав Эвэр бүрээ дахин тесхийгээ Бид хоёр хоёр т салан явж тулалдах талбарын хаа зохих зохих өнцөгт очин бэлдэн зогслоо Өвгөн Мерлин гарч ирээд Саграмор ноёнд аал з ны шүлс шиг нимгэхэн бүрхэвч өмсгөхөд Саграмор ноён Гемлет ы н эцгийнх сүүдэртэй төстэй болж харагдах болов. Хаан дохио өгч эвэр бүрээ дахин дуугарахад Саграмор ноён асар том морин жадаа бэлдэн барьж нимгэн н ө мрөгөө хийсгэсээр над руу шууд довтлон айсуй би нэг исгэрээд өөдөөс нь харавсан сум шиг давхихдаа түүнийг олж хараагүй боловч чимээ анираар нь таамаглан яваа царай гаргаж байлаа. хүмүүс миний өрсөлдөгч дайсныг сайшаан хөхүүлэн хашгиралдах бөгөөд бас нэг хүн надад зориулан нөхөрсөг маягаар

- Туранхай Жим минь тэсэж үзнэ шүү гэх сонсдов Кларенс л тэгн хашгнрсан нь гарцаагүй л дээ хэл сэн үгийнх нь байдлаар үзэхэд өөр хэн байх билээ. Аймшигтай жадных нь үзүүр миний цээжнээс бүтэн ха гас алд хэртэй ойртон ирэхэд нь би морио хажуу тийш зайлан бултахад аварга том баатар маань хий жадлан хажуугаар нисэн өнгөрлөө хүмүүс арга нижигнүүлэн ташиж надад баяр хүргэлээ Тийнхүү хоёртээ давхилдан холдсон бид хоёр дахин бие биеийн зүг давхилдлаа Гурав дахь удаагаа ч тэгж давхилдлаа хүмүүс надад баяр хүргэн жигтэйхэн их алга ташин хөгжлдөхөд С а ргэмор ноён тэвчиж чадахыг болин а ргаа өөрчилж намайг хойноос минь хөөх болов. гэвч ямар ч тус болсонгүй, бид хоёр муур хулгана болж тоглож байгаа юм. шиг харагдах болж сүүлдээ би давамгайлах болж бултаж ард нь ороод өөрөөр нь даажин хийх болов. Яг ард нь тулж очоод мөрий нь алгадсан ч удаатай Сүүл сүүлдээ тэр намайг биш харин би түүнийг араас нь хөөгөө чин болж хувирлаа хичнээн чармайн оролдовч тэр миний ард гарч чадахаа больсон юм. Яаж оролдсон ч би ард нь тэр миний урд ороод б а йдаг болсон юм. бүр цөхрөнгөө бараад тулалдааны өөрийнхөө булан руу мань хүн арга буюу зүглэн явсан билээ. уурандаа багтрах дөхөж ухаан санаа нь бүдгэрч намайг элдвээр доромжлох үгээр дайрахад миний тэвчээр алдагдав би эмээлийнхээ бүүрэннээс цалмаа а в ч б а руун гартаа гогцоолдон барилаа Над уруу давхин ирж байсны нь та нар харсан ч болоосой Тэр удаа мань эр тоглоомгүй намайг няхчихья гэж бодсон нь илтг нүд нь цусаар эргэлдсэн байлаа. би морин дээрээ тайван хүлээн зогсож цалмаа толгой дээгүүрээ эргүүлж байлаа. Бид хоёрын хоорондын зай дөчөөдхөн алхмын төдий болж богиносоход миний бие өөдөөс нь гэнэт ухасхийн хөдөлж шидмэсэн зэвсэгнийхээ үзүүрийг агаарт могой мэтээр цагариглуулахад сургуультай морь минь зог тусав Нүд ирмэхийн зуурдгүй бахим гогцоо Саграмор ноёны хүзүүг ороон авч эмээлээс нь ховх татан унагав мөн ч дуулиантай шиг юм. болсон шүү, базар ваа нь Тэр ертөнцөд шинэ юм. бүхэн хамгийн их

алдар цуутай байсан нь маргаангүй Тэндхийн хүмүүс морь уургалах, цаламдах тиймэрхүү зугаа наадмыг огт мэдэхгүй байсан болохоор бүгд суудлаасаа огло харайн босоцгоон сүйд майд болж байлаа. Тал бүрээс

- Бис Бис хэмээн хашгиралдана тийм үг тэд хаанаас сурсан юм. бол гэж би гайхаж байсан боловч морьтон баатруудын үүр тэр аяараа дүнгэнэлдэн шуугилдсан Надад хийх ажил зөндөө байсан болохоор надад хэл бичгийн нарийн ширийн юм. бодох цаг зав үнэндээ гараагүй юм. Саргамор ноёны хүзүүнээс цалам салгаж цацарт нь аваачсаны дараахан би тулалдааны талбар дээр дахин гарч цалмаа телгой дээгүүрээ эргүүлэн зогслоо Саргамор ноёны орыг хэ нээр залгуулах вэ гэдгийг морьтон баатрууд шийдсэн цагт би шинэ тулалдаанд орно гэдгийг мэдэж байлаа. Надтай тулалдах гэсэн амьтан тун олон байсан болохоор оры нь залгах хүн мундахгүй олон байсан хэрэг шүү дээ Эрви де Релөлө ноён оры нь залгахаар шийджээ Пардхийгээд л галд автсан байшин шиг юм. миний зүг цахилан давхих нь тэр би ч бултлаа, тэр ч хүзүүн дээ миний үслэг гогцоонд урхидуулан хажуугаар шуугин өнгөрөөд нүд ирмэхийн зуур морь нь эмээл хоссон болов. хүмүүс дахиад л надад бис бис хэмээн хашгиралдаж дахин дахин нэхэж байлаа. Намайг тав дахий нь явгалаад орхиход миний хуягт дайснууд энэ ер тоглоом шиг юм. биш болж байна. гэж мэдээд зөвлөлг ө өн хийхээр хуран цугларав . Тэд ёс дүрмээ зөрчин миний эс рэг хамгийн алдартай хамгийн хүчирхэг гэснээ л гаргаж тулалдуулахаар шийджээ би эхлээд Ламорак дө Гайис нь , дараа нь Галахд ноёныг эмээлээс нь буулга хад тэдний өчүүхэн ертөнц туйлын ихэд гайхжээ Тэд нарт одоо миний эсрэг хүчирхэгээс хүчирхэг, шилдгээс шилдэг хэмээгдэх Агуу их Ланселот ноёныг л өөрийн нь тавьж Ганц өмнөө барьдаг хэзээний ө мөг түшгээрээ намайг бут цохихыг оролдох ганцхан арга үлдсэн байв. Намайг бахархмаар байсан гэж бодож байна. уу ? Тэгэхээр барах уу даа Бритами хаан Артур, Гиневра, хо шуунутгийн жижиг жимбэрүү хаад ноёд, олон орны алдар цуутан морьто баатар эрс цацар майхан лиг дүүрэн, тэдний дотор Дугуй Ширээний баатар нар, христосын ёртөнцийн хамгийн алдар суутай хүмүүсийн нүүрэн дээр дийлж давамгайлж байлаа. шүү дээ Тэр гайхамшигт олон баатруудынх нь наран саран болсон хамгийн охь манлай нь дөрвөн түмэн нүдний бишрэн бахдан харах тусгайд миний зүг урт жадаа онилон уу галан дайрлаа, Ойртон ирэхий нь хүлээн давхийх ч үгүй зогсов миний санаанд Хардфордын зүүн хэсгийн холбоочин жижигхэн эмэгтэйн ачит дүр зурсхийн орж ирээд яг тэр минутанд намайг харсан бол ямар догь вэ гэж бодогдлоо Ялагдашгүй баатар намайг догшин шуурга мэт дайрлаа Үзэгч олон бүгд суудлаасаа огло харайн босож байна. . Авзаатай гогцоо агаарт гялсхийж алимад олны анивчихийн ч зуургүй хугацаа өнгөрөхөд миний бие гэдрэгээ харж унасан Ланселот ноёныг чиргүүл тэргээр татах адил араасаа гулдарч нижгэнэн алга таших нусныхаа алчуураар даллах үй олонд хий үнсэн талархаж явав бүрмөсөн яллаа Одоо хэн ч миний эсрэг тулалдахыг зүрхлэхгүй Хэрэн тэнүүчлэгч морьтон баатрууд сөнөх нь энэ гэж би алдар гавьяандаа мансууран сэтгэж цалмаа эвхэн эмээлийнхээ бүүргэнд өлгөлөө бас нэг хүн надтай тулалдах юм. гэсэн мэдээг эвэр бүрээ зарлахад би, би ганцаараа ч биш тун их гайхаж билээ. . Ухаанд багтамгүй хэрэг байсан юм. гэвч би Мерлин м ини й дэргэдүүр ирээд хулгай маягаар дайжин зайлахы нь ажаад миний цалам алга болохыг мэдсэн юм. Хөгшин чоно ми ни й цалмыг хул га йлан а в ч хувцсандаа нуусан нь гарцаагүй Эвэр бүрээ хоёр дахь удаагаа тасхийгээ . Ноён Саграмор морин дээр залран миний зүг айсууг би олж харлаа, Шороо тоосы нь гөвж, бас нимгэхэн гивлүүрээр бүрхэж өгсөн байв. Би дэргэд нь зөвхөн түүний явах чимээнээр таамаглан очиж буй царайлав мань хүн

- чиний чих тун соргог юм. гэсэн ч чи энүүнээс мултрах хөг чинь өнгөрсөн дөө гэж

мундаг том юлднийхээ ишийг надад х а р уу л ж байна. Шидэт бүрхүүлийн цаана байгаа болохоор чи юу бол о хы нь мэдэхгүй байгаа гэвч энэ бол өнөөх урт эв хавгүй жад биш юлд байгаа юм. чи энүүнээс мултрахгүй гэв Нүүрнийхээ халхавчийг сөхөж үхлийн муу ёрын инээмсэглэл үзүүлнэ Үнэхээр түүний юлднээс зайлах арга алга Одоо бид хоёрын аль нэг нь заавал үхэж таарах байлаа. Түүний илдний ир миний биед дөнгөж хүрч гэмээн таалийгаачийн нэрийг дуулгахад зовлонгүй байв. Бид хоёр хамт явж очоод хаан, хатан хоёрт баяр хүргэв Ван баахан балмагдаж

- Өнөөх хачин зэвсэг чинь хаана бейна? гэж асуув

- Эзэнтэн минь хулгайд алдчихжээ

- Дахиад байхгүй юу ?

- Байхгүй шүү, эзэнтэн минь , би ганцыг л авч гарсан юм. Мерлин хөндлөнгөөс

- Өөр байх ч үгүй юм. чинь , ганцыг л авсан байна шүү дээ Өөр байх ч үгүй Тэр ганц нь чөтгөрийн тэнгэсийн хааны юм. байхгүй юу Энэ хүн бол хууран мэхлэгч, юу ч мэддэггүй хүн Хэрэв энэ хүн юм. мэддэг байсан бол энээзэвсгийг найм удаа хэрэглэсний дараа тэнгэсийн ёроолд орж алга болно. гэдгийг мэдэх ёстой байсан гэв

- Тэгвэл энэ хүн чинь зэвсэггүй болж шүү дээ, Саграмор ноён та энэ хүндээ юлд хэрэглэхийг з ө вшөөрөх юм. байгаа биз дээ гэж хаан хэлэхэд Ланселот ноён ө ндөсхийн

- би өөрийнхийгөө хэрэглүүлье Энэ хүн бол амьд байгаа бүх хөлөг баатрын дотроос хамгийн гарамга й нь юм. тэгэхлээр миний юлдийг хэрэглэг гэлээ. Тэгээд юлдээ хуйнаас нь сугалахыг завдтал Саграмор ноён

- Тэгж болохгүй Энэ хүн өөрийнх ө ө л шилж сонгож а всан зэвсгээрээ тулалдах ёстой Өөрөө зэвсгээ сонгож авах эрхтэй байсан, тэр эрхээ л эдлэг эндүүрсэ н б о п эндүүрлийнхээ балгийг хар толгойгоороо л хариуцаг гэж сүвээрхэв

- Хөлөг баатар чи сохор мэт а ашилж байна. чи өшөөгөө авах гэхдээ ухаан санаа чинь балартжээ чи зэвсэггүй хүнийг алахад хүрээ юу ? гэж ван хашгирлаа

- Тэгж зүрхэлж гэм миний өмнө яахыгаахариуцзг гэж Ланселот ноён хашгирав

- би хэн хүссэн хүний өмнө хариуцахад бэлэн байна. гэж Саграмор ноён ууртайгаар хашгирлаа Мерлин хамгийн бузар үмхий санаатай, бах т а в нь ханасан байдалтайгаар инээмсэглэн хөндлөнгөөс орж

- мөн зөв сайхан үг хэлж байна. даа Олон таван үг ярих хэрэг алга, эрхэм хаантан одоо дохиогоо л өгвөл таарна гэлээ., Ван арга буюу найр, тавихад хүрчээ Эвэр бүрээ дуугарахад бид хоёр тал тал руу гаа зай авахаар салан одов Бие биеэс зуун алхмын зайтай газраас биеийг ширтэн морьтой хөшөөшиг огт хөдөлгөөнгүй зогслоо Нам гү м болж минут хэртэй хугацаа өнгөрөх н ь эцэс төгсгөлгүй удах мэт санагдана Хэн нь ч нүд салгалгүй ширтэх агаад огт үл хөдлөө Ван дохио өгч тулалдуулах зүрх хүрэхгүй удаагаад байх шиг байлаа. Тэгж тэгж гар өргөн дохиход бүрээ ч тасхийгээ Саграмор ноёны урт юлд агаарт гялсхийн дугуйлдаж, тэр сүртэй баатар эр миний зүг уулгалан айсуй би байрнаасаа хөдөлсөнгүй Тэр ойртсоор би хөдлөхгүй л зогслоо Үзэгч олны сэтгэл түгшиж надад

- Зугт, зугт амиа авар Алууллаа гэж хашгиралдаж байв. Би тэр хуй салхи шиг хурдлан айсуу этгээдийг арван таван метр хэртэй ойрттол нь байрнаасаа ямхын төдий ч хөдөлсөнгүй, тэгээд л гар буугаа хуйнаас нь сугалан авч манасхийлгэмцээ чухам юу гээч болсныг хэн ч ухааран ажиг амжил өгөлгүй буугаа хуйнд нь хийчихлээ Хөлөг баатрын морь нь миний хажуугаар нисэх мэт цахилан өнгөрөхөд дээрх эзэн Саграмор ноён хөсөр үхтхийн унаад чулуу шиг хөдөлгөөнгүй хэвтэнэ Түүн рүү гүйлдэн очсон хүмүүс үхсэний нь үзээд хэлэх үгүй хэл нь хөшиж мэлрэх бөгөөд бие цогцост нь ажиглагдах аливаа том шарх үзэгдэхгүй учраас ямар ч шалтгаангүйгээр үхчихсэн байна. гэж бодоцгоов бололтой Гархин хуягных нь цаана цээжинд нь сум нэвтэрсэн жижигхэн шарх байлгүй яах вэ, гэвч тэд тийм юмыг үхлийн шарх гэж бодохгүй байв. галт зэвсгийн шархаар цус гарах нь бага байдаг болохоор жаахан гарсан цус нь доогуур нь орж хуяг дуулгы нь нэвглэж чадсангүй би тэднийг тулалдаанд уриалсан уриаг зэсэн дээр сийлүүлэн олшруулж энд тэндгүй тарааж ард түиэнд уншиж өгөх ганц ламтай газар лууч явуулж байсан, сонин зарлалын хуудаснууд дээр зогсоо зайгүй хэвлүүлж байлаа. би уриалан дуудахыгаа сэргээснээр үл барам ерг өтгөсөн юм. Өдрөө н товлоод орхи тэгвэл миний бие тавин туслагчийн хамт гарч ертөнцийн бүх хөлөг баатрыг устгана гэж зарлаж байлаа. Тэр бол айлган сүрдүүлэх гэсэн хэрэг биш, би хэлснээ хэрэг дээр нь биелүүлье гэж бодож байсан юм. хэлсэн амандаа хүрч чадах байсан юм шүү миний уриалан дуудсаны утга учир тодорхой байсан болохоор түүнийг ойлгохгүй хүн гэж байхгүй байв. Адгийн тэнэг хөлөг баатар ч гэсэн бууж өгөхөөс өөр аргагүй гэдгийг ойлгосон юм. Тэгээд ч бүгдээрээ бууж өгөх нь тэр Гурван жилийн дотор тэд миний сэтгэл санааг зовоохуйц юм. хийсэн гэж санах зүйл алга Гурван жилийн хугацаа өнгөрлөө гэж сана Тэгээд тэр хооронд Англи орон хичнээн их өөр болсон гэж санана Аз жаргалтай, цэцэглэн мандсан, гайхмаар их хувирсан орон болсон юм. энд тэндгүй бага, дунд сургууль, хэдэн сайн сонин гардаг болсон Зохиолч нар ч бий болсон Тэдний дотроос арван гурван зууны турш миний мэдэх хуучны уран цэлмэг үгтэй боть зохиол гаргасан Алиа дайнэдэн ноён хамгийн гарамгай нь байсан Хэрэв тэр хүн ботиноосоо номлогчийн тухай хуучны бузар шог зүйлийг ч гэсэн хассан бол би зүгээр л байх байсан гэвч би тэр шогий нь тэвчээрлэж хэрхэвч чадаагүй, тэгээд номы нь устгаж, зохиогчий нь дүүжлүүлсэн Боолын ёсыг устгасан хүн бүхнийг хуулийн өмнө адилхан эрхтэй болгосон Гарал язгуур харгалзалгүй бүх хүнээс татвар авах болгосон Цахилгаан, утсан харилцаа, гэрэл зураг, бичгийн машин, оёдлын машин, уурын хүч, эрчим хүчийг ахуй амьдралд аажмаар нэвтрүүлж байлаа. Темз мөрнөөр хоёр гурван галт онгоц хөвөх болсон Хэд хэд э н дайны онгоцтой болж, худалдааны анхны галт онгоц бий болсон би Америк тив нээх экспедиц явуулах санаатай байлаа. би хэд хэдэн төмөр зам тавьж байсан бөгөөд К а мелот Лондонг холбосон төмөр зам гүйцээд ашиглалтад орсон байсан юм. Төмөр замын хөдөлгөөний үйлчилгээний бүх ажлыг ер бишийн хүндтэй эрхэм чухал ажил гэж үзэх болгох тийм ухаан надад байв. Би тийм ажилд морьтон баатар, тайж нарыг татан оруулж, тэднийг албаар ажиллуулж, тийнхүү ажил төрөлгүй дэмий хэрж тэнүүчлэх дэмийрэн эрх танхи явах яадлаас ангижруулах төлөвлөгөөтэй байсан юм. Төлөвлөгөө маань тун амжилттай болж тэр алба ажилд орох гэж өрсөлдөцгөөдөг боловч цаг 33 минутад явдаг буухиа галт тэрэгний кондуктороор нэг бэйс ажиллаж байв. Гүнгээс доош хэргэмтэй кондуктор гэж ганц ч байгаагүй Тэд сүрхий сайн ажилладаг хүмүүс байсан а н боловч хоёр сүрхий дутагдалтай байсан, тэрий нь би тоохгүй өнгөрдөг байсан юу гэвэл хуяг дуулгаа тайлдагүй, замын хөлснөөс завшдаг, өөрөөр хэлбэл төмөр замын компаний хөрөнгө хулгайлдаг байсан юм. Ашиг тустай ажилд ороогүй ганц ч морьтон баатар гэж тус оронд байхгүй болсон Тэд одоо ч гэсэн улс орны өнцөг булан бүрээр хэсдэг хүмүүс байсан боловч

эрдэм мэдлэг тараах болсон тэд угаас тэнэж хэсүүчлэх хорхойтой улс байсан болохоор иргэншил соёлыг түгээхдээ шилдэг хүмүүс болсон Тэд урьдын адил юлд жад, алмасан сүх, хуягтайгаа явдаг байсан болохоор оёдлын машин буюу хөгжмийн хайрцаг хэрэглэх, аль эсхүл төмөр утсан тор, эсвэл архи үл хэрэглэгчдийн нийгэмлэгийн сэтгүүл захихгүй зөрөх, тиймэрхүү хүн гарвал дор нь учры нь олчихоод л цааш явдаг байсан юм. би тун их баяр баясгалантай байлаа. миний дээр үеэс хүсэж мөрөөдөж байсан, нууцаар төлөвлөсөн ажлууд маань аажмаар хэрэгжин биежиж байв. тиймэрхүү төлөвлөгөө надад хоёр байсан бөгөөд тэр хоёр бол бусад бүх төлөвлөсөн ажлын дотроос хамгийн томхон нь байлаа. Нэг нь бол католик сүм хийдийг устгаж, оронд нь протестант шашин бий болгох, тэгэхдээ тө рийн биш хүмүүсийн хүслээрээ л шүтэх тийм шашин байлгах бодолтой байсан Нөгөө нэг нь Артур хааныг үхсэнээс хойш бүх эрэгтэй, эмэгтэй хүмүүст буюу ядахнаа бүх цэцэн тэнэг эрэгтэйчүүд, хорин нэгтэй хүүгээсээ илүү уха а н суусан болон, дунд зэргийн на с ны бүх хүмүүст сонгуулийн Ний ти йн эрх олгож, эдлүүлэх тийм хууль батлаж гаргах явдал байсан юм. Артур надтай чацуу буюу дөчтэй байсан болохоор бас гучин жил амьд я в ж мэдэх байсан Тэгэхлээр тэр хооронд миний бие дэлхийн түүхэнд анх удаа үйлдэх үйл хэрэг болох эрс шийдвэртэй боловч цус үл урсгах хувьсгалын хэрэгт хүн амын хамгийн идэвхтэй хэсгийг ядаж цөхөлгүй бэлтгэж дөнгөнө гэж бодож байлаа., Тэгээд Бүгд Найрамдах төртэй болох ёстой байсан би анхных нь ерөн хийлөгч болох тийм биеэ голохгүй хүсэл төрсөндөө ичгүүртэй боловч үнэнээ хэлэхээс биш Нэгэнт л хүн юм. болохоор хүний хийдгийг хийхээс яая гэх вэ, би өөрөө ойлгож байсан юмаа Кларенс хувьсга л хийхийг бас хүсэн мөрөөдөж байсан Тэгэхдээ арай өөр маягаар боддог байсан Эрх ямбат анги давхаргагүй боловч төрийн тэргүүнд сонгуулийн биш харин үе залгамжлах г эр бүл бүхий тийм Бүгд Найрамдах төр байгуулах бодолтой байв. Хаанчлах г эр бүлийн сайхныг үзэж хүндэлж сурсан ард түмнийг тийм юм.наас нь салгавал тэд доройтон буурч уйдаж үхнэ, тэгэхлээр тийм юм.ы нь салгаад яах вэ гэж бодно би бол хаадыг аюултай хүмүүс гэж үздэг байв. мань хүн Тэгвэл хааны ширээнд муурыг залах хэрэгтэй гэдэг байлаа. Муур мийгээр хааны удам угсааг хийвэл яг таарна гэж тэр залуу боддог байлаа л даа Тэдгээрийн ашиг тус нь бусад хаадын удам угсаанаас дутахгүй, мэдэх чадах нь ч мөн тэр дайтай, сайн муутал нь ч мөн тэр дайтай, айл хөрш хаанчлах муур мий нүүдтэйгээ мөн тэр дамтай хэрэлдэж муудалцах дур хүсэлтэй нэр хичээхдээ бас л адил инээдэм хүрэм байхыгн дээр тэдгээрийн идэж зуурамдахг эдэлж хэрэглэх нь гавихгүй бага байх болно. гэж бодно М я уу V, М я уу X, М яууХын бурханлаг өршөөлөөр гэж байхад ч хандгайн өмдтэй хаан ширээнд зал а рсан бусад ямар ч муурнаас юун дордох билээ. л

- Муур мий бол хаадаас ёс суртхууны талаар ихээхэн дээгүүр учраас хаанаа дууриах заншилтай ард түмэнд хамгийн сайн нөлөө үзүүлж чадна Ард олон нь чухам хэн байсан ч хааны хэргэм гуншинг хүндэтгэж заншсан байдаг болохоор хорлонт биш тэр гоёмсог МУУР мийг ялангуяа тэдгээр нь хэнийг ч дүүжилж алахгүй, толгойгий нь авахгүй, хэ ний г ч шорон гянданд хийхгүй аливаа харг и с догшин шудлрга бус юм. үйлдэхгүй байхыг нь мөдхөн мэдэх тул бүр ч ихэд хүндэтгэх болно. Тэгээд тийм хааныг ямар ч хаанаас илүү хүндэлж илүү хайртай байх болно. хотол е ртөнц даяа ра манай хүнлэг энэрэнгүй, нарийн журам горимыг шагшиж хааны яргачингууд энд тэндгүй алга болно. Онгойсон орон тоог нь манай хааны удам угсааны зулз гууд эзлэх болно. Манайх дэлхий дахины хааны ширээг хангаж байх муур үржүүлэх газартай болно. Дөчин жилийн дараа манайх хангаснаар Европ дахин муурын захиргаатай болох юм. Эцэс төгсгөлгүй нийтийн энх тай в ан буй болж М яууу м яууу гр р м

яугэсэн юм. болно. гэж орчин үеийн цэвэр англи хэлээ р хэлэв би түүнийг үнэнээсээ тэгж ярьж байна. гэж итгээд зарим талаар итгэж эхэлж байтал гэнэт муур шиг дуугараад эхлэх нь тэр би айж ухаан гарчих дөхлөө гэвч Кларенс тийм сүрхий байдалтай байгаад байж чаддаг хүн биш, тийм байна. гэж яадгийг ч мэддэггүй хүн юм. Үндсэн хууль бүхий хаант засгийн нэлээд сайн тесөл боловсруулж байсан боловч түүнийгээ зохих ёсоор үнэлэх чадалгүй даанч хөнгөн хийсвэр хүн бала й юм. Б и түүнийг загная гэж бодтол гэнэт Сэнди учиргүй их айчихсан гүйж орж ирлээ у йлж цорхироод хэлэх үг нь мэдэгдэж өгөхгүй байв. Би түүнийг тэвэрч сэтгэлий нь тайвшруулах санаатай өхөөрдөн

- юу болоо вэ? Хайрт минь , яриач дээ гэж асуув толгойгоо миний цээжинд нааж дөнгөж дуулдахаар

- Тө в холбоочин гэлээ.

- Бушуулаарай Утсаар хааны эмчийг дуудуул гэж би Кларенст хэлэв . Минут хэртэйн хойно миний бие өлгий т эй хүүхдийн өмнө сөхрөн суусан бөгөөд Сэнди бүхий л ордон даяар зарц шивэгчин гүйлдүүлэв . Амьсгаа нь багтарч байна. гэж би шууд мэдээд чихэнд нь бөхийж

- хүү минь сэргэж үз Тө в холбоочин гэж шивнэхэд талимаа нүдээ аажим нээж арай чарай

- А ав гэлээ. Тэгэхэд нь дотор онгойлоо Үхэж байгаа хэрэг биш байсан байх нь ээ хүүхрийн уусмалд хүн явуулаад өөрөө нэг утлага бэлдэв я агаад гэвэл Сэнди юм. уу хүүхдийг өвдөхөд нь эмч хүлээгээд дэмий суухгүй болсон юм. би тэднийгээ бөөцийлэх сүрхий туршлагатай болсон билээ. би охиноо голцуу өргөж өсгөсөн, эвий нь олж саатуулдаг, эх нь яах учраа ч олохгүй байхад нь сормуусных нь нулимсыг хатааж чаддаг байсан юм. Яг тэр үеэр Ланселот ноён баяр ёслолоор өмсдөг хуяг дуулгатайгаа тө в өргөөгөөр дамжин худалдааны танхим руу явав Тэр бол худалдааны танхимын дарга байсан юм. Тэр албан тушаалыг Галахад ноёноос худалдаж авсан байх юм. яагаад гэхэд худалдааны танхим нь Дугуй Ширээний морьтон баатруудаас бүрдэж байсан бөгөөд Дугуй Ширээ нь ажил хэргийн хурал хуйд үйлчилдэг байсан юм. Дугуй Ширээнд суух а д хүн үнэмшмээргүй их үнэтэй байсан болохоор нэгэнт хүн үнэмшихгүй тоог хэлээд ч яах билээ. Ланселот ноён биржчин байсан ба шинэ төмөр замын хувь нийлүүлсэн тэмдэгтийн зарим хэсгийг эзэгнэж байсан, тэгээд ч яг тэр өдөр жаахан бууруулж тоглох санаатай байж Тэгээд юу болох байв.? Хуучин Ланселот Ланселот хэвээр л үлдэх байсан Нээлттэй хаалгаар санаандгүй хартал хамгийн хайртай эмэгтэй нь өвчтэй байгааг хараад хамаг бүхнээ мартаж нь тэр Бууруулах тоглоом болох нь уу өгсүүлэх тоглоом болох нь уу , түүнд огт падгүй болж, бүх ам ъж иргаа алдаж байсан ч жижигхэн Тө в холбоочинтойгоо л үлдэх байлаа. Тэгээд ч үлдсэн шүү Дуулгаа авч булан руу шидчихээд минут хэртэй болоход ариутга л д ус буцалгаж байлаа. Тэр хооронд нь Сэнди өлгийн дээгүүр нь бүтээлэг ээхсэн болохоор багтраа гаргах юм. хийхэд бэлэн болов. Ланселот ноён уур савсуулахад бид тэр саванд нь түүхий шохой, нүүрс хүчил, сүүний хүчил нэмж, тийнхүү эм н элгийн уур хий нь хоолойгоор дамжин х ө нжлийн доогуур орж өлгийд нь орж эхэлсэн юм. Тэр бид хоёр өлгийн нь хоёр хажууд манааны цэрэг шиг л зогсож байлаа. Сэндийн сэтгэл амарч бид хоёрт талархсанаа илэрхийлэн бургасны нухсан хальс ороосон том гом гэгчийн янжуур өгч татахыг зөвшөөрөхд өө хүүхдийн ө лгийд утаа нь нэвтэрдэггүй юм. би тамхи татдаг хүнийг улсынхаа эмэгтэйчүүдийн дотроос хамгийн анх удаа үзсэн хүн болохоор тамхи татаж байгаа хүнийг харахад сайхан байдаг юм. гэсэн билээ. Ланселот ноёныг

эрхэмлэг хуяг дуулгаа өмсчихөөд ө лгий т эй хүүхдийн дэргэд сууж байхыг нь харахад үнэхээр сэтгэл уярлаар байлаа. Сайхан ч эр, бодь сэтгэлтэй ч хүн, эхнэр хү ү хэд хоёроо аз жаргалтай явуулж чадах хүн гэвч Гиневра ер нь тэгээд нэгэнт тус болж болохгүй юмны төлөө гашуудах хэрэг бий юу даа би түүний хамт аюул өнгөртөл гурван өдөр гурван шөнө жижүүрлэсэн Тэгээд нялх хүүхдээ үнсэхэд дуу л га н ых нь өд сөд хүүхдийн алтан толгой дээрээс ө н гийж билээ. Өлгийтэй хүүхдээ Сэндид хянуур гэгч нь өгөөд сэтгэл хөдлөн зогсох хоёр эгнээ цэрэг зарц нарын дундуур төө өргөө рүү явлаа Түүнийг би түүнээс хойш дахин үзэх учиргүй байсныг надад хэн ч хэлээгүй билээ. Энэ хорвоод амьд явахад юу гээч хэцүү вэ, бурхан минь Эмч нар хэлэхдээ эмэгтэйн э рүүл мэнд, тэнхээ тамиры сэргээе гэвэл тэнгэс далайн эрэг хавь газраар очих хэрэгтэй гэв, Тэгээд бид далайн хөлөг авч хоёр зуун тавин зарц,гоцго, бараа бологчидтойгоо явах нь тэр, хоёр долоо хоногийн хойно б и д францын эрэг хүрч очиход эмч нар энд буух нь зүйтэй гэлээ. Тэр газрын бага хаан нь биднийг найрсгаар хүлээн авсан тул бид тэр хишгий нь хүртсэн юм. Түүний орон байр тохь тух барагтай байсан боловч би хөлөг онгоцноосоо зарим юм. авчирч түүний эв хавгүй муу хуучин шилтгээнд төвхнөн суусан юм. Сарын сүүлээр хөлгөө буцааж хүнсний зүйл болон сүүлийн үеийн мэдээ зэдээ авчир гэв Гурав дөрөө хоногийн дараа эргэж ирэх ёстой байсан захиж явуулсан мэдээ зэдээний дотор сүүлийн үед өөрийнхөө хийж байсан нэг туршилтыг юу болоо бол гэж сонирхож байв. миний тэр төлөвлөж байсан зүйл маань юу байсан гэвэл морьтон баатруудын тулалдааныг өөр юм.аар сольж тэднийг хавь ойрынхондоо гэм хоргүй өөр юм. эрхэлдэг болгож тэдний аагандаа багтахгүй байгаа их илүү хүч тэнхээг зөв а шиглах, мөн түүнчлэн тэдэнд буй сайн сайхан юм.ы нь , өрсөлдөн урал дд аг сайн чанары нь дэмжих тийм санаа байсан юм. би нэг хэсгий нь тог лоомд сэм дасгалжуулан сургах ажил зохиогоод байсан болохоор тэднийг нийтийн өмнө гаргаж өрсөлдүүлэн уралдуулж хүч чадлы нь сорих өдөр ойртож байсан юм. миний тэр туршлага маань бэйсбол тоглох сургууль байлаа. Тэр тоглоомыг шууд нийтийн чанартай болгож өө сэвгүй сайн юм. болгохын тулд миний бие эхлээд хорин тоглогчийг шилж авахдаа чадал чансаагаар нь биш зэрэг дэвээр нь авсан билээ. тоглоомд оролцох морьтон баатрын хэн нь ч өөртөө эзэмшүүнтэй байсан тиймэрхүү этгээд Артур хааны харьяанд зөндөө байсан юм. чинь Ёстой л шувуун толгой багтах зайгүй гэгчээр энд тэндгүй тийм ноёд байса юм. чинь Харин тэр баатрууд усанд орохдоо хүртэл хуяг дуулгатайгаа байдаг байсан болохоор тэрний нь тайлуулна гэдэг гонжийнжаа байв. Харин нэг багий нь нөгөөгөөс нь ялгахын эрхээр тэднийг өмсгөлийнхөө өнгө з ү сийг жаахан өөрчлөх хэрэгтэй байна. гэснийг нь зөвшөөрсөн нь дээдийн заяа болсон юм. Тэгээд нэг баг нь ноосон цамц маягийн гарх и н хуягтай, нөгөө нь миний шинээр гаргуулсан Бессемер гангаар хийсэн хуяг өмсөх болсон юм. тоглоомын талбай дээр тэдний бэлтгэл хийж тоглохыг харахад үнэхээр ухаанд багтамгүй санагддагсан Бөмбөгнөөс зайлж зугадна гэж байхгүй Бөмбөг нь бессемер ган хуягт нь тусаад зуун тавин алхам хэртэй ойж байх шүү дээ тоглогч гүйдэл дундаа ойчоод бөмбөгнийхөө хойноос гэдсээрээ гулсан явах хуягт тэрэг портонд орж байгаа мэт санагдана Шүүгчээр нь эхлээд тайж язгууртгүй хүн тавьж байсан боловч сүүлдээ болихоос аргагүй болсон миний бэйсболын багийн аргыг олно гэдэг өөр ямар ч тийм багт ажиллахаас хамаагүй хэцүү байв. Шүүгчийн анхны шийдвэр сүүлчийн болж төгсөх явдал ердийн хэрэг болж байлаа. Шүүгчээ хэзээний огтчин тасчиж нөхөд нь дамнуургаар аваад явдаг болсон билээ. Нэг шүүгч нэг тоглоом өнгөрүүлэх насгүй болоод байхлаар сүүлдээ шүүгчийн ажил нэр муутай болов. Тэгэхлээр нь улс гүрний дотор хамгийн дээгүүр хэргэм зэрэгтэй, алба тушаалтайгаараа хамгаалагч болж чадахуйц тийм хүмүүсийг шүүгчээр томилохоос өөр домгүй болсон билээ. Багуудын бүрэлдхүүнийг харуулья

*Б е сем е рийн баг Цамцтаны баг Артур ван
Цамцтаны баг Артур ван Эзэн х а ан Люций
Лот Лотиа н ы ван Логр и с ван
хойд Га л лийн в ан Маргольт Ирландын в ан
Марсил в ан Морганор в ан
Бага Британы в ан Майс Корнаалийн в ан
Лабор в а н Мөлиодас Лионы в ан
Пөллам Лист е нжийн в ан Нонтр Гарлотын в ан
Багдемагус в ан Нууры н в ан
толлем ля Ф э нт в ан Сирийн Султан
Ш үү гч Кларанс*

нийтийн өмнө болох анхны тэмцээнд миний багцаалж байснаар таван түмэн хүн ирэх байв. тийм зугаатай юм. үзэхийн тулд дэлхийн нэг ө нцгөөс нөгөөг нь хүртэл явсан ч яах вэ Хаврын цаг, газар дэлхий шинэ нөмрөгөө хэдэрч, дулаан сайхан байсан болохоор юм. юм. аятай т а атай байсан

Д ө чин нэгдү гээ р б үлэг

ХӨӨСӨН НЬ

Г эвч охины маань бие гэнэт с үрхий өвдсөн учир бид хоёр тэрнийхээ дэргэдээс холдож чадалгүй уг тэмцээнийг анхаарч ч чадаагүй юм. өөр хүнээр сувилуулах хэрэггүй гэж бодоод Сэнди бид хоёр өдөр шөнөгүй ээлжлэн харлаа Сэнди ямар шүү сайхан сэтгэлтэй, хичнээн эгэл, хичнээн чин зүрхний сайн хүн байсан гэж санана хэлэх өөгүй эхнэр, эх хүн байсан юм. Морьто н баа т руудын дүрэм ёсоор надаас тулалдааны талбар дээр хэн нэг нь булааж авч чадаагүй цагт миний өмч байсан болохоор Сэндитэй би суусан хэрэг шүү дээ Намайг гэж тэр маань бүх Британ даяар явж Лондоны цаазын индэр дээр намайг олоод надаас мах цусаар салшгүй холбоотой мэтээр миний дэргэд ирж зогссон билээ. би өөрөө . Шинэ Английн хүн тэгэхлээр миний бодлоор бол тийнхүү салж чадахгүй байсаар сүүл сүүлдээ түүнийхээ нэрийг бузарлах хэрэг болжээ. гэж ойлгосон юм. Сэ н ди тэгж ойлгохгүй байсан боловч би аливаа маргааныг зогсоох гэж гэрлэхээр шийдэж билээ. Тэр цагт би эрдэнэтэй боллоо гэж мэдээгүй гэтэл тэр маань ёстой л эрдэнэ байжээ. Нэг жил өнгөрөхөд би түүнийгээ бүр бишрэн шүтдэг болсон Тэр маань хамгийн дот н о, хамгийн хайрт нөхөр болсон билээ. Нэг хүйсний хүмүүсийн сайн сайхан нөхөрлөлийн тухай яриа байдаг гэтэл нэг эрмэл з эл, нэг дээд үзэл санаагаар амьдардаг эр, эм хоёрын нөхөрлөлийг бодохноо тийм нөхөрлөл дэмий л гавих зүйл биш ажээ. тийм нөхөрлөл бол энэ хорвоогийн л нөхөрлөл, харин эр эмийн жинхэнэ нөх ө рлөл бол тэнгэр бурхны чанар бүхий зүйл юм. . Анхандаа миний бие зүүд нойрондоо ар в ан гурван зууны тэртээг боддог байсан болохоор ханамжгүй сэтгэл маань хариулж үл чадан нэгэнт үгүй болсон ертөнц рүү дэмий л тэмүүлдэг байв. Шөнө нойрон дундаа үглэх миний тиймэрхүү үгийг Сэнди олон удаа с о н с чээ Сэнди угаас агуу уужим

сэтгэлтэй хүн байсан болохоор тэр үг нь урьдын цагт миний хайр сэтгэлтэй байсан эмэгтэйн нэр юм. бол уу даа г эж бодоод анхныхаа хүүхдэд миний үглэдэг үгээр нэр өгсөн билээ. Тэгж хэлэхэд нь баярлаж нулимс гаргах дөхөж, харин намайг баярлуулсандаа миний нүд үрүү чанх эгц инээмсэглэн харсаар

- Чамд хайртай байсан тэр хүн чинь бидэнд мартагдалгүй нандин үлдэж бидний чихнээ хөгжим мэт дуулдаж байх болно. чи одоо нэгэнт охиноо ямар нэртэй болсныг мэдлээ Намайг үнс гэж огт санаандгүй байтал хэлэхэд нь арай л газар савж унаагүй билээ. Харин би таагаагүй юм. би тааварлаж яавч чадахгүй байсан гэхдээ тэрнийхээ сэтгэлийг бодохлоор би яаж ч таахгүй юм байна. гэж хэлэх билээ. тэгээд үнэнээ мэдэгдэж орхихгүйн тулд

- Хайрт минь , би мэдэлгүй яах вэ Яи их сайхан сэтгэлтэй хүн шүү Харин тэрнэрээ чи өөрийнхөө амаар хэл л дээ Эхлээд чамаар хэлүүлэх юмсан гэж би хүсэж байна. Тэгвэл миний чихэнд хөгжим шиг сонсдоно гэлээ. Энэ үгэнд минь баярлаж хөөрөөд

- Төвийн холбоочин гэх нь тэр би арай л инээд алдчихсангүй Инээд алдчихсангүй дээ бурхандаа залбирдаг юм. Гэхдээ би инээд алдахгүй гэж тун их хичээж хүч гаргасан болохоор хэдэн долоо хоногийн турш яс мах хангинаад байж билээ. Сэнди тэгж андуу бодож байснаа хэзээ ч ойлгоогүй юм. Нэг удаа у т саар ярихад тийм үг дуулдахад Сэнди гайхсанаа уурлаж билээ. гэвч би утасны хүүхнүүд миний даалгаснаар ажилладаг юм. гэж хэлсэн Тэгээд миний алдагдсан бүсгүй найзын тэр хөөрхөн нэр, түүний амидай өчүүхэн хүн хоёрын нэр нь тэр цагаас хойш утсаар ярихад баяр мэндийн үг болж билээ. Энэ нь үнэн биш боловч чухам хэрэгэй зүйл байсан юм. Бид хоёр хүүхдээ сахиад дэргэдээс нь хоёр хагас долоо хоног болсон болохоор хорвоод юу болж буйг мэдэхээ больсон Тэгж тэгж уйгагүй сувилсных охин маань эдгэрч баярлаж талархсан гэвэл багадаа, ер юу ч гэж хэлэхийн аргагүй их баярлаж байлаа. Сүүдрийн хөндийгөөр хүүхдээ дагаж яваад түүнийгээ амьд мэнд байж хамгийг гийгүүлэн баясган инээмсэглэхий нь үзсэн хүн бүр ямар байдгийг андахгүй дээ Бид энэ хорвоодоо дахин эгэж ирэх нь тэр Бие биенийхээ нүдийг ширтэн харж байтлаа гэнэт х ө лөг онгоц яваад хоёр долоо хоног гаруй болсон атлаа эргэж и рээгүй байдаг хачин юмаа гэсэн нэгэн адил бодолд автан гайхаж билээ. би зарц гоцго нараа дуудуулав . Тэд сэтгэл түгшин шаналаад удсан нь нүүр царайнаас нь тодхон байна.м Хэдэн хүний хамт таван бээр газар давхиж уулын орой дээр гарч тэнгисийн алсын барааг харлаа Саяхан хүртэл тэр тэнгисийг цагаа н далиараа чимж байсан худалдааны х ө лгүүд минь хаа байна. Дарвуул ч харагдахгүй, уур утаа ч үзэгдэхгүй, хаашаа л харвал хов хоосон, өнөөх их хөлтэй, бараа сүртэй, бахдам дуу шуугиантай амьдрал яасан бэ? би удаж төдөлгүй төдхөн эргэж ирээд хэнд ч ганц ч үг хэлсэнгүй, гагцхүү Сэндид л бүгдий нь ярилаа Тийнхүү аймаар их өөр болсон явдалд ямар учир байгааг бид тайлж чадахгүй байлаа. Гадаадын дайсан орж ирээ юу ? Газар хөдлөө юу ? Тахал гараа юу ? Улс гүрнээрээ сөнөж орхив уу ? Яаж ч бодоод дэмий байлаа. Одоо л биеэр явж үзэхээс өөр домгүй болох нь тэр би вангийн ганцхан жижиг хөлөг уурын завийг зээлдэж аваад замд гарахаар бэлдлээ Салж хагацахын зовлон хичнээн их вэ би явахдаа охиноо үнсэв . Инээхэд нь бид хоёр нэн их баярлаж билээ. Өвдсөнөөсөө хойш анх л инээж байгаа нь тэр хүүхдийн шулганаа, хэл ороолдуулан хэлэх үг лүгээ зүйрцэх сайхан хөгжим байхгүй шүү дээ тийм сайхан хөгжмийн эгшиг сонсдохоо байж өнчирсэн чихий чинь хэзээ ч дахин мялаахгүй, оронд нь том хүний үг гарч ирнэ гэж бодохоос хичнээн их уйтгартай гэвч тийм сайхан дурсгалтайгаар явнаа гэдэг хичнээн баярлууштай вэ? Маргааш өглөө нь гэхэд миний бие нэгэнт Английн эрэг хүрсэн байлаа. Дуврийн онгоцны зогсоолд далайн хөлгүүд харагдах

боловч далбаа нь буучихсаныг үзвэл амьд голтой юм. тэнд байхгүй ажээ. Бүтэн сайн өдөр байсан боловч Көнтөрберийн гудамжнаа ганц ч хүн үзэгдэхгүй Ганц ч хувраг хүн харагдахгүй, ганц ч хонх дуугарах сонсдохгүй нь л хамгаас их гайхалтай Үхлийн гунигт нам гүй байдал энд тэндгүй би учры нь ч олсонгүй Тэгтэл хотын захад хүн оршуулах цуваа тааралдлаа . Талийгаачийн төрөл төрөгсөд байхаас биш хувраг хүн ч харагдсангүй хонхны дуу, өрөөл унших, лаа дэн барих аль нь ч үгүй аж Дэргэд нь сүм байвч тэд уйлж гашуудсаар дэргэдүүр нь гараад явчлаа би хонхны х нь г а зрыг шага й хад хар юм.аар бүтээгээд хэлий нь уячихсан харагдав Тэгээд л хамаг учры нь ойлгох нь тэр Одоо Англи оронг ямар аюул нөмрөөд буйг нь ойлголоо Харийн дайсан довтлон ирсэн хэрэг үү Харийн дайсан орж ирснээс ч долоон дор юм. болжээ. Тэр бол сүм хийдээс хөөнө гэгч ажээ. би хэнээс ч юу ч асуусангүй Сүм хийд сүйд хийж байгаа мэдэгдсэн юм. Одоо гадаад төрх байдлаа өөрчлөөд л сэмхэн мултрахаас өөр аргагүй болов. зарц маань надад хувцсаа өгч би ойд орж сольж өмсөөд цааш ганцаар явлаа Тэгвэл л аюул багатай байсан юм. Тун ёозгүй аялал болж билээ. энд тэндгүй нам гү м Лондонд ч өөрцгүй Хөл хөдөлгөөн бүр тасарчээ хүн хар хааяа үзэгдэх нь толгой гудайсан, айж цочсон гав ганцаараа, бие биенээс холуур, ярьж хөөрөх ч үгүй, инээж хөхрөлдөх ч чимээ огт үл гарна Ши н эхэн болж өнгөрсөн дайн тулалдааны ул мөр Тауэр дээр ил байна. Тун базаахгүй явдал үнэхээр болжээ. Камелот руу галт тэргээр явъя гэж бодсон боловч юун галт тэрэг мэрэг Төмөр замын буудал дээр очсон чинь эзэнгүй агуй шиг юу ч алга хов хоосон Тэгээд явган алхлаа хоёр өдрийн турш огт хүн амьтангүй уйтгарт цөл газраар явах шиг болж билээ. Дав аа , мягмар гариг, ням гаригаас юугаар ч ялгагдахгүй байлаа. Камелотод би бүр шөнө орой болсон хойно очсон, Урьд нарны гэрэлд гийх адил гэрлээр мяралздаг байсан хот маань одоо бүр шөнөөсөөч хав харанхуй, пад харласан юм. болжээ. Сүм хийд намайг дийлж миний асаасан со ё л иргэншлийн галыг нэг мөсөн унтрааж авсан нь тэр хотын царайнаа с харагдах ажээ. . Харанхуй гудамж нь эл хуль сэтгэл зүрх хачин болж дотуур нь явсаар байхад өндөр толгойн дээр сүндэрлэн байдаг шилтгээний бараан дүр дүнхийх бөгөөд ганц ч цонхойд нь гэрэл байхгүй Өргүүр гүүр бууж, асар том хаалга нэлий т эл онгойжээ Намайг дуудах хүн амьтан ч алга, огт аниргүй бөгөөд том хашаан дунд хөлийн чимээ маань тун аягүй ганцаар дуулдана

Дөч и н хоёрдугаар б үлэг

ДАЙН

Кларенс амралтынхаа өрөөнд ганцаар уйтгарлан сууж байлаа., Өмнө нь цахилгаан дэнлүүний оронд эртний дэн асаастай, цонхны нь хөшиг буулгаастай өрөө нь бүдэг бадаг гэрэлтэнэ Намайг хармагцаа ухасхийн угтлаа

- Таныг амьд мэнд үзсэндээ тэр буман м и льерэйс төлөхөд ч бэлэн байна. Би хувцас хүнараа өөрчилсөн байсан боловч тэр намайг шууд таньсан юм. тийм учраас миний айдас хүрч билээ.

- Яагаад ийм болов.? юу болов.? гэж би асуухад

- Хатан хаа н Гинервагаас л болж ийм га й дайрлаа гэсэн ч ер нь яваа яваандаа ийм га й түйтгэр гарцаагүй дайрах байжээ. ийм га й зайлшгүй тохиолдох байсан Харин аз болоход хатан хаан эхэлж дээ

- Ланселот ноён ч тэгээ л биз?

- Тэгэлгүй яах вэ

- тодорхойхон ярьж аль даа

- Сүүлийн хэдэн жилийн дотор хатан хаан, Ланселот ноён хоёрын харьцааг улс гүрний дотор ганц хүн л таашаахгүй байсныг та мэднэ

- тийм, Артур ван ч

- Ганц хүн л бас сэжиг аваагүй байсан

- Вангийн сэтгэлд тийм юм. ороогүй, найз нөхрийнхөө зүгээс тийм юм. хийнэ гэж зүүдлээ ч үгүй байх

- Бирж гэж таны гаргасан шинэ нэг юм. бий болоогүй байсан бол ван тэр тухайг мэдэлгүй байсаар насаа сэтгэ л амар элээх байсан биз Таныг явсан хойно Лондон, Көнтербери, Дуврын хооронд тавьж байсан төмөр зам дуусдаг дээрээ очоод байлаа. Төмөр замын хувь нийлүүлсэн тэмдэгт ч биржийн тоглоомд гарахад бэлэн болоод байлаа. Тун осолтой юм. болж мэдэхийг хүн болгон мэдэж байсан Тэмдэгтүүдийг дуртай худалдан авцгааж байсан Тэгтэл Ланселот ноён юу хийсэн гэж санана?

- Бод в ол өөрт өө байса н бүх тэм д эгтийг худал даж тэмдэгтийн үнийг бууруулснаа дараа нь өөрөө хоёр дахин хямд үнээр эгүүлэн худалдаж аваад л бусдыгаа хооср уулаа биз

- Яг тэгсэн Тэмдэгтийн үнэ арав хүрч байхад хүмүүс түүнд арван тав зургаагаар зарсандаа хөх инээд нь хүр баярлаж байсан боловч удаан хугацаанд баярлаж чадсангүй Хэдхэн өдрийн дараа нөгөөдүүл чинь Үп ялагдагчийн тэмдэгтийг авахад хоёр зуун наян гурван янчаанаа өгөх гэж царай алдах болдог хэрэг шүү

- Бурхан минь

- Хувхайртал шулах нь тэр Цаадуулынх нь хохь болсхгүй юу Улс амьтан ч баярлаж байсан Тэгсэн чинь үгүйрсэн улсын дотор Агравэн ноён, вангийн ач Мордред ноён байж Нэгдүгээр үзэгдлийн шувгарга нь тийм боллоо хоёрдугаар үзэгдэл, анхны тайз юу болсон гээч Карлайл шилтгээнд ван хэд хонон ан авлахаар иржээ Ажиллагч хүмүүс нь хэн хэн байсан гэвэл вангийн ач Агравэн, М ордред хоёр ван ахдаа Гиневра, Ланселот ноён хоёрын харьцааны талаар нүдий нь нээж өгчээ тийм бузар булай хэрэгт ямар ч хамаагүй гэж Говэн, Гарет, Гахөрис ноёд хэлжээ Тун сүртэй хэрүүл шууги а н дэгдэх нь тэр Тэгж байтал нь Ван ороод ирж л дээ Морд е р, Агравэн хоёр өнө ө х жигтэйхэн юмаа яриад тавьчихжээ Цааш нь хэл мэдээгүй хэтүүр ажиллагаа эхэлж Ланселот ноёнд урхи бэлдсэн байна. Урхинд нь ноён ч орчихжээ Энэнээс болж Мордред, Аг равэн, бас арай доогуур албатай арван хоёр морьтон баатар хов живэнд орсныхоо гайг амсаж Мордредээс бусад нь Ланселотод алагдах нь тэр, гэсэн ч үүнээс болж Ван, Ланселот ноён хоёрын харьцаа сайжирч чадахгүй байсан, сайжирсан ч үгүй

- Б у р х а н м и н ь Д а й н а а с ө ө р ю у н д хү р э х б и л э э . В а н т у л с т э р а я а р а а в а н г и й н т а л , Л а н с е л о т н о ё н ы т а л г э э д л х о ё р х о н х у в а а г д а ж о р х и х г ү й ю у

- Я г л т и й м б о л с о н В а н , в а н а х а й г а р и у т г а н а г э ж т ү ү д э г т ш и л ж ү ү л э х э д н ь Л а н с е л о т н о ё н а м и н д н ь о р ж т а б и д н и й х а м а г с а й н с а й х а н н ө х д и й м и н ь х я д с а н Б е л и а с л е О р ю л ю н о ё н , С ө г в а р и д е с н о ё н , Г р и ф л е т л е Ф и с д е Д ь е н о ё н , Б р а н д а й л с н о ё н , Э г л о в э л н о ё н г э э д л б ү г д а м ь н а с а а а л д с а н

- Ээ чи минь сэтгэл зүрхий минь шимшрээж байна.

- Тэгээд зогссон гэж бодно уу ? тор ноён, Готер ноён, жиллимер ноён,

- Бейсболын багийн минь хамгийн сайн тоглогч байж билээ. Баруун гараараа Манч сайн цохидог байж билээ.

- Райнольд, Дамус, Приам гураан ах дүү ноён, Кей Тэнүүлч ноён

- Шүдээрээ бембөг олон удаа авч чадаж байсан бас л сайн тоглогч байсан сан за больёдоо

- Драент ноён, Ламбегус ноён, Хермаинд ноён, Пертолоп ноён, Периманес ноён бас хэн гэж бодож байна.

- Бушуул бушуул Намайг битгий зовоогоод бай

- Гахерис ноён, Гарет ноён, хоёул

- Ухаанд багтамгүй санагдана Тэр хоёр чинь Ланселотыг бурхан шиг хүндэтгэдэг байсан улс шүү дээ

- Тэр хоёрын хувьд тохиолдлын чанартай болсон юм. Тэр хоёр хажуугаас харж л байсан хоёр Ван ахайг яаж шийтгэхийг харах гээд ээр зэвсэггүй ирэхгүй юу Ланселот ноён галзуууурандаа мөртөө тааралдсан бүрийг цавчилсаар байгаад тэр хоёрыгоо ч байна. гэдгийг мэдэлгүй аваад хаячих нь тэр Тэр тулалдааныг харуулсан нэг гэрэл зураг энэ байна. Энэ зургийг одоо сонины мухлаг бүрт зарж байгаа харахгүй юу Ланселот ноён ван ахайн дэргэд сэлмээ далайчихсан, хажууд нь Гарет ноён үхэж байна. Утаа наагуур нь баагиж байгаа ч гэсэн ван ахайн сэтгэлийн зовлон царайд нь ил байгаа биз Айхтар сайн зураг шүү

- Айхтар зураг байна. Хадгалах хэрэгтэй Түүхийн баримт, үнэлж баршгүй эд Цааш нь

- Дараа нь ёстой жихэнэ дайн болсон доо Ланселот ноён ухарч өөрийнхөө аз жаргалын шилтгээнд очоод талынхаа морьтон баатруудыг цуглуулж байхад ван их цэрэг хөдөлгөж олон хоног байлдаан болж энд тэндгүй цуса нэлий урссан. Дараа нь сүм хийдийн зүгээс ванг Ланселот ноён, ван ахай нартай ер нь ганц Говэн ноёноос бусадтай нь эвлэрүүлж, Говэн ноён Гарет, Гахерис хоёр ах дүүгээ алагдсанд юу боловч эвлэрэхгүй ланселот ноёнтэй байлдана, бэлдэж байгэхэд Ланселот ноён талынхнаа дагуула өөрийн нутаг Гийвен руу хөдлөхөд Говэн ноён араас нь цэрэг аван хөдөлж Артур ванг мөн явья хэмээн ятгав. Артур таныг эргэж иртэл вант улсынхаа удирдлагыг Мордред ноёны мэдэлд үлдээсэн

- Өө Мөн дөө, ер нь ухаантай хүн нь ил байна.

- тийм шүү Мордред ноён шууд л ван болох гэсэн Хамгийн түрүү Гинерватай гэрлэх гэхэд нь цаадхи нь оргоод Лондонгийн Тауэрт нуугдаж орхижээ Мордред Тауэрыг дайрч, тэгэхлээр нь Кентерберийн ёнзон хамба түүнийг шашнаасаа хөөсөн Ван эргэж ирэхэд Мордред өөдөөс нь түүнтэй Дувр, Кентербени, Бирхөмын талд байлдсан Сүүлдээ найрамдах хэлэлцээ хийж Мордред нь Корнекклис, Кент хоёрвиг Артуйсын амьд сэрүүн байхад эзэмших, дараа нь бүх вант улсыг шилжүүлэн авах болзолтой таржээ

- Сүрхий юм. болжээ. Бүгд Найрамдах төр байгуулах гэсэн хүсэл мөрөөдөл минь

хоосон өнгөрчээ

- тийм ээ хоёр талын их цэрэг хоеул Сойсберийн дэргэд байж Говэн, Говэны толгой нас барсан газраа, Тауэрт байгаа Артурыг унтаж байхад Говэн, Говэн өөрөө биш, сүнс нь ирж ямар ч болтугай нэг сарын хугацаанд байлдаан хийх х э рэг г үй шү ү гэжээ гэтэл санамсаргүй явдал шийдвэрлэх тулаан хийхэд хүргэжээ Артур, Мродредэд итгэхгүй байсан болохоор х э рэ в хэлэлцээ хийх үеэр нэг л хүн сэлэм су г а л ж гэм э эн даруй бүрээгээр дохио ө гч дайсныг дайрах хэрэгтэй гэж тушаасан байж Мордред бас тийм тушаал цэрэгтээ өгсөн байж Хагас минутын дараа хоёр их цэрэг бие биеий н эсрэг хөдөлжээ Өдөржин байлдаад ван ч,, Таныг явсан хойно бид сониндоо нэг шинэ журам гаргасан юм.

- нээрэн үү? Чухам юу юм.

- Фронтын сурвалжлага

- догь

- Манай сонин тун амжилттай байсан, яагаад гэвэл дайн болж байсан тэр үед биднийг шашнаас хөөгөөгүй байсан юм. Манай сонины сурвалжлагч нар хоёр их цэргийн аль алинд нь байсан Тэр тулалдаан хэрхэн яаж төгссөн тухайг манай нэг сурвалжлагч хэрхэн мэдээлснийг би уншиж өгье

В ан ий ш т и й ш х ар вал хам а г сай н морьтон б а атрууд нь Бук е н д е Бутл е р но ё н , түүний а х Беди в ер н о ё н хоёроос бус а д нь бүгд а лагдсан байв. ү лдсэн т эр хо ёр нь шархадсан байхыг үзээд Иссус бурхан минь миний ариун үйлт морьтон баатрууд минь хаана байна..Ийм гунигт өдлийг үзтэлээ миний амьд явах хэрэг юу байна..Энэ бүхий л хэргийг тарьсан Мордредийг олоход минь туслаач гээд Мордред үхсэн олон улсын дунд сэлмээ тулан зогсохыг олж харав.Мордред руу гүйн очиж чиний үхэх цаг чинь иржээ гэж хашгирахад Мордред өөдөөс нь ухасхийв.Артур ван Мордредийн бамбайн доогуур нэвт жадлав. Мордред сэлмээ хоёр гарынхаа хар хүчээр Артур вангийн толгой руу буулгаад үхэтхийн унав.Ариун төрөлт Артур ван ч мэдээ алдан унаж ухаан орон ортлоо удсан.....

- Кларанс минь , цэргийн сурвалжлагадаа гойд с а йн бичиж шүү чи ч тэргүүн зэргийн сэтгүүлч болжээ. Ван тэгээд эдгээ юу ? Зүгээр болоо юу ?

- Үгүй шүү, хөөрхий, үхчихсэн би хачин их гайхсан билээ. тийм хүнийг алж боломгүй мэт ямагт санаж явсан юм. л даа

- Ван ахай яасан?

- Олмсберид гэлэнмаа болсон

- мөн ч их өөр болжээ. ийм богино хугацванд Яана гэх вэ? Ухаанд багтамгүй санагдаж байна.

- Яах ийхийг би хэлж өгье

- заа тэг

- Амиа дүйж хамаг чадлаараа чармайя

- чи юу хэлэх гээд байна.

- Одоо засгийн эрх сүм хийдийн мэдэлд орсон Таныг Мордрөдын х амт сүмээс хөөсөн Таныг амьд байгаа цагт энэ явдал салахгүй Сүм хийд, амьд үлдсэн морьтон эрсийг зарлан хуралдуулж байна. Төныг эргээд нрсэн гэдгийг мэдмэгцээ ер амар заяа үзүүлэхгүй

- Нохой долоо Бидэн шиг үхлийн цохилт өгч чадах хэрэгсэлтэй, с ургууль сайн цэрэгтэй улсад юу бо лох билээ.

- Элэнцэг нь Итгэж болох хүн бидэнд тавь жараас илүү алга шүү дээ . Юу гэнэ ээ? Манай сургууль соёлын газар, манай дархны газрууд ,,

- Морьтон баатруудыг үзмэгцээ тэд чинь тэдний талд орчих нь дайсны талд орно Тэр улсыг мухар сүсгээс ангижруулж чадсан гэж бодож байгаа юм. биш биз дээ?

- Үнэнийг хэлэхэд би тэгж бодож байсан

- Тэгвэл дахиж тэгж бүү бод Тэд хөөгд ө хийн өмнө таны үгэнд ордог байсан Хөөгдсөнөөсөө хойш гуйвах болсон сэтгэлд нь сэв суусан о йлгох хэрэгтэй д айсны цэрэг ирэхэд танаас урваж тэдний талд орно

- Муу мэдээ байна. даа Бид ч өнгөрчээ Бидний зааж сургасан бүхэн маань өөрсний маань толгой дээр буух болжээ.

- Үгүй байх аа, тэд тэгж чадахгүй

- Яагаад?

- Яагаад гэвэл би үнэнчээр үлдсэн хүмүүстэйгээ а рга саам хийсэн л дээ Энэ тухай сүүлд ярьж өгье Т а зальтай ч сүм хийд танаас илүү зальтай Сүм хийд л албанд байсан докторуудын хүчээр таныг алсын аянд мордуулсан хэрэг байна.

- Кларенс

- нээрэн шүү, яг тийм, би мэдсэн Хөлөг онгоцны чинь матр ас , дарга нарыг бүгдий нь сүм хийд х а хуу л ьдсан байж

- Даанч д ээ ?

- Үнэн гэм Анх нь би мэдээгүй байсан, хож и м лавтай мэдсэн Нөөц бэлтгэл аваад буцаж очиход би Кадиксаас явна гэж та хөлөг онгоцныхоо даргаар надад а м хэлүүлсэн үү?

- Кадиксаас? би Кадиксад ер очоогүй шүү дээ

- Кадиксаас явж алс холын тэнгис далайгаар г эр бүлийнхээ эрүүл мэндийг базаах гэж явна гэж үг хэлүүлсэн үү?

- Үгүй чиш юм. хэлэх байсан бол бичих л байсан байлгүй

- Тэгэх л ёстой миний санаа зовж сэжиглэж эхэлсэн юм. Ахмадыг буцахад нь нэг тагнуул дагуулаад явуулчихсан юм. Тэр цагаас хойш х ө лөг он гоцны тухай ч тагнуулыныхаа тухай ч юу ч сонссонгүй би таныг хоёр долоо хоног хүлээгээд Кадикс руу хойноос чинь хүн явуулья гэж

шийдээд явлаа гэвч тэр бодол маань биелсэнгүй,

- Яагаад?

- Манай флот гэнэт хачин алга болсон Төмөр зам, цахилгаан, утсан харилцаа маань бас л гэнэт хачин жигтэйхэн ажиллагаагүй болсон, албан хаагчид нь таран явж, утасны модыг тас хөрөөдөж, цахилгаан гэрэл хэрэглэхийг сүм хийдийн зүгээс хориглосон, Нэн даруй Ямар нэг арга хэмжээ авах ёстой байлаа. Таны амь нас ны төлөө санаа минь зовж сүйд болоогүй Яагаад гэвэл та мэтийн их илбэт хүний эсрэг тус улсын дотор Мерлингээс бусад нь түмэн цэрэгтэйгээр ч хөдөлж чадахгүй л дээ Тэгэхлээр таны ирэхэд л бэлдэх хэрэгтэй байсан юм. Өөрийнх ө ө амь насны төлөөч сэтгэл зовоогүй, яагаад гэхэд таны хайртай хүнд хэн ч халдаж чадахгүй Тэгээд би юу хийсэн гэвэл үйлдвэр дархны аа газруудын залуучуудаас хамгийн итгэлтэй гэснийгээ түүн авч нууц даалгавар өгсөн Тавин хоёр л хүн дээ Арван дөрвөөс бага арван долоогоос ахмад ганц ч хүн байхгүй

- Яагаад гагцхүү жаал хө в үүд шилж аваа вэ?

- Яагаад гэвэл бусад нь мухар сүсгийн хүрээнд төрж өссөн байна. Мухар сүсэг тэдний мах цусанд нь шингэжээ Бид тэднийг боловсролын хүчээр хувиргасан гэж бодсон, тэд ч өөрснөө өөр боллоо гэж бодож байсан гэтэл сүмийн хөөлтөөс тэд гялбаа шиг биш болоод явчсан Өөрснөө тийм болж байгаага ч андсангүй би ч андсангүй Жаал хөвүүдийн хувьд бол өөр хэрэг байна. долоо найман жилийн турш бидний хүмүүжилд байсан хүүхдүүд чинь сүм хийдээс нэг их айхгүй юм. тэднүүсийн дундаас л би тавин хоёр хүүхэд багачуул шилж авсандаа Тэгээд би сэмхэн явж Мерлиний хуучин жижиг биш бүр том агуйг нь очиж үзсэн

- Гайхамшиг үзүүлнэ гээд цахилгаан машинаа анх байрлуулж байсан тэр агуйд уу ?

- Яг мөн Гайхамшиг үзүүлэх хэрэг нэгэнт үгүй цагт тэр машинуудаа өөр зорилгоор одоо ашиглаж болно. шүү дээ Бүслэлтэд орвол яаж мэдэх вэ гээд тэр агуйд хоол хүнсний зүйл а ваача а д хийчихсэн

- Тун зүйтэй Тун мэргэн бодол байна. даа жаалаар хүнд харагдахгүй, дотроос нь мануулж байгаа хажуугаар явах хүн харыг ер зүгээр байлгаарай харин орж очих гэсэн хүнд яадгий нь үзүүлээд өгөврэй гэсэн Дараа нь би ууланд гарч таны унтлагын өрөөг тэсрэх минатай холбосон утас, манай бүх үйлдвэр, завод, дархны газар, агуулахтай холбосон нууц утсуудыг олж таслах нэгий нь тасалж, холбох нэгий нь холбоод шөнө нөгөө хэдэн жаалтайгаа явж агуйтайгаа холбоод орхисон Одоо тэр утас хаанаас гарч хаагуур явж хаана хүрдгийг бид хоёроос өөр хэн ч мэдэхгүй Бүх утсаа газар доогуур явуулсан, тэгэх ажлыг бид хэдхэн цагийн дотор л хийж амжсан Одоо бид агуйгаасаа цайзнаасаа гадагш гаралгүйгээр нүд ирмэхийн зуурд бүх соёл иргэншлийнхээ бүтээсэн зүйлийг дэлбэлж чадах болсон

- Энэ чинь з ө в алхам, зүй ёсны алхам байна. Цэрэг дайны чухал шаардлагаас болж юу ч болж мэднэ шүү дээ юм. мөн ч их өө р болжээ. Бид бүслэлтийн байдлыг хэзээ нэгэн цагт ордны дотор тэвчин өнг ө рөөж чадна гэж боддог байж гэвч за цааш нь ярь даа

- Дараа нь бид төмөр утсаар хаалт татсан

- Төмөр утсан хаалт?

- тийм ээ, та өөрөө тийм юм. хийх талаар хоёр гурван жилийн өмнө надад хэлж өгсөн

шүү дээ

- Аа тийм, одоо санаж байна. Сүм хийд анх удаа бидэнтэй хүч сорин үзэх гэж нэг оролдож байхад нь тэгж байсан, дараа нь бид харзнаж байж больё гээд хойшлуулсан Тэгээд чи яаж шүү хийв дээ?

- Агуйд байгаа том динамогоосоо залгаса н тусгаарлагчгүй нүцгэн, арван хоёр бүдүүн утас авсан Хасах, нэмэх хоёр цэнэгтэй

- зөв

- Утсаа агуйныхаа гадаа аргаж бараг газрын хөрс эй чацуу голчоороо зуун ярд тийм хэсэгхэн газар шон босгосон Арван хоёр тусгай шон н эг нэгнээсээ арван алхмын хэр зайтай ө ө р өө р хэлбэл арван хоёр шон маань дугуйрч явсаар утасны үзүүрүүдийг бүгдий нь агуйд оруулчихаж байгаа юм. л даа

- Зүйтэй зөв Цааш нь

- Шонгуудаа газар таван фут гүн шаасан бие биеэсээ гурван ан фут зайтай зузаан дүн з эн багананд бэхэлсэн

- Сайн ч хийж, бөх ч байгаа даа

- Утаснуудаа агуйн гадаа газардуулаагүй Динамын нэмэх цэнэгтэй туйлаас гарч байгаа юм. Газартай хасэх цэнэгээр нийлнэ Утасны агуйд орж ирсэн үзүүр болгоныг газардуулсан

- Тэр чинь л болохгүй дээ,

- Яагаад?

- Эрчим хүч дэндүү их зарсан хэрэг Эрчим хүч дэмий үрэгдүүлэхгүй юу Хасах цэнэгээр бүх системдээ ганцхан л газардуулга хийвэл болно. Утаснуудынхаа үзүүрийг агуйдаа эргүүлж оруулаад газардуулалгүйгээр тус тусад нь бэхлэх ёстой Тэгэхлээр хичнээн их хэмнэлт гарна вэ Морин цэрэг бидэн рүү дайрахдаа манай хаалтаар дайрна Морь нь утсанд шүргэхээс нааш ямар ч эрчим хүч, ямар ч мөнгө цэнгэ зарахгүй болно. шүү дээ Утас шүргэмц газраар дамжин хасах цэнэгийн залгаа үүсэж морь нь үхнэ Чухам хэрэгтэй цагт л эрчим хүчээ зарах болно. Цахилгаан гялбаагаа гартаа бэлэн зэхээстэй барьж байна. гэсэн үг шүү дээ Яг л цэнэгтэй буу шиг Буудахад л зарлага гарахаас биш өөр ямар ч илүү зарлага гарахгүй Ганцхан л газардуулга хэрэгтэй

- нээрэн тийм юм. аа Яагаад би тэгж бодоогүй юм. бол Хямдаар барахгүй ажиллагаа ч сайн байх нь байна. Яагаад гэвэл утас тасарлаа ч гэсэн, орооцолдлоо ч гэсэн хортой юм. болохгүй нь байна шүү дээ

- Ялангуяа агуйдаа гэмтсэн утсыг автоматаар унтраах унтраалгатай болчиг бүр догь болно. Цааш нь их бууны талаар юу болсон?

- их бууч бий дотуур тойргийн төвд өргөн гэгчийн өндрөөрөө зургаан фут тавцан дээр арван гурван их буу их хэмжээний сумын хамт зоож бэлдсэн

- Сайн байна. их бууны бүлэг ойр хавийгаа захирдаг болохоор сүм хийдийн морьтон

эрсийг дөхөн ирэхэд өмнөөс нь хөгжимтэй угтана гэсэн үг а гуйн дээрх хадан цохиог яасан?

- Тэнд бас утсан хаалт хийж буу зоосон Тэд биднийг чулуугаар шидэж барахгүй, санаа зоволтгүй

- Шилэн бортоготой динамит мина яасан бэ?

- Мина ч бэлдсэн тун сайхан цэцэрлэг байгуулсан Өргөнөөрөө зуун фут бүс маягаар төмөр утсан хаалтыг тойруулж хийсэн байгаа Миных газар тавьж дээгүүр нь элс асгасан Харахад тэр жаахан цэцэрлэг гэм ээ рг ү й санагдана Харин дотор нь орсон хүн сайнаа үзэхгүйдээ

- Минээ шалгаж үзсэн үү?

- Шалгаж үзье гэж бодож байсан боловч

- Тэгээд? ш алгаж үзээгүй бол ч тун муудаа

- Шалгах талаар уу ? Сайнаараа байгаа, би мэдэж байна. хэдийг замын дагуу тавьж үзсэн, шалгаж үзсэн л дээ

- Тэгвэл өөр хэрэг Хэн шалгах нь тэр вэ?

- Сүмийн комисс

- Сайн л хэрэг байна. даа

- Тэд биднийг эрхэндээ оруулна гэж и рсэн Миных шалгая гэж ирсэн ч юм. биш, санаандгүй л тийм юм. болчихсон

- Шалгалтынхаа үр дүнгийн талаар комисс илтгэсэн үү?

- Тэгэхээр барах уу даа Бүхэл бээрийн газар дуулдахаар илтгэл болсон юм.

- санал нэгтэй илтгэл үү?

- санал өгөөгүй хүн ер байхгүй Ирээдүйн комисст сануулга болгож зам дээр бага сага тэмдэг тавиулсан гэвч дахин бидний сэтгэлийг зовоох юм. гараагүй дээ

- Кларенс чи тун сайн юм. хийжээ

- Цаг хавчаагүй юм. чинь , яарах сандрах хэрэг ч гарсангүй Бид хоёр түр дуугүй болж сууснаа би

- Бүгдийг бэлджээ, Жаахан ч юм. орхисонгүй Бүгдийг бодож боловсруулсан байна. Мартсан ч юм. алга Одоо яахыг би мэдэж байна.

- Одоо хүлээгээд л суухаас өөр юм.гүй болсон гэдгийг би ч мэдлээ

- тийм биш ээ, ноён минь Босоод цохилт өгөх хэрэгтэй байна.

- Тэгж үнэхээр бодож байна. уу ?

- Яг тэгж бодож байна. Би бол хориглох хамгаалах талын хүн биш, давших талын хүн Ямар ч гэсэн хүч бараг тэнцүү байгаа үед нээрэн, цохилт ө г ө х ө ө л өгнө Ингэхийг бидний тоглоомын маань дүрэм шаардаж байна.

- чи бараг л гарцаагүй з өв юм. хэлж байна. ший маань хэдийд эхлэх вэ?

- Одоо Бид Бүгд Найрамдах төр тунхаглана

- энэ чинь жүжгийнхээ тайллыг хурдатгана гэсэн Үг

- уухай Бас хичнээн хурдан явцтай гээч Маргааш өглөө гэхэд л Англи орон тэр аяараа зөгийн үүр болж хувирна Харим сүм хийд л дуугүй байдаг биш юм. бол шүү, сүм хийд дуугүй байх гэсэн ном үгүй л дээ бичээд байгаарай, би хэлээд өгье

Тунхаглан зарлах бичиг

Бүгдийн сонорт з арлан тунхаглах нь Ван нэгэнт ширээгээ залгамжлах хүн үлдээлгүй нас барсан болохоор засгийн газар эмхлэн байгуулагдах хүртэл төрийн жолоог гараасаа үл гаргах нь мин и й үүрэг билээ. Хаант төр үеэ дуусгажээ Тэгэхлээр, улс төрийн засгийн бүх эрх анхныхаа эх ундарга болсон ард түмэндээ эргэж ирж байна. Хаант төрийн хамтаар түүний бүхий л дэглэм сөнөж байна. Тайж язгууртан ч гэж байхгүй, эрх ямбат анги ч гэж байхгүй, улсын шашин гэж ч байхгүй боллоо Одоогоос хүн бүхэн эрх тэгш болно. хүн бүр өөрийнхөө дураар шашинаа сонгож авна Төрийн өөр аливаа хэлбэр байхыг больсон одоо цагт үндэстний заяаны байдал болсон Бүгд Найрамдах ёсыг үүгээр тунхаглан зарлая Өөрсдийн төлөөлөгчдийг саналаараа сонгож тэдэндээ засгийн газар эмхлэн байгуулах үүрэг өгөх нь Британы ард түмний үүрэг мөн

Эзэн

гэж гарынхаа үсгийг зураад он, сар, өдрөө тавьж Мерлиний агуй гэгчихсэн юм. Кларенс хэлэхдээ

- Тэгвэл бид нар өөрснийхөө байгаа газрыг хэлж өгөөд ирээд барьж авагтун гэж тэднүүсийг залж байх шив дээ гэв

- Тэгэх л хэрэгтэй байна. Бид энэ тунхаглалаараа тэдэнд нэг цохилт өглөө одоо тэднүүсийн ээлж Энийг хэвлээд энд тэндгүй наах хэрэгтэй Дараа нь 2 унадаг дугуй олдвол Мерлиний с ү м р үү очъё

- Арван минутын дараа бүгд бэлэн болно. Энэ цаас тарахад маргааш ямар шүү их сүртэй юм. болох бол Энэ ч сайхан орд шүү, чи бид дахин үүнийг үзэх бол уу үгүй бол уу гэвч ийм юм. бодох хэрэггүй

Дөчин гуравду га ар бүлэг

ЭЛСЭН БҮСЭД БОЛСОН ТУЛАЛДААН

Мөрлиний агуйд Британы эрүүл чийрэг, ухаалаг, сэргэлэн, хүмүүжил сайнтай, эвдэрч завхраагүй тавин хоёр жаал хүү, Кларенс, бид хэд байлаа. Үүр тиймэгц миний бие бүх үйлдвэр, дархны газрууд руу хүн явуулж аж лаа зогсоогоод амьтай голтой бүхнээ холхон байлга, байшин барилгы чинь нууц минаар дэлбэлнэ гэж хэлүүлээд чухам хэдийд гэдгий нь битгий хэлээрэй гэв хүмүүс намайг мэдэх учраас надад итгэжээ Тэр үгийг сонсмогцоо тэд үс гэзгээ ч сам н алгүйгээр харайн одо ц гоох учир хэдийд тохиромжтой гэсэн цагтаа би дэлбэлэлт хийж чадах байв. Дэлбэрэх аюул өнгөрөөгүй цагт тэднүүсийг байрандаа хэн ч яаж ч буцааж чадахгүй л дээ Бид бүхэл долоо хоног хүлээж билээ. би үргэлж юм. бичиж байсан болохоор уйдаагүй байсан Гурван өдрийн дотор тэмдэглэлээ тууж хэлбэртэй болгож түүнийгээ туурвин дуусгахад ганц хоёр л бүлэг нэмж бичихэд болох болоод байлаа. долоо хоногийн эцсийг эхнэртээ захиа бичиж өнгөрөөсөн Ер нь би т эгж явахдаа Сэндид өдөр бүр заавал захиа бичдэг байсан юм. Захиа бичих ч дуртай, эхнэртээ ч сайн байсан болохоор тэр зуршлаа одоо хүртэл орхиогүй, харин захиа явуулах ямар ч бололцоогүй болчихоод байсан захиа бич нэ гэдэг маань цаг барж хүнтэйгээ ярьж байгаа шиг юм шүү дээ би яг л түүнтэйгээ ингэж ярьж ийм үг хэлж байгаа юм. шиг санана Сэнди, хэрэв, Төв Станц байна. уу та хоёр энэ агуйд зургаараа биш биеэрээ байсан бол бид цагийг мөн ч сайхан өнгөрөөх байж дээ миний бяцхан охин эхийнхээ өвдөг дээр дээш харж хэв т ээд амандаа атгасан гараа үнхэж нэг юм. шулганах шиг болоход эх нь инээж охиноо инээлгэх гэж эрүүгий нь гижгэдэж, тэр зуураа надтай үг сольж байгаа юм. шиг нүдэнд харагдах бөгөөд миний бие тийнхүү гартаа үзэг барин бичиж дотроо элдвийг төсөөлөн бодож байлаа. Бид уулзаад хамт нэг дор байгаа ч юм. шиг санагдана юу юу болж байгааг мэдэх гэж би шөнө болгон тагнуул явуулж байсан л даа Ирэх мэдээ өдөр болгон түгшүүртэй болсоор байлаа. энд тэндгүй морьтон эрс Англи даяар давхилдан их цэрэг өдий төдийгөөрө ө бий болж буй сурагтай Хар лам нар ч морьтон эрсийн хажуугаар явж нэг ёсондоо ариун дайнд мордох тэд н ийг зоригжуулан уриалж байв. том"жи жи г бүх тайж язгууртан сүм хийдийг өмгөөл ө н хамгаалахаар зорьжээ Бидний санаж байснаар л яг болж буй бололтой Дажгүй, бид тэр хогийн ургамлыг бүгдий нь сөнөөнө, тэр цагт ард түмэн гагцхүү бүгд Найрамдах ёсоо хамгаалан үзэлцэх болно. Аяа би яасан мал шиг тэнэг амьтан бэ Тэр долоо хоногийн эцэст олон түмэн нь ганцхан өдөр л Бүгд Найрамдах ёсны төлөө байсныг мэдсэн билээ. Илүү хугацаагаар тэд түүнийг дэмжээгүй юмдаг Сүм хийд, тайж язгууртан нарыг муухай хармагц тэд хонь шиг номхон амьтад болон хувирсан юм. Тэгээд тэр хонинууд нь тэр дорхноо хашаанд орж, өөрөөр хэлбэл, цэргийн хуаранд орж өөрсдийн хямдхан амь нас, үнэтэй үс хял гасаа Үнэн хэрэг гэгчийн төлөө өгч гарах нь тэр д өнгөж саяхан хүртэл боол байсан хүмүүс Үнэн хэрэг гэгчийн талд орж түүнийг магтан дуулж, амжилты нь өрөөж, бусад эгэл хүмүүсийн адилаар сэтгэл зүрхээ өгөч биширцгээж байлаа. Даанч тэнэг мунхаг хэрэг шүү хүн биш, хог новш о доо энд тэндгүй Бүгд Найрамдах

ёс сөнөтүгэй хэмээн орилолдох болж ганц хүн эсэргүүцэхээ болив ийм юм. болно. гэж би үнэндээ огт бодоогүй юм шүү Англи орон тэр аяараа бидний эсрэг хөдлөө би өнөөх тавин хоёр залуугийнхаа нүүр царай, явж гишгэх байдал ухамсаргүй хөдөлгөөн бүрий нь сайн ажиглан судалсан,

- яагаад гэвэл тэр бүгд нь бидний н ууцыг илчлэх, бидний эрхэмлэн нууж байсан бүхнийг маань ил болгох хэл байлаа л даа Тэр бүхэн нь Англи орон тэр аяараа бидний эсрэг байна. гэсэн бодол салшгүй буйт илтгэх бөгөөд цаашлах тутам анхаарлы нь аргагүй л татаж санаа бодлы нь эзэмдэж зүүд нойрон дундаа ч гэсэн Англи орон тэр аяараа, Англи орон тэр аяараа бидний эсрэг байна. гэсэн үг чихэнд нь аймшигтайгаар сонсдох болжээ. Энэ бүхэн юу болж дуусахыг би гадарлаж байлач сэтгэл тэгж их түгшсэн нь сүүл сүүлдээ гадагш заавал дэлбэрэн гарч ирэх тул хэрэгтэй тэр мөчид урьдад сайн бодож боловсруулан, тайвшруулан засах хариуболгож байлаа. миний бодсон зөв байв. Яг цаг нь тулж ирсэн бүр мэдэгдээд ирж билээ. Өнөөх жаалууд маань , хөөрхий амьтад, даанч өрөвдмөөр болж, зовж шаналсан нь сэтгэл түгшиж мэгдсэн нь үнэхээр өрөвдөлтэй, харахаас нүд хальтрам болж билээ. Тэдний т өлөөлөгч нь эхлээд хэлэх гэсэн үгээ ч хэлж чаддагүй, дуу нь ч гарч өгдөггүй шүү Тэгснээ гэнэт бөглөө нь гарах шиг болж миний сургуульд сурсан цэвэр орчин үеийн англи хэлээр ингэж хэлэв

- Бид, Англи хүүхдүүд гэдгээ мартахыг хичээсэн билээ. Бид, оюун ухааныг сэтгэлээс дээгүүр, үүргийг хайрлахаас дээгүүр тавихыг хичээсэн билээ. Бидний ухаан бодол бидэнд захирагдавч сэтгэл зүрх минь захирагдсангүй Бидний эсрэг зөвхөн тайж нар, сүүлийн дайн тулалда ан ы эцэст үлдсэн дөнгөж хоёр түм хагас буюу гурван түм орчин морьтон баатар байхад бид сэтгэл нэгтэй, юу наас ч мятрахгүй байлаа. тань өмнө зогсож буй энэ тавин хоёр залуугийн хэн нь ч Тэд өөрснөө хүссэн хойно хохь н ь гэж б а йсан юм. гэтэл байдал өөр болж Англи орон даяараа бидний эсрэг босож ирлээ шүү дээ Ай, ноёнтон минь , гэгээн ухаанаа зарж бод энд ард түмэн чинь бидний ард түмэн, бид чинь түүний мах цусны тасархай, бид тэдэндээ хайртай, биднийг тэдний эсрэг тэмцэхийг та бүү уриалж үз Хэрэг явдлыг урьдаас таамаглан мэдээд бэлдэнэ гэдэг маань юу гэсэн үг болох нь энэ вэ дээ Хэрэв миний бие хэрхэхийгээ бэлдээгүй байсан бол тэр жаалын үгэнд уймарч хариуд нь юу ч гэж хэлэхээ мэдэхгүй балмагдаж мэдэх байлаа. гэвч би бэлдчихээд байсан болохоор и н гэж хэлсэн

- хүүхдүүд минь , та нарын сэтгэл зүрх чинь үнэнч байж, зөв юм. хийж байна. Та Англи нутгийн хүүхдүүд, тэр чигээрээ үлджээ Нэр төрөө бузарласангүй о доо элдэвт тээнэгэл з эн биеэ бүү зовоо, тайвшир Англи орон тэр аяараа бидний эсрэг явж байна., харин хэн өмнө нь явж байна. Ер нь дайны ердийн дүрэм ёсоор ямар хүн нь тэргүүнд нь явдаг билээ.? хэлээч

- Хуяг дуулга өмсөн хэдэрсэн морьтон баатруудын морин хороод

- Зөв Тэд гурван түм Тэд нүдний хараа чилмээр их газрыг эзлэн явдаг Тэднээс өөр ямар ч хүн Элсэн б үсэд орохгүйг тануус бод Бид тэдний л учрыг олох хэрэгтэй байгаа юм. Ар сүүлд нь дагаж я в аа эгэл оло н ард нүд ирмэхийн зуургүй ухран зугадах болно. Тэр Гэр орондоо ч хойшлууламгүй чухал ажил төрөлтэй улс шүү дээ Морьтон баатрууд гэдэг чинь бүгд тайж нар, тэд л бидний хөгжмийн аяар бүжиглэн дэгэнцэх болно. Бид тэр гурван түмэн морьтон эрстэй л үзэлцэх юм. гэдгийг би батлан хэлье Одоо та юу бодож буйгаа х эл, та нарынхаар явья Бидэнд тулалдаан хийхээс ухрах, дайны талбараас ухрах хэрэг байна. уу ?

- Үгүй Бүгд нэгэн зэрэг жинхэнэ сэтгэл зүрхнээсээ тэгж ухрахгүй гэдгээ илэрхийлж билээ.

- Магадгүй, та нартэр гурван түмэн морьтон эрсээс айж байна. уу ? Ингэж тоглоом болгон хэлэхэд тэд чангаар инээлдэн айж түгшихээ нэгэнт больж өөр өөрийнхөө эзлэх ёстой байр луу баяр хөөртэй тарж явлаа Сүрхий багачуул, охид шиг ч царайлаг залуус байж билээ. Одоо би дайсантайгаа үзэлцэхэд бэлэн байлаа. Ирц гээвэл ч ирэг, биднийг балмагдуулахаасаа өнгөрсөн хүлээж ядсан их өдөр болох нь тэр Өгл ө ө үүрээр агуйн хаалга манаж байсан харуулын цэрэг ирж тэнгэрийн тэртээ хаяанд бөөн хар бараан юм. гарч ирээд дуу чимээ гарах мэт, лав хөгжмийн дуушуу шиг байна. гэлээ. Өглөөний хоол унд бэлэн болж бид өл хүчээ авлаа хоол ундны дараа миний бие залуустаа товчхон үг хэлээд их бууныхаа тооцоог Кларенст өгч тэргүүн сэргийлэхэд явуулав Нар мандаж алсыг гэрэлтүүлэхэд тэртээ тэнд үй түмэн цэрэг далайн долгио мэтээр үелээн удаан боловч ямагт ойртон о й ртсоор авай Ойртох тусам сүр бараа нь айдас төрүүлэм Англи орон даяараа л ирж я в аа нь тэр шүү дээ Төдхөн тоо тоймшгүй олон туг хиурын өнг ө нь тодорч байна. Хуяг дуулга, гархин хуяг нь нарны гэрэлд нүд гялбам агаад бүхэл тал нутгийг тэр аяар нь бүрхсэн мэт ажээ. Харахад сайхан гэдэг нь тийм сай хан гоёд харагдах юм. би ер үзээгүй Тэгсээр бүр нарийн ширийн зүйл нь тодрон харагдах болов. Олон зуун метр ө ргөн тэргүүн эгнээнд нь дандаа хуяг дуулга хэдэрсэн морьтон баатар эрс явна Гэнэт бүрээн дуу тас хийхэд морьтой эрс ухасхийн урагшилж дэргүүлэн давхив Ямар сүртэй харагдана вэ би амьсгаа дар а н хүлээлээ Тэдний ойртох тусам шаргалтан шаргалтах Э л ст Бүсийн цаа д ахи нов ногоон зурвас улам улам нарийссаар давхих морьдын урд талд туузан чинээ зурвас болж харагдсанаа төдхөн морьдын туурай дор алга болов. Бурхан минь тэргүүн эгнээний тэр их цэрэг тэр аяараа аяндын дуу адил чимээн дунд эрчлэн эргэлдэх хуй салхинд хийсэх зомгол мэтээр тэнгэрт дэгдэн, газар дэлхий утаагаар дүүрч өнөөх их цэргийн үлдсэн ар хэсгийг бидний нүдний хараанаа үзэгдэхгүй болгон бүрхэв миний цэргийн төлөвлөгөөний хоёрдугаар зүйлийг биелүүлэх цаг болов. Намайг цахилгаан товч дарахад бүх Англи орон тэр аяараа л ул сууриараа донслон доргив Тэрхүү дэлбэрэлтээр бидний ариун санаагаараа босгож бүтээсэн хамаг соёл иргэншил маань газрын хөрснөөс арчигдан агаар хийд дэгдэх нь тэр х айран юм. гэвч өөр арга байгаагүй юм. чинь Бид өөрснийхөө бэлдсэн зэ в сгийг дайсандаа өгч өөрснийгөө төхөөрүүлэх ёсгүй шүү дээ Дараа нь миний амьдралд тохиолдсон хамгийн уйтгартай арван таван минут эхэлсэн юм. Бид тал талаасаа төмөр утас, өтгөн утаагаар бүслэгдэн нам гүмийн дотор хүлээн суулаа Тэр утаан дундуур бидэнд юу ч харагдахгүй Сүүл сүүлдээ утаа их л муухан замхран бас нэг хорин таван минут өнгөрөхөд газар цэвэршиж бид ний сонирхлыг татсан юм. харагдах болов. Хаана ч ганц ч амьд амьтан харагдахгүй байна. Дэлбэрэлтийн дараа л бид хамгийн аюул осолгүй газар байгаагаа мэдлээ Динамитын дэлбэрэлтээр өргөнөөрөө зуун фут гуу жалга бий болж түүнээс гарсан шороо нь хоёр талаар өндрөөрөө хорин тав орчим фут далан бий болгосон байлаа. харин алагдсан хүн амьтан тоолж барамгүй болжээ. . Амь үрэгдсэн хүний тоо авья гэхэд олноосоо гадна бүтэн хүүр гэх юм. үлдсэнгүй, харин товч, төмөрт холилдсон зуурмаг л болсон байв. Ганц ч амьд амьтан харагдахгүй байв. Бодвол бүр ар талын эгнээнд шархадсан амьтад байгаа л биз, тэднийгээ утаан дундуур зайлуулж авсан биз Иймэрхүү юм. болоход ёс шиг халдварт овчин тархдаг болохоор амьд үлдсэн нь мөн л халдварт өвчин тахалд авгах нь гарцаагүй л даа Тэдэнд нэмж ирэх хүч байгаагүй болохоор Английн морьтон эрсийн эцсийн горьдло г о нь тэгээд л төгсөх нь тэр Одоо дайсанд хүч гэх юм. үлдээгүй, үлдсэн байлаа. ч юу базаах билээ. лав л морьтон эрс

байхгүй болсон гэж би бодоод аюул өнгөрлөө гэж санаж байсан тийм учраас миний бие өөрийн цэрэгт дор сийрүүлсэн агуулга бүхий тунхаглал гаргаж баяр хүргэсэн Үүнд хүн төрөлхтний эрх чөлөө, тэгш байдлын тө лөөтэмцэгч байлдагч дайчид аа Та нарт жанжин чинь баяр хүргэж байна. хүчин чадалдаа омогшсон хэрцгий дошгин дайсан биднийг дайрсан юм. Тануус тэдэнд зохих хариугий нь өгө в. Богино хугацаанд болж өнгөрсөн энэ тулалдаанд тануус алдар суугаа мандууллаа Энэ бол бид ганц ч амь насыг алдалгүйгээр байгуулж буй, түүхнээ эн з эрэгцэх жишээгүй их ялалт юм. Манай орчлон гаригууд тойрог замаараа замнан яваа цагт Элст Бүсийн тулалдаан хүмүүсийн ой тойноос хзэээ ч арилан мартагдахгүй эз эн Намайг өөрөө энэ тунхаглалыг уншин сонсоход хүмүүс алга ташин талархсан юм. миний бие м ө н дайнаас гарав о доо хийх дайн бол сүүлчийнх нь болно. Тэр бол түүхэнд гарсан хамгийн богино, хамгийн удахгүй дайн болох юм. Харин дайнд оролцогсдын ерөнхий тоотой зүйрлэх юм. бол алагдсан, шархадсан хүнийхээ тоогоор хамгийн сүйтгэлтэй дайн болох юм. Ард түмэнтэй хийх дайн төгс л өө Үүнээс хойш бид зөвхөн морьтон эрстэй л үзэлцэх асуудалтай байна. Английн морьтон эрсийг алж болох боловч ялж болохгүй учраас бид тэмцэл хийх хэрэгтэй байна. Ганц гэсэн морьтон эр үлдсэн цагт дайн дууссан гэж бодож болохгүй Бид тэднээс ганцыг ч үлдээлгүй алах хэрэгтэй удтал алга нижигнүүлэн т аш ив . Дайсан хүрч ирвэл мэдээлэг гээд миний бие өнөөх далан шороонууд дээр хоёр гурван харуул тавилаа Манай бэхлэлтийн урд талаар урсдаг голоос шинэ гульдрил гаргаж урсгаж хэрэгтэй цагт ашиглах бодлоор нэг инженерээ дөчин залуугийн хамт явуулав Дөчин хүн маань хоёр цаг ажиллаад л дараа ээлжиндээ өгч байхыгн тулд хоёр хэсэг болон хуваагджээ Арван цагийн дотор л бух ажлыг дуусгасан байв. Харанхуй болоход би харуул хамгааллынхныгаа дуудсан Умар зүгт нэг лагерь байгааг нэг харуул маань илрүүлсэн боловч тэр нь дурангаар л харагдана уу гэхээс биш зүгээр харагдахгүй хол байлаа. Хэд хэдэн морьтон эр манай бэхлэлтийн зүг хэдэн үхэр хөөж ойр туулсан боловч өөрснөө ойртож ирсэнгүй гэж бас нэг харуул маань мэдээлэв Тэгнэ гэж би бодоогүй Тэд биднийг л сорьж байж Биднийг бас дахин улаан аюул учруулах нь уу , үгүй юу гэж тэд тагнаж байж шөнө болмогц тэд зориг гарган дайрч мэдэх байв. Бид тэдэн шиг мунхаг мулгуу амьтан байсан бол чухам тэр шөнө л дайрах гэж оролдох байсандаа Энэ тухайгаа Кларенсад хэлэхэд

- Таны хэлдэг үнэн Тэд лав оролд ож үзэх байх гэлээ.

- Тэгвэл ч тэдний бүр үхэл нь ирэх нь тэр дээ

- Яриа юу байх вэ

- Тэдэнд өчүүхэн төдий ч горьдлого байхгүй

- Өчүүхэн ч байхгүй — Кларенс минь тэгж бодохлоор аймаар ч юм. шиг, хөөрхий амьтад би тэгж бодохоос бүр зовоод байх суух газар ч ол дохгүй юм. шиг санагдаж байлаа. Адаг сүүлд нь би сэтгэлээ тайтгаруулах гэж морьтон зрст дор дурдсан илгээлт явуулсан юм. Үүнд А н глийн зэвсэгт бослогын мор ьт он эрсийн эрхэмсэг тэргүүнд Та нар дэмий байлдаж байна. Бид та нарын хүч чадлыг хүч чадал гэж тооцож болох аваас андахгүй мэдэж байгаа шүү Та нар бидний эсрэг таван мянгаас илүүгүй морьтон эрс байлдуулна Тэгэхлээр, та нарт ялах ганц ч горьдлого байх ёсгүй, Бодоод үзэцгээ бид сайн зэвсэглэж сайн бэл д сэн, бид тавин дөр в үүлээ Тавин дөрвөн хүн л гэж үү? Үгүй, энэ хорвоод хамгийн авьяаслаг, ухаантай тавин дөрвөн толгой гэж мэдэгтүн,

- Энэ бол Английн гантиг эргийг далайн давалгаа дийлдэгүйн адил та нарын мэтийн тэнэг хүч явч д ийлэ х гүй хүч юм. Ухаанаа зарж үз Бид та нарын амийг ү лдээхэд бэлэн байна. Эхнэр, хүүхдээ бодож ийм өршөөлөөс татгалзах хэрэггүй Та нарыг бид сүүлчийн удаа зэвсгээ хураалган Бүгд Найрамдах төрд бууж өг тэгвэл бүхнийг өршөөнө гэж шаардаж байна шүү Гарын үсэг Эзэн би илгээлт бичгээ Кларенсад уншиж өгөөд үүнийгээ цагаан дарцаг хамгаалалттайгаар дайсанд явуулъя гэсэн юм. гэтэл мань хүн маш ёжтойгоор тачигнатал инээж

- Та чинь одоо хүртэл тайж нар хэн болохыг сайн ойлгож чадаагүй байна. Цаг, хөдөлмөрөө хэмнэж үзье Намайг тэр морьтон эрсийн тэргүүн гэж бод Тэгээд та цагаан дарцгаа барьсаар энэ илгээлтээ надад өгөг би хариугий нь өгье гэхэд түүний санаа надад зөв санагдав би дайсны цэргээрээ хүрээлэгдэн өнөөх бичгээ гаргаж ирээд уншлаа гэж бодлоо гэтэл Кларенс х а риу хэлэхийн оронд миний гараас бичгийг булаан авч дээрэнхүйгээр нүүр амаа муухай болгон заналтайгаар

- Энэ малыг хэдэн хэсэг болгон хөрөөдөөд сагсанд хийж тэр атигар боол руу нь буцаагаад өг Өөр хариу надаас авахгүй гэлээ. Баримттай юмтай зүйрлэхэд онол гэгч хичнээн өчүүхэн бэ Баримт тийм л байсан юм. Үр дүн нь чухам л тийм байх байжээ. би тэр бичгээ урж хаяад дэмий нялуун сэтгэлээ ч орхилоо Тэгээд ажилдаа орох нь тэр Агуй, батарөй хоёрынхоо хоорондын дохиоллыг шалгаад зөв байгааг нь мэдэж, агуй, төмөр утсан хаалтнуудын хоорондын цахилгаан холбоог шалгаж үзлээ Тэр холбоогоороо би арван хоёр шугамны алинаар нь ч цахилгаан гүйдэл явуулж чадах байсан юм. Голын шинэ гольдролдоо гурван шилдэг залуугаараа харуул тавьж цаг дутамд ээлж сольж байсан бөгөөд гар буугаар гурав дахин буудсан цагт миний тушаалыг биелүүлэх хэрэгтэй гэж тэдэндээ зааварласан юм. Бусад харуулаа шөнө буулгаж хоригийн дотор ч ганцыг үлдээгээгүй, агуй дотор чимээ шуугиан бүү гарга гэж тушаагаад цахилгаан гэрлийг сүүмийх төдий асаах болгосон юм. Тэгснийхээ дараа бүх төмөр утсан хаалтны цахилгаан гүйдлийг салгаж хоорондуур нь явж манай бэхэлгээг тойрон бий болгосон шороон далан дээр очиж дээр нь гараад тэр хөвсгөр далангийн налуу энгэрт алсыг ажин хэвглээ Пад харайхуй байсан учраас юу ч харагдахгүй байв. юу ч сонсдохгүй Бүгд үхчихсэн юм. шиг нам гүм, от чимээгүй Хари шөнийн цагаар үргэлж дуулах шувууны жигүүрийн сүрд сүрдхийх, хорхой фавынны дүнгэнэх, алсад айлын нохой хуцах, үхэр мөөрөх нь уг чимээгүй байдлыг эвдэх нь бүү хэл, харин улам ч чи мээгүй болгож улам ч уйтгар гунигтай болгох ажээ. юу ч харагдахгүй учраас нүдээ чилээж ширтэхээ болиод харин чимээ чагиаж, тэсвэртэйхэн чагнавал эрх биш юм. олж сойсоно гэж бодсон маань худал болсон гүй Тэгэхдээ тийм хурдан сонсоогүй шүү, тун их удсан Төмөр хавирах чимээ чихий минь дэлслээ шүү Яг л тийм чимээ гарахыг отож байсан болохоор амьсгаз гаа даран улам хичээнгүйлэн чагнавал хойд зүгээс уг чимээ ойртон байлаа. Гэнэт надтай бүр зэрэгцээ газар, далангийн нөгөө талд зуун футын зайтай газар өнөөх чимээ гарлаа Тэгтэл далангийн орой дээгүүр хар хар цэг цухуйлаа хүний толгой юу ? Дэндүү их хичээсэн цагт нүдэнд ч итгэх бэрхтэй, ер нь юу ч үгүй байгаа ч байж мэдэх гэсэн ч таавар маань удалгүй тайлагдав бүр гуун дотор төмөр хавирах чимээ сонсдоо Гуу жалгыг зэвсэгт этгээдүүд эзэлж буйг би ухаарлаа Тэд, биднийг балмагдуулан дайрах гэж байгаа юм. байж Бодвол тэд биднийг үүрээр юм. уу , эсвэл эртхэн ч дайрах юм. байж би эргэж утас руугаа явлаа харсан сонссон маань хангалттай Тавцандаа хүрч очоод төмөр утсан хамгаалалтынхаа дунд биений хоёр эгнээнд цахилгаан гүйлгэх дохио өглөөТэгээд агуйдаа орж ирвэл жижүүрээс бусад нь бүгд унтаад юм. бүхэн хэвийн байдалтай байна. Би Кларенсыг сэрээж гуу жалгаар цэрэг дүүрч

байна. Янз нь морьтон эрс бүлгээрээ биднийг дайрах гэж байгаа бололтой гэлээ. Үүрийн хяраа дөнгөж тусмагц гуужалганд нуугдсан олон мянган цэрэг авиран гарч довтлоход араас нь бүх их цэрэг шууд дайрах нь ээ Кларенс хэлэхдээ

- Тэд харанхуйг далимдуулан тагнуул явуулах байх шүү хоригийн гадуур шугамын гүйдлийг салгавал яадаг юм.? Азаа туршиг л даа

- Салгачихсаан, Кларенс Намайг чи зочинд дургүй хүн гэж бодоо гэж үү?

- Хаанаас, та бодь сэтгэлтэй хүн би очиж Зочдоо угт а х гэж уу ? Хамт явья Бид хоёр төмөр утсан хамгаалалтын дотуур хоёр эгнээний дунд орж хэвтэв Эхлээд юу ч харагдахгүй байсан боловч яваандаа чүд маань харанхуйд дасаж утсан хаалтныхаа багануудыг олж харах болов. Шивнэж ярьж байснаа Кларенс гэнэт

- Энэ юу вэ? гэж асуулаа

- Хаана? юу ?

- Тэр тэр

- Тэр гэж хаана?

- Тэр, өөрийн чинь цаагуур нэг хар юм. хоёрдугаар эгнээний хажууд Бид хоёул олж харлаа Тэгээд би

- Кларенс аа, хүн шив дээ? гэхэд

- биш байх аа, Үгүй хүн юмаа хашаа налаад зогсож байна.

- Ойртож очоод шалгая Бид хоёр дөрвөн хөллөн мөлхөө нээрэн, хуяг дуулгатай өндөр эр байлаа. Эгц зогсон хоёр гараараа утаснаас зуурчээ биенээс нь шатсан махны үнэр ханхална Хө ө рхий амьтан мануухай шиг амьгүй болон зогсох бөгөөд юунд алагдсанаа мэдэх аргагүй үхжээ модон хүн шиг хөдөлгөөнгүй зогсох агаад дуулганых нь дээдхи өд шөнийн салхинд өрвөлзөнө . Дуулганых нь нүхээр ша г айж харсан боловч бид хоёр хэн болохы нь таньсангүй, таних, танихгүйгий нь ч мэдэж чадсангүй Бас нэг юм. ойртох чимээ гармагц нь бид хоёр хэвт чихлээ Бас нэг эр сүүмэлээн сэмхэн хэтэж тэмтэрч байснаа үхсэн нөхрөө хармагц зог тусан цочиж минут хэртэй зогссоноо цаадхийгаа яагаад хөдлөхгүй байгаа юм. бол хэмээн гайхаж сэмхнээр чи юун тухай бодол болов. ноён Мар гээд гараа хүүрний мөрөн дээр тавилаа, аяархан ёолоод уналаа, үхсэн үхээртээ алагдан үхэтхийн уналаа Тун аягүй юм. энэ үзэгдэлд оршном хагас цагийн турш эрт хөдөлсөн тэр шувууд тав таван минутын зайтай хүрч ирэн үхлээ олсоор байлаа. Гартаа гагцхүү юлднээс өөр барьсан зэвсэггүй байв. Тэд юлдээрээ тэмтчин цахилгаан гүйдэлгүй утсаар замаа олж байсан юм. Гэнэ гэнэ хөх оч үсрэхэд юу болж буйн учрыг бид хоёр мэдэж байсан юм. Тэд юлдээрээ цэнэгтэй утсанд хүрээд үхэж байгаа нь тэр нэг хэсэг чимээ тасарснаа хуяг дуулга нар нүрхийн унах чимээ байн байн гарна, тийм юмыг пад харанхуйн дотор сонсох айдас ч хүрмээр Бид хоёр утсан хамгаалалтынхаа дотоод эгнээгээр зугаалга хийхээр шийдэв Бид хоёр бүр босоо явахад эвтэйхэн санагдаж, тэд харлаа ч гэсэн өөрсдийн хүн яв ж байна. гэж бодох, аль эсхүл хардаад а лах гэлээ. ч хүрэхгүй юм. чинь , бас тэд жадгүй яваа болохоор жадны аюул хүрч ирэхгүй байсан ю м Зугаатай зугаалга болж байлаа.в шүү Хамгаалах хаалтны хоёрдугаар эгнээний цаагуур энд тэндгүй үхдэл байгаа нь харанхуйд сүүмийн үзэгдэнэ Утаснаас гараараа тас зууран үхсэн, хөшөө

болон үхсэн морьтон эр арван тав байгааг бид тоолон мэдлээ Үхэж буй хүн хашгирч ч амжилгүй амь тавихуйц манай цахилгаан тийм хүчтэй цохиж байлаа. Дараа нь морьдын төвөргөөн бүдэг сонсдоход юу болохы нь бид хоёр ойлгосон Тэдний гэнэт үзүүлэх гэсэн гайхуулах юм нь тэр л дээ Би, Кларенсыг агуйдаа орж цэргээ сэрээгээд ямар тушаал өгөхийг хүлээж бай гэж шивнэв Кларенс төдхөн эргэж ирлээ Бид хоёр дуу чимээгүй аянга дайран ирсэн дайсныг хэрхэн устгаж байгааг нь ажиглан тэр хамгаалалтынхаа эахад удаан зогссон билээ. Нарийн юм. харагдаж өгөхгүй байсан боловч овооролдох хар бараан юмны хэмжээ улам улам нэмэгдсээр буй нь ил байлаа. Манай лагерь тийнхүү тал талаасаа үхдэл хүүрээр зузаан ханаар хүрээлэгдэх адил бүслэгдэх нь тэр Тэр явдлын хамгийн аймшигтай нь чив чимээгүй, ямар ч орилоон, хашгираан ёолох ийлэх чимээгүй байх явдал ажээ. Биднийг тэд гэнэдүүлэн дайрах гэхдээ аль болохоор чимээ анир гаргахгүйг хичээн явсан боловч тэргүүн эгнээ нь зорьсон цэгтээ дөнгөж хүрч ирлээ хэмээн орилолдон хашгирах даваан дээрээ гарах гэтэл галт төмөр утсанд тулж дуугарч ч чадалгүй үхэж байлаа. Эгнээнүүдийн хооронд дайран довглогчид маш хурдан нэвтэрч байсан учир би гуравдугаар шугаманд гүйдэл өгч бараг нэг зэргээр д ө р ө в тавдугаар шугамд гал өгсөн юм. Гол цохилт өгөх цаг болов. гэж бодсон Ямар ч болтугай харах хэрэгтэй байлаа. Намайг товч дарахад манай гуужалгын дээр тавин ширхэг цахилгаан нар гялсхийн гийлээ Бурхан минь , юу гээч юм. харагдана вэ? Биднийг үхдэл хүүр гурван хана болон бүсэлсэн байв. Буса д хаалтнуудын хоорондуур пиг дүүрэн цэрэг утаснуудын дундуур болгоомжлон давшиж байв. Гэнэт нүд гялбасан гэрэлд гэнэдсэ н тэднүүс хөшиж орхих шиг болон зогсов Яг тэр хошиж зогссон агшныг ашиглах хэрэгтэй байлаа. тийм завшааныг ч алдаагүй л дээ Тэд минутын дараа сэхээ орж дайчин уриа хашгиралдан хамазгүй дайрахад манай утас тасарч болох байлаа. Тэгэхлээр би тэдний тэгж балмагдах агшны нь далимдуулж бүх хаалтныхаа утсанд нэг зэрэг цахилгаан гүйлгээд орх и сон чинь бүгд үхэх нь тэр ё ололдох чимээ сая дуулдсан шүү Ар в ан нэгэн мянган хүн амь тавьж байгаа нь тэр, Шөнийн цагт сүртэйгээр гаслан орилолдох нь тэр их цэргийн үлдсэн хэсэг нь арваад мянган хүн гуужалга даван манай цайз руу довглон буйг нь ганцхан харахад л ямаршуу болох нь мэдэгдэнэ Тэгэхлээр тэд бидний гарт ороод ирсэн хэрэг байлаа. Тэдэнд одоо амь мултра х ямар ч газаргүй болжээ. Эмгэнэлт явдлын хамгийн сүүлчийн үзэгдлийг үзүүлэх цаг болов. би гар буугаараа гурав дахин буудаад

- Ус тавь гэлээ. Дэлбэрэх чимээ нүргэлж усыг тогтоон барьж байсан хамар нурж уулын ус гуужалга руу цутган орж өргөнөөр өө зуун фут г үнээрээ хорин таван фут мөрөн бий болгов

- их буундаа Га л лаад Үхэл нь нэгэнт ирсэн тэр түмэн этгээдийг арван гурван үхэр буу сэглэж эхлэх нь тэр Тэд бажга алдан м инут хэртэй галын тусгай дунд элийрч байснаа гэдрэг салхинд хоогдох хог новш шиг ухран зүтгэлээ Дөрөөний нэг хэртэй нь далангийн орой хүрч амжилгүй үхэж, дөрөвний гурав нь гуужалга руу гүйлдэн ороод усанд живж үхлээ Биднийг гал нээсний дараа арваадхан минут болоод дайсны зэвсэгт эсэргүүцэл бүрмөсөн дарагдаж дайн дууссан юм. Бид тавин дөрвөн хүн Англи орны эзэн болов. Бидний эргэн тойронд хоёр түм таван мянган хүний үхдэл хүүр хэвтэнэ гэвч аз жаргал гэгч хичнээн хувирамтгай вэ Тун удалгүй, ганц цаг хэртэй болсны хойно

- миний буруугаас болж гэвч надад цааш нь бичих чадал алга даа Ингээд төгсгө в

Дөчин дөрө вдүгээ р бүлэг

КЛАРЕНСИЙН ХО Ж МЫН ҮГ

Кларенс миний бие үүнийг түүний оронд бичих ёстой болжээ. Шархадсан хүмүүст Ямар нэг түсламж үзүүлж болох нь уу, үгүй юу хоёул явж үзье гэс э н юм. би тэр үгий нь таашаагаагүй билээ. Ш а рхадсан хүн олон байгаа бол бид тэдэнд тусалж барахгүй, тэгэхлээр тэдэн дундуур хэсэж явахын хэрэггүй гэсэн юм. гэвч түүнийг нэгэнт шийдсэн санаанаас нь буцаана гэдэг амар гүй байдаг болохоор бид утасныхаа гүйдлийг салгаад хамгаалагч дагуулан хүүрэн дундуур гарч тулалдааны талбай дээр очлоо Алагдсан нөхрөө нуруугаараа түшиж суусан нэг шархтай хүн биднийг туслаж хайрлаач гэлээ. Эзэн түүний дэргэд очин тонгойж яриа эхлэхэд цаадхи нь түүнийг т аньж чинжаалаараа хутгалав Дуулган дээр нь нэр нь байсан учир тэрнийг М е лиагронс ноён гэж би таньса н Тэр дахин тусламж гуйх хэрэгцээгүй болсон доо Бид эзнийг агуйдаа аваачиж амь насанд нь осол багатай тэр шархы нь боож өгсөн билээ. Түүнийг сахиж бөөцийлөхөд Мерлин бидэнд туслалцсан юм. Түүнийг бид таниагүй байсан чинь мань хүн хөгшин чавганцын хувцас өмс е н сайн сэтгэлт хүн болж ирсэн байлаа. Эзнийг шархдаад хэд хонож байтал наранд борлосон, үс сахалгүй яг л чавганц хүн ирж хоол унды нь хийж өгч байя гэсэн юм. Хуурамч чавганц бидэнд ярихдаа хамаг садан төрөл нь дайсны шинээр эмхлэн байгуулж буй цэргийн лагерьт өөрийн нь орхин одсон учир өлбөр үхэх нь гэсэн билээ. Эзэн тэр үед нэгэнт эдгэрч он дарааллынхаа түүхэн бичгийг дуусгаж байсан цаг байлаа. Бидэнд хүн хүч хүрэлцээ муутай байсан болохоор тэр чавганцын тус тун хэрэгтэй бодогдсон юм. Бид өөрсдийнхөө тавьсан урхи н д орчихоод байж л даа, Бид тэндээ үлдэх юм. гэхэд үхдэл биднийг алах байлаа. Бэхлэлтээсээ гарч явах юм. бол хамгаалалт хаалтгүй болох байв. Бид ялсан боловч өөрснөө бас ялагджээ, Эзэн үүнийг ойлгож байсан, бид ч ойлгож байлаа. Хэрэв тэр байгуулагдаж буй лагериудынх нь нэг дээр очиж хэлэлцээ хийх гэвэл гэвч эз э н ч явж чадсангүй, би ч явж чадаагүй, яагаад гэвэл хамгийн түрүү миний бие тэр түмэн хүүрийн ялзран үмхийрэхэд хордон өвчилсөн юм. миний дараа бусад маань ө вдөж эхэлсэн м аргааш Маргааш гал нөмөрлөө . Өнгөрчээ, шөнө дунд сэрээд хараал тэр шулмас Эзний толгой дээр нэг юм. хийж байхыг нь мэдээд энэ юу болж байна. вэ гэвэл Динамын дэргэд жижүүрлэж байсан хүнээс бусад маань бүгд унтаж байлаа. Огт чимээ аниргүй ч авганц нөгөөх солиотой мэт нууц шившлэгээ болиод үүдний зүг өлмий дээрээ чиглэн явлаа

- Зогс чи юу хийсэн бэ? гэж би хашгирлаа Чавганц дороо зогсож бүр ханхгар дуугаар

- Та нар ялагч байсан бол ялагдагч болсон доо Тануус бүгд үхнэ чи ч өөрцгүй Тануус энэ агуйд тэрнээс бусад нь нэгд нэгэнгүй үхнэ Цаадхи чинь одоо унтаж байгаа, арван гурван зуун жил унтах болно.

Б и Мерлин байна шүү гэв Ингэж хэлээд тэнэг мэтээр учиргүй их хадганан инээж гуйвж дайван үсэрч унахыг дөхөж байгаад нэг утаснаас бариад авлаа Ам нь одоо хүртэл ангалсан хэвээр, одоо хүртэл инээсээр байна. Бие нь хумхийн тоос болон хувирах хүртэл тэр инээсээр л байх болно. Эзэн чулуу мэт хөдлөхгүй унтсаар байна. . Хэрэв өнөөдөр сэрэхгүй бол бид учры нь ухаарч шарилы нь хэн эс олох, хэн ч эс доромжлох агуйн хамгийн цаад талын мухарт аваачиж тавих болно. Харин үлдсэн бид нар ярилцаж тохирохдоо хэрэв хэн нэг маань эндээс амьд мултардаг юм. бол энд болсон бүх явдлыг нэгд нэгэнгүй бичээд гар бичмэлээ биднийхээ сайн санаат хайрт тэргүүн Эзнийхээ хажууд, амьд ч бай, үхсэн ч бай, сайн санаа өвөрлөн орхино . Тэр бол ямар, ч болтугай түүний юм. билээ. гэлцсэн билээ.

Гар б и чмэлийн төгсгөл

ЗОХИОГЧИЙН ХО ЖИМ БИЧСЭН ЗҮЙЛ

Намайг гар бичмэлээ цааш тавихад үүр нэгэнт цайсан байлаа. Бороо бараг зогсож, ерт өнц з эвхий саарал даан, уйтгартай санагдаж, усан шуурга намжаад сүүрс алдан мэгших мэт авай Биг танихгүй хүний өрөөний хагас онгорхой үүдэнд очиж чагнав . Дуугарах дуугий нь сонсоод үүдий нь тогшив Хариу дуугарахгүй атал түүний дуудуулдсаар тэгэхлээр нь ша г айж харвал тэр хүн орондоо дээш харан хэвтэх бөгөөд дуу тасалданга боловч эршүүдхэнээр ярьж хоёр гараа дээш гарган атгаж тав их нь халуундаа дэм и йрч буй хүн мэт ажээ. Дэргэд нь аяархан очиж харахад хүнгэнэтэл ярьсаар л, Анхаарлы нь татах гэж би үг хэлбэл жалхгүй нүд нь баяр талархлаар дүүрч зэвий даасан царайд нь улаан туяа тусаад ирлээ

- Өө, Сэнди минь хүрээд ирэв үү, мөн ч их хүлээ лээ Чамайгаа мөн ч их саналаа миний хажууд суу, намайг битгий орхи, дахиад хэзээ ч бүү орхи, хэзээ ч Сэнди Гараа, гар чинь хаа байна. Гараа нааш, хайрт минь , одоо хичнээн сайхан байна., би дахиад аз жаргалтай боллоо Бид хоёул аз жаргалтай, тийм ээ, Сэнди? чи надад тод харагдахгүй, үүл, манан шиг байна., гэсэн ч чи энд л байгаагаас хойш яах вэ Сайхан хэрэг би гары чинь барьж байна. Гараа битгий авчихаарай, би удаан барихгүй, би мөд Аа манай өөд ө с хаа байгаа вэ? Төвийн станц Хариу дуугарахгүй байх чинь , у н таж байгаа юм. бол уу ? Сэрэхлээр нь аваад ир, би гары нь барьж үзье, нүүрий нь , сэвлэгий нь , салахын ёс гүйцэтгэе Сэнди чи минь энд байна. Би агшин зуур мартаад чамайг яваад өгчихөж гэж бодлоо би өвдөөд удаж байна. уу ? Лав удсан байх, бүхэл хэдэн сар болсон байх Ямар зүүд зүүдэлж байна. гэж санана Хачин, ймаар зүүд, Сэнди Үнэн юм.наас өөрөөс нь тод тийм зүүд, энэ ч солиол доо тийм тод зүүд байх гэж хаа б айх вэ Ван үхсэн, хувьсга л гарсан гэж зүүдэлсэн Кларенс, би, хэний хэдхэн сурагч бид хэдүүлхнээ Английн бүх морьтон эрсийн эсрэг байлдаж байна. гэж ухаан санаанд багтамгүй солиотой юм. санаанд орсон . Энэ ч бас хамгийн хачин нь биш шүү би өөр зууны үеийн хүн, ирээдүйн зууны хүн юм. гэж зүүдэлсэн я г үнэн юм. шиг санагдсан . Гэнэт би тийм зуунд ороод дахин өөрийнхөө зуунд эргэж орж байна. гэж санагдаад гав ганцаараа огт т аньж үл мэдэх Англи оронд очиж, чи бид хоёрын хооронд арван гурван зуун жилийн зааг байгаа юм. шиг санагдсан шүү би өөрийн т эр орноос, өөрийн найз нөхдөөс төдий их холын заагтай болчих шиг санагдсан Би, өөрийн хайртай дуртай бүхнээс, өөрийнхөө санаж сарвайж явсан бүхнээс тийм их заагтай болчихлоо гэж зүүдэлсэн Аймаар х эн ч төсөөлөхийн аргагүй аймаар, Сэнди Аяа, Сэнди, миний хажууд суу, намайг бүү орхи, дахиад намайг солиороход бүү хүргэ Үхэх яах вэ, юу ч биш, тийм л зүүд үзэхгүй бол яах вэ, тийм зүүд шиг там алга д ахиад тэгж зүүдэлбэл би яагаад ч тэсэхгүй Сэнди минь Бас нэг хэсэг хоорондоо холбоогүй юм. ярьсаар дуу нь тасарлаа, бодвол амьсгаагаа хураах нь ойртож буй бололтой . Гэнэт гараараа хөнжлөө тэмтчин эхлэхэд нь одоо л таалал төгсөж байна. даа гэж би ойлгов . Эцэслэхийнхээ өмнөхөн амь нь тэмцээд хамаг бие нь чичрэн таталдаад ирмэгц аяархан өндийж нэг юм. чагнах маягтай болсноо ингэж хэлэв

- бүрээ юу ? Вандаа Гүүрээ буулга хүмүүсээ шилтгээний хананд Унтраагаарай Тэр маань сүүлчийнхээ гайхамшгийг бэлдэж байсан боловч түүнийгээ төгсгөлд нь хүргэж чадаагүй юм.

